



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС

Хууль зүйн эрдэм шинжилгээний мэргэжлийн сэтгүүл

Цуврал 4 (95)

Улаанбаатар хот
2023 он

Сэтгүүлд нийтэлсэн бүтээл нь Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

© Сэтгүүлд нийтлэгдсэн бүтээлийн зохиогчийн эрх Сэтгүүлийн редакц болон зохиогчид хадгалагдана.

Эх бэлтгэгч, дизайнер: Б.Заяа

Хэвлэсэн газар: Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хэвлэх үйлдвэр

Улсын бүртгэлийн дугаар: 279
ISSN:2226-9185
Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс
эрхлэн гаргав. Жилд 5 дугаар гарна.

Хаяг: Улаанбаатар-46, Чингэлтэй дүүрэг,
4 дүгээр хороо, Бага тойруу /15160/,
Хуульчдын гудамж 1,
Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн байр
Утас: +(976)-11-315735
Факс: 315735
Вэб хуудас: www.nli.gov.mn
Цахим хаяг: lawjournal@legalinstitute.mn

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

- Ерөнхий эрхлэгч: **Х.Эрдэм-Ундрах** Хууль зүйн ухааны доктор (*Dr.jur.*),
Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал
- Эрхлэгч: **М.Түвшинжаргал** Хууль зүйн ухааны доктор (*Ph.D*)
Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга
- Гишүүд:
- С.Нарангэрэл** Академич, Хууль зүйн шинжлэх ухааны доктор (*Sc.D.*),
МУИС-ийн эмерит профессор
- Ц.Сарантуяа** Хууль зүйн шинжлэх ухааны доктор (*Sc.D.*), профессор
- Г. Банзрагч** Хууль зүйн ухааны доктор, УДШ-ийн шүүгч
- Н.Баярмаа** Хууль зүйн ухааны доктор, УДШ-ийн шүүгч
- Э.Батбаяр** Хууль зүйн ухааны доктор, профессор, ДХИС-ийн
ШШГАС-ийн Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны
тэнхимийн эрхлэгч
- С.Болормаа** МУИС-ийн ХЗС-ийн Практик сургалтын төвийн
эрхлэгч, хууль зүйн ухааны доктор (*Ph.D*), дэд профессор
- Б.Буянхишиг** Хууль зүйн ухааны доктор, МУИС-ийн ХЗС-ийн
Хувийн эрх зүйн тэнхимийн ахлах багш
- Ц.Давхарбаяр** Хууль зүйн ухааны доктор (*Ph.D.*), дэд профессор,
Шүүхийн сахилгын хорооны гишүүн
- Г.Давааням** Хууль зүйн ухааны доктор(*LL.D*), дэд профессор, МУИС-
ийн ХЗС-ийн хувийн эрх зүйн тэнхимийн ахлах багш
- Д.Зүмбэрэлхам** Хууль зүйн ухааны доктор, профессор,
ШЕЗ-ийн гишүүн
- Г.Нарантуяа** Хууль зүйн ухааны доктор, ХЭҮК-ын гишүүн
- Д.Сүнжид** Хууль зүйн ухааны доктор (*Dr.jur.*), дэд профессор
ХЭҮК-ын дарга.
- С.Сүхбаатар** Хууль зүйн ухааны доктор
- Б.Улаанбаатар** Хууль зүйн ухааны доктор (*Ph.D.*), дэд профессор,
МУИС-ийн ХЗС-ийн Хувийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч
- М.Уянга** Хууль зүйн ухааны доктор (*Ph.D.*), дэд профессор МУИС-ийн
ХЗС-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга,
- Ц.Цогт** Хууль зүйн ухааны доктор (*LL.D.*), УДШ-ийн шүүгч
- Д.Эрдэнэчимэг** Хууль зүйн ухааны доктор, дэд профессор,
ШССМХ-ийн захирал
- Ж.Эрхэсхулан** Хууль зүйн ухааны доктор (*Ph.D.*), дэд профессор,
МУИС-ийн ХЗС-ийн Нийтийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч
- Д.Янжинхорлоо** Хууль зүйн ухааны доктор, МУИС-ийн ХЗС-ийн
Хувийн эрх зүйн тэнхимийн дэд профессор
- Анна Тумурова** Хууль зүйн ухааны доктор (*Ph.D.*), ОХУ-ын Буриадын
Улсын их сургуулийн Төр, эрх зүйн онол, түүхийн тэнхимийн профессор
- Накамура Масаки** Хууль зүйн ухааны доктор (*Ph.D.*), Япон Улсын

Нагоягийн их сургуулийн Эдийн засгийн сургуулийн дэд профессор

Ким Габ Сок *Хууль зүйн ухааны доктор, Жүнбү Их сургуулийн
Цагдаагийн сургуулийн профессор*

Пак Жеон Вон *Хууль зүйн ухааны доктор (Ph.D.), БНСУ-ын Кукмины
их сургуулийн Хууль зүйн сургуулийн профессор*

Сарпеков Р.К. *БНКаЗУ-ын Хууль тогтоомж, эрх зүйн мэдээллийн
хүрээлэнгийн захирал, БНКаЗУ-ын Гавьяат ажилтан*

Том Гинсбург *Хууль зүйн ухааны доктор (Ph.D.), АНУ-ын Чикагогийн
их сургуулийн профессор*

Хариуцлагатай нарийн
бичгийн дарга:

Э.Сэлэнгэ *Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний
ажилтан*

Тус дугаарын өгүүллийг хянасан:

Х.Эрдэм-Ундрах
М.Түвшинжаргал
Г.Банзрагч
Н.Баярмаа
М.Уянга
Г.Нарантуяа
Д.Сүнжид
Б.Буянхишиг
С.Болормаа
Э.Батбаяр
Д.Янжинхорлоо
Д.Эрдэнэчимэг

EDITORIAL BOARD

EDITOR-IN-CHIEF

ERDEM-UNDRAKH Khurelbaatar *Doctor of Jurisprudence, Director,
The National Legal Institute of Mongolia*

MANAGING EDITOR

TUVSHINJARGAL Moyor *Doctor of law (Ph.D.), Academic Secretary
The National Legal Institute of Mongolia*

MEMBERS

NARANGEREL Sodovsuren *Member of the Academy of Sciences, Science
doctor of law (Sc.D.), Emeritus Professor,
National University of Mongolia*

SARANTUYA Tserenbaltav *Science doctor of law (Sc.D.), Professor, School of
Law, National University of Mongolia*

BANZRAGCH Gochoo *Doctor of Jurisprudence (Dr.jur.), Justice, The
Supreme Court of Mongolia*

BAYARMAA Nyamdoo *Doctor of law (LL.D.), Justice, The Supreme
Court of Mongolia*

BATBAYAR Enkhee *Ph.D., Professor, Department Head, Court order
enforcement college, University of Internal Affairs
of Mongolia*

BOLORMAA Soloon *Ph.D., Associate Professor, Head of Legal Clinic
Center, School of Law, National University of
Mongolia*

BUYANKHISHIG Bat-Erdene *Ph.D., Senior Lecturer, Private Law Department,
School of Law, National University of Mongolia*

DAVKHARBAYAR Tseveensuren *Doctor of Law (Ph.D.), Member, The Judicial
Disciplinary Committee of Mongolia*

DAVAANYAM Gankhuyag *Doctor of Law*

ERDENECHIMEG Dashpuntsag *Ph.D., Associate professor, Director, Judicial
Training, Research and Information Institute*

ERKHESKHULAN JambaaJultem *Doctor of law (Ph.D.), Head of the Public Law
Department, School of Law, National University
of Mongolia*

NARANTUYA Ganbat *Ph.D, Commissioner, The National Human Rights
Commission of Mongolia*

SUNJID Dugar *Doctor of Jurisprudence (Dr.jur.), Ass.prof,
The National Human Rights Commission of
Mongolia*

SUKHBAATAR Sumiya *Doctor of law (LL.D.)*

TSOGT Tsend *Doctor of law (LL.D.), Justice, The Supreme
Court of Mongolia*

ULAANBAATAR Byambajav *Doctor of law (Ph.D.), Head of the Private Law
Department, School of Law, National University
of Mongolia*

UYANGA Myagmar *Doctor of law (Ph.D.), Academic Secretary,
School of Law, National University of Mongolia*

YANJINKHORLOO Dambadarjaa	<i>Ph.D., Associate professor, Private Law Department, School of Law, National University of Mongolia</i>
ZUMBERELPKHAM Dorjdamba	<i>Doctor of law (Ph.D.), member, The Judicial General Council of Mongolia</i>
ANNA TUMUROVA	<i>Doctor of law (Ph.D.), Professor, Buryat State University, Russian Federation</i>
MASAKI NAKAMURA	<i>Doctor of law (Ph.D.), Professor, Nagoya University of Economics, Japan</i>
GIM, GAB-SEOK	<i>Ph.D., Professor, Department of Police, Joongbu University</i>
PARK JEON WONG	<i>Doctor of law (Ph.D.), College of Law and Graduate School of Legal Affairs, Kookmin University, Republic of Korea</i>
RAMAZAN K.SARPEKOV	<i>Doctor of law (Ph.D.), Director, The Institute of Legislation and Legal Information, Republic of Kazakhstan</i>
TOM GINSBURG	<i>Doctor of law (Ph.D.), Professor, The University of Chicago, USA</i>
STAFF:	
SELENGE Enkhzorigt	<i>Researcher, The National Legal Institute of Mongolia</i>

The papers of the series reviewed by:

ERDEM-UNDRAKH.KH
TUVSHINJARGAL.M
BANZRAGCH.G
BAYARMAA.N
UYANGA.M
NARANTUYA.G
SUNJID.D
BUYANKHISHIG.B
BOLORMAA.S
BATBAYAR.E
YANJINKHORLOO.D
ERDENECHIMEG.D

State Registration Number:279
ISSN: 2226-9185
The National Legal Institute publishes
Mongolian Journal of Law five times
per year.

Address: 4th Khoroo, Chingeltei District,
Lawyer's Street-1, Ulaanbaatar-15160, Mongolia
Phone:+(976)-11-315735
Fax: 315735
Website: www.nli.gov.mn
E-mail: lawjournal@legalinstitute.mn

АГУУЛГА

ЭРХ ЗҮЙН СЭТГЭЛГЭЭ: ҮЗЭЛ БОДОЛ, ЭРГЭЦҮҮЛЭЛ

Ёс суртахуунт нийгмийг бүтээх нь авлига буурах чухал хүчин зүйл болох нь 12
Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Хэв журмын хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн ахмад, МУИС-ийн ХЗС-ийн магистрант Т.Жавхлан

ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР НӨЛӨӨ

Үл хөдлөх хөрөнгө болон газрын нөхөн төлбөр, үнэлгээний эрх зүйн зохицуулалт 23

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн докторант Я.Өнөрбаян

Хурдан морины уралдаанч хүүхдийн эрхийн зарим асуудал, тэдгээрийг шийдвэрлэх арга зам 34

БНХАУ-ын Өвөр Монголын Их сургуулийн докторант Т.Баясгалан

ЭРХ ЗҮЙН СУДАЛГАА, ТОЙМ , ҮР ДҮН

Шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх иргэний эрх зүйн хариуцлага, онолын үндэслэл 47

ДХИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн эрхлэгч, дэд хурандаа Я.Батгэрэл

Европын нийгэмлэгийн картелийн эрх зүйн онолын сэтгэлгээний хөгжил ба түүхэн үйл явдлуудыг эргэцүүлэх нь 58

СЭЗИС-ийн Эрх зүйн тэнхимийн ахлах багш, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн докторант Л. Отгонбаяр (LL.M)

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын тогтолцооны эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудал 75

ХУИС-ийн ОУХНС-ийн тэнхимийн багш Т.Заяа

Хөдөлмөрийн тухай хууль дахь стандарт заалт, үүрэгжүүлсэн болон үүрэгжүүлээгүй хэм хэмжээний эрх зүйн үр дагавар 88

Шихихутуг Их Сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, докторант Ё.Болормаа

Дарагдмал үнэт зүйл болон түүх, соёлын дурсгалт зүйлийн иргэний эрх зүйн зохицуулалтын уламжлал 101

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн докторант Ч.Доржсүрэн

Монгол Улсын иргэний өмчилсөн газрыг нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн албадан чөлөөлөх хуулийн зохицуулалт: Харьцуулсан судалгаа 113

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн докторант Я.Өнөрбаян

Сонгуулийн эрх зүйн антропологи гэж юу вэ? 129

“Ворд Медиа” ХХК-ийн “Өрөг.мн”-ийн үйл ажиллагаа эрхэлсэн захирал, Хууль зүйн бакалавр Э.Тамир (LL.B)

Монголын Криминологичдын холбооны ахлах судлаач, МУИС-ийн ШУС-ийн Нийгмийн ухааны салбарын антропологийн хөтөлбөрийн докторант, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн докторант, Бизнесийн удирдлагын бакалавр (ВВА) С.Номынбаясгалан

Хүүхэд үрчлэлтийг хүчингүйд тооцох эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлах нь	152
<i>ИЗОУИС-ийн багш, докторант А.Батбаатар</i>	
Бие даасан агентлагийн томилгооны эрх зүйн зохицуулалт	167
<i>Хууль зүйн ухааны магистр (LL.M) Б.Төрболд</i>	
Гэмт хэрэг үйлдэхээс татгалзуулах онол (Deterrence Theory): Өсвөр насны хүн	180
<i>Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнгийн хяналтын прокурор Д.Нямбат</i>	
Хүнийг генийг хувилах буюу генетикийн ижил хуулбарыг бүтээх ажиллагааны талаарх хууль зүйн зохицуулалт	187
<i>Докторант Ц.Амарсанаа</i>	
Автомашин ачилтын компаниуд Захиргааны ерөнхий хуульд заасан эрх шилжүүлэн авсан этгээд мөн үү?	201
<i>МУИС-ийн ХЗС-ийн магистрант, УДШ-ийн дэргэдэх ШССМХ-ийн Захиргааны эрх зүйн секторын судлаач Н.Хулан</i>	
Үнэт цаасны зах зээлд дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцох: хариуцлагын тогтолцоо /харьцуулсан судалгаа/	212
<i>Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ажилтан М.Ганди</i>	
Дотоодын болон олон улсын эрх зүй улс үндэстний аюулгүй байдлыг хангах тогтолцооны салшгүй хэсэг болох нь	224
<i>Эрх зүйч С.Уянга</i>	
Гэм буруугүйгээр үүргийн гүйцэтгэлийг биелүүлэх боломжгүй болохтой холбоотой эрх зүйн асуудал	238
<i>МУИС-ийн ХЗС-ийн магисрант М.Уянга</i>	
МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ	
<i>Мэдээ</i>	249

CONTENT

LEGAL THINKING: VIEWS AND REFLECTIONS

- Building an society that has moral value is an important factor in reducing corruption** 12
Javkhlan. T, Police captain, Senior inspector of Metropolitan Police Department. Master's student, School of Law, NUM

IMPLEMENTATION AND EFFICIENCY OF LAW

- Real estate and land compensation, legal regulation of evaluation** 23
Ya. Unurbayan, Ph.D student, School of law, NUM
- Issues related to the rights of child jockeys in Mongolian traditional horse racing and ways to solve it** 34
Bayasgalan.T, Ph.D student, Inner Mongolia University, People's Republic of China

LEGAL RESEARCH OVERVIEW

- Theoretical framework on civil law liability for legal person who avoids the court decision** 47
Ya.Batgerel, Head of the Department of Civil Court Decision Executive Studies, School of Court Decision Executive, University of Internal Affairs, Lieutenant Colonel (LL.M)
- Some reflections on relationship between historical events and theoretical evolution of European community's cartel law** 58
Otgonbayar.Lkh, Senior lecturer, Department of Legal Studies, University of Finance and Economics, Ph.D student, School of Law, NUM
- Issues on the improvement of the legal environment of national security of Mongolia** 75
Zaya.T, Lecturer, Department of International Relations and Social Sciences, University of the Humanities /MA/
- Legal consequences of standard provisions, mandatory and non-mandatory norms of the Labor law** 88
Bolormaa.Yo, Ph.D student, Lecturer at the Department of Private Law, Shihihutag University
- The tradition of civil law regulation of treasure-trove and historical and cultural objects** 101
Dorjsuren.Ch, Ph.D student, School of law, NUM
- The legal regulation on expropriating land owned by citizens of Mongolia for public use: A comparative study** 113
Ya. Unurbayan. Ph.D student, School of law, NUM
- What is the anthropology of electoral law?** 129
Tamir.E, Cooperation director of "Urug.mn" of "Word Media" LLC (LL.B)
Nomynbayasgalan.S, Ph.D student, School of Arts and Sciences, NUM, Ph.D student, School of Law, NUM, Senior researcher of Mongolian Criminological Society (BBA)
- A comparative study of legal regulations for annulment of child adoption** 152
Batbaatar.A, Ph.D student, Ikh Zasag International University

Legal regulations regarding the appointment to the independent agencies	167
<i>Turbold.B (LL.M)</i>	
Criminology deterrence theory: Adolescent	180
<i>Nyambat.D, Public prosecutor of Training and research institute, The State Prosecutor General's Office of Mongolia</i>	
Legal regulation regarding human gene copying or genetic identity	187
<i>Amarsanaa.Ts, Ph.D student</i>	
Are towing companies the subject entities who are granted administrative functions under the General Administrative Law?	201
<i>Khulan.N, Master's student, School of Law, NUM, Researcher, Administrative Law sector; Judicial Training, Research and Information Institute</i>	
Insider trading: Accountability system /Comparative study/	212
<i>Gandi.M, Researcher at the National Legal Institute of Mongolia</i>	
The integration of domestic and international law in national security systems	224
<i>Uyanga.S, Lawyer</i>	
Legal issues related to innocent default	238
<i>Uyanga.M, Master's student, School of Law, NUM</i>	

NOTES

<i>News</i>	249
-------------	------------

ЕРӨНХИЙ ЭРХЛЭГЧИЙН ЗУРВАС



Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс “Хууль дээдлэх ёс” сэтгүүлийн 2023 оны IV улирлын 95 дахь дугаараа уншигч Та бүхэндээ өргөн барьж байна.

“Хууль дээдлэх ёс” сэтгүүл нь хянан магадлагаа бүхий (Peer-reviewed) сэтгүүл гэдгээрээ онцлог бөгөөд бид 2023 онд хянан магадлагаа хийх сэтгүүлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг өргөтгөн ажилласан юм. Ийнхүү сэтгүүлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг хууль зүйн


салбарт бүрт мэргэшсэн эрдэмтэн, багш нараар нэмэгдүүлсэн явдал нь Монгол Улсын хууль зүйн салбар төрөлжин хөгжиж байгаатай нягт холбоотой. Өөрөөр хэлбэл, сэтгүүлд ирүүлж буй бүтээл, нийтлэлүүд нь, иргэн, эрүү, захиргаа зэрэг эрх зүйн суурь харилцаанд хамаарахаас гадна Монгол Улсад шинээр үүсэж хөгжиж буй бусад салбар эрх зүйн харилцаа, цаашлаад салбар дундын шинжлэх ухаанд хамаарах нь олонтаа байгааг тэмдэглэх нь зүйтэй. Цаашид ч Монгол Улсын хууль зүйн салбар ийнхүү илүү төрөлжин хөгжиж, нарийн мэргэшил бүхий нягт нямбай хуульчид олноор мэндэлнэ гэдэгт итгэлтэй байна.

Өндөр түвшинд мэргэшсэн эрдэмтэн, судлаачдын санал, зөвлөмж нь сэтгүүлийн төдийгүй хууль зүйн салбарын хөгжилд чухал ач холбогдолтойг энд тэмдэглээд, сэтгүүлийн зөвлөлийн гишүүнээр ажиллаж, бүтээл бүрт хянан магадлагаа хийн өөрсдийн мэдлэг оюунаа харамгүй хүртээдэг сэтгүүлийн зөвлөлийн гишүүддээ Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хамт олны өмнөөс гүнээ талархал илэрхийлье.

Хууль зүйн шинжлэх ухааны салбарыг хөгжүүлэхэд гар бие оролцон яваа нийт эрдэмтэн багш, судлаач, зохиогч, эрхэм уншигч Та бүхний эрдмийн их үйлсэд өндөр амжилт хүсэн ерөөе.

Хүндэтгэсэн,

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ,

ХУУЛЬ ЗҮЙН УХААНЫ ДОКТОР  Х.ЭРДЭМ-УНДРАХ (Dr.jur)

ЁС СУРТАХУУНТ НИЙГМИЙГ БҮТЭЭХ НЬ АВЛИГА БУУРАХ ЧУХАЛ ХҮЧИН ЗҮЙЛ БОЛОХ НЬ



Т.Жавхлан

*Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Хэв журмын хэлтсийн ахлах байцаагч,
цагдаагийн ахмад, МУИС-ийн ХЗС-ийн магистрант*

ТОВЧЛОЛ:

Түүхэнд нэгэн цагт Монголчууд биднийг хүн чанартай, ёс суртахуунтай гэгдэж байсан үе байжээ. Тодруулбал, Чингис хааны хаанчлалын үед амьдарч байсан монголчуудын нийтээрээ даган хүндэлсэн сайн сайхан зан чанаруудын тухай гадны аялагч, судлаачид олонтаа бичсэн байдаг. Гэвч өнөөгийн бидний хувьд нийтийг боддог бус амин хувиа хичээгсэд олширч, зан ааш нь харгис догшин, хар муу санаагаар дүүрэн болжээ. Ийм зан үйлийн нэг нь нийгмийн зөв зохион байгуулалтыг аажмаар эвдэж, хүн ардынх нь ахуй амьдралыг доройтуулж байдаг авлига гээч зүйлтэй холбогдоно. Авлигыг хууль тогтоомж, түүний хэрэгжилтийг сайжруулснаар илрүүлж, хор уршгийг нь арилгах гэж хичээх боломж бий ч энэ нь урт удаан хугацаанд авлигатайгаа хамт орших сонголт юм. Харин авлига өгөх, авах явдлыг дорвитойгоор буулгах, авлигын хөрс суурийг арчин хаяхын тулд бид ёс суртахуун сэргэн цэцэглэх хөрс суурийг бүрдүүлэх замаар ёс суртахуунт байдлыг нэмэгдүүлэх ёстой.

ТҮЛХҮҮР ҮГС:

Авлига, ёс суртахуун, авлига ба ёс суртахуун, нийгмийн хөгжил, ёс суртахуун хөгжих суурь

I. ОРШИЛ

Нийгэмд гарч буй бүхий л зүйлс бол хүний оюун санаа, ухамсарт байдлын үр дагавар юм. Өөрөөр хэлбэл, сайн болоод муу нь ч адил бидний ухамсарт байдлын бүтээл юм. Гэмт зан үйлүүд, үл үзэгдэх болон үл илрэх муу сэтгэлүүд бүгд бидний ухамсарт байдаг учраас үүнийг зогсоох, өөрчлөх боломжтой гэсэн итгэл үнэмшил ч бидэнд төрж байдаг. Зогсоож, өөрчилж болох нийгмийн энэхүү үзэгдлүүдийг яагаад бид үл хайхран орхиод байна вэ? Хувь хүний асуудал, ёс суртахуунтай байх үгүй нь хүний өөрийнх нь сонголт гэж үзсэнээс болдог байж болох юм. Н.Лүндэндорж “Jurisprudence: Эрх зүй судлал” номондоо нэгэнтээ: “Ёс суртахуун болон шашны хэм хэмжээ хүний эрх чөлөөний хэмжээг өөр өөрийнхөөрөө: “энэ бол буруу” эсвэл “энэ бол буянтай” гэх зэргээр үнэлдэг. Гэтэл эрх зүй хүний эрх, эрх чөлөө, шударга ёс гэсэн үнэт зүйлд тулгуурладаг” гэсэнчлэн бид зөв, буруугийн тухай ойлголтыг хувь хүмүүсийн ёс суртахуунлаг байдалд итгэн үлдээж, хүний эрх, эрх чөлөөг,

мөн түүнчлэн шударга ёсыг хамгаалахаар өнөөгийн эрх зүйн тогтолцооны гүн далайд орчихжээ. Тийм учраас хүмүүсийн бурууг хийгээд байгаа алдаатай ухамсрыг засаж залруулж чадахгүйгээр гэмт хэрэгтэй улайран тэмцсээр байна.

Ёс суртахууны хэм хэмжээ нь сайн болон муу, зөв болон буруугаа зохицуулж, удирдаж чаддаг байх аваас муу болоод буруугаар нэгнийхээ эрх, амгалан тайван байдалд халдаж буй үйлдлийг багасгаж, магадгүй зогсоож болох юм. Өөрөөр хэлбэл, бид сайн сайхан зан чанар, зөв үйлд үр хүүхдээ болоод өөрсдийгөө сурган өнөөдрийн байгаа нөхцөл байдлаа өөрчилж чадах аваас буруу үйлээс холдох боломжтой. Авлигын гэмт хэргийг бид хууль тогтоомжоос гадна буюу ёс суртахууны хэм хэмжээгээр, мөн түүнчлэн эрх зүйн хэм хэмжээгээр буюу хууль тогтоомжийн үүрэг оролцоотой зэрэгцүүлэн хэрэгжүүлэх нь зүйтэй. Өнөөдрийн адил гагц хууль, дүрэм журамд найдан явж үл болно.

Энэхүү судалгааны ажлаар авлига гэх гэмт зан үйл, гэмт хэргийн цаад уг сурвалж нь ёс суртахуунгүй байдалтай нягт холбоотой болохыг илрүүлж, нийгэмд гарч буй авлигатай дан ганц хуулиар тэмцэх бус ёс суртахуунгүй байдлыг зогсоох өөр арга хэмжээг авч хэрэгжүүлснээр тус гэмт хэргийн тоо буурч, нийгэмд өөрчлөлт бий болох боломжтой гэдгийг батлан харуулахыг зорилоо. Авлига болон түүнд холбогдох хууль тогтоомжийн талаарх асуудлыг судлаачид олноор бичиж, судалсан байдаг. Гэсэн хэдий ч авлига болон ёс суртахууны холбоо хамаарлын тухай судалгаа манай улсад хараахан хийгдээгүй байна. Үүгээрээ энэхүү судалгааны ажил нь шинэлэг талтай бөгөөд цаашид дараах агуулгыг хөндөн авч үзнэ. Үүнд:

- ёс суртахууны тухай ойлголт, ёс суртахуунт байдал бүрдэх хөрс суурь
- ёс суртахуунгүй нийгэм ёс суртахуунтай болон өөрчлөгдөх боломжтой эсэх
- авлига ба ёс суртахуунгүй байдлын холбоо хамаарал
- авлигын индексээр тэргүүлдэг буюу авлигын гэмт хэрэг бага гардаг улс орнуудад нийтлэг байдаг онцлог зэрэг болно.

II. ҮНДСЭН ХЭСЭГ

A. Чингис хааны хаанчлалын үеийн Монгол Улс дахь авлига, түүнтэй төсөөтэй үйлдлийн талаар авч хэрэгжүүлж байсан бодлого

Монголчууд бидний хувьд олон мянган жилийн туршид ард түмнийхээ ахуй амьдрал, нийгмийн харилцааг зохицуулахаар бий болгосон хууль цаазын арвин их судлагдахуунтай билээ. Тэр дундаа Чингис хааны хаанчлалын үеийн хууль цааз, Монголын нууц товчоо болон тэдгээрт холбогдох бусад баримт бичиг нь судалгааны чухал ач холбогдолтой юм. Өгүүллийн энэ хэсгээр Чингис хааны болон түүнийг тэнгэрт хальсны дараахан үеийн (Чингис хааны дараагаар түүний үйл хэргийг үргэлжлүүлсэн Өгөдэй¹ хааны хаанчлалын үеийн) монголын нийгэм дэх авлигатай төсөөтэй үйлдэлд авч хэрэгжүүлдэг байсан бодлого, тус нийгмийн онцлог байдлын тухай авч үзэх бөгөөд Чингис хааны бүтээн байгуулсан нийгэм нь ёс суртахуунт байдал дэлгэрэх хөрс суурийг сайтар тавьж чадсаны үрээр иргэд нь сайн зан чанарыг эрхэмлэх болсон тухай, ёс суртахуунт байдал бүрдэх хөрс суурь нь юу байх, ёс суртахуунгүй нийгэм ёс суртахуунтай болон өөрчлөгдөх боломжтой эсэх гэсэн асуултаудад хариулт өгнө.

Монголчуудын ахуй амьдрал, ёс журмыг харуулсан нэн тэргүүний эх сурвалж нь Монголын нууц товчоо бөгөөд тус бүтээлийн 153 дугаар зүйлд² нийтэд оногдох, хуваан хэрэглэвэл зохих олзыг ганцаар эсвэл цөөхүүлээ хүртсэнд хариуцлага оногдуулж байсныг батлах дараах зүйл бичигджээ.

¹ Өгөдэй хааны хаанчлалын үеийг судалгааны объектод хамруулсан шалтгаан нь Монголын Нууц Товчооны тодорхой хэсэг тус хааны хаан ширээнд суун үйл хэргээ явуулсан үеийг багтаасантай холбоотой юм. Тиймээс бид зөвхөн Монголын Нууц Товчоонд тусгагдсан агуулгын хүрээнд Өгөдэй хааны хаанчлалын үеийн авлига, түүнтэй төсөөтэй үйлдэлд авч хэрэгжүүлж байсан бодлогыг авч үзнэ.

² Ж.Лувсандорж, *Монголын нууц товчоон (Монгол Улсын Нууц Түүх)*, Уб, Бэмби сан, 2014, 53-54 дэх тал.

Тэр өвөл өвөлжиж Нохой жил (1202), намар нь Чингис-Хаан Цагаан-Татаар, Элч-Татаар, Дутууд, Арухай-Татаар – эдгээр татаар [аймгууд]-тай Далан-Нөмөргөст байлдав. Байлдахын өмнө Чингис-Хаан, байлдааны дэг журам тохиролцсон нь: ~ Дайсан хүмүүнийг дарваас олзонд бүү саатъя. Даран барваас тэр олз биднийх буй-заа. Хуваалдана бид. Бид эсрэг этгээдэд няцаагдвал анх довтолсон газартаан эргэж ирье. Анхны довтолсон газартаан эс эргэсэн хүнийг алья~ гэж тохиролцов. Далан нөмөргөст хатгалдаж, татаарыг зугтаалгав. Нэхэн хөөж Улхуй-Шилүгэлжидэд-улст нь нийлүүлж эзлэн авав. Цагаан-Татаар, Элч-Татаар, Дутууд-Татаар, Арухай-Татаарын эрхтэн-дархтныг (язгууртан) тэнд сөнөөх тэр байлдаанд, Алтан, Хучар, Дааридай гурав үгстээн үл хүрэн, олзонд саатжээ. Тохиролцсон дэг журмыг эс дагаж, хэлэлцсэн үгстээн үл хүрэн гэж Зэв Хубилай хоёрыг илгээж, тэдний олзолсон адуу, авсан юм бүхнийг авхуулав.

Мөн түүнчлэн, Монголын нууц товчооны 280 дугаар зүйлд Өгөөдэй хаан өртөөнд хэрэглэгдэх мал идээ, хүн хүчийг хэрхэн гаргах талаар зөвшилцөн хэлэлцсэн тухай байдаг. Энд ямар ямар зүйлийг гаргах тухай заан хэлэлцээд “... Улааны агт, шүүсний хонь, саалийн гүү, тэргэнд хөллөх үхэр, тэрэг тэргүүтнийг эндээс бидний хэмлэсэн (хэмжиж тогтоосон) хэмээс

Охор уяа дутуулаас

Оргилоор хагас алдалтан болтугай!

Халбаган хигээс дутуулаас

Хамар хагас алдалтан болтугай хэмээн зарлиг болов”³ гэсэн байдаг. Энд хамар хагас алдалтан болтугай гэдэг нь тухайн хүний хөрөнгийн хагасыг албан татварт авч торгохыг битүү ёгтоор хэлсэн үг⁴ гэж тайлбарласан байдаг. Энэхүү зүйлүүд нь төрийн өмчид хамаарах, нийтээрээ хүртвэл зохих хөрөнгийг хувийн ашиг сонирхолд ашиглуулахгүй байхыг зорилгоо болгосон байх ба энэ утгаараа өнөөгийн нийгэм дэх авлигын гэмт хэргүүдтэй холбогдож байна. Г.Совд нарын “Монгол хууль” номд “Нууц товчооны 280-р зүйлд дурдсаныг нягтлаваас, өртөөний асуудлыг төр захиргааны хууль зүйлээр зохицуулж байсан боловч өртөөнд хэрэглэгдэх эд зүйлсийг чухалд үзэж түүнийг алга болгох, дутаах зэргээр үрэгдүүлбэл эрүүгээр шийтгэхээр хуульчлан тогтоосон нь тэр үед өртөөний албыг хэрхэн чухалд үзэж байсны нотолгоо юм”⁵ гэжээ. Энэ нь мөн л өөрт үл хамаарах эд хөрөнгөнд шунах, өртөө хариуцсан хүн бол хариуцлага алдахыг үл зөвшөөрдөг байсныг дахин нотлон харуулсан буюу ёс суртахуунтай байхыг далдуур уриалсан арга хэмжээ болохыг харуулж байна.

Харин Их засаг хуульд засаг захиргааны байгууламжийг эмхлэн тогтоож олон ноёдыг шат дараалан томилж зохих албан тушаалтныг буй болгосон явдалтай холбогдуулан “аливаа албан тушаалыг өөрийн дураар хэн нэгэн хүнд шилжүүлж болохгүй. Энэ заалтыг ямар нэг байдлаар зөрчвөл “хатуу ял шийтгэл оногдуулна”⁶ гэж заажээ. Түүнчлэн улсын дотор юу болж байгаа хийгээд ямар чухал ажил үүрэг тавигдаж буйг нийтээрээ мэдэж байхад зориулан байнгын өртөөг байгуулах хэрэгтэй. Төр улсын хүчирхэг байхын уг сурвалж нь “ноёд түшмэд, цэрэг байлдагч, жич хөтөч, зарц хүртэл тус бүрийн тушаалд сууж хүлээсэн үүргээ шударга сайнаар гүйцэтгэх ёстой. Тийм байвал мөнх тэнгэрийн хүчинд их үйлс бүтээнэ”⁷ гэжээ. Мөн түүнчлэн, тус хуульд хадгалуулсан эд хөрөнгийг удаа дараа үрэгдүүлснийг эрүүгийн хуулийн холбогдолтой заалтуудад оруулсан байдаг.⁸ Эдгээрээс бид ногдуулсан үүрэг хариуцлагыг ёс төртэйгөөр, хариуцлагатайгаар биелүүлэх

³ Эмхтгэж редакторласан Д.Оюунбадрах, *Монголын сонгодог бичгийн уран зохиолын гурван оргил, тууль- I*, Уб, Болор судар, Мөнхийн үсэг, 2009, 80 дахь тал.

⁴ Мөн тэнд.

⁵ Г.Совд нар, *Монгол хууль*, Уб, education company, 1997, 15-16 дахь тал.

⁶ Г.Совд нар, *Монгол хууль*, Уб, education company, 1997, 23 дахь тал.

⁷ Мөн тэнд.

⁸ Мөн тэнд.

ёстой гэж сургаж байсныг харж болохоор байна. Энэ нь өнөөгийн төрийн албан хаагчдын ажил үүргээ шударга сайнаар гүйцэтгэж, хээл хахуулиас ангид байх ёстой гэх өнөөгийн хууль тогтоомжтой дүйж байгаа юм.

Ийнхүү дээр дурдсанчлан муу үйлийг хориглосон хатуу чанга хууль цааз үйлчилж байсны хамт Чингис хааны хаанчлалын үед амьдарч байсан монголчуудыг ихэд ёс суртахуунтай хэмээн үзэж, нийгэм тэр чинээгээрээ тайван амгалан, сайн сайхан байсан тухай дурдсан бүтээлүүд олон байдаг. Жишээлбэл, Чингис хааны хаанчлалын үеийн монголчуудын шударга буюу ёс суртахуунтай байдлыг илтгэх нэгэн баримтыг академич С.Нарангэрэл⁹ “Чингис хааны ёс суртахуун – эрх зүйн шастир” бүтээлдээ оруулсан байна. Үүнд:¹⁰

Нэгэн өдөр Чингис хаан Их Монгол улсын заргач Шихихутугыг дуудан ирүүлээд түүнд алтан тоногтой ногт өгөөд – Энэ алтан ногтыг олны хөлийн газар, хүний нүдэнд харагдахуйц газар, зам дээр тавьчихаад ир гэв. – Их эзэн та яах гэж байгаа юм бэ? хүн авчихгүй биз хэмээн Шихихутаг ихэд гайхан асуув. Чингис хаан өгүүлрүүн – Хишигтнээр алсаас сайтар харуул, түүнийг авсан, аваагүй нь хамаагүй, бүгдийг нь бариад над дээр авчирна шүү гэжээ. Шихихутуг – Дөрвөн хүн хажуугаар нь өнгөрсөн боловч хэн нь ч авсангүй шүү хэмээн Чингис хаанд айлтгаад нөгөө дөрвийг оруулж ирэв. – Энэ алтан ногтыг харсан уу? хэмээн Чингис хаан эхний хүнээс асуув. – Харсан, хаантаан гэж тэр хариулав. Чингис хаан – Их үнэ цэнэтэй эд гэдгийг чи мэдээгүй юм гэж үү гэхэд – Мэдсэн. Их хаантаан, алтан тоногтой эд байсан шүү дээ хэмээхэд – Тэгээд чи яагаад аваагүй юм бэ? гэж асуухад нөгөө хүн толгой сэгсрэн – Би яахан зориглох билээ. Алдаж гээгдүүлсэн эд зүйлс анхны эзэндээ очих учиртай, хэрэв түүнийг олоод өөртөө авсан, нуун дарагдуулсан бол толгойгүй болгоно гээд Их засагт заачихсан байдаг шүү дээ гэв.

Чингис хаан – Чи яагаад аваагүй вэ? хэмээн хоёр дахь хүнээс асуув. – Надад тэр ногтноос дутахааргүй ногт байгаа л даа. Намайг найман аймагтай зоригтой дайтсан гэж манай мянганы ноён шагнасан юм л даа гэж хариулав.

Чингис хаан гуравдахь хүнээс – Өөрт чинь арай бүр илүү үнэ цэнэтэй ногт байгаа юм биш биздээ гэж асуухад тэрбээр – Үгүй ээ, их хаантаан, би дараа дайлаар мордохдоо түүнээс илүүг олоод авна шүү дээ хэмээн хариулав.

Чиний хувьд? Хэмээн дөрөв дэх хүнээс эзэн хаан асуухад – Энэ бол миний эд зүйл биш. Өөрийн бус зүйлийг авна гэдэг гутамшигтай хэрэг. Нэгэн удаа Жүрхэдийн Сачабэхийн нөхөр Хатигдай алтан ногт хулгайлаад баригдсан гэсэн. Тэр үед хаан эзэн та хулгай тонуул хийхийг яс махнаасаа үзэн яддаг учраас бидний хэрэглэх зүйлс өөрсдийн ариун хөдөлмөрийн үр шим байх ёстой. Гэтэл хулгайч луйварчид хөлс хүчээ гаргаагүй байж, бусдын зүйлсийг зүй бусаар авч, хүмүүсийг сорон мөлждөг. Тийм болохоор хар хэрээ шиг тийм хулгайч луйварчдыг газартай тэгшлэх хэрэгтэй хэмээн Таны айлдсаныг би дуулсан юм л даа гэж хариулав.

Чингис хаан Шихихутуг руу харан инээмсэглэн – Ийм шулуун шударга ард иргэдтэй юм чинь, би, бид ер нь одоо юундаа алзах вэ?, “Аливаа хүний шударга нь дэгжинэ” гэдэг чухамдаа үнэн шүү, Хөх Монгол эдүгээ мандан бадрахаас өөр яахав дээ хэмээн бахархалтай айлдсан гэдэг.

Өмнө дурдсанчлан дээрх баримт нь Чингис хааны хаанчлалын үеийн нийгмийн амар тайван, ёс суртахуунлаг байдлыг илтгэж байна. Гэтэл Чингис хаан удирдан чиглүүлэхээс өмнө манай монголчууд тийм ёс журамтай, ёс суртахуунлаг байгаагүй тухай академич С.Нарангэрэлийн “Чингис хааны ёс суртахуун - эрх зүйн шастир” бүтээлд дурдсан байна. Тус бүтээлд “... бэлэг сэлт авахыг Чингис хаан хатуу хориглож байсан нь цаанаа их учиртай

⁹ Монгол Улсад Чингис хааны үеийн хууль цааз, нийгмийн онцлогыг судлан хамгийн олон бүтээл туурвил хэвлүүдсэн байдаг судлаач нь академич С.Нарангэрэл билээ. Мөн түүнчлэн, энэхүү судалгааны агуулгыг нотлох баримтууд түүний бүтээлд илүүтэй байсан тул түүний бүтээлийг судалгаандаа эш татан оруулахаас өөр аргагүй байсныг дурдах нь зүйтэй.

¹⁰ С.Нарангэрэл, *Чингис хааны ёс суртахуун- эрх зүйн шастир*, УБ, Адмон, 2014, 29-30 дахь тал

юм билээ. Яагаад гэвэл монголчууд бэлэг сэлтийг эрээ цээргүй авах, гар харах явдал газар авсан учраас түүнийг таслан зогсоход Чингис хаан онцгой анхаарч байжээ. Энэ тухай Плано Карпини “... хаад, ноёд нь ч тэр, бус хүн нь ч тэр, эрхтэн язгууртан нь ч тэр, энгийн хүн нь ч тэр, биднээс их бэлэг сэлт нэхэх бөлгөө. Бэлэг сэлт өгөхгүй бол тэр элчийг дорд үзээд зогсохгүй, хүн ч гэж үл тооно” хэмээгээд “Эд хөрөнгө, уналга ачлага тэр ч бүү хэл хүн хүртэл бүх юм эзэн хааны юм болдог бөгөөд энэ тухай саяхан хааны зарлиг ч гарсан гэдгийг мэдвэл зохилтой” хэмээн бичсэн байдаг¹¹ гэжээ. Үүнээс бид аливаа хүн, үндэстний зан чанар өөрчлөгдөн хувьсаж болох бөгөөд гагцхүү зөв удирдлага, зөв арга замыг олж чадвал өнөөгийн хувийн ашиг сонирхлоо бодсон үйлдлүүд үгүй болж болно гэдгийг харж болох юм.

Чухам хэрхэн тухайн үеийн хүн ард сайн үйлийг дээдлэн биширч, мууг үйлдэхээс ямагт зайлсхийдэг болсон бэ гэдэг нь бидний анхаарлаа хандуулвал зохих зүйл мөн. Хатуу чанга хууль цааз нөлөөлсөн үү? Чингис хааны бүтээсэн энэрэнгүй нийгэм, зөв удирдлагын арга¹² нөлөөлсөн үү? гэвэл аль аль нь орох биз ээ. Өнөө цагт хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж байгаа ч түүнийг сахин биелүүлэх ухамсаргүй хүмүүс олширч, хуулийг мөрдөн сайхан амьдрах боломж ч хомс болсноор хулгай, дээрэм, авлига ихэссээр байгаа. Тэгэхээр дээрх баримтуудаас харахад Чингис хааны хаанчлалын үед, зөв шударгаар хүн таатай амьдрах боломжтой нийгмийг бүтээж чадсанаараа ард иргэд нь ч сайн сайхан зан чанарыг эрхэмлэх болсон нь гарцаагүй байна. Сайн сайхан, зөв шударгыг эрхэмлэнэ гэдэг нь хээл хахууль зэрэг мууг үгүйсгэнэ гэсэн үг билээ.

“Эрх зүй, ёс суртахууны аль аль нь хүмүүсийн зан байдлыг зохицуулах талаар адил төстэй зүйл байхын хамт нэг нь нөгөөгөөсөө ялгаатай”¹³. Тийм учраас өнөөгийн нийгмийн авлигыг хууль тогтоомжийг хэрэгжүүлснээр бууруулах арга зам нь алдаатай болж байна. Хууль тогтоомжоос гадна ард иргэдийнхээ амьдралын чанар, зөв сайхнаар амьдрах боломжийг нь бий болгож ёс суртахуунт байдалд нь анхаарснаар бид авлига гээч зүйлийг бууруулж чадах юм. Азийн сан болон Сэнт-Мааралын сангийн 2018 оны “Авлигын талаарх мэдлэг, хандлага”¹⁴ судалгаанд дурдсанаар манай улсад авлига нь ажилгүйдлийн дараа орох хоёр дахь хамгийн ноцтой асуудал байгаа ч өдөр тутам гардаг жижиг авлига тогтвортой бууралттай байгааг дурджээ. Ийнхүү буурсан шалтгаан нь олон нийтийн авлигын талаарх ойлголт, хандлага өөрчлөгдсөнтэй холбоотой байна. Өөрөөр хэлбэл авлигын хор хөнөөлийг таниулах талаар олон нийтэд зориулагдан хийгдсэн ажлууд нь эерэг өөрчлөлтийг бий болгожээ. Тодруулбал, 2006 онд зарим төрлийн авлигыг хүлээн зөвшөөрч болно гэсэн асуулгыг судалгаанд хамрагдагсдын 41.8% хүлээн зөвшөөрөөгүй бол 2018 онд 54.7% болж авлигыг эсэргүүцдэг иргэдийн тоо нэмэгдсэн байна. Мөн түүнчлэн, хээл хахууль өгөхгүй гэсэн итгэл үнэмшилтэй хүмүүсийн тоо ч 28.7 хувиас 46.9% болтлоо өсчээ. Энэ нь хэрхэн олон нийтийн санаа бодол өөрчлөгдөж болдгийг, аливаа зүйл буруу гэдгийг ойлгуулснаар хэрхэн сайн зүйлс дэлгэрч болдгийг харуулсан жишээ байна.

Дээрхийг нэгтгэн дүгнэвэл чин шударгаар сайхан амьдрах боломжтой нийгмийг бүтээсэн нь ёс суртахуунтай байдал нэмэгдэх үндэс суурь нь болжээ. Ёс суртахуунт байдал зөв, шударга байсныхаа шагналд таатай амьдрах боломжтой тийм л нийгэмд оршдог юм. Чингис хааны зөв удирдлага, зөв нийгмийн байгуулал нь тухайн ард түмнийг сайн үйлсэд хөтлөн, ёс суртахуунтай болон хувирахад хамгийн их нөлөөлсөн гэж үзэхэд буруудахгүй биз ээ.

¹¹ С.Нарангэрэл, *Чингис хааны ёс суртахуун- эрх зүйн шастир*, Уб, Адмон, 2014, 133-134 дэх тал.

¹² Энэ талаар академич С.Нарангэрэлийн Чингис хааны ёс суртахуун- эрх зүйн шастир бүтээлээс дэлгэрүүлэн унших боломжтой.

¹³ Монгол Улсын их сургуулийн хууль зүйн сургуулийн багш нарын хамтын бүтээл, *Монгол Улсын төр, эрх зүйн үндэс*, сурах бичиг, нэмж зассан хоёр дахь хэвлэл, Уб, 2000, 47 дахь тал.

¹⁴ Энэхүү судалгааны үр дүнг Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас гаргасан “Монгол Улс дахь авлигын эсрэг шинэчлэлт” тайлангаас авав. OECD, Anti-corruption reforms in Mongolia, 4th round of monitoring of the Istanbul Anti-corruption Action Plan, 2019 https://www.transparency.mn/files/ugd/d84145_0b92effcc039467a915c9350b996f85d.pdf [Сүүлд үзсэн: 2023.11.28]

В. Авлигын гэмт хэргийг ёс суртахуунт байдлыг дэлгэрүүлснээр бууруулах нь

Өгүүллийн энэхүү хэсгээр юун түүрүүн ёс суртахуун, авлига гэж юу болох, яагаад хүмүүс авлига өгч, бас авдаг шалтгааныг тодруулах замаар авлига нь хэрхэн ёс суртахуунгүй байдалтай холбогдож буйг тодорхойлох юм. Эцэст нь аливаа нийгэм авлигын гэмт хэргийг ёс суртахуунтай байдал цэцэглэх нөхцөлийг бий болгосноор бууруулж, багасгах боломжтой гэсэн аргументыг батлахыг зорино.

“Ёс суртахуун (morality)” гэдэг ойлголтыг Кэмбрижийн толь бичигт¹⁵ 1. Зөв, шударга, хүлээн зөвшөөрөгдөхүйц байх чадвар 2. Сайн эсвэл муу зан чанарын талаарх хувь хүний эсвэл нийгмийн стандартын цогц хэмээн тайлбарласан байдаг. Харин Стэнфордын философийн нэвтэрхий тольд үгийн мөн чанараараа morality¹⁶ гэх үг нь 1. Аливаа нийгмийн 2. Шашин гэх мэт зарим бүлгийн 3. Хувь хүний өөрийн зүгээс бий болгосон/хүлээн зөвшөөрсөн зан байдлын код буюу дүрэм юм гэсэн байх бол норматив талаас нь авч үзвэл бүхий л саруул ухаант хүн дагаж мөрдөхөөр тодорхойлон тогтоосон зан үйлийн нийлбэр юм гэжээ. Монголчуудын хувьд “ёс суртахуун” гэх ойлголтыг хүнд байж болох бүхий л сайн зан чанарууд хэмээн үздэг. Жишээлбэл, академич С.Нарангэрэл “Чингис хааны ёс суртахуун – эрх зүйн шастир” бүтээлийнхээ “Чингис хааны ёс суртахуун”¹⁷ гэсэн гарчиг бүхий дэд хэсэгтээ шударга ёс, эр зориг, ичих ба эмээх сэтгэл, үүрэг ба хариуцлага, жудаг, нинжин ба өрөвч сэтгэл, нэр төрөө эрхэмлэх, үнэн байх, итгэл хүлээх, тэсвэр тэвчээртэй байх, эв эеийг эрхэмлэх, өгөөмөр сэтгэл, үл хомхойрох, атаа хонзон эс өвөрлөх, найрсаг зочломтгой зан зэргүүдийг багтаасан байдгаас харж болно. Мөн түүнчлэн, ёс суртахууны үндсэн ойлголтууд нь сайн муугийн тухай, шударга ёсны тухай, үүрэг хариуцлагын тухай, аз жаргалын тухай, амьдралын утга учрын тухай, чин эрмэлзлэлийн тухай ойлголтууд юм.¹⁸

Харин “авлига” гэх ойлголтыг “Транспэрэнси Интернэшнл” төрийн бус байгууллага (ТББ)-аас тодорхойлохдоо “Авлига гэдэг нь итгэж хүлээлгэсэн эрх мэдлийг амин хувийн сонирхлоор ашиглах явдал юм. Авлигын өртөг, өртөгдсөн салбараас хамаарч жижиг авлига, өндөр түвшний авлига, улс төрийн авлига гэх төрлүүдтэй байж болно”¹⁹ гэжээ. Үүнээс жижиг авлига (petty corruption)-ыг²⁰ эмнэлэг, сургууль, цагдаагийн байгууллага болон бусад төрийн байгууллагуудтай харилцахдаа сайн үйлчилгээ авч, өөрийн хэрэгцээг хангах зорилготой энгийн хүмүүстэй харилцаанд орж буй төрийн албан хаагчдын хууль бус үйлдэл гэж үзсэн байдаг бөгөөд улс төрийн авлига (political corruption)²¹ бол өөрсдийн эрх мэдэл, байр суурь, эд баялгаа хадгалах, нэмэгдүүлэхийн тулд баялгийн хуваарилалт, санхүүжүүлэлтийн шатанд бодлогын, институцийн болон дүрэм журмын өөрчлөлт хийн зөрчил, хууль бус үйлдэл гаргаж буй хууран мэхлэлт юм гэжээ. Харин өндөр түвшний авлига (grand corruption)²² нь олонхын эдлэх, хүртэх ёстой сайн сайхныг цөөнх хүртэн бусад хувь хүн болон нийгэмд маш ноцтой хохирол учруулдаг ч ихэвчлэн хариуцлага, шийтгэл хүлээхгүй өнгөрдөг өргөн эрх мэдэлтнүүдийн хуулийг зөрчсөн үйлдэл байдаг гэж авлига болон авлига өгөх, авах үйлдлийн шалтгааныг тодорхойлон, тайлбарласан.

Авлигын учруулж буй хор хөнөөлийг тус байгууллагаас тайлбарлахдаа авлига нь нийгэмд маш олон замаар нөлөөлдөг бөгөөд хамгийн золгүй байдал нь хүний амь, түүнээс наана хүмүүсийг эрх чөлөө, эрүүл мэнд, санхүүгийнх нь хувьд хохироодог гэсэн байдаг. Цааш авч үзэхдээ авлигын хор хөнөөлийг, учруулах хохирлыг улс төрийн, эдийн засгийн,

¹⁵ <https://dictionary.cambridge.org/dictionary/english/morality> [Сүүлд үзсэн: 2023.11.30]

¹⁶ <https://plato.stanford.edu/Archives/Win2012/entries/morality-definition/> [Сүүлд үзсэн: 2023.11.30]

¹⁷ С.Нарангэрэл, *Чингис хааны ёс суртахуун- эрх зүйн шастир*, УБ, Адмон, 2014, 3-4 дэх тал (номын агуулга).

¹⁸ Б.Оюунчимэг, *Ёс зүй: Ёс суртахууны тухай ном*, нэмж, засварласан дөрөв дэх хэвлэл, УБ, Бемби сан, 2019, 78 дахь тал.

¹⁹ “Транспэрэнси интернэшнл Монголиа” ТББ-ын албан ёсны цахим хуудас. <https://www.transparency.mn/avliga-gezhi-yuu-ve>

²⁰ Мөн тэнд.

²¹ Мөн тэнд.

²² Мөн тэнд.

нийгмийн болон хүрээлэн буй орчны гэж 4 бүлэгт хуваажээ. Улс төрийн хувьд бол авлига нь ардчилал, хуулийн засаглалын хамгийн том дайсан байдаг бол эдийн засгийн хувьд үндэсний баялгийг багасгаж байдаг. Харин нийгэмд улс төрийн тогтолцоонд иргэдээс итгэх итгэлийг үгүй хийдэг байхад хүрээлэн буй орчны хууль тогтоомжийг зохих ёсоор хэрэгжүүлээгүйгээс байгаль орчны сүйрэл бий болох аюул нэмэгдэж, байгалийн баялаг хурдацтай багасаж байдаг.²³ Ингээд үзэхээр авлига олон салбарыг хамарч байдаг туйлын хор хөнөөлт үзэгдэл яахын аргагүй мөн билээ.

Ёс суртахууны хариуцлагатай байдал нь авлигаас татгалзах үндэслэл гэж үзэж болох уу?²⁴ гэсэн гарчигтай авлигын нөхцөл байдалд хүмүүсийн ямар үйлдэл гаргахыг туршин дүгнэлтээ гаргасан нэгэн судалгаанд өндөр ёс суртахууны хариуцлага хүлээсэн хүмүүсийн авлигын асуудалд өртөх магадлал нь бага, түүнээс хүртэх санхүүгийн ашиг хонжоог илүүд үзэх хандлага ч маш бага байна гэсэн байдаг. Мөн түүнчлэн, шударга байдлыг үнэт зүйлээ гэж үзэх тусам, хүн чанар-шударга байдал нь хичнээн өндөр байх чинээгээр тухайн хүний авлигаас татгалзах, авлигыг жигших сэдэл нь их байна гэсэн санааг дурджээ. Ёс суртахуунт байдлыг хэр хэмжээгээр дэлгэрүүлж, бий болгож чадна төдий хэмжээгээр авлига багасах боломжтойг бид үүнээс харж болох бөгөөд эсрэгээрээ сөрөг үр дагаварт хүргэдгээрээ, зөвхөн өөрийн ашиг сонирхлыг бодон бусдад хор, хохирол учруулдагаараа авлига нь муу буюу ёс суртахуунгүй байдалтай холбогдож байгааг ч төвөггүй харж болно.

Дээр дурдсанчлан авлига бол хувийн ашиг хонжоо олж авахын тулд төрийн эрх мэдлээ хортойгоор ашиглах явдал мөн.²⁵ Түүнчлэн, өөрийн ашиг сонирхлын төлөө албан тушаалтныг ашиглах явдал ч мөн билээ. Ингээд үзэхээр нэг талаар үүрэг хариуцлагаа ухамсарласан, шударга байж чадаагүй хүний тухай, нөгөө талаар зөвхөн өөрийгөө бодогч буюу хувиа хичээгчийн тухай ойлголтууд гарч ирж байгаа юм. Академич С.Нарангэрэл хэлэхдээ: “Нийгэм бүхэлдээ ёс суртахууны уналт ялзрал доройтолд ороод хүн хамгийн аюултай адгуус араатнаас ч долоон дор болоод ирэхээр зэрэг л тэр эрүүл саруул хүний ухаанд багтамгүй ноцтой, аюултай, аймшгууд ил гардаг. Тийм учраас гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажлыг ерөөсөө л хүнтэй ажиллах, хүнээ хүн болгохоос (хар багаас) эхлэх хэрэгтэй” гэжээ.²⁶ Энэ нь ёс суртахууныг нийгэмд төлөвшүүлэн гэмт хэргээс урьдчилан сэргийлж, гэмт хэргийн гаралтыг багасгах тухай юм.

Нийгэмд ёс суртахуунаас гадна эрх зүйн хэм хэмжээг тусгасан хууль хэрэгтэй ч нийгмийн өргөн хүрээтэй, олон төрөл хэлбэртэй харилцааг дан ганц хуулиар зохицуулах боломжгүй байдаг.²⁷ Нийгмийн өдөр тутмын амьдрал, үйл ажиллагаа, харилцааг ёс суртахуун л зохицуулдаг.²⁸ Дээр авч үзсэнчлэн бид ёс суртахуунтай иргэнийг бэлтгэхийн тулд түүнийг бага балчир наснаас нь сургаж, хүмүүжүүлэх ёстой нь зүй юм. Ийнхүү иргэнээ хүмүүжүүлэхдээ боломж хязгаарлагдмал, муу бүхнээр дүүрсэн нийгэм хэвээрээ байх аваас муу нэрийг хусавч арилдаггүйтэй адил зүйл болохыг санах хэрэгтэй. Нууц товчоонд бичсэнээс үзвэл XII, XIII зууны монголчуудын дунд хэлсэн үгэндээ хүрээгүй буюу тангаргаа няцсан, хүн алсан, хаан эзэндээ үнэнч бус хандагсдыг заавал алдаг хатуу журам монголын хаадын дотор үе улиран дамжин ирсэн байна.²⁹ Энэ нь үнэнч шударга байдлыг ихэд чухалчлан авч үздэг байсны жишээ бөгөөд бурууг цээрлүүлдэг энэхүү байдал нь бусдад сургамж болж сайныг дэлгэрүүлэх нэг арга болж байсан. Гэвч бид өнөөгийн ертөнцөд ганц хууль тогтоомжид найдан, муу бүхэн ундрэн гардаг хүний хүмүүжилгүй, мунхаг, хувиа бодогч, шуналтай байдлуудыг өөрчлөх ажлыг хийхгүй байж үл болно.

²³ Мөн тэнд.

²⁴ Tanner C, Linder S, Sohn M, “Does moral commitment predict resistance to corruption? Experimental evidence from a bribery game”, 2022 https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract_id=3530305 [Сүүлд үзсэн: 2023.02.02]

²⁵ Сьюзан Роуз-Аккерман, *Авлига, төр хоёр*, орч. Ц.Цэрэн, Уб, Нэнко пубблишинг, 2007, 125 дахь тал.

²⁶ Р.Дарьхүү нар, *Ёс суртахууны боловсрол*, Уб, Тотопресс, 2020, 6-7 дахь тал.

²⁷ Б.Оюунчимэг, *Ёс зүй: Ёс суртахууны тухай ном*, нэмж, засварласан дөрөв дэх хэвлэл, Уб, Бемби сан, 2019, 13 дахь тал.

²⁸ Мөн тэнд.

²⁹ Г.Совд нар, *Монгол хууль*, Уб, education company, 1997, 11 дэх тал.

Дүрэм журам, хууль тогтоомж нь олон мянган жилийн тэртээгээс л хүмүүсийн зан үйл, зан чанарыг зохицуулагч, түүнийг номхруулагч байсаар ирсэн ч бид яагаад гэмт хэрэггүй, амгалан тайван нийгэмд амьдарч чадахгүй байна вэ? Хүмүүс үнэхээр ял шийтгэл, муу бүхнээс айдаг байсан бол бид өдгөө сайн сайхан бүхнээр дүүрсэн гэрэл гэгээтэй нийгэмд амьдрах байжээ. Гэтэл хүн хариуцлага хүлээх, гутаан доромжлогдохоос айхаас илүүтэй өөрийн хүслээ гүйцээж чадахгүй байх, амьдралаа залгуулах хоолгүй, мөнгөгүй байх зэргээс л айдаг бололтой юм. Маргаашийн хоолны төлөө хулгай хийж, маргаашийн олз ашгийн төлөө авлига авч, өөрийн зорьсон санасныг гүйцэлдүүлэхийн тулд хээл хахууль өгч байгаа нь үнэн билээ. Иймд бид гэмт хэрэгтэй тэмцэхдээ ямар ч нөхцөлд хүнийг муу үйлийг нь сонгодог бус, үргэлж сайн руу нь тэмүүлдэг зан чанар, үнэлэмжтэй болгох хэрэгтэй биз ээ. Өөрөөр хэлбэл, ёс суртахуунтай байх боломж бүхий нийгмийг цогцлоох ёстой юм. Ийм байдлыг бий болгохгүйгээр хүмүүсээс ёс суртахуунтай байхыг шаардах нь утга учиргүй зүйл гэж зохиогчийн зүгээс үзэж байна.

Авлигын индексээр 2022 онд Денмарк, Финланд, Шинэ Зеланд, Норвеги, Сингапур, Швед, Швейцарь, Нидерланд, ХБНГУ, Ирланд, Люксембург, Хонг Конг, Австрали, Канад, Эстони, Исланд, Уругвай, Бельги, Япон, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улс гэсэн 20 улс тэргүүлж байна.³⁰ Улс орнуудыг 0-100 хүртэлх оноогоор дүгнэж 100 оноог авилгагүй буюу маш цэвэр харин 0 оноог маш их авилгажсан гэж үздэг байна.³¹ Дээрх улс орнууд нь 73-90 хүртэлх оноогоор үнэлэгдсэн байх бөгөөд бусад орнуудтай харьцуулахад авилгын гэмт хэрэг хамгийн бага гардаг гэсэн үг юм.³²

Дэлхий нийтээрээ Япончуудыг ёс суртахуунтай, ёс журамтай хэмээн хэлэлцдэг. Авлигын гэмт хэргийн гаралт хамгийн багатай гэгдэх Денмарк улсын хувьд хүн амьдрах таатай нийгмийг бүтээж чадсаныг гэрчлэх аз жаргалын индексээр дэлхийд 2-т³³ жагсдаг. Тус улс нь амьдралын өндөр стандарт, маш сайн хөгжсөн нийгмийн халамжтай бөгөөд нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээгээрээ ч дэлхийд дээгүүр байр (16 дугаар байранд эрэмблэгдсэн³⁴) эзэлдэг.³⁵ Денмаркаас бусад дээр дурдсан улсууд ч мөн дэлхийн 190 орноос нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээгээрээ дараах байруудад³⁶ [Люксембург (3), Сингапур (4), Швейцарь (9), Норвеги (11), Хонг Конг (12), Исланд(14), Нидерланд (15), ХБНГУ (19), Швед (20), Австрали (21), Бельги (22), Канад (24), Финланд (25), Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улс (26), Япон (28), Шинэ Зеланд (32), Эстони (40), Уругвай (62)] орсон байдаг. Энэ нь эдгээр улсууд авлига бий болох нэг үндэс болох эдийн засгийн асуудлыг шийдвэрлэснээр ийнхүү эрэмбэлэгдэх болсныг илтгэж байна гэж үзэж байна. Дээр дурдаж байсанчлан, ёс суртахууны хэм хэмжээг сахидаг иргэдтэй, өндөр ёс зүйтэй албан хаагчидтай байхын тулд бид тус сайн сайхны хөрсийг бий болгож чадах нөхцөл байдлыг бий болгох ёстой юм. Тодруулбал, улс орны эдийн засгийн чадавх нэмэгдэж төрийн албан хаагчдын цалин өндөр байх, иргэдийн амьжиргааны түвшин сайн байх нь санаа зовнил багатай амгалан тайван нийгмийг бүтээх үндсэн нөхцөл яахын аргагүй мөн билээ. Авлига нь хүрээлэн буй орчин, түүх, нийгмийн хөгжлийн бүтээгдэхүүн юм³⁷ гэдгийг эдгээр улсуудын жишээ батлан харуулж байна.

³⁰ Transparency International, World corruption index 2022, <https://www.transparency.org/en/cpi/2022> [Сүүлд үзсэн: 2023.02.08]

³¹ Мөн тэнд.

³² Энэ талаарх дэлгэрэнгүй мэдээллийг <https://www.transparency.org/en/cpi/2022> холбоосоор авах боломжтой.

³³ <https://pumeauniversity.org/world-happiness-index/> [Сүүлд үзсэн: 2023.02.08]

³⁴ GDP per Capita: <https://www.worldometers.info/gdp/gdp-per-capita/> [Сүүлд үзсэн: 2023.02.08]

³⁵ <https://www.britannica.com/place/Denmark/Settlement-patterns> [Сүүлд үзсэн: 2023.02.08]

³⁶ GDP per Capita: <https://www.worldometers.info/gdp/gdp-per-capita/> [Сүүлд үзсэн: 2023.02.08]

³⁷ Грахам Брүүкс, *Авлигын кримнологи: онолын чиг хандлага*, орч.Авлигатай тэмцэх газар, Уб, Урангар пресс, 2021, цахим хувилбар, 30 дахь тал.

III. ДҮГНЭЛТ, САНАЛ

Монголчууд бидний олон мянган жилийн төрт ёсонд сайн ба муу, буруу ба зөвийг ялган зааглаж муу болон бурууг үргэлж цээрлүүлж ирсэн байдаг. Ялангуяа, Чингис хааны хаанчлалын үед зан суртахууны хувьд тийм ч сайн байгаагүй Монголчуудыг нэгтгэн, ёс суртахуунлаг ард түмэн амьдран суурьших боломжийг олгосон нийгмийн байгуулалт, удирдлагыг хэрэгжүүлж чадсанаараа ялгардаг. Чингис хааны энэхүү үйл хэрэг нь одоогийн авлигын индексээр тэргүүлдэг улс орнуудын эдийн засгаа тогтворжуулж, хүн амар тайван амьдрах боломжийг бий болгосон жишээтэй адил юм. Үүнээс бид санаа авч мууг үйлдэх шаардлагагүй, сайнд үргэлж тэмүүлэх боломжтой нийгмийн суурь хүчин зүйлсээ олшруулах хэрэгтэй. Тодруулбал, юун түрүүн бизнесийн байгууллага, хувь хүмүүсийг дэмжих, улс орныхоо эдийн засгийн чадамжийг нэмэгдүүлэх, төрийн албан хаагчдыг авлигад үл өртөх хэмжээний цалинтай болгох зэрэг ажлууд хийгдвэл зохилтой юм. Учир нь авлига бол амин хувийн олз ашгаа нэмэгдүүлэх, хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх гэсэн сэдлээс үүдэлтэйг санууштай.

Ийнхүү нийгмийн суурь асуудлуудыг шийдвэрлэхийн хамт залуу үе болоод бусад үеийнхнийг сайн сайхан зан чанарт сургах төрийн бодлогыг авч хэрэгжүүлэх нь зүйтэй болно. Муу үйл хийх, буруу санаа санах эхлэл бидний уураг тархинд бүрэлдэж байдаг тул хууль тогтоомжийн хатуу аргаар бус хүн байх, хүн болохынх нь хувьд бидэнд өгөгдсөн сайн чанарууд болох ёс суртахууныг сургах, ёс суртахуунт байдлын үнэ цэнийг мэдрүүлэх нь зайлшгүй болоод байна. Гэр бүл, боловсролын байгууллага, амьдран буй орчиндоо мөрдөх ёс суртахууны хэм хэмжээнүүдийг тодорхой болгон нийтэд таниулах ажлыг төрөөс бодлогоор хэрэгжүүлэх ёстой.

ЭХ СУРВАЛЖ

Монгол хэл дээрх

Ном, өгүүлэл, судалгааны тайлан

1. Г.Совд нар, Монгол хууль, Уб, education company, 1997.
2. Сьюзан Роуз-Аккерман, Авлига, төр хоёр, орч. Ц.Цэрэн, Уб, Нэпко павлишинг, 2007.
3. Эмхтгэж редакторласан Д.Оюунбадрах, Монголын сонгодог бичгийн уран зохиолын гурван оргил, тууль- I, Уб, Болор судар, Мөнхийн үсэг, 2009.
4. Ж.Лувсандорж, Монголын нууц товчоон (Монгол Улсын Нууц Түүх), Уб, Бэмби сан, 2014.
5. С.Нарангэрэл, Чингис хааны ёс суртахуун- эрх зүйн шастир, Уб, Адмон, 2014.
6. Б.Оюунчимэг, Ёс зүй: Ёс суртахууны тухай ном, нэмж, засварласан дөрөв дэх хэвлэл, Уб, Бемби сан, 2019.
7. Р.Дарьхүү нар, Ёс суртахууны боловсрол, Уб, Тотопресс, 2020.

Цахим эх сурвалж

1. Грахам Брүүкс, Авлигын криминологи: онолын чиг хандлага, орч.Авлигатай тэмцэх газар, Уб, Урангар пресс, 2021, цахим хувилбар <https://iaac.mn/post/103833>

Гадаад хэл дээрх

Ном, өгүүлэл, судалгааны тайлан

1. Tanner C, Linder S, Sohn M, “Does moral commitment predict resistance to corruption? Experimental evidence from a bribery game”, https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract_id=3530305
2. Howard Whitton, Transparency International, implementing effective ethics standards in government and the civil service, <https://www.oecd.org/mena/governance/35521740.pdf>

Цахим эх сурвалж

1. <https://www.transparency.mn/avliga-gezh-yuu-ve>
2. <https://www.transparency.org/en/cpi/2022>
3. <https://purneauniversity.org/world-happiness-index/>
4. <https://www.worldometers.info/gdp/gdp-per-capita/>
5. <https://www.britannica.com/place/Denmark/Settlement-patterns>

**BUILDING AN SOCIETY THAT HAS MORAL VALUE IS AN IMPORTANT FACTOR
IN REDUCING CORRUPTION**

Javkhlan. T

*Police captain, Senior inspector of Metropolitan Police Department,
Master's student, School of Law, NUM*

ABSTRACT:

There was a time in history when Mongolians were considered humane and moral. In particular, foreign travelers and researchers have often written about the universally respected virtues of Mongolians who lived during the reign of Chinggis Khan. But for us today, there are more and more selfish people who do not think about the community, and their behavior is full of cruel and evil intentions. One of these practices is related to corruption, which gradually destroys the proper organization of society and degrades the livelihood of the people. There is an opportunity to try to detect and eliminate corruption by improving laws and enforcement, but this is a costly and long-term option to live with corruption. However, in order to significantly reduce corruption and destroy the root of corruption, we should form the foundation for the revival of morals of people, and make people understand the beneficial aspects of morals that can be distinguished from the bad ones.

KEYWORDS:

Corruption, morality, corruption and morality, social development, basis for moral development

ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ БОЛОН ГАЗРЫН НӨХӨН ТӨЛБӨР, ҮНЭЛГЭЭНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ



Я.Өнөрбаян

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн докторант

ТОВЧЛОЛ:

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолд улсын тусгай хэрэгцээнд үндэслэн газар чөлөөлөх тохиолдолд иргэний газар, үл хөдлөх хөрөнгийн нөхөн олговрын хэмжээг тухайн иргэнтэй харилцан тохиролцоонд хүрээгүй бол хэрхэн шийдвэрлэх талаар эрх зүйн зохицуулалтыг бий болгох үндсэн чиглэл баталсан. Нийгмийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан албадан газар чөлөөлөх үйл явцын хамгийн маргаантай асуудал бол газрын үнэлгээг тооцох арга, аргачлал юм. Цаашид иргэний өмчлөлийн газрын нөхөн олговор олгох асуудлыг хуулийн процессын дагуу тодорхой онцлогтой авч үзэх, зах зээлийн жишгээр тооцохгүй газрын суурь үнийн зохицуулалтыг баримталснаар үл ойлголцол үүсгэж байгаа нэг шалтгаан юм. Энэ өгүүллийн хүрээнд Монгол Улсын иргэний өмчлөлийн газар, түүн дээрх үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээг хэрхэн зохицуулах талаар зарим улс орны туршлагыг харьцуулан үзэж боломжит санал, шийдлийг эрэлхийлсэн.

ТҮЛХҮҮР ҮГС:

Газрын нөхөн төлбөр, үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээ, үнэлгээний арга, аргачлал, гэрээгээр тохиролцох.

I. Үл хөдлөх эд хөрөнгө болон иргэний өмчилсөн газрын нөхөн төлбөрийн эрх зүйн зохицуулалт

Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө”¹ гэжээ. Хэрэв Монгол Улсын иргэнд өмчлүүлсэн газрыг улсын тусгай хэрэгцээнд нөхөн олговортойгоор солих буюу эргүүлэн авах бол газрын асуудал эрхэлсэн яам нь Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн дагуу нөхөн төлбөр, түүний төрөл, газрын үнэ түүний хэмжээ, төлбөрийн нөхцөлтэй холбоотой асуудлыг тухайн газрын эзэмшигч этгээдтэй урьдчилан тохиролцоно. Энэ талаар Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 37 дугаар зүйлийн дагуу арга хэмжээг авна. Үүнд:

1. Өмчийн газрыг нь сольж байгаа тохиолдолд иргэний хүсэлтийг үндэслэн өмчилж байсан газраас нь төлөв байдал, чанарын хувьд дордохооргүй газар түүнд өмчлүүлэх;
2. Газрыг нь эргүүлэн авч байгаа тохиолдолд газрынх нь үнийг төлөх;

¹ Монгол Улсын Үндсэн хууль, 1992, 16.3 дугаар зүйл.

3. Иргэний өмчилж байсан газарт байгаа үл хөдлөх эд хөрөнгийн үнийг төлөх;
4. Өмчлөгчөөс тухайн газарт зарцуулсан хөрөнгийг нөхөн төлөх;
5. Газрыг улсын тусгай хэрэгцээг үндэслэн солих буюу эргүүлэн авснаас өмчлөгчид учруулах хохирлыг иргэний хууль тогтоомжид заасны дагуу бүрэн хэмжээгээр нөхөн төлөх.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 36 – 39 дүгээр зүйлд зааснаар газар өмчлөгч иргэн нь өмчлөх эрхийн баталгаагаар хангагдахаар зохицуулсан байна.²

Монгол Улсын Их Хурлаас 2015 онд баталсан Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль нь зөвхөн хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд иргэн, хуулийн этгээд болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга санаачлан хэрэгжүүлэх төсөлтэй холбогдсон газар чөлөөлөх харилцааг зохицуулсан байдаг онцлогтой. Энэ хүрээнд 2022 оны байдлаар нийслэлийн хэмжээнд 2617 нэгж талбарын газрыг чөлөөлж, нийтдээ 277 бүтээн байгуулалтын ажил хэрэгжиж, үүний нөхөн олговорт 106,5 тэрбум төгрөг зарцуулсан байдаг.

Харин Засгийн газрын 2017 оны 287 дугаар тогтоол “газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах, түүний хэмжээ, заагийг тогтоох, ашиглах журам”-ын 3.5.3-т Улсын тусгай хэрэгцээнд авах газар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөл, эзэмшлийн газартай давхцсан тохиолдолд тэдгээр (цаашид “Нөлөөлөлд өртөж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага” гэх)-т улсын тусгай хэрэгцээг үндэслэн газрыг солих буюу эргүүлэн авах тухай мэдэгдлийг тухайн аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газраар уламжлан хүргүүлнэ. Энэ тохиолдолд Газрын тухай хуулийн 18.1.3-т заасны дагуу нөхөх олговор олгож, уг журмын 4.4-т Иргэний өмчилж байгаа газарт олгох нөхөх олговорт Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 37.1-д заасны дагуу дараах зүйлийг хамруулан тооцно.³

4.4.1. Иргэний өмчлөлийн газрыг сольж олгох тохиолдолд иргэний хүсэлтийг үндэслэн өмчилж байгаа газраас нь төлөв байдал, чанарын хувьд дордохооргүй газар олгох;

4.4.2. Иргэний өмчлөлийн газрыг нөхөх олговортойгоор эргүүлэн авах тохиолдолд Иргэнд өмчлүүлэх газрын үнэлгээний аргачлалын дагуу тодорхойлсон үнийг газрын биржийн зах зээлийн үнэтэй харьцуулан иргэний өмчлөлийн газрын үнийг тэдгээрийн дунджаар тогтоох;

4.4.3. Иргэний өмчлөлийн газар дээр байгаа барилга байгууламж буюу үл хөдлөх эд хөрөнгийн үнийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд заасан үнэ болон данс бүртгэлийн үнэ, даатгалын үнийн аль нэгийг үндэслэн тогтооно. Эдгээр үнэ нь хоорондоо их хэмжээний зөрүүтэй тохиолдолд үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгэгдсэн үнээр тогтоох;

4.4.4. Газар өмчлөгч иргэнээс тухайн газарт зарцуулсан хөрөнгийг тогтооход тухайн газрыг нөхөн сэргээх, хамгаалахад зарцуулсан хөрөнгийг хамруулах бөгөөд холбогдох нотлох баримт, мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн тогтооно.

4.5. Иргэний өмчлөлийн газрыг улсын тусгай хэрэгцээг үндэслэн солих буюу эргүүлэн авснаас үүссэн газар өмчлөгчид учрах хохирлын хэмжээг Иргэний хуулийн 229.1-д заасныг үндэслэн дараах байдлаар тооцно.

4.5.1. Эд хөрөнгөд учруулсан бодит хохирлын нөхөх олговорт газар, үл хөдлөх эд хөрөнгийн үнээр;

4.5.2. Бусад бодит хохиролд газар чөлөөлж, нүүлгэн шилжүүлэх зардал болон шилжилт, хөдөлгөөн хийхтэй холбогдон гарах зардал (шилжилт хөдөлгөөний бүртгэл буюу хаяг, сургууль, цэцэрлэгийн бүртгэл хийлгэх)-аар;

4.5.3. Олох ёстой байсан орлогод Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8.1-д заасан үйл ажиллагааны орлого болон хөрөнгийн орлогыг хамааруулах бөгөөд

² Монгол Улсын Иргэнд Газар өмчлүүлэх тухай хууль, 2002, Төрийн мэдээлэл №27(264).

³ Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах түүний хэмжээ, заагийг тогтоох, ашиглах журам <https://legalinfo.mn/mn/detail?law-Id=208296&showType=1>.

тэдгээрийн татвар ногдох орлогын дүнг иргэнд нөхөх олговрыг бүрэн олгож дуусгах хүртэлх хугацаагаар тооцохоор тусгажээ. Мөн аймаг, нийслэлийн Засаг дарга нөлөөлөлд өртөж буй иргэн, аж ахуй нэгж байгууллагатай “Улсын тусгай хэрэгцээнд газар эргүүлэн авах, солих” гэрээ байгуулж, гэрээнд өөрөөр заагаагүй бол нөхөх олговрыг бүрэн төлж дуусгасан өдрөөс хойш 30 хоногийн дотор газрыг чөлөөлж тухайн газар нутгийг хариуцсан Засаг даргын мэдэлд шилжүүлэх бөгөөд дээрх хугацаанд газраа чөлөөлөөгүй тохиолдолд Газрын тухай хуулийн 59 дүгээр зүйлд заасны дагуу албадан чөлөөлөх арга хэмжээг авна. Журам бол захиргааны акт учраас иргэдийн эзэмшилд буй газрыг үнэгүүдүүлэх, өмчийн эзний эрхийг хохироох, нийгэмд шударга бус явдал үүсгэж болзошгүй юм.⁴ Засгийн газраас газраа чөлөөлж байгаа иргэнтэй байгуулах үнэ тохиролцоо гэрээний үе шатыг боловсронгуй болгох, өртөгдсөн этгээдийн хөдөлмөр эрхлэлтийг хадгалах, нийгмийн хамгааллын цогц арга хэмжээг хуульчлаагүйгээс иргэдийн зүгээс газраа чөлөөлөхөөс татгалзах үндэслэл болдог.⁵ Үүнээс гадна газар чөлөөлөх талаар мэдээлэл, мэдэгдлийг цаг хугацааны хувьд тулган хэлэх явдал бодит байдалд нөлөөлөлд өртсөн газар өмчлөгч иргэд болон төсөл хэрэгжүүлэгчийн хооронд ихээхэн хүндрэл үүсгэдэг.

II. Газрын нөхөн төлбөр, үнэлгээ

Газрын үнэлгээ гэдэг нь газрын шинж чанарт үндэслэн ашиглалтын боломжийг урьдчилан таамаглах үйл явц юм.⁶ Практикт газрын зах зээлийн үнээс илүүтэйгээр газрын чанар, эдийн засгийн үнийг тодорхойлоход засгийн газраас баталсан газрын суурь үнийг ашиглах нь түгээмэл. Өөрөөр хэлбэл газар чөлөөлөхтэй холбогдсон харилцаанд газар, түүн дээрх үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээ, нөхөн олговрын хэмжээг тодорхойлоход энэхүү харилцаанд нөхөн орлуулалтын үнээр,⁷ эсхүл зах зээлийн үнийн дүнгийн аль их байгаагаар нь тооцохгүйгээр харин олон жилийн өмнө батлагдсан газар болон эд хөрөнгийг төрөөс өмчлүүлэх, хувьчлах харилцаанд голлон хэрэглэгддэг газрын суурь үнийн зохицуулалтыг баримталж байгаагаас шалтгаалан иргэдтэй тохиролцоонд хүрэхгүй байх нь элбэг байна. Үүнээс гадна нөхөн олговрын зардлыг төсөвт тусгадаггүй байдал нь газар чөлөөлөх үйл ажиллагаанд хүндрэл учруулж байгаа нэг хүчин зүйл юм. Иймд тухайн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэгч төрийн эрх бүхий байгууллагын төсөвт нь газар чөлөөлөх үйл ажиллагааны зардлыг тусгах нь зүйтэй юм. Монгол Улсын иргэнд өмчлүүлэх газрын үнийг “Иргэнд өмчлүүлэх газрын үнэлгээний аргачлалыг шинэчлэн батлах тухай”⁸ (Монгол Улсын засгийн газрын 2019 оны 8 дугаар сарын 14- ний өдрийн 324 дүгээр тогтоол)- оор тодорхойлоход энэхүү аргачлалыг мөрдөнө. Түүнчлэн гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлэх газрын үнийг байршлаас нь хамааруулан “Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс), суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоол⁹ батлагдсан юм. Энэ тогтоолын 2.2-т Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлэх газрын үнийг дор дурдсан байдлаар тодорхойлно.¹⁰

$$Иү = Сү * Т;$$

⁴ Н.Баярсайхан Н, Л.Дондов, “Газар чөлөөлөх бодлогод эрхэд суурилсан хандлагыг нэвтрүүлэх шаардлага” илтгэл, “Газартай холбоотой хүний эрхийн асуудлууд” онол, практикийн бага хурал, 2015.

⁵ С.Энхмэнд, “Иргэний өмчийн газрыг төр улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах эрх зүйн үндэслэл” илтгэл, “Газартай холбоотой хүний эрхийн асуудлууд” онол, практикийн бага хурал, 2015.

⁶ David G, Rossit A Theoretical framework for land evaluation, 1996, p.166.

⁷ Нөхөн орлуулалтын үнэ гэж газар чөлөөлөлтөд өртөгчийн алдсан хөрөнгийг дахин бий болгоход шаардагдах хөрөнгийн хэмжээг буюу алдсан хөрөнгөтэй ойролцоо хэмжээ, чанартай барилга байгууламжийг барих эсвэл одоогийн зах зээлийн үнэ цэнийн дагуу алдсан газар болон барилга байгууламжийг худалдаж авах үнийг, үүнд элэгдэл, дахин ашиглах боломжтой, үлдэх материалын үнэ цэнийг оруулан тооцохгүй.

⁸ Иргэнд өмчлүүлэх газрын үнэлгээний аргачлал, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=210057&showType=1> Засгийн газрын тогтоол.

⁹ Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс), суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээг тогтоох тухай- <https://legalinfo.mn/mn/detail?lawId=13596>, Засгийн газрын тогтоол.

¹⁰ Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс), суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээг тогтоох тухай- <https://legalinfo.mn/mn/detail?lawId=13596>, Засгийн газрын тогтоол.

Иү – иргэнд өмчлүүлэх газрын үнэ;

Сү – 1м² газрын суурь үнэлгээ;

Т – талбайн хэмжээ.

Жишээ 1. Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Толгойт орчимд байрлах 700 м² газрыг өмчлүүлэх тохиолдолд газрын үнийг тодорхойлох нь: Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Толгойт орчмын газар нь “Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс), суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээ тогтоох тухай” Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтад заасны дагуу газрын үнэлгээний 7 дугаар зэрэглэл (бүс)-д хамаарагдаж, газрын суурь үнэлгээ нь 24 500 төгрөг байна. Тодорхойлбол:

$Иү = 24\ 500 \text{ төг/м}^2 * 700 \text{ м}^2 = 17\ 150\ 000 \text{ төгрөг болно.}$

Жишээ 2. Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл суманд байрлах 700 м² газрыг өмчлүүлэх тохиолдолд газрын үнийг тодорхойлох нь:

Тосонцэнгэл сумын 1 м² газрын суурь үнэлгээ нь “Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс), суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээ тогтоох тухай” Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтад заасны дагуу 1400 төгрөг байна. Тодорхойлбол:

$Иү = 1400 \text{ төг/м}^2 * 700 \text{ м}^2 = 980\ 000 \text{ төгрөг болно.}$ Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын газрын суурь үнэлгээг тогтоохдоо газрын зах зээлийн үнийн мэдээнд шинжилгээ хийж, түүн дээрээ газрын үнэд нөлөөлөх гол хүчин зүйлс болох байршил, инженерийн хангамж, нийгэм, эдийн засгийн болон байгаль орчны нөхцөл харгалзан 17 ашиглалтын зориулалт, 16 бүсчлэлд хувааж ялгавартайгаар тогтоосон байдаг. Тухайлбал: Байршлаасаа хамааран гэр бүлийн хэрэгцээний зориулалттай 1 мкв газрын суурь үнэлгээ 1800–81800 төгрөг бол худалдаа бүх төрлийн үйлчилгээний зориулалттай 1 мкв газрын суурь үнэлгээ 19200–128000 төгрөг болох юм.¹¹ Энэ нь зах зээлийн өнөөгийн бодит байдалтай нийцэхгүй байгааг хянан үзвэл зохино.

Дээрх тогтоолыг үндэслэн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 12/39 тоот “газрын үнэлгээний зэрэглэл /бүс/-ийн газрын төлбөр тооцох итгэлцүүрийн тоон утга, түүнийг хэрэглэх зааг, хязгаарыг шинэчлэн тогтоох тухай”¹² тогтоолд газрын үнэлгээний бүсийн зааг, хязгаарын солбицол, 1мкв газарт ногдуулах газрын төлбөрийн хэмжээг тодорхойлсон байна.

Засгийн газрын 2018 оны 222 дугаар тогтоолоор “Хот суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны нөхөх олговор олгох журам”-ыг батлан гаргасан байдаг. Түүнчлэн Засгийн газрын 2018 оны 181 дүгээр тогтоолоор батлагдсан “Газрын эдийн засгийн үнэлгээ хийх аргачлал”-ын 13.1-т газрын эдийн засгийн үнэлгээний зургийг газрын үнэлгээний тойргоор 5 жил тутам, хот, тосгон, бусад суурины газрын үнэлгээний зэрэглэлээр 3 жил тутам хийнэ. Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс)-ээр тодорхойлсон газрын суурь үнэлгээг холбогдох зургийн хамт энэхүү аргачлалын 13.1-д заасан хугацаанд Засгийн газарт хүргүүлж батлуулахаар тусгасан байна.¹³ Тухайлбал, 2016 онд “Таван богд трейд” ХХК нь худалдан авсан 2698 ам метр газар, барилгын үнэ 23.850.000 000 /хорин гурван тэрбум найман зуун тавин сая/ төгрөгийг бүрэн төлсөн тул Сүхбаатар дүүргийн 8 хорооны нутаг дэвсгэрт байрлах “Улаанбаатар” сонин хуучин хэвлэх үйлдвэрийн барилгыг газрынх нь хамт өмчлөх эрхээ авсан¹⁴ нь зах зээлийн бодит үнэ билээ.

¹¹ ГЗБГЗЗГ, <https://www.gazar.gov.mn/medleg/faq/49>, 2023.06.11-ний байдлаар.

¹² НИТХ, Газрын үнэлгээний зэрэглэл /бүс/-ийн газрын төлбөр тооцох итгэлцүүрийн тоон утга, түүнийг хэрэглэх зааг, хязгаарыг шинэчлэн тогтоох тухай, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16389996204821>.

¹³ Газрын эдийн засгийн үнэлгээ хийх аргачлал, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=208628&showType=1>

¹⁴ <https://news.mn/r/714997/>.

III. Үл хөдлөх хөдлөх эд хөрөнгийн үнэлгээ

Эд хөрөнгийн үнэлгээг олон улсын болон үндэсний стандарт, мөн чанар, шинж чанар, онцлог, зориулалтыг харгалзан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн яамнаас баталсан хөрөнгийн үнэлгээний аргачлалын дагуу өртөг буюу үнэ цэнэ, стандарт үнэ, орлого бий болгох зэрэг үнэлгээний янз бүрийн аргуудыг нэгтгэн үнэлж хийнэ. Ингэхдээ Сангийн сайд, Барилга хот байгуулалтын сайдын хамтарсан 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 202/196, “Аргачлал батлах тухай” тушаалаар¹⁵ зохицуулсан байдаг. Энэ аргачлалаар нөхөх олговрын зориулалтаар хөрөнгийн үнэлгээг хийхдээ Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль, Газрын тухай хууль, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль, Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, үнэлгээний олон улсын стандарт, холбогдох журмыг баримтлахаар заажээ. Уг аргачлалын 2-т зааснаар газрын нөхөн олговрын үнэлгээг хийхдээ “хамгийн өндөр ба хамгийн сайн байх” зарчимд тулгуурлаж, зах зээлийн бодит үнийг баримтална. Тухайн Аймаг, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар баталсан газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу мэдэгдэх хуудас өгсөн өдөр (цаашид “Үнэлгээний өдөр” гэх)-өөс хойш хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэхээр сонгосон талбайд барьж байгуулсан барилга байгууламж болон газрын үнэд орсон өөрчлөлтийг үнэлгээнд тооцохгүй. Үнэлгээчин нь хөрөнгийн үнэлгээний тусгай зөвшөөрөлтэй үнэлгээ хийх эрх авсан иргэн¹⁶ байна.

Газар, үл хөдлөх эд хөрөнгө нөхөх олговрын зориулалттай үнэлгээний аргачлалын 4-т зааснаар газрын нөхөн олговрын үнэлгээг “хэсэгчлэн тооцох”¹⁷ аргаар багахан хэсэг (нэгж талбарын гуравны нэг) хэсэг нь газар чөлөөлөлтөд хамаарах бол, харин томоохон хэсэг (нэгж талбарын гуравны хоёр) нь хамаарах бол “өмнөх ба дараах”¹⁸ аргыг хэрэглэнэ. Энэ аргаар үнэлгээчин нь газар чөлөөлөлт хийгдэхээс өмнө ба дараах байдлаар газар чөлөөлөлтөд хамаарах газар, үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээг хийнэ. Эдгээр нийт газарт эдлэх хувийн жингээс гадна газар, үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөл, ашиглалтын байдал зэргийг харгалзан үзнэ. Үнэлгээний аргачлалын 4.7.2-т Өмчлөх эрх бүхий газрын үнэлгээг шалгах хуудсаар¹⁹ баталгаажсан газрын нэгжийн жишиг үнийг газар чөлөөлөлтөд хамаарах газрын хэмжээгээр үржүүлэн тооцох бөгөөд газрыг газраар, газрыг орон сууцаар сольж байгаа тохиолдолд тэмдэгтийн хураамж, газрын гэрчилгээний зардал, үл хөдлөх гэрчилгээний зардлыг тооцохоор заажээ.

Газрыг албадан чөлөөлөх явцад тухайн газар эзэмшигчтэй хэлэлцээр хийх хугацааг тогтоох, өөр нэг шийдэл бол хэлэлцээрт хүрээгүй тохиолдолд албадан чөлөөлөх хугацааг тогтоох явдал юм. Энэ нь зөвхөн нийт газар чөлөөлөх иргэдийн газрын 75 хувиас дээш хэсгийг чөлөөлсөн нөхцөлд хэрэглэгдэх боломжтой байж болно. Түүнчлэн газрыг солих тохиолдолд газраа сонгох эрхтэй байх ёстой. Мөн иргэний газар өмчлөх эрхийг тасалдуулахгүй байх үүднээс нөхөх олговорт газар, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээнээс гадна, бизнесийн үйл ажиллагааны ашиг орлогын хохирол, алдагдал, үл хөдлөх эд хөрөнгийг

¹⁵ Газар, үл хөдлөх эд хөрөнгийн нөхөх олговрын зориулалттай үнэлгээний аргачлал, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=211379&showType=1>.

¹⁶ Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, 3.1.11 болон 14 дүгээр зүйл.

¹⁷ Газар, үл хөдлөх эд хөрөнгийн нөхөх олговрын зориулалттай үнэлгээний аргачлал, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=211379&showType=1>

Хэсэгчлэн тооцох арга нь газар чөлөөлөлтөд хамаарах газар, үл хөдлөх хөрөнгө тус бүрийн үнэ цэнэ, газар чөлөөлөх зардал, түр суурьшуулах зардал, бусад холбогдон гарах зардлын нийлбэрээр тодорхойлно.

¹⁸ Газар, үл хөдлөх эд хөрөнгийн нөхөх олговрын зориулалттай үнэлгээний аргачлал, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=211379&showType=1>

Нөхөх олговрыг “Өмнөх ба дараах” аргаар үнэлгээг хийхдээ газар чөлөөлөлт хийгдэхээс өмнө, газар чөлөөлөлт хийгдсэний дараах байдлаар болон газар чөлөөлөлтөд хамаарах үнэлгээг тус тус тодорхойлно.

¹⁹ Газар, үл хөдлөх эд хөрөнгийн нөхөх олговрын зориулалттай үнэлгээний аргачлал, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=211379&showType=1> Шалгах хуудас нь нөхөх олговрын зориулалттайгаар үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхтэй холбогдуулан үнэлгээний ажлын үндсэн нөхцөлүүд, нөхөх олговрын дүнг тодорхойлоход шаардлагатай хөрөнгийн үнэлгээнд хамрагдах хөрөнгийн үнэлгээний зүйлийн нэр төрөл, тоо хэмжээ болон хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны төрлийн талаар оролцогчдын харилцан тохиролцож, зөвшөөрснийг нотлох бичиг баримт юм.


буулгах, нүүлгэн шилжүүлэх зардал, амьдрах түрээсийн байрны хөлс, нийгмийн даатгалын асуудлыг анхаарах нь зөв юм.

Төлөвлөлт, шийдвэр гаргах үйл явц практикт

Хувийн өмчийн газрыг чөлөөлөхийн тулд уг нөлөөлөлд өртсөн иргэдтэй нэг жилийн өмнө хэлэлцээр хийх ёстой. Үүний дараа Засгийн газраас газар чөлөөлөх шийдвэрээ гаргадаг. Гэтэл бодит байдалд Нийслэлийн засаг даргын шийдвэрийн дагуу газар чөлөөлөлт хийж байгаа нь хууль тогтоомжид нийцэхгүй байна. Хэдийгээр нийтийн эрх ашгийн үүднээс төр газар чөлөөлөх шийдвэр гаргаж байгааг ойлгож болох хэдий ч төрийн нэрээр хувийн өмчийг хүчээр авах, улс төрийн албан тушаалтан, төрийн албан хаагч нийтийн эрх ашиг нэрээр хуульчлаагүй асуудлаар гаргасан шийдвэрээ хүч хэрэглэхэд ашиглах ёсгүй.²⁰ Монгол Улсын Үндсэн хуульд заасанчлан иргэний өмчлөх эрхийг зөвхөн хуульд заасан үндэслэлээр хязгаарлах тул тусгайлсан хуулиар зохицуулах шаардлагатай. Үл хөдлөх хөрөнгийг үнэлэхдээ зөвхөн барилгын материалын үнийг харгалзан үздэг. Өөрөөр хэлбэл, барилгачдын цалин, тээврийн зардал гэх мэт бусад зардал нь үнэлгээнд огт хамрагддаггүй. Практикт нөлөөлөлд өртсөн хүмүүс нүүлгэн шилжүүлсэн хүмүүстэй тохиролцсоны дагуу нөхөн төлбөрийн гэрээ байгуулсны дараа нөхөн төлбөрийн нийт мөнгөний 40 хувь, үлдсэн 60 хувийг газар чөлөөлсний дараа олгодог. Тухайн нөлөөлөлд өртсөн иргэдэд газар чөлөөлөх хугацааг 3-7 хоногийн өмнө мэдэгдэл өгдөг, өртсөн иргэд газар дээр нь дэлгүүр, байшин байгаа эсэхээс үл хамааран 3-7 хоногийн дотор газраа чөлөөлөх шаардлагатай хохирсон иргэнээс газраа аль болох хурдан чөлөөлөхийг шаарддаг. Тиймээс иргэдэд нүүлгэн шилжүүлэлтэд бэлтгэх, ирээдүйн амьдралаа сайтар төлөвлөх боломж хомс байдаг нь газрын албаны ажилтнуудтай хийсэн ярилцлагаас харагдаж байсан юм.

НӨХӨХ ОЛГОВРЫН ДҮНГ ТООЦООЛОХ ЖИШЭЭ

1.Хэсэгчлэн тооцох арга /Piecemeal/-ын жишээ.



Жишээ 1: Иргэн А-ийн газар чөлөөлөлтөд хамаарах газрын хэмжээ нь нийт газрын 14.3% (100м.кв/700м.кв) буюу 1/3-ээс бага хэмжээг эзэлсэн, иргэн А ба Б нь хамааралгүй, иргэн А нь газар чөлөөлөлтөд хамаарах 100 м.кв газартаа тохирох нөхөх олговрыг авах боломжтой гэдгээ илэрхийлэн шалгах хуудсан дээр тэмдэглүүлсэн байв.

Бодолт: Тухайн газрын өмчлөлийн байдлыг тодорхойлохдоо үнэлгээчин нь энэ тохиолдолд нэгж талбарын “багахан хэсэг” нь газар чөлөөлөлтөд хамрагдсан гэж үзнэ. Иргэн А-гийн нөхөх олговрын дүнг тодорхойлохдоо энэ аргачлалын 4.1.1-д заасан

²⁰ Н.Баярсайхан, Л.Дондов, “Газар чөлөөлөх бодлогод эрхэд суурилсан хандлагыг нэвтрүүлэх шаардлага” илтгэл, “Газартай холбоотой хүний эрхийн асуудлууд” онол, практикийн бага хурал, 2015.

“хэсэгчлэн тооцох” аргыг хэрэглэнэ.

Жишээ 2: Иргэн А-ийн газар чөлөөлөлтөд хамаарах газрын хэмжээ нь нийт газрын 14.3% (100м.кв/700м.кв) буюу 1/3-ээс бага хэмжээг эзэлсэн, иргэн А нь иргэн Б-ийн хамаарал бүхий этгээд байсан, уг иргэд нь өмчлөлийн газраа дундуураа хоёр хуваалгахыг хүсэхгүй байгаагаа илэрхийлэн шалгах хуудсан дээр тэмдэглүүлсэн байв.

Бодолт: Тухайн газрын өмчлөлийн байдлыг тодорхойлохдоо үнэлгээчин нь энэ тохиолдолд нэгж талбарын “томоохон хэсэг” нь газар чөлөөлөлтөд хамрагдсан гэж үзнэ. Иргэн А-гийн нөхөх олговрын дүнг тодорхойлохдоо энэ аргачлалын 4.1.2-т заасан “өмнөх ба дараах” аргыг хэрэглэнэ.²¹

Монгол Улсын иргэний хуулийн 103 дугаар зүйлийн 1-т зааснаар өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлана²² гэсэн тул газар өмчлөгчийн өмчлөх эрхийг зөвхөн хуулийн тодорхой зохицуулалтаар хязгаарлана. Тухайлбал,

Хөшигийн хөндийн газар чөлөөлт: Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 140 дүгээр, 2016 оны 154 дүгээр, 2021 оны 307 дугаар тогтоолуудаар нийт 31475.3 га газрыг Улсын тусгай хэрэгцээнд авсан. Барилга Хот Байгуулалтын сайдын 2021 оны 240 дүгээр тушаалаар газар чөлөөлөх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө боловсруулан батлуулсан. Мөн 1:500-ны масштабтай байрзүйн зураг ортофото зургийг тус тус хийлгүүлсэн. Эдийн засгийн чөлөөт бүс, ложистикийн бүс, оюутны хотхон, худалдаа, олон нийтийн бүсүүдийн төлөвлөлттэй шилжүүлэх ажил хийгдэж байна. Үүнээс Төв аймгийн Алтанбулаг суманд 672 нэгж талбар байршил шилжүүлсэн, Сэргэлэн суманд 359 нэгж талбар хүчингүй болсон одоо 2023 нэгж талбар үлдсэн. Нийт 3054 нэгж талбар нөлөөлөлд өртөж, бүртгэл судалгаа хийсэн.

Мэргэн тоньюкукийн цогцолбор музей баригдах газрын газар чөлөөлт: Монгол Улсын Шадар сайдын 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 35 дугаар тушаалаар Нийслэлийн Налайх дүүрэг, Төв аймгийн Эрдэнэ сум хоорондын хилийн цэс орчмын газрын маргаантай асуудлыг шийдвэрлэх санал боловсруулах, Мэргэн Тоньюкукийн цогцолбор музей баригдах 20 га газрыг чөлөөлөх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан.

Тус музей баригдах газарт 13 иргэний газар өртсөн бөгөөд өмчлөх эрхтэй 11 иргэнтэй байршил, шилжүүлэхээр зөвшилцөж, эзэмших эрхтэй 2 иргэний газрыг Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын захирамжаар хүчингүй болгосон. Зөвшөөрөлгүй газар эзэмшсэн иргэн өөрөө газраа чөлөөлөх хүсэлт ирүүлснээр нөлөөлөлд өртсөн иргэдээс гомдол, маргаан нөхөн олговрын зардал гаргахгүйгээр ажлыг зохион байгуулж газрыг чөлөөлсөн.²³

IV. Газар албадан чөлөөлөх, үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээний эрх зүйн зохицуулалтыг сайжруулах боломж:

Иргэний эзэмшил, өмчлөлийн газрыг төр, түүний эрх бүхий байгууллагын шийдвэрээр дайчлан авах нь олон улс оронд Үндсэн хууль болон холбогдох бусад хуулиар зөвшөөрөгдсөн²⁴, түгээмэл үйл ажиллагаа бөгөөд гагцхүү дайчлан авах зорилго нь нийтийн эрх ашгийн төлөө, мөн иргэнд учирсан хохирлыг зүй ёсоор нөхөн төлөх ёстой гэсэн зарчимтай байдаг. Өмчийг дайчлан авахдаа хүний эрхийг зөрчих, хохироох явдал гарч болзошгүй учраас эрх зүйн зохих стандартыг тавьдаг. Энэ стандартын гол агуулга нь зөвхөн нөхөн олговор бус, харин нөхөх олговрыг эрх зүйн байх ёстой процессын дагуу тодорхой шинжүүдээр тодотгож, цаг хугацааны шалгуур тавьдаг.²⁵ Тухайлбал, АНУ-ын Дээд шүүхийн шийдвэрт газрын талаар дурьдахдаа хэн нэгэнд хохирол учруулсан бол түүнийгээ

²¹ Газар, үл хөдлөх эд хөрөнгийн нөхөх олговрын зориулалттай үнэлгээний аргачлал, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=211379&showType=1>

²² Иргэний хууль, 2002, Төрийн мэдээлэл №7(244).

²³ Газар чөлөөлт (gazar.gov.mn), 2023.04.26-ний өдөр хандсан.

²⁴ Jaar Zevenbergen, Systems of Land Registration Aspects and Effects, p.51 <https://www.ncgeo.nl/downloads/51Zevenbergen.pdf>

²⁵ Н.Лүндэндорж, Нийгмийн болон хувийн өмчийн эрх зүйн тулгамдсан асуудал, Уб, 2002, 26 дахь тал

“бүрэн, яг ижил хэмжээгээр” нөхөн төлөх ёстой. Хэрвээ илүү өгвөл илүү төлсөн, дутуу төлвөл дутуу нөхөн төлсөн гэж үзнэ.²⁶ Энэ утгаараа эрх зүйн зохих ёсны стандартгүйгээр, мөн зохих хэмжээний нөхөх олговор олгохгүйгээр хүнийг эд хөрөнгөнөөс нь салгаж болохгүй юм. Нобелийн шагналт эдийн засагч, Философич Amartya Sen бичихдээ нөхөх олговрыг тодорхойлох өөр нэг чухал үзүүлэлт бол нөхөх олговрыг үнэлэхдээ нөлөөлдөртсөн иргэдийн биет эд хөрөнгөөс гадна биет бус хохирлыг, өөрөөр хэлбэл, иргэдийн сайн сайхан байдалд нөлөөтэй хүчин зүйлсийг үнэлэн үзэх нь шударга нөхөх олговор олгох явдал юм. Нөхөх олговрын хэмжээг тогтооходоо хүний эд хөрөнгөө захиран зарцуулах эрх чөлөө, боломжийг харгалзан үзвэл зохих чухал хүчин зүйл юм гэсэн нь аливаа хүний эрх чөлөөг ямар ч тохиолдолд хязгаарлах ёсгүй бөгөөд сэтгэл санааны хувьд нийгмийн шударга ёсны талаарх үзэл санааг тод харуулсан. НҮБ-ын судалгаагаар зах зээлийн эдийн засагтай хөгжингүй олон оронд газар чөлөөлөх нөхөн олговрын стандарт нь тухайн газрын зах зээлийн шударга үнэд суурилдаг.²⁷ Мөн Ж.Роулс “Иргэдийн сайн сайхан, сэтгэл хангалуун байдлыг хангахын тулд тухайн нийгэмд хэрэгжүүлж буй бодлого, түүний хэрэгжилт, нийгмийн хандлагын талаас нь аз жаргал, сонголт хийх боломж гэж үзээд нөхөх олговрыг үнэлбэл хэтэрхий субъектив болно”²⁸ гэж үзсэн нь газрыг төрөөс нөхөх олговортойгоор авах нөхцөлд шударга ёсны үзэл чухал гэдгийг илтгэж байна.

Герман Улс. Герман улсад газрын үнэлгээний ажлыг төрийн байгууллага биш, зах зээлийн ажиглалт хийж, бусдаас хараат бус байдлаар газрын жишиг үнийг тогтоох үндсэн үүрэг бүхий мэргэшсэн үнэлгээчдийн зөвлөл гэж байдаг. Үнэлгээний журмыг засгийн газар гаргана.²⁹ Газрын жишиг үнийн карт нь тухайн газрын байдал, зах зээлийн жишиг үнийг бүсүүдээр үзүүлсэн байдаг. Мөн жишиг үнийн картанд газрын зориулалт, байршил болон газрын онцлог байдалтай холбоотой бусад мэдээллийг харуулдаг.³⁰ Барилгатай газар: Газрын үнэлгээ хийхэд мэргэжилтнийг оролцуулж, зах зээлийн үнийг үндэслэл болгодог. Газрын үнэлгээ хийх тухай журмын дагуу газрын үнийг тухайн үнэлгээ хийх үеийн зах зээлийн ханшийг үндэслэн тодорхойлдог. Газрын үнэлгээ хийхэд тухайн газрын хэмжээ, барилга, бусад хөрөнгийг харгалзан үздэг. Тухайлбал, 2010 оны байдлаар Берлин хотын дүүргүүдийн үнийн картаас харахад төвийн хэсэгт 1 метр квадрат газар 15000-20000 евро, захын хэсэгт 2800 евро байгааг тэмдэглэнэ.³¹ Тухайн газрыг барилгатай, барилгагүй үед үнэлэх журмыг тодорхойлжээ. Тухайлбал, барилгагүй газрын хувьд нэн тэргүүнд газрын үнийг тогтоох бөгөөд газрын үзүүлэлтийг харгалздаг. Газрын үзүүлэлтийг бие даасан болон хараат бус шинжээчид жилд нэг удаа тогтоодог. Ийнхүү газрын үзүүлэлтийг татвар, санхүү хариуцсан яаманд мэдээлж, нийтлүүлдэг. Барилга байгууламжтай газрын үнэлгээг хийхэд газрын үнэ, барилга байгууламжийн үнийг тогтоодог. Газрын үнийг өмнөх аргачлалаар тогтоох бөгөөд барилга байгууламжийн үнийг нэг буюу хэд хэдэн аргачлалын дагуу тогтоодог. Нэгдүгээрт, харьцуулалтын арга буюу ижил төрлийн газрын үнийг тогтоох замаар, Хоёрдугаарт, орлогын буюу тухайн газраас олж буй цэвэр ашгаар нь, Гуравдугаарт, зардал, элэгдэл зэргийг тооцож бодит үнийг тогтоох замаар хэрэгжүүлдэг. Германы Иргэний хуульд зааснаар тусгай статусгүй барилгатай газрын үнийг тухайн барилга болон газрын үнэ хоёрын нийлбэрээр тогтоодог. Түүнчлэн дээрх бүх аргыг хослуулан хэрэглэж газрын үнийг тогтоож болно.³²

²⁶ Rodert E. Goodin (1989) Theories of confensation, Oxford journal of legal studies Vol.9, No.1.

²⁷ Food and Agriculture Organization of the United Nations (2008). Compulsory Acquisition of Land and Compensation. FAO Land Tenure Studies: 23, 27-30, 40-41, 43, 53.

²⁸ John Rawls (1971) A theory of justice.

²⁹ Б.Гантулга, Б.Сайнжаргал, ХБНГУ-ын үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний тогтолцоо, эрх зүйн орчны туршлага, УБ, 2010, 28 дахь тал

³⁰ Ц.Норовдондог, Ипотекийн үнэт цаасны зах зээлийн хөгжлийн асуудал, УБ, 2011, 70 дахь тал.

³¹ Б.Гантулга, Б.Сайнжаргал, ХБНГУ-ын үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний тогтолцоо, эрх зүйн орчны туршлага, УБ, 2010, 37 дахь тал.

³² Мөн тэнд 29 дэх тал.

2022 онд Улсын Их Хуралд Нийгмийн зайлшгүй хэрэгцээнд зориулан газар чөлөөлөх тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлд газар чөлөөлөлтөд өртөгчид сонсох ажиллагаа явуулах, урьдчилан мэдэгдэж танилцуулах, нөхөн олговрын үнэлгээ нээлттэй байх зарчмыг баримтална хэмээжээ. Газар чөлөөлөх нөлөөлөлд өртөгчид нөхөх олговор тооцох, түүнийг олгох зорилтын хүрээнд төслийн 12 дугаар зүйлийн 1-т “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол нөхөн олговрын үнэлгээг Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд заасан зарчим, арга, аргачлалын дагуу тогтооно”, 12.2-т “Нөхөн олговрын үнэлгээг хийх зарчим, аргачлал, арга нь бүх нөхөн олговрын үнэлгээнд ижил, нээлттэй, ил тод байна” гэж заасан нь Үндсэн хуулийн 1.2-т заасан зарчимд нийцүүлэн хуульчлахдаа газар болон түүн дээрх үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээг шударгаар шийдвэрлэх нь төрд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм.

V. Дүгнэлт

Монгол Улсын иргэний өмчилсөн газар, түүн дээрх үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээ, нөхөн олговрын хэмжээг тодорхойлоход нөхөн орлуулалтын үнээр эсхүл зах зээлийн үнийн дүнгийн аль их байгаагаар нь тооцохгүйгээр харин олон жилийн өмнө батлагдсан газар болон эд хөрөнгийг төрөөс өмчлүүлэх, хувьчлах харилцаанд голлон хэрэглэгддэг газрын суурь үнийн зохицуулалтыг баримталж байгаагаас шалтгаалан иргэдтэй тохиролцоонд хүрэхгүй байх нь элбэг байна.

Тухайн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэгч төрийн эрх бүхий байгууллагын төсөвт нь газар чөлөөлөх, нөхөн олговрын зардлыг тусгаж өгөх шаардлагатай. Иймд иргэний өмчилсөн газар болон үл хөдлөх эд хөрөнгийг нөхөн олговрын үнэлгээг тогтоохдоо харьцуулалтын арга буюу ижил төрлийн газрын үнийг тогтоох замаар, орлогын буюу тухайн газраас олж буй цэвэр ашгаар нь, зардал, элэгдэл зэргийг тооцож бодит үнийг тогтоох аргуудыг хослуулан хэрэглэх нь зүйтэй юм.

ЭХ СУРВАЛЖ**Монгол хэл дээрх*****Хууль тогтоомж***

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992.
2. Иргэний хууль, 2002.
3. Монгол Улсын Иргэнд Газар өмчлүүлэх тухай хууль, 2002.
4. Хөрөнгийн үнэлгээний тухай хууль.
5. Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах түүний хэмжээ, заагийг тогтоох, ашиглах журам <https://legalinfo.mn/mn/detail?lawId=208296&showType=1>
6. Иргэнд өмчлүүлэх газрын үнэлгээний аргачлал, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=210057&showType=1> Засгийн газрын тогтоол,
7. Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс), суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээг тогтоох тухай- <https://legalinfo.mn/mn/detail?lawId=13596>, Засгийн газрын тогтоол.
8. Газрын эдийн засгийн үнэлгээ хийх аргачлал, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=208628&showType=1>.
9. Газар, үл хөдлөх эд хөрөнгийн нөхөх олговрын зориулалттай үнэлгээний аргачлал, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=211379&showType=1>.

Ном, өгүүлэл, судалгааны тайлан

1. Н.Лүндэндорж, Нийгмийн болон хувийн өмчийн эрх зүйн тулгамдсан асуудал, УБ, 2002.
2. Б.Гантулга, Б.Сайнжаргал. ХБНГУ-ын үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний тогтолцоо, эрх зүйн орчны туршлага, УБ, 2010.
3. Ц.Норовдондог, Ипотекийн үнэт цаасны зах зээлийн хөгжлийн асуудал, УБ, 2011.
4. Н.Баярсайхан, Л.Дондов, “Газар чөлөөлөх бодлогод эрхэд суурилсан хандлагыг нэвтрүүлэх шаардлага” илтгэл, “Газартай холбоотой хүний эрхийн асуудлууд” онол, практикийн хурал, 2015.
5. С.Энхмэнд, “Иргэний өмчийн газрыг төр улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах эрх зүйн үндэслэл” илтгэл, “Газартай холбоотой хүний эрхийн асуудлууд” онол, практикийн бага хурал, 2015.
6. ГЗБГЗЗГ, <https://www.gazar.gov.mn/medleg/faq/49>, 2023.06.11-ний байдлаар.
7. НИТХ, газрын үнэлгээний зэрэглэл /бүс/-ийн газрын төлбөр тооцох итгэлцүүрийн тоон утга, түүнийг хэрэглэх зааг, хязгаарыг шинэчлэн тогтоох тухай, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16389996204821>.

Цахим эх сурвалж

1. Газар чөлөөлөлт (gazar.gov.mn), 2023.04.26-ний өдөр хандсан.
2. <https://news.mn/r/714997/>.

Гадаад эх сурвалж***Ном, өгүүлэл, судалгааны тайлан***

1. David G. Rossitr A theoretical framework for land evaluation, 1996, 166.
2. Rodert E. Goodin (1989) Theories of confensation, Oxford journal of legal studies Vol.9, No.1.

3. Food and Agriculture Organization of the United Nations (2008). Compulsory Acquisition of Land and Compensation. FAO Land Tenure Studies: 23, 27~30, 40~41, 43, 53.
4. John Rawls (1971) A theory of justice.
5. Jaap Zevenbergen. Systems of Land Registration Aspects and Effects, p.51 <https://www.ncgeo.nl/downloads/51Zevenbergen.pdf>.

REAL ESTATE AND LAND COMPENSATION, LEGAL REGULATION OF EVALUATION

Unurbayan.Ya

Ph.D student, School of Law, NUM

ABSTRACT:

Resolution No. 12 of 2021 of the Great Khural of Mongolia, the basic guideline are approved by creating legal regulations on how to settle the amount of compensation for civilian land and real estate in case of land acquisition based on social needs of the state were not reached with the citizen.


The most controversial issue in the forced land acquisition process based on social needs is method of calculating land valuation. In the future, the issue of compensation for civilian-owned land will be considered with specific features according to the legal process, and the regulation of the base price of land, which is not calculated according to market standards, is one of the reasons that cause misunderstandings.

Within the framework of this article, we have compared the experiences of some countries on how to regulate the valuation of civilian-owned land and real estate on it, and sought possible suggestions and solutions.

KEYWORDS:

Land compensation, real estate valuation, valuation methods and methods, agreement on contracts.

ХУРДАН МОРИНЫ УРАЛДААНЧ ХҮҮХДИЙН ЭРХИЙН ЗАРИМ АСУУДАЛ, ТЭДГЭЭРИЙГ ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ



Т.Баясгалан

БНХАУ-ын Өвөр Монголын Их сургуулийн докторант

ТОВЧЛОЛ:

Энэхүү судалгаа нь хурдан морины уралдаанд оролцож буй уралдаанч хүүхдийн эрхийн зөрчлийн талаарх асуудлыг агуулж, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх саналыг дэвшүүлсэн. Монголчууд эртнээс уламжлагдан ирсэн хурдан морины уралдааны өв соёлоороо бахархдаг ард түмэн билээ. Гэвч эдүгээ зарим уралдаанч хүүхдийн амьд явах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, хөгжих, сурч боловсрох, хөдөлмөрийн мөлжлөгөөс ангид байх зэрэг эрх нь хурдан морины уралдаанд бэлтгэх, оролцох үед тодорхой хэмжээгээр зөрчигдсөөр байна. Судлаач бид цаашид эдгээр хүүхдийн эрхийн зөрчил болон хурдны морь уралдуулах хүүхдийн насны доод хязгаар, морин уралдаанд хүүхэд оролцуулахгүй байхад нийгмийн сэтгэл зүй хэрхэн хүлээн авах зэрэг нарийвчилсан судалгаа хийж, түүнд тулгуурлан эрх бүхий байгууллагаас үр дүнтэй, бодит арга хэмжээг авах шаардлагатай байна.

ТҮЛХҮҮР ҮГС:

Уралдаанч хүүхдийн насны доод хязгаар

УДИРТГАЛ:

Монголчууд 3000 гаруй жилийн өмнө мориог гаршуулж¹, 2232 жилийн турш Төрт ёсны эрийн гурван наадмыг тэмдэглэн өнгөрүүлсэн ард түмэн төдийгүй морь, морин уралдааны түүх, өв соёл хосгүй учир эдүгээг хүртэл бидний ахуй амьдрал, баяр цэнгүүнд салшгүй холбогджээ. Иймд Монгол наадам нь 2019 онд Монгол Улсын Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яамны сайдын тушаалаар Монгол Улсын соёлын биет бус өвд,² 2010 онд ЮНЕСКО-д “Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн төлөөллийн жагсаалт”-д тус тус бүртгэгдсэн байна. Эрт цагт Монгол Улсад мал аж ахуй өргөн дэлгэр байсан ба дайн байлдаанд эрэгтэй хүнийг байнгын бэлтгэлтэй байлгах, хүүхэд наснаас нь моринд гарамгай байлгах зорилгоор эрийн гурван наадмыг зохион байгуулдаг байжээ. Харин орчин үед энэ зорилго нь төдийлөн нийцэхгүй бөгөөд зөвхөн өв уламжлал гэх нэрийн доор бага насны хүүхдээр хурдны морь уралдуулж байна. Үүнийг ёс заншлын он цагийн зөрчилдөөн гэж тодорхойлж ч болох юм. Хэдийгээр хурдан морины уралдаан нь үндэсний

¹ Journal of Archaeological Science, volume 81, “A Bayesian chronology for early domestic horse use in the Eastern Steppe” 2017, P.56.

² Монгол Улсын Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яамны сайдын тушаал, 2019.11.29, А/759.

өв соёл, бидний бахархал боловч өнөө цагт хүүхдийн эрхийн хэд хэдэн зөрчлийн суурь шалтгаан болж байгаа талаар энэхүү судалгаанд тусгаж, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх санал дэвшүүлэхийг зорьсон болно.

Манай улсад хурдан морины уралдааныг хурдан морины, цэвэр үүлдрийн болон эрлийз морьдын уралдаан гэж ангилдаг.³ Харин шигшмэл буюу их хурд, дүнжингарав хавар зуны бүсийн уралдаан, аймаг болон сум, дүүргийн баяр наадмын уралдаан гэх мэт 7 зэрэглэлд уралдаан зохин байгуулагдаж байна. Сүүлийн жилүүдэд хурдан морины эзэд болон уяачид Монгол морьдыг улам хурдан болгох зорилгоор эрлийзжүүлэх явдал ихэссэн ба үүнийг зарим судлаачид өв уламжлал алдагдахад хүргэж байна хэмээн үзэж байна. Монгол морины онцлог нь жижиг биетэй намхан, холын зайг туулах чадвартай байдаг бол эрлийзжүүлснээр биесийн шинж байдалд нь өөрчлөлт орж, том биетэй, хурд ихсэж байгаа нь нэг талаас уралдаанч хүүхдийн мориноос унаж, бэртэхэд нөлөөлж болзошгүй тул цаашид эрлийз морьдыг хүүхдээр унуулахгүй байвал зохино. Нөгөөтээгүүр морьдыг эрлийзжүүлэх нь ашгийн шинж чанартай хурдан удмын морийг үнэд хүргэх, бооцоот уралдаан зохион байгуулах зэрэг сөрөг үр дагаварт хүргэж байна.

Өнөө цагт зарим уралдаанч хүүхдүүд хурдан морины уралдаанд оролцох болон уралдааны бэлтгэл ажил хангахтай холбогдох ажил хөдөлмөр эрхэлж, ингэхдээ сургуулиасаа чөлөө авах эсхүл, таслах зэргээр хичээлийн хоцрогдолд орж, улмаар сурч боловсрох эрхээ ч эдэлж чадахгүйд хүрчээ. Түүнчлэн, цалин хөлсгүй хөдөлмөрлөснөөр хөдөлмөрийн мөлжлөгт өртөж, тодорхой хэмжээний хохирол амссаар байна. Мөн, жил бүр мориноос унаж, бэртсэн болон амь насаа алдсан хүүхдүүдийн тоо нэмэгдсээр байгаа ч энэ тохиолдолд хариуцлага тооцох тогтолцоо хараахан бүрэлдээгүй байгаа тул эрх бүхий байгууллагаас тухайн асуудлыг анхааралдаа авч, бодитой, үр дүнд хүрэхүйц арга хэмжээг авах шаардлага бий болсон байна.

Нэг. Хурдан морины уралдаанч хүүхдийн насны доод хязгаар ба хөдөлмөр эрхлэлт

Монгол Улсын хэмжээнд хурдан морины уралдаанч 15885 хүүхэд бүртгэлтэй байдгаас 15403 нь эрэгтэй, 482 нь эмэгтэй хүүхэд байна. Тэдгээрээс 7-9 насны 5308, 10-12 насны 6000 орчим, 13-15 насны 2743, 16-18 насны 323 хүүхэд бий гэх статистикаас харахад ихэнхдээ бага насны хүүхдүүд хурдны морь унаж байна.

Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 138 дугаар конвенцод хөдөлмөр эрхлэх насны доод хязгаар нь бүрэн бус дунд боловсрол эзэмших нас байх бөгөөд ямар ч тохиолдолд 15 наснаас доошгүй, өсвөр үеийнхний эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй ажлын хувьд 18 наснаас доошгүй байна гэж заасан байдаг. Монгол Улс энэхүү гэрээнд 2002 онд нэгдэн орж, уг заалт нь Хөдөлмөрийн тухай хуульд тусгагдсан. Ингэхдээ уг хуулийн 142 дугаар зүйлд насанд хүрээгүй хүний хөдөлмөр эрхлэлтийг тусган, 13-15 насны хүнийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөлтэйгөөр хөнгөн ажил эрхэлж болно гэж заасан.⁴ Үүнээс үзэхэд манай улсын хувьд хөдөлмөр эрхлэх насны доод хязгаар 13 наснаас эхэлж байна.

Улс орон, судлаач бүр хэдэн нас хүртэлх хүүхдийг бага насны хүүхэд гэж тодорхойлох нь өөр өөр байдаг. Тухайлбал, Германы сэтгэл зүйч Эрик Эриксон 6 хүртэлх насны хүүхэд мөн Английн их сургуулийн профессор Дохерти Ж. болон Хагхёс нар “Хүүхдийн хөгжил” номдоо бага нас гэдэгт 0-12 настай хүүхэд гэж тус тус үзсэн. Гэхдээ олонх судлаачид, бодлого боловсруулагчид бага насны бүлэгт ихэнхдээ ургийн хөгжлийн үеэс 6-10 насыг хамааруулж, энэ насны хүүхдийн онцлог нь дахин давтагдашгүйгээр хүрээлэн буй

³ Монголын хурдан морины уралдааны дүрэм, 2019 он, 4 дүгээр бүлэг 10 дугаар зүйл.

⁴ Хөдөлмөрийн тухай хууль, 2021, 142.3-д Хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжилд сөрөг нөлөө үзүүлэхгүй, сурч боловсроход саад учруулахгүй нөхцөлд 13-15 насны хүнийг хууль ёсны төлөөлөгч /эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч/-ийн зөвшөөрөлтэйгөөр хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байранд хөнгөн ажил эрхлүүлж болно.

орчноо таньж, дасан зохицох, шинэ зүйлийг сурч, мэдэхийн хэрээр эрхтэн тогтолцоо нь боловсронгуй болж, өөртөө үйлчлэх, бусадтай харилцах, асуудлыг шийдэх туршлага хуримтлуулж, улмаар олон талаар өөрийгөө таньж, нээдэг үе хэмээн тодотгож байна.⁵ Эрх зүйн хүрээнд манай улс 0-13 насны хүүхдийг бага насны хүүхдэд тооцдог ба шинжлэх ухаанд үндэслэсэн Олон улсын судлаачдын бүтээл, Олон улсын гэрээ, Монгол Улсын хуулиудад ч бага насны хүүхдийг хөдөлмөр эрхлүүлэх нь зохимжгүй хэмээн үздэг.

Гэвч Үндэсний их баяр наадмын тухай хуульд хурдны морийг 8 ба түүнээс дээш насны хүүхэд унахаар хуульчилсан. Энэ нь зөвхөн Үндэсний их баяр наадам, томоохон хэмжээний ойн баяр наадмын үеэр уралдаанд оролцогч хүүхдийн насыг бүртгэж, уралдуулдаг. Түүнчлэн, жижиг хэмжээний морин уралдаан, уралдаанд бэлтгэх явц, хөдөө орон нутгийн айл өрхийн өдөр тутмын амьдралын хэв маягаас шалтгаалж, 8-аас доош насны хүүхэд хурдны морь унах нь олонтой тохиолддог. 8 ба түүнээс дээш насны хүүхдийг хурдны морь унахыг хуулиараа зөвшөөрсөн нь хэдэн зууны турш өвлөгдөн ирсэн уламжлалтай холбогдуулан тайлбарлах боловч нөгөө талаас хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангах⁶ талаар төдийлөн анхаараагүй хэмээн үзэхийн зэрэгцээ Олон улсын гэрээ, Монгол Улсын Үндсэн хууль, бусад ердийн хуулийг илт зөрчсөн тул энэ нь бага насны хүүхдийг хурдны морь унуулахгүй, уралдаанд оролцуулахгүй байж болох хангалттай үндэслэл юм.

Уралдаанч хүүхэд нь уралдааны бэлтгэл хангахад оролцох, морь унаж уралдуулахаар хөдөлмөрийн аман тохиролцоо байгуулж, ингэхдээ тэдгээрийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нар хүүхдийг төлөөлөх, тэр ч байтугай зарим хүүхдүүд өөрсдөө ажил гүйцэтгэл, цалин хөлсний тохиролцоог хийж байна. Олон нийтийн сүлжээгээр уралдаанч хүүхдийг өндөр цалинжуулж, морь уралдуулна гэх зарууд олширсон. Үүнийг лавлахад нэг сарын ажлын хөлс нь 800.000-2.400.000 төгрөг, хэрэв уралдаанд айрагдах болон түрүүлбэл тусгай урамшуулал олгоно⁷ гэж байхад зарим нь уралдаанд оролцох бүрд 20.000-30.000 төгрөгөөр цалинжуулна хэмээсэн. Үүнээс үзвэл, уралдаанч хүүхдүүд өнөө цагт хөдөлмөрийн харилцаанд оролцогч болж байна. Харин өөрийн гэр орондоо уламжлалт хэлбэрээр уралдаж байгаа хүүхдүүдийн хувьд хөдөлмөрийн эрх зүйн харилцаа үүсэхгүй хэмээн зарим судлаачид үзжээ.⁸ Судлаачийн зүгээс өөрийн гэр орон, танил хамаатан саданд уламжлалт хэлбэрээр морин уралдаанд оролцож буй хүүхдүүд нь хөдөлмөрийн эрх зүйн харилцаа үүсгэж, цалин хөлсгүй бол энэ нь хөдөлмөрийн мөлжлөгт тооцогдоно гэж үзэж байна. Учир нь дээрх хоёр тохиолдлыг харьцуулан үзвэл уралдаанд бэлтгэх, хурдны морь уралдуулах зэрэг ижил төрлийн ажил үүргийг зарим нь цалинтай бусад нь ахуйн уламжлалт хөдөлмөр нэрийн доор цалин урамшуулалгүй хөдөлмөр эрхэлж байгаа нь хөдөлмөрийн мөлжлөгт⁹ тооцож болохуйц харагдаж байна. Хурдан морьдын эзэд эсхүл уяач зэрэг хүүхдээр морь уралдуулахаар тохирсон этгээдүүдийг хөдөлмөр олгогч гэж үзвэл

⁵ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан “Бага насны хүүхдийн цогц хөгжил” судалгаа, Улаанбаатар хот, 2020, 9-10 дахь тал.

⁶ Хүүхдийн эрхийн тухай конвенц, 1990, 3 дугаар зүйлд Нийгмийн хамгааллын улсын буюу хувийн байгууллага, шүүх, захиргааны болон хууль тогтоох байгууллагаас хүүхдийн талаар явуулах аливаа үйл ажиллагаанд юуны өмнө хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангахад анхаарлаа хандуулна.

⁷ Б.Мөнгөнтамир: Уралдаанч хүүхдүүд ховордож, цалин нь 2.4 саяд хүрэв, Nnews.mn, <https://news.mn/r/25666055/>. [Сүүлд үзсэн: 2023.10.05].

⁸ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, “Хурдан морины хаврын уралдаан ба хүүхдийн эрх” судалгааны тайлан, УБ, 28 дахь тал.

⁹ Хөдөлмөрийн тухай хууль, 2021, 142.2-д Насанд хүрээгүй хүний оюун ухаан, биеийн хөгжил, амь нас, эрүүл мэндэд аюул учруулах, хүмүүжил, ёс суртахуунд сөргөөр нөлөөлөх, хууль тогтоомжоор хориглосон хөдөлмөр эрхлүүлэх, хүүхдийн хөдөлмөрийг мөлжлөгийн хэлбэрээр ашиглах, цалин хөлсийг шударга бусаар тооцож олгох, хүүхдийн нэрээр хууль бус үйл ажиллагаа явуулах зэрэг тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөрийг хүүхдээр эрхлүүлэхийг хориглоно. Эрүүгийн хууль 13.13-д Бусдад хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, илт хохиролтой болзол, нөхцөл тулгаж, эсхүл хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдлыг далимдуулан эрхшээлдээ оруулж цалин хөлсгүй хөдөлмөр эрхлүүлсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

хүүхдээр хөдөлмөр эрхлүүлж буйгаа хариуцсан төрийн байгууллагад мэдэгдэх үүрэгтэй¹⁰ ч энэ нь амьдралд огт хэрэгждэггүй, ямар харилцаагаар хүүхэд уралдаанд оролцуулж байгаа нь ойлгомжгүй байдал үүсгэдэг. Хэрэв хүүхэд өөрөө хүсээгүй байхад гэр бүлийн шахалт дарамтад хурдны морь унаж байгаа бол энэ нь албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэрэг¹¹ болох ч магадлалтай. Гэвч энэ нь гол маргах зүйл биш бөгөөд бага насны хүүхэд хүнд хэлбэрийн хөдөлмөр эрхэлж байгаа нь голлон анхаарах асуудал юм.

Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 182 дугаар конвенцын 3 дугаар зүйлийн (d) хэсэгт заасан аюултай ажлын төрлийг холбогдох Олон улсын хэм хэмжээ, ялангуяа Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай 1999 оны зөвлөмжийн 3, 4 дэх хэсгийн заалтыг харгалзан үзсэний үндсэн дээр үндэсний хууль тогтоомжоор, эсхүл ажил олгогч болон ажилчдын байгууллагатай зөвшилцсөний дараа эрх бүхий байгууллагаас тогтоосон хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр, түүний төрлүүдийн жагсаалтыг үе үе хянаж, шинэчилж байхыг гишүүн улсад үүрэг болгосон байдаг. Гэвч Монгол Улсын эрх бүхий байгууллага уралдаанч хүүхдүүдийн хөдөлмөр эрхлэлт тэвчишгүй хөдөлмөрт орохгүй хэмээн тайлбарлаж байна. 2022 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 122, 123 дугаар тушаалаар “Ажлын байрны жагсаалт”-ыг шинэчлэн батлахдаа тодорхой судалгаа авч, түүний үр дүнд үндэслэсэн гэх ба хөдөө аж ахуй, газар тариалан, олборлолт гэх мэтээр ажлын байруудыг зааж өгсөн. Мал аж ахуйн салбарт насанд хүрээгүй хүүхдүүд тодорхой хэмжээгээр хөдөлмөр эрхэлж болох ба энэ нь хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр биш¹² хэмээн үзэж байгаа нь учир дутагдалтай байна. Дээрх шийдвэрээс үндэслэн эрх бүхий байгууллага нь бага насны хүүхэд хурдны морь унах, уралдаанд оролцох нь хөнгөн хэлбэрийн хөдөлмөр гэж үзэж байвал нэгдэн орсон Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 138 дугаар конвенцоор 15 нас, Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу дор хаяж 13 насны хүнээр хурдны морь унуулахаар байна.

Насанд хүрээгүй хүний долоо хоногийн ажлын цаг 30-аас илүүгүй байхаар¹³ хуульчилсан ч 20 гаруй уралдаанч хүүхдийг хамруулсан бие даасан судалгаагаар эдгээр хүүхдүүд морь уралдуулах, сунгаа, бэлчээр сэлгэж нүүх, морьдын уралдаан хооронд замд явах, тухайн айлын ахуйд туслах зэрэг ажилд амралтын өдөргүйгээр долоо хоногт дунджаар 40-60 цаг хөдөлмөр эрхэлж байгаа нь тогтоогдсон. Мөн, морин уралдаануудын хооронд хол зайнд аймаг сумд дамжин явах нь хүүхдийг албан томилолтоор явуулж байгаатай адилтган үзэж болох юм. Хөдөлмөрийн тухай хуулийн 143.3 дугаар зүйлд урлаг, спортын үзүүлбэр, зар сурталчилгаанд оролцуулахаас бусад тохиолдолд насанд хүрээгүй хүнийг албан томилолтоор ажиллуулахыг хориглоно гэж заасан. Нутаг бэлчээр сэлгэн нүүх, уралдаануудын хооронд замд явах нь хүүхдийн аюулгүй байдал, эцэг эхийн хараа хяналтаас холдох эрсдэлээс гадна дээрх хуулийн заалтыг зөрчсөн үйлдэл мөн.

Эрх бүхий байгууллага, судлаач бид хүүхдээр хурдны морь унуулах эсэх асуудалд дорвитой судалгаа хийж, Төрийн зүгээс Олон улсын гэрээ, Үндсэн хууль, бусад хуулийг зөрчихгүйгээр шийдвэр гаргах нь зүйн хэрэг ч цаашид үүсэх эрсдэлийг тооцох нь чухал юм. Өөрөөр хэлбэл, хурдны морь унах уралдаанч хүүхдийн насыг хязгаарлаж тогтоох нь ирээдүйд хэд хэдэн эрсдэлийг үүсгэж болзошгүй. Тухайлбал, өнөө цагт Монголчууд хот суурин газарт амьдрах нь ихсэж, нүүдлийн мал аж ахуй эрхлэх нь багасаж байна. Ингэснээр

¹⁰ Хөдөлмөрийн тухай хууль, 2021, 142.6-д Ажил олгогч 18 насанд хүрээгүй хүнээр хөдөлмөр эрхлүүлэх бол хүүхдийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, гүйцэтгэх ажил, ажиллах хугацаа, хөдөлмөрийн нөхцөл зэргийн талаар бүртгэл хөтөлж, хөдөлмөрийн болон хөдөлмөрийн хяналтын асуудал хариуцсан тухайн шатны төрийн байгууллагад хөдөлмөр эрхлэлтийн харилцаа үүссэнээс хойш ажлын 10 өдрийн дотор мэдэгдэнэ.

¹¹ Хөдөлмөрийн тухай хууль, 2021, 8.2-д “Албадан хөдөлмөрлүүлэх” гэж аливаа торгууль, шийтгэл ногдуулахаар айлган сүрдүүлэх, хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх замаар хүнийг хүсэл зоригийнх нь эсрэг ажил, үйлчилгээ эрхлүүлэхийг ойлгоно.

¹² *А.Цэсүүрэн, Хөл нүүцэн зугтаахаар туслах уяач араас хөөж ирээд, гэртээ аваачаад хүлчихдэг*, Nnews.mn, <https://news.mn/r/2613628/>, [Сүүлд үзсэн: 2023.08.29].

¹³ Хөдөлмөрийн тухай хууль, 2021, 6 дугаар бүлэг 84 дүгээр зүйл 3 дахь заалт.

хурдны морь унах хүүхдийн тоо аажмаар буурч, тэдгээр хүүхдийн эрэлт хэрэгцээ нэмэгдэн, хөдөлмөрийн ахиу хөлс амлах, хүүхэд худалдаалах, хүчээр морин уралдаанд оролцуулах, хөдөлмөрийн мөлжлөг бий болох зэрэг сөрөг үр дагавартай хэмээн үзэж байна. Үүнтэй холбоотой нэгэн жишээ дурдахад Катар, Арабын Нэгдсэн Эмират Улс, Оман зэрэг улсад олон зууны турш уламжлагдан ирсэн тэмээн уралдаан зохион байгуулагддаг. Тэмээг манай улсын морин уралдаантай адил бага насны хөнгөн жинтэй, ойролцоогоор 4-7 насны бие жижиг, эрэгтэй хүүхэд унадаг. Арабын баячууд тэмээ унуулах хүүхдээ Судан, Пакистан, Иран, Бангладеш, Афганистан зэрэг орнуудаас хулгайлан “Усбах” хэмээх хуаранд амьдруулж, биеийн жинг хөнгөн байлгахын тулд олон өдрөөр хоол өгөхгүй байх, хүүхдүүд тэмээн уралдаанд оролцоходоо унаж, гэмтэх, амиа алдах явдал ч их гарчээ. Ийм хуаранд байсан олон зуун хүүхдийг хүний эрхийг хамгаалагчид олж, сулласан явдал цөөнгүй.¹⁴ Дээрхээс дүгнэж үзэхэд иргэдийнх нь амьжиргааны түвшин нэмэгдсэнээр хүүхдээ амь насаар нь дэнчин тавьж, тэмээн уралдаанд оролцуулах нь цөөрсөн тул тэмээ унах хүүхдийн тоо багасаж, улмаар улс дамнасан хүүхэд хулгайлах гэмт хэргийн шалтгаан нөхцөл нь болжээ. Мөн, тэмээн уралдаан нь бооцоотой төдийгүй, уралдах тэмээний үнэ нь ч өндөр байсан нь мөнгөнд шунасан этгээдүүд хүүхдийг эрхийг зөрчихөд хүргэсэн байна. Манай улсад хэсэг бүлэг хүмүүс нэгдэн морьдын бооцоот уралдаан зохион байгуулж, хурдан морьдын үнэ өндөр байгааг ч бид мэднэ. Гагцхүү уламжлалаа зүй зохистой өвлүүлэн үлдээж, хүүхдийг эрхийг зөрчихгүй байх нь чухал асуудал юм.

Хоёр. Уралдаанч хүүхдийн амьд явах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн асуудал

Хүүхдийн эрхийн тухай конвенцод Монгол Улс 1990 онд нэгдэн орсон бөгөөд Олон улсын өмнө хүүхдийн эрхийг хамгаалах үүрэг хүлээсэн. Манай улс уг конвенцын оролцогч улс болохын хувьд мөн Үндсэн хуулиараа Монгол Улсын иргэн бүр амьд явах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхтэй гэж заасанчлан уралдаанч хүүхдийн амь нас, эрүүл мэнд, эрүүл, аюулгүй орчинд амьдрах асуудлыг анхааралдаа авах нь зүйтэй. Гэвч уралдаанч хүүхдийн эдгээр эрхүүд зөрчигдөж байгааг дараах тоон баримтаас харж болно.

Монгол Улсад 2017-2018 онд нийт 121450 морийг 71121 хүүхэд уралдуулснаас 942 хүүхэд мориноос унаж, 22 хүүхэд хүнд гэмтэл авч, 1 хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй болж, 2 хүүхэд амь насаа алдсан. 2019 онд 172 хурдан морины уралдаан зохион байгуулагдсанаас 121 хүүхэд унаж бэртсэн байна.¹⁵ 2022 оны 7 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд нийт 835 уралдаан зохион байгуулагдаж, давхардсан тоогоор 33,818 уралдаанч хүүхэд оролцжээ. Тухайн уралдаанч хүүхдүүдээс 292 хүүхэд хөнгөн бэртэл, 12 хүүхэд хүнд бэртэл авсан байна. Үүнээс зургаан хүүхэд эмнэлгийн байгууллагад хүргэгдэж, эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан бол зургаан хүүхэд уралдааны үеэр амь насаа алдсан гэх харамсалтай мэдээ байна.¹⁶

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2018 оны хяналт шалгалтын дүнгээс үндэсний их баяр наадмаар хамгаалалтын дуулгагүй 336, хамгаалах хувцас хэрэгсэлгүй 183, морины хэрэгсэлгүй 330, гуравласан гэрээ байгуулаагүй 4771, даатгуулаагүй 1174 хүүхэд уралдаанд оролцуулсан зөрчил илэрсэн. Мөн 7 нас хүрээгүй 52 хүүхдийг уралдаанд оролцуулах гэж байсныг зогсоосон. 2018 оны дүн мэдээг 2017 онтой харьцуулахад мориноос унаж, амь нас нь эрсэдсэн тохиолдол байхгүй, мориноос унасан хүүхдийн тоо 282-аар, хөнгөн гэмтэл авсан хүүхдийн тоо 39-өөр тус тус буурсан үзүүлэлттэй байна. Осол гэмтлийн тоо буурахад нөлөөлсөн гол хүчин зүйл нь хүүхдийн хамгаалах хувцас хэрэгсэл болон морины хамгаалах хэрэгслийг стандартын дагуу зөв, бүрэн хэрэглэсэнтэй

¹⁴ А.Ихсанаа, *Тэд хүүхдээр уралдааны тэмээ унуулбал шоронд орно*, gogo.mn, <https://gogo.mn/r/jmow8/>, [Сүүлд үзсэн: 2023.05.03].

¹⁵ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын 2020.07.09-ний өдрийн албан ёсны мэдээлэл.

¹⁶ Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2022.07.26-ны өдөр гаргасан мэдээлэл.

холбоотой гэж үзжээ.¹⁷

Зөвхөн уралдааны явцад гэлтгүй өдөр тутмын амьдралын хүрээнд мориноос унах, моринд өшиглүүлэх зэргээр бэртэл гэмтэл авсаар байна. 2022 оны эхний хагас жилийн байдлаар Гэмтэл согог судлалын үндэсний төвийн яаралтай түргэн тусламжийн тасагт мориноос унаж гэмтсэн шалтгаанаар нийтдээ 600 гаруй хүн ирснээс 242 нь хүүхэд хурдан морь унаж байгаад бэртсэн мөн гэмтлээ даалгүй нас барсан 23 тохиолдол байна. Мориноос унаж гэмтсэн хүүхдүүдийн дийлэнх хувийг 8-11 насны хүүхэд эзэлж байгаа бөгөөд ихэнх нь тархины гэмтэл, дээд, доод мөчний хугарал, гэмтэлтэй байжээ.¹⁸ Түүнчлэн, хурдны морь тогтмол унаснаар хүүхдийн биед ямар нөлөө үзүүлдэг талаар биений тамир, спортын улсын хорооны спортын мэргэжлийн эмч нар хамтран 21 аймгийн 8-14 насны 80 уралдаанч хүүхдийн бие бялдрын ерөнхий хөгжилд судалгаа хийжээ. Энэхүү судалгаагаар хэвийн хөгжилтэй хүүхдүүдтэй харьцуулахад нийт хурдан морь унадаг хүүхдүүдийн 12 хувьд нь цээжний хэлбэр шөвгөр, 28 хувьд нь хэт хөнгөн ясны бүтэцтэй биений хэв шинж, 8,75 хувьд нь нурууны нэг тал руу мурийсан мурийлттай, 8,75 хувьд нь хөлийн ул хавтгай болсон, 6,25 хувь нь шувуун цээжтэй гэжээ.¹⁹ Мөн, эрүүл мэндийн байгууллага дээр хийгдсэн клиник бодит судалгаа болон бэртэл гэмтэлд хийгдсэн дүн шинжилгээгээр хурдан морины уралдаанч хүүхдэд толгой болон мөчдийн гэмтэл, ясны хугаралт, хөлдөлт, осгох, амьсгалын замын өвчин, дотор эрхтний доргилт, нүдний эвэрлэг бүрхүүлийн гэмтэл зэрэг бэртэл гэмтэлт өртдөг байна.²⁰

Хүүхэд чанартай хоолтэжээлээр хангагдах эрхтэй.²¹ Саяхныг хүртэл уралдаанд оролцох хүүхдийг хөнгөн байлгахын тулд шар будаанаас өөр хүнд хоол идүүлдэггүй уламжлалтай²² байсан ч энэхүү уламжлал нь өнөөг хүртэл байсаар байна. Хүүхдийн жин хөнгөн байснаар морины давхих хурдад сайнаар нөлөөлдөг хэмээн хүүхдэд бага хэмжээний хоол өгөх тохиолдлууд ажиглагдсан. Түүнчлэн, хүүхдийг чанартай амин дэм агуулсан хоол хүнсээр хангах нь эцэг эхийн үүрэг боловч айлд амьдарч буй хүүхдүүдийн хувьд хэрхэн аж төрж буйд хяналт тавих боломжгүй, хоол хүнсний асуудал нь ч эрсдэлтэйд тооцогдоно.

Хүүхдийн амьд явах жам ёсны эрхийг хүлээн зөвшөөрч, хүүхдийн амьдрах, эсэн мэнд хөгжих бололцоог дээд зэргээр бүрдүүлэн хангах үүргийг Төр нь Олон улсын болон иргэдийнхээ өмнө хүлээсэн.²³ Үүний дагуу эрх бүхий байгууллагаас уралдаанч хүүхдийн эрхийн асуудалд анхаарлаа хандуулж, зарим нэг арга хэмжээг авсан байна. Тухайлбал, 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн Үндэсний их баяр наадмын тухай хуульд өмнө нь байгаагүй хэд хэдэн заалтыг нэмж тусгасан. Үүнд Үндэсний их баяр наадмын үндэсний хурдан морины уралдаанд уралдах морийг найм, түүнээс дээш насны хүүхэд унах бөгөөд уралдаанч хүүхэд нь уралдааны үед болон морины сунгаа, бэлтгэлийн үеийг хамруулсан нэг жилийн ослын даатгалд даатгуулсан байна. Үндэсний хурдан морины уралдааны явцад хүүхдийг ослын даатгалд даатгуулсан эсэх болон стандартын шаардлага хангасан хамгаалалтын хувцас, хэрэглэл хэрэглэж байгаа эсэхэд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина гэж зааснаас гадна уралдаанч хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага MNS 6264:2018 стандартыг хэрэгжүүлж эхэлсэн. 2003 оны хуульд 7-оос дээш насны хүүхэд

¹⁷ Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2019.07.01 -ний өдрийн тайлан.

¹⁸ Гэмтэл согог судлалын үндэсний төвийн яаралтай түргэн тусламжийн тасгийн 2022.06.28-ны өдрийн тайлан мэдээ.

¹⁹ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, “Хүүхдийн хөдөлмөрийн чанарын судалгаа”, Уб, 2022, 80 дахь тал.

²⁰ С.Отгонбаяр, *Морь унаач хүүхдийн амь нас хохирсон ч зөлей тохиолдол хэмээн үзэж харцуцлага тооцдоггүй гэв*, Шуурхай. mn, <https://shuurhai.mn/p/20920>, [Сүүлд үзсэн: 2023.09.21].

²¹ Хүүхдийн эрхийн тухай конвенц, 1990 он, 24 дүгээр зүйлийн 1 дэх заалтын е хэсэгт Хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээл, хөхөөр хооллохын давуу тал, эрүүл ахуй, амьдрах орчны ариун цэвэр, осол аюулаас урьдчилан сэргийлэх талаарх мэдээллээр нийгмийн бүх давхарга, түүний дотор эцэг эх, хүүхдийг хангах, түүнчлэн энэ талын боловсролтой болох, суурь мэдлэгээ ашиглахад дэмжлэг тусалцаа үзүүлэх.

²² О.Намнандорж, *Монголын хурдан морины тухай*, Ардын цэргийн хэвлэл үйлдвэр, 1951, 46 дахь тал.

²³ Хүүхдийн эрхийн тухай конвенц, 1990, 6 дугаар зүйлийн 1 дэх заалт.

хурдан морь унана гэж заасныг нэг насаар ахиулсан ч энэ нь төдийлөн ач холбогдолтой гэж үзэхгүй байна. Харин хяналт тавих байгууллагыг тодорхой болгож, уралдаанчдыг даатгалд хамруулах, хамгаалалтын хувцас хэрэгслийг стандартжуулсан нь сайшаалтай ч уралдаанч хүүхдийн эрх хамгаалах асуудал бүр мөсөн шийдэгдээгүй л байна. Төрөөс томоохон ач холбогдол бүхий арга хэмжээ авсан нь жил бүрийн 10 дугаар сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хурдан морины уралдаан зохион байгуулахыг хориглосон шийдвэр гаргасан явдал юм.²⁴ Ингэснээр хүйтний улиралд хүүхдүүд хурдан морины уралдаанд оролцож, гар хөлөө хөлдөөх, осгох, амь насаа алдах эрсдэлээс сэргийлж чадсан. Гэсэн хэдий ч хүүхдийг хурдны морь уралдуулахыг хориглоогүй цагт хүүхдийн амь нас, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх эрсдэл дагуулсаар байна.

Дараагийн хөндөгдөх чухал асуудал нь хүүхэд уралдааны болон түүнд бэлтгэх явцад мориноос унаж, амь нас, эрүүл мэндээрээ хохирсон тохиолдолд хариуцлагын тогтолцоо манай улсад хараахан бүрэлдээгүй байна. 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдөр Зөрчлийн тухай хуульд шинэ хоёр заалт оруулсан нь хурдан морины уралдаанд уралдаанч хүүхдэд болон бусад хүүхдийн аюулгүй байдалд эрсдэлтэй нөхцөлийг үүсгэж, амь нас, эрүүл мэндэд хохирол учруулахуйц эд зүйл хэрэглүүлсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учирсан хохирлыг нөхөн төлүүлж уяачийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.²⁵ Үндэсний бөх, сурын болон шагайн харваа, хурдан морины дүрмийг бөх, уяач, сурын болон шагайн харваач, дасгалжуулагч, эмч зөрчсөн бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэж тус тус нэмэлт өөрчлөлт оруулжээ. Дээрх хуулийн заалтууд нь учир дутагдалтай ба уралдаанч хүүхэд сунгаа, үсэргээ, уралдааны үед эсхүл, өдөр тутмын амьдралд хурдны морь унахдаа ямар нэгэн байдлаар бэртэл гэмтэл авах, нас барсан тохиолдолд хохирлыг барагдуулах мөн эмчилгээний зардлыг хариуцах эзэнгүй, золгүй явдал хэмээн үзэж байна. Жишээ нь, Өвөрхангай аймагт зохион байгуулагдсан уралдаанд 12 настай эмэгтэй хүүхэд мориноосоо унаж, түнх, булууны яс нь хугарч, хөлгүй болж, байнгын тахир дутуу болсон бөгөөд эмчилгээний зардал байхгүйгээс гадаад улс орон явж, эмчлүүлж чадалгүй насан туршдаа тахир дутуу болсон.²⁶ Мөн, долоодугаар ангийн Самбо, жүдогоор хичээллэдэг эрэгтэй хүүхэд ахынхаа хурдны морийг уралдуулж байхдаа мориноос унаж, тархиндаа хүнд гэмтэл авсны улмаас эмчилгээ хийлгэсэн ч одоо тухайн хүүхэд нь эрүүл мэндийн байдлаас шалтгаалан морь унах, спортоор хичээллэх боломжгүй болсон байна.²⁷ Морь бол адгуус амьтан ямар ч үед эрсдэлийг дагуулна, уралдааны явцад айж үргэх, хадуурч давхих зэргээс хүүхэд мориноос унаж амь насаа алдах, бэртэх эрсдэлтэй төдийгүй энэ мэт бодит тохиолдлууд олноор байгааг Төр болон зарим иргэд мэдсэн ч мэдээгүй мэт хүүхдийн амь нас, насан туршийн тахир дутуу болох эрсдэлээр баяр цэнгэлийн зугаа хийж, хохирлыг барагдуулах тогтолцоо ч үгүй наадамдсаар л байна.

Гурав. Уралдаанч хүүхдийн хөгжих буюу сурч боловсрох эрхийн асуудал

Хүүхэд амрах, чөлөөт цагаа өнгөрүүлэх, насныхаа онцлогт тохирсон тоглоом болон наадамд оролцох эрхтэй.²⁸ Түүнчлэн, хүүхдийн хичээлийн оролцоог тогтмолжуулах болон сургууль завсардалтын түвшнийг бууруулах үүргийг Төр хүлээнэ.²⁹ Нөгөөтээгүүр, эцэг эх, асран хамгаалагчид хүүхдээ боловсрол эзэмшүүлэх, гэр бүлийн хүмүүжил олгох болон амралт, чөлөөт цагийг гаргаж, тавтай өнгөрүүлэхэд анхаарах үүрэгтэй. Харамсалтай нь зарим уралдаанч хүүхдийн сурч боловсрох эрх зөрчигдөж байна. Тухайлбал, уяачид, эцэг, эхчүүд хичээлийн жил дуусаагүй байхад ойролцоогоор 4 дүгээр сараас эхлэн хүүхдүүдийг

²⁴ Монгол Улсын Засгийн газрын тогтоол, 2019, дугаар57.

²⁵ Зөрчлийн тухай хууль, 2017, 6 дугаар зүйлийн 20 дахь заалт.

²⁶ О.Мөнхсайхан, *Хурдан мориноос унаж амь насаа алдсан 25 хүүхдийн гэгээн дурсгалд зориулав*, <https://ikon.mn/n/ydh>, [Сүүлд үзсэн: 2023.01.13].

²⁷ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, “Хүүхдийн хөдөлмөрийн чанарын судалгаа”, Уб, 2022, 82 дахь тал.

²⁸ Хүүхдийн эрхийн тухай конвенц, 1990 он, 31 дүгээр зүйлийн 1 дэх заалт.

²⁹ Хүүхдийн эрхийн тухай конвенц, 1990 он, 28 дугаар зүйлийн 1 дэх заалт е хэсэг.

сургуулиас нь нууцаар авч явах тохиолдол нийтлэг гардаг байна.³⁰ Жил бүрийн 5 дугаар сараас эхлэн анги дэвших болон төгсөлтийн шалгалт явагдах үетэй зэрэгцэн хурдан морины хаврын уралдаан эхэлж, хүүхдүүд хичээл таслах, чөлөө авах, хичээлийн хоцрогдол үүсэх асуудлууд гарсаар байна. Зарим уралдаанч хүүхдийн гэр бүлийн амьжиргааны түвшин доогуур байгаагаас хүүхдээ мөнгөөр хурдны морь унуулахын тулд эцэг эх нь өөрсдөө сургуулиас нь чөлөө авах ч тохиолдол гардаг.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос гаргасан “Хүүхдийн хөдөлмөрийн чанарын судалгаа”-ны тайланд дурдсан уралдаанч хүүхдүүдийн өдрийн цаг зарцуулалтын талаар хийсэн ярилцлагыг сийрүүлбэл, “Өглөө 6 цагт босож, мориндоо ус, гэжээл өгөөд, өдөр жүчээндээ байлгана, орой мөн л морины ажлаа хийгээд их оройтож гэртээ ордог. Тэр хооронд зав гарахаар л тоглодог” гэж 9 настай хүүхэд хэлсэн бол туслах уяач, уралдаанч 14 настай хүү “Ажил маш их ба 6-7 дугаар ангид байхдаа л бага зэрэг зав гарч, тоглож нааддаг байсан тэрнээс хойш уяачийн туслахтай адилхан өдөр шөнөгүй ажиллахын хажуугаар морио унаж уралдуулдаг. Ер нь 13-аас дээш настай унаач хүүхдүүдийн хувьд өглөө эрт ус зөөж, морио услаад, гэжээлийг нь зуурч тавьж өгөх, өдрийн цагаар морио алхуулж байгаад ..., Өвөл, хавартаа уралдаан цөөнтэй бол сургуульдаа яваад бага ч гэсэн зав гарна. Харин зун, намрын цагт зав гарна гэж бараг байхгүй. Уяач болон туслах уяачийн хийдэг бүх ажлыг хийгээд явдаг болохоор ажил үнэхээр ихтэй” гэж хэлсэн байна.³¹ Мөн, хүүхдүүд “Өглөө эрт босдог, орой 23 цаг гээд амраад, уралдааны үед үүрээр босдог. Морь унахаа болиод гэртээ байдаг ажил хийх юм сан гэж боддог. Морь унадаг эмэгтэй хүүхдүүдийн хувьд ялгаа бага ч тэд гүү, үнээ саахад тусалдаг. Морио услах, байраа цэвэрлэх хоол хийх гээд ижил ажил хийдэг. Эрэгтэй хүүхдүүд малд явах, мал ялгах зэрэгт нэмж тусалдаг” гэжээ.³² Хурдны мориог өдөрт нэг удаа л уралдуулдаг боловч хүүхдийг дараалан дөрвөн насны морь унуулах тохиолдол гарч, ингэснээр нийт 100 орчим километр замыг морин дээр өнгөрөөдөг байна.³³ Эдгээр хүүхдийн сурч боловсрох, нийгмийн амьдралд оролцож хөгжих нь хаагдмал, морь уралдуулах, мал аж ахуйн өдөр тутмын ажил хөдөлмөр эрхлэхэд дийлэнх цагийг өнгөрүүлж байна. Эрдэмтэд хүүхдийн бага насны туршлага, хөгжлийн шинж байдал нь түүний ирээдүйн амжилттай суралцах, чанартай амьдрах эх үндэс болдог³⁴ хэмээн үзэж байхад манай улс бага насны хүүхдийн таньж мэдэх, сурч боловсрох онцлогийг үл харгалзан уралдаанч хүүхдүүдийг зөвхөн морин уралдаанд зориулж, тэдгээрийн хөгжих буюу сурч боловсрох эрхийг зөрчиж байна.

Хүүхдийн эрхийн тухай конвенцод Хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангахад шаардлагатай хэмээн эрх бүхий байгууллага, шүүхийн шийдвэрийн дагуу, хэрэглэгдэх хууль, журмыг үндэслэн шийдвэр гаргаснаас бусад тохиолдолд хүүхдийг хүсэл зоригийнх нь эсрэг эцэг эхээс нь салгахгүй байх үүрэг хүлээнэ. Ийм шийдвэрийг эцэг эх хүүхдэдээ хэрцгийгээр харьцах, анхаарал, халамжгүй орхих, эсхүл эцэг эх нь тусдаа амьдардаг тохиолдолд хүүхдийн оршин суух газрын талаар зохих шийдвэрийг гаргана гэж заасан.³⁵ Өөрөөр хэлбэл, шүүхийн шийдвэрээс бусад тохиолдолд хүүхдийг эцэг эхээс нь удаан хугацаагаар салгаж үл болно. Гэтэл зарим уралдаанч хүүхэд эцэг эхээсээ хол уяачдыг даган айлд амьдрах ч тохиолдол гарч байна. Эцэг эхийн хараа хяналт, хайр халамжаас ангид, сурч боловсрох эрх нь зөрчигдөн, эцэг эх нь хүүхдэдээ боловсрол олгож, сурч хөгжихөд нь дэмжлэг үзүүлэхийн оронд таньж мэдэхгүй орчин, хүмүүсийн дунд хөдөлмөр эрхлүүлэхээр явуулж байгаа нь хүүхдийн эрхийн ноцтой зөрчилд тооцогдох нь лавтай.

³⁰ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, “Хүүхдийн хөдөлмөрийн чанарын судалгаа”, Уб, 2022, 76 дахь тал.

³¹ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, “Хүүхдийн хөдөлмөрийн чанарын судалгаа” Уб, 2022, 78 дахь тал.

³² Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс “Хүүхдийн хөдөлмөрийн чанарын судалгаа”, Уб, 2022, 79 дэх тал.

³³ Х.Хорлоо, Б.Одончимэг, *Найман настай хүүхэд хурдан морь унах нь зүйтэй юу*, globalpressjournal.com, <https://globalpressjournal.com/asia/mongolia/8-year-old-allowed-race-horse/mn/>, [Сүүлд үзсэн: 2023.04.27].

³⁴ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан, “Бага насны хүүхдийн цогц хөгжил” судалгаа, Уб, 2020,10 дахь тал.

³⁵ Хүүхдийн эрхийн тухай конвенц, 1990, 9 дүгээр зүйлийн 1 дэх заалт.

ДУГНЭЛТ, САНАЛ

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, хуульч, судлаач, мэргэжилтэн, сэтгүүлч нар өнөө цагт хурдан морины уралдаанч хүүхдийн амьд явах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох эрх нь зөрчигдөж, цаашлаад хөдөлмөрийн мөлжлөгт өртөж байгааг тодорхой судалгаа, тоо баримтаар харуулж байгаа боловч эрх бүхий байгууллагаас төдийлөн дорвитой арга хэмжээ авахгүй байна. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Монгол Улс дахь Удирдлагын баг нь тус байгууллагын хүний эрхийн шинжээчдээс ирүүлсэн удаа дараагийн ажиглалт, зөвлөмжид үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их хурлын даргад албан захидал илгээсэн билээ. Уг мэдэгдэлд Монгол Улсын Засгийн газрыг 18-аас доош насны хүүхдийг жилийн аль ч улиралд хурдны морь унуулж уралдуулахгүй байхыг хууль тогтоомж, зохион байгуулалтын үйл ажиллагаандаа тусган, шаардлагатай бүхий л арга хэмжээг нэн яаралтай авч хэрэгжүүлнэ гэдэгт найдаж байгаагаа илэрхийлсэн.³⁶ Гэсэн ч Монгол Улсын эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас одоог хүртэл хариу илгээгүй, шаардагдах арга хэмжээг аваагүй байна. Хүүхдийн эрхийг чухалчлах атал үл тоомсорлож байгаа нь нэг талдаа шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтнууд өөрсдийн эрх ашиг давамгайл байж болзошгүй хэмээх хардлага урган гарч байна. 2017 онд Al Jazeera Монголын улс төрчид 654 хурдан морь эзэмшиж байгааг олж тогтоосон баримт олон нийтэд ил болж байсан.³⁷ Тэгвэл НҮБ-ын зөвлөснөөр нэн даруй насанд хүрээгүй хүнээр хурдны морь унуулж, уралдуулахгүй байх шийдвэр гаргах нь зөв эсэхэд анхаарлаа хандуулъя. Юуны өмнө шууд хориглох нь зохимжгүй, одоогийн байдлаар тухайн асуудлаар хүүхдийн эрхийн зөрчилтэй холбогдолтой судалгаа нэлээдгүй бий ч эрс хориглосноор олон нийт үүнийг хэрхэн хүлээж авах болон цаашдын эрсдэлийн судалгаа хомс байна. Өөрөөр хэлбэл, хүүхдийг хурдны морь унуулахыг хориглосноор түүхэн дэх “Хуурай хууль”³⁸-ийн алдааг давтах эрсдэлтэй гэх саналыг гаргаж байна. Хөдөө орон нутагт нууцаар бооцоот уралдаан зохион байгуулах, хүүхдийн эрхийн зөрчил улам л нуугдмал шинж рүү орж болзошгүй. Иймд энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд шат дараатай арга хэмжээг авах нь зүйтэй хэмээн үзэж, дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу 13-аас дээш насны хүнээр эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөлтэйгөөр хурдны морь унуулахаар хуульчлах. Харин бага насны хүүхдээр хурдны морь унуулсан тохиолдолд хариуцлагыг чангатгах нь чухал. Цаашлаад хэдэн жилийн дараагаар насны хязгаарыг 15 нас болгон өөрчилбөл зохино. Ингэж аажмаар арга хэмжээ авснаар хүүхдийн эрхийн зөрчил хурцадмал болоод нуугдмал байдалд орохоос сэргийлэхийн зэрэгцээ өв уламжлалаа ч зүй зохистой авч үлдэх ач тустай хэмээн үзэж байна. Бусад улс орны туршлагаас үзвэл, Арабын Нэгдсэн Эмират Улс 2002 оны 07 дугаар сард 15 наснаас доош настай хүүхдийг тэмээн уралдаанд оролцуулахгүй байх шийдвэр гаргаж, бага насны хүүхдийг тэмээн уралдаанд оролцуулбал хорих ял оногдуулах арга хэмжээ авдаг болсон. Харин Катарын Эмир Хамад Аль Тхани 2005 онд хүүхдийг тэмээн уралдаанд оролцуулахыг хориглож, 2007 онд тэмээн уралдаанд робот ашиглах тухай зарлиг гаргажээ.³⁹ Ийм шийдвэрийг гаргасан ч эдгээр улсын тэмээн уралдааны өв соёл хадгалагдан үлдсэн хэвээр л байна.

2. Уралдаанч хүүхдийн насны доод хязгаарыг 13 нас болгоход асуудал бүрэн шийдэгдэхгүй тул учирч болох эрсдэлийг бүрэн тооцоолж, тэдгээрээс сэргийлэх арга хэмжээг авах нь зүйтэй. Тухайлбал, морин уралдаан зохион байгуулах нэгдсэн дүрмийг

³⁶ <https://mongolia.un.org/mn/>. [Сүүлд үзсэн: 2023.04.27].

³⁷ Ж.Мандхай, Унаач хүүхдүүд амь насаараа дэнчин тавин уралдаж байна, Ikon.mn, <https://ikon.mn/opinion/1m7r>. [Сүүлд үзсэн: 2023.05.03].

³⁸ <https://www.oxfordreference.com/display/10.1093/oi/authority.20110803100348899>. [Сүүлд үзсэн: 2023.09.25].

1920-1933 оны хооронд АНУ-д архи, согтууруулах ундаа үйлдвэрлэх, худалдаалахыг хуулиар хориглосон ч зохион байгуулалттай бүлэглэлүүд хууль бусаар архи, согтууруулах ундаа зарж, иргэдийн архины хэрэглээ өсөж, гэмт хэргийн тоо огцом нэмэгдсэн тул хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, архи, согтууруулах ундаа үйлдвэрлэх, худалдаалахыг зөвшөөрсөн.

³⁹ А.Ихсанаа, Тэд хүүхдээр уралдааны тэмээ унуулбал шоронд орно, gogo.mn, <https://gogo.mn/r/jmow8/>. [Сүүлд үзсэн: 2023.05.03].

баталж, тухайн дүрэмд уралдааны зохион байгуулалт, аюулгүй байдлыг нарийвчлан тусгавал зохино. Цаашлаад уралдаанч хүүхдийн аюулгүй байдалд хамаарах бүхий л хяналт шалгалт, уралдааны бэлтгэл ажилд туулах замыг нарийвчлан тогтоох, морь үргэж саад болох зүйлс байгаа эсэхийг шалгах, уралдааны явцад олон тооны машиныг зэрэгцүүлэн явуулахгүй байх, шаардлагатай эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх байршлыг зааж өгөх, алсын зайны удирдлагатай камерын тоо болон аюулгүй ажиллуулах талаар тусгах, газар зүйн онцлог, цаг агаарын нөхцөл байдал зэргийг тус тус тогтоож өгөх шаардлагатай. Одоогийн байдлаар нарийн тогтоосон зохион байгуулалтын нэгдсэн дүрэмгүй учир аймаг, сумд засаг захиргааны нэгжүүд харилцан адилгүй морин уралдааныг зохион байгуулж байна. Жишээ нь, зарим аймаг, сумдын хурдан морины уралдааны явцад цөөн тооны машин зэрэгцүүлэн явуулж байхад нэг хэсэг нь үзэгдэх орчингүй тоос шороо ихтэй нөхцөлд олон тооны машин хамтад нь явуулж байгаа нь уралдаанчдад хүндрэлтэй нөхцөл үүсгэдэг.

3. Уралдаанч хүүхдийн эрх зөрчигдөхөд гол нөлөө үзүүлж байгаа этгээд нь тэдгээрийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нар байж болох юм. Гэр бүлийн хэрэгцээнд өөрийн хүүхдээр хурдны морь унуулж байгаа ч үйлдлийнхээ үр дагавар, эрсдэлийг бүрэн тооцоолох чадваргүй бага насны хүүхэдтэй холбоотой шийдвэр гаргахдаа хүүхдийнхээ ашиг сонирхлыг чухалчлах ёстой. Иймд бага насны хүүхдээр морь унуулах шийдвэр гаргаж буй эдгээр хүмүүст хүүхдийн эрхийн тухай ойлголт, холбогдох эрх зүйн акт, бага насны хүүхдээр хурдны морь уралдуулахад үүсэх эрсдэлүүдийг таниулах ажил болон хүүхдийн эрхийн зөрчлийн тогтмол хяналтыг холбогдох төрийн байгууллага, харьяа сургуулиудтай хамтарч явуулах. Түүнчлэн, айлд бага насны хүүхдээ хурдны морь унуулах нэрийдлээр хөдөлмөр эрхлэхийг зөвшөөрсөн, хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох эрхийг илт ноцтойгоор зөрчиж, бага насны хүүхдийг хурдны морь унуулах, мал аж ахуйн ажилд хүнд хөдөлмөр эрхлүүлж буй эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нарт хариуцлага тооцох тогтолцоог бий болговол зохино.

4. Олон тооны морин уралдааныг цэгцэлж, тоог нь багасгах арга хэмжээ авах. Жилд дунджаар том жижиг 2400 гаруй хурдан морины уралдаан зохион байгуулагддаг байна.⁴⁰ Гэхдээ энэ нь албан бус тоо бөгөөд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын мэдээллийн санд 2018-2020 онд нийт 671 уралдаан зохион байгуулснаас аймаг, сумдад 647, нийслэлд 24 уралдаан зохион байгуулагдсан гэж бүртгэгджээ. Дээрх тооны зөрүү нь бүртгэлгүй хурдан морины уралдаан олноор зохион байгуулагдаж байгаа нь илэрхий харагдахаар байна. Улсын төсвөөс санхүүжиж зохион байгуулагддаг уралдааны тоог багасгаснаар улсын төсөвт ч хэмнэлт үзүүлж болох юм. Түүнчлэн, бүртгэл хийлгээгүй үсэргээ, сунгаа, уул, овооны тахилга, ургийн баярт зориулсан болон бооцоот уралдаан зохион байгуулж, хүүхдийн насыг үл харгалзан, хамгаалах хувцас хэрэгсэлгүйгээр морь уралдуулах тохиолдол олонтой гарч байна. Иймд том жижиг гэлтгүй уралдаан бүрд зохион байгуулалтыг сайжруулах, уралдаанч хүүхдүүдийн бүртгэл, аюулгүй байдалд хяналт тавих тогтолцоог бий болгох шаардлагатай хэмээн үзэж байна.

⁴⁰ А.Тэлмэн, Хурдан морины уралдааны төлөв байдал, ирээдүй, [todmagnai.mn](http://www.todmagnai.mn), <http://www.todmagnai.mn/n/2f>, [Сүүлд үзсэн: 2023.10.05].

ЭХ СУРВАЛЖ**Монгол хэл дээрх*****Хууль, тогтоомж***

1. Хүний эрхийн түгээмэл тунхаглал 1948.
2. Хүүхдийн эрхийн тухай конвенц 1989.
3. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 182 дугаар конвенц 1999.
4. Хөдөлмөрийн насны доод хязгаарыг тогтоох 146 дугаар зөвлөмж 1973.
5. Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 138 дугаар конвенц 1973.
6. Монгол Улсын Үндсэн хууль 1992.
7. Хөдөлмөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ 2021.
8. Үндэсний их баяр наадмын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ 2022.
9. Хүүхдийн эрхийн тухай хууль 2016.
10. Зөрчлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ 2017.
11. Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/ 2015.
12. Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль 2020.
13. Монгол улсын Засгийн газрын 2005 оны 06 дугаар сарын 07-ний өдрийн 119 дугаар тогтоол
14. Монгол улсын Засгийн газрын 2019 оны 57 дугаар тогтоол
15. Монголын хурдан морины уралдааны дүрэм /шинэчилсэн найруулга/ 2019.
16. Монголын морин спорт, уяачдын холбоо нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагын дүрэм 2019.
17. Монголын морин спорт, уяачдын холбооны Рейтингийн зөвлөлийн чансаа тогтоох журам 2019.
18. Монгол Улсын Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яамны сайдын 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/759 дугаар тушаал.
19. Увс аймгийн засаг даргын “Баяр наадам, нийтийг хамарсан арга хэмжээг хориглох тухай” захирамж 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдөр А/428.
20. Архангай аймгийн засаг даргын “Бүсийн уралдааны тов тогтоох тухай” захирамж 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр.
21. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын зөвлөмж 2018 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр 1/04.
22. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүний зөвлөмж 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдөр 05/02.

Ном, өгүүлэл, судалгааны тайлан

1. О.Намнандорж, Монголын хурдан морины тухай, Ардын цэргийн хэвлэх үйлдвэр, 1951.
2. Х Сампилдэндэв, Н.Уртнасан, Т.Дорждагва. Монгол зан үйл, баяр ёслолын товчоон, УБ Бемби Сан, 2006.
3. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Хүний эрхийн цуврал нийтлэл, 2012.
4. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Эрх зүйн судалгааны төв, Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан, Хурдан морины хаврын уралдаан ба хүүхдийн эрх хурдан морины хаврын

- уралдаан ба хүүхдийн эрх судалгааны тайлан, Улаанбаатар хот, 2015.
5. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Хүүхдийн хөдөлмөрийн чанарын судалгаа, 2022.
 6. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан, Бага насны хүүхдийн цогц хөгжил, судалгаа, Улаанбаатар хот, 2020.
 7. О.Мөнхсайхан, Унаач хүүхдийн амь нас, эрүүл мэндээс илүү чухал зугаа, уламжлал байх ёсгүй, 2017.

Цахим эх сурвалж

1. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын 2020 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн албан ёсны мэдээлэл <https://nhrcm.gov.mn/>.
2. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Цагдаагийн ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн 2022 оны 06 дугаар 30-ны өдрийн хамтран гаргасан мэдээлэл <https://www.fcy.gov.mn/website/home.aspx>.
3. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2019 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн тайлан <https://www.igov.mn/>.
4. Гэмтэл согог судлалын үндэсний төвийн яаралтай түргэн тусламжийн тасгийн тайлан мэдээ 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдөр <https://www.gemtel.mn/>.
5. <https://vip76.mn/content/25904>.
6. <https://montsame.mn/mn/read/296832>.
7. <https://mongolia.un.org/mn/>.
8. <https://ikon.mn/opinion/1m7r>.
9. <https://ikon.mn/n/ydh>.
10. <https://gogo.mn/r/jmow8/>.
11. <https://news.mn/r/2566055/>.
12. <http://child.gov.mn/news/5fbfafb7af97ad5c9a7f6ae5/detail/62c6d8640509076bfe-f58eab>
13. <https://www.policywatch.mn/huuhdiinerhiinumguulul.html>.
14. <https://www.oxfordreference.com/display/10.1093/oi/authority.20110803100348899>
15. <http://www.todmagnai.mn/n/2f>.
16. <https://globalpressjournal.com/asia/mongolia/8-year-old-allowed-race-horse/mn/>

Гадаад хэл дээрх

Ном, өгүүлэл, судалгааны тайлан

1. Journal of Archaeological Science, volume 81, “A Bayesian chronology for early domestic horse use in the Eastern Steppe” 2017, P.56.

**ISSUES RELATED TO THE RIGHTS OF CHILD JOCKEYS IN MONGOLIAN
TRADITIONAL HORSE RACING AND WAYS TO SOLVE IT*****Bayasgalan.T****Ph.D student, Inner Mongolia University***ABSTRACT:**

This research includes issues related to the rights of child in Mongolian traditional horse racing and to put forward recommendations to improve the legal framework for promoting the protection of the rights of child jockeys. The rights of child jockeys have become critical issue in recent years, and many alarming issues have emerged concerning injuries or fatalities of those children due to the falling off horses during racing. The Mongolian people have been nomadic for a living since ancient times and still retain their nomadic culture to this day. Horses are not only the most important mounts in nomadic life, but have also played a crucial role in daily life, production, and warfare for centuries. The Mongolian ethnic group holds horse racing activities during festivals to liven up the festive atmosphere. However, nowadays children, sometimes as young as 8 years old, are competing in horse racing under circumstances that are detrimental to their survive, health, education, family life, play and recreation, an adequate standard of living and to be protected from abuse and it contradicts in many ways the effective enforcement of the core principles of international standards on child rights. In the future, it is extremely important for us to continue to inherit and promote the traditional horse racing culture without violations of children's rights.

KEYWORDS:

The minimum age of the child jockeys

ШҮҮХИЙН ШИЙДВЭР БИЕЛҮҮЛЭЭГҮЙ ЭТГЭЭДЭД ХҮЛЭЭЛГЭХ ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ХАРИУЦЛАГА, ОНОЛЫН ҮНДЭСЛЭЛ



Я.Батгэрэл

*ДХИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн
Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн эрхлэгч,
дэд хурандаа*

ТОВЧЛОЛ:

Эрүү, иргэн, захиргаа зэрэг эрх зүйн шинжлэх ухааны тодорхой салбарт гол судлагдахуун нь гэм буруугийн асуудал байдаг. Ямар үйлдэл, эс үйлдлийг эрх зүйн зөрчил, гэмт хэрэг гэж үзэх, эдгээрт холбогдсон этгээдийг хэдийд ямар шалгуураар гэм буруутайд тооцож хууль зүйн хариуцлага хүлээлгэх талаар¹ эрдэмтэн судлаачид судлан онолын янз бүрийн хувилбаруудыг дэвшүүлсээр иржээ.

Хууль зүйн хариуцлагын нэг төрөл болох иргэний эрх зүйн хариуцлагын ойлголт, иргэний хариуцлагын хэлбэр, төрөл, хариуцлага хүлээлгэх үндэслэлийн талаар дэлгэрүүлэн судалж шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд иргэний эрх зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэлийг тодорхойлон гаргахыг зорилоо.

ТҮЛХҮҮР ҮГС:

Иргэний эрх зүй, хууль зүйн хариуцлага, иргэний эрх зүйн хариуцлага, үүрэг хариуцлага, гэм буруу, эрх зөрчигч, төлбөр төлөгч

I. ОРШИЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт “Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх”², “хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх”³ нь Монгол Улсын иргэний шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн ёсчлон биелүүлэх үндсэн үүрэг хэмээн заасан байдаг.

Хуулиар хүлээсэн үндсэн үүргээ манай иргэн бүр шударгаар сахин биелүүлэхэд хариуцлага чухал роль гүйцэтгэнэ. Өөрөөр хэлбэл Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийн заалтыг биелүүлээгүй, эсвэл хүний нэр төр, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгээгүйн төлөө нийгэм нь өөрийнхөө гишүүнд хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх зүй ёсны шаардлага урган гарна. Ийм хариуцлагыг хууль зүйн шинжлэх ухаан

¹ Д.Зүмбэрэлхам, Гэм буруугийн презумпцийн зарчмыг Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хэрэгжүүлэх онол, практикийн зарим асуудал. (докторын зэрэг горилсон бүтээл), 2001, 12 дахь тал.

² Монгол Улсын Үндсэн хууль, 1992, Төрийн мэдээлэл эмхэтгэл №1.

³ Мөн тэнд.

судлах бөгөөд тэр нь нийгмийн хариуцлагын нэгэн онцгой төрөл болох хууль зүйн хариуцлага юм.⁴

Эрдэмтэн, судлаачид хууль зүйн хариуцлагыг олон талаас нь тухайлбал түүхэн, улс төрийн, эдийн засгийн, үйлдвэрлэлийн, хууль зүйн, мэргэжлийн, ёс суртахууны, хувь хүний гэх мэтээр янз бүрээр авч үзсэн байдаг. Хууль зүйн хариуцлагын төрлийг дараах байдлаар 5 ангилан авч үзсэн байна.

- Үндсэн хуулийн хариуцлага;
- Сахилгын хариуцлага;
- Захиргааны хариуцлага;
- Иргэний хариуцлага;
- Эрүүгийн хариуцлага.

Судлаачид хууль зүйн хариуцлагын талаар нэг сэдэвт бүтээл, эрдмийн зэрэг хамгаалах судалгааны ажил, илтгэл, өгүүлэл гаргадаг хэдий ч шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх иргэний эрх зүйн хариуцлагын талаар судалгааны ажил хийгээгүй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явц дахь иргэний эрх зүйн хариуцлага нь эрх зөрчигчийн эд хөрөнгөнөөс хохирлыг албадан гаргуулж, эрх зөрчигдсөн талд олгож, эд хөрөнгөний эрхийг сэргээж, оролцогчдын эрхийг хамгаалдаг төрийн албадлага бөгөөд бусад субъектэд дохио, санамж болж сахилгажуулах хэрэгсэл болдгоороо ихээхэн ач холбогдолтой чухал арга хэмжээ юм.

Иймд энэхүү өгүүллээр хууль зүйн хариуцлагын дотроос иргэний эрх зүйн хариуцлага, түүний төрөл, хэлбэр, хариуцлага хүлээлгэх үндэслэлийн талаар дэлгэрүүлэн судалж, шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх иргэний эрх зүйн хариуцлагын үндэслэлийг тодорхойлж, холбогдох дүгнэлт өгөхийг зорилоо. Уг өгүүллийн хүрээнд түүхчлэн судлах аргыг түлхүү ашигласан болно.

II. ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ХАРИУЦЛАГА:

A. Иргэний эрх зүйн хариуцлагын тухай ойлголт

Иргэний эрх зүйн хариуцлагын талаар манай улсын эрдэмтэн, мэргэд болох хууль зүйн шинжлэх ухааны доктор, академич С.Нарангэрэл, доктор, профессор Т.Мөнхжаргал, доктор, профессор Д.Баярсайхан, доктор О.Отгонтуяа, судлаач Д.Гиймаа, Ж.Ууганчимэг, Т.Азжаргал нар дараах байдлаар томъёолсон байдаг.

Тухайлбал академич С.Нарангэрэл “Иргэний эрх зүйн хариуцлага-(civil legal responsibility); гражданско-правовая ответственность) хууль зүйн хариуцлагын нэгэн төрөл; бусдын иргэний субъектив эрхийг зөрчсөнтэй холбогдсон, иргэний эрх зүйд заасан үүргийг биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйгээс үүсэх иргэний эрх зүйн хэм хэмжээгээр тогтоосон хууль зүйн үр дагавар. Иргэний эрх зүйн хариуцлага нь хууль буюу гэрээгээр тогтоосон тааламжгүй, эдийн засгийн хувьд ашиггүй, эд хөрөнгийн шинжтэй үр дагаврыг буй болгодог хохирлыг нөхөн төлүүлэх, анз (торгууль, алданги) төлөх гэм хорыг арилгах зэрэг нөлөөллийн арга хэмжээг бусад этгээдийн (үүрэг гүйцэтгүүлэгч) эсхүл төрийн эрх ашгийн тулд эрх зөрчигчид (үүрэг гүйцэтгүүлэгчид) хэрэглэхэд оршино⁵” гэж тайлбарлажээ.

Доктор, профессор Т.Мөнхжаргал “Иргэний эрх зүйн дэх хариуцлага нь хууль зүйн бусад хариуцлагад байх нийтлэг шинжийг агуулахын сацуу өөртөө өвөрмөц онцлогтой хариуцлагын хэлбэр юм. Тэрхүү өвөрмөц шинж нь Нэгд: эд хөрөнгөний ба түүнтэй холбоотой эд хөрөнгөний бус харилцаагаар тодорхойлогддог. Хоёрт: иргэний эрх зүй дэх үүргийг хэрхэн гүйцэтгэсэн үр дагавартай шууд холбоотой байна. Өөрөөр хэлбэл үүргийг

⁴ Ж.Долгорсүрэн, Захиргааны хариуцлага. 1998, 8 дахь тал.

⁵ С.Нарангэрэл, Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг, 2021, 240 дэх тал.

биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй, хугацаа хожимдуулсан талын гэм буруутай үйлдэл, эс үйлдлийн сөрөг дагавар баймааж хариуцлага байх ёстой. Гуравт: үүргийг биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйн улмаас үүрэг гүйцэтгүүлэгчид материалын болон сэтгэл санааны хохирол учирсан нөхцөлд хэрэглэгддэг”⁶ гэж тодорхойлсон байдаг бол доктор, профессор Д.Баярсайхан “иргэний хуулиар тогтоосон журмыг зөрчсөн буюу гэрээний үүргээ биелүүлээгүй буруутай этгээдэд хууль ба гэрээний нөхцөл, заалтыг үндэслэн эрх бүхий этгээдээс оногдуулж буй хариуцлага юм. Энэхүү хариуцлагын нэг онцлог нь шүүгч, төрийн эрх бүхий албан тушаалтнаас гадна гэрээний болон иргэний эрх зүйн харилцаанд оролцогч байгууллага, иргэн, хувь хүний аль нэг тал нь уг хариуцлагыг /буруутай талд/ нөгөө талдаа оногдуулах эрхтэй байдагт оршино. Гол төлөв эд хөрөнгийн бүрэн ба хязгаарлагдмал хариуцлага, тэрчлэн торгууль, нөхөн төлбөр /өсгөн нэмэгдүүлсэн, алданги, анз/-ийн хэлбэрээр илэрч болно”⁷ гэж, судлаач Д.Гиймаа Иргэний эрх зүй бүтээлдээ “Иргэний эрх зүйн хариуцлага гэдэг нь иргэний эрх зүйн хэм хэмжээ зөрчсөн гэм буруутай этгээдэд төрийн эрх бүхий байгууллагаас хэрэглэж байгаа албадлагын арга хэмжээ юм. Иргэний эрх зүйн хариуцлага нь хууль зүйн бусад хариуцлагад байх нийтлэг шинжийг агуулахын сацуу өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой байна”⁸ гэж, судлаач Ж.Ууганчимэг “Иргэний эрх зүйн хариуцлага гэдэг нь: Иргэний гүйлгээнд хууль зүйн адил тэгш эрхтэй оролцогчдын эдийн засгийн хэвийн харилцааг хөхүүлэн дэмжих, тэдний зөрчигдсөн эрхийг сэргээхэд чиглэсэн эд хөрөнгийн шинжтэй санцрыг хэрэглэхтэй холбогдсон төрийн албадлагын нэг хэлбэр юм”⁹ гэж тус тус тодорхойлсон байна.

Мөн доктор О.Отгонтуяа Иргэний эрх зүй бүтээлдээ “Иргэний эрх зүйн хариуцлага гэдэг нь иргэний эрх зүйн зөрчил гаргагчаас хохирогчид учруулсан хохирол, гэм хорыг нөхөн төлүүлэх буюу хохирогчийн иргэний зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээхэд чиглэсэн цээрлэлийг шүүхээс оногдуулах замаар төрийн албадлага хэрэглэж буй нэг хэлбэрийг хэлнэ”¹⁰ гэж үзсэн бол судлаач, докторант Т.Азжаргал Хууль зүйн хариуцлага бүтээлдээ “Иргэний эрх зүйн хариуцлага гэдэг нь иргэний гүйлгээнд хууль зүйн адил тэгш эрхтэй оролцогчдын эдийн засгийн хэвийн харилцааг хөхүүлэн дэмжих, тэдний зөрчигдсэн эрхийг нөхөн сэргээхэд чиглэсэн эд хөрөнгийн шинжтэй санцрыг хэрэглэхтэй холбогдсон төрийн албадлагын нэг хэлбэр юм”¹¹ гэж авч үзжээ.

Иргэний эрх зүйн хариуцлага нь хууль зүйн хариуцлагын нэг төрөл бөгөөд хууль зүйн хариуцлагын бүхий л шинжийг өөртөө агуулсан байдаг. Иргэний эрх зүйн хариуцлага нь эрх зүйн тогтолцоонд иргэний эрх зүйн гүйцэтгэх чиг үүрэг, зохицуулах зүйл, зохицуулалтын аргаас хамаарч хэд хэдэн онцлогтой байдаг. Үүнд:

- Хохирогчийн зөрчигдсөн эрхийг сэргээхэд чиглэгдсэн байдаг. Энэ нь нөхөн сэргээх шинжийг агуулна.
- Иргэний эд хөрөнгийн ба түүнтэй холбоотой эд хөрөнгийн бус харилцаагаар тодорхойлогддог.
- Үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй, хугацаа хэтрүүлсэн талын гэм буруутай үйлдэл, эс үйлдлийн сөрөг үр дагавар байдаг.
- Учруулсан гэм хор, хохиролд тохирсон тэнцвэртэй байдаг. Хуульд тусгайлан заасан онцгой тохиолдолд хариуцлагын хэмжээг дээгүүр тогтоох буюу өсгөн нэмэгдүүлж болдог.
- Иргэний эрх зүйн харилцаанд оролцогчид, үүргээ биелүүлээгүй тохиолдолд хүлээх хариуцлагыг гэрээндээ урьдчилан тохиролцож болдог.

⁶ Т.Мөнхжаргал, Монгол Улсын иргэний эрх зүй, 2003, 190 дэх тал.

⁷ Д.Баярсайхан. Эрх зүйн онол, 2018, 164 дэх тал.

⁸ Д.Гиймаа, Иргэний эрх зүй, 2015, 155 дахь тал.

⁹ Ж.Ууганчимэг, Иргэний эрх зүйн лекцүүд, 2016, 196 дахь тал.

¹⁰ О.Отгонтуяа, Иргэний эрх зүй, 2017, 124 дэх тал.

¹¹ Т.Азжаргал, Хууль зүйн хариуцлага, 2023, 100 дахь тал.

Доктор, профессор Т.Мөнхжаргал “эрх зөрчигчийн эд хөрөнгөнөөс хохирлыг албадан гаргуулж, эрх зөрчигдсөн талд олгож түүний эд хөрөнгөний эрхийг сэргээж байгаа нь төрийн албадлага, өмчийн эрхийг хамгаалах болон бусад субъектэд хүмүүжил, дохио санамж болох чухал арга хэмжээ юм” гэж, судлаач Э.Чулуунцэцэг “иргэний эрх зүйн хариуцлага нь эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус баялагтай холбоотой харилцаанд оролцогчдын эрхийг хамгаалах, сахилгажуулах хэрэгсэл болдгоороо ихээхэн ач холбогдолтой” гэж тус тус үзсэнтэй судлаачийн хувьд санал нэг байна. Иргэний хариуцлагын гол агуулга нь гэм буруутай талд эдийн засгийн нэмэгдэл үүрэг хүлээлгэдэг, цээрлүүлэх шинжтэй арга хэмжээ байдаг.

Хууль зүйн салбарын судлаачдын гаргасан тодорхойлолт болон хууль зүйн хариуцлага хүлээлгэж байгаа шинж, чанарыг үндэслэн “Иргэний хариуцлага гэдэг нь иргэний эрх зүйн зөрчил гаргагч иргэний эрх зүйд заасан үүргийг биелүүлээгүй эсхүл үүргээ биелүүлэхээс зайлсхийсэн тохиолдолд Иргэний хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад хууль, тогтоол, дүрэм, журамд заасан хэм хэмжээг үндэслэн хохирлыг нөхөн төлүүлэх, анз төлөх, гэм хорыг арилгах зэрэг арга хэмжээг эрх бүхий байгууллагаас оногдуулах төрийн албадлагын арга хэмжээ юм” гэж тодорхойлж болохоор байна.

Б. Иргэний эрх зүйн хариуцлагын хэлбэр:

Иргэний эрх зүйн зөрчил гаргасан этгээдэд хүлээлгэж буй эд хөрөнгийн цээрлэл (хариуцлага)-ийн илэрхийллийг иргэний эрх зүйн хариуцлагын хэлбэр гэнэ.¹² Иргэний хуульд хариуцлагын янз бүрийн хэлбэрийг заасан байна. Тухайлбал хохирлыг нөхөн төлүүлэх, анз, шаардах эрх буюу гүйцэтгээгүй үүргийг нөхөн биелүүлэх, дэнчингээ төлбөрт өгөх, улсын орлогод хураах гэх мэт.

Үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас үүрэг гүйцэтгүүлэгчид учирсан бүх хохирлыг үүрэг хүлээгч төлөх үүрэгтэй.¹³ Хохирлыг бүрэн хэмжээгээр төлүүлэх нь хариуцлагын чухал зарчим буюу гол хэлбэр юм. Хохирлыг нөхөн төлүүлэх нь:

➤ Эрх зөрчигчид хэрэглэж буй албадлага болно. Өөрөөр хэлбэл эрх зөрчигч үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй хугацаа хожимдуулсан гэм бурууг буруушааж буй цээрлэл болно.

➤ Хохирол нөхөн төлүүлэх нь иргэд, хуулийн этгээд, үйлдвэрлэл, үйлчилгээ үр ашигтай эрхэлж, ашиг хуримтлал бий болгох, ахуй амьдарлаа дээшлүүлэх эдийн засгийн эрхтэй хосолж байдаг. Энэ нь эрх зөрчигчөөс хохирлыг яаралтай албадан гарган хохирогчид өгөх нь түүний ажил амьдрал, үйлдвэрлэлийн цаашдын хэвийн ажиллагаанд нөлөөлнө.

➤ Иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдод дохио санамж болж улмаар аж ахуйн амьдралд хууль ёсыг сахиулах хэрэгсэл болдог.¹⁴

Анз бол иргэний эрх зүйн хариуцлагын нэг өвөрмөц хэлбэр бөгөөд торгууль, алданги гэсэн 2 төрөлтэй. Хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй тал хууль буюу гэрээнд зааснаар нөгөө талдаа төлөх ёстой мөнгөн төлбөрийг анз гэнэ.¹⁵ Анзын нийт дүн нь гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 хувиас хэтэрч болохгүй. Хохирол төлөх нь иргэний эрх зүйн хариуцлагын гол хэлбэр болдог бол анз нь нэмэлт хариуцлага болдог онцлогтой.

Торгууль нь талуудын хооронд үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй тал нь төлөхөөр тухайн үүргийн үнийн дүнгийн тодорхой хувиар тогтоосон болон урьдчилан тодорхой хэмжээгээр заасан мөнгөн дүн байна. Алдангийн хувьд энэ нь үүргийн гүйцэтгэлийг хангахгүй удаашруулахтай холбогдон гарч ирэх бөгөөд торгуультай адил бүр эхнээс нь тогтоогдохгүй харин үүргийн гүйцэтгэлийн хугацаа хэтрүүлсний үр дагаварт

¹² Т.Азжаргал, Хууль зүйн хариуцлага, 2023, 104 дэх тал.

¹³ Т.Мөнхжаргал, Монгол Улсын иргэний эрх зүй, 2003, 193 дахь тал.

¹⁴ Т.Мөнхжаргал, Монгол Улсын иргэний эрх зүй, 2003, 194 дэх тал.

¹⁵ Иргэний хууль, 2002, Төрийн мэдээлэл эмхэтгэл №7.

үндэслэн тогтоогддог. Алдангийн хэмжээ гэрээнд заасан хугацаа хэтрүүлсэн тал нь хоног дутам гүйцэтгээгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5 хувиас хэтрэхгүй хэмжээгээр төлөхөөр тогтоосон байна.

Дэнчин нь гэрээг байгуулсны нотолгоо болгон ямар нэг төлбөр төлөхөд чиглэж байдаг. Өөрөөр хэлбэл гэрээ байгуулсныг батлах тэмдэг болгож мөнгөн төлбөрийг төлж буй хэлбэр юм. Дэнчин өгөгч нь үүргийн гүйцэтгэлийг хангах үүргээ зөрчсөн байвал түүнийг үүргийн гүйцэтгэлд субьектив байдлаар буруутгах, эсхүл гэм буруутайд тооцох бөгөөд тухайлбал, тэрээр үүргийн гүйцэтгэлийн хугацааг хэтрүүлснээс болж үүргийн гүйцэтгэл хангагдаагүйн хариуцлагад татагдан дэнчингээ алдах юм.¹⁶

Шаардах эрх буюу гүйцэтгээгүй үүргийг нөхөн биелүүлэх хариуцлагын нэг өвөрмөц хэлбэр ба үүрэг гүйцэтгэгч, гүйцэтгүүлэгч хоёр үүргийн биелүүлэх явцад зохих ёсоор биелүүлэхийг нэмэлт үүрэг болгон шаардлага тавьдгаараа онцлогтой. Үүргийн дутагдал доголдлыг даруй түргэн засах, биелүүлэхийг хугацаа тогтоон шаардах, хэрэв дурдсан хугацаанд биелүүлэхгүй бол гэрээгээ цуцлах, хохирлоо, төлүүлэх, шүүхэд нэхэмжлэл гаргана хэмээн тулган шаардах эрхтэй гэсэн үг юм.

Улсын орлогод хураах гэдэг нь хууль бус болон шударга бус аргаар эд хөрөнгө олж авсан, бусдын хөрөнгөөр үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн зэрэг хуульд тусгайлан заасан тохиолдолд олж авсан хөрөнгийг улсын орлогод хураан авах ба энэ нь хариуцлагыг нэг өвөрмөц хэлбэр байдаг.

В. Иргэний эрх зүйн хариуцлагын төрөл:

Иргэний эрх зүйн хариуцлагын онцлогийг харгалзан иргэний эрх зүйн зөрчилд оногдуулах хариуцлагын төрлийг хариуцлага үүсэх үндэслэл, хариуцлага хүлээх субьектээс хамааруулан дараах байдлаар тодорхойлж ялгаж болно.

Иргэний эрх зүйн хариуцлагыг хариуцлага үүсэх үндэслэлээр нь:

➤ **Гэрээний хариуцлага:**

Талуудын хооронд байгуулсан гэрээ буюу хуульд заасан тохиолдолд үүсэх бөгөөд үүрэг хүлээгч үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол хүлээлгэх хариуцлага юм.

➤ **Гэрээний бус хариуцлага:**

Зөвхөн хуулийн дагуу үүсэх хариуцлага бөгөөд ямар нэгэн гэрээний харилцаанд байгаагүй этгээд гэм хор учруулсанд хариуцлага хүлээнэ.

Хариуцлага хүлээх субьектээс хамаарч:

➤ **Хамтран хүлээх хариуцлага:**

Үүрэг хүлээгч хэд хэдэн этгээдийн хэн аль нь үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө буюу хохирогчийн өмнө бүрэн хэмжээгээр хүлээх хариуцлага юм.

➤ **Хэсгээр хүлээх хариуцлага:**

Үүрэг хүлээгч тус бүр нь хууль буюу гэрээнд зааснаар өөрт ноогдох хэсгээр хүлээдэг хариуцлага юм.

➤ **Холимог хариуцлага:**

Үүрэг хүлээгч гүйцэтгүүлэгч хэн аль нь гэм буруутай байгаад бие биеийнхээ өмнө хүлээх хариуцлага юм

➤ **Нөхөх хариуцлага:**

Үүрэг хүлээгчийн хүлээх хариуцлага нь хохирол алдагдлыг нөхөн төлөхөд хүрэлцэхгүй тохиолдолд төлөөгүй тэр хэсгээр гуравдагч этгээдийн хүлээх хариуцлага юм.

➤ **Өмчлөгчийн хариуцлага:**

Аливаа этгээдийн хувьд тухайн зүйлийн өмчлөгч болохынхоо хувьд тухайн өмчлөлийн зүйлээс шалтгаалан бусдад хохирол учирсан бол хариуцлага хүлээх тухай ойлголтыг

¹⁶ Ё.Каюот нар, Монгол Улсын иргэний хуулийн тайлбар, 2005, 1046 дахь тал.

хэлнэ.¹⁷

Г. Иргэний эрх зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэл:

Бусдад гэм хор учруулсан этгээдээр хохирлыг төлүүлэхийн тулд уг этгээдийн гэм буруу, учирсан хохирлын хооронд шалтгаант холбоотой байх тухай зарчим дэлхийн улс орнуудад нийтлэг хэрэгжиж байна¹⁸. Манай орны хувьд энэхүү зарчмыг нийтлэг хэрэглэж байгааг эрдэмтэн судлаач нар өөрсдийн бүтээлдээ тусгасаар ирсэн байдаг.

Харин доктор, профессор Б.Буянхишиг “үүрэг гүйцэтгэгч нь өөрийн субьектив гэм буруутай үйлдлийн улмаас ямар нэг хариуцлага хүлээхээс гадна тэрээр бусдын өмнөөс хариуцлага хүлээх тохиолдол бий”¹⁹, докторант Т.Азжаргал “ердийн тохиолдолд үүрэг гүйцэтгэгч нь санаатай, болгоомжгүй үйлдлийнхээ хариуцлагыг хүлээнэ. Энэ нь хариуцлага хүлээлгэх субьектив нөхцөл болдог бөгөөд үүргийн зөрчилтэй няг холбоотой байна. Мөн эрх зүйн тогтолцоонд аливаа этгээдийн хариуцлагыг ярихын эхлээд хариуцлага хүлээх чадамжтай эсэхийг тогтооно”²⁰ гэж тус тус үзсэн байдаг бөгөөд “эдгээрээс үзэхэд хариуцлага хүлээлгэх үндэслэл нь үүргийн зөрчил, иргэний эрх зүйн чадамж, гэм буруугийн хэлбэр гэсэн гурван нөхцөлөөс бүрдэнэ”²¹ тус тус тодорхойлжээ.

Монгол Улсын Иргэний хуульд аливаа этгээдийн хариуцлагыг тооцохдоо эх газрын эрх зүйн тогтолцоонд мөрддөг гэм буруугийн зарчмыг (ялангуяа хохирол арилгах нөхцөлд) удирдлага болгодог. Энэ нь англи-саксоны эрх зүйн тогтолцооноос ялгах нэг онцлог билээ²².

Иргэний эрх зүйн хариуцлага хүлээлгэхийн тулд дараах зөрчлийн бүрэлдэхүүн хангагдсан байхыг шаарддаг.

- Эрх зөрчигч гэм буруутай байх;
- Эрх зөрчигчийн хууль бус үйлдэл;
- Хохирол учирсан байх;
- Эрх зөрчигчийн хууль бус үйлдэл ба хохирлын хооронд шалтгаант холбоо байх.

Эрх зөрчигчийн гэм буруу гэдэг нь:

Эрх зөрчигч өөрийн хууль зөрчсөн үйлдэл, эс үйлдэл, түүний үр дагаврыг үнэлэх сэтгэхүйн хандлага юм. Гэм буруу нь санаатай ба болгоомжгүй гэсэн 2 хэлбэртэй. Эрх зөрчигч өөрийн үйлдэл, эс үйлдлийн хууль бус болохыг болон түүний сөрөг үр дагаврыг мэдсэн, мэдэх боломжтой байсан атлаа түүнийг зориуд хүсэж үйлдсэнийг санаатай хэлбэр гэнэ. Эрх зөрчигч өөрийн үйлдэл, эс үйлдлийн хууль бус болохыг мэдсэн, мэдэх боломжтой байсан боловч сөрөг үр дагавар гаргуулахгүй гэж хөнгөмсгөөр найдсан эсвэл гарах үр дагаврыг урьдчилан мэдээгүй бол гэм буруугийн болгоомжгүй хэлбэр гэнэ.

Эрх зөрчигчийн хууль бус үйлдэл нь:

Иргэний эрх зүйн харилцаанд оролцогчид хууль буюу гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй эсвэл хуулиар хориглосон үйлдлийг хийж байгаагаар илэрнэ.

Хохирол нь:

Эд хөрөнгийн ба эд хөрөнгийн бус гэж 2 ангилах бөгөөд эд хөрөнгийн бус хохиролд бусдын амь насыг хохироох, эрүүл мэндийг сарниулах, бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасны улмаас хохирогчийг санаа сэтгэлийн дарамтад оруулсан үр дагавар байдаг бол эд хөрөнгийн хохирол нь бодит хохирол, түүнтэй холбогдон гарах нэмэгдэл зардал, орох ёстой байсан орлого байдаг.

Эрх зөрчигчийн хууль бус үйлдэл ба хохирлын шалтгаант холбоо нь:

Хууль бус үйлдэл, эс үйлдлээс шалтгаалан эд хөрөнгийн алдагдал, зардал гэх мэт хохирол бий болсон байхыг хэлнэ.

¹⁷ Т.Азжаргал, Хууль зүйн хариуцлага, 2023, 103 дахь тал.

¹⁸ Ж.Оюунгунгалаг, Харьцуулсан иргэний эрх зүй, 2013, 96 дахь тал.

¹⁹ Б.Буянхишиг, Иргэний эрх зүй (тусгай анги), 2011, 88 дахь тал.

²⁰ Т.Азжаргал, Хууль зүйн хариуцлага, 2023, 106 дахь тал.

²¹ Мөн тэнд. 106 дахь тал.

²² Мөн тэнд. 106 дахь тал.

Эрх зөрчигчийн хууль бус үйлдэл нь хууль буюу гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу гүйцэтгэх ёстой үүргийг биелүүлээгүй, эсхүл хориглосон үйлдлийг хийж байгаагаар илрэх бөгөөд үүнийг хууль бус идэвхтэй үйлдэл, хууль бус идэвхгүй үйлдэл гэж хоёр хэлбэрт хуваана.²³

Иргэний эрх зүйн харилцаан дахь хууль бус идэвхтэй үйлдэл нь хууль гэрээгээр хориглосон зүйлийг хийж байгаагаар илэрнэ. Хууль бус идэвхгүй үйлдэл нь хууль гэрээгээр хүлээсэн үүргийг хийх ёстой ба хийж чадах атал хийгээгүйгээр илэрч байдаг. Хийх ёстой гэдэг нь хууль зүйн шалгуур бөгөөд тэр нь хүлээсэн үүргээ биелүүлээгүйг, харин чадах байсан гэдэг нь уг үүргийг гүйцэтгэх бүрэн бололцоотой байхыг хэлнэ.²⁴

Эрх зөрчигчийн гэм буруутай нь тогтоогдсон явдал нь хууль зүйн хариуцлага хүлээлгэх субъектив үндэслэл болно. Өөрөөр хэлбэл, хууль тогтоомжид эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн гэж үзэн хууль зүйн хариуцлага хүлээлгэхээр заасан байх нь иргэний эрх зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

III. ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ЯВЦ ДАХЬ ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ ҮНДЭСЛЭЛ:

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад Иргэний хууль, Гэр бүлийн тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу дараах тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч иргэний эрх зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэл үүснэ. Тухайлбал:

1. Хүүхдийн тэтгэлгийг хугацаанд нь төлөөгүй этгээдэд хүлээлгэх хариуцлага;
2. Албадан дуудлага худалдаанд оролцогчийн хариуцлага;
3. Шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаар битүүмжилсэн, барьцаалсан, хураасан эд хөрөнгө хадгалагчийн хүлээх хариуцлага;

Дэлгэрүүлэн авч үзвэл:

1. Хүүхдийн тэтгэлэг гэж хуульд заасан хэмжээ, хугацаагаар мөнгөн болон эд хөрөнгөөр гаргуулж, гагцхүү тэжээн тэтгүүлэгч хүүхдийн хэрэгцээнд зарцуулах хөрөнгийг хэлнэ. Хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагаа нь иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны нэгэн адил явагддаг хэдий ч энэ нь гэр бүлийн хүрээнд бий болсон нарийн харилцаа гэдгээрээ онцлогтой. Мөн гэм хор учруулсны улмаас хүүхдийн тэтгэлэг төлөхөөр шийдвэрлэгдэх тохиолдол цөөнгүй байна. Эдгээр нь гэмт хор учруулснаас эсхүл тэжээн тэтгэх үүргээс улбаалан тэтгэлэг тогтоосон эсэхийг үл харгалзан хэрэгжүүлэх арга, журам нь нэг байдаг.

Монгол Улсын Гэр бүлийн тухай хуульд зааснаар эцэг, эх нь насанд хүрээгүй болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдээ тэжээн тэтгэх үүрэгтэй. Энэхүү үүргээ эцэг, эх нь харилцан тохиролцож гэрээ байгуулан шийдвэрлэж болохоор хуульд заасан ба хэрэв тэтгэлгийн хэмжээг харилцан тохиролцоогүй, тохиролцоонд хүрч чадаагүй, гэрээ байгуулаагүй тохиолдолд Шүүх хүүхдийн насны байдлыг харгалзан сард төлүүлэх тэтгэлгийг хэмжээг 11 хүртэлх насны хүүхдэд тухайн бүс нутагт тогтоогдсон амьжиргааны доод түшингийн 50 хувиар, 11-16 нас /суралцаж байгаа бол 18 нас/-тай болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдэд амьжиргааны доод түшингийн 100 хувиар тогтоодог.

Хүүхдийн тэтгэлгийг мөнгийг тухайн тэжээн тэтгүүлэгч хүүхдийн оршин суугаа нутаг дэвсгэрт тогтоосон бүс нутгийн хэмжээгээр тооцон гаргуулж, олгоно. Хүүхэд гадаад улсад суугаа бол иргэний бүртгэлд бүртгэгдсэн, сүүлчийн оршин сууж байсан нутаг дэвсгэр эсхүл тэтгэлэг авагчийн оршин суугаа нутаг дэвсгэрийн бүс нутагт тогтоосон хэмжээгээр тооцон олгож болно.

²³ Т.Азжаргал, Хууль зүйн хариуцлага, 2023, 101 дэх тал.

²⁴ Мөн тэнд. 101 дэх тал.

Хүүхдийн тэтгэлгийг хугацаандаа төлөөгүй төлбөр төлөгчид Гэр бүлийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасан “шүүхийн шийдвэрээр тогтоосон тэтгэлгийг хугацаанд нь төлөөгүй бол хожимдуулсан хоног тутамд тогтоосон тэтгэлгийн үнийн дүнгийн 0,5 хувиар алданги төлөх бөгөөд алдангийн нийт хэмжээ төлөгдөөгүй тэтгэлгийн үнийн дүнгийн 50 хувиас хэтрэхгүй байна”²⁵ хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

Шийдвэр гүйцэтгэгч нараас ярилцлагын аргаар судалгаа авахад хуулийн дээрх заалтыг хэрэгжүүлэн ажилладаггүй, ихэнх төлбөр авагч нар үндсэн тэтгэлгээ аваад энэ талаар хүсэлт гаргадаггүй тул гүйцэтгэх баримт бичгийг хаадаг байна. Энэ нь хүүхдийн эрхийг зөрчсөн үйлдэл мөн.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нэг өвөрмөц онцлог бол бусад байгууллагууд хэрэгжүүлдэггүй хуулиар олгогдсон чиг үүрэг болох албадан дуудлага худалдааг зохион байгуулах явдал юм. Хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийн дагуу өр төлбөртэй этгээдийн хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийг албадан дуудлага худалдаагаар худалдан борлуулах ажиллагааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хэрэгжүүлдэг.

Дуудлага худалдаа гэж хамгийн өндөр үнэ санал болгосон этгээд ялагч болдог үнэ хаялцуулах ажиллагааг хэлэх бөгөөд нэг этгээд оролцсон дуудлага худалдааг явагдаагүй гэж үзнэ. Шүүхийн шийдвэрийн дагуу зохион байгуулж буй албадан дуудлага худалдааг нээлттэй хэлбэрээр явуулна.

Албадан дуудлага худалдааны гол зорилго нь албадан худалдааны ажиллагаанаас аль болох их орлого олох бөгөөд тэр хэмжээгээр төлбөр төлөгч үүргээс чөлөөлөгдөнө. Ийм учраас хууль тогтоогч үл хөдлөх хөрөнгийг албадан дуудлага худалдаагаар худалдан борлуулахаар зохицуулсан бөгөөд аль болох олон оролцогч оролцсоны үр дүнд эд хөрөнгийн үнэ өсөх боломжтой болно. Албадан дуудлага худалдаагаар төлбөр төлөгчийн эд хөрөнгийг нээлттэй худалдан борлуулахад авлига бий болох асуудлаас урьдчилан сэргийлнэ.

Дуудлага худалдаанд оролцогч саналын хуудас бөглөж, биеийн байцаалт эсвэл аж ахуйн нэгжийн гэрчилгээг нотариатаар баталгаажуулсан хуулбарыг бүртгүүлэн, эд хөрөнгийн анхны үнийн 10 хувьтай тэнцэх дэнчинг тушаасан байна. Албадан дуудлага худалдаанд оролцогч урьдчилан тогтоосон хугацаа, хэмжээ, журмын дагуу дэнчин төлсөн байна. Дэнчин төлсөн тохиолдолд албадан дуудлага худалдаанд оролцуулна. Албадан дуудлага худалдааг явуулаагүй, оролцогч байхгүй, эсхүл оролцсон боловч ялаагүй этгээдэд дэнчинг буцаан олгоно.

Үнэ өсгөх зарчмаар хамгийн өндөр үнэ амласан худалдан авагч албадан дуудлага худалдаа явуулж байгаа бүрэн эрх бүхий этгээдэд үнийг шилжүүлэх үүрэгтэй. Албадан дуудлага худалдаагаар худалдсан үл хөдлөх эд хөрөнгийн үнийг бүрэн төлсөн үеэс худалдан авагчид тухайн үл хөдлөх хөрөнгийн өмчлөгч болох эрх үүснэ.

Дуудлага худалдаанд оролцож зохих журмын дагуу дэнчин²⁶ төлсөн этгээд тухайн дуудлага худалдааны ялагч болж эд хөрөнгийг худалдан авах эрхтэй болох бөгөөд эд хөрөнгийн үнийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан хугацаанд²⁷ төлөөгүй бол үүргийн гүйцэтгэл хангагдаагүйн хариуцлагад татагдан дэнчингээ алдах²⁸ бөгөөд дэнчинг улсын орлого болгох үндэслэл болно.

²⁵ Гэр бүлийн тухай хууль, 1999, Төрийн мэдээлэл эмхэтгэл №30.

²⁶ Дуудлага худалдаанд урьдчилан тогтоосон хугацаа, хэмжээ, журмын дагуу дэнчин төлсөн оролцогч оролцоно гэж Иргэний хуулийн 197 дугаар зүйлийн 197.17 заасан.

²⁷ Дуудлага худалдаагаар борлогдсон үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлсэн эсэх тухай дуудлага худалдааны эрхлэн хөтлөгчийн шийдвэрийг тогтоосон хугацаанд танилцуулна. Энэ хугацаа нь 14 хоногоос хэтрэхгүй байна. Дуудлага худалдааг эрхлэн хөтлөгчийн шийдвэрт дуудлага худалдааны ялагчийн овог, нэр, дуудлага худалдаагаар худалдан авсан эд хөрөнгийн үнэ, хөрөнгийн үнийг бүрэн төлсөн болон өмчлөх эрх үүсэх, эд хөрөнгө чөлөөлөх хугацааг заана гэж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.10, 71.11 дэх хэсэгт тус тус заасан.

²⁸ Дуудлага худалдааны ялагч худалдаж авсан эд хөрөнгийн үнийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.10-т заасан хугацаанд төлөөгүй бол дэнчинг улсын орлого болгоно гэж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.12-т заасан.

3. Шийдвэр гүйцэтгэгч битүүмжилсэн, барьцаалсан, хураасан үл хөдлөх хөрөнгийг төлбөр төлөгч болон бусад этгээдэд хадгалуулж болох бөгөөд хадгалагч этгээдэд эд хөрөнгийг хадгалж, түүний бүрэн бүтэн байдлыг хангах үүрэг хүлээнэ. Энд “бусад этгээд” гэдэгт хэнийг хамааруулах вэ? төлбөр авагчид хадгалуулж болох уу гэдэг асуудал маргаантай байдаг. Хуульд хураан авсан эд хөрөнгийг төлбөр авагчид хадгалуулах талаар заагаагүй бөгөөд энэ нь тухайн эд хөрөнгийг худалдан борлуулахаас нааш төлбөр авагчийн удирдлагад шилжүүлэхгүй байхаар зохицуулжээ.

Эд хөрөнгө хадгалагч нь төлбөр төлөгч, түүний гэр бүлийн гишүүн биш бол хадгалуулсны хөлсийг гэрээгээр тохиролцсоны дагуу олгох бөгөөд хадгалагч хадгалуулагчийн зөвшөөрөлгүйгээр эд хөрөнгийн хэвийн байдлыг өөрчилсөн, эд хөрөнгийг гуравдагч этгээдэд шилжүүлсэн, сольсон, үрэгдүүлсэн, нуусан бол учирсан хохирлыг бүрэн хариуцна. Эд хөрөнгийг хадгалуулахдаа Иргэний хуульд²⁹ заасны дагуу хадгалагч талтай гэрээ байгуулна. Гэрээнд талууд эд хөрөнгө хадгалах нөхцөл, хадгалах хугацаа болон талуудын эрх үүргийг тусгана.

Хэрэв хадгалагч тал шийдвэр гүйцэтгэгчийн хадгалуулахаар хүлээлгэн өгсөн эд хөрөнгөд хохирол учруулсан, чанар байдлыг алдагдуулсан, гэм хор учруулсан бол түүнд иргэний эрх зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

Шийдвэр гүйцэтгэгчийн эд хөрөнгө хураан хадгалалт хамгаалалтыг хэрхэн шийдвэрлэсэн талаар түүврийн аргаар гүйцэтгэх баримт бичигт судалгаа хийхэд, эд хөрөнгө хадгалуулахдаа хадгалагч талтай гэрээ байгуулдаггүй, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тэмдэглэлд тусгах байдлаар хадгалалтын асуудлыг шийдвэрлэдэг, гэрээ байгуулсан боловч хадгалалтын хөлсийг тохиролцоогүй зэрэг байдлууд багагүй байна.

IV. ДҮГНЭЛТ, САНАЛ:

Шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх иргэний эрх зүйн хариуцлага, онолын үндэслэлд хийсэн судалгаа, шийдвэр гүйцэтгэгч нартай хийсэн ярилцлага, гүйцэтгэх баримт бичигт хийсэн судалгаандаа үндэслэн дараах дараах дүгнэлтийг хийлээ.

Шийдвэр гүйцэтгэгч нар шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд эрүүгийн хариуцлага болон захиргааны хариуцлага (зөрчлийн хариуцлага) оногдуулж ирсэн боловч иргэний хариуцлага хүлээлгэх асуудлыг орхигдуулсаар иржээ. Тэд хууль хэрэгжүүлэн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахдаа төлбөр төлөгч болон эд хөрөнгийн хариуцлага хүлээсэн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогч, гуравдагч этгээдийн зүгээс учруулсан гэм хорыг арилгах, төлбөр авагчийг хохиролгүй болгох, төлбөр авагчийн хууль ёсны эрхийг хангах талаар хангалттай ажиллахгүй байна гэж үзэж байна.

Шийдвэр гүйцэтгэгч нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад иргэний эрх зүйн зөрчил гаргасан этгээдэд тухай бүр хариуцлага тооцож ажиллах нь дараах ач холбогдолтой юм. Тухайлбал:

Нэгдүгээрт: Тухайн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогчийн зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэхийн зэрэгцээ, төлбөр төлөгч этгээдийг шүүхийн шийдвэр биелүүлэхээс зайлсхийхээс урьдчилан сэргийлэх, нийгэмд шударга ёсыг тогтооход чухал үүрэгтэй.

Хоёрдугаарт: Иргэний эрх зүй дэх хариуцлага нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцогчдыг сахилгажуулах, хүмүүжүүлэх, хууль ёсыг хэвшүүлэх хэрэгсэл болдог тул бусад эрх зөрчигчдөд дохио, санамж болж, шүүхийн шийдвэр гарцаагүй биелэгддэг байх зарчмыг хангахад ихээхэн ач холбогдолтой байна.

²⁹ Иргэний хуулийн 422 дугаар зүйлийн 422.1-д “Хадгалалтын гэрээгээр хадгалагч нь хадгалуулагчаас шилжүүлэн өгсөн хөдлөх эд хөрөнгийг хадгалах үүрэг хүлээнэ”, мөн хуулийн 422 дугаар зүйлийн 422.6-д “Хадгалалтын гэрээний хугацаа дууссан эд хөрөнгийг хадгалуулагчид буцаан өгөх үед хадгалагч өөрийн санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлийн улмаас учирсан хохирлыг хариуцна”, мөн хуулийн 424 дүгээр зүйлийн 424.1-д “Гэрээнд өөрөөр заагаагүй бол хадгалагч нь хадгалалтад шилжүүлсэн эд хөрөнгийг алдсан, дутагдуулсан, гэмтэсэнээс хадгалуулагчид учирсан хохирлыг төлнө” гэж тус тус эд хөрөнгө хадгалагчид хүлээлгэх хариуцлагын талаар заажээ.

Судлаачийн зүгээс судалгааны ажлын дэвшүүлсэн зорилго, зорилтдоо хүрсэн гэж дүгнэж байгаа болно.

Иргэний эрх зүйн хариуцлага, түүнийг шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хүрээнд дараах саналыг гаргаж, практикт хэрэгжүүлэх бүрэн боломжтой гэж үзэж байна. Үүнд:

1. Шийдвэр гүйцэтгэгч нарт иргэний эрх зүйн хариуцлага, хариуцлага хүлээлгэх үндэслэлийн талаар сургалт зохион байгуулах; (Шийдвэр гүйцэтгэгч нарт онолын мэдлэг олгох, цаашид шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тохиолдол бүрт хэрэглэж хүний эрхийг ханган ажиллах нь зүйтэй байна.)

2. Хүүхдийн тэтгэлгийг хугацаанд нь төлөхгүй тэтгэлгийн хуримтлал үүсгэх тохиолдол бүрт төлбөр төлөгчид иргэний хариуцлага хүлээлгэх санал гарган шүүхэд хандан шийдвэрлүүлж хэвших;

(“Гэр бүлийн тухай” хуулийн 50 дугаар зүйлд заасан хариуцлага тооцон шүүхийн шийдвэрээр тогтоосон тэтгэлгийг хугацаанд нь төлөөгүй бол хожимдуулсан хоног тутамд тогтоосон тэтгэлгийн үнийн дүнгийн 0,5 хувиар алданги төлүүлэх)

3. Эд хөрөнгө хадгалахдаа төлбөр төлөгч болон гуравдагч этгээдтэй Иргэний хуульд заасны дагуу хадгалагч талтай хадгалалтын гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг ханган ажиллах. Хадгалагч тал гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд иргэний хариуцлага хүлээлгэх асуудлыг тухай бүр шийдвэрлүүлж байх;

(Гэрээнд талууд эд хөрөнгө хадгалах нөхцөл, хадгалах хугацаа болон талуудын эрх үүргийг тусгаж, хадгалагч тал хадгалалтад шилжүүлсэн эд хөрөнгийг алдсан, дутагдуулсан, гэмтээсэн, хадгалалтын гэрээний хугацаа дууссан үед хадгалагчийн санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлийн улмаас учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх иргэний хариуцлагын талаар зааж өгөх нь зүйтэй. Эд хөрөнгө хадгалах, хамгаалах асуудлыг орхигдуулснаас битүүмжилсэн, барьцаалсан, хураан авсан эд хөрөнгийн өнгө үзэмж, чанар байдал алдагдаж гэр хэрээр хөрөнгийн үнэ цэнэ нь буурах эрсдэл үүснэ.)

ЭХ СУРВАЛЖ

Монгол хэл дээрх

Хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992.
2. Иргэний хууль, 2002.
3. Гэр бүлийн тухай хууль, 1999.
4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2017.

Ном, өгүүлэл, судалгааны тайлан

1. С.Нарангэрэл, Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг, УБ, 2021.
2. Т.Мөнхжаргал, Монгол Улсын иргэний эрх зүй, УБ, 2003.
3. Д.Баярсайхан, Эрх зүйн онол, УБ, 2018.
4. Д.Гиймаа, Иргэний эрх зүй, УБ, 2015.
5. Ж.Ууганчимэг, Иргэний эрх зүйн лекцүүд, УБ, 2016.
6. Ж.Долгорсүрэн, Захиргааны хариуцлага, УБ, 1998.
7. О.Отгонтуяа, Иргэний эрх зүй, УБ, 2017.
8. Т.Азжаргал, Хууль зүйн хариуцлага, УБ, 2023.
9. Э.Чулуунцэцэг, Эрх зүйн онол, УБ, 2017.
10. Ж.Оюунтунгалаг, Харьцуулсан иргэний эрх зүй, УБ, 2013.
11. Б.Буянхишиг, Иргэний эрх зүй (тусгай анги), УБ, 2011.
12. Ё.Кают нар. Монгол Улсын иргэний хуулийн тайлбар, УБ, 2005.

Цахим эх сурвалж

1. <https://www.legalinfo.mn>
2. <https://cd.gov.mn>

THEORETICAL FRAMEWORK ON CIVIL LAW LIABILITY FOR LEGAL PERSON WHO AVOIDS THE COURT DECISION

Ya. Batgerel

*Head of the Department of Civil Court Decision Executive Studies,
School of Court Decision Executive, University of Internal Affairs,
Lieutenant Colonel (LL.M)*

ABSTRACT:

In certain areas of legal science, such as criminal, civil, and administrative, the main subject of study is the problem of guilt. Scholars have been researching and putting forward various theories on what actions and inactions are considered legal violations and crimes, and when and by what criteria the person involved in these acts is considered guilty and held liable.

The concept of civil legal liability, a type of legal liability, and the types and types of civil liability, and the grounds for imposing liability, are intended to clarify the grounds for imposing civil liability on the person who fails to comply with the court's decision.

KEYWORDS:

Civil law, law liability, civil law liability, duty liability, guilt, rights disburter, payer

ЕВРОП ДАХЬ КАРТЕЛИЙН ЭРХ ЗҮЙН СЭТГЭЛГЭЭНИЙ ХӨГЖИЛ БА ТҮҮХЭН ҮЙЛ ЯВДЛУУДЫГ ЭРГЭЦҮҮЛЭХ НЬ



Л.Отгонбаяр

*СЭЗИС-ийн Эрх зүйн тэнхимийн ахлах багш,
МУИС-ийн Хууль зүйн сургуулийн докторант*

ТОВЧЛОЛ:

Энэхүү өгүүллээр Дэлхийн II дайны өмнөх ба дараах үеийн Европын сэргээн босголт, эдийн засгийн шилжилт, хөгжлийн үе шатуудад картель хэмээх үзэгдэл хэрхэн нөлөөлсөн хийгээд энэ ойлголт өөрөө хэрхэн хувьсан өөрчлөгдсөнийг харуулахыг зорьсон болно.

ТҮЛХҮҮР ҮГС:

Европын нүүрс ба гангийн нийгэмлэг, Европын холбоо, картелийн эрх зүй, картель, өрсөлдөөний эрх зүй, картелийн сонгодог онол, картелийн орчин үеийн онол.

I. ОРШИЛ:

Энэхүү өгүүллийг бичих болсон нь картель хэмээх ойлголт хэрхэн хөгжиж ирсэн тухай дагнан бичигдсэн диссертациуд болох ХБНГУ-ын эрдэмтэн Х.А.Леонардтын олон улсын эдийн засгийн түүх судлалын бүтээл¹, Унгарын эрдэмтэн А.Пеллегийн Европын холбоо ба Германы картелийн зохицуулалтын эдийн засгийн түүх судлалд холбогдох² бүтээлүүдийг уншиж судлах явцад гарч ирсэн асуулттай холбоотой.

Тийнхүү сонирхол татсан асуулт нь Дэлхийн II дайны өмнөх ба дараах үеийн Европын хөгжил, сэргээн босголт, эдийн засгийн шилжилтийн үе шатууд картель хэмээх үзэгдэл, түүний эрх зүйн зохицуулалтад хэрхэн нөлөөлсөн тухай ерөнхий асуулт юм. Тухайлбал, картелийн сонгодог онол гэж нэрлэх Р.Лифманны онол яагаад Чикаго их сургуулийн эрх зүй ба эдийн засгийн эрдэмтдийн картелийн орчин үеийн онолчдын бүтээлд эш татагддаггүй, тойрч гардаг тухай. Тэрчлэн картелийн сонгодог онолоос өмнө нь хууль ёсны гэж үздэг байсан аж үйлдвэрийн хамтын ажиллагааг илэрхийлсэн картелийг 1930 оноос 1950 оны хооронд Европ дахинд ямар үзэл санааны хувьсал, үйл явдлын өрнөл, өөрчлөлт болж байж либерал онол, неоклассик улс төрийн эдийн засгийн онолд нийцэхүйц хэмжээнд хуулиар хориглосон үйлдэл болгож зохицуулах болсон бэ гэсэн асуулт нь өнөө ч үнэ цэнээ алдаагүй бөгөөд хангалттай тодорхой хариултгүй байсаар байна. Асуултын хариултыг өргөн хүрээтэй судалгаа шаардах тул энд бүрэн хэмжээгээр өгөхөөс илүүтэй асуудал байгааг түүхэн үйл

¹ Leonhardt, H. A. (2018). The Development of Cartel+ Theory between 1883 and the 1930s—from International Diversity to Convergence.

² Anita Pelle (2010). *The German Roots of the European Community's Cartel Regulation* (Doctoral dissertation, Hungarian Academy of Sciences).

явдлын үе өрнөлтэй нь харьцуулж гаргаж тавин эргэцүүлэл, эрдмийн диалогийн эхлэлийг тавих нь энэ өгүүллийн зорилго юм.

Ач холбогдлын хувьд³ одоогоор манай улс Өрсөлдөөний тухай Монгол Улсын хуульд картель нь захиргааны хариуцлагын нэлээд хүнд санкцитай зөрчилд тооцогдох болсон бол улмаар “жижиг эрүүгийн хууль” (misdemeanor) гэгдэх Зөрчлийн тухай хуульд тусган хамгийн хүнд хариуцлага хүлээлгэх болсон нь аль зэрэг зөв алхам болох хийгээд ийм хатуу зохицуулалтын үр дагавар, хангалттай үндэслэл нь юу байсныг дам эргэцүүлэхэд энэ өгүүлэл өчүүхэн ч гэсэн хувь нэмэр болно гэж үзэж байна. Учир нь дайны галд шатсан баруун Герман, Европ дахин шууд л картелийг эрх зүйн зөрчилд тооцоогүй байгааг энд эш татсан түүхэн үйл явдлууд харуулав.

Энэ тухай мөшгин судлахад Европ дахин дэлхийн дайнаас сэргэсэн, өрсөлдөөний хуулийг хэрхэн АНУ-ын шахалтаар батлан нутагшуулсан, тэр нь ямар агуулгатай байсан зэрэг олон асуултын гогцоо болох ажээ. Улс үндэстний дотоод зах зээл дэх картелийн хор уршгийг шинжлэх ухааны маш сайн үндэслэлтэй тайлбарласан картелийн орчин үеийн онол нь орчин үеийн үндэсний эрх зүйн зохицуулалтын чиг хандлага, онолын үндэслэл болж байгааг харуулахыг зорив.

Гэвч хачирхалтай асуулт байгаа нь Европын холбоо нь бүс нутгийн олон улсын стратегийн түүхий эд(нүүрс ба ган)-ийн хамтын ашиглалт, хуваарилалт, худалдаанд эдийн засгийн сонирхол бүхий картель байгууллага хэлбэрээр эхнээсээ байгуулагдсан нь тодорхой байгааг энд түүхэн үйл явдал хэсэгт авч үзсэн. Картель хэмээх үзэгдэл ямагт сөрөг талтайг неоклассик улс төрийн эдийн засгийн онол, картелийн орчин үеийн онол нотолдог. Гэтэл картель нь олон улсын шинжтэй болох тусам зөвшөөрөгддөг, хориглолт зохицуулалтгүй болдгийг ч эргэцүүлэн тунгаах боломжийг энэхүү бэсрэгхэн судалгаа харуулсан гэж үзэж болох юм.

II.КАРТЕЛИЙН СОНГОДОГ ОНОЛ, ТӨРИЙН ХЯНАЛТТАЙ ЭДИЙН ЗАСГИЙН ОНОЛ БА ТҮҮХЭН ҮЙЛ ЯВДЛУУД

2.1. Р.Лифманны “хэлмэгдсэн онол”⁴ буюу картелийн анхны системтэй ажиглалт

Өдгөө барууны орнуудын өрсөлдөөний эрх зүйн хичээлүүдэд хэрэглэгддэг ном, сурах бичгүүдэд картелийн сэдвийг авч үзэхдээ уг бүтээлийг огт дурддаггүй⁵, эш татдаггүй нь хачирхалтай санагдсаны учир энэхүү эх зохиолыг энд зориуд авч үзэж Монгол хэлнээ эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулахаар шийдлээ. Магадгүй үзэл суртлын шалтгаанаар тийнхүү үл тоомсорлогдож байсан ч саяхнаас судлаачид энэ бүтээл, онолын тухай мэр сэр эш татах болсон. Тиймд өрсөлдөөний эрх зүйг хөгжүүлж буй бидний хувьд танин мэдэхүйн үнэ цэнтэй байж болно.

Энэ бүтээлийн зохиогч нь Германы Фрайбургийн их сургуулийн профессор Р.Лифманн бөгөөд тэрээр картелийн тухай дагнан судалсан хамгийн анхны онолын бүтээлээ аль 1932 онд “Картель, Концерн ба Траст” нэртэй хэвлүүлжээ. Нэг сэдэвт бүтээлийн хэлбэрээр бичигдсэн уг бүтээлд картелийн түүхэн хөгжил, аж үйлдвэрийн эдийн засаг, ажиллах хүч, хэрэглэгчид үзүүлэх картелийн нөлөө, төрөөс картелийг зохицуулах, бодлого, картелиуд бусдыгаа эгнээндээ элсүүлэхэд хэрэглэдэг байсан арга гэх мэт эрх зүйн асуудлыг иж бүрнээр нь авч үзжээ. Түүний бүтээл 1890-1930-аад оны үеийн гол төлөв Европ тивийн улс орнууд, трансатлантын эдийн засгийн амьдралын ажиглалт дээр тулгуурласан эмпирик

³ Хууль зүйн салбарын ач холбогдлын тухайд, судлаач биднээс ямагт энэ ажил чинь практикт ач холбогдолтой болох, Монголд бодитой хэрхэн тус нэмэр болох юм бэ, шүүхээс хууль хэрэглэхэд, эсхүл тодорхой хууль тогтоомжийг засан сайжруулахад хэрэгтэй юм хий гэсэн яаруу давчуу анхааруулга, шүүмж байнга ирдэг. Түүнд урам зориг дүүрэн хариу өгөх боломжгүй байгаад хүлцэл өчихийн зэрэгцээ, энэхүү ажил нь ямар нэг захиалгат бодлогын судалгаа биш тул тодорхой яв цав дүгнэлт, зөвлөмж байхгүй болно.

⁴ Classic Cartel Theory

⁵ Whish, R., & Bailey, D. (2021). *Competition law*. Oxford University Press. pp. 512-52; Jones, A., & Sufrin, E. (2001). EC competition law: Text, cases, and materials. pp. 858-939; Fox, E. M., Geradin, D., & EU, C. L. (2017). Cases, Text, and Context. 33-62; Motta, M. (2004). *Competition policy: theory and practice*. Cambridge university press. Pp. 167-178

онол гэж үзэж болох юм.

Р.Лифманн картелийг зах зээлээ монопольлохын төлөө бие даасан аж ахуй эрхлэгчдийн хоорондын сайн дурын хэлцэл гэж тодорхойлсон.⁶ Тэрбээр Дэлхийн I дайны дараа үеэс түгээмэлжих болсон хоёр ба түүнээс дээш тооны аж үйлдвэрийн байгууллагуудыг эгнээндээ нэгтгэсэн сонирхлын бүлэг (interest group) гэх үзэгдлийг картелиас ялгаж “маш ойрын хамаатан” гэж үзээд гагцхүү тэдгээр нь салбарын нийт худалдааг багтааж монополь байр сууринд хүрсэн тохиолдолд картельд тооцогдоно⁷ гэснээс үзвэл Р.Лифманн картелийн тодорхойлолтод “хамтын монополь” (collective dominance) шинжийг чухалчилсан байна.

Тэрбээр картель нь уламжлалт, хуваарилалтын, патентын гэсэн хэлбэртэйгээр оршин байдаг гэж тэмдэглэжээ. Германы хөдөө аж ахуйгаас бусад салбарт өргөн дэлгэр хөгжсөн аж үйлдвэрийн салбарын холбоод (industry associations)-ыг картелийн сонгодог хэлбэр гэж үзэн тухайн үеийн түүхэн тоо баримтуудыг салбар, салбараар дурджээ. Түүний тэмдэглэсэнээр Германд 1923 оны байдлаар гэхэд дараах аж үйлдвэрийн холбоод картель хэлбэрээр идэвхтэй ажиллаж байсан гэжээ.⁸

Хүснэгт 1: Герман дахь картелиуд 1923 оны байдлаар.

Уул уурхай	51
Төмөр ба ган	73
Металл хайлуулах, хагас боловсруулалт хийх	17
Инженерийн	147
Уурын зуух худалдаа	48
Төмөр замын вагон ба вагон	1
Автомашин ба дугуйн үйлдвэрлэл	8
Төмөр ба ган эдлэл	234
Цахилгааны барааны үйлдвэрлэл, шинжлэх ухааны болон оптик багаж хэрэгсэл	56
Техник хангамж	78
Мод	44
Арьс	46
Чулуу ба хайрга	30
Барилгын материалын худалдаа	37
Керамикийн үйлдвэрүүд	10
Шилэн хийц	20
Химийн бодис	91
Тос, өөх	36
Цаас	107
Нэхмэл эдлэл	201
Бэлэн хувцас	71
Шар айраг исгэх, соёолж бэлтгэх тээрэмдэх	97
Элсэн чихэр, хүнсний бүтээгдэхүүн	24
Элсэн чихэр	49
Тээвэр, тээврийн агентлагууд	4
Уул уурхай	51
Нийт 26 салбар	1631

Эх сурвалж. Р.Лифманн (1930)

⁶ Robert Liefmann, *Cartels, Concerns and Trusts* (1932, first edition) Batoche Books Kitchener 2001, p.37.

⁷ Ibid. p.286.

⁸ Ibid. p.61.

Картель нь таван хэлбэрээр оршин байна гэж Р.Лифманн ажигласан байна. Уламжлалт гурван хэлбэр нь бүс нутгийн буюу зах зээлийн газар зүйн хил хязгаарын; үнийг хэлцэн тохирох; үйлдвэрлэлийн картель болно. Эдгээр уламжлалт гурван хэлбэрийн картельд аль алинд нь үр нөлөөтэй үйл ажиллагааг хангах зорилготой хяналтын нууц ажилтан ажилладаг. Картель хэлцэл тохиролцоог зөрчигсдөд чанга шийтгэл оногдуулна. Өргөн цар хүрээтэй картелийн хувьд хяналтын хороо ажиллана. Заримдаа чуулган зохион байгуулж зөвлөлддөг гэжээ.

Түүний тодорхойлсон дөрөв дэх буюу илүү ахисан шатны картелийн хэлбэр нь хуваарилалтын картель (distributio cartel) юм. Энэ нь нийт нийлүүлэлт эсхүл нийт эрэлтийг гишүүдэд хуваарилах үүрэгтэй.⁹ Р.Лифманн ажигласнаар хуваарилалтын картель нь ихэвчлэн олон нийтийн компани хэлбэртэй, масс үйлдвэрлэл дэх нийт мэдээллийг эзэмшиж, гишүүдэд хуваарилалт хийх бөгөөд ихэнх нүүрс, төмрийн хүдэр, гангийн үйлдвэрлэл, уурхайн эзэд үүнд гишүүнчлэлтэй. Гишүүд хоорондоо мөрддөг квот, хуваарилалтыг тодорхойлдог томъёотой. Энэ төрлийн картелийн нэг жигүүр нь тендерийн буюу квотын картель. Тэд томоохон худалдан авалтын өмнө гишүүдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулна.¹⁰

Тав дахь төрөл нь патентын картель. Энэ нь патентад суурилсан монополь эрхээс улбаатай төрөөс олгосон нэг ба хэд хэдэн патентыг зөвхөн гишүүд хоорондоо харилцан ашиглуулах тохиролцоонд үндэслэнэ. Ердийн патент ашиглах гэрээнээс ялгаатай нь энэ гэрээний зорилго нь гэрээнд оролцогч талууд патент ашиглах эрхээ урвуулан ашиглаж өрсөлдөөнийг хамтдаа хянах, хязгаарлахад чиглэгддэг.¹¹

Түүний ажигласнаар өрсөлдөгчид шууд л өөр хоорондоо ойлголцоод сайн дураараа хамсан ажилладаггүй. Картель санаачлагчид өрсөлдөгчөө картельд нэгтгэх дараах аргуудыг хэрэглэж байгааг тогтоосон.¹² Үүнд:

Шируун өрсөлдөөн буюу үнийн дайны арга (Fierce competition or price war methods). Картель нь монопольчлохын тулд аль болох салбарын бүрэн төлөөллийг хангаж, бүгдийг нэгтгэхийг зорьдог. Чингэхийн тулд заримдаа тулгах арга хэмжээ хэрэглэхээс аргагүй болдог. Үнийг түр хугацаанд бууруулж барих, бүр тэглэх арга Америкийн төмөр замын компаниудын үнийн дайны үед хэрэглэгдэж байсан ба эцэстээ бүгд картельд нэгдэх хүртэл үргэлжилсэн. Ижил зүйл Германы цагаан будааны цардуул үйлдвэрлэгчдийн хооронд болж зах зээлд нэвтрэгчийг үйлдвэр бариулахгүй байлгахын төлөө үгсэн тохиролцож байсан бол Шведэд шоколад үйлдвэрлэгчдийн хооронд ижил оролдлого хийгдэж байжээ.

Өрсөлдөгчөө худалдан авах (Buying-up of competing firms). Энэ аргыг элсэн чихэр, цахилгааны утас, цагаан будааны цардуул, цемент, хүрэн нүүрс, зэсийн картелиуд хэрэглэсэн. Ихэвчлэн энэ зорилгоор өрсөлдөгчөө худалдан авахад зориулж сан үүсгэн байгуулж, өрсөлдөгчөө худалдан авсны дараа үйл ажиллагааг нь зогсоодог. Энэ аргыг мөн түүхий эдийн нийлүүлэгчтэй хамтран хэрэгжүүлэхдээ тэднийг зөвхөн картелийн гишүүдтэй тусгай гэрээ байгуулахыг шахаж, энэ нөхцөлийг нь эс зөвшөөрвөл түүнээс картелийн гишүүд огт худалдан авалт хийхгүй гэх нөхцөлийг бүрдүүлснээр өрсөлдөгчөө бойкотонд оруулах болон үнээр ялгаварлуулна. Эсрэг чиглэлд мөн бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдахгүй байх арга хэрэглэж болно. Тухайлбал, гутлын бөөний худалдаачид дэлгүүрүүдийн эсрэг ийм арга хэрэглэж байсан ажээ.

Онцгой гэрээ (Exclusive contract or trade). Тодорхой бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо түүхий эд үйлдвэрлэгчдийн холбоотой гишүүд хоорондын онцгой эрхийн гэрээ байгуулах бөгөөд картельд нэгдээгүй өрсөлдөгчдөд энэ онцгой таатай нөхцөл үйлчлэхгүй. Тухайн үед коксжуулсан нүүрс ба ширмийн холбоод, шилэн лонх ба үйсэн бөглөө

⁹ Ibid, pp. 64-5.

¹⁰ Ibid, p.66.

¹¹ Ibid, p.70.

¹² Ibid, pp.110-1.

үйлдвэрлэгчдийн холбоод, шил үйлдвэрлэгч ба шилэн дэнлүүний картель зэрэг бусад олон салбарууд хоорондоо ийм тохиролцоотой байсныг тус тус жишээ болгон тэмдэглэжээ.

Тарифын гэрээ (Tariff contracts). Тодорхой салбарт ажилтан ба ажил олгогчийн хоёрын хооронд харилцан хараат, хамааралт байдлыг бий болгоход тусалдаг хөдөлмөрийн хөлсний жишгийг тохиролцоо гэрээ. Ийм төрлийн гэрээ нь картель ба үйлдвэрчний эвлэлийн хооронд хийгддэг ба хэлэлцэн тохиролцож буй хоёр тал тус бүрдээ нөгөөгийнхөө монополь байр суурийг бодитоор баталгаажуулж, үйлдвэрчний эвлэл нь пүүсүүдийн нэгдэл(картель)-ээс гадуурх аж ахуйн нэгжид гишүүдээ ажиллуулахгүй байх, хариуд нь картелийн гишүүд зөвхөн тус үйлдвэрчний эвлэлийн гишүүдийг ажиллуулах замаар энэ хамтын ажиллагаа бодитойгоор баталгааждаг. Ийм тохиолдлууд 1872-1880 оны хооронд Солинген, Ремшейд зэрэг ахуйн хутга, хайчны үйлдвэрийн худалдааны салбар - үйлдвэрлэл ба үйлдвэрчний эвлэлийн хооронд, цаашлаад 1887 онд Зүүн Швейцарь болон Вогтландын нэхмэл торны үйлдвэрүүдэд тус тус тохиолдсон бол Баварь мужийн толины шилний салбар, Франконы алтны хийцлэлийн, Баруун Германы барилгын заслын хээлэгч төхөөрөмжийн үйлдвэрлэл, Чехийн товчны үйлдвэрүүдэд тохиолдож байсныг жишээ болгон дурдсан.¹³

Түүний нотолж буйгаар Дэлхийн I дайны дараахан буюу 1919 оны гуравдугаар сараас [Германд] картельд төр үнэ тогтоох чиг үүрэгтэйгээр оролцож эхэлсэн байна.¹⁴ Хямралын үед үйлдвэрлэгчид үйлдвэрлэлийн хэмжээг бууруулахаас өөр аргагүй тул хүнд хэцүү үеийн тэдний хамтын ажиллагаа /картель/ ач холбогдолтойг хүлээн зөвшөөрсөн ч үйлдвэрлэлийн өртөг, зардал багатай өрсөлдөгчийн хувьд байнга ийм хамсах ажиллагаанаас ангижрахыг хүсэн, өрсөлдөхийг илүүд үздэг. Тэрчлэн эдийн засгийн нөхцөл байдал хэвийн үед хуурамч айдас хүйдэс үүсгэн нийлүүлэлтийг хязгаарлах, үнийг нэмэх зэрэг монопольчлох арга хэмжээ авахыг зөвтгөх аргагүй гэжээ.¹⁵

Дэлхийн I дайны дараах хямралын үеийн Германы аж ахуйн нэгжүүд картель, сонирхлын бүлэг, нэгдэл эсхүл концернуудын хэлбэрээр зах зээлийн төвлөрлийг бий болгон өрсөлдөөний эрчмийг сулруулан хязгаарлаж, оронд нь аж үйлдвэрийн салбаруудад зах зээлийг рациональчлах чиглэлээр идэвхтэй ажиллаж байсан ерөнхий хандлагыг Р.Лифманн эмпирик ажиглалтад үндэслэсэн олон бодит нотолгоогоор харуулсан.

Картелийн талаарх Р.Лифманны энэхүү бүтээлийг эргэцүүлэн үзвэл хувийн компаниуд эсхүл төрийн оролцоотойгоор зах зээлийг рациональчлах замаар хүндрэлийг амжилттай даван туулсан тухай нотолгоо баримтуудаар дүүрэн байгаа нь картель болон түүнтэй төстэй сонирхлын бүлгүүдийн гол давуу талыг тодотгох гэсэн бололтой. Тэрчлэн АНУ дахь трастуудыг (үнэн хэрэгтээ картелиудыг) эрс хориглох Шерманы хуулийг баталсан тухайг төдийлөн сайшаагаагүй, мөн Герман дахь ажилчин ангийг бослого тэмцэл гаргахгүй байлгах хөшүүрэг буюу хөдөлмөрийн нийлүүлэлтийг тогтвортой болгодог үйлдвэрчний эвлэлийн тарифын гэрээг нэг төрлийн картель гэж үзсэн ч буруутгаагүйгээс үзвэл тэрбээр картелийн эерэг талуудыг нотлохыг эрмэлзсэн гэж дүгнэж болно. Хэдий тийм боловч түүний үзэл санаа тэр чигтээ картелийг сайшаасан туйлширмал бас биш. Картель эдийн засгийн хүндрэлтэй үед бий болох, зайлшгүй шинжтэй үзэгдэл болохыг олон талын эмпирик баримтуудыг дурдахын зэрэгцээгээр бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийг хүлцэх хэмжээнээс өндөр түвшинд байлгах, зах зээлийн бүтцийг “тогтвортой” боловч хөлдөнги, зогсонги болгох, технологийн дэвшлийг сааруулах хүнд суртал гэх мэтийг араасаа дагуулдаг нь картелийн маргаангүй сул тал гэдгийг ч хүлээн зөвшөөрсөн байдаг.

Дэлхийн түүхэнд 1883-1930 онуудад картель үзэгдлийн хөгжил, өөрчлөлтийг дагнан судалж диссертаци бичсэн эрдэмтэн Х.А.Леонардтын үзсэнээр Дэлхийн II дайны дараах “Америкжуулах үйл явц”, неолиберал үзэл баримтлал улс төрийн эдийн засгийн хөгжилд

¹³ Ibid, pp. 121-2.

¹⁴ Ibid, p.84.

¹⁵ Ibid, pp. 90-1.

давамгайлах болсноор картелийн сонгодог онол нь үзэл суртлын золиос болж нэг ёсондоо “хэлмэгдсэн” гэж хэлж болох онол ажээ. Бодит байдал дээр Герман улс дэлхийн эдийн засгийн шинжлэх ухааны ноён оргилд хүрээд байсан бөгөөд 1930-аад оны эдийн засгийн хямралыг хамгийн амжилттай даван туулж, болзошгүй хүнд үед хамгийн бэлтгэлтэй байсан нь үнэн юм бол картелийн сонгодог онолын ач холбогдлыг үнэлэх түүхэн үнэлэмж ч тийнхүү шударга байх ёстой. Картелийн сонгодог онолыг түүхэн ач холбогдолтой онолуудын жагсаалтанд оруулах ёстой¹⁶ гэж маргасантай санал нийлэхгүй байхын аргагүй юм.

2.2. Нацист дэглэм - төрийн хяналттай эдийн засгийн онол¹⁷ хийгээд түүний мөхөл

Оксфордын их сургуулийн судлаач А.Эзраки бодлого боловсруулагч нар картелийг бүхэлдээ сөрөг үр дагавартай тул орчин цагийн эдийн засгийн хорт хавдартай зүйрлэдэг бол эрх зүй хоёрдмол утгагүйгээр хориглож хамгийн хүнд хариуцлагыг хуульчилж, хууль сахиулагчид илрүүлэх ажлыг тэргүүн зэргийн зорилтоо болгодог гэжээ.¹⁸ Картель нь бүхэлдээ тэвчишгүй сөрөг муу гэх байр суурь нь “орчин үеийн баруун”-д хэвлэгдсэн бүтээлүүдийн ерөнхий чиг шугам буюу картелийн орчин үеийн онолын гол агуулгыг илэрхийлдэг. Гэвч чухам хэдий үеэс картель нь сөрөг, муу үзэгдэл гэгдэж, энэ хандлага түгээмэлжсэн нь ул суурьтай судлууштай асуудал мөн. Ялангуяа картель нь эдийн засгийн хямралын үед аяндаа бий болдог бөгөөд хүнд үеийг даван туулах үр дүнтэй арга мөн гэсэн картелийн сонгодог онолтой сөргүүлэн дэнслэх, өнөө цагт ч амь бөхтэй оршсоор байгаа энэ үзлийг нухацтай авч үзэх нь онолын хувьд ач холбогдолтой юм.

Картельд хандах хандлагын өөрчлөлтийг түүхчлэн авч үзэхэд “барууны” гэгдэх нэгдсэн ойлголт Дэлхийн II дайны дараа бүрэлдсэн байна. Эдийн засаг, эрх зүйн онолын гэхээс илүүтэй энэ талаарх сэтгэлгээний харилцан адилгүй байр суурь, хууль зүйн бодлогын ялгаатай чиглэлүүд Европын орнууд болон АНУ-д оршиж ирсэн байна.

АНУ-д картелийн бүх хэлбэрийг хориглох алхам хууль зүйн бодлогын хувьд 1890 онд батлагдсан Шерманы хуулиас эхэлсэн. 19 дүгээр зууны хоёрдугаар хагасаас АНУ-д картелиуд(трастууд гэж нэрлэгдэх)-ын улс төр, эдийн засагт тогтоосон ноёрхлоос АНУ-ын үндсэн хуульт байгууламж, ардчилал, хууль дээдлэх ёс ба хүний эрх, эрх чөлөөний үзэл санааг хамгаалах нийгэм, эдийн засаг, үзэл санааны цогц хувьсал нь Шерманы хуулийн ерөнхий эх сурвалж болжээ. Энэ хууль нь шууд картель гэсэн тодорхой объект руу чиглээгүй ихээхэн ерөнхий бөгөөд үгсэн хуйвалдах, монополичлох аливаа оролдлогыг хориглосон зарчмын заалтаас эхэлсэн бол жишгийн эрх зүйн уламжлалаар цаашид хөгжсөн.¹⁹ АНУ-д картелийг хориглох эрх зүйн зохицуулалт Шерманы хууль 1890 онд батлагдсанаас хойш хууль зүйн бодлогын хувьд жишгийн эрх зүйн хүрээнд нэг мөр болж, өнөөдөр ч хүчин төгөлдөр үйлчилж байна.

Харин эх газрын Европт хууль ёсны бөгөөд хэрэгжих бололцоотой гэрээний зохицуулалттай байсан картельд хандах эрх зүйн сэтгэлгээ огцом өөрчлөгдөж, АНУ-ын жишигтэй ойртож түгээмэлжих хүртэл хагас зуу илүү жилийн нүүр үзсэн юм. Энэхүү сонирхолтой үеийн түүхэн үйл явцыг эдийн засаг – эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн түвшинтэй холбож Чехийн судлаач Л.Никодим дараах байдлаар нэгтгэн дүгнэсэн нь онолын ач холбогдолтой эргэцүүллийн холбоосыг бий болгож байна. Үүнд:

- 19 дүгээр зууны төгсгөлд Венад хөрөнгийн биржийн уналтаар эхэлсэн Европын эдийн засгийн хямрал нь чөлөөт зах зээлийн тогтолцоонд итгэх Европчуудын итгэлийг сулруулж, шүүмжлэлт хандлагыг араасаа дагуулсан.

¹⁶ H. A. Leonhardt: The Development of Cartel 28 + Theory between 1883 and the 1930s, p.78-9.

¹⁷ Theory of controlled economy.

¹⁸ A.Ezrachi, Competition and Antitrust law. A Very Short Introduction (Oxford University Press, 2021) pp. 63-4.

¹⁹ Л.Отгонбаяр “Шерманы хуулийн эх сурвалж: Түүхэн тойм, өрсөлдөөний эрх зүйг хөгжүүлэхэд түүний ач холбогдол”, “Хууль дээдлэх ёс” сэтгүүл, цуврал 78, 2020 оны дугаар №03.

- Төв Европ дахь эдийн засаг, эрх зүйн сэтгэлгээ нь хоёр туйлт байр сууринд «түгжигдсэн» байсан. Нэг туйл нь чөлөөт зах зээлийн тогтолцоонд эрэлт, нийлүүлэлт тэнцвэрээ олж чаддаггүй, үйлдвэрлэлийн илүүдлийг дагуулдаг бөгөөд энэ нь хямралын шалтгаан гэх туйлшрал. Удаах туйлшрал нь үйлдвэрлэлийн илүүдлээс үүдсэн үр ашиггүй байдлыг зохицуулах гол арга зам нь монополь бүтэц буюу картель гэж итгэх болсон явдал.

- Дээрх туйлшралын гол шалтгаан нь 1873 оны хямралын шалтгааныг тайлбарлах онол байхгүй байсантай холбогдоно. Өнөө үед энэ хямралыг бизнесийн мөчлөгийн онол (monetary theory of business cycles)-оор хялбархан тайлбарлаж болох бөгөөд тухайн үеийн хямралын бодит шалтгаан нь Франц-Германы (1870-71) дайны дараах нөхөн төлбөрөөс ихээхэн шалтгаалсан нь тодорхой болсон.

- Хямралын дараа засгийн газрууд протекционист бодлогыг түгээмэл хэрэгжүүлж, гаалийн тарифыг өргөжүүлэх болсон. Энэ арга хэмжээ зөвхөн 1873 оны хямралаар зогсохгүй, 1929 онд эхэлсэн “Их хямрал”-ын үед ч гадны өрсөлдөгчөөс дотоодын зах зээлээ хамгаалах нь түгээмэл арга хэмжээ байсны зэрэгцээ картель байгуулахад таатай орчин болсон. Эхэндээ картельжих үйл явц зах зээлээс аяндаа урган гардаг дотоод шалтгаан буюу эндоген шинжтэй байсан бол 1929 оноос хойш засгийн газрын шахалтаар бий болж эхэлсэн.

- 1930 оныг хүртэл Чехословак, Унгар, Австри, Германд бүх салбарыг хамарсан картелийг хориглосон хууль байгаагүй харин Унгар, Германд картелийг зохицуулах оролдлогууд байсан. Германы хувьд картель гэрээ нь хууль ёсны хүчин төгөлдөр, хэрэгжих боломжтой хэлцэл (legally binding and enforceable agreement)-д тооцогдож байв.

- Нацист дэглэм(1933-1945)-ийн үед албадмал картельчлал (forced cartelization) цэцэглэн хөгжиж эхэлсэн бөгөөд эдийн засгийн төвлөрсөн удирдлагын хүрээнд картелиуд Засгийн газрын заавраар ажиллахаас өөр сонголт байгаагүй.²⁰

Германд Үндэсний социалист (Нацист) үзэл бүхий нам²¹ засаглаж байсан 1933-1945 онуудад хяналттай эдийн засгийн онол (theory of controlled economy) бүхий эдийн засгийн удирдлага хэрэгжиж байв. Энэ дэглэм тус улсын эдийн засгийн хүчин чадлын давуу талыг ашиглан хэт үндсэрхэг, арьс өнгөөр ялгаварлаж хоморголон устгах, тоталитар, эзлэн түрэмгийлэх цэргийн дэглэмийг бий болгож хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн билээ.

Төрийн хяналттай үндэсний социалист эдийн засгийн онол (NS-Lenkungslehre) нь үндэсний эдийн засагт төр давамгайлах чиг хандлагад суурилсан. Салбар бүрт дэд хувилбаруудтай, харилцан уялдаа бүхий систем юм. Зохицуулалт, төлөвлөлтийн хэрэгслийн хувьд либерал эдийн засгийн макро эдийн засгийн процессын загваруудыг ашигласан. Картелийн онолын элементүүд, картелийн техникүүдэд зайлшгүй суурилж, дайны эдийн засгийн экспертийн мэдлэгт тус тус тулгуурлаж байв. Тооцоолол, бүтээгдэхүүний нормчлол ба дизайныг стандартчилах арга, үйлдвэрлэлийн шинэ технологийг нэвтрүүлэх арга зам, амьдрах чадваргүй аж ахуйн нэгжүүдийг хааж салбарын хэмжээнд рациональчлах бодлого явуулах, квотын хуваарилалтанд оптимизаци тохиргоо хийх зэрэг аргуудыг ашиглана. Эдгээр зохицуулалтын арга техникийг сайжруулахад эдийн засгийн бүх салбарын үүрэг оролцоо, бүртгэл тооцоо зайлшгүй шаардагддаг байв.²²

Х.А.Леонардтын тэмдэглэснээр Дэлхийн II дайнд үндсэндээ АНУ ялж²³ Нацист Герман ялагдсанаар уул Германчуудын хүн төрөлхтний эдийн засгийн онолын сэтгэлгээнд оруулсан бүх хувь нэмэр, тэр дундаа картелийн онол ч хамтдаа үгүйсгэгдэж хэлмэгдсэн

²⁰ Nikodym, L.(2014). Theoretical aspects of cartelization in Central Europe—An introduction to cartel theory. *Central European Papers*, 2(1), 25-38.

²¹ <https://www.britannica.com/topic/Nazi-Party>.

²² Н. А. Leonhardt: The Development of Cartel 28 + Theory between 1883 and the 1930s, p.80.

²³ Албан ёсоор АНУ, ЗХУ, Британийн холбоотны хүчин ялсан гэж түүхэнд тэмдэглэдэг ч Дэлхийн хоёрдугаар дайны дараа эдийн засгийн хүчин чадлаар үнэхээр АНУ л хамгийн хүчирхэг, дэлхийн нөлөө бүхий гүрэн болж үлдсэн нь үнэн.

ажээ.²⁴ Нацист дэглэмд ашиглагдаж байсан улс төр, эдийн засгийн онол, үзэл санааг дайнд ялсан АНУ, ЗХУ-ын үзэл суртлын хүчнүүд аль аль нь хориглон үгүйсгэсэн нь түүхэн үнэн юм. “Картелиуд Гитлерийг бий болгож, Гитлер дайныг эхлүүлсэн” хэмээх хэлц гарч байв.²⁵

Ялсан хоёр гүрэн Европ төдийгүй дэлхийн улс орнуудыг “төмөр хөшиг”-өөр хоёр хэсэгт хуваасан бөгөөд энэ нь улс төр, эдийн засаг, үзэл суртлын хуваагдал байсан. Дэлхийн II дайны дараах Европын сэргээн босголт, реформын талаар аливаа дүгнэлтийг хийхэд түүхэн хоёр томоохон үйл явдлыг зайлшгүй авч үзэх ёстой. Нэгдүгээрт, АНУ-ын шууд санаачилгаар 1944 оны Бреттон Вүүдсийн гэгдэх олон улсын мөнгө санхүүгийн түүхэн конференц зохион байгуулагдаж, түүгээр Олон Улсын Валютын Санг үүсгэн байгуулж, олон улсын санхүүгийн байгууллагуудын ажиллах зарчмыг олон улсын хэмжээнд тодорхойлсон билээ. Хоёрдугаарт, АНУ-ын Конгресс алдарт “Маршаллын төлөвлөгөө”-г баталж, 1948-51 оны хооронд түүнийг хэрэгжүүлэхдээ дайнд хохирол амссан Европын 16 улсын²⁶ эдийн засгийг сэргээн босгоход их хэмжээний мөнгө санхүү, бодлогын туслалцаа үзүүлсэн билээ. Энэ хүрээнд олон улсын санхүүгийн байгууллагуудын тусламж, дэмжлэгээр хэрэгжсэн хөгжлийн албан ёсны төсөл, хөтөлбөрүүдийн үр шимээр АНУ болон Европын эдгээр улс орнуудад эдийн засгийн бүтцийн болон үзэл санааны реформ хийгдэж, чөлөөт эдийн засаг, улс төр, эрх зүйн хамтын үнэт зүйлс багтай бүрэлдэн тогтсон нь дамжиггүй юм.

АНУ-ын Шерманы хуулийн дагуу картель нь “худалдааг хязгаарлах” гэмт хэрэгт тооцогддогтой агуулга нэг байдлаар Европт ч картель нь эдийн засагт сөрөг үр нөлөөтэй, ёс зүйд нийцэхгүй, буруушаасан шинжтэй түгээмэл утгыг илэрхийлэх болжээ. Чингэснээрээ үзэл баримтлалын хувьд Европ дахинаа түгээмэлжиж эхэлсэн неоклассик эдийн засгийн онолтой чухам нийцэмжтэй болж ирэв.

Энэ хэсгээс зөвхөн дараах таамаглалыг дэвшүүлж болохоор санагдаж байна. Картель нь Нацист дэглэмийн төрийн хяналттай үндэсний социалист эдийн засгийн удирдлагад ашиглагдсан болох нь түүхэн үнэн бөгөөд энэ дэглэмээс өмнө нь, хойно ч байсан үзэгдэл. Тэр бүү хэл А.Смит ч картель түгээмэл байдаг тухай тэмдэглэсэн байдаг.²⁷ Тиймээс барууны улс орнууд картелийн талаар сөрөг байр суурьтай байдгийн учир шалтгаан нь энэ үзэгдэл эдийн засгийн гүйцэтгэлийг хурдасгах онцлогтой ба тэрхүү потенциал нь төрийн хяналт үзэл суртлын гарт орж дайны машин болж ашиглагдахаас болгоомжилсноос үүдэлтэй гэж таамаглаж болох юм.

III. ДЭЛХИЙН II ДАЙНЫ ДАРААХ ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТЫН ҮЕИЙН КАРТЕЛИЙН ЭРХ ЗҮЙН СЭТГЭЛГЭЭ БА ТҮҮХЭН ҮЙЛ ЯВДЛУУД

3.1. Фрайбургийн сургууль, *Soziale Marktwirtschaft*²⁸ ба Германд картелийн эрх зүйн зохицуулалт нэвтэрсэн нь

Фрайбургийн их сургуулийн судлаачид хожмоо Ордолибералист эдийн засгийн сургууль гэгдэх болсон дэг сургуулийг бий болгосон. Тус сургуулийнхан 1930 оноос эхлэн эрх зүй ба эдийн засгийн ухааны уялдаа холбоог ихээхэн сонирхож хөгжүүлж ирсэн.²⁹ Энэ нь Германы протестант ёс зүй, неолиберал үзлийн нэгдэл гэж хэлж болох өвөрмөц өөрийн гэсэн онцлогтой улс төрийн эдийн засгийн сургааль юм. Гол төлөөлөгч нь В.Үйкен (W.Eucken) бөгөөд цаашид үргэлжлүүлсэн хүмүүсийн дотроос энэ сургуулийн өрсөлдөөний бодлогыг хөгжүүлж, хожмоо Дэлхийн II дайны дараа батлагдсан Германы өрсөлдөөний

²⁴ Ibid, p.75.

²⁵ Fear, J. R. (2006). *Cartels and competition: Neither markets nor hierarchies*. Division of Research, Harvard Business School. P.15.

²⁶ Австри, Бельги, Дани, Франц, Грек, Исланд, Ирланд, Итали, Люксембург, Нидерланд, Норвеги, Португал, Швед, Швейцарь, Турк, Британи.

²⁷ Адам Смит, *Үндэсний Байлаг* (Улаанбаатар: Непко, 2018) 152 дахь тал.

²⁸ Social market economy – нийгмийн баримжаат зах зээлийн эдийн засаг.

²⁹ Pelle A. (2011). *The German roots of the European community's cartel regulation: from a historical and theoretical perspective*. LAP Lambert Academic Publishing. p.43.

хуулийн үзэл санааны эцэг гэгддэг хуульч, эдийн засагч профессор Ф.Бом (Franz Böhm) юм. Нацист дэглэмийн үед нууц далд хэлбэрт шилжин нууцаар хуралддаг байсан энэхүү үзэл санааны бүлгэмийн төлөөлөгчид картель, төрийн хатуу хяналт бүхий төвлөрүүлсэн удирдлагыг аль алиныг нь шүүмжилж ирсэн.

Фрайбургийн эрдэмтдийн гол үзэл санааг В.Үйкений ончтойгоор хэлсэн “төр нь эдийн засагт цэцэрлэгчийн үүрэгтэй оролцох ёстой” гэсэн зүйрлэлээр хураангуйлж болох юм. Ямар ч цэцэрлэгт тогтмол арчилгаа, тордлого хэрэгтэйн адил төр нь үндсэн хуулийн эрх зүйн арга хэрэгслээр эдийн засагт дараах нөхцөл байдлыг хангах чиг үүрэгтэй гэжээ. Үүнд:

- Оновчтой үнийн систем;
- Тогтвортой валют;
- Зах зээлд нэвтрэхэд нээлттэй;
- Хувийн өмч;
- Гэрээний эрх чөлөө (өрсөлдөөнийг хязгаарлахгүй, бусдын гэрээний эрх чөлөөг хөндөхгүй);
- Үүрэг хариуцлагатай байдал;
- Эдийн засгийн зөв бодлого (эдийн засгийн процесс угаас эмзэг, тиймд төр түүнийг тэр хэвээр нь орхих ёсгүй)³⁰.

Фрайбургийн сургуулийн үндэслэсэн энэхүү нийгмийн шударга ёс, ёс суртахууныг зарчим болгосон төрийн хязгаарлагдмал оролцоотой зах зээлийн эдийн засгийг *Soziale Marktwirtschaft* буюу нийгмийн баримжаат зах зээлийн эдийн засаг гэж нэрлэх нь бий. Тэрчлэн Ф.Бомын үзсэнээр чөлөөт эдийн засаг байна гэдэг нь эрх зүйн хувьд эрх тэгш талууд чөлөөт байдлаар солилцоо хийж, гэрээ байгуулах эрх чөлөөтэй байна гэсэн үг. Эдгээр нь үндсэн хуулийн дэг журмыг зах зээлийн эдийн засгийн хэвийн амьдралд үйлчлүүлэн хөгжүүлэх холбоос болж өгдөг. Түүнийхээр үндсэн хуулийн дэг журам нь өрсөлдөөнийг хязгаарласан гэрээ, хэлцэл, картелийг зөвшөөрдөггүй байх чиглэлээр хөгжих ёстой. Гэрээний эрх чөлөө нь үндсэн хуулийг тойрч гарах ёсгүй бөгөөд ямар ч гэрээ нийтийн ашиг сонирхлыг зөрчих буюу суурь дэг журам (*primary order*)-тай зөрчилдөх зорилго агуулах ёсгүй. Тэрбээр өрсөлдөөн нь ашгийн төлөөх эдийн засгийн ёс суртахууны ноён нуруу юм хэмээн зүйрлэжээ.³¹

Дайны дараах Европыг сэргээн босгох үйл явц АНУ-ын удирдлага, хяналт дор явагдсан ба уг үйл явцын дотроос Европын эдийн засаг, улс төрийн үйл явцад чухал нөлөөтэй нь баруун Герман байсан тул америкчууд орон нутгийн барууны үзэлтэй хүний нөөцөд тулгуурлах шаардлага тулгарсан. Ийнхүү тэд Фрайбургийн сургуулийн ордолибералистуудтай хамтран ажиллаж 1950 оноос хойш АНУ-ын өрсөлдөөний эрх зүйн зарчмуудыг нутагшуулах шахалтыг үзүүлж эхэлсэн байдаг. Энэ зорилгоор байгуулагдсан ажлын хэсгийг Ф.Бом удирдав. Хуулийн төсөл аж үйлдвэрийн салбарын эсэргүүцэлтэй тулж, хууль тогтоох байгууллагад удтал хэлэлцэгдсэний эцэст 1957 онд “Өрсөлдөөнийг хязгаарлахын эсрэг хууль” (*Gesetz gegen Wettbewerbsbeschränkungen*, товчоор “GWB”) нэртэйгээр батлагджээ. Хууль батлагдсанаас нэг жилийн дараа Германы Картелийн Газар байгуулагдсан түүхтэй.³² Энэхүү хууль батлагдахдаа зарим төрлийн картель болон өрсөлдөөнийг хязгаарласан гэрээг хориглолтод хамааруулахгүй байхаар заав. Тухайлбал, хугацааг тохиролцоо (*term-fixing*), борлуулалтын урамшуулал, жижиг дунд үйлдвэрийн картель гэрээ, сүлжээ байгуулах замаар томоохон аж үйлдвэрийн пүүсүүдтэй өрсөлдөх боломжийг олгох зэрэг өргөн хүрээний чөлөөлөлтийн нөхцөлүүдийг агуулжээ. Тэрчлэн дараах тодорхой салбарууд, сегментийг шинэ тутам батлагдсан хуульд картель хэлцэл

³⁰ Ibid, p.52.

³¹ Ibid, pp. 51-53.

³² Quack, S., & Djelic, M. L. (2005). Reinforcement: The Story of Antitrust and Competition Law in Germany and Europe. *Beyond Continuity: Institutional Change in Advanced Political Economies*, 255.

байгуулсан ч хориглолтод хамааруулахгүй гэж заажээ. Үүнд:

- Тодорхой салбарууд: Далайн болон агаарын тээвэр, банк, зээлийн газрууд, даатгал, нийтлэг хэрэглээний салбарууд бүхэлдээ;
- Жижиг дунд аж ахуй эрхлэгчид нэгдэж сүлжээ бий болж, том эсхүл гадаадын томоохон пүүстэй өрсөлдөөний тэнцвэртэй нөхцөлийг бүрдүүлэхэд.³³

Эндээс дүгнэхэд эдийн засгийн шилжилтийн, эсхүл дайн, хямрал зэрэг онцгой нөхцөл байдлаас сэргэх шатанд байгаа улс орны хувьд картелийн эрх зүйн зохицуулалтын хувьд бага зэрэг зөөлөн алхам хийж болдог нэг жишээ энэ болно.

3.2. Европын нүүрс ба гангийн нийгэмлэг (картель) байгуулах санаа Европын холбоо болж өөрчлөгдсөн нь

Дэлхийн дайнуудын хөлд нэрвэгдсэн Европ дахинд энх тайвныг тогтоож, эдийн засгийг сэргээх улс төр, эдийн засгийн чухал хөшүүрэг нь Франц – Баруун Германы стратегийн түүхий эд болох нүүрс ба гангийн түүхий эдийн нөөцийг эв найртайгаар хамтран ашиглах олон улсын түүхий эдийн картель байгуулах явдал байж болохыг Францын тал ойлгож, санаачилга гаргасан. Энэхүү санаачилгыг ажил хэрэг болгох ажлыг Францын дипломатч, санхүүч Жан Моннед хариуцуулж тэрбээр 1950 оны 5 дугаар сараас эхлэн Герман, АНУ-ын талуудтай идэвхтэй ажилласан байна. Юуны өмнө тэрбээр АНУ-д энэ саналаа танилцуулж нааштай хариу авсан байна. Ж.Моннед стратегийн баялгийн хамтын ашиглалт, үйлдвэрлэлийн хамтын ажиллагаа, Европын хэмжээний томоохон хэрэглээг удирдах замаар АНУ-тай ижил загвараар Европ хөгжиж хүчирхэгжих ёстой гэсэн бат итгэл үнэмшил байв.

АНУ-ын талын болгоомжлол нь хамтын ажиллагааг ямарваа хэлбэрээр олон улсын картель болгохгүй байх явдал байв. Францын тал энэ байр суурийг нухацтай авч үзэж гэрээнд картель байгуулаагүй тухай заалт оруулахын дашрамд эдийн засгийн хямралын үед картель гэрээ, хэлцлийг хязгаартайгаар байгуулж болох заалт оруулах амлалт өгчээ. Улмаар энэхүү гэрээний саналд Франц, Баруун Герман, Итали, Бельги, Недерланд болон Люксембургийн талууд нааштай хандаж, тэдгээр 6 улсын хооронд яриа хэлэлцээр эхэлсэн байна.³⁴

Хэлэлцээр амжилттай болсны дараа 1952 онд Европын Нүүрс ба Гангийн нийгэмлэг байгуулагдаж, энэ яриа санаачилгыг ажил хэрэг болгосны учир Ж.Монне тус нийгэмлэгийн анхны Ерөнхийлөгч болсон. Европын Нүүрс ба Гангийн нийгэмлэг нь үндсэндээ бүс нутгийн түүхий эдийн олборлолт, үйлдвэрлэл, нийлүүлэлт, хэрэглээг Засгийн газар хоорондын байгууллагын хяналтанд авах замаар бүс нутгийн аюулгүй байдлыг эдийн засгийн хөшүүргээр ханган уялдуудах олон улсын картель төдийгүй гео-эдийн засгийн алсын хараатай алхам байсан гэж дүгнэж болно.

Европын Нүүрс ба Гангийн нийгэмлэгийг картель гэж үзэхээс зайлсхийж, харин ч 1952 оны үйл ажиллагааны олон талт суурь гэрээндээ картелийг хориглох заалт оруулсан гэдэг ч картелийн тухай түгээмэл ойлголтууд болох гэрээнд оролцогчид газарзүй, эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзахгүйгээр бүтээгдэхүүний болон тээврийн үнийг өөр хоорондоо нэг түвшинд тогтоох, гол мэдээлэл солилцоо, ажиллах хүчний болон хөрөнгө оруулалтын зардлыг удирдах, гэрээнээс гадуурх этгээдтэй хийх худалдааны хэлэлцээрт нэг цонхны бодлого барьж хэлэлцээр хийх зэргийг доор гэрээний үндсэн агуулгатай харьцуулан анхааралтай уншвал энэ нь томоохон картель байсан гэж дүгнэх нь дамжиггүй юм. Үүнд:

- Нүүрс ба гангийн үнийг ил тод нийтэлж байх ба (гишүүдэд) үнийг ялгаварлахгүй байна.
- Хөрөнгө оруулалтын менежмент. Гэрээний дээд удирдлага нь хөрөнгө оруулалтын

³³ Ibid, p.10.

³⁴ Ibid.

чиглэлээр туслалцаа үзүүлэх бөгөөд хөрөнгө оруулалтыг аж үйлдвэрийн салбарын тогтворжуулалтын зорилгоор татаас олгох хэлбэрийн хөрөнгө оруулалтыг хориглоно.

- Картелийг хориглох. Гэрээний дээд удирдлага нь (уурхайн олборлогчдын) нэгдэж нийлэх процесст зөвшөөрөл олгоно.

- Татаас (уурхайн олборлогчдод) олгохыг хориглоно.

- Хөдөлмөрийн бодлого. Хөдөлмөрийн үйл явц, бодлого, мэдээлэл нь ил тод байна.

- Тээвэрлэлт. Төмрийн хүдрийн тээврийн тариф улс болгоны хувьд ижил байхаар тооцож нийтэлж байна.

- Гадаад харилцаа. Сайд нарын зөвлөлийн удирдлага дор гэрээний дээд удирдлага нь нүүрс ба гангийн талаар хэлэлцээр хийх эрхтэй бөгөөд Гадаадын Засгийн газартай дипломат харилцаа тогтоох, хэлэлцээр хийнэ.

- Хямралын үеийн арга хэмжээ. Хямралын үе тохиолдвол гэрээний дээд удирдлага нь гишүүдэд үйлдвэрлэлийн квот тогтоож болно.³⁵

Энэхүү нийгэмлэг нь амжилттай ажилласны үндсэн дээр нийгэмлэгт нэгдсэн улс орнууд эдийн засгийн хамтын ажиллагаагаа илүү өргөжүүлэхээр тогтож 1957 оны Европын эдийн засгийн нийгэмлэг байгуулах Ромын гэрээ (ЕЕС), 1958 оны Европын цөмийн энергийн хамтын ажиллагааны нийгэмлэг(Euratom)-ийг тус тус байгуулсан билээ. Анхны хамтын ажиллагааны эхлэл болсон Европын Нүүрс ба Гангийн нийгэмлэг нь 1960 оноос Европын Парламент нэртэй болсныг тус байгууллага албан ёсны түүхэндээ тэмдэглэн үлдээсэн билээ.³⁶

Стратегийн түүхийг эд, атомын эрчим хүч, Европын эдийн засгийн хамтын ажиллагааны өргөн цар хүрээтэй бүтцүүдийг бий болгосон ч Европын холбооны гэрээ(Ромын болон Лисабоны)-нд бүс нутгийн орон зайд дотоодод үйлчлэх худалдаа, эдийн засгийн нэгдмэл зах зээлийн интеграцийг хамгаалах шударга өрсөлдөөн, картелийг хориглох зохицуулалтууд агуулагдаж ирсэн.³⁷

Европын энэхүү хамтын ажиллагаа нь нэг талаас гэрээний болон институцийн хувьд нэг ёсны протекционист (бусдаас өөрийгөө хамгаалах) арга хэрэгсэл шинжтэй, тэрчлэн гишүүн улсууд доторх аж ахуй эрхлэгчдийн хоорондын өрсөлдөөний шударга байдлыг картелийн орчин үеийн онол, олигополийн онолын үүднээс авч үзэж зохицуулах гэсэн зэрэгцээ өөр өөр зорилтууд бүхий парадокс шинжтэй, өрсөлдөөний эрх зүйн зохицуулалтын өвөрмөц загвар, арга хэрэгсэл гэж дүгнэж болох юм.

3.3. Картелийн орчин үеийн онол³⁸ картелийг хориглох хууль зүйн бодлогын гол үндэслэл болох нь

Дэлхийн II дайны дараах “барууны” ертөнцийн тэргүүлэх судлаачид картелийн сонгодог онолыг хүлээн зөвшөөрөх нь бүү хэл тийм онол байсан эсэх тухай ч дурдахгүй, улмаар дагнан бичигдсэн бүтээлүүдийг ч үл ойшоож ирсэн нь шударга бус болохыг картелийн онолыг түүхчлэн судалсан судлаачид тэмдэглэцгээх болсон³⁹ тухай бид өмнө дурдсан. Барууны судлаачдын энэ байр суурь нь ердийн нэг алдаа төдий бус, антифашист, неолиберал үзэл суртлын гүн гүнзгий суурьтай гэж үзэж болох юм. Энэ таамаглалыг батлах мэт 1964 онд картелийн орчин үеийн онолын гол төлөөлөгч, АНУ-ын Чикаго сургуулийн Нобелийн шагналт эдийн засагч Ж.Стиглер “өрсөлдөөнийг хязгаарлах гэсэн их хүслээс

³⁵ Meunier, S., & McNamara, K. R. (Eds.). (2007). *Making history: European integration and institutional change at fifty* (Vol. 8). Oxford University Press, USA. p.92.

³⁶ <https://www.europarl.europa.eu/about-parliament/en/in-the-past/the-parliament-and-the-treaties/treaty-of-rome> [Сүүлд холбогдсон 11/04/2023].

³⁷ Whish, R., & Bailey, D. (2021). *Competition law*. Oxford University Press. pp. 512-52; Jones, A., & Sufrin, E. (2001). *EC competition law: Text, cases, and materials*. pp. 858-939; Fox, E. M., Geradin, D., & EU, C. L. (2017). *Cases, Text, and Context*. 33-62; Motta, M. (2004). *Competition policy: theory and practice*. Cambridge University Press. pp. 167-178.

³⁸ Modern cartel theory.

³⁹ Fear, J. R. (2007). Cartels. In: Geoffrey Jones and Jonathan Zeitlin (eds.): *The Oxford handbook of business history*. Oxford: Univ. Pr., p. 268–293; H. A. Leonhardt: *The Development of Cartel 28 + Theory between 1883 and the 1930s*, p.77.

нь үүдэн үгсэл хуйвалдаан хэрхэн, яагаад үүсдэг тухай тайлбарлах нь хүмүүсийн төсөөлж чадахаас ч илүү хүндрэлтэй байсан. Учир нь картель хууран мэхлэх сэдлээр анх бий болсон тул угаас тогтворгүй байсан”⁴⁰ хэмээн тэмдэглэсэн байдаг.

Ж.Стокинг, М.Ваткинс нарын картельд өгсөн тодорхойлолт хамгийн нийтлэг хэрэглэгдэн эш татагддаг тодорхойлолт юм. Тэд картелийг нэг төрлийн аж ахуй эрхлэгчдийн хооронд буюу тэдгээрийн нэрийн өмнөөс, тэдгээрийн хоорондох өрсөлдөөнийг үр нөлөөтэйгээр хязгаарлах эсвэл арилгах зорилготой тохиролцоо гэж тодорхойлдог. Картель хэр зэрэг үр нөлөөтэй байх нь гэрээнд оролцогч өрсөлдөгчдийн тооноос ихээхэн хамаардаг.⁴¹

Ж.Стиглер нь төрийн зохицуулалтын хувьд Фрайбургийн В.Үйкений байр суурьтай үндсэндээ ижил бодолтой байсан. Төрийн зохицуулалтын уламжлалт чиг үүргүүд, тэр дундаа нийтийн сайн сайхны төлөө ба гэнэтийн үйл явдлыг шийдвэрлэх чиглэлээр төрийн оролцоог хүлээн авах учиртай ч эдийн засагт аль болох бага оролцох нь зүйтэй гэж үзсэн.⁴²

Тэрбээр аж үйлдвэрийн салбарт картель үүсэх хөрс суурь болсон нөхцөлүүдийг тодорхойлсон олигополийн онолыг боловсруулсан.⁴³ Түүний онол олигополийг таньж мэдэх, түүнээс бий болох хор уршгийг өрсөлдөөний байгууллага илрүүлэх, таслан зогсооход онцгой ач холбогдолтой байж ирсэн билээ. Тодорхой зах зээлд үгсэл хуйвалдаан буюу картель бий болох магадлалыг ихэсгэх зах зээлийн дотоод зүй тогтол байдаг эсэхийг тодорхойлоход түүний олигополийн онолын зорилго чиглэгдсэн байна. Үүнд:

Эрэлтийн мэдрэмж (Elasticity of demand): Тухайн зах зээлд эрэлтийн мэдрэмж бага байх тусам үнийг өндөр тогтоох нь ашигтай байдаг. Учир нь ерөнхийдөө үгсэн хуйвалдсан өндөр үнэд хүргэхийн тулд үйлдвэрлэлээ багасгадаг бол эрэлтийн мэдрэмж бага зах зээлд тэрхүү багасгах хэмжээ нь бага учраас ашиг нь ч өндөр. Эрэлтийн мэдрэмж бага үед картель үүсэх магадлал ихсэх хэдий ч эрэлтийн мэдрэмж ихтэй бол картель бий болдоггүй, байдаггүй гэж бодож болохгүй. Эрэлтийн мэдрэмж гэж байгаа нь пүүсүүдэд ихээхэн зах зээлийн хүч байхгүй, картель үүсэхийн өмнөх мэдрэмжийг хэлж байна. Хэрвээ зах зээлийн хүч байвал эсвэл картелийн үеийн мэдрэмжээр тооцвол, мэдрэмж их тусам харин ч картель тогтвортой оршин тогтнож байгаа гэдгийн илрэл байж болно. Картель нь монополийн үнэтэй ойролцоо болтол үнийг өсгөж чадсан гэсэн үг. Үүнийг шалгах нэг арга бол картелийн аргаар үнийг нь тогтоосон бүтээгдэхүүнийг орлох бүтээгдэхүүнүүд нь адилхан үнэтэй бол илүү өртгөөр бүтсэн эсэхийг нягтлах юм. Хэрвээ илүү зардлаар үйлдвэрлэгдсэн мөртлөө адил үнээр зарж байгаа бол илүү өрсөлдөөнтэй нөхцөлд үйлдвэрлэгдэхээргүй бүтээгдэхүүн гэсэн үг юм.

Худалдагчийн төвлөрөл (Seller concentration): Картель болон хамсах зан үйл нь нийлүүлэгч цөөн байх тусам илүү түгээмэл болдог. Картель байгуулан гишүүдийн үйл ажиллагааг зохицуулж, хянахад гишүүд нь цөөхөн бол зардал, чирэгдэл багатай байх нь ойлгомжтой. Түүнчлэн, пүүсүүд зах зээлд эзлэх хувь хэмжээ, зардлын бүтцийн хувьд ойролцоо байх тусам тэдний эрх ашиг салаалан ялгарах магадлал багатай бөгөөд зарим пүүсүүд нь урвах эрсдэл багатай ажээ.

Зах зээлд нэвтрэх саад бэрхшээл (Barriers to entry): Зах зээлд нэвтрэх саад бэрхшээлүүд нь үгсэн хуйвалдах магадлалыг ихэсгэдэг. Учир нь, пүүсүүд картелийн үнэ болон бусад тохиролцоог нураах буюу үнийг бууруулахын тулд зах зээлд нэвтрэх бололцоо муутай байдаг. Гэвч картель нь амжилт олохын тулд салбар дахь бүх пүүсүүд нэгдэх шаардлагагүй. Томоохон пүүсүүд нь үнээ зохицуулаад, захын хэдэн үр ашиггүй өрсөлдөгч нь картелийн зохицуулалт болон зах зээлд нэвтрэх саадын “шүхэр” дор хоргодох боломжтой.

⁴⁰ Fear, J. R. (2006). *Cartels and competition: Neither markets nor hierarchies*. Division of Research, Harvard Business School. p.3.

⁴¹ Stocking G.W. and M.W. Watkins (1948), *Cartels or Competition? The Economics of International Controls by Business and Government*, New York: The Twentieth Century Fund.

⁴² Pelle A. (2011). *The German roots of the European community's cartel regulation: from a historical and theoretical perspective*. LAP Lambert Academic Publishing. p.59.

⁴³ G. J. Stigler, 'A Theory of Oligopoly', *Journal of Political Economy*, Vol. 72, 1964, pp 44-61; reprinted in his *The Organization of Industry* (University of Chicago Press, 1968) Chap. 5.

Худалдан авагчийн төвлөрөл (Buyer concentration): Цөөн тооны том худалдан авагч нь картель үүсэх магадлалыг бууруулдаг. Учир нь томоохон худалдан авагч нь худалдагчаа сольсон тохиолдолд картель дэх гишүүд нь тухайн гишүүнийг заль мэх хэрэглэж, бусдаа хуурсан эсэхийг тодорхойлоход бэрх байдаг. Худалдан авагч нийлүүлэгчээ тийнхүү сольсон нь үйлчилгээний чанар, хямдралын бодлого гэх мэт үндэслэлтэй хүчин зүйлээс ч хамаарсан байж болно. Эсвэл картелийн нэг гишүүн нь бусдынхаа итгэлийг эвдэж, нууцаар тохиролцсон байх боломжтой. Мөн том худалдан авагч нь хуйвалдсан тохиролцоог илрүүлж, хариу үйлдэл үзүүлэх магадлал өндөр байдаг.

Үнийн бус өрсөлдөөнгүй байдал (Absence of non-price competition): Картелиуд стандартчлагдсан бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг ба бусдаар үнийн өрсөлдөөнөөс хамааралтай салбаруудад илүү түгээмэл байдаг. Бүтээгдэхүүнүүд ялгаатай, үнийн бус өрсөлдөөн давамгайлсан зах зээлд зохицуулах арга хэмжээнүүдийн зохион байгуулалтын болон хяналтын зардал харьцангуй их тул картель үүсэх магадлал багатай. Өөрөөр хэлбэл, гишүүд үнийн бус өрсөлдөөнийг хянахад асар хүндрэлтэй ба бүтээгдэхүүнүүд буюу пүүсүүд ялгамжтай байхын хэрээр картель үүсгэхээс хүртэх ашиг, алдагдал нь янз бүр байна. Тиймд пүүсүүд урвах эрсдэл ихэснэ.

Мэдээлэл солилцоо (Exchange of information): Оролцогчид нэгэндээ зорилтот үнэ ба үйлдвэрлэлийн талаар дохио өгөх ямар нэгэн арга хэрэгсэл байх ёстой. Үнэ, зах зээлийн нөхцөл, бараа, бүтээгдэхүүний ихээхэн хувь нь хаана арилжиж байгаа болон импорт ба экспортын талаар мэдээлэл түгээдэг салбарын эвлэл эсвэл худалдааны танхим байх нь дээрхи дохио өгөх ажлыг хөнгөвчилдөг. Чухал мэдээллийг хэвлэлийн мэдэгдлээр мөн солилцож болно. Гэхдээ мэдээлэл солилцооны үед хянуур хандах шаардлагатай. Аливаа пүүс мэдэгдэлдээ чадамж хязгаарлагдмал байна, үнээ нэмнэ гэж хэлэхэд ямар ч асуудалгүй. Харин картель нь үр дүнтэй үйл ажиллагаа явуулахад ч, хэрэг үүсгэж аливаа хохирол нэхэмжлэхэд ч олон нийтэд мэдэгдсэнийхээ дагуу үнээ нэмсэн байх нь л чухал.

Дампуурах өндөр эрсдэл (High risk of bankruptcy): Картелиуд тогтмол болон хувьсах зардлын харьцаа нь өндөр байдаг салбаруудад илүү түгээмэл байдаг. Үүний гол шалтгаан нь үнийн өрсөлдөөн, ялангуяа “үнийн дайн”, нь бие даасан пүүсүүдийн оршин тогтнолд бодитойгоор заналхийлдэг. Дампуурах эрсдэл тийм их байхад пүүсүүд үнийн өрсөлдөөнийг буюу ихээхэн алдагдал хүлээх боломжийг бууруулах хуйвалдсан тохиролцоонд татагдах нь аргагүй.

Зогсонги эсвэл буурч байгаа эрэлт (Static or declining demand): Эрэлт нь тогтвортой эсвэл буурч байгаа салбарт хуйвалдсан тохиролцоогоо зөрчиж буй пүүсүүдийг илрүүлэхэд илүү хялбар болдог. Учир нь зах зээлд эзлэх хэмжээний өөрчлөлтөө түр зуурын эсвэл мөчлөгийн шинжтэй эрэлтийн савлагаанаас үүдэлтэй гэж халхавчлах боломж байхгүй болно. Эсрэгээрээ эрэлт нь ихээхэн хэмжээгээр нэмэгдэж байгаа зах зээлд картелийн үнээс хямдруулан буулгах пүүсийн улмаас үүсэх эрэлтийн ихээхэн нэмэгдэлтэй холбоотойгоор тохиролцоо зөрчсөн пүүсүүдийн борлуулалтыг түр зуурын ба мөчлөгийн эсэхийг ялгаж салгахад хүндрэлтэй байдаг учраас картель бараг үүсэхгүй.

Олон зах зээл дэх харилцаа (Multi-market contact): Пүүсүүд хоорондоо хэд хэдэн зах зээлд өрсөлддөг бол хуйвалдсан үр дүнгээс бусдыгаа хуурч замаасаа мурийх магадлал нь багасдаг. Пүүсүүд урвагчийг шийтгэхдээ зөвхөн картель байгуулсан зах зээлээс гадна үйл ажиллагаа эрхэлдэг бусад зах зээлүүдэд мөн адил шийтгүүлэх боломжтой. Ингэснээр хуйвалдаандаа үнэнч бус хандсан пүүсийн боломжит алдагдал ихсэх тул үгсэл хуйвалдаан харьцангуй тогтвортой байна гэсэн үг.

Хуйвалдааны түүх (History of collusion): Картелиуд нь картелийн түүхтэй салбаруудад үүсэх магадлал өндөр байдаг. Тухайн картель үүсэхэд хүргэх хүчин зүйлс нь байх бөгөөд пүүсүүд нь харьцангуй картель болж ажиллах туршлагатай байх хандлагатай.

Дээр дурдсанаар картель бий болох онолын нөхцөлийг харгалзан чөлөөт өрсөлдөөнийг

дэмжих, картелийг устган хориглохгүй аваас төртэй нийлсэн картелиуд юунд хүргэж байсан тухай анхааруулгыг хүчтэйгээр сурталдах нь өнөөгийн олон улсын цөөнгүй байгууллагууд (OECD, UNCTAD, ICN), барууны сургуулиудын картельд хандах хандлагыг төлөөлж байна гэж үзэж болно.

Дотоодын зах зээлд картелийн учруулдаг хор уршгийг тайлбарласнаараа картелийн орчин үеийн онол нь үндэсний эрх зүйн зохицуулалт дахь картелийг хориглох хатуу чиг хандлагыг зөвтгөхүйц онолын үндэслэл болж байдаг ажээ. Картелийг тодорхойлох арга зүйн хувьд картелийн орчин үеийн онол, олигополийн онолд суурилах болж, энэ нь ямар ч хөдөлбөргүйгээр дотоодын эдийн засагт картелийн бүхий л сөрөг талуудыг зүй тогтолтой нь нээн харуулж байна. Картелийн орчин үеийн онол нь АНУ-ын болон Европын холбооны зөвхөн дотоодын зах зээлд хамаарах өрсөлдөөний эрх зүйд өдгөө ч гүн гүнзгий нөлөө үзүүлсээр байна.

Картелийн орчин үеийн онолын энэ талаарх сонгодог онолоос эрс ялгаа нь неолиберал байр суурьнаас картелийг эрс буруушаах боловч картелийг эдийн засгийн хүрээнд дэх үзэгдэл болох талаас нь судлан шинжилж, түүний бүрэлдэн бий болох нөхцөл шалтгаан, зүй тогтолуудыг шинжлэх ухааны үндэстэй тайлбарлаж энэхүү үзэгдлийн талаарх барууны гэж хэлж болох түгээмэл ойлголтыг төлөөлдөг гэж үзэж болох юм. Картелийн орчин үеийн онол нь өрсөлдөөний эрх зүйд стандарт эдийн засгийн онол, өрсөлдөөний загвар хууль, олон улсын байгууллагуудын зөвлөмжийн үндэслэл болж байгаа билээ.

IV. ДҮГНЭЛТ

Энэхүү өгүүллийн 2.1 дэх хэсэгтэй холбоотойгоор дүгнэхэд, картелийн сонгодог онолыг түүхэн ач холбогдолтой онол гэж үзэх болсон судлаачидтай санал нийлэхгүй байхын аргагүй юм. Р.Лифманны картелийн сонгодог онол нь картель хэрхэн бий болсон, хөгжиж байгаа тухай эрдэм шинжилгээний үнэ цэнтэй эх зохиол мөн бөгөөд үзэл суртлын шалтгаанаар нэлээд эш татах явдал хязгаарлагдсан бололтой. Ялангуяа картель нь эдийн засгийн хямралын үед аяндаа бий болдог бөгөөд хүнд үеийг даван туулах үр дүнтэй арга мөн гэсэн картелийн сонгодог онолыг шууд үгүйсгэхэд хангалттай үндэслэл байхгүй гэж үзэж болох юм. Магадгүй тиймээс ч хямралын үеийн картель арга хэмжээ, үйлдвэрлэл борлуулалтын квот хуваарилалт гэсэн картель зохицуулалт аж ахуй эрхлэгчдийн дунд бий болдог бололтой.

Өгүүллийн 2.2. дахь хэсэгтэй холбоотойгоор зөвхөн таамаглалыг дэвшүүлсэн бөгөөд картель нь Нацист дэглэмийн төрийн хяналттай үндэсний социалист эдийн засгийн удирдлагад ашиглагдсан нь түүхэн үнэн бөгөөд барууны улс орнууд картелийн талаар сөрөг байр суурьтай байдгийн учир шалтгаан нь энэ үзэгдэл эдийн засгийн гүйцэтгэлийг хурдасгах онцлогтой ба тэрхүү потенциал нь төрийн хяналт үзэл суртлын гарт орж дайны машин болж ашиглагдахаас болгоомжилсноос үүдэлтэй байж болох юм. Р.Лифманны онол, бүтээл яагаад Чикаго их сургуулийн эрх зүй ба эдийн засгийн эрдэмтдийн картелийн орчин үеийн онолчдын бүтээлд эш татагддаггүй тухайд мөн дээрх шалтгаантай болов уу.

Харин өгүүллийн 3.1 дэх хэсэгт картелийн сонгодог онолоос өмнө нь хууль ёсны гэж үздэг байсан аж үйлдвэрийн хамтын ажиллагааг илэрхийлсэн картелийг 1930 оноос 1950 оны хооронд Европ дахинд ямар үзэл санааны хувьсал, үйл явдлын өрнөл, өөрчлөлт болж байж либерал онол, неоклассик улс төрийн эдийн засгийн онолд нийцэхүйц хэмжээнд хуулиар хориглосон үйлдэлд тооцож зохицуулах болсон бэ гэсэн асуултанд хариулахыг зорьсон. Юуны өмнө эдийн засгийн хямралаар өндийсөн нацизм, түүнд хэрэглэгдэж байсан картель арга хэрэгслүүд дайны дараа хүчтэй эсэргүүцэлтэй тулсан талаар энэ хэсэгт авч үзсэн. АНУ-аас Европыг сэргээн босгох төлөвлөгөө гарган хэрэгжүүлсэн талаар авч үзлээ. Энэ үед АНУ-ын засан тохинуулагчид Фрайбургийн сургуулийн эрх зүй ба эдийн засгийн ухааны эрдэмтдийг түшиглэн эрх зүй, эдийн засгийн шинэтгэлийг хэрэгжүүлсэн.

Фрайбургийн ордолиберал үзэлтнүүд дайны дараах баруун Германы сэргээн босголт, эрх зүй, эдийн засгийн шинэчлэлд нийгмийн баримжаат эдийн засгийн бодлого гэсэн дэвшилтэт үзэл санааг дэвшүүлэн чухал үүрэгтэй оролцсоныг дурдсан. Төр өрсөлдөөнд цэцэрлэгчийн үүрэгтэйгээр оролцох, ёс суртахууны үүднээс өрсөлдөөн, картелийг зохицуулах үзэл санааг Ж.Бом хуульч дэвшүүлсэн бөгөөд түүний ахалсан төслийн багаас боловсруулсан 1957 оны “Өрсөлдөөнийг хязгаарлахын эсрэг хууль” (Gesetz gegen Wettbewerbsbeschränkungen)-ийг батлагдахдаа хэд хэдэн тохиолдлыг картель болон өрсөлдөөнийг хязгаарласан гэрээг санкц бүхий хориглолтод хамааруулахгүй байхаар заасныг авч үзсэн.

Дээрх хуулиас манай улсын хувьд ач холбогдолтой гэж үзэж болох сургамж нь Германд 1957 онд батлагдсан “Өрсөлдөөнийг хязгаарлахын эсрэг хууль” (Gesetz gegen Wettbewerbsbeschränkungen) жижиг дунд үйлдвэрийн картель гэрээ, сүлжээ байгуулах замаар томоохон аж үйлдвэрийн пүүсүүдтэй өрсөлдөх боломжийг олгох зэрэг өргөн хүрээний чөлөөлөлтийн нөхцөлүүдийг агуулсан байдал юм. Энэ нь эдийн засгийн хувьд өөрчлөлт шилжилтийн, эсхүл дайн, хямрал зэрэг онцгой нөхцөл байдлаас сэргэх шатанд байгаа улс орны жижиг дунд аж ахуй эрхлэгчид нэгдэж сүлжээ бий болж, хүчирхэг эсхүл гадаадын томоохон пүүстэй өрсөлдөөний тэнцвэртэй нөхцөлд өсөж өндийхөд картелийн эрх зүйн зохицуулалт бага зэрэг зөөлөн алхам хийж болдог туршигдсан түүхэн нэг жишээ гэж үзэж болно. Энэ санааг энэ удаад санал хэлбэрт оруулсангүй. Учир нь тусгайлсан судалгаа зайлшгүй шаардагдлагатай.

Харин 3.2 дахь хэсгийн хувьд Европ дахь картелийн зохицуулалтын дараагийн түүхэн үйл явдлыг хөндөхдөө картель олон улсын шинжтэй байх тохиолдолд түүний зохицуулалт өвөрмөц байдаг талаар бүрэн дүгнэлт болж төгөлдөржөөгүй дараах санаагаа эрдмийн диалогид зориулан хуваалцсан билээ. Үүнд:

Европын Нүүрс ба Гангийн нийгэмлэг нь үндсэндээ бүс нутгийн түүхий эдийн олборлолт, үйлдвэрлэл, нийлүүлэлт, хэрэглээг Засгийн газар хоорондын байгууллагын хяналтанд авах замаар бүс нутгийн аюулгүй байдлыг эдийн засгийн хөшүүргээр ханган уялдуудах олон улсын картель төдийгүй гео-эдийн засгийн алсын хараатай алхам байсан гэж үзэж болох юм. Европын энэхүү хамтын ажиллагаа нь нэг талаас гэрээний болон институцийн хувьд нэг ёсны протекционист (бусдаас өөрийгөө хамгаалах) арга хэрэгсэл шинжтэй, тэрчлэн гишүүн улсууд доторх аж ахуй эрхлэгчдийн хоорондын өрсөлдөөний шударга байдлыг картелийн орчин үеийн онол, олигополийн онолын үүднээс авч үзэж зохицуулах гэсэн зэрэгцээ өөр өөр зорилтууд бүхий парадокс шинжтэй, өрсөлдөөний эрх зүйн зохицуулалтын өвөрмөц загвар, эрх зүйн зохицуулалтын онцгой арга хэрэгсэл ажээ. Эндээс ажиглагдсан зүйл нь картель олон улсын цар хүрээтэй байх үед, эсхүл бүс нутгийн хэмжээнд стратегийн түүхий эдийн олборлолт, боловсруулалт, худалдааны харилцаанд зохицуулалтгүй, хориглолтгүй оршиж байдгийг харуулж байна. Өөрөөр хэлбэл, хилийн гаднах олон улсын эдийн засгийн харилцаанд хэд хэдэн улсын Засгийн газар оролцсон картель байх боломжтой гэдгийг харуулах нэг бэлэн жишээ нь энэ түүхэн үйл явдал гэж үзэж болох юм.

Эцэст нь 3.3 дахь хэсэгт өнөө үед АНУ-ын болон Европын холбооны зүгээс бусад улс орнуудыг өрсөлдөөний хууль тогтоомжоо хөгжүүлэхийг уриалдаг чиглэлийн онолын үндэслэл ямар байгааг тоймлон харуулахыг зорьсон. Картелийн орчин үеийн онол нь өрсөлдөөний эрх зүйд стандарт эдийн засгийн онол, өрсөлдөөний загвар хууль, олон улсын байгууллагуудын зөвлөмжийн үндэслэл болж байна. Мөн дотоод зах зээл дэх картелийн хор уршгийг тайлбарласнаараа картелийн орчин үеийн онол нь улс орнуудын үндэсний эрх зүйн зохицуулалт дахь картелийг хориглох хатуу чиг хандлагыг зөвтгөхүйц онолын хүчтэй үндэслэл болж байдгийг нотолж байна. Ж.Стиглерийн тодорхойлсон картель үүсэх зүй тогтол, картелийн орчин үеийн онол, олигополийн онол нь картелийг тодорхойлох арга зүй чухал үндэс болж картельтай тэмцэх чиг баримжаа болж байна.

ЭХ СУРВАЛЖ

Монгол хэл дээрх:

Ном, өгүүлэл, судалгааны тайлан

1. Адам Смит, Үндэсний Баялаг, Уб., 2018.
2. Б.Амарсанаа, М.Уянга, Г.Давааням нар, Өрсөлдөөний эрх зүйн онол, практик Уб., 2022
3. Л.Отгонбаяр, “Шерманы хуулийн эх сурвалж: Түүхэн тойм, өрсөлдөөний эрх зүйг хөгжүүлэхэд түүний ач холбогдол”, “Хууль дээдлэх ёс” сэтгүүл, цуврал 78, Уб., 2020.

Гадаад хэл дээрх:

Ном, өгүүлэл, судалгааны тайлан

1. A.Ezrachi, Competition and Antitrust law. A Very Short Introduction Oxford University Press, 2021.
2. Anita Pelle, The German Roots of the European Community’s Cartel Regulation, Doctoral dissertation, Hungarian Academy of Sciences, 2010.
3. Fear, J. R, Cartels and competition: Neither markets nor hierarchies. Division of Research, Harvard Business School, 2006.
4. Fox, E. M., Geradin, D., & EU, C. L. Cases, Text, and Context, 2017.
5. G. J. Stigler, ‘A Theory of Oligopoly’, Journal of Political Economy, 1964, reprinted in his The Organization of Industry University of Chicago Press, 1968.
6. H. A. Leonhardt. The Development of Cartel 28 + Theory between 1883 and the 1930s.
7. Jones, A., & Sufrin, E. EC competition law: Text, cases, and materials, 2001.
8. Leonhardt, H. A. The Development of Cartel + Theory between 1883 and the 1930s—from International Diversity to Convergence, 2018.
9. Meunier, S., & McNamara, K. R. Eds. Making history: European integration and institutional change at fifty (Vol. 8). Oxford University Press, USA, 2007.
10. Motta, M. Competition policy: theory and practice. Cambridge University Press, 2004.
11. Nikodym, L. Theoretical aspects of cartelization in Central Europe—An introduction to cartel theory. Central European Papers, 2(1), 2014.
12. Pelle. A, The German roots of the European community’s cartel regulation: from a historical and theoretical perspective. (LAP Lambert Academic Publishing, 2011.
13. Quack, S., & Djelic, M. L. Reinforcement: The Story of Antitrust and Competition Law in Germany and Europe.
14. Beyond Continuity: Institutional Change in Advanced Political Economies, 2005.
15. Robert Liefmann, Cartels, Concerns and Trusts (1932, first edition), Batoche Books Kitchener, 2001.
16. Stocking G.W. and M.W. Watkins Cartels or Competition? The Economics of International Controls by Business and Government, New York: The Twentieth Century Fund, 1948.
17. Whish, R., & Bailey, D. Competition law. Oxford University Press, 2021.

Цахим эх сурвалж

1. <https://www.britannica.com/topic/Nazi-Party>.
2. <https://www.europarl.europa.eu/about-parliament/en/in-the-past/the-parliament-and-the-treaties/treaty-of-rome>.

**SOME REFLECTIONS ON RELATIONSHIP BETWEEN HISTORICAL EVENTS
AND THEORETICAL EVOLUTION OF EUROPEAN COMMUNITY'S CARTEL LAW**

Otgonbayar Lkh

*Senior lecturer, Department of Legal Studies,
University of Finance and Economics,
Ph.D. student, School of Law, NUM*

ABSTRACT:

This article aims to examine how the cartel phenomenon affected the reconstruction, economic transition, and development stages of Europe before and after World War II, as well as how this concept has evolved.

KEYWORDS:

European community, cartel law, cartel, competition law, classic cartel theory, modern cartel theory.

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТОГТОЛЦООНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АСУУДАЛД



Т.Заяа

ХУИС-ОУХНС-ийн тэнхимийн багш

ТОВЧЛОЛ:

Гадаад бодлого, үндэсний аюулгүй байдал (ҮАБ) нь нягт холбоотой ойлголтууд юм. Монгол Улсын (МУ) аюулгүй байдал, үндэсний язгуур ашиг сонирхлыг олон улсын эрх зүйн хүрээнд улс төр-дипломатын аргаар хангах нь гадаад бодлогын тэргүүлэх зорилт мөн хэмээн 2011 оны Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалд заажээ. Энэхүү зорилтын хэрэгжилтийг хангахад эрх зүйн орчин хангалттай бүрдсэн байх нь зүй ёсны асуудал юм. Гадаад бодлого, үндэсний аюулгүй байдлын талаарх судалгаануудыг гол төлөв улс төр, олон улсын харилцааны өнцгөөс ажиглан хийх нь олонтоо юм. Хуульч, эрх зүйч нарын дунд бага судлагдсан ба эрх зүйн орчны судалгаа, дүн шинжилгээ хомс байдаг.

Энэхүү судалгаанд “нийгмийн нэгж системийн арга”-ыг ашигласан ба Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын эрх зүйн дотоод орчны судалгаа, шинжилгээний үр дүнг хувь хэмжээ, тоон үзүүлэлтээр гаргахыг зорьсон юм. Ингэхдээ Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (2010), Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийг(2001) судалгааны үндсэн объект болгосон болно.

Судалгааны үр дүнгийн тухайд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тогтолцоонд системийн шинжилгээ хийснээр уг тогтолцоо нь эрсдэлийг хэсэгчлэн эсэргүүцэх чадвартай системийн ангилалд хамаарч аливаа нийгмийн нэгж тогтолцооны бүрдүүлбэл зохих 5 дэд тогтолцооны 40 хэв шинжээс 26 хэв шинжийг бүрдүүлж нийтдээ 65 хувийн гүйцэтгэлтэй байгааг тодорхойлсон болно.

Судалгааны арга: Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд шинжилгээ хийхдээ “нийгмийн нэгж системийн аргачлал”-ыг ашигласан болно¹.

Түүнчлэн, Үндэсний аюулгүй байдлын тогтолцоонд Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн гүйцэтгэх үүрэг, ач холбогдол, түүний чадавхыг улс төрийн засаглалын хувьд адил улсуудтай харьцуулан авч үзэж, эрх зүйн байдлыг сайжруулах асуудлыг хөндсөн болно.

¹ ЗСДС-аас боловсруулсан системийн шинжилгээ хийх аргачлалыг тус байгууллагын зөвшөөрлөөр ашигласан болно.

ТҮЛХҮҮР ҮГС:

Эрх зүйн дотоод орчин, нийгмийн нэгж системийн аргачлал, системийн шинжилгээ, үндэсний аюулгүй байдал, Үндэсний аюулгүй байдлын Зөвлөл

УДИРТГАЛ

Аливаа улсын гадаад бодлогын үндсэн зорилго нь үндэсний эрх ашгаа хамгаалах асуудал байдаг. Ингэхдээ тус эрх ашгийг хангах тал дээр явуулж буй бодлого нь өөр өөрийн гэсэн онцлогтой. Тухайлбал, их гүрнүүдийн хувьд хатуу хүчний бодлого буюу олон улсын харилцааны үндсэн онол болох “улс төрийн реализмын онол” (Х.Моргентау, 1948), харин зөөлөн хүчний бодлого нь (Ж.Най, 1990) нь идеализм, либерализмын онолуудаар тус тус тайлбарлагддаг.

Улс гүрнүүдийн хувьд үндэсний аюулгүй байдлын баталгаа, аюулгүй байдлаа хангасан эсэхийг тодорхойлох асуудлаар нэгдсэн жишиг, загвар гэсэн ойлголт байдаггүй. Учир нь улс бүрийн үндэсний ашиг сонирхол харилцан адилгүй байдаг.

Сэдвийн судлагдсан байдлын тухайд К.Волдмакер, М.Петков гэсэн гадны судлаачдын бүтээлүүд байдаг. Волдмакерын хувьд үндэсний аюулгүй байдлын тогтолцооны зохион байгуулалт, түүний хөгжлийн чиглэлийг тодорхойлох болон орчин үеийн аюулгүй байдлын нөхцөлд хамгийн их нийцсэн загварын талаар өөрийн “Үндэсний Аюулгүй байдлын тогтолцооны жишиг загвар” бүтээлдээ дурдсан байдаг (Waldemar Kitler, 2021). Перковын хувьд «аюулгүй байдал» гэх парадигм нь постмодерн нийгэмд яагаад ийм чухал болсон, түүний нөлөөлөл, утга учир юунд оршдог вэ гэсэн асуултад хариулж, түүнийг нэмэгдүүлэхэд тогтолцооны загвар ямар байх ёстой гэх асуултад хариу өгөхийг оролдсон байдаг (Petkov, 2018). Гэвч аль аль судлаачийн хувьд эрх зүйн зохицуулалтын асуудлыг хангалттай авч үзээгүй бөгөөд өнөөгийн өөрчлөгдөж буй дэлхийн бодлогод аливаа улсын аюулгүй байдал, үндэсний эрх ашиг нийцсэн байх ёстой саналуудыг дэвшүүлсэн байдаг. Манайд улсад тус сэдвээр гол төлөв улс төр, олон улсын харилцааны судлаачид, дипломагуудын бүтээлүүд зонхилдог. Тухайлбал, Г.Төмөрчулуун, Ж.Энхсайхан, Р.Болд, Д.Уламбаяр нарын бүтээлүүдийг дурдаж болох байна. Гэвч Үндэсний аюулгүй байдлыг тогтолцооны эрх зүйн зохицуулалтын хувьд авч үзээгүй ба гол төлөв цөмийн зэвсгийн асуудал, хүний аюулгүй байдал, аюулгүй байдлын тулгамдсан асуудал зэрэг тогтолцооны нэгээхэн асуудлыг хөндсөн байна.

Иймд Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын тогтолцооны жишиг загвар боловсруулах, эрх зүйн орчныг бүхэлд нь хэрхэн сайжруулах талын судалгаа дутмаг учир энэхүү судалгааг хийхийг зорьсон болно.

МУ-ын Үндэсний аюулгүй байдлын өнөөгийн тогтолцоо бүрэлдэн бий болоход МУ дахь 1990-ээд оны улс төрийн тогтолцооны өөрчлөлт шинэчлэл чухал үүргийг гүйцэтгэсэн. Үүний тод илрэл нь 1992 онд анхны ардчилсан Үндсэн хууль, 1994 онд Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 2001 онд Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн тухай хуулиуд батлагдан гарсан явдал юм.

2010 онд улмаар Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг өөрчлөн шинэчилсэн байдаг. Энэхүү баримт бичиг нь МУ-ын Үндэсний аюулгүй байдлын эрх зүйн орчинг бүрдүүлж буй гол бодлогын баримт бичиг юм. 1994 оны үзэл баримтлалд тусгагдсан “үндэсний аюулгүй байдал, язгуур эрх ашгийг хангах, хамгаалах зорилгоор Үндэсний аюулгүй байдлын тухай (2001), Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн тухай (1992) тухай хуулиудыг баталж байсан түүхтэй. Гэвч 2010 онд Үндэсний аюулгүй байдлын тухай шинэ үзэл баримтлал батлагдсан ч дагалдах хуулиудаа УИХ шинэчлэн батлаагүй байдаг.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн эрх зүйн байдлыг 1992 онд батлагдсан ҮАБЗ-ийн тухай хуулиар тодорхойлсон байдаг. Тус байгууллагын бүтэц бүрэлдэхүүн, бүрэн эрхийг МУ-ын УИХ тодорхойлдог бөгөөд МУ-ын Ерөнхийлөгч тэргүүлдэг (МУ-ын Үндсэн хууль, 1992).

Гэвч сүүлийн жилүүдэд МУ-ын эдийн засгийн аюулгүй байдал алдагдаж, нэг улсаас хамааралтай болсон, хуулийн дагуу олгогдсон эрх мэдэл алдагдсан, хариуцлагын тогтолцоо хэрэгждэггүй, улс төрийн намуудын оролцоо их, дурын байгууллага, албан тушаалтан дур зоргоороо шийдвэр гаргадаг, иргэний нийгмийн оролцоо сул, аюулгүй байдлын эрх ашиг орхигдсон, аюулгүй байдал, гадаад бодлогоо нэгдмэл байлгаж чадахгүй байгаа, гадаад харилцааны яам (ГХЯ)-ны эрх мэдэл хумигдаж бодлогын нэгдсэн байдалд оролцох байдлыг орхигдуулсан, бодлогын баримт бичгүүд болох Үндэсний аюулгүй байдлын болон Гадаад бодлогын үзэл баримтлалд нийцэж байгаа эсэхийг нягтлахгүй байгаа, хүний нөөцийн чадавх сул, төрийн байгууллагууд хоорондын уялдаа сул байгаа нь тухайлбал, байгууллага хоорондын ажлын уялдааг хангаж ажиллахыг захирамжилсан акт хэрэгждэггүй, ҮАБЗ-ийн шийдвэр зөвлөмжийн шинжтэй, гадаад харилцааны сайдын захирамжилсан тушаал нийт гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд сул байгаа зэрэгтэй холбоотой юм.

Судалгааны аргачлал

Системийн загвар нь аливаа системийн төлөв байдал, түүний үйл ажиллагааны гүйцэтгэл болон үр дүнг тоон утгаар хэмжих шинжилгээ, оношилгооны аргачлал юм (Зураг 1-ийг үзнэ үү.) Тус аргаар Монгол Улсын Үндсэн хууль, Инновацийн тухай, Хөдөлмөрийн тухай зэрэг хуулиудад шинжилгээ хийгдэж, туршигдаж, олон нийтийн дунд удаа дараа хэлэлцүүлэгдсэн юм (“Үндсэн хуулийн үзэл баримтлалыг системийн загвараар шинжилж, дүрслэх нь” судалгааны тайлан. ЗСДС. УБ.2019, “Гарааны бизнесийг дэмждэг экосистемийн жишиг загвар боловсруулах нь” судалгааны ажлын тайлан. ЗСДС. УБ.2021.



Зураг 1. Нийгмийн нэгж системийн логик дүрслэл.

Хууль, эрх зүйн баримт бичгүүдээс тус харилцааг шууд зохицуулж буй Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн тухай хуульд системийн шинжилгээ хийхдээ Тохируулгатай Угсардаг Системийн /ТУС/ загварын дагуу хэвийн үйл ажиллагаатай нийгмийн нэгж системийн завал бүрдүүлэх суурь 40 хэв шинжийг жишиг загвар болгон сонгосон. Үүний дараа хэвийн үйл ажиллагаатай системийн 40 хэв шинжийг хангах шийдлийг хуульд тусгасан эсэхийг үнэлсэн. Үнэлгээ өгөхдөө хэв шинжийг хангах шийдлийг хуульд тусгасан бол 2 оноо, тусгаагүй бол 1 оноо өгч, эцэст нь нийлбэр дүнг тодорхойлох замаар системийг төлөв байдлыг тодорхойлсон (Зураг 2-г үз).



Зураг 2. Системийн шинжилгээний аргачлал

Аргачлалын харьцуулалт



Зураг 3. Уламжлалт болон системийн (инженерчлэлийн) аргачлалын харьцуулалт

1. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын өнөөгийн тогтолцоо, эрх зүйн орчин

1.1 Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын тогтолцоо

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын өнөөгийн тогтолцоо бүрэлдэн бий болоход МУ дахь 1990-ээд оны улс төрийн тогтолцооны өөрчлөлт шинэчлэл чухал үүргийг гүйцэтгэсэн. Үүний тод илрэл нь 1992 онд анхны ардчилсан Үндсэн хууль, 1994 онд Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 2001 онд Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн тухай хуулиуд батлагдан гарсан байдаг.

Улмаар 2010 онд Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг өөрчлөн шинэчилсэн байдаг. Энэхүү баримт бичиг нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын эрх зүйн орчинг бүрдүүлж буй гол бодлогын баримт бичиг юм. 1994 оны үзэл баримтлалд тусгагдсан “үндэсний аюулгүй байдал, язгуур эрх ашгийг хангах, хамгаалах зорилгоор Үндэсний аюулгүй байдлын тухай (2001), Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн тухай (1992) тухай хуулиудыг баталж байсан түүхтэй. Гэвч 2010 онд Үндэсний аюулгүй байдлын тухай шинэ

үзэл баримтлал батлагдсан ч дагалдах хуулиудаа УИХ шинэчлэн батлаагүй байдаг.


Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын өнөөгийн тогтолцооны зорилго нь:

- Оршин тогтнохуйн үндэс болох тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хил хязгаар, нутаг дэвсгэрийн халдашгүй бүрэн бүтэн байдал, хүн ам, удмын сангийн аюулгүй байдал, соёл иргэншлийн аюулгүй байдал,

- Эдийн засгийн аюулгүй байдал, эдийн засгийн олон тулгуурт бүтэц, хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого явуулахад оршиж байна (Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 2010).

1.2 Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тогтолцооны оролцогч талууд

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын тогтолцооны оролцогч талуудыг салбарын гол эрх зүйн баримт бичгүүд болох Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн тухай хууль зэргээс авч үзвэл үндсэн болон туслах чиг үүрэг бүхий дараах оролцогч талууд байна (Зураг 4-г үзнэ үү).



Зураг 4. МУ-ын Үндэсний аюулгүй байдлын тогтолцооны оролцогч талууд (эх сурвалж: хууль, эрх зүйн баримт бичгүүдэд тусгагдсан байдлаар)

Дээрхээс үзвэл МУ-ын Үндэсний аюулгүй байдлыг хангах тал дээр гол оролцогч тал болох МУ-ын Ерөнхийлөгч, МУ-ын УИХ, МУ-ын ЗГ, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл (ҮАБЗ), орон нутгийн өөрөө удирдах байгууллага, үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй төрийн бусад байгууллагууд багтсан байна. Харин тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудад Байгаль орчныг хамгаалах алба, гаалийн алба, дипломат алба, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн хяналтын алба, зэвсэгт хүчин, цэрэг, татварын алба, тусгай алба, иргэдийн харьяалал, шилжилт хөдөлгөөний асуудал эрхлэх алба, иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн асуудал эрхлэх алба зэрэг хамаардаг байна. Эдгээр байгууллагууд нь хуулиар олгогдсон чиг үүргийнхээ дагуу МУ-ын үндэсний аюулгүй байдлыг хангах тал дээр тус тусын үүргийг хүлээсэн байдаг байна (Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 2010; Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, 2001; Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн тухай, 1992).

1.3 МУ-ын Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн эрх зүйн байдал

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн эрх зүйн байдлыг 1992 онд батлагдсан ҮАБЗ-ийн тухай хуулиар тодорхойлсон байдаг. Тус байгууллагын бүтэц бүрэлдэхүүн, бүрэн эрхийг МУ-ын УИХ тодорхойлдог бөгөөд МУ-ын Ерөнхийлөгч тэргүүлдэг (МУ-ын Үндсэн хууль, 1992) тухай өмнө өгүүлсэн билээ (Зураг 5-г үз).



Зураг 5. ҮАБЗ-ийн өнөөгийн бүтэц

МУ-ын хувьд 1992 оны 5 дугаар сарын 29-нд Улсын Бага Хурал МУ-ын Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн тухай хуулийг баталж Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийг байгуулсан. Зөвлөлийн анхдугаар хуралдаан 1992 оны 8 дугаар сарын 8-нд болж, түүгээр Зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилох тухай, Зөвлөлийн ажлын дотоод журам болон Зөвлөлийг мэдээллээр хангах журмын төсөл зэрэг асуудлыг хэлэлцэн баталсан байдаг (ҮАБЗ-ийн тухай, 2018). Улмаар 2001 оны 12-р сарын 27-ны өдөр МУ-ын УИХ-аас Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийг баталж, уг хуулийн 17.1-т “Үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн бодлого, үйл ажиллагааг төрийн нэгдмэл бодлогод нийцүүлэн уялдуулан зохицуулах чиг үүргийг Зөвлөл хэрэгжүүлэх” гэсэн заалт оруулж өгчээ (Үндэсний аюулгүй байдлын тухай, 2001). Ингэснээр ҮАБЗ аюулгүй байдлын нэгдмэл бодлогод хяналт тавих асуудлаар зохих хэмжээний эрх мэдэлтэй болсон байдаг.

ҮАБЗ-ийн талаарх бусад төрийн байгууллагуудын ойлголт, үнэлэмж бага, гадаад бодлого ба аюулгүй байдлын асуудлаар шийдвэр гаргахад нөлөөлөх эрх зүйн зохицуулалт сул, Зөвлөлийн нарийн бичгийн дарга нарын (НБД) мэргэжил, боловсрол, үүрэг гүйцэтгэх хугацаа, нэр хүнд харилцан адилгүй байдаг (ҮАБЗ байгуулагдсан цагаас хойш томилогдон ажиллаж байсан НБД нарын дотор гадаад бодлого, аюулгүй байдлын талаар мэргэшсэн энэ талын ажлын туршлага хуримтлуулсан мэргэжлийн хүмүүс байсан бол сүүлийн жилүүдэд энэ албан тушаалд мэргэжлийн бус, бизнесмен, эдийн засгийн бүлэглэлүүдтэй ямар нэгэн байдлаар нэр холбогдсон, тодорхой ашиг сонирхлын зөрчилтэй, иймээс олон нийтийн дунд нэр хүнд муу этгээдийг Ерөнхийлөгч өөрийн эрх мэдлийн хүрээнд намын харьяалал болон бусад шалтгаанаар томилдог болсон нь нууц биш) зэргээс үүдэн МУ-ын аюулгүй байдалтай холбоотой гадаад бодлогын шийдвэр гаргалтын нэгдмэл байдал, залгамж чанар алдагдаж буй юм.


“МУ-ын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “МУ-ын Үндэсний аюулгүй байдлын тухай хууль”, “МУ-ын Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийг мэдээллээр хангах

журам” зэргээс харахад өнөөдөр аюулгүй байдал, гадаад бодлоготой холбоотой чухал шийдвэрийг Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрлэх журам тогтсон (практик дээр хэрэгжиж байгаа эсэх нь эргэлзээтэй). ГХЯ МУ-ын гадаад харилцааны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, гадаад бодлогыг хэрэгжүүлэх эрхээр хангагдсан хэдий ч ЗГ-ын бусад салбарын яамд өөр өөрсдийн чиглэлийн гадаад харилцааг явуулдаг жишиг тогтсон (Мягмардорж, 2019). Ерөнхийлөгчийн гадаад харилцаанд гаргаж буй шийдвэрийг Ерөнхийлөгчийн Тамгын газар тухайлбал, Ерөнхийлөгчийн гадаад бодлого, аюулгүй байдлын зөвлөх боловсруулдаг болсон бол орон нутгийн засаг захиргааны нэгжүүд гадаад харилцааны асуудлаар бие даасан шийдвэр гаргах байдал түгээмэл болоод байна. Шат шатны төрийн байгууллагууд гадаад бодлогын асуудлаар бие даасан шийдвэр гаргах болсон нь гадаад бодлогын нэгдмэл байдал, залгамж чанар алдагдахад хүрч, улмаар МУ-ын гадаад бодлого, үндэсний аюулгүй байдал ноцтой байдалд орох нөхцөл байдал үүсээд буй юм.

Гадаад харилцааны яам (ГХЯ) нь гадаад харилцааны асуудлаар гарч буй шийдвэрүүдийг уялдуулан зохицуулах, нэгдмэл байдал, залгамж чанарт хяналт тавих зохих ёсны үүргээ гүйцэтгэх боломжоор хомс болсон. Харин Үндэсний аюулгүй байдлын Зөвлөл нь үндэсний аюулгүй байдалтай холбоотой аливаа улс төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэх буй яам, агентлагийн үйл ажиллагаанд хяналт тавих үндсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон.

МУ-ын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд үндэсний аюулгүй байдлыг боловсронгуй болгох зорилтын хүрээнд 4.1.3-т “Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж, ажил үүргийн давхцал, хийдлийг арилгаж, харилцан зохицуулалт хийх механизмыг боловсронгуй болгох болгоно” (МУ-ын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 2010) хэмээн заасан байдаг хэдий ч УИХ, ЗГ, хүчний байгууллагууд, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн эрх үүргийг хязгаарлах явдал байсаар байна (Зураг 6-г үз).

Тавантолгой төсөл, Төмөр замын бодлого боловсрогдох явц



Зураг 6. Тавантолгой болон Төмөр замын асуудлаар шийдвэр гаргах процесс (эх сурвалж: УИХ-ын гадаад бодлого, үндэсний аюулгүй байдлын байнгын хорооноос хийсэн хайгуул судалгааны материал).

Дээрхээс үзэхэд, МУ-ын гадаад бодлого, үндэсний аюулгүй байдлын асуудлаар гарах шийдвэрт ҮАБЗ-ийн оролцоо сул байгааг стратегийн ач холбогдол бүхий хоёр жишээн дээр харуулсан байна.

1.4 Үндэсний аюулгүй байдлыг хадгалах чиг үүрэг бүхий бусад улс дахь байгууллагууд

Дэлхий нийтийн жишгийг харахад гадаад харилцааны асуудлаар өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн явуулдаг байгууллага нь гадаад харилцаа, дипломат албаны төрийн байгууллага болох ГХЯ байдаг бол үндэсний аюулгүй байдалтай холбоотой чухал асуудлаар гадаад бодлогын нэгдмэл шийдвэр гаргах, түүний хэрэгжилтэд хяналт тавих үүрэг гүйцэтгэдэг төрийн үндсэн механизм нь Үндэсний аюулгүй байдлын Зөвлөл/хороод байдаг аж.

Олон улсын жишгээс харахад төрийн тогтолцоо, засаглалын хэлбэрээр нь авч үзвэл парламентын засаглалтай улс орнуудад Үндэсний аюулгүй байдлын Зөвлөл нь Засгийн газрын бүтцэд хамаарч байгаа ба байнгын бүтэц бүрэлдэхүүнд нь чиглэлийн яамдуудын сайд нар тухайлбал, үндэсний аюулгүй байдалд шууд хамаарах дараах чиглэлийн яамдын сайд нар багтсан байна. Үүнд:

- Гадаад харилцааны сайд
- Хууль зүй, дотоод хэргийн сайд
- Батлан хамгаалахын сайд
- Сангийн сайд
- Хөгжлийн бодлого хариуцсан сайд
- Байгаль орчны сайд г.м

Мөн түүнчлэн Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нэршил нь зөвлөлөөс гадна газар, хороо гэх мэт нэршилтэй байна. Бүрэлдэхүүний хувьд дунджаар 8-9 хүнтэй байх ба Ерөнхий сайд тус байгууллагыг тэргүүлдэг жишиг байдаг байна (Хавсралт 1-г үз).

МУ-ын хувьд ҮАБЗ-ийг Ерөнхийлөгч тэргүүлдэг ба тус байгууллагын бүрэлдэхүүнийг УИХ-аас томилдог (МУ-ын Үндсэн хууль, 1992). Бүрэлдэхүүнд ерөнхийлөгчөөс гадна Ерөнхий сайд, УИХ-ын дарга нар багтдаг. Энэ нь нэг талаар, улсын аюулгүй байдлын асуудлаар төрийн гурван өндөрлөгийн эрх мэдлийг тэгш байдлаар хуваарилаж буй хэрэг боловч нөгөө талаар хууль тогтоох байгууллагын тэргүүнд илүү эрх мэдлийг төвлөрүүлж буй хэрэг юм. УИХ нь Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд улсын дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлдог (Үндсэн хууль, 1992).

Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийг ерөнхийлөгч тэргүүлэх нь илүүтэйгээр ерөнхийлөгчийн засаглалтай улс орнуудад түгээмэл байдаг практик юм. Үндсэн хуулийн дагуу МУ бол Ерөнхийлөгчийн бус харин парламентын (Үндсэн хууль, 1992) засаглалтай улс юм. Ерөнхийлөгчийн засаглалтай улс орнуудад ҮАБЗ-ийг нь ерөнхийлөгч тэргүүлэх нь зүй ёсны хэрэг билээ.

2. МУ-ын Үндэсний аюулгүй байдлын эрх зүйн орчны судалгаа, шинжилгээ

Үндэсний аюулгүй байдлын эрх зүйн орчин нь гадаад болон дотоод эрх зүйн орчноос бүрдэнэ. Гадаад эрх зүйн орчин нь МУ-ын нэгдэн орсон үндэсний аюулгүй байдлыг хангах тал дээр бусад улстай байгуулсан олон улсын гэрээнүүдээс бүрдэх ба дотоод эрх зүйн орчин нь МУ-д хүчин төгөлдөр үйлчилж буй бодлогын баримт бичгүүд (тухайлбал, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 2010) хууль тогтоомж (Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, 2001), (Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн тухай, 1992) бусад эрх зүйн актуудаас бүрдэнэ.

Үндэсний аюулгүй байдлыг хангах тал дээр Монгол Улсад 40 гаруй бие даасан хууль хүчин төгөлдөр үйлчилж байгаагаас 70 гаруй хувь нь хувь хүн, МУ-ын иргэний, аж ахуйн нэгж, байгууллагын аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн хууль тогтоомжууд байна. Тухайлбал, хүнсний бүтээгдэхүүний, хөдөлмөрийн, замын хөдөлгөөний, гамшгаас хамгаалах, хувь хүний мэдээллийг хамгаалах г.м

Үлдсэн 30 гаруй хувь нь МУ-ын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал, улс төр, цэрэг зэвсэг, энхийг дэмжих ажиллагааны талаар, дайны байдлын асуудлыг тус тус зохицуулсан байна.

Энэ нь иргэний аюулгүй байдлыг хангах тал дээрх эрх зүйн зохицуулалт илүүтэйгээр зонхилж буйг харуулж байна. Энэ нь буруу зүйл бус бөгөөд Үндэсний (улсын) аюулгүй байдлын цаана иргэний аюулгүй байдлыг ойлгоно. Иргэний аюулгүй байдлыг хангана гэдэг нь түүний үндсэн эрх, эрх чөлөөний хэрэгжилттэй холбогддог.

2.1 Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, түүнд хийсэн системийн шинжилгээ, түүний үр дүн

ҮАБ-ын тогтолцоо нь системийн аргачлалын дагуу аливаа тогтолцоонд бүрдүүлбэл зохих 5 дэд тогтолцооны 40 хэв шинжийг зайлшгүй хангасан байх ёстой юм.

МУ-ын ҮАБ-ын тогтолцоо дахь 1-зорилгын дэд тогтолцоо нь бүрдүүлбэл зохих 14 хэв шинжээс 12 бүрдүүлж 85.7 хувь, 2-үүргийн дэд тогтолцооны 22 хэв шинжээс 11 бүрдүүлж 50 хувь, 3-мэдээллийн дэд тогтолцооны 20 хэв шинжээс 13-г бүрдүүлж 65 хувь, 4-эргэх холбооны дэд тогтолцооны 12 хэв шинжээс 10-г буюу 83.3 хувь, 5-хэмжүүр үзүүлэлтийн дэд тогтолцооны бүрдүүлбэл зохих 12 хэв шинжээс 6 буюу 50 хувийг тус тус эзэлсэн байна (Зураг 4-г үз).

Нийт үр дүн: МУ-ын Үндэсний аюулгүй байдлын тогтолцоо нь нийгмийн нэгж системийн бүрдүүлбэл зохих 5 дэд тогтолцооны 40 хэв шинжээс 26 бүрдүүлж нийт 65 хувийн үнэлгээтэй гарсан байна (Зураг 2-г үз). Энэ нь эрсдэлийг хэсэгчлэн эсэргүүцэх чадвартай тогтолцооны ангилалд хамаарч байна (Зураг 4-г үз). Аливаа нийгмийн нэгж системийн үзүүлэлт 50 хувиас дээш үзүүлэлттэй байх ёстой бөгөөд ингэснээр хэвийн ажиллагаатай тогтолцоо хэмээн үзэж болох юм.


ҮАБ-ын тогтолцоо нь эрсдэлийг хэсэгчлэн эсэргүүцэх чадвартай байхад нөлөөлж буй гол хүчин зүйл нь талуудын хүлээх үүрэг тодорхой бус, хүлээх хариуцлагыг нарийвчлан тусгаагүй байгаатай холбогдож байна. Албан тушаалтан, байгууллагууд хоорондын харилцан холбоо тодорхой бус, мэдээлэл, холбоо, мэдээллийн хүлээн авч буцаж илтгэх механизм дутуу, мэдээллийн сан хэрхэн бүрдэх, хүлээх хариуцлага, хариуцлагын хэлбэр тодорхой бус, хэрэгжилтийн хангах механизм тодорхой бус байгааг харуулж байна.

Үндэсний аюулгүй байдлын тогтолцоо нь хэвтээ бус босоо тогтолцоо байх шаардлагатай. Одоо буй тогтолцоонд хуулийн шинжилгээ хийж үзэхэд тус чиглэл доороосоо дээшээ бус дээрээсээ доошоо чиглэлтэй байгааг харуулж байна.

№	Дэд тогтолцоонууд	Хэв шинж	Гүйцэтгэлийн оноо	Гүйцэтгэлийн хувь	Системийн төлөв байдлын үнэлгээ
1.	Зорилгын дэд тогтолцоо	14	12	85.7%	Эрсдэлийг бүрэн эсэргүүцэх чадвартай систем
2.	Үүргийн дэд тогтолцоо	22	11	50%	Эрсдэлийг эсэргүүцэх чадваргүй систем
3.	Мэдээллийн дэд тогтолцоо	20	13	65%	Эрсдэлийг хэсэгчлэн эсэргүүцэх чадвартай систем
4.	Эргэх холбооны дэд тогтолцоо	12	10	83.3%	Эрсдэлийг бүрэн эсэргүүцэх чадвартай систем
5.	Хэмжүүр үзүүлэлтийн дэд тогтолцоо	12	6	50%	Эрсдэлийг эсэргүүцэх чадваргүй систем
	Нийт:	80	52	65%	Эрсдэлийг хэсэгчлэн эсэргүүцэх чадвартай систем

Зураг 7. Хуулийн шинжилгээний үр дүн (эх сурвалж: судлаачийн өөрийн судалгааны үр дүн)

Хэвийн ажиллагаатай нийгмийн нэгж тогтолцоо болон МУ-ын аюулгүй байдлын эрх зүйн тогтолцооны логик дүрслэлийг харьцуулсан байдлаар доорх зурагт харуулсан байна (Зураг 8-г үз).



Зураг 8. Нийгмийн нэгж тогтолцоо болон МУ-ын Үндэсний аюулгүй байдлын эрх зүйн тогтолцооны системийн логик дүрслэл

ДҮГНЭЛТ

ҮАБ-ын өнөөгийн тогтолцооны хувьд төрөөс хувь хүний аюулгүй байдлыг хангахад илүүтэйгээр чиглэгдсэн байна. Хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг, оролцоо үндэсний хэмжээний асуудалд чухал байр суурь эзлэх нь зохистой.

Хууль, эрх зүйн орчны хувьд Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (2010) онд батлагдсан ч бусад хуулийг шинэчлээгүй байна. Тухайлбал, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийг (2001), Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн тухай хуулийг (1992) зэргийг шинэчлэх нь зүйтэй.

Системийн шинжилгээний үр дүнг: сайжруулах тал дээр арга хэмжээ авах. Тухайлбал, оролцогчдын үүрэг, хариуцлагыг нарийвчлан тодорхойлох, оролцогч талуудын хооронд мэдээллийн урсгалыг тодорхой болгох,

Үндэсний аюулгүй байдлын тогтолцоог нэг бүхэл систем гэдгээр авч үзэх нь зүйтэй ба тус тогтолцоо дахь дэд тогтолцоонуудын хэвийн ажиллагаа, тэнцвэрийг хангах, эрх зүйн баримт бичгүүд хоорондын уялдаа, талуудын эрх үүргийн нийцэл зэрэг нь тодорхой бусаар зохицуулагдсан байна.

МУ-ын аюулгүй байдлын эрх зүйн орчин нь салбар тус бүрийн аюулгүй байдлыг хамгаалах асуудлаар гадаад харилцааны бодлого салангид байгаа нь аюулгүй байдлын асуудал нэгдмэл бус тус тусдаа байгаад хүргэж, үндэсний эрх ашиг зөрчигдөхөд хүргэх магадлалтай.

Аюулгүй байдлын өнөөгийн тогтолцоонд аюулгүй байдлыг бүхэлд нь хэмжих үндсэн хэмжүүр үзүүлэлт байхгүй байна. Ийм учир аль нэг салбар, дэд тогтолцооны хэвийн ажиллагаа алдагдахад хүргэж байна.

МУ-ын гадаад бодлогын нэгдмэл байдал, залгамж чанарыг хангахад Засгийн газрын бүтцийн байгууллагуудын хамтын ажиллагаа чухал юм. Иймд нийгмийн салбар тус

бүрийн гадаад хамтын ажиллагаа, үндэсний аюулгүй байдлыг хангахад Үндэсний аюулгүй байдлын Зөвлөл чухал үүрэгтэй оролцох шаардлагатай. Харамсалтай нь, манай улсын хувьд тус байгууллагын гадаад бодлогын шийдвэр гаргалтад оролцох оролцоо бага, эрх хэмжээ хангалтгүй, чадавх сул байгаа зэрэг олон асуудал байна. Түүнчлэн, тус байгууллага нь хуулиар олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд зөвлөмж (энэ нь дагаж биелүүлбэл зохих хатуу хэм хэмжээ бус юм) боловсруулдаг зэрэг чадавхыг бууруулж байгаа хүчин зүйлсүүд байна. Иймд дээрх байгууллагын чадавхыг нэмэгдүүлэхийн тулд хууль, эрх зүйн орчинг САЙЖРУУЛАХ шаардлагатай байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. МУ-ын Үндэсний аюулгүй байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэх Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн (ҮАБЗ) чиг үүргийг нарийвчлан тогтоох, ҮАБЗ-ийн тухай хуулийг шинэчлэх нь зүйтэй юм. Парламентын засаглалтай улсуудад Аюулгүй байдлын Зөвлөлийг ерөнхийлөгч бус ерөнхий сайд тэргүүлдэг жишиг байдаг. Иймд тус асуудлыг цаашид нарийвчлан судлах нь зүйтэй юм.

2. МУ-ын Үндэсний аюулгүй байдлын тогтолцооны оролцогч талуудын үүргийн гүйцэтгэлийг хэрхэн хангах, хэрхэн хэмжих талын зохицуулалтыг бий болгох. Эрх зүйн баримт бичгүүдийн хувьд байгууллага хоорондын хамтын ажиллагаа, үйл ажиллагааны уялдаа, нэгдмэл байдлыг хангах талын эрх зүйн зохицуулалтыг нарийвчлах.

3. ҮАБЗ-ийн чадавхыг нэмэгдүүлэх, ингэхдээ хийгдэх чухал шинэчлэлт нь тус байгууллагын бүтэц бүрэлдэхүүнийг шинэчлэх, чухал салбарын сайдуудыг бүрэлдэхүүнд оруулах, Үндэсний аюулгүй байдалтай шууд хамаарах гадаад бодлогын нэгдмэл байдал, залгамж чанарыг хадгалах асуудлаар бодлого боловсруулах, түүний хэрэгжилтэд хяналт тавих, улмаар зөрчигдсөн тохиолдолд хатуу хариуцлага тооцох чиг үүрэг бүхий механизмыг шинээр бүрдүүлсэн эрх зүйн зохицуулалтыг бий болгох (үүнийг одоо байгаа ҮАБЗ-ийн бүтцийг шинэчлэн сайжруулах замаар хийх, ҮАБ-ын тухай хуулийг шинэчлэх, зөвлөлийн бүрэлдэхүүний чиг үүргийг боловсронгуй болгох, гарах шийдвэрийг нийтээр дагаж мөрдөх хатуу хэмжээний шинжтэй болгох) шаардлагатай байна. Тухайлбал, МУ-ын Үндсэн хуулиар олгогдсон ерөнхийлөгчийн ҮАБЗ-г тэргүүлдэг бүрэн эрхийг Засгийн газрын тэргүүнд шилжүүлэх, ҮАБ-ын тухай хуулийг шинэчлэх, тус байгууллагын бүрэн эрх, бүтэц бүрэлдэхүүнийг тусгаж өгөх, үндэсний аюулгүй байдлыг ханган ажиллах үндсэн болон тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах талын зохицуулалт шаардлагатай байна.

4. Мөн түүнчлэн гадаад харилцааны салбарын бие даасан хуулийн хамрах хүрээнд Гадаад харилцааны асуудлаар Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн оролцоог нэмэгдүүлэх, гадаад бодлого, аюулгүй байдлын асуудлаар шийдвэр гаргахад оролцогч бүхий л төрийн байгууллагын албан тушаалтнууд төдийгүй улс төрийн намууд, эрдэмтэд судлаачид, иргэд, олон нийтийн төлөөллийг оролцуулан цаг үеийн, гэнэтийн асуудлаар нэгдмэл шийдвэр гаргах зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлыг тусгаж өгөх хэрэгтэй.

ЭХ СУРВАЛЖ**Монгол хэл дээрх*****Хууль тогтоомж***

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992.
2. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 2010.
3. Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал, 2011.
4. Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, 2001.
5. Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн тухай, 1992.
6. Засгийн газрын 2013 оны 5-р сарын 11-ний өдрийн 169 тоот тогтоол.
7. Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах журам, 2013.
8. “Гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдсэн зохицуулалтыг сайжруулах тухай, 2010.

Ном, судалгааны тайлан

1. “Үндсэн хуулийн үзэл баримтлалыг системийн загвараар шинжилж, дүрслэх нь” судалгааны тайлан. ЗСДС. УБ.2019
2. “Гарааны бизнесийг дэмждэг экосистемийн жишиг загвар боловсруулах нь” судалгааны ажлын тайлан. ЗСДС. УБ.2021
3. Төмөрчулуун Г, “Гадаад бодлогын шийдвэр гаргах өрнөдийн онол ба МУ”, ШУ-ны /Sc.D / докторын зэрэг горилсон судалгааны ажил, 2006 он
4. Тавантолгой болон Төмөр замын асуудлаар шийдвэр гаргах процесс (эх сурвалж: УИХ-ын гадаад бодлого, үндэсний аюулгүй байдлын байнгын хорооноос хийсэн хайгуул судалгааны материал).
5. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын гадаад, дотоод орчны судалгаа, дүн шинжилгээ. Хамтын бүтээл. 2014

Гадаад хэл дээрх***Ном, өгүүлэл***

1. Alexander Martin (21 November 2013). “Japan to Form Own National Security Council”. The Wall Street Journal. Retrieved 4 February 2014.
2. “National Security Committee”. directory.gov.au. Department of Finance. 17 June 2019. Retrieved 16 January 2020.
3. Martin Perkov. “National security system”. Knowledge International journal. 2018
4. Waldemar Kitler. Model of the National Security System: Selected Problems. European Research Studies Journal. 2021
5. Цахим эх сурвалж
6. https://www.researchgate.net/publication/340790247_Evaluating_Strategies_Six_Criteria_for_National_Security_Professionals
7. <https://www.lawteacher.net/free-law-essays/international-law/assessing-factors-of-national-security-international-law-essay.php>
8. https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_191669/

ISSUES ON THE IMPROVEMENT OF THE LEGAL ENVIRONMENT OF NATIONAL SECURITY OF MONGOLIA

Zaya.T

*Lecturer, Department of International Relations and Social Sciences,
University of the Humanities /MA/*

ABSTRACT:

Foreign policy and National Security are closely related concepts. The Foreign Policy Concept of Mongolia (2011) states that the priority of Foreign Policy is to ensure the security and national interests of Mongolia through political and diplomatic means within the framework of international law. It is natural to have a sufficient legal basis to ensure the implementation of this goal.

Studies on Foreign Policy and National Security are often conducted from the perspective of political sciences and international relations. There are not sufficient studies and analyses of the domestic legal environment among lawyers and jurists.

In this study, the “system method” was used, and the results of the research and analysis of the domestic legal environment of the National Security of Mongolia were intended to be expressed in statistics and figures. The National Security Concept (2010) and the National Security Law (2001) are the main objects of the research.

Regarding the results of the research, by conducting a system analysis of the National Security System of Mongolia, it was concluded that the system has a performance of 65 percent by forming 26 types out of 40 types of 5 sub-systems that should be consisted of any social unit system depending on the system category that can partially resist the risk.

Research methodology: “Social unit system methodology” was used to analyze the concept of National Security and the Law on National security of Mongolia.

In addition, the role and importance of the National Security Council in the National Security System, its potential in terms of political governance, and the issue of improving the legal status were discussed.

KEYWORDS:

Domestic legal environment, social unit system methodology, system analysis, National Security, National Security Council.

ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬ ДАХЬ СТАНДАРТ ЗААЛТ, ҮҮРЭГЖҮҮЛСЭН БОЛОН ҮҮРЭГЖҮҮЛЭЭГҮЙ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ ЭРХ ЗҮЙН ҮР ДАГАВАР



Ё.Болормаа

*Шихихутуг их сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн ахлах багш,
докторант*

ТОВЧЛОЛ:

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор суурь хууль болох тус хуулийн заалтуудыг стандарт заалт, үүрэгжүүлсэн болон үүрэгжүүлээгүй заалтын хэлбэрээр авч үзсэнээр, холбогдох заалтуудын зорилго, хууль зүйн боломж, хууль зүйн үүрэг, онцлог, үр дагавар зэргийг тодорхойлоход ач холбогдолтой байж болох юм.

Хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд ажил олгогч, ажилтан талууд суурь хэм хэмжээ, зарчимд нийцүүлэн тус хуулиар шууд зохицуулаагүй асуудлыг нөхөн болон нарийвчлан зохицуулах зорилгоор байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ¹ батлан гаргах шаардлага болон боломж нь хууль зүйн хувьд бий болдог. Аж ахуй нэгж, байгууллагад үйлчилж буй холбогдох хөдөлмөрийн дотоод хэмжээний стандарт заалт, үүрэгжүүлсэн болон үүрэгжүүлээгүй хэм хэмжээний практик хэрэгжилт, хууль зүйн үр дагаварын асуудлыг хөндөн авч үзэхэд оршино.

ТҮЛХҮҮР ҮГС:

Хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ², захиргааны хэм хэмжээний акт, хөдөлмөрийн дотоод журам, стандарт заалт³, үүрэгжүүлсэн болон үүрэгжүүлээгүй⁴ хэм хэмжээ,⁵ нөхөн

¹ Хөдөлмөрийн тухай хууль. 4.1.10 дахь заалт, “хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ” гэж хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудлаар аж ахуйн нэгж, байгууллага дотооддоо дагаж мөрдөхөөр холбогдох хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээрт нийцүүлэн ажил олгогчоос бичгээр гаргасан баримт бичгийг; Өөрөөр хэлбэл, байгууллагад үйлчилж буй дүрэм журмын ерөнхий томъёолол бөгөөд байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг өөртөө багтаасан гэж үзнэ.

² Хөдөлмөрийн тухай хууль. 4.1.10 дахь заалт, “хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ” гэж хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудлаар аж ахуйн нэгж, байгууллага дотооддоо дагаж мөрдөхөөр холбогдох хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээрт нийцүүлэн ажил олгогчоос бичгээр гаргасан баримт бичгийг;

³ Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулиар дээд, доод хязгаарыг заасан заалтуудаар илэрнэ.

⁴ Хөдөлмөрийн тухай хуулиар заавал биелүүлэх, дагаж мөрдөх нь хууль зүйн үүрэг байдлаар томъёологдсон заалтуудаар ойлгоно. Харин үүрэгжүүлээгүй заалт нь талуудад санал болгож буй заалтууд буюу харилцан тохиролцож хөдөлмөр эрхлэлтийн харилцааг зохицуулж болох боломж нь хуулиар олгогдсон гэж харж болохоор заалтууд хамаарна.

⁵ Хөдөлмөрийн тухай хууль. 92.1 дэхь заалт, Ажилтныг байнга оршин суугаа газраас нь өөр, алслагдсан газар байрлуулж ажил үүрэг гүйцэтгүүлэхээр уул уурхай, олборлох салбарын ажил олгогч ургын ээлжээр ажиллуулах горим хэрэглэж болно.

зохицуулах, нарийвчлан зохицуулах⁶

АГУУЛГА:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн⁷ заалтуудыг стандарт заалт, үүрэгжүүлсэн болон үүрэгжүүлээгүй заалт байдлаар авч үзэх нь

2. Холбогдох стандарт заалт, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнээс бий болох эрх зүйн үр дагаварыг авч үзэх нь

1. Хөдөлмөрийн тухай хуулийн заалтуудыг стандарт заалт, үүрэгжүүлсэн болон үүрэгжүүлээгүй заалт байдлаар авч үзэх нь

Хуульд тусгагдсан ерөнхий агуулга бүхий хэм хэмжээ болон тусгай нарийвчилсан хэм хэмжээ, тэдгээрийн зохицуулалтын уялдаа, түүнчлэн бусад хуулийн хамаарал зэрэг нь хуулийг хэрэглэхэд түвэгтэй байдлыг бий болгодог.⁸ гэжээ. Энэ нь Хөдөлмөрийн хууль тогтоомж⁹-той хамааралтай мэт. Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулагдах хөдөлмөрийн харилцааны мөн чанар, онцлог нь хууль зүйн ямар аргаар түүнийг зохицуулах нь зохистойг тодорхойлох гол хүчин зүйл болдог.¹⁰ Тус хуулиар материаллаг болон процессын хэм хэмжээг нарийвчлан хуульчлах боломжгүйг тус харилцаа нь өөрөө бий болгодог. Тиймээс тухайн байгууллага хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг батлан гаргахдаа материаллаг хэм хэмжээг заахаас гадна, асуудлыг ямар процессоор шийдвэрлэхийг процессын зураглалын хамт гаргах зайлшгүй шаардлагатай. Зохицуулалтын арга нь тус салбарын харилцааг зохицуулах эх сурвалж болох хууль тогтоомжоор¹¹ илэрдэг. Хөдөлмөр эрхлэлтийн харилцааг зохицуулалтын ерөнхий аргаар зохицуулах буюу хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, холбогдох бусад хууль, хөдөлмөр эрхлэлтийн салбарт нийтээр дагаж мөрдөх шинжтэй захиргааны хэм хэмжээний акт, улсын хамтын хэлэлцээрээр зохицуулах нь ажил олгогч, ажилтан талуудын хувьд, салбар харгалзахгүйгээр тоглоомын нийтлэг дүрэм¹² гэж үзэж болно. Харин аж ахуй нэгж, байгууллага хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг хөдөлмөр эрхлэлтийн харилцааны онцлогтоо нийцүүлэн бий болгох нь тусгайлсан дүрэм байдлаар ойлгогдож болох юм. Хөдөлмөрийн тухай хуулийн заалтууд нь стандарт заалт, үүрэгжүүлсэн заалт, үүрэгжүүлээгүй заалт хэлбэрээр хуульчлагджээ. Энэ байдлаар холбогдох заалтуудыг түүвэрлэн байршуулж авч үзье. Үүнд, стандарт заалтууд

⁶ Хөдөлмөрийн тухай хууль нь зохицуулагдаж буй хөдөлмөр эрхлэлтийн харилцааны онцлогтой холбоотойгоор холбогдох хуулийн заалтуудыг нарийвчлан зохицуулах, тус хуулиар зохицуулалтгүй байгаа асуудлыг хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ батлан гаргаж зохицуулахыг үүрэгжүүлсэн эсвэл үүрэгжүүлээгүй байдаг.

⁷ Ё.Болормаа, “МУ-ын хөдөлмөрийн тухай хуулийн зорилт ба хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэглээ”, Хууль дээдлэх ёс №1 (2023), 92 дахь тал.

⁸ Ц.Давхарбаяр, Д.Янжинхорлоо, Иргэний эрх зүйн хэм хэмжээг арилжаа /худалдааны/-ны харилцаанд тайлбарлан хэрэглэх онол, арга зүй, (сургалтын гарын авлага), УБ, 2020, 10 дахь тал.

⁹ Ё. Болормаа, “Хөдөлмөрийн хууль тогтоомж ба хөдөлмөрлөх эрхийн зарим асуудал”, Хууль дээдлэх ёс, №4 (2018), 89 дэх тал.

¹⁰ Б.Уранцэцэг, “Аж ахуй нэгж байгууллагад тогтоогдон үйлчлэх хэм хэмжээ /дотоод хэм хэмжээ/ түүнийг хөдөлмөрийн маргааныг шийдвэрлэхдээ шүүх хэрэглэж буй практик”, Шүүх эрх мэдэл №4 (2017), 46 дахь тал.

¹¹ Хөдөлмөрийн тухай хууль. 2.3 дахь заалт, Хөдөлмөрийн эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актууд энэ хуулийн 2.5-д зааснаас бусад тохиолдолд дараах эрэмбээр үйлчилнэ:

2.3.1.энэ хууль;

2.3.2.Монгол Улсын бусад хууль;

2.3.3.захиргааны хэм хэмжээний акт;

2.3.4.салбар, салбар дундын хамтын хэлэлцээр;

2.3.5.хамтын гэрээ;

2.3.6.хөдөлмөрийн гэрээ;

2.3.7.аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ.

2.4.Хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцсэн хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг холбогдох талууд дагаж мөрдөх үүрэгтэй.

¹² Ямар нэгэн тоглоомын дүрэмтэй адилтган үзэж болох юм. Нийтлэг дүрмийг ХтХ гэж харж болох юм. Харин байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг тусгайлсан дүрэм гэж үзэж болох юм.

нь Тухайлбал, Хамтын гэрээ, хамтын хэлэлцээр байгуулах¹³, ажлын цагийн дээд хязгаар¹⁴, хөдөлмөрийн гэрээний хэлбэр¹⁵, ажилтан ажил үүргээ гүйцэтгэхээс тагталзах эрх¹⁶, өөр ажилд түр шилжүүлэх¹⁷, урьд эрхэлж байсан ажил, албан тушаалд нь эгүүлэн авах¹⁸, дагалднаар ажиллах хөдөлмөрийн гэрээ¹⁹, үл өрсөлдөх үүрэг²⁰, хөдөлмөр эрхлэлтийн харилцааг ажилтны санаачилгаар цуцлах²¹, бөөнөөр халах үеийн зохицуулалт²², ажлын бүтэн бус цаг²³, ээлжийн ажлын цаг²⁴, дуудлагын цаг²⁵, уртын ээлжээр ажиллуулах²⁶, туслах малчин, гэрийн үйлчилгээний ажилтан, тэдгээртэй адилтгах ажилтантай байгуулах хөдөлмөрийн гэрээний онцлог²⁷, ажил олгогчийн зардлаар суралцах ажилтны хүлээх

¹³ Хөдөлмөрийн тухай хууль. 31.3 дахь заалт, Хамтын гэрээ, хамтын хэлэлцээрийг 3 жилээс илүүгүй хугацаагаар байгуулна. Мөн 31.4.Цалин хөлсний асуудлаар байгуулах хамтын гэрээ, хамтын хэлэлцээрийг нэг жилээс доошгүй хугацаагаар байгуулна.

¹⁴ Хөдөлмөрийн тухай хууль. 84.1 дэхь заалт, Долоо хоногийн ердийн ажлын цаг 40-өөс илүүгүй байна. 84.2.Ердийн ажлын өдрийн үргэлжлэл найман цагаас илүүгүй байна. 84.3.Насанд хүрээгүй хүний долоо хоногийн ажлын цаг 30-аас илүүгүй байна. Мөн 84.4 дэхь заалт, Долоо хоногийн ажлын цагийн дээд хязгаар нь 56 цагаас илүүгүй байна. Өдөрт ажиллах илүү цагийн хязгаар нь дөрвөн цагаас илүүгүй байна.

¹⁵ Тус хуулийн 48.2 дахь заалт, Хүндэтгэн үзэх шалтгаанаар хөдөлмөрийн гэрээг бичгээр үйлдвэрлэх бол ажилтныг ажил үүргээ гүйцэтгэх эхлэлээс хойш ажил олгогч ажлын 10 өдрийн дотор хөдөлмөрийн гэрээг нөхөн байгуулах үүрэгтэй.

¹⁶ Хөдөлмөрийн тухай хууль. 54.1.3 дахь заалт, Ажил олгогч ажилтны цалин хөлсийг олгоход зохих өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд олгоогүй.

¹⁷ Хөдөлмөрийн тухай хууль 58.1.2 дахь заалт, Үйлдвэрлэлийн осол болон гамшгаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийн үр дагаврыг арилгах зэрэг зайлшгүй шаардлага гарсан, эсхүл аж ахуйн нэгж, байгууллагын хэвийн ажиллагааг алдагдуулахад хүргэсэн бөгөөд урьдчилан мэдэх боломжгүй нөхцөл байдал үүссэн бол 45 хүртэл хоногийн хугацаагаар;

¹⁸ Хөдөлмөрийн тухай хууль. 61.1.1 дэхь заалт, Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдаж хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь дуусгавар болсон хүн хөдөлмөрийн чадвар сэргээгдсэн тухай эрүүд мэндийн магадлалын зөвлөлийн шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор ажилдаа орох хүсэлтээ гаргасан; Мөн 61.1.3 дахь ажлын байр нь хасагдсан шалтгаанаар ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгосноос хойш гурван сарын дотор уг ажлын байр дахин бий болсноос хойш 30 хоногийн дотор ажилтан хүсэлт гаргасан;

¹⁹ Хөдөлмөрийн тухай хууль. 62.6 дахь заалт, Дагалдан ажилтны үндсэн цалин түүний гүйцэтгэх ажил үүрэг, эзэмших ажлын дадлага, үр чадвар зэргийг өөртэй нь тохиролцож тогтоох бөгөөд ижил төрлийн ажил үүрэг гүйцэтгэж байгаа үндсэн ажилтны үндсэн цалингийн 70 хувиас доогуур байж болохгүй.

²⁰ Хөдөлмөрийн тухай хууль. 72.4 дэхь заалт, Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа дуусгавар болсноос хойш үл өрсөлдөх нэмэлт нөхцөл, эсхүл дагалдах гэрээ үйлчлэх хугацаанд ажил олгогч ажилтанд хамгийн сүүлийн сарын цалин хөлсний нь 50-аас доошгүй хувийн олговрыг сар бүр олгоно. 79.2.Ажилтан хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлах тухай ажил олгогчид бичгээр мэдэгдсэн өдрөөс хойш 30 хоног өнгөрмөцг ажлын байраа орхих эрхтэй бөгөөд энэ тохиолдолд хөдөлмөр эрхлэлтийн харилцаа цуцлагдсанд тооцно.

²¹ Хөдөлмөрийн тухай хууль 80.4 дэх заалт, Ажил олгогч энэ хуулийн 65.4.2, 78.1.5, 80.1.1, 80.1.2, 80.1.3-г заасан үндэслэлээр хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлах тухай ажилтанд 30-аас доошгүй хоногийн өмнө бичгээр мэдэгдэх бөгөөд ажилтанд мэдэгдэл өгсөн тухайгаа шаардлагатай тохиолдолд ажил олгогч нотлох үүрэгтэй.

²² Хөдөлмөрийн тухай хуулийн 81.6. Ажил олгогч бөөнөөр халах шийдвэрээ гаргасан өдрөөс хойш 30 хоногийн дотор харьяа нутаг дэвсгэрийн хөдөлмөрийн асуудал хариуцсан байгуулагад бичгээр мэдэгдэнэ.

²³ Хөдөлмөрийн тухай хууль. 86.1 дэх заалт, Ажлын бүтэн бус цагаар ажиллах ажилтны долоо хоногт ажиллах цаг 32-оос илүүгүй байна.

²⁴ Хөдөлмөрийн тухай хууль. 87.1 дэх заалт, Ажил олгогч ээлжийн ажлын цаг, хуваарийг ээлжийн ажил эхлэхээс 48-аас доошгүй цагийн өмнө ажилтанд мэдэгдэнэ.

²⁵ Хөдөлмөрийн тухай хууль. 89.2 дахь заалт, Ажилтан ажил олгогчийн заасан байршилд хүлээсэн бол тухайн хугацаанд ногдох үндсэн цалингийн 50-аас, бусад тохиолдолд 30-аас доошгүй хувийн олговрыг ажил олгогч ажилтанд олгоно. Мөн 89.2.Ажилтан ажил олгогчийн заасан байршилд хүлээсэн бол тухайн хугацаанд ногдох үндсэн цалингийн 50-аас, бусад тохиолдолд 30-аас доошгүй хувийн олговрыг ажил олгогч ажилтанд олгоно. Мөн түүнчлэн 89.3.Ажил олгогч дуудлагаар ажиллуулах өдөр, цагийг ажилтанд 24-өөс доошгүй цагийн өмнө мэдэгдэх бөгөөд ажилтныг нэг сард наймаас илүү удаа дуудлагаар ажиллуулахгүй.

89.3. Хөдөлмөрийн тухай хуулийн Ажил олгогч дуудлагаар ажиллуулах өдөр, цагийг ажилтанд 24-өөс доошгүй цагийн өмнө мэдэгдэх бөгөөд ажилтныг нэг сард наймаас илүү удаа дуудлагаар ажиллуулахгүй.

²⁶ Хөдөлмөрийн тухай хууль. 92.3 дахь заалт, Уртын ээлжээр ажиллах ажилтны ажлын өдрийн үргэлжлэл 12 цагаас илүүгүй байх бөгөөд энэ хуулийн 87 дугаар зүйлийг баримтлан энэ хуулийн 109.1-д заасны дагуу илүү цагийг тооцож нэмэгдэл хөлс олгоно. Мөн хуулийн 92.4. Хөдөлмөрийн тухай хуулийн Уртын ээлжээр ажиллах ажилтны нэг ээлжид ажил үүрэг гүйцэтгэх хугацаа 14 хоног, амрах хугацаа 14 хоног байна.

²⁷ Хөдөлмөрийн тухай хууль. 71.6 дахь заалт, Ажил олгогч нь туслах малчин, гэрийн үйлчилгээний ажилтныг долоо хоногт тасралтгүй 24 цагаас дээш хугацаагаар амрах, энэ хуульд заасны дагуу ээлжийн амралт олгох үүрэгтэй.

үүрэг²⁸, ээлжийн амралт, түүний хугацаа²⁹, туслах малчны цалин хөлс³⁰, сул зогсолтын үеийн олговор³¹, цалин хөлснөөс хийх суутгал, түүний хэмжээг хязгаарлах³² гэсэн зохицуулалтуудаар илэрчээ. Төрөөс холбогдох хуулийг батлан гаргахдаа тоон үзүүлэлтээр илэрсэн заалтуудын хэрэгжилтийн дээд, доод хязгаарыг хуульчилж өгсөн байна.

Харин үүрэгжүүлсэн байдал нь холбогдох хуулиас дараах байдлаар харагдана. Тухайлбал, ...үүрэгтэй³³...дагаж мөрдөх үүрэгтэй³⁴,...дагаж мөрдөнө³⁵...бүрдүүлэх үүрэгтэй³⁶, ...байршуулах үүрэгтэй³⁷, ...ажлын байраар хангах үүрэгтэй³⁸, ...баталж мөрдүүлнэ.³⁹

²⁸ Хөдөлмөрийн тухай хууль. 73.3 дахь заалт, Сургалтын дараа ажилтны тухайн аж ахуйн нэгж, байгууллагад үргэлжлүүлэн ажиллах хугацааг талууд харилцан тохиролцох бөгөөд гурван жилээс илүүгүй байна.

²⁹ Хөдөлмөрийн тухай хууль. 99.3 дахь заалт. Хуульд өөрөөр заагаагүй бол ажилтны ээлжийн үндсэн амралтын хугацаа ажлын 15 өдөр байна. Мөн хуулийн 99.4.Хөгжлийн бэрхшээлтэй болон 18 насанд хүрээгүй ажилтны ээлжийн үндсэн амралтын хугацаа ажлын 20 өдөр байна. Мөн хуулийн 99.8.Ажилтан өөрийн хүсэлтээр ээлжийн амралтыг тухайн ажлын жилдээ багтаан хэсэгчлэн эдэлж болно. Хэсэгчлэн амрах ээлжийн амралтын аль нэг тасралтгүй амралтын үргэлжлэх хугацаа нь ажлын 10 өдрөөс доошгүй байна.

³⁰ Хөдөлмөрийн тухай хууль. 112.1 дэх заалт, Туслах малчин зөвшөөрсөн бол түүний цалин хөлсний 30-аас илүүгүй хувийг мөнгөн бус хэлбэрээр олгож болно.

³¹ Хөдөлмөрийн тухай хууль. 116.1 дэх заалт, Ажил олгогчоос үл шалтгаалан гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.2-т заасан аюулт үзэгдэл, эрх бүхий төрийн байгууллагын шийдвэрийн улмаас, эсхүл ажилтнаас үл шалтгаалах сул зогсолтын хугацаанд түүнийг өөр ажилд шилжүүлэх боломжгүй бол түүнд үндсэн цалингүйнх нь 60-аас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний олговор олгох бөгөөд олговрын хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур байж болохгүй.

³² Хөдөлмөрийн тухай хууль. 119.2 дахь заалт, Ажилтны нэг сарын цалин хөлснөөс хийх нийт суутгал нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварыг хассан цалин хөлсний дүнгийн 20 хувиас, хүүхдийн тэтгэлэг гаргуулах, эсхүл хэд хэдэн суутгал зэрэг хийх бол цалин хөлсний 50 хувиас хэтрэхгүй байна.

³³ Тус заалт нь Хөдөлмөрийн тухай хуульд 53 байна.

³⁴ Хөдөлмөрийн тухай хууль. 2.4 дэх заалт, Хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцсэн хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг холбогдох талууд дагаж мөрдөх үүрэгтэй. /Гэсэн заалт 1 байна/

³⁵ Хөдөлмөрийн тухай хууль. 2.2 дахь заалт, Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө. 40.3.Аж ахуйн нэгж, байгууллага татан буугдах үйл явц бүрэн дуусах хүртэлх хугацаанд хамтын гэрээг дагаж мөрдөнө. 107.5.Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг салбар, салбар дундын хамтын хэлэлцээрээр энэ хуулийн 107.3-т заасан хэмжээнээс нэмэгдүүлэн тогтоосон бол түүнийг дагаж мөрдөнө.

³⁶ Хөдөлмөрийн тухай хууль. 6.3.Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхалтаас ангид байх нөхцөлийг ажил олгогч бүрдүүлэх үүрэгтэй. Мөн 7.4. Ажил олгогч ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гарсан гомдлыг шийдвэрлэх журмыг хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгаж, дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтыг үл тэвчих орчныг бүрдүүлэх үүрэгтэй. Мөн 31.6. Ажил олгогч хамтын гэрээ, хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд ажил олгогчоос шаардагдах хөрөнгийг төсөвтөө тусгаж, хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй. /Гэсэн заалт 3 байна./

³⁷ Хөдөлмөрийн тухай хууль. 6.6. Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхалтаас гэж үзсэн хүн, ажилтан, ажилтны төлөөлөгч гомдлоо тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, дээд шатных нь албан тушаалтан, холбогдох төрийн бус байгууллага, үйлдвэрчний эвлэл, хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх байгууллага, хууль хяналтын байгууллага, хөдөлмөрийн хяналтын байгууллага, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, шүүхэд тус тус гаргаж болно. Гомдлыг хүлээн авах байгууллага, албан тушаалтны нэр, хаяг, харилцах утас, цахим шуудангийн хаягийг ажил олгогч нийт ажилтанд харагдахуйц газар байршуулах үүрэгтэй. 7.3.Ажилтан, ажил олгогч, гуравдагч этгээд ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтад өртсөн гэж үзвэл гомдлоо тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, дээд шатны албан тушаалтан, холбогдох төрийн бус байгууллага, үйлдвэрчний эвлэл, хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх байгууллага...байршуулах үүрэгтэй. 33.5. Ажил олгогч хамтын гэрээ, тухайн аж ахуйн нэгж, байгууллагад үйлчлэх хамтын хэлэлцээрийг нийт ажилтанд харагдахуйц газар байршуулах үүрэгтэй. 45.2.Ажилтны мэдээллийг авах, боловсруулах, хадгалах, ашиглах журам, түүнд оруулсан өөрчлөлтийг ажил олгогч нийт ажилтанд харагдахуйц газар байршуулах үүрэгтэй. Мөн 122.2. Ажил олгогч хөдөлмөрийн дотоод журмыг шинээр баталсан, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулсан тохиолдолд нийт ажилтанд танилцуулж, харагдахуйц газар байршуулах үүрэгтэй. Хөдөлмөрийн гэрээг цуцлах үндэслэл болон хөдөлмөрийн сахилгын зөрчлийг хөдөлмөрийн дотоод журамд тусгайлан заана.

³⁸ Хөдөлмөрийн тухай хууль. 43.2.3. энэ хуульд заасны дагуу хувь хүнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулж, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд заасан шаардлага, стандартад нийцсэн, ялгаварлан гадуурхалт, дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтаас ангид ажлын байраар хангах

³⁹ Хөдөлмөрийн тухай хууль. 103.3. Ажил олгогч хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээрт нийцүүлэн цалин хөлсний талаар дараах хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг баталж мөрдүүлнэ.

103.3.1.ажил мэргэжлийн жагсаалт;

103.3.2.ажлын байрны тодорхойлолт;

103.3.3.энэ хуулийн 106.3-т заасантай нийцсэн хөдөлмөрийн норм, норматив;

103.3.4.цалин хөлсний журам.

122.1. Ажил олгогч ажилтны төлөөлөгчийн саналыг харгалзан хууль тогтоомжид нийцүүлэн тухайн аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээнд үйлчлэх хөдөлмөрийн дотоод журмыг баталж мөрдүүлнэ.

...хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр тогтооно.⁴⁰, ... хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр зохицуулна.⁴¹, ...тогтоон мөрдүүлнэ⁴²,...бодлого хэрэгжүүлнэ.⁴³...үйлчилнэ⁴⁴...тусгана⁴⁵... байгуулна⁴⁶ гэсэн заалтуудаас харагдана. Үүнтэй холбоотойгоор, ажил олгогчын зүгээс заавал батлан мөрдүүлэхээр хуулиар үүрэгжүүлсэн, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг авч үзвэл, Хөдөлмөрийн тухай хуулийн 122.1. “Хөдөлмөрийн дотоод журам”, 7.4. “Ажлын байрны дарамт, бэлгийн дарамтаас сэргийлэх, таслан зогсоох, арилгах, холбогдох гомдлыг хүлээн авч шийдвэрлэх журам”, 45.1. ”Ажилтны мэдээллийг авах, боловсруулах, хадгалах, ашиглах журам”, 43.2.8 “Хяналтын төхөөрөмж байршуулж, ашиглах журам”, 103.3. Ажил мэргэжлийн жагсаалт, Ажлын байрны тодорхойлолт, Хөдөлмөрийн норм, норматив, Цалин хөлсний журам, Нууцтай холбоотой журам зэрэг нь тухайн хөдөлмөр эрхлэлтийн харилцааны үйл ажиллагааны чиглэл, онцлог, ажилтнуудын тоо зэргээс шалтгаалан бие даасан байдлаар батлагдан мөрдөгдөх эсвэл хөдөлмөрийн дотоод журамд бүлэг байдлаар оруулан зохицуулагдах боломжтой. Хөдөлмөрийн тухай хууль дахь үүрэгжүүлээгүй хэм хэмжээг авч үзвэл, Тухайлбал, ...эрхтэй⁴⁷, ...баталж мөрдүүлж болно.⁴⁸, ...байгуулж

⁴⁰ Хөдөлмөрийн тухай хууль. 108.1. Ажилтны ур чадварын, ажилласан жилийн, мэргэшлийн зэргийн, хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилласны болон бусад нэмэгдлийг хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр тогтооно. Мөн 109.6. Ажилтанд эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй нэмэлт ажил үүрэг гүйцэтгэсний болон бусад нэмэгдэл хөлсний хэмжээг хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр тогтооно.

⁴¹ Хөдөлмөрийн тухай хууль. 100.2. Хувийн чөлөө олгох журам, чөлөөний хугацаа, хувийн чөлөөтэй байх хугацаанд олговор олгох эсхийг хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр зохицуулна. Мөн 139.1. Гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, эцэг өөрөө хүсэлт гаргасан бол ажил олгогч түүнд хүүхэд асрах чөлөө олгох бөгөөд энэ хугацаанд тэтгэмж олгох асуудлыг холбогдох хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр зохицуулна.

⁴² Хөдөлмөрийн тухай хууль. 43.2.8. зайлшгүй шаардлагаар ажлын байранд хяналтын тоног төхөөрөмж ажиллуулах бол энэ тухай ажилтанд урьдчилан мэдэгдэх, ашиглах журмыг тогтоон мөрдүүлэх, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 3.1.15-д заасан ахуйн байранд хяналтын тоног төхөөрөмж байрлуулахгүй байх;

⁴³ Хөдөлмөрийн тухай хууль. 43.3. Ажил олгогч нь ажил, амралтын цагийг зохицуулах, хөдөлмөр эрхлэлтийн уян хатан нөхцөл хэрэглэх зэргээр ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгах замаар ажилтны хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлнэ. /...байгуулах замаар хэрэгжүүлнэ, ...арга хэмжээг авч хэрэгжүүлнэ, ...чиг үүргийг хэрэгжүүлнэ,... байцаагч хэрэгжүүлнэ,...хяналтыг хэрэгжүүлнэ, ажил олгогч хэрэгжүүлнэ/

⁴⁴ Хөдөлмөрийн тухай хууль. 2.3.Хөдөлмөрийн эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актууд энэ хуулийн 2.5-д зааснаас бусад тохиолдолд дараах эрэмбээр үйлчилнэ.... 35.2.Салбар, салбар дундын хамтын хэлэлцээр нь тухайн хэлэлцээрт оролцогчдын төлөөлж байгаа нийт ажилтан, ажил олгогчид хамаарч үйлчилнэ.... 64.5.Туршилтаар ажиллах ажилтанд хөдөлмөрийн хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ нэгэн адил үйлчилнэ... 66.4.Ажлын бүтэн бус цагийн ажилтан энэ хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд ажлын бүтэн цагаар ажиллах ажилтны нэгэн адил эрх эдэлж, үүрэг хүлээх бөгөөд хөдөлмөрийн хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ түүнд нэгэн адил үйлчилнэ. 68.3.Зайнаас ажиллах ажилтан энэ хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд нжил төрлийн ажил үүрэг гүйцэтгэж байгаа бусад ажилтантай адил эрх эдэлж, үүрэг хүлээх бөгөөд хөдөлмөрийн хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ түүнд нэгэн адил үйлчилнэ.

⁴⁵ Хөдөлмөрийн тухай хууль. 49.1.Хөдөлмөрийн гэрээнд дараах гол нөхцөлийг тусгана: 49.1.1.ажлын байрны нэр, ажлын байрны тодорхойлолтод заасан гүйцэтгэх ажил үүрэг; 49.1.2.ажил үүрэг гүйцэтгэх байршил; 49.1.3.цалин хөлсний хэмжээ; 62.2.Дагалднаар ажиллах хөдөлмөрийн гэрээнд энэ хуулийн 49 дүгээр зүйлд заасан нөхцөлөөс гадна ажилтны дагалдан ажиллах хугацаа, дагалдуулан ажиллуулах ажилтан, эзэмшвэл зохих ажлын дадлага, ур чадварын талаар тусгайлан тусгана гэх мэт /14 заалт байна./

49.1.4.хөдөлмөрийн нөхцөл.

⁴⁶ гэсэнтэй холбоотой заалт 16 байна.

⁴⁷ Тус заалт нь Хөдөлмөрийн тухай хуульд 32 байна.

⁴⁸ Хөдөлмөрийн тухай хууль. 106.1. Ажил олгогч ажиллах хүчний тоог төлөвлөх, ажиллах хүчний тоог ажил, мэргэжлээр тогтоох, хийснээр цалин хөлс олгох зорилгоор хөдөлмөрийн норм, норматив баталж мөрдүүлж болно.

болно⁴⁹, ...баталж болно.⁵⁰, ...тогтоож болно.⁵¹, ...олгож болно.⁵², ...тусгаж болно.⁵³, ...зохицуулж болно.⁵⁴, ...эвлэлдэн нэгдэх эрх⁵⁵, ...тохиролцож болно⁵⁶ гэсэн заалтуудаас авч үзэхэд энэхүү ...ж болно гэсэн заалтууд нь...ж болохгүй ч байж болохыг бас хуулиар зөвшөөрчээ гэж үзэж болохоор байна. Тухайлбал, Хөдөлмөрийн тухай хуулийн 20.1 дэхь заалтад, Хамтын хэлэлцээ хийх санаачилгыг аль ч тал гаргаж болно. Мөн 107.2 дахь заалтад, Ажил олгогч, ажилтны төлөөлөгч харилцан тохиролцсон бол цалин хөлсийг аж ахуйн нэгж, байгууллагын болон салбар, салбар дундын түвшинд тус тус хамтын гэрээ, хамтын хэлэлцээрээр зохицуулж болно. Мөн хуулийн 145.1 дэхь заалтад, Ахмад настан, тэтгэвэр авагч хөдөлмөр эрхэлж болно гэх мэт. Практикт хөдөлмөр эрхлэлтийн харилцааг зохицуулахдаа илрэх хэлбэр нь Хамтын гэрээ, ...нэмэгдэл, нэмэгдэл хөлс олгох журам, Хувцас хэрэгсэл олгох журам, Хоол, унааны мөнгө олгох журам, Буцалтгүй тусламж олгох журам, Ур чадварын нэмэгдэл хөлс олгох журам...гэх мэт талууд харилцан тохиролцож шийдвэрлэж болох боломжийг хуулиар олгосон.

Үүрэгжүүлээгүй эрх зүйн актын цаана хөдөлмөр, нийгмийн баталгааг бий болгохтой холбоотой асуудал нарийвчилсан зохицуулалтгүй, тодорхойгүй байдлаар үлдэх магадлалтай. Өөрөөр хэлбэл, Тус байгууллага холбогдох асуудлын хүрээнд дүрэм, журмыг батлан гаргасан хэдий ч ерөнхий зохицуулалттай эсвэл огт дүрэм журам байхгүй байх нь бий. Практикт байгууллагууд, зарим тохиолдолд хамтын гэрээгүйгээр⁵⁷, бусад дүрэм, журмын хэлбэрээр нийгмийн баталгааг хангах зохицуулалт хийх нь байдаг. Гэвч энэ нь эрх зүйн үр дагаварын хувьд харилцан адилгүйг анхаарах нь зүйтэй. Байгууллагад хүчин төгөлдөр үйлчилж буй дүрэм журам буюу хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ нь материаллаг зохицуулалт нь ерөнхий бөгөөд нарийвчилсан зохицуулалт бага, хэрэгжих эсэх нь хоёрдмол утгатай, тодорхойгүй, зохицуулалтын давхардал, хийдэлтэй, хэрхэн хэрэгжүүлэх процессын зохицуулалт тодорхойгүй, агуулгын бус, хэлбэрийн зохицуулалттай байдаг нь нийтлэг тохиолддог. Ийнхүү хэлбэрдсэн хөдөлмөрийн дотоод хэмжээ буюу байгууллага бүрт үйлчлэх эрх зүйн актууд нь тухайн байгууллагад ажиллаж буй ажилтнуудын эрхийг

⁴⁹ Хөдөлмөрийн тухай хууль. 49.3. Энэ хуулийн 49.1-д зааснаас гадна ажил үүргийн онцлогтой нь холбоотойгоор эд хөрөнгийн хариуцлагын, нууцын, сургалтын, үл өрсөлдөх зэрэг нэмэлт нөхцөлийг харилцан тохиролцож хөдөлмөрийн гэрээнд тусгах, эсхүл эдгээр асуудлаар хөдөлмөрийн гэрээнд дагалдах тусгайлсан гэрээ байгуулж болно. Мөн 14.4. Нийгмийн хоёр талт түншлэлийн хүрээнд дараах баримт бичгийг байгуулж болно:

14.4.1.салбар, салбар дундын хамтын хэлэлцээр;

14.4.2.хамтын гэрээ;

14.4.3.хууль тогтоомжид заасан бусад. /...байгуулж болно гэсэн заалт-19/

⁵⁰ Хөдөлмөрийн тухай хууль. 74.2. Аж ахуйн нэгж, байгууллагын нууц хадгалах, нууцтай харьцах журмыг ажил олгогч баталж болно.

⁵¹ Хөдөлмөрийн тухай хууль. 82.3. Хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээрээр энэ хуулийн 82.1, 82.2-т заасан тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэн олгохоор тогтоож болно. Мөн 109.9.Ээлжээр ажилладаг ажилтны ээлж долоо хоногийн амралтын болон нийтээр амрах баярын өдөр таарсан бол энэ хуулийн 109.2, 109.4-т заасан нэмэгдэл хөлс олгохгүй. Харин хамтын гэрээ, хамтын хэлэлцээрээр нэмэгдэл хөлс тогтоож болно. /...тогтоож болно гэсэн заалт-6/

⁵² Хөдөлмөрийн тухай хууль. 100.1. Ажил олгогч ажилтны хүсэлтээр хувийн чөлөө олгож болно.

100.2.Хувийн чөлөө олгох журам, чөлөөний хугацаа, хувийн чөлөөтэй байх хугацаанд олговор олгох эсэхийг хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр зохицуулна. /...олгож болно гэсэн заалт-8/

⁵³ Хөдөлмөрийн тухай хууль. 37.1.Хамтын гэрээгээр зохицуулах харилцааг талууд харилцан тохиролцоо бөгөөд ажилтны хөдөлмөрлөх эрх, хууль ёсны ашиг сонирхолтой холбоотой дараах асуудлыг хамтын гэрээнд тусгаж болно. /ХтХ 37.1.1-37.1.11/

⁵⁴ Хөдөлмөрийн тухай хууль. 107.2. Ажил олгогч, ажилтны төлөөлөгч харилцан тохиролцсон бол цалин хөлсийг аж ахуйн нэгж, байгууллагын болон салбар, салбар дундын түвшинд тус тус хамтын гэрээ, хамтын хэлэлцээрээр зохицуулж болно. Мөн 125.4. Амьжиргааны өртгийн өөрчлөлттэй уялдуулан энэ хуулийн 125.1-д заасан нөхөн төлбөрийн хэмжээг индексжүүлэх асуудлыг хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр зохицуулж болно.

⁵⁵ Хөдөлмөрийн тухай хууль. 9.1. Ажилтан болон ажил олгогч аливаа байгууллага, албан тушаалтнаас зөвшөөрөл авахгүйгээр эрх, хууль ёсны ашиг сонирхлоо төлөөлөн хамгаалах байгууллага байгуулах, чөлөөтэй эвлэлдэн нэгдэх, үйл ажиллагаагаа явуулах, дүрмээ батлах, төлөөлөгчөө сонгох эрхтэй.

⁵⁶ Хөдөлмөрийн тухай хууль. 71.6.Ажил олгогч туслах малчин, гэрийн үйлчилгээний ажилтан, тэдгээртэй адилтгах ажилтантай ажил үүргийн онцлогийг харгалзан ажил, амралтын цагийг энэ хуульд зааснаас өөрөөр харилцан тохиролцож болно. /ХтХ-д 5 заалт байна.

⁵⁷ Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 13 дахь илтгэл. 101 дэхь тал. /Судалгаанд хамрагдсан байгууллагуудын 60 орчим хувь нь хамтын гэрээ, хэлэлцээргүй байв. Энэ нь тэдгээр байгууллагад Үйлдвэрчний эвлэл байхгүйтэй холбоотой юм гэжээ./

зөрчих, ажил олгогч, ажилтан талууд үл ойлголцох, байгууллагын соёлыг бүтээхэд асуудал үүсэх, шууд ба шууд бус ялгаварлан гадуурхалт бий болох зэрэг тус салбарын зарчим агуулгаараа зөрчигдөх, хэрэгжихгүй байх нөхцөл нь болдог.

Тухайн аж ахуй нэгж байгууллагууд үүрэгжүүлсэн болон үүрэгжүүлээгүй хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг хуульд нийцүүлэн бий болгох нь талуудад давуу болон сул талтай байх нь бий. Тухайлбал, Үүрэгжүүлсэн эрх зүйн актын хувьд, 122.1. “Хөдөлмөрийн дотоод журам” нь хэт ерөнхий байх /...бэлгийн дарамтад өртсөн бол байгууллагын хүрээнд хэнд хандах нь тодорхойгүй, өртсөн болон өртүүлсэн ажилтны нууцлал хадгалагдах нь тодорхойгүй байх мөн тухайн байгууллагын ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар ойлгоно...гэх мэт стандарт заалтаар ойлгож болохоор заах, холбогдох журмаар тодорхойлсон үүрэг ...гэх мэт гэж задгай заагдсан байдал зэрэг/, хэт нарийвчилсан байх /...ажлаас чөлөө авахдаа хэнд хандах, хэрхэн мэдэгдэх нь тодорхойгүй байх эсвэл шат дамжлага ихтэйгээр чөлөө авах, ...заавал биеслэн, бичгээр чөлөө авах, чөлөөний хүсэлтийг өөрийн биеэр авчирч өгөх...гэх мэт/ Харин үүрэгжүүлээгүй эрх зүйн актын хувьд, Тухайлбал, ...Хамтын гэрээ...⁵⁸ нь байгууллагад санхүү мөнгөний асуудал үүсгэж болох ч, нийт ажилтнуудын ажлын бүтээмж, тогтвор суурьшил төдийгүй нийгмийн баталгааг хангахад чухал хэрэгсэл нь болдог. Дурьдсан эрх зүйн актууд нь байгууллагуудын хувьд заавал байх, байх нь зохистой учир дурьдлаа. Байгууллагуудын хувьд дотооддоо ямар эрх зүйн актуудыг бий болгох нь харилцан адилгүй байдаг. Энэ нь тухайн байгууллагын бодлого, үйл ажиллагаатай салшгүй холбоотой.

Хөдөлмөр эрхлэлтийн харилцааг зохицуулах хууль тогтоомж нь ерөнхийгөөс тусгайруу чиглэсэн байдаг. Өөрөөр хэлбэл, Хөдөлмөрийн тухай хууль⁵⁹, хөдөлмөрийн дотоод журам⁶⁰, Хамтын гэрээ⁶¹, хөдөлмөрийн гэрээ⁶²...байдлаар харж болно. Эдгээр эрх зүйн баримт бичиг нь хөдөлмөр эрхлэлтийн хүрээнд түгээмэл бөгөөд бусад хөдөлмөрийн дотоод хэм хэмжээний хувьд зохицуулалт нь, чөлөөтэй, нээлттэй юм. Хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд нөхөн болон нарийвчилсан зохицуулалтыг стандарт заалт, үүрэгжүүлсэн болон үүрэгжүүлээгүй эрх зүйн актын хүрээнд зохицуулалт хийхгүйгээр хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбоотой хууль ёсны ашиг сонирхол баталгаатай хангагдах боломжгүйн зэрэгцээ ажил олгогч талд ч эрх зүйн сөрөг үр дагавар үүсгэнэ. Холбогдох хуульд нийцүүлэн гаргасан хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ нь хууль тогтоомжийн хэрэглээний хувьд нарийвчилсан эх сурвалж нь болохыг анхаарах нь зүйтэй.

2. Холбогдох стандарт заалт, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнээс бий болох эрх зүйн үр дагаварыг авч үзэх нь

Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ бий болох эсэхэд нөлөөлдөг үү, эсвэл...гэсэнтэй холбоотойгоор тус харилцаа нь зохицуулалтын аргаа өөрөө тодорхойлдог гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл, Зохицуулалтын тусгай арга нь хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр илэрдэг. Тус хэм хэмжээ нь өмнө дурьдсанчлан стандарт заалт болон үүрэгжүүлсэн, үүрэгжүүлээгүй заалтыг нарийвчлах, нөхөн зохицуулах байдлаар илэрнэ. Хэм хэмжээ нь⁶³ аливаа нэг үйлдэл хийгдэнэ буюу болно гэдгийн илэрхийлэл юм гэснийг өргөн хүрээтэйгээр ойлгох нь чухал байх. Өөрөөр хэлбэл, Хөдөлмөрийн эрх зүйн харилцааны бүтэц /ЭРХ=ҮҮРЭГ=ШААРДАХ ЭРХ=ХАРИУЦЛАГА/-ийг

⁵⁸ Хөдөлмөрийн тухай хууль. 4.1.7. “хамтын гэрээ” гэж тухайн аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны хөдөлмөр эрхлэх, түүнтэй холбогдох эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөдөлмөрийн хууль тогтоомжоор тогтоосон суурь хэм хэмжээнээс дордуулахгүйгээр харилцан тохиролцож ажилтныг илүү таатай нөхцөлөөр хангах, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл, нийгмийн хамгаалалтай холбоотой хуулиар шууд зохицуулаагүй асуудлыг шийдвэрлэхээр ажил олгогч, ажилтны төлөөлөгчийн хооронд байгуулж, зохих журмын дагуу бүртгүүлсэн тохиролцоог; /Энд 2 зорилго агуулагдаж буйг харж болно/

⁵⁹ Монгол улсын нутаг дэвсгэрт хөдөлмөр эрхэлж буй бүхий л субъектэд хамааралтай.

⁶⁰ Зөвхөн тухайн байгууллагын нийт ажилтнуудад хамааралтай. /дэг журмын тогтоох/

⁶¹ Зөвхөн тухайн байгууллагын нийт ажилтнуудад хамааралтай. /хөдөлмөрлөх эрх ашиг, нийгмийн баталгааг хангаж, хамгаалах/

⁶² Зөвхөн ажил олгогч, ажилтанд хамааралтай. /2 субъект хоорондын тухайлсан харилцааг нарийвчилсан зохицуулах/

⁶³ Ханс Кельзен, “Хэм хэмжээний тухай ерөнхий онол”, 2013, 18 дахь тал

Хөдөлмөрийн тухай хуулийн заалтууд нарийвчлагдах, нөхөн зохицуулагдах байдлаар харах нь зүйтэй болов уу. Тухайлбал, ЭРХ=ҮҮРЭГ=ШААРДАХ ЭРХ=ХАРИУЦЛАГА нь Хөдөлмөрийн тухай хууль-Хөдөлмөрийн дотоод журам-Хөдөлмөрийн гэрээ гэх байдлаар уялдаж, нарийвчлагдаж зохицуулагдах ёстой байдаг. Харин практик ажиглагдаж буй нь Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн дотоод журам, Хөдөлмөрийн гэрээний холбогдох заалтууд, түүн дотроо талуудын эрх, үүрэг нь хуулбарлагдсан байдалтай байна. Мөн түүнчлэн Хөдөлмөрийн тухай хуульд хариуцлага нь ерөнхий байгааг холбогдох байгууллага журмаараа нарийвчилж заах хэрэгтэй. Тухайлбал, ямар тохиолдолд хаалттай сануулахыг тодорхой болгосон үед нээлттэй сануулах нь тодорхой болно гэж ойлгож болно. Үндэсний эрх зүйн тогтолцоо, салбар эрх зүй, институт, бүлэг, зүйл, заалт бүгд уялдаа холбоотой, гинжин хэлхээтэй. Р.Дворкиний онолоор хууль тогтоомж хоорондоо цуврал роман шиг холбоотой, цул, бүхэллэг чанартай аж. Тийм учраас энэ тогтолцоо, гинжин холбоонд нь аливаа эрх зүйн хэм хэмжээг авч үзэж, бүрхэг утгыг нь тодруулж, хөдөлгөөнгүй нэгдмэл утгыг батлах ажиллагаа юм. Хэрэв тухайн хэм хэмжээний уялдаа холбоо тодорхойгүй, бүрхэг байсан ч шүүгч уг хэм хэмжээний тогтолцооны мөн чанар, агуулгад тулгуурлан тайлбарладаг.⁶⁴ гэжээ. Өөрөөр хэлбэл, байгууллагад мөрдөгдөж буй хөдөлмөрийн хэм хэмжээ тогтоосон акт болох дүрэм, журам, гэрээ зэрэг нь суурь хуультайгаа уялдсан, холбогдох харилцааны мөн чанарыг ойлгосон байх нь чухлыг илэрхийлжээ гэж үзэж болохоор байна.

Хөдөлмөр эрхлэлтийн харилцааг ерөнхий хуульд нийцүүлэн нөхөн болон нарийвчилсан байдлаар зохицуулж болох стандарт заалт, үүрэгжүүлсэн болон үүрэгжүүлээгүй хөдөлмөрийн дотоод хэм хэмжээний талаар өмнөх хэсэгт авч үзсэн. Эндээс холбогдох заалтуудын талаар авч үзвэл, Хөдөлмөрийн тухай хуульд заагдсан үүрэгжүүлсэн баримт бичгийн нэг болох “Ажлын байрны дарамт, бэлгийн дарамтаас сэргийлэх,⁶⁵ таслан зогсоох, арилгах, холбогдох гомдлыг хүлээн авч шийдвэрлэх журам”-ыг тухайлсан байдлаар авч үзье. Энэ асуудал нь байгууллагын ёс зүйн зөвлөлийн онцгой харьяалалд байх төдийгүй холбогдох асуудлын талаар эрсдлийн үнэлгээ хийх, хүний хувийн мэдээллийг хамгаалах асуудлын хүрээнд, гомдол гаргагчийн нууцлалыг хадгалах бөгөөд хуульд зааснаас бусад тохиолдолд болон өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр бусдад задруулахгүй байх, тухайн ажилтны амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдал, хувийн нууц, нэр төрд халдсан мэдээ, мэдээллийг аливаа хэлбэрээр түгээхийг хориглох, гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байх хугацаанд хүчирхийлэлд өртсөн гомдол гаргагчийг хамгаалах механизмыг материаллаг болон процессийн хэм хэмжээг тодорхой болгож ажиллах нь ажил олгогчийн хуульд заасан үүрэг юм. Тапан Мишра НҮБ-ын Суурин төлөөлөгч /2022/, Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүнтэй холбоотой гомдлыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын хүрээнд хянан шийдвэрлэх талаарх арга зүйн зөвлөмж /2020/-д ажлын байран дахь бэлгийн дарамт, хүчирхийлэлд өртсөн тухайгаа ярьж мэдээлэх нь хүнд сэдэв тул энэ төрлийн зөрчил, гэмт хэргийн бүртгэгдсэн байдал бодит байдлаас бага байдаг. Учир нь мэдээлэл өгсөн этгээдийг хамгаалах эрх зүйн зохицуулалт сул байдагтай холбоотой. Мөн ажлын байран дахь дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтын талаар Монгол улсад хууль, эрх зүйн зохицуулалт хангалттай байдаг ч хэрэгжилт хангалтгүй хэвээр байгааг иргэд, олон нийт, төр, төрийн бус байгууллага, судлаач, шинжээчид анхааруулсаар байна гэжээ. Эндээс “Ажлын байрны дарамт, бэлгийн дарамтаас сэргийлэх, таслан зогсоох, арилгах, холбогдох гомдлыг хүлээн авч шийдвэрлэх журам”-ыг хэлбэрийн бус, агуулгын зохицуулалтыг сайжруулах шаардлагатайг анхаарах хэрэгтэй.

⁶⁴ Н.Лүндэндорж, “Хууль тайлбарлан хэрэглэх онол, арга зүй”, Шүүх эрх мэдэл сэтгүүл, №1 (2015), 7 дахь тал.

⁶⁵ Монгол Улсын “Жендрийн эрх тэгш байдлыг хангах тухай” хуулийн хэрэгжилтийг тандан судлаж, “Ажлын байрны бэлгийн дарамт”-ын талаархи төсөл. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаархи 18 дахь илтгэл. 2019, ХЭҮК /Е.Болормаа /холбогдох төсөлд хамтран ажилласан болно/

Түүнчлэн Монгол Улсын хууль тогтоомжид ажлын байрны дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтыг зохицуулсан байдлын зөрчлийг онолын үүднээс ялгаж таних нь чухал. Энэ төрлийн хэрэг цөөн бүртгэгддэг шалтгаан нь тухайн хүний хувийн мэдээлэл, түүний нууцлалтай холбоотой⁶⁶ бөгөөд хохирогчид ажлаас халагдахаас, тушаал бууруулахаас, ойр дотныхон нь энэ талаар олж мэдэхээс сэтгэл нь зовж, тухайн зөрчлийн талаар мэдээлдэггүй байна.⁶⁷ Мэдээлдэг болгоход хууль зүйн материаллаг төдийгүй процессын эрх зүйн орчныг ажил олгогчийн зүгээс бий болгох нь чухал. Өөрөөр хэлбэл, ...дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтын талаар ялган зохицуулах, маргаан гарсан тохиолдолд хэнд хандах, хэд хоногийн дотор хэрхэн шийдвэрлэх зэрэг нь тодорхой байх. Холбогдох асуудлын хүрээнд эрх зүйн зохицуулалт нь, Монгол улсын олон улсын холбогдох гэрээнүүд, олон улсын конвенц, түүнчлэн Монгол улсын Хөдөлмөрийн тухай хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хууль болон “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” засгийн газрын тогтоол зэрэгт ажлын байрны бэлгийн дарамтын талаар тусгажээ. 2021 онд Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Ажлын байрны бэлгийн дарамтын мэдлэг, хандлага болон тархалтын байдлын судалгаа”-гаар дийлэнх ажиллагсад АББД-ын талаар мэдлэг багатай буюу юуг бэлгийн дарамт гэж ойлгох, эрх зүйн зохицуулалтуудын талаар мэдлэг, мэдээлэл хангалтгүй байна.⁶⁸ гэжээ.

АНУ-ын Иргэний эрхийн Акт (1964)-ийн 7-р хэсэгт ажлын байранд хүнийг яс үндэс, арьсний өнгө, шашин шүтлэг болон хүйсээр нь ялгаварлан гадуурхахыг хориглодог⁶⁹. Үүнд хүйсэнд суурилсан дарамт хүчирхийлэл нь холбогдох хэсгийн 703-ийг зөрчсөн үйлдэл буюу хууль зөрчсөн үйлдэл хэмээн тодорхойлжээ.⁷⁰ АНУ-ын 1974 оны Нууцлалын Акт⁷¹-аар хувь хүний нууцыг хамгаалдаг. Гэхдээ практикт⁷² ажил олгогч болон ажилтан хоёрын бэлгийн дарамттай холбоотой асуудлыг нууцлалын гэрээгээр зохицуулах тохиолдолд ч байдаг ажээ.⁷³ Энэхүү нууцлалын гэрээ хохирогчийн мэдээллийг нууцлах, хохирогчид мөнгөн болон бусад хэлбэрээр дэмжлэг үзүүлэх зэргээр сайн талууд байж болох ч ⁷⁴ бэлгийн дарамт үйлдэгчийн үйлдлийг нуун дарагдуулах, цаашид гарах энэ төрлийн хэргийг өдөөх сөрөг талтай.⁷⁵ гэж үзсэн байна. Төрийн захиргааны албан хаагчдын дунд ажлын байрны бэлгийн дарамтад өртсөн тохиолдолд гомдол гаргаж, асуудлаа шийдвэрлүүлэх талаарх ойлголт, хандлагыг тодорхойлох зорилготой “Төрийн захиргааны албан хаагчдын ажлын байрны бэлгийн дарамтын мэдлэг, хандлага, зан үйлийн төлөв байдлын судалгаа”⁷⁶-гаар нийслэл, орон нутгийн төрийн захиргааны байгууллагын 3000 орчим эмэгтэй албан хаагчийг хамруулжээ. Судалгаанд хамрагдсан дөрвөн хүн тутмын нэг нь “Ажлын байрны бэлгийн дарамтад нэг болон түүнээс удаа өртдөг, өртөж байсан” гэж хариулсан нь энэ төрлийн дарамтын эсрэг хууль зүйн нарийвчилсан зохицуулалт шаардлагатайг

⁶⁶ Dobbin, Kalev 2020

⁶⁷ Johnson et al 2016

⁶⁸ ТАЗ-ын судалгаа 2021

⁶⁹ АНУ-ын Тэгш хөдөлмөрлөх боломжоор хангах Комисс 2022

⁷⁰ Холбооны дүрмийн Код 2016

⁷¹ Privacy Act, 5 U.S.C. § 552a

⁷² 2017 онд олон нийтийн анхаарлыг АББД, бэлгийн дарамт сэдэвт хандуулж өгсөн үйл явдал бол АНУ-ын кино продюссер, Мирамакс компаний үүсгэн байгуулагч Харви Вейнштейнтэй холбоотой бэлгийн дарамт, хүчин, бэлгийн мөлжлөгтэй холбоотой хэрэг юм. Шүүхээс түүнийг гэм буруутгайд тооцон 23 жилийн хорих ял өгсөн ба энэ үйл явдалаас улбаалан олон алдартан, бизнесменүүдийн бэлгийн дарамттай холбоотой асуудлууд ил болжээ.

⁷³ Altman 2020

⁷⁴ Martin 2017

⁷⁵ Altman 2020

⁷⁶ Нэгдсэн Үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилтээр Төрийн албаны зөвлөлөөс хэрэгжүүлж байгаа “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийн хүрээнд Хүний эрхийн Үндэсний Комисс “Нийгмийн бодлого, хөгжлийн судалгааны хүрээлэн” ТББ-тай хамтран гүйцэтгэсэн судалгааны тайлан, 2021 он.

илэрхийлжээ гэж үзэж болохоор байна. Өөрөөр хэлбэл, Хөдөлмөрийн тухай хуулинд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамттай холбоотойгоор ажил олгогчийг үүрэгжүүлсэн хэдий ч хөдөлмөрийн дотоод журмын тодорхой нэг заалтаар хязгаарлагдан зохицуулагдаж байгаа нь нарийвчилсан зохицуулалт бий болгожээ гэж үзэх боломгүй юм. Үүний цаана мөн л зөрчил гарсаар, эрх нь зөрчигдсөн хэвээр байх нөхцөл нь бүрдсээр байхыг үгүйсгэхийн аргагүй юм.

1998 онд Испаний худалдаа, үйлдвэрчний эвлэлээс зохион байгуулсан Пандора төслийн хүрээнд Испани, Ирланд, Швед улсууд дахь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ажлын байрны нөхцөл байдал, бэлгийн дарамттай холбоотой судалгаа хийсэн нь олон төрлийн ажил, ялгаа бүхий албан тушаалтай хүмүүсийг хамарсан томоохон судалгаа болсон төдийгүй энэхүү судалгаагаар бэлгийн дарамттай холбоотой хэргүүдийн үндэс суурь нь байгууллагын соёл, ёс зүйн дүрэм, урамшууллын системтэй холбоотой бөгөөд хууль, журмууд нь дангаараа асуудлыг шийдэхгүй байна гэсэн дүгнэлт гарчээ. Түүнчлэн уг төслийн дүгнэлтэд Хөдөлмөрийн тухай хууль, Зөрчлийн болон Эрүүгийн хууль тогтоомжийг эхлэн харахаасаа өмнө байгууллага нь өөрийн дотоод дүрэм, журмаараа АББД-аас урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авах нь илүү үр дүнтэй гэжээ.⁷⁷ Ийнхүү Монгол улсын хувьд ч хөдөлмөр эрхлэлтийн харилцааны хүрээнд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамттай холбоотой материаллаг болон процессын нарийвчилсан хэм хэмжээг бий болгох хэрэгтэйг дахин дурьдах нь зүйтэй болов уу.

Мөн түүнчлэн Хөдөлмөрийн тухай хуулийн стандарт заалт, үүрэгжүүлсэн болон үүрэгжүүлээгүй заалтууд нь тус харилцааны онцлогтой холбоотойгоор уул уурхайн салбарын хүрээнд ч хуульчлагдсан үүргийнхээ хүрээнд үйлчилнэ.

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар Уул уурхайн салбартай⁷⁸ холбоотой тусгайлсан стандарт заалт нь уртын ээлжээр ажиллуулах /ХтХ-нд ажлын өдрийн үргэлжлэл 12 цагаас илүүгүй байх, илүү цагийг тооцож нэмэгдэл хөлс олгоно. Нэг ээлжид ажил үүрэг гүйцэтгэх хугацаа 14 хоног, амрах хугацаа 14 хоног байна. Тус хугацааг багасгах тохиолдолд ажил үүрэг гүйцэтгэх, амрах хугацаа нь тэнцүү байхаар ажил олгогч, ажилтны төлөөлөгч харилцан тохиролцож болно. Мөн түүнчлэн аяллын цаг, аяллын зардалтай холбоотойгоор уртын ээлжээр ажиллах ажилтны заасан байршил бүхий газраас ажилдаа ирэх, буцах зардлыг ажил олгогч хариуцна. Уртын ээлжээр ажиллах ажилтны ажил, амралтын цагийн горим, уртын ээлжээр ажилласны нэмэгдэл зэргийг хамтын гэрээ, салбарын хамтын хэлэлцээрээр тогтооно. Насанд хүрээгүй хүнийг уртын ээлжээр ажиллуулахыг хориглоно/ зохицуулалт юм. Тус салбарын хөдөлмөр эрхлэлтийн хүрээнд хуулийн зарим зохицуулалттай холбоотой хэрэгжилтийг авч үзвэл, 1999 оны Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу компаниуд гол төлөв 2/1, 3/2, 4/2, 5/3 гэсэн харьцаагаар уурхайд ажиллах болон гэртээ амрах хоногуудыг зохицуулсан уртын ээлжийн хуваарь хэрэгжүүлдэг байсан бол шинэчилсэн хөдөлмөрийн тухай хуулийн 14/14 гэсэн заалтаар уртын ээлжийн хуваарийн дагуу нэг ажилтны уурхайд ажиллах хугацаа багасаж, ажлын цаг буурсан байна. Уртын ээлжийн хуваарийг хүснэгтээр жишээ болгон харуулвал,

⁷⁷ Chappell & Martino 2006

⁷⁸ Хөдөлмөр эрхлэлтийн салбарт 2020 оны 4-р улирлын байдлаар нийт 1,124.6 мянган иргэн ажиллаж байснаас уул уурхайн салбарт 44,3 мянган иргэн, 2021 оны 3-р улирлын байдлаар нийт хөдөлмөр эрхлэгч 1,135.6 мянга байснаас 57,8 мянга нь уул уурхайн салбарт, 2021 оны 4-р улирлын байдлаар нийт 1,127.1 мянган иргэн ажиллаж байснаас 5% буюу 56,2 мянган иргэн нь уул уурхайн салбарт ажиллаж байсан статистик судалгаа байна. [BookLibraryDownload.ashx \(1212.mn\)](#)

Уртын ээлж	ХТХ /2022/	ХТХ /1999/							
	14/14	2/1	Өөрчлөлт	3/2	Өөрчлөлт	4/2	Өөрчлөлт	5/3	Өөрчлөлт
Нэг уртын ээлжинд ажиллах хоног	14	14		21		28		35	
Нэг уртын ээлжинд амрах хоног	14	7		14		14		21	
Нэг уртын ээлжинд зарцуулах нийт хоног	28	21		35		42		56	
Нэг жилд ажиллах уртын ээлж /тоогоор	13	17	(4)	10	3	9	4	7	7
Нэг жилд ажиллах өдөр	183	243	(61)	219	(37)	243	(61)	228	(46)
Нэг жилд амрах хоног	183	122	61	146	37	122	61	137	46

Эндээс ажилтнуудын уурхайд ажилладаг өдөр 37-61 хоногоор багасаж, ажилтны амрах хугацаа нэмэгдсэн сайн тал ажиглагдаж байна. Гэсэн хэдий ч энэ нь цалин хөлсөнд хэрхэн нөлөөлснийг авч үзвэл, Уул уурхайн салбарын уртын ээлжээр ажилладаг ажилтнуудад дараах төрлийн нэмэгдэл хөлс байдаг. Тухайлбал, Хээрийн нэмэгдэл, /уртын ээлжийн нэмэгдэл/ хөдөлмөрийн нөхцөлийн, хоолны, аялалын /ирэх, буцах/, тээврийн, ажилласан жилийн, ур чадварын, шөнийн ээлжийн зэрэг.

Эдгээрээс холбогдох нэмэгдлүүд нь ажилтны уурхайд ажиллах хоногт харгалзаж тооцогддогыг харгалзан цалин хөлсний бууралтыг ерөнхийд нь харж болох юм.

Уурхайд ажиллах хоногийн бууралт	37	61
Уурхайд ажиллах хоногийн бууралт хувиар	10%	17%
Хээрийн нэмэгдлийн бууралт (30% тооцов)	3.04%	5.01%
Хэвийн бус нөхцлийн бууралт (30% тооцов)	3.04%	5.01%
	6.22%	26.74%

Уурхайд ажиллах хоног багасахтай холбоотой ажилтнуудын цалин хөлс ойролцоогоор 16%-27% буурсан байдлыг харж болно. Мөн түүнчлэн Уурхайн ажил тасалдалгүй явагддаг тул нэг уртын ээлжнээс бууж буй ажилтан уртын ээлж хүлээж авч байгаа ажилтандаа ажлаа хүлээлгэж өгөх 1 өдрийн давхцалын хугацаа байдаг. Шинэчилсэн хөдөлмөрийн тухай хуулиар ирэх, буцах хоногийг ажлын 14 хоногтоо оруулснаар, уурхайн байрладаг аймаг, хотоос бусад аймаг, хотоос ирж ажилладаг ажилтныг 14 хоног амраахын тулд ажил хүлээлцэх хугацаа, аяллын хугацаа хоёрыг 14 хоногтоо багтаах боломжгүй, ажилтан заавал илүү цагаар ажиллах эсвэл амралтын 14 хоногоос хасах шаардлагатай болж байна. Хүснэгтэнд харуулснаар ирэх, буцах хоног, ажил хүлээлцэх хоногийг ажлын 14 хоногтоо багтааж оруулснаар ажилтан 14 хоног амрах боломжгүй, амрах хугацаа 10 хоног болж байна. Тиймээс энэхүү 14/14 гэдэг хуваарийг уурхайд ажилладаг, тухайн аймаг, хотод амьдардаг ажилтнуудаас бусад аймаг, хотод амьдардаг ажилтнуудад хэрэгжүүлэхэд хүндрэлтэй гэж үзэж болохоор байна. Мөн уртын ээлжийн 14/14 хуваарьт монгол, гадаад ажилтны эрх зүйн ялгаатай зохицуулалт үгүй тул уурхайн компанид ажилладаг гадаад ажилтнууд мөн тус хуваариар ажиллана гэж харж болно. Гадаад ажилтнууд монгол ажилтнуудтай харьцуулахад нисэх онгоцоор Монгол улсад ирэх, буцахдаа монгол ажилтнуудаас илүү олон цагийг зарцуулдаг зэрэг. Манай улсад 2021 оны 4 дүгээр улирлын эцэст гадаадын 77 улсын 5.6 мянган иргэнхөдөлмөрийн гэрээгээр ажиллаж мөн сайн дурын ажил хийж байна⁷⁹. Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэдийг ажиллаж буй салбараар харвал, Гадаад иргэдийн 36.1% нь уул уурхай, олборлох салбарт ажиллаж байна. Уул уурхайн салбарын гадаад ажилтнууд ихэвчлэн 4/2, 5/3

⁷⁹ BookLibraryDownload.ashx (1212.mn), Immigration

хуваариар ирж ажилладаг нь зардал нэмэгдэх шалтгаан нь болохыг үгүйсгэх боломжгүй юм.

Дүгнэлт, Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь нэлээд өргөн хүрээнд үүсэж, өөрчлөгдөж, дуусгавар болж байдаг. Үүнтэй холбоотойгоор, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, хөдөлмөр эрхлэлтийн харилцааг тусгайлан зохицуулсан бусад хууль мөн түүнчлэн хөдөлмөр эрхлэлтийн салбарт улсын хэмжээнд дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон акт, тухайн байгууллага дотооддоо дагаж мөрдөх дүрэм, журам, гэрээ зэрэг хэм хэмжээ тогтоосон актууд бий. Хөдөлмөрийн тухай хууль нь суур хэм хэмжээг бий болгож, хөдөлмөр эрхлэлтийн харилцааг ерөнхий байдлаар зохицуулдаг ч, байгууллага бүр нарийвчилж, нөхөж зохицуулах хууль зүйн шаардлага, боломж нь “Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ бий болох эсэхэд нөлөөлдөг үү, эсвэл...” гэдэгтэй холбоотойгоор ойлгогдоно.

Тус илтгэлийн нэгдүгээр асуудлын хүрээнд, Хөдөлмөрийн тухай хууль дахь холбогдох заалтууд нь стандарт заалт, үүрэгжүүлсэн болон үүрэгжүүлээгүй хэлбэрээр хуульчлагдсаныг “дүрмийн” болон “дүрмийн бус” хэмээн үзэж болохоор байгааг авч үзлээ. Харин энэхүү асуудалтай холбоотойгоор илтгэлийн хоёрдугаар асуудлыг авч үзэхдээ, практикт байгууллагуудад хөдөлмөрийн хуулийн холбогдох заалтуудыг хэрэглэхдээ нийтлэг үүсдэг асуудал болон зарим тухайлсан салбарт хөдөлмөрийн хуулийн холбогдох заалтуудын хэрэгжилт ямар байгааг тухайлан авч үзсэн болно. Энэхүү судалгаагаар авч үзсэн асуудлуудыг холбогдох хуулийг хэрэгжүүлэгч хэн боловч анхаарах нь зүйтэй болов уу. Хөдөлмөрийн тухай хуулийн зорилт, заалтуудын зорилгыг зөв ойлгож, хэрэгжүүлэхэд л асуудлын чухал нь байна.

ЭХ СУРВАЛЖ

Хууль тогтоомж

1. Хөдөлмөрийн тухай хууль, 2022.

Ном, өгүүлэл, судалгааны тайлан

1. Ханс Кельзен, Хэм хэмжээний тухай ерөнхий онол, 2013, 18 дахь тал.
2. Н.Лүндэндорж, “Хууль тайлбарлан хэрэглэх онол, арга зүй”, Шүүх эрх мэдэл сэтгүүл, №1 (2015), 7 дахь тал.
3. Б.Уранцэцэг, Аж ахуй нэгж байгууллагад тогтоогдон үйлчлэх хэм хэмжээ /дотоод хэм хэмжээ/ түүнийг хөдөлмөрийн маргааныг шийдвэрлэхдээ шүүх хэрэглэж буй практик, Шүүх эрх мэдэл сэтгүүл, №4, 2017.
4. Ё. Болормаа, “Хөдөлмөрийн хууль тогтоомж ба хөдөлмөрлөх эрхийн зарим асуудал”, Хууль дээдлэх ёс, №4 (2018), 89 дэх тал.
5. Ё.Болормаа, “МУ-ын хөдөлмөрийн тухай хуулийн зорилт ба хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэглээ”, Хууль дээдлэх ёс №1 (2023), 92 дахь тал.
6. Монгол улсын “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай” хуулийн хэрэгжилтийг тандан судлаж, “Ажлын байрны бэлгийн дарамт”-ын талаархи төсөл. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаархи 18 дахь илтгэл. 2019, ХЭҮК /Ё.Болормаа холбогдох төсөлд хамтран ажилласан болно/
7. Chappell & Martino 2006.
8. Johnson et al 2016.
9. Холбооны дүрмийн Код 2016.
10. Martin 2017.
11. Altman 2020.
12. Dobbin, Kalev 2020.
13. Төрийн албаны зөвлөлийн судалгаа 2021.

14. Privacy Act, 5 U.S.C. § 552a.
15. АНУ-ын Иргэний эрхийн Акт (1964)-ийн 7-р хэсэг.
16. Нэгдсэн Үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилтээр Төрийн албаны зөвлөлөөс хэрэгжүүлж байгаа “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийн хүрээнд Хүний Эрхийн Үндэсний Комисс “Нийгмийн бодлого, хөгжлийн судалгааны хүрээлэн” ТББ-тай хамтран гүйцэтгэсэн судалгааны тайлан, 2021.
17. АНУ-ын Тэгш хөдөлмөрлөх боломжоор хангах Комисс 2022.
18. BookLibraryDownload.ashx (1212.mn), Immigration.

LEGAL CONSEQUENCES OF STANDARD PROVISIONS, MANDATORY AND NON-MANDATORY NORMS OF THE LABOR LAW

Bolormaa.Yo

Ph.D student, Lecturer at the Department of Private Law, Shihihutag University

ABSTRACT:

Almost a year has passed since the revised version of the Labor Law came into effect. Researching provisions of the law dividing into standard, mandatory, and non-mandatory provisions can be important for determining the purpose, legal possibilities, legal obligations, features, and consequences of the relevant provisions of the Labor Law.

In the employment relationship, the employer and employee parties have the legal requirement and opportunity to approve the internal labor regulations of the organization under the basic norms and principles of the labor legislation in order to complementarily or in detail regulate matters that are not explicitly outlined in the law.⁸⁰

In this research, the practical implementation of standard, mandatory, and non-mandatory provisions of internal labor regulations in legal entities and organizations, and its legal consequences will be also considered.

KEYWORDS:

Internal labor norms⁸¹, administrative normative acts, internal labor regulations, standard provisions⁸², mandatory and non-mandatory norms⁸³, complementary regulations, in detail regulations⁸⁴

⁸⁰ Section 4.1.10 of the Labor Law determines that “internal labor norms” means a written document issued by an employer on labor and social protection matters pursuant to the relevant legislation, collective agreement, and collective bargaining to observe internally at a legal entity or organization. In other words, internal labor norms are the general formulation of the rules that apply to the organization and it is considered that it includes the internal labor regulations of the organization.

⁸¹ Section 4.1.10. of the Labour Law of 2022 states “internal labor regulations” means a written document issued by an employer on the labor and social protection matters pursuant to the relevant legislation, collective agreement and collective bargaining to observe internally at a business entity or organization;

⁸² It is illustrated by provisions that set the maximum and minimum requirements.

⁸³ Mandatory norms are provisions that formulate obligatorily binding actions in the Labor Law, while non-mandatory norms are provisions that offer opportunities to the parties. It can be understood that non-mandatory norms are provisions of the law in which the parties can regulate employment relationships based on their collective bargaining or mutual negotiation.

⁸⁴ In connection to the specific employment relationship, some provisions of the Labor Law can be regulated in detail by the parties, or some additional regulations can be set by parties to complement when some matters are not explicitly outlined in the law.

ДАРАГДМАЛ ҮНЭТ ЗҮЙЛ БОЛОН ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН УЛАМЖЛАЛ



Ч.Доржсүрэн

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн докторант

ТОВЧЛОЛ:

Энэхүү өгүүллээр Монгол Улсын үе үеийн иргэний хуулийн дарагдмал үнэт зүйл болон түүх, соёлын дурсгалт зүйлтэй холбоотой зүйл, заалтуудыг харьцуулан судалж, тэдгээрийн онцлог, ялгаатай болон ижил төстэй байдлыг дүгнэн тодорхойлсон бөгөөд давуу тал бүхий зарим зохицуулалтыг одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Иргэний хуульд тусгах саналыг дэвшүүллээ. Соёлын биет өвийн өмчлөлтэй холбоотой иргэний эрх зүйн харилцааг Соёлын өвийг хамгаалах хуулийн хэм хэмжээтэй уялдуулан зохицуулах нь оновчтой гэж үзсэн болно.

ТҮЛХҮҮР ҮГС:

Дарагдмал үнэт зүйл, өмч, түүх, соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор.

УДИРТГАЛ

Иргэний эрх зүйн хэм хэмжээ нь эдийн болон эдийн бус баялагтай холбоотой нийгмийн харилцаанд оролцогчид эрх тэгш байх боломжийг олгодог ч төр ба иргэний “статус”¹-аас эд хөрөнгө өмчлөх эрх үүсэх, дуусгавар болох хэд хэдэн тохиолдолд харилцан адилгүй байдаг. Төр нь зарим төрлийн эд юмсын өмчийн эрхийг олж авах... онцгой эрх эдэлдэг.² Тухайлбал, эзэн нь тодорхойгүй, нийтийн зориулалттай эд зүйл (нийтийн зориулалттай төрийн өмчлөлийн зүйлд ...түүх соёлын үнэт зүйл, хөшөө дурсгал, археологи, палеонтологийн олдвор зэрэг хуулийн тусгайлсан хамгаалалт, зохицуулалтад байдаг зүйлс болон төрийн захиргааны ба орон нутгийн өөрөө удирдах байгууллагын хяналт, эзэмшилд нийтийн зориулалтаар ашигладаг зүйлс орно.³)-ийн өмчлөлд төр давуу

¹ Статус (лат. status; англ.status) – хууль тогтоомжид заасан эрх ба үүргийн нийлбэр цогцоор тодорхойлогдох иргэн, хуулийн этгээд, улс, тодорхой нутаг дэвсгэрийн эрх зүйн байдал. С.Нарангэрэл. Монголын эрх зүйн эх толь бичиг. 4 дэх хэвлэлт. Уб, 2015. 382-383 дахь тал.

² О.Жамбалдорж, Ж.Амарсайхан нар. Монгол Улсын иргэний эрх зүй /эд баялагийн эрх, оюуны өмчийн эрх/ II дэвтэр. Уб., 2006. 98 дахь тал

³ Ц.Цэрэнпэлжээ. Өмчийн эрх зүй (Онол, практикийн асуудалд). Уб., 2000. 116 дахь тал.

эрхтэй. Түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байх⁴ тул төр нь ард түмэн, улс орны өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхдээ соёлын өвийг ямар нэг хязгаарлалтгүй өмчилнө. Гэхдээ иргэдийн өмчлөх эрхэд ёс бусаар халдахгүй ба төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө.⁵

Монгол Улсын Иргэний хуульд өмчлөгчийг буюу эрх бүхий этгээдийг тогтоох боломжгүй болтол удаан хугацаагаар газарт булагдсан, эсхүл дарагдаж орхигдсон үнэт зүйл /дарагдмал үнэт зүйл/ дотор түүх, соёлын дурсгалт зүйл байвал тэдгээрийг төрийн өмчлөлд шилжүүлж, олдсон газрын буюу эд хөрөнгийн өмчлөгч болон эд юмсыг олсон этгээдэд түүний үнийн дүнгийн 50 хувьтай тэнцэх мөнгөн шагналыг тэнцүү хувааж олгох⁶ зохицуулалт бий. Энэ нь төрийн чиг үүрэг, түүх, соёлын дурсгалт зүйлийн шинжлэх ухааны ач холбогдол, иргэний өмчлөх эрхийн огтлолцол дээрх нийгмийн “өвөрмөц” харилцаа юм. Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд хөдөө, орон нутаг /Говь-Алтай, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Ховд, Хэнтий аймаг/-т малаа хариулж явахдаа олсон ховор олдвор, түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйлийг Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, музейд хүлээлгэн өгч шагнал авсан тохиолдол хэд хэд гарчээ.⁷ Тэднийг соёлын өвийг сурвалжлан олсон, нээлт хийсэн, соёлын өвийн сан хөмрөгийг баяжуулах, авран хамгаалахад идэвх санаачилгатай ажилласан, эсхүл иргэний хуульд заасан үүргээ биелүүлсэн зэрэг үндэслэлээр мөнгөн шагнал олгосон байх юм. Холбогдох байгууллагын нарийн бүртгэл, судалгаа одоогоор алга байна.

Түүх, соёлын дурсгалт зүйлийг хаанаас олох нь хамаагүй, өмчлөгч иргэн, байгууллага тодорхой бус, тогтоох боломжгүй бол төрийн өмч гэж үзнэ. Гэтэл нийтийн эзэмшил, өөрийн болон бусдын өмчлөл дэх нутаг дэвсгэр (газрын хөрс, агуй, хадны завсар, барилга, байшингийн аль нэг хэсэг гэх мэт)-ээс түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг олсон иргэд хуулийн зохицуулалтыг мэддэггүйгээс, эсхүл шунахайн сэдэл, сонирхлоор завших, бусдад, ялангуяа эртний эдлэлийн худалдаачдад зарахыг илүүд үзэх нь олонтоо. Иргэний хуулийн 118 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг үл биелүүлэх нь соёлын биет өвийг завших гэмт хэрэгт хүргэх бөгөөд цаашдаа төрийн соёлын өвийн хамгаалалтыг сулруулж, олон нийтийн дунд хууль бус үйлдэл, хандлагыг дэлгэрүүлэх сөрөг үр дагавартай. Хуулийн хэрэгжилтийг хангах, үр нөлөөг дээшлүүлэхийн тулд олон нийтэд сурталчлан таниулахын зэрэгцээ зохицуулалтын үүсэл, уламжлалыг мэдэж, онцлог зарим хэм хэмжээг сэргээн ашиглаж болно. Ингээд Ардын хувьсгалаас өмнөх үеийн хууль цаазын бичиг, үе үеийн иргэний хуулиудад дарагдмал үнэт зүйлтэй холбоотой асуудлыг хэрхэн зохицуулж ирснийг судлан үзье.

ҮНДСЭН ХЭСЭГ

Монголын уламжлалт хууль цаазын эх сурвалжуудыг авч үзвэл аливаа эрхийн харилцааг эрүү, иргэн, захиргаа гэх мэтээр өнөөгийнх шиг ангилан ялгалгүй, харин нэг дор хамтатган бичээнийг харж болно. Нэн ялангуяа иргэний эрх зүйн харилцааг зан заншлаар голчлон зохицуулж байсан бөгөөд аажимдаа хуулиар зохицуулах болжээ.⁸ Их засаг хууль, Алтан хааны цааз, Үйсэн цаазууд, 1640 оны Их цааз, Монгол цаазын бичиг, Халх журам, Зарлигаар тогтоосон Гадаад Монголын төрийг засах явдлын Яамны хууль зүйлийн бичиг, Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйн бичиг зэрэгт иргэний эрхийн холбогдолтой заалтууд нэлээдгүй байдаг. Анхны төрөлжүүлэн нэгтгэсэн Иргэний хуулийг 1926-1929

⁴ Монгол Улсын Үндсэн хуулийн Долдугаар зүйлийн 1 дэх хэсэг. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 1992, №1.

⁵ Мөн тэнд. Арван зургадугаар зүйлийн 3 дахь хэсэг.

⁶ Монгол Улсын Иргэний хуулийн 118 дугаар зүйл. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2002, №7.

⁷ “Түүх соёлын үнэт олдвор олсон иргэдийг шагналаа” нийтлэл. <https://news.mn/r/91276/>, “М.Алтантүлхүүрт 14 сая төгрөгийн урамшуулал олгоно” нийтлэл. <https://news.mn/r/621112/>, “Археологийн олдвор хүлээлгэн өгсөн иргэдэд талархал илэрхийлэв” нийтлэл. <https://montsame.mn/mn/read/49097/>.

⁸ З.Сүхбаатар, Б.Батбаяр нар. Монгол Улсын Иргэний хууль тогтоомж (түүхэн эмхэтгэл) 1206-2012. Уб, 14 дэх тал.

онд боловсруулан баталснаас хойш 1952, 1963, 1994, 2002 онуудад шинэчлэн найруулж, тодорхой цаг үеүдэд холбогдох нэмэлт, өөрчлөлтүүдийг хийсээр өнөөг хүрчээ.

“Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйн бичиг”-ийн “Янз бүрийн гэмт хэрэг” хэмээх жаран тавдугаар дэвтэрт: Газарт булсан хуучны багаж, хонх, хэлтрэг, бичиг баримт, тамга зэргийг олсон этгээд 30 хоногийн дотор мэдэгдээгүй бол 80 ташуур занчихаар зааж, газар булсан юмны эзэн нь олдохгүй бол ухаж гаргасан этгээдийг эзэмшигч гэж үзээд дээрх зүйлсийг 30 хоногийн дотор мэдэгдэх шаардлагатайг тайлбарт⁹ дурджээ. Энэ дагуу газарт булаатай нэрлэн заасан эртний эдлэлийг¹⁰ ухаж гаргасан этгээд эзэн нь олдоогүй тохиолдолд эзэмшигч болох бөгөөд тогтоосон хугацаанд яам, тамгад мэдэгдэх ёстой. Хуучны багаж, хонх, хэлтрэг, бичиг баримт, тамга зэрэг нь түүх, соёлын дурсгалт зүйл бөгөөд энэ заалтын тайлбар соёлын биет өвийг олж авах, эзэмших, (үл) мэдэгдэхтэй талаар иргэний эрх зүйн хэм хэмжээг агуулна. Газарт булсан юмны эзэн нь өмчлөгч, ухаж гаргасан этгээд эзэмшигч болно. Тэр үед эзэмшигчийн эрх, үүргийг нарийвчлан зохицуулаагүй байсан ч улсад мэдэгдэх шаардлага нь тухайн зүйлийн эзэмшил, өмчлөлийг шийдвэрлэх арга зам байв.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Иргэний хууль /1926-1929/-ийн Тавдугаар бүлгийн хоёрдугаар анги “Эрт цагийн булш ба аливаа гээгдсэн зүйлийг олох тухай”-д нийт 6 зүйлийг багтаажээ. Түүний 106 дугаар зүйлд: Булшны дотроос ил гарсан аливаа юмыг хуучны зүйлийг сахин хамгаалах тухай дүрэмд заасан эх түүх музейд холбогдох чухал ховор зүйл бус аваас олсон хүмүүний хувийн хөрөнгө болмой; 107 дугаар зүйлд: Аливаа булшны зүйлийг энгийн олсон хүмүүн тухай бүр даруй улсын судар бичгийн шинжлэх ухааны хүрээлэнд мэдүүлж хянан байцаалгаад, хэрэв дээр зүйлд заасан чухалд заасан чухал бүтээл болох аваас харьяат хүрээлэнгийн газраа хураалгаж мэдүүлсэн этгээдэд зохих шагналыг олговоос зохимой¹¹ хэмээсэн байна.

“Хуучны зүйлийг сахин хамгаалах дүрэм”-д зааснаар Монгол Улсын хязгаар дотор буй бүхий хуучны дурсгал болох зүйл цөм Монгол Улсын өөрийн хөрөнгө болох тул Монгол Улсын Ардыг гэгээрүүлэх Яамны Судар бичгийн хүрээлэнгийн мэдэлд байх бөгөөд хуучны дурсгал болох зүйлүүд нь:

Нэг. Эх түүхэнд холбогдох бичиг зураг бүхий ба бичиг зураггүй булшны чулуун хөрөг, жич зураг бичигтэй ба зураг бичиггүй хад, байц, чулуун пайлуур багана зэргийн зүйл, хуучин цагийн зоосын аймаг;

Хоёр. Чулуу, шороо овоолох зэргээр үйлдсэн булшнууд бүх хэрэгслийн хамт;

Гурав. Эрт цагийн эвдэрхий хот балгас зэрэг зүйл;

Дөрөв. Орон сав зэрэг эртний түүх ба онгон тахилгад холбогдох урлан үйлдсэн зүйл;

Тав. Музейд агуулбал зохих археологи хэмээх хуучин байдлын юм ба газар доороос олдох палеонтологи хэмээх эрт цагийн ургамал ба амьтны үлдэгдэл зэрэг юмс;

Зургаа. Хуучны суртал, заншлыг мөрдөж ард олноор сахиж хамгаалсаар ирсэн онгон дархан уул, цаазтай ой хөвч, хэсэг мод ба урт насны ганц нэгэн мод;

Долоо. Олон зүйлийн ховор амьтан¹² зэрэг болно.

Дээрхээс “Хуучны зүйлийг сахин хамгаалах дүрэмд заасан эх түүх музейд холбогдох чухал ховор зүйл” гэдэгт аливаа булшин дотроос гарсан элдэв хэрэгсэл, хуучны зоос, тахилгын зүйл, археологи, палеонтологийн олдвор зэргийг ойлгохоор байна. Гэхдээ шууд “булш” гэж заасан нь явцуу хүрээг илэрхийлэх бөгөөд эдгээр зүйлүүд ихэвчлэн эрт цагийн булшнаас олддогтой холбон үзсэн бололтой.

⁹ Б.Баярсайхан, Ж.Энхнасан нар. “Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал” /1911-2009/ У6 хот. 2011. 71 дэх тал.

¹⁰ Хүний хөдөлмөрөөр бүтээгдсэн, хөдлөх шинж чанартай хуучны эд хэрэглэгдэхүүн зүйлс /Ч.Д./

¹¹ ХХДС, ХЗМТ. Иргэний хуулиуд /1926, 1952, 1963, 1994, 2002/, нэмэлт, өөрчлөлтүүд. Уб, 2002. 38 дахь тал.

¹² Хуучны зүйлийг сахин хамгаалах дүрэм. Нэгдүгээр болон хоёрдугаар зүйл. Ж.Амарсанаа, Б.Баярсайхан нар. Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл. Хоёрдугаар боть /1911-1926.V сар/. Уб, 2010. 492 дахь тал.

Монголд эд хөрөнгийн эзэмшлийн эрхийг анх 1952 оны Иргэний хуульд хуульчилж, улс өөрийн эд хөрөнгийг шударга ба шударга бусаар эзэмшигч нарын алианаас нь ч нэхэж авч болохоор¹³ заасан хэдий ч уг хуулийн 50-54 дүгээр зүйлүүдэд гээгдэл эд хогшил, алдуул мал олохтой холбоотой асуудлыг тусгаж, эрт цагийн булшны дотроос ил гарсан аливаа юмыг түр эзэмших, зохих газар мэдүүлж хураалгах, шагнал хүртээх тухай зүйл, заалтыг хассан байна. 1930-1940 оны Шүүх цаазын бичиг болон Эрүүгийн хуульд: Данслан бүртгэх буюу улсын чухал зүйлүүдийг агуулах, хадгалах газруудад шилжүүлэн хадгалуулбал зохих уран сайхны ба хуучин дурсгал бүхий зүйлүүд буюу цугларуулан хураасан үзэсгэлэнгийн зүйлийг нуун дарагдуулсан байвал 300-500 төгрөг хүртэл торгож уул зүйлүүдийг хураавал зохино¹⁴ гэх зүйл бий. Тэгвэл хуучны зүйлүүдийг нуун дарагдуулсан буюу зохих газарт шилжүүлэн өгөөгүй үйлдлийг шинээр гэмт хэрэгт тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэх болсон нь 1952 оны иргэний хуульд хуучны зүйлийн талаарх өмнөх үеийн зохицуулалтыг оруулахгүй байхад хүргэсэн гэвэл бас эргэлзээтэй. Учир нь 1934–1952 он хүртэл хугацаанд 1926 оны Иргэний хууль хүчин төгөлдөр үйлчилж байсан бөгөөд дээрх эрүүгийн хуулийн хэм хэмжээ газарт булж орхигдсон эзэнгүй хуучны зүйлийг олох, мэдүүлэх, шилжүүлэн өгөх, урамшуулал авах иргэний эрхийг хөндөхгүй билээ.

БНМАУ-ын Ардын Их Хурлаас 1963 онд баталсан Иргэний хуулийн 102 дугаар зүйл (Нуусан зүйл)-д зааснаар газар булаах, бусад аргаар нууж орхисон бөгөөд эзэн нь тогтоогдохгүй байгаа буюу эзэн нь өмчлөх эрхээ алдсан мөнгө, үнэ бүхий зүйл улсын өмч болно. Нуусан зүйлийг илрүүлсэн хүн энэ тухай орон нутгийн Ардын Депутатуудын Хурлын гүйцэтгэх захиргаа, санхүүгийн зохих байгууллагад шилжүүлэн өгөх үүрэгтэй. Нуусан зүйлийг илрүүлж зохих байгууллагад шилжүүлсэн хүн уул зүйлийн үнийн арван хувьтай тэнцэх шагнал улсаас авах эрхтэй. Албан үүргийн ёсоор хайгуул, малталт хийж байгаад нуусан зүйлийг илрүүлбэл шагнал авах эрхгүй.¹⁵ Нуусан зүйл нь “эзэнгүй” мөнгө, үнэ бүхий зүйл байх бөгөөд өмчлөгч нь тогтоогдохгүй бол улсын өмчлөлд шилжинэ. Түүнийг олж илрүүлсэн хүнийг хуульд эзэмшигч гэж тодорхойлоогүй ч тухайн зүйлээ улсад шилжүүлэн өгснөөрөө үнийн дүнгийн зохих (10) хувиар шагнал авах эрх эдэлнэ. Харин археологи, палеонтологи, геологийн хайгуул, малтлагын явцад илрүүлсэн бол шагнал авахгүй.

Ийнхүү 1926 оны “эртний булшны дотроос ил гарсан аливаа юм” 1952 онд алга болж 1963 онд “нуусан зүйл”-ээр эргэн ирэхдээ зөвхөн хуучны зүйлийг бус олж илрүүлсэн мөнгө, үнэ бүхий зүйлийг бүгдийг улс хураан авах, шагнал нь хувь хэмжээтэй байх, албан үүргийн дагуу хайгуул, малталт хийж олсон этгээд шагнал авахгүй байх “нөхцөл”-үүдийг дагуулжээ.

Иргэний хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай (1990 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн) хуулиар дээрх зүйлийг өөрчлөн найруулж, 83 дугаар зүйл (Дарагдмал үнэт зүйл)-д газарт булсан, бусад аргаар нууж орхисон бөгөөд эзэн нь мэдэгдэхгүй байгаа дарагдмал мөнгө, үнэт зүйл төрийн өмч болно. Дарагдмал мөнгө, үнэт зүйлийг илрүүлсэн хүн энэ тухай орон нутгийн цагдаагийн газар буюу Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанд даруй мэдэгдэж шилжүүлэн өгөх үүрэгтэй. Дарагдмал үнэт зүйлийг илрүүлж зохих байгууллагад шилжүүлсэн хүн төрийн зохих байгууллагаас уул зүйлийн үнийн хорь хүртэл хувьтай тэнцэх шагнал авах эрхтэй. Албан үүргийн ёсоор хайгуул, малталт хийж байгаад дарагдмал үнэт зүйлийг илрүүлбэл энэ хуульд заасан шагнал олгохгүй¹⁶ гээд хэрэв өмчлөгч өөрт байгаа бөгөөд улсын бүртгэлд авагдсан түүх, соёлын дурсгалт зүйлийг эвдэж гэмтээх

¹³ О.Жамбалдорж, Ж.Амарсайхан нар. Монгол Улсын иргэний эрх зүй /эд баялагийн эрх, оюуны өмчийн эрх/ II дэвтэр. Уб., 2006. 119 дэх тал.

¹⁴ 1934 оны Шүүх цаазын бичгийн 150 дугаар зүйл, 1942 оны БНМАУ-ын Эрүүгийн хуулийн 87 дугаар зүйл. Д.Адъяабазар. “Монгол улсын 1921 оноос хойшхи Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт” Уб., 1998. 97, 141 дэх тал.

¹⁵ Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Иргэний хууль. Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо. Уб, 1963. 41 дэх тал.

¹⁶ ХХДС, ХЗМТ. Иргэний хуулиуд /1926, 1952, 1963, 1994, 2002/, нэмэлт, өөрчлөлтүүд. Уб, 2002. 172-173 дахь тал.

зэргээр хайр гамгүй эзэмшвэл орон нутгийн Ардын хурлын гүйцэтгэх захиргаа, төрийн зохих байгууллагаас уул этгээдэд урьдчилан сануулж (нийтийн ашиг сонирхлын үүднээс зайлшгүй шаардлагатай байвал урьдчилан сануулахгүй), тогтоосон хугацаанд уул байдлаа зогсоохгүй бол төрийн зохих байгууллагын нэхэмжлэлээр дээрх эд хөрөнгийг шүүх хураан авч (хураан авахдаа хариу төлбөр төлөх эсэхийг шүүх шийдэх) төрийн өмчид шилжүүлэх зохицуулалт (84 дүгээр зүйл. Түүх, соёлын дурсгалт зүйлд хайр гамгүй хандах)-ыг¹⁷ шинээр нэмжээ.

Хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр нуусан зүйл (мөнгө, үнэ бүхий зүйл) нь дарагдмал үнэт зүйл (мөнгө, үнэт зүйл), улсын өмч нь төрийн өмч, санхүүгийн зохих байгууллага нь цагдаагийн газар болж, уг зүйлийг илрүүлж шилжүүлсэн хүнд олгох шагналын хэмжээ 10 хувиар нэмэгдсэн ажээ. Харин хуульд өмчлөгч улсын бүртгэлд бүртгүүлсэн түүх, соёлын дурсгалт зүйлд хайр гамгүй (эвдэж, гэмтээж) хандвал шүүхийн шийдвэрээр төр хураахаар болж Монгол Улсын түүх, соёлын дурсгалт зүйлд аюул учирсан тохиолдолд иргэдийн өмчлөлөөс төрд шилжүүлэн авах эрхийг тогтоосон байна. Энэ нь амины өмчийн эрхийг улс нийгмийн эрх ашигт харш ашиглаж үл болох¹⁸ Үндсэн хуулийн зарчимд нийцэх ба БНМАУ-ын улс хоршоолол, олон нийтийн байгууллага, иргэдийн өмчид байгаа соёлын дурсгалт зүйл нь хүний оюун санаа, хүч хөдөлмөрөөр бүтсэн, монголын ард түмний түүхийн бүхэл үеийн турш уламжлан хуримтлагдсан соёлын өв, үндэсний баялгийн хэсэг болох тул түүнийг БНМАУ-ын хуулиар хамгаалах¹⁹ ерөнхий заалт болон БНМАУ-ын соёлын дурсгалт зүйлийг улсын хамгаалалтад авна. БНМАУ-ын соёлын дурсгалт зүйлийг бүрэн бүтэн байлгах явдлыг БНМАУ-ын Соёлын яам, аймаг, хот, сум (хот), хорооны АДХ-ын гүйцэтгэх захиргаа хариуцан гүйцэтгэнэ²⁰ гэсэн Соёлын дурсгалт зүйлийг хамгаалах хуулийн зохицуулалттай уялдана.

Иргэний хуулийн 1994 оны шинэчилсэн найруулгын 128 дугаар зүйл (Дарагдмал мөнгө, үнэт зүйл)-д 1. Газарт булсан буюу бусад байдлаар дарагдаж орхигдсон бөгөөд эзэн нь мэдэгдэхгүй байгаа дарагдмал мөнгө, үнэт зүйл төрийн өмчлөлд байна. 2. Дарагдмал мөнгө, үнэт зүйлийг илрүүлсэн этгээд энэ тухай зохих нутгийн захиргааны буюу цагдаагийн байгууллагад даруй мэдэгдэж шилжүүлэн өгөх үүрэгтэй. 3. Дарагдмал мөнгө, үнэт зүйлийг илрүүлж, зохих байгууллагад шилжүүлсэн этгээд төрийн зохих байгууллагаас шагнал авах эрхтэй. Шагналын хэмжээг энэ хуулийн 126 дугаар зүйлийн 6 дахь хэсэг (Шагналыг эд хөрөнгө өмчлөгч болон олсон этгээдийн хооронд тохиролцсон хэмжээгээр, тохиролцохгүй бол уг эд хөрөнгийн үнийн арван хувиар олгоно)-т зааснаар тогтооно. 4. Хайгуул, малгалт хийх албан үүрэг бүхий этгээд уг үүргээ гүйцэтгэх явцдаа дарагдмал мөнгө, үнэт зүйлийг илрүүлсэн бол энэ зүйлд заасан шагнал олгохгүй. 129 дүгээр зүйл (Түүх, соёлын дурсгалт зүйлд хайр гамгүй хандах)-д 1. Өмчлөгч өөрт байгаа бөгөөд улсын бүртгэлд авагдсан түүх, соёлын дурсгалт зүйлийг эвдэж, гэмтээх зэргээр хайр гамгүй эзэмшиж байвал нутгийн захиргааны байгууллагаас уг этгээдэд урьдчилан сануулж, дээрх байдлаа засахыг хугацаа тогтоон шаардах, эсхүл төрд худалдахыг санал болгоно. 2. Өмчлөгч худалдах саналыг хүлээж аваагүй буюу энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлэхгүй бол зохих нутгийн захиргааны байгууллагын нэхэмжлэлийг үндэслэн уг эд хөрөнгийг шүүхийн шийдвэрээр дайчлан авч, төрийн өмчлөлд шилжүүлж болно. 3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар эд хөрөнгийг дайчлан авахдаа өмчлөгчид нөхөх олговор олгох ба түүний хэмжээг өмчлөгчийн саналыг харгалзан шүүх тогтооно. 4. Түүх, соёлын дурсгалт зүйлийг ач холбогдол, түүнийг хайр гамгүй эзэмшиж байгаа зөрчлийн

¹⁷ Мөн тэнд. 173 дахь тал.

¹⁸ БНМАУ-ын Үндсэн хууль (1960 он)-ийн Арван гуравдугаар зүйл. Ханнс Зайделийн Сан, “Эрх зүйн боловсрол” Академи. 1924, 1940, 1960, 1992 оны Үндсэн хуулиуд. Уб, 2007. 99 дэх тал.

¹⁹ БНМАУ-ын Соёлын дурсгалт зүйлийг хамгаалах хуулийн 1-р зүйл. Ж.Амарсанаа, Б.Баярсайхан нар. Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл. Тавдугаар боть /1958.XI сар -1970 он/. Уб, 2010. 606 дахь тал

²⁰ Мөн тэнд. 6-р зүйл. 607 дахь тал.

шинж байдлыг харгалзан төрийн зохих байгууллагын нэхэмжлэлийг үндэслэн шүүхийн шийдвэрээр түүнийг үнэ төлбөргүй хураан авч, төрийн өмчлөлд шилжүүлж болно²¹ гэжээ.

Хуулийн бүтцээс шалтгаалан зүйлийн гарчиг, дугаар өөрчлөгдөж, хэсгүүдэд хуваасан ч агуулга хэвээрээ байна. Харин 129 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт нөхөн олговор олгохгүй байх нөхцөлийг шинээр оруулжээ. Өмчлөгч нь орон нутгийн захиргааны байгууллагаас зөрчил арилгуулах үүргийг биелүүлээгүй, зөрчлийг удаа дараа гаргасаар байхаас гадна, зөрчил нь зөвхөн ашиг олох зорилгоор, үндэсний эрх ашигт хохирол учруулах байдлаар борлуулахыг завдсан, борлуулсан зэрэг ноцтой шинжтэй бол шүүх үнэ төлбөргүйгээр уг эд хөрөнгийг хураан авч төрийн өмчлөлд шилжүүлнэ²² гэсэн үг. Төр хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлөх Үндсэн хуулийн заалт (Арван зургадугаар зүйлийн 3 дахь хэсэг)-тай зөрчилдөх мэт боловч өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болох (Тавдугаар зүйлийн 3 дахь хэсэг)-той нийцнэ. Мөн Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлд түүх, соёлын дурсгалт зүйлийг өмчлөх эрхийг хязгаарлах 3 шаардлагыг заасан бөгөөд түүнд бүртгэл мэдээллийн санд бүртгэгдсэн түүх, соёлын дурсгалт зүйлийг өмчлөгч иргэн уг зүйлийг эвдэх, гэмтээх зэргээр гамгүй ашиглавал түүнийг Иргэний хуульд заасан нөхцөл, журмын дагуу төрийн өмчид шилжүүлэн авна²³ гэжээ.

Монгол Улсын Иргэний хуулийн 118 дугаар зүйлийн 118.1 дэх хэсэгт хуульд өөрөөр заагаагүй бол өмчлөгчийг буюу эрх бүхий этгээдийг тогтоох боломжгүй болтол удаан хугацаагаар газарт булагдсан, эсхүл дарагдаж орхигдсон үнэт зүйл /дарагдмал үнэт зүйл/ олдсон бол түүнийг олсон болон тухайн зүйл олдсон газар буюу эд хөрөнгийн өмчлөгч нар хоорондоо өөрөөр тохиролцоогүй бол тэнцүү хэмжээгээр хувааж өмчлөх эрхтэй²⁴ болохыг хуульчилсан. Үүний хэрэгжих урьдчилсан нөхцөл нь: а/ эд хөрөнгө нь хөдлөх эд хөрөнгө байх, б/ эд хөрөнгө дарагдмал байдалтай байх, в/ эд хөрөнгийн өмчлөгчийг тогтоох боломжгүй байх, г/ хэн нэгэн этгээд эд хөрөнгийг олсон байх зэрэг явдал юм. Эд хөрөнгө нь үл хөдлөх, хөдлөх шинж чанартай бөгөөд газар, түүнээс салгасан ч зориулалтын дагуу ашиглаж болох эд юмс нь хөдлөх эд хөрөнгөд хамаарна. Эд хөрөнгийг ердийн мэдрэхүйгээр (харах, сонсох гэх мэт) шууд олж мэдэх боломжгүй байх тохиолдолд дарагдмал гэж үзнэ. Энд уг эд хөрөнгө нь өмнө нь гээгдсэн, эсхүл эзэнгүй эд хөрөнгийн талаар яригдаж байгаа эсэх нь хамааралгүй²⁵ юм. Дарагдмал үнэт зүйл гэдэг нь аль нэг этгээд санаатайгаар, удаан хугацаагаар газарт булсан, эсхүл дарж орхисон, түүний өмчлөгчийг буюу эрх бүхий этгээдийг тогтоох боломжгүй үнэт зүйлийг хэлдэг.²⁶

Хэрэв дарагдмал үнэт зүйлс дотор түүх, соёлын дурсгалт зүйл байвал тэдгээрийг төрийн өмчлөлд шилжүүлнэ. Энэ тохиолдолд дарагдмал үнэт зүйл олдсон газрын буюу эд хөрөнгийн өмчлөгч болон эд юмсыг олсон этгээдэд түүний үнийн дүнгийн 50 хувьтай тэнцэх мөнгөн шагналыг тэнцүү хувааж олгоно.²⁷ Энд зохицуулагдсан тохиолдлын хувьд эхлээд тусгай хуулиудад энэ олдмол үнэт зүйлсийн өмчлөх эрхийн харилцааг түүхийн болон соёлын үнэ цэнтэй нь холбогдуулж зохицуулсан журам байгаа эсэхийг шалгах хэрэгтэй²⁸ гэвэл Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.Түүх, соёл, шинжлэх ухааны ач холбогдол бүхий үнэт зүйл оршин байгаа нутаг дэвсгэр, газрын хэвлий

²¹ Монгол Улсын Иргэний хууль /Шинэчилсэн найруулга/. Төрийн мэдээлэл, 1995, №1.

²² Ц.Цэрэнпэлжээ. Өмчийн эрх зүй (Онол, практикийн асуудал). Уб., 2000. 74-75 дахь тал.

²³ БНМАУ-ын Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хууль. Ж.Амарсанаа, Б.Баярсайхан нар. Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл. Наймдугаар боть /1993-1994 он/. Уб, 2010. 344 дэх тал.

²⁴ Монгол Улсын Иргэний хууль.Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2002, №7.

²⁵ Ё.Каюг, Э.Шпанглер нар. Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар /Шинжлэх ухааны тайлбар/. Уб, 2015. 205 дахь тал.

²⁶ О.Жамбалдорж, Ж.Амарсайхан нар. Монгол улсын иргэний эрх зүй /эд баялагийн эрх, оюуны өмчийн эрх/ II дэвтэр. Уб., 2006. 44 дэх тал.

²⁷ Монгол Улсын Иргэний хуулийн 118 дугаар зүйлийн 118.3 дахь хэсэг. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2002, №7.

²⁸ Ё.Каюг, Э.Шпанглер нар. Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар (Ерөнхий анги). Уб., 2006. 414 дэх тал.

нь төрийн хамгаалалтад байх бөгөөд аливаа олдвор нь төрийн өмч мөн²⁹ гэснийг дурдаж болно. Олдвор гэж олж авсан, учирч тохиолдсон үнэт дурсгалыг хэлэх³⁰ тул ерөнхий агуулгаараа аливаа олдвор гэдэгт археологи, палеонтологийн олдвор төдийгүй газарт булагдсан, дарагдаж орхигдсон уламжлалт багаж хэрэгсэл, баримтат өв, угсаатан, ястны эд өлгийн зүйлс багтана. Хуульд зааснаар эдгээр нь бүгд түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл юм.

БНМАУ-ын 1963 оны Иргэний хуулиас эхлэлтэй газарт булагдсан, дарагдаж орхигдсон дарагдмал мөнгө, үнэт зүйл (нуусан зүйл)-ийн эзэн нь тогтоогдохгүй бол цөмийг төр өмчлөлдөө авдаг 1994 оны Иргэний хууль /Шинэчилсэн найруулга/-ийн улбаа 2002 онд арилж, дарагдмал үнэт зүйл дотор түүх, соёлын дурсгалт зүйл байгаагаас бусад тохиолдолд тухайн зүйл олсон болон олдсон газар буюу эд хөрөнгийн өмчлөгч нар хоорондоо тохиролцсон, тохиролцоогүй бол тэнцүү хэмжээгээр хувааж өмчлөхөөр болов. Түүнчлэн дарагдмал үнэт зүйл олдсон газар буюу эд хөрөнгийн өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр, дарагдмал үнэт зүйлийг олох зорилгоор эрэл хайгуул хийж түүнийг олсон бол тухайн үнэт зүйл нь уг үнэт зүйл олдсон газрын буюу эд хөрөнгийн өмчлөгчид бүрэн хэмжээгээр шилжинэ³¹. Мэдээж хайгуул, малталт хийх албан үүрэг бүхий этгээд уг үүргээ гүйцэтгэх явцдаа илрүүлсэн дарагдмал үнэт зүйлс, археологийн болон палеонтологийн олдворт энэ зүйлд заасан журам хамаарахгүй.³² Дарагдмал үнэт зүйл (өмчлөгчийн эрхийг хангах)-ийн талаарх хуулийн зохицуулалт өмнөх үеэс илүү сайжирч, түүх, соёлын дурсгалт зүйлд хайр, гамгүй хандахтай холбоотой зүйлийг хасажээ.

Монгол Улсын Иргэний хуулиуд дахь дарагдмал үнэт зүйлтэй холбоотой зохицуулалтыг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 1

Хуулиуд	БНМАУ-ын Иргэний хууль /1926 он/	БНМАУ-ын Иргэний хууль /1952 он/	БНМАУ-ын Иргэний хууль /1963 он/	БНМАУ-ын Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль /1990 он/	Монгол Улсын Иргэний хууль /Шинэчилсэн найруулга/ /1994 он/	Монгол Улсын Иргэний хууль /2002 он/
Бүлэг, анги	Тавдугаар бүлэг Хоёрдугаар анги Эрт цагийн булш ба аливаа гээгдсэн зүйлийг олох тухай	Нэгдүгээр бүлэг Өмчийн эрх	Долдугаар бүлэг Өмчийн эрхийг олох ба дуусгавар болох	Хоёрдугаар бүлэг Өмчлөх эрх үүсэх, дуусгавар болох	Есдүгээр бүлэг Өмчлөх эрх үүсэх, дуусгавар болох	Хоёрдугаар дэд бүлэг Өмчлөх эрх үүсэх, дуусгавар болох
Зүйл	106 дугаар зүйл 107 дугаар зүйл	-	102 дугаар зүйл. Нуусан зүйл	83 дугаар зүйл. Дарагдмал үнэт зүйл	128 дугаар зүйл. Дарагдмал мөнгө, үнэт зүйл	118 дугаар зүйл. Дарагдмал үнэт зүйл

²⁹ Соёлын өвийг хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2014, №23.

³⁰ Монгол хэлний их тайлбар толь. <https://mongoltoli.mn/dictionary/detail/67404>.

³¹ Монгол Улсын Иргэний хуулийн 118 дугаар зүйлийн 118.2 дахь хэсэг. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2002, №7

³² Мөн тэнд. 118 дугаар зүйлийн 118.4 дэх хэсэг.

Газарг булагдсан, дарагдсан зүйл	Аливаа булшны зүйл	-	Мөнгө, үнэ бүхий зүйл	Дарагдмал мөнгө, үнэт зүйл	Дарагдмал мөнгө, үнэт зүйл	Дарагдмал үнэт зүйл
	Эх түүх музейд холбогдох ховор зүйл, чухал бүтээл		-	-	-	-
Өмчлөх эрх бүхий этгээд	Олсон хүмүүн	-	Орон нутгийн АДХ-ын гүйцэтгэх захиргаа буюу Санхүүгийн зохих байгууллага	Орон нутгийн цагдаагийн газар буюу Ардын Хурлын гүйцэтгэх захиргаа	Зохих нутгийн захиргаа буюу цагдаагийн байгууллага	Уг үнэт зүйл олсон болон олдсон газрын буюу эд хөрөнгийн өмчлөгч
	Ховор зүйл байвал Судар бичгийн шинжлэх ухааны хүрээлэн					Түүх, соёлын дурсгалт зүйл байвал төр
Шагнал авах эрх, шагналын хэмжээ	Зохих шагнал	-	Уул зүйлийн үнийн 10 хувьтай тэнцэх шагнал	Уул зүйлийн үнийн 20 хувьтай тэнцэх шагнал	Тохиролцсон хэмжээгээр, тохиролцоогүй бол уг эд хөрөнгийн үнийн 10 хувь	Үнийн дүнгийн 50 хувьтай тэнцэх мөнгөн шагнал
			- Албан үүргийн ёсоор хайгуул, малталт хийж байгаад илрүүлбэл шагнал олгохгүй. - Хайгуул, малталт хийх албан үүрэг бүхий этгээд уг үүргээ гүйцэтгэх явцдаа дарагдмал үнэт зүйл /археологи, палеонтологийн олдвор/-ийг илрүүлсэн бол шагнал олгохгүй. /энэ зүйлд заасан журам хамаарахгүй./			

ДҮГНЭЛТ

Их засаг хууль, Алтан хааны цааз, Үйсэн цаазууд, 1640 оны Их цааз, Монгол цаазын бичиг, Халх журам зэрэг Монголын хууль цаазын түүхэн эх сурвалжуудад иргэний эрхийн холбогдолтой заалтууд цөөнгүй боловч дарагдмал үнэт зүйл болон түүх, соёлын дурсгалт зүйлийн талаарх зохицуулалт алга байна. Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйн бичгийн 65 дугаар дэвтэр дэх эрүүгийн эрх зүйн хэм хэмжээний тайлбарт газар булаатай нэрлэсэн эртний эдлэлийн эзэн олдохгүй бол ухаж гаргасан этгээдийг эзэмшигч гэх, эзэмшигч олсон зүйлийг холбогдох газарт 30 хоногийн дотор мэдэгдэх шаардлагатайг дурджээ. Гэвч үүнийг цэвэр иргэний эрх зүйн зохицуулалт гэж үзэхгүй.

Манай улсын анхны Иргэний хууль /1926 он/-ийн “Аливаа хөрөнгө хогшлын тухай” тавдугаар бүлэгт “Эрт цагийн булш ба аливаа гээгдсэн зүйлийг олох тухай” хэмээх 6 зүйл бүхий бие даасан (хоёрдугаар) анги байсан ба аливаа булшны дотроос гарсан эд юмс дотор эх түүх музейд холбогдох ховор зүйл, чухал бүтээл байх аваас Судар бичгийн хүрээлэнд хураалгаж, олсон этгээд зохих шагнал авахаар заасан нь одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Иргэний хуулийн дарагдмал үнэт зүйл дотор түүх, соёлын дурсгалт зүйл байвал төрийн өмчлөлд шилжүүлж, олдсон газрын буюу эд хөрөнгийн өмчлөгч болон эд юмсыг олсон этгээдэд мөнгөн шагналыг тэнцүү хувааж олгох зохицуулалттай ижил, түүний эхний хувилбар гэхээр байв.

Харин 1952 оны БНМАУ-ын Иргэний хуульд дээрх зохицуулалтыг огт тусгаагүй бөгөөд 1963 оны БНМАУ-ын Иргэний хуулийн долдугаар бүлэг “Өмчийн эрхийг олох ба дуусгавар болох”-ийн 102 дугаар зүйл (Нуусан зүйл)-д газар булаах, бусад аргаар нууж орхисон, эзэн нь тодорхойгүй мөнгө, үнэ бүхий зүйл улсын өмч байна гэжээ. Өөрөөр хэлбэл түүх, соёлын дурсгалт зүйл гэж ялгахгүйгээр нуусан зүйлс бүхэлдээ төрийн мэдэлд шилжинэ. Нуусан зүйлийг олж шилжүүлсэн хүн уг зүйлийн үнийн 10 хувьтай тэнцэх шагнал авна. Гэхдээ зүйлийн дагуу албан үүргийн ёсоор хайгуул, малталт хийж байгаад илрүүлсэн бол шагнал авах эрхгүй.

БНМАУ-ын Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль (1990.12.06)-иар зүйлийн дугаар, нэршил өөрчлөгдөж, шагналын хэмжээ 20 хувьд хүрчээ. Нуусан зүйлийн оронд одоогийн “дарагдмал үнэт зүйл” гэх нэр томъёог хуульд анх хэрэглэсэн байна. Өмчлөгч улсын бүртгэлд бүртгүүлсэн түүх, соёлын дурсгалт зүйлийг эвдэх, гэмтээх зэргээр хайр гамгүй хандсан бөгөөд шаардлагын дагуу уул байдлаа зогсоохгүй бол шүүхийн шийдвэрээр хураан авч (хариу төлбөр өгөх эсэхийг шүүх шийднэ), төрийн өмчлөлд шилжүүлэх шинэ зүйлийг оруулж ирсэн нь БНМАУ-ын Соёлын дурсгалт зүйлийг хамгаалах хуультай уялдсан түүх, соёлын дурсгалт хөдлөх зүйлийг хамгаалахад чиглэсэн дэвшилтэд шийдэл болжээ.

Монгол Улсын Иргэний хууль /Шинэчилсэн найруулга/-иар дээрх 83 (128), 84 (129) дүгээр зүйлүүд нь хэлбэрийн хувьд ялимгүй өөрчлөгдсөн боловч агуулга хэвээрээ байна. Өмнө нь өмчлөгч өөрт байгаа түүх, соёлын дурсгалт зүйлийг хайр гамгүй хандвал төрийн зохих байгууллагын нэхэмжлэлээр хураан авч, нөхөн олговрыг өгөх эсэхийг шүүх шийддэг байсан бол тухайн зүйлийн ач холбогдол, зөрчлийн шинж байдлыг харгалзан шүүхийн шийдвэрээр түүнийг үнэ төлбөргүй хураан авч, төрийн өмчлөлд шилжүүлж болохоор заажээ. Энэ бол түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах зорилготой өмчлөх эрхийн хуулийн хязгаарлалт юм. Үндсэн хуульд харшлахгүй.

Хүчин төгөлдөр үйлчилж эхлээд 20 гаруй жилийг үдэж буй Иргэний хуулийн 118 дугаар зүйлийн хэм хэмжээнд өмнөх үеийн иргэний хуулиудын зарим зохицуулалт, нэр томъёог уламжлан авч тусгасан, хууль тогтоогч иргэний өмчлөх эрхийг хангахад багагүй анхаарсан нь ажиглагдана. Гэхдээ дарагдмал үнэт зүйлийг олсон этгээд энэ тухайгаа ямар байгууллагад хэдий хугацаанд мэдэгдэх нь тодорхой бус болжээ. Дарагдмал үнэт зүйл гэдэг бол удаан хугацаагаар газарт булсан, эсхүл дарж орхисон, түүний өмчлөгчийг буюу эрх бүхий этгээдийг тогтоох боломжгүй үнэт зүйл бөгөөд урьдчилсан нөхцөлөөр хөдлөх эд хөрөнгө юм. Тэгэхээр дарагдмал үнэт зүйлийн удаан хугацаагаар газарт булагдсан, дарагдсан байдал нь соёлын биет өвийн түүхэн тодорхой орон зай, цаг үеийг төлөөлөх шинжийг агуулах бөгөөд хууль хэрэгжих урьдчилсан нөхцөл болон соёлын биет өвийн ангиллын дагуу дарагдмал үнэт зүйл нь түүх, соёлын “хөдлөх” дурсгалт зүйл байна.

Анх БНМАУ-ын Иргэний хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 1990 оны хуульд тусгалаа олж, 1994 оны Монгол Улсын Иргэний хууль /Шинэчилсэн найруулга/-иар төгөлдөржсөн өмчлөгч улсын бүртгэлд авагдсан түүх, соёлын дурсгалт зүйлийг эвдэж, гэмтээх зэргээр хайр гамгүй хандвал захиргааны байгууллагаас уг байдлаа засахыг хугацаа тогтоон шаардах, төрд худалдахыг санал болгох, биелүүлэхгүй бол нөхөн олговор олгож, эсхүл үнэ төлбөргүйгээр шүүхийн шийдвэрээр хураан авч төрийн өмчлөлд шилжүүлэх зохицуулалт 2002 оны Иргэний хуульд ороогүй. Тиймээс бүртгэл мэдээллийн санд бүртгэгдсэн түүх, соёлын дурсгалт зүйлийг өмчлөгч иргэн уг зүйлийг эвдэх, гэмтээх зэргээр гамгүй ашиглавал түүнийг Иргэний хуульд заасан нөхцөл, журмын дагуу төрийн өмчид шилжүүлэн авах заалтыг Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хуулиас хасжээ.

Өмнөх үеийн Иргэний хуулиуд дахь дарагдмал үнэт зүйл болон түүх, соёлын дурсгалт зүйлтэй холбоотой зохицуулалтууд нь өмчлөх эрх үүсэх, дуусгавар болох харилцааг

зохицуулахын хамт соёлын биет өвийг хамгаалахад чиглэж, Хуучны зүйлийг сахин хамгаалах дүрэм, БНМАУ-ын Соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хууль, Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хуулиудтай харилцан уялдсан байжээ.

Эцэст нь өгүүлэхэд Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Үндэсний болон орон нутгийн музейд иргэд, ялангуяа малчид хөдөө хээрээс олсон дарагдмал үнэт зүйл буюу түүх, соёлын дурсгалт зүйлийг шилжүүлэн өгсөн тохиолдол гардаг ч энэ талаар нэгдсэн тоо, судалгаа алга байна.

САНАЛ

Өгүүллийн үндсэн хэсэг, дүгнэлтэд үндэслэн дарагдмал үнэт зүйл болон түүх, соёлын дурсгалт зүйлтэй холбоотой харилцааг зохицуулах дараах саналуудыг дэвшүүллээ.

1. Дарагдмал үнэт зүйл олсон талаар хаана, ямар хугацаанд мэдэгдэхийг хуульд зааж өгснөөр иргэд хаана хандах нь тодорхой болж, нөгөө талаас бүртгэл, хяналт сайжрах ач холбогдолтой. Тодруулбал, 118 дугаар зүйлийн 118.1. ...газарт булагдсан, эсхүл дарагдаж орхигдсон үнэт зүйл /дарагдмал үнэт зүйл/ олдсон бол орон нутгийн захиргааны буюу цагдаагийн байгууллагад 30 хоногийн дотор мэдэгдэнэ.

2. Иргэний хуулийн 118 дугаар зүйлийн 118.3 дахь хэсэгт заасан “...түүх, соёлын дурсгалт зүйл...”-ийг хууль хэрэгжих урьдчилсан нөхцөл болон Соёлын өвийг хамгаалах тухай хуульд заасан соёлын биет өвийн ангиллын дагуу “түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл” болгож, “...тэдгээрийг төрийн өмчлөлд шилжүүлнэ.” гэснийг “...тэдгээрийг Соёлын өвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, төрийн өмчлөлд шилжүүлнэ.” гэж өөрчлөн найруулбал оновчтой. Ингэснээр 118.1 дэх хэсэгт заасан дарагдмал үнэт зүйлсийг бүртгэж авсан байгууллага, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл байх магадлалтай гэж үзвэл холбогдох яаманд хүргүүлэх арга хэмжээ авна.

3. Хуулийн 118 дугаар зүйлийн 118.4 дэх хэсэгт “...археологийн болон палеонтологийн олдворт...” гэснийг Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 6 болон 30 дугаар зүйлийг харгалзан “олдворт”, эсхүл “түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлд” гэвэл зохино.

4. Түүх, соёлын дурсгалт зүйлд хайр гамгүй хандсан бол уг зүйлийг төрийн өмчлөлд шилжүүлэн авдаг уламжлалт зохицуулалтыг соёлын биет өвийг бүртгэн хамгаалах орчин цагийн хэрэгцээ шаардлага, иргэний хуулийн бүтэц, агуулгад нийцүүлэн хуульчлах боломжтой. Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуулиар түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг санаатай эвдэх, гэмтээх нь гэмт хэрэг, хадгалж, хамгаалах, ашиглахдаа анхны төрх, нэгдмэл цогц байдал, шинж чанарыг алдагдуулж гэмтээх нь зөрчил тул Соёлын өвийг хамгаалах хуулийн холбогдох зүйлүүдтэй уялдуулан шинэ зүйлийг дараах байдлаар томъёолов. Үүнд:

118¹ дүгээр зүйл. Соёлын биет өвийн өмчлөх эрхийг шилжүүлэх

118¹.1. Өмчлөгч этгээд соёлын биет өвийг бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлэх, эсхүл худалдах, бэлэглэх, өвлүүлэх зэргээр өмчлөх эрхээ бусдад шилжүүлснээ мэдэгдэх үүргээ биелүүлээгүй бол сум, дүүргийн засаг дарга 30 хоногийн дотор бүртгүүлж, мэдэгдэхийг шаардана.

118¹.2. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд соёлын биет өвийг төрд худалдахыг санал болгоно. Саналыг эс зөвшөөрвөл аймаг, нийслэлийн засаг дарга төрийн өмчлөлд шилжүүлэн авахаар шүүхэд нэхэмжлэл гаргана.

118¹.3. Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг худалдах анхны саналыг төрд тавихгүйгээр худалдах, эсхүл гадаад улсын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүний өмчлөлд шилжүүлэхийг завдсан, түүх соёлын үл хөдлөх дурсгалыг тогтоосон журам, стандартыг зөрчиж засварласан нь соёлын биет өвийг төрийн өмчлөлд шилжүүлэх үндэслэл болно.

118¹.4. Соёлын биет өвийг төрийн болон орон нутгийн өмчлөлд шилжүүлэх, өмчлөгчид нөхөн олговор олгох эсэхийг шүүх шийдвэрлэнэ. Нөхөн олговрын хэмжээг Соёлын асуудал

эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон өмчлөгчийн саналыг харгалзан тогтооно.

5. Дарагдмал үнэт зүйлтэй холбоотой иргэний хууль тогтоомжийн түүхэн уламжлал хийгээд одоогийн зохицуулалтыг олон нийтэд сурталчлах, Иргэний хуулийн 118 дугаар зүйлийн 118.3 дахь хэсэгт зааснаар түүх, соёлын дурсгалт зүйлийг төрийн өмчлөлд шилжүүлсэн өгсөн тухай улсын хэмжээний нэгдсэн бүртгэл хөтөлж, дүн шинжилгээ хийх ажлуудыг зохион байгуулбал үр дүнд хүрнэ.

ЭХ СУРВАЛЖ

Монгол хэл дээрх

Хууль тогтоомж

1. БНМАУ-ын Үндсэн хууль, 1960.
2. Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 1992, №1.
3. БНМАУ-ын Шүүх цаазын бичиг, 1934.
4. БНМАУ-ын Эрүүгийн хууль, 1942.
5. БНМАУ-ын Эрүүгийн хууль. Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо. Уб., 1961.
6. БНМАУ-ын Иргэний хууль. Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо. УБ, 1963.
7. БНМАУ-ын Соёлын дурсгалт зүйлийг хамгаалах хууль. 1970.
8. БНМАУ-ын Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хууль. 1994.
9. Монгол Улсын Иргэний хууль /Шинэчилсэн найруулга/. Төрийн мэдээлэл, 1995 №1.
10. Монгол Улсын Иргэний хууль.Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2002, №7.
11. Соёлын өвийг хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ Төрийн мэдээлэл. 2014. №23
12. Монгол Улсын Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2016. №07
13. Зөрчлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/.Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2017. №24.

Ном, өгүүлэл, судалгааны тайлан

1. Д.Адъяабазар. “Монгол улсын 1921 оноос хойших Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт” Уб., 1998.
2. Ц.Цэрэнпэлжээ. Өмчийн эрх зүй (Онол, практикийн асуудалд). Уб., 2000.
3. ХХДС, ХЗМТ. Иргэний хуулиуд /1926, 1952, 1963, 1994, 2002/, нэмэлт, өөрчлөлтүүд. Уб, 2002.
4. О.Жамбалдорж, Ж.Амарсайхан нар. Монгол Улсын иргэний эрх зүй /эд баялгийн эрх, оюуны өмчийн эрх/ II дэвтэр. Уб., 2006.
5. Ё.Каюг, Э.Шпанглер нар. Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар (Ерөнхий анги). Уб., 2006.
6. Ханнс Зайделийн Сан, “Эрх зүйн боловсрол” Академи. 1924, 1940, 1960, 1992 оны Үндсэн хуулиуд. Уб, 2007.
7. Ж.Амарсанаа, Б.Баярсайхан нар. Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл. Хоёрдугаар боть /1911-1926.V сар/. Уб, 2010.
8. Ж.Амарсанаа, Б.Баярсайхан нар. Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл. Тавдугаар боть /1958.XI сар -1970 он/. Уб, 2010.
9. Ж.Амарсанаа, Б.Баярсайхан нар. Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл. Наймдугаар боть /1993-1994 он/. Уб, 2010.
10. Б.Баярсайхан, Ж.Энхнасан нар. Монгол улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009) Уб. 2011.

11. З.Сүхбаатар, Б.Батбаяр нар. Монгол Улсын Иргэний хууль тогтоомж (түүхэн эмхтгэл) 1206-2012 он. Уб., 2012.
12. С.Нарангэрэл. Монголын эрх зүйн эх толь бичиг. Дөрөв дэх хэвлэлт. Уб. 2015.
13. Ё.Кают, Э.Шпанглер нар. Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар /Шинжлэх ухааны тайлбар/. Уб, 2015.

Цахим эх сурвалж:

1. <https://mongoltoli.mn/dictionary/detail/67404>.
2. <https://news.mn/r/91276/>.
3. <https://news.mn/r/621112/> .
4. <https://montsame.mn/mn/read/49097/>.
5. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=10439>.

THE TRADITION OF CIVIL LAW REGULATION OF HIDDEN VALUABLES AND HISTORICAL AND CULTURAL MEMORIAL OBJECTS

Dorjsuren.Ch

Ph.D student, School of law, NUM

ABSTRACT:

The articles and provisions related to hidden valuables and historical and cultural memorial objects of the civil laws of Mongolia from time to time have been compared, and their characteristics, differences and similarities were summed up and a proposal has been put forward to incorporate some regulations in the current Civil Code in this article. It has been suggested that the regulation of civil law relations related to the ownership of tangible cultural heritage is rational in relation to the norms of the Law for the Protection of Cultural Heritage.

KEYWORDS:

Hidden valuables (treasure-trove), property, historical and cultural memorial objects, archaeological and paleontological finds

МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ӨМЧИЛСӨН ГАЗРЫГ НИЙГМИЙН ЗАЙЛШГҮЙ ХЭРЭГЦЭЭГ ҮНДЭСЛЭН АЛБАДАН ЧӨЛӨӨЛӨХ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ: ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА



Я.Өнөрбаян

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн докторант

ТОВЧЛОЛ:

Монгол Улсад хот байгуулалт болон хот төлөвлөлтийг хэрэгжүүлэх, хотыг дахин хөгжүүлэх явцад хамгийн чухал асуудлын нэг бол газрын тухай асуудал юм. Иргэний өмчилсөн газрыг улсын тусгай хэрэгцээнд ямар зарчмаар хэрхэн авах талаар Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн хүрээнд ерөнхий байдлаар хуульчилсан хэдий ч өнөөдрийн нөхцөл байдлыг зохицуулахад учир дутагдалтай байна. Хэдийгээр Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх эрх зүйн үндсэн зарчмуудыг Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон, хамгаалсан боловч эдгээр зарчмыг Газрын тухай хууль, Иргэний хууль, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль гэх мэт бусад хуульд сайн тусгаагүй байна. Энэхүү өгүүллтийн хүрээнд: Дээрх хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, газар албадан чөлөөлөх эрх зүйн зохицуулалтын сул тал, зөрчил дутагдлыг илчилж, гадны зарим орны сайн туршлагыг харьцуулах замаар бие даасан хууль гаргах талаас зөв үнэлэлт дүгнэлт өгөх явдал юм.

ТҮЛХҮҮР ҮГС:

Газар чөлөөлөх, нөхөн олговор, нийгмийн зайлшгүй хэрэгцээ, газар чөлөөлөлтөд өртөгч.

I. Газар чөлөөлөх үндэсний эрх зүйн зохицуулалт

Иргэнд өмчийн газартай нь холбогдуулан хуульд заасны дагуу газрын эзэнд үүрэг хүлээлгэх эрхийг¹ Үндсэн хуулиар, хууль тогтоогчид олгосон нь салшгүй эрх болох өмчийн эрхийг хязгаарлах боломжийг нээж өгсөн. Хувийн өмчийн газрыг хуулиар зохицуулсны үр дүнд газрын үнэ нэмэгдэх болон буурах тохиолдол байдаг². Жишээ нь, Гэр хорооллын дахин төлөвлөлтийг дурьдаж болно. Монгол Улсын иргэн газар өмчилж авсан тэр цагаас эхлэн бусад бүх этгээд, төр хүртэл газрын эзний өмнө өмчийн эрхийг нь хүндэтгэх, хувийн өмчийн зүйлд нь халдахгүй байх үүрэг хүлээдэг³ явдал юм. Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 2-т “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч

¹ Монгол Улсын Үндсэн хууль, 1992, 6.4 дүгээр зүйлийн 6.4 дэх хэсэг.

² Д.Гангабаатар, “Хувийн өмчийн газрыг шууд бусаар дайчлан авахаас хамгаалах Үндсэн хуулийн зохицуулалт”, Эрх зүй сэтгүүл, 2015, №1(31) 64 дэх тал.

³ Мөн тэнд 65 дахь тал.

өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”⁴ гэж өмчлөгчийн өмчлөх эрхийг хууль батлан хамгаалах тухай зааж энэ үүргийг төрд хүлээлгэсэн байна. Монголчуудын аж амьдралын үндсэн хэв маяг нь бэлчээрийн мал аж ахуй байсантай холбоотой газар бол Монгол улсын түүхэнд 1992 оныг хүртэл хувийн өмчийн эд хөрөнгө байгаагүй.⁵ Монголын иргэдийн тухайд ч гэсэн газрыг хувьдаа өмчлөхөд өмчийн эрхийн бүрэн утгатай харьцуулахад зарим талын хязгаарлалтыг Үндсэн хуулийн хэмжээнд хуульчилсан явдал бол Монгол Улсад газар эзэмшиж ирсэн уламжлалыг тусгасан онцлогтой. Гавьяат хуульч Г.Совд: а/ Газар өмчлөгч нь юуны өмнө өөрийн өмчлөлийн газрыг гадаадын иргэн буюу аль ч улсын иргэн биш этгээдэд худалдах, бэлэглэх, барьцаалах эрх байхгүй, б/ иргэд өмчийнхөө газрыг төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй бусдад дур мэдэн эзэмшүүлж, ашиглуулж болохгүй, в/ бэлчээр, нийтийн эдэлбэрийн болон тусгай хэрэгцээний газрыг иргэд хувьдаа өмчлөхгүй, г/ иргэд газрын хэвлий буюу хөрсөн дээрх баялаг, ой, усны нөөц, ан амьтныг хувьдаа өмчлөхгүй⁶ гэж Монгол улсын Үндсэн Хуулийн тайлбар номонд дурьджээ. Монголчуудын газрыг хувьдаа өмчилж ирээгүйг капиталын нууцыг нээн ойлгох хөгжлийн төвшин, чадваргүйтэй холбоотойгоос гадна малаар дамжуулж газрыг ашигладаг нүүдлийн мал аж ахуйн амьдралын хэв шинжийг нөхцөлдүүлсэн байгаль цаг агаар, түүнээс үүдэлтэй газрын хөрс, ургамлын онцлогтой холбон авч үзэх нь зүйтэй болов уу.⁷ Монголчуудын түүхэнд газрыг хувьд өмчилж байсан эсэх талаарх дээрх эрдэмтдийн судалгааг харьцуулан үзэхэд миний бие газрыг хувьд өмчилж байгаагүй гэсэн талд санал нэгдэж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлд зааснаар Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно. “Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно”⁸ гэсэн Үндсэн хуулийн заалт нь өмчийн эрхийг үндсэн хуулийн хүрээнд чухалчлан хамгаалсныг харуулна. Ийн хамгаалсан нь өмчийн эрх нь хүний бусад эрх, эрх чөлөөг эдлэх баталгаа болдогтой холбоотой.⁹ Энэ нь хувь хүний хамгаалалтын бүс үүсгэдгээрээ төрийн дур зоргоор авирлахын эсрэг хувь хүний орон зайг бий болгож, бусад эрх, эрх чөлөөгөө эдлэх боломжийг бүрдүүлдэг учраас өмчийн эрхийг тухайлан Үндсэн хуулиар баталгаажуулжээ.¹⁰ Тус хуулийн 6 дугаар зүйлийн 4-т “Төр газрын эзэнд газартай нь холбогдсон үүрэг хүлээлгэх, улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор газрыг солих буюу эргүүлэн авах, уг газрыг хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашиглавал хураан авч болно”¹¹ гэсэнээр хувийн өмчийн газрыг дайчлан авах боломжийг бүрдүүлжээ. Мөн газар зохион байгуулалт, төлөвлөлт, кадастрийн зураглалыг нарийн гүйцэд хийгээгүй эсвэл шинээр зайлшгүй нөхцөл байдал илрэх тохиолдолд иргэний газар өмчлөх эрхийг хамгаалах зорилгоор дээрх зохицуулалтыг хийсэн гэж ойлгоно. Улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор газрыг солих буюу эргүүлэн авах үйлдэл нь өмчлөгчийн хувийн эрхийг нийтлэг эрх ашгийн үүднээс хязгаарлах онцгой тохиолдол бөгөөд өөрөөр шийдвэрлэх бололцоогүй нь тал бүрээр нотлогдсон, хамгийн гол нь газар өмчлөгч түүнийг нь хүлээн зөвшөөрөх нөхцөлд л хэрэгжих агуулгатай. Тиймээс нөхөх олговор нь төрийн байгууллагаас иргэний газар өмчлөх эрхэд халдсаны хариу төлбөр, уучлалын материаллаг хэлбэр, мөн нөхөх олговор бол урьдчилсан, шударга¹² байх ёстой. Монгол Улсын иргэнд

⁴ Монгол Улсын Үндсэн Хууль, 1992, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг.

⁵ Д.Сүнжид, Үл хөдлөх эд хөрөнгийн Үндсэн хуулийн асуудлууд, 2016, www.Legaldata.mn.

⁶ Г.Совд нар, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, УБ, 2000, 48 дахь тал.

⁷ Н.Лүндэндорж, “Монголд газрыг хувьд өмчилж байсан эсэх талаархи түүхэн маргаан, түүнд хийсэн түүх, философи, эрх зүйн шинжилгээ”, “Газар, удирдлага, эрх зүй” түүвэр өгүүлэл, УБ, 2005, 67 дахь тал.

⁸ Монгол Улсын Үндсэн хууль - Төрийн мэдээлэл, 1992, №1.

⁹ Д.Гангабаатар, “Хувийн өмчийн газрыг шууд бусаар дайчлан авахаас хамгаалах Үндсэн хуулийн зохицуулалт”, Эрх зүй сэтгүүл, 2015, №1(31) 66 дахь тал.

¹⁰ Д.Гангабаатар, “Үндсэн хуулийн эрх зүй” төрийн байгуулал, зарчим, үзэл баримтлал, УБ, 2016, 103 дахь тал.

¹¹ Монгол Улсын Үндсэн хууль - Төрийн мэдээлэл, 1992, №1.

¹² Н.Лүндэндорж, Монгол Улсын Үндсэн хууль шинжлэх ухааны тайлбар, УБ, 2022, 88 дахь тал.

газар өмчлүүлэх тухай хуульд төрийн албан хаагчид захиргааны эрх мэдлээ урвуулан ашиглахаас хамгаалах арга хэмжээ хангалтгүй туссан, мөн газар өмчлөгч эрх, үүргээ шударгаар хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бий болгох нь зүйтэй.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 1-т батлан хамгаалах, аюулгүй байдал, шинжлэх ухааны туршилт, зам, шугам сүлжээ, барилга байгууламж¹³ барихыг тусгай хэрэгцээ гэж үзээд, 34.1-т байгалийн гамшиг, осол, онцгой тохиолдлыг зайлшгүй хэрэгцээ гэж үзжээ. Харин Газрын тухай хуулийн 16.3-р зүйлд улсын тусгай хамгаалалттай газар, улсын хилийн зурвас газар, улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах газар, аймаг дундын отрын бэлчээр зэрэгт зориулан газрын нэгдмэл сангийн аль ч ангиллын газрыг улсын тусгай хэрэгцээнд авч болохоор байгаа юм.¹⁴ Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Иргэн нь хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно” гэж хувийн өмчийг дээдлэн хууль зүйн баталгааг тодорхой тусгаж өгсөн билээ.¹⁵ Үүний зэрэгцээ тус зүйлд “Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө”¹⁶ гэжээ. Өөрөөр хэлбэл, төр түүний эрх бүхий байгууллага нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмч ялангуяа иргэний газрыг шаардлагатай тохиолдолд нөхөх олговортойгоор дайчлан авч болно. Энэхүү нөхөх олговор нь урьдчилан олгогдсон байх бөгөөд шударга¹⁷ зарчимд нийцсэн байх явдал юм. Энэ зүйлийн эд хөрөнгийг дайчлан авах гэдэгт иргэний өмчийн газар хамаарна. Мөн зайлшгүй хэрэгцээ гэдэг нь нэн даруй хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай нийгмийн хэрэгцээг ойлгоно.¹⁸ Тухайлбал, Төсөл хэрэгжүүлэгч нь сонгосон талбай дахь газар, үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөгч, эзэмшигчтэй харилцан тохиролцож, гэрээ байгуулсны үндсэн дээр газрыг газраар солих, газрыг орон сууцаар солих, газрыг худалдах, худалдан авах зэрэг аргаар шилжүүлэн авч болохоор Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд¹⁹ заажээ.

Газрын харилцааны асуудлыг шийдвэрлэх талаар УИХ, ЗГ, Аймаг, Нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын эрх хэмжээг Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиар²⁰ тодорхойлсон билээ. 2002 онд газрыг хязгаартай өмчилж Монгол Улсын иргэнд гэр бүлийн хэрэгцээний, аж ахуйн²¹ гэсэн хоёр зориулалтаар аймаг, нийслэл, сум, дүүрэг, тосгонд газар өмчлүүлэхээр заасан байна. Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь газрын бодлогын асуудлыг нэгтгэн зангидаж, иргэдэд өмчлүүлэх газрын байршил, зориулалт, хэмжээ, заагийг сум, дүүрэг тус бүрээр нэгтгэн бүртгэнэ гэж Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 10 дугаар зүйлд заажээ.

Үндсэн Хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт: Хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн²² гэж заасан. Доктор Д.Сугар Өмчлөх эрхийг хамгаалах хууль тогтоомж бүрэн хэмжээгээр боловсронгуй болж амжаагүй, хүний үндсэн эрхийн халдашгүй байдлыг бүрэн хэмжээгээр үнэлж хүлээн зөвшөөрч сураагүй байна. Иргэдийн дунд ийм сэтгэл зүй бүрэлдээгүйгээс гадна эрх зүйн бодлого, үзэл суртлыг боловсруулах үүрэгтэй төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтнуудын эрх зүйн соёл дутмаг

¹³ Монгол Улсын Иргэнд газар өмчлүүлэх тухай хууль - Төрийн мэдээлэл, 2002, №27(264).

¹⁴ Газрын тухай хууль - Төрийн мэдээлэл, 2002 он, №27(264) 2002.

¹⁵ Г.Батаа, Ч.Жадамба, Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн төр иргэний газрыг дайчлан авахтай холбоотой нөхөн олговрын хүрээг тодорхойлоход тулгамдаж буй эрх зүйн асуудал, Эрх зүй сэтгүүл, 2013, №2, 50-51 дэх тал.

¹⁶ Монгол Улсын Үндсэн хууль - Төрийн мэдээлэл, 1992, №1.

¹⁷ Г.Совд нар. Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, Уб, 2000, 44 дэх тал.

¹⁸ Д.Гангабаатар, “Үндсэн хуулийн эрх зүй” төрийн байгуулал, зарчим, үзэл баримтлал, Уб, 2016, 109 дэх тал.

¹⁹ Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль -Төрийн мэдээлэл, 2015, №28(889).

²⁰ Монгол Улсын Иргэнд газар өмчлүүлэх тухай хууль - Төрийн мэдээлэл, 2002, №27(264).

²¹ Мөн тэнд, 4-р зүйл.

²² Монгол Улсын Үндсэн Хууль - Төрийн мэдээлэл, 1992, №1.

байгаа шалтгаанаар өмчлөх эрх зөрчсөн тухай маргаан Үндсэн хуулийн цэц, Иргэний болон Захиргааны шүүхүүдэд тасрахгүй байгаа²³ нь газар өмчлөх эрхийн зөрчил их байгааг харуулж байна.

II. Газар чөлөөлөх, газар өмчлөгчийн эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалт

Иргэний өмчийн газрыг улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах /Eminent domain/ Орчин цагийн төр улсууд нийтийн эрх ашгийн үүднээс хувийн өмчийн газрыг нөхөн төлбөр төлөх замаар өөрийн өмчлөлд эргүүлэн авах эрхийг хадгалан авч үлддэг нь нийтлэг байна. Төрөөс уг эрхийг хэрэгжүүлэхгүйгээр нийтийн зорилт, эрх ашгийг хамгаалах боломжгүй болдог.²⁴ Доктор Н.Лүндэндорж “дэлхий нийтэд нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийг дайчлан авах эрх зүйн байх ёстой процесс нь зөвхөн нөхөн олговор олгох тухай бус, харин тэр нь шударга нөхөх олговор байх ёстой”²⁵ гэжээ. Хувийн өмчийг албадан авахдаа шударга нөхөх олговор олгох, эрх зүйн зохих ёсны процедур /due process of law/-ыг хангах ёстой.²⁶ Үндсэн хууль нь төрд хувийн газар өмчлөх эрхийг цуцлах ихээхэн эрх мэдлийг өгдөг. Газар өмчлөгчийн нөхөн төлбөр авах эрхийг Үндсэн хуульд заасан байдаг бол газар эзэмшигчийн нөхөн төлбөр авах эрхийг зөвхөн Газрын тухай хуульд заасан байдаг. Мөн энэ талаар газар ашиглагчдын эрхийг хамгаалах үндсэн хуулийн хэллэг нь «Улсын тусгай хэрэгцээ» гэж юу болох нь тодорхойгүй байна.²⁷

Монгол Улсын иргэний өмчийн газрыг чөлөөлөхдөө Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 9.1.4-т Засгийн газар иргэний өмчийн газрыг улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах шийдвэр гаргах; Газрын тухай хуулийн 18.1.3-т улсын тусгай хэрэгцээнд авахтай холбогдуулан газрыг солих буюу эргүүлэн авах тохиолдолд нөхөх олговор олгох гэж тус тус заасан. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн²⁸ 32.1-т заасан 3-н тохиолдолд иргэний өмчийн газрыг засгийн газрын шийдвэрээр нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авна. Үүнд:

1. Улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах;
2. Шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай байгуулах;
3. Улсын чанартай зам, шугам сүлжээ, барилга байгууламж барих гэж заажээ;

Ийнхүү иргэний өмчийн газрыг улсын тусгай хэрэгцээнд авахдаа газрыг зайлшгүй солих, эргүүлэн авах болсон зориулалт, үндэслэлийг тодорхой зааж, газрыг нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах тухай шийдвэр гарахаас нэгээс доошгүй жилийн өмнө газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага газар өмчлөгчтэй урьдчилан тохиролцсон байхаар уг хуулийн 32.3 болон 32.5 дугаар зүйлүүдэд хуульчилсан байна. Ийнхүү газар эзэмшигчтэй урьдчилсан хэлэлцээр хийхдээ дараах асуудлыг харилцан тохиролцоно. Үүнд:

- Тухайн газрын үнэ;
- тухайн газар дээрх үл хөдлөх эд хөрөнгийн үнэ;
- өмчлөгчөөс уг газарт зарцуулсан хөрөнгө, газрыг улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авснаас өмчлөгчид учрах хохирлын хэмжээ;
- улсын тусгай хэрэгцээнд авах газрын хэмжээ;
- улсын тусгай хэрэгцээнд авсан газрыг сольж олгох газрын байршил, хэмжээ, төлөв байдал, чанар;

²³ Д. Сугар, Өмчийн харилцааны хөгжил, эрх зүйн зохицуулалтын зарим асуудал, У6, 2020.

²⁴ Kevin Gray, Land law and human rights, Willan Publishing, 2002, 2011, 145 дэх тал.

²⁵ Н.Лүндэндорж, Нийтийн болон хувийн өмчийн эрх зүйн тулгамдсан асуудал, У6, 2012, 41 дэх тал.

²⁶ С.Нарангэрэл, “English – Mongolian jurisprudence dictionary”, У6, 2005, 344 дэх тал.

²⁷ Robin Mearns. Pastoral institutions, land tenure and land policy reform in Post-Socialist Mongolia, <https://opendocs.ids.ac.uk/opendocs/bitstream/handle/20.500.12413/2427/Research%20Report%20No.3.pdf?sequence=1>.

²⁸ Монгол Улсын Иргэнд газар өмчлүүлэх тухай хууль -Төрийн мэдээлэл, 2002, №27(264).

- газрыг чөлөөлөх нөхцөл, хугацаа;
- газрыг чөлөөлөхтэй холбогдон талуудын хүлээх үүрэг, хариуцлага;
- нөхөх олговрын хэмжээ, түүнийг төлөх журам, хугацаа;

Иргэний газрын нөхөн олговрыг улсын төсвөөс гаргах бөгөөд хэрэв талууд хэлэлцээр хийгээд зөвшилцөлд хүрээгүй бол маргааныг Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 32.7-д заасны дагуу шүүх шийдвэрлэнэ.²⁹

Энэ нь төрөөс газрыг эргүүлэн авах талаар тухайн өмчийн эзэнтэй тохиролцоно гэснээс бус зөвшилцөх, эрх зүйн туслалцаа авах бололцоо хангагдсан эсэх, тухайн орон нутаг нийтэд мэдээлэх, тэдэнтэй зөвлөлдөн хэлэлцэж, ил тод нээлттэй байх зарчим тусгагдаагүй, мөн хуулинд урьдчилан тохирох гэсэн хугацаа гаргаж өгсөн мэт боловч тухайн орон нутгийн иргэд нийтээрээ ижил түвшний мэдээлэл авч хэлэлцэх, алдах боломж, орчны өөрчлөлтөө хэлэлцэх бололцоог хангах заалт хуульчлагдаагүй байна.³⁰

Газар өмчлөгч нь улсын тусгай хэрэгцээний улмаас өртсөн газарт дараах эрхтэй байна.

- Газрын асуудал эрхэлсэн байгууллагын эрх мэдэлтэнтэй тохиролцсоны дагуу улсын тусгай хэрэгцээний улмаас өртсөн газрын нөхөн төлбөрийг бүрэн төлөхийг шаардаж, хуульд заасан хууль зүйн үндэслэл, журам, тогтоосон хугацааны дагуу тэдэнд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар зохих арга хэмжээ авахыг шаардах, өмчлөгчөөс тухайн газарт зарцуулсан хөрөнгийг нөхөн төлүүлэх болон иргэний өмчилж байсан газарт байгаа үл хөдлөх эд хөрөнгийн зах зээлийн үнэтэй тэнцэх нөхөн төлбөр авах,

- Улсын тусгай хэрэгцээнд нөхөн олговортойгоор иргэний өмчлөлийн газрыг авах тухай засгийн газрын шийдвэр хууль болон бусад эрх зүйн актуудтай зөрчилдөж байгаа, эсвэл газар өмчлөгчийн эрхийг зөрчсөн гэж үзвэл газар өмчлөгч нь уг шийдвэрийг хүчин төгөлдөр бус хэмээн шүүхэд хандах эрхтэй иргэний газар өмчлөх эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн шийдвэрийн улмаас иргэнд учирсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан байгууллага нөхөн төлөхөөр Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 36 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заажээ.

- Хувийн гэр, орон сууцны хашааны газрыг нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах тохиолдолд түүнийг чөлөөлөх ажлыг зөвхөн 5 дугаар сарын 15-ны өдрөөс 9 дүгээр сарын 15-ны өдрийн хооронд хийхээр Газрын тухай хуулийн 42-р зүйлийн 4-т хуульчилсан.³¹

Нийгмийн зайлшгүй хэрэгцээ – Үндсэн хуульд тусгасан энэ ойлголтыг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжуудаас зөвхөн Патентын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 1.1-д “үндэсний аюулгүй байдал, баглан хамгаалах, хүн, амьтны эрүүл мэнд, хүнсний хангамж зэрэг нийгмийн зайлшгүй хэрэгцээнд шаардлагатай бол” лизенц эзэмшигчид төлбөр төлөх болзолтойгоор албадан лизензээр ашиглуулахаар шийдвэрлэж болно гэжээ. Нийгмийн зайлшгүй хэрэгцээ болон улсын тусгай хэрэгцээний заагийг тодорхойлох төрийн байгууллага, төрийн албан хаагч, иргэд, аж ахуй нэгж байгууллагад нэгдсэн ойлголтод хүрэх шаардлага үүсч байна. Хэрэв нийгмийн зайлшгүй хэрэгцээг улсын тусгай хэрэгцээ мөн гэж үзвэл тусгай хэрэгцээний ангилалд нэмж оруулах нь зүйтэй.

Иргэний өмчийн газрыг дайчлан авах - Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн³² 34 дүгээр зүйлд зааснаар иргэний өмчийн газрыг хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан үрэгдэх, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд их хэмжээний хохирол учруулахуйц гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон, аюул үүссэн тохиолдолд гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд зориулан иргэний өмчийн газрыг хуульд заасан журмын

²⁹ Монгол Улсын Иргэнд газар өмчлүүлэх тухай хууль -Төрийн мэдээлэл, 2002, №27(264).

³⁰ Н.Баярсайхан, Л.Дондов, “Газар чөлөөлөх бодлогод эрхэд суурилсан хандлагыг нэвтрүүлэх шаардлага” илтгэл, “Газартай холбоотой хүний эрхийн асуудлууд” онол, практикийн бага хурал, 2015.

³¹ Газрын тухай хууль - Төрийн мэдээлэл, 2002, №27(264).

³² Монгол Улсын Иргэнд газар өмчлүүлэх тухай хууль-Төрийн мэдээлэл, 2002, №27(264).

дагуу аймаг, нийслэл, дүүрэг, сумын Засаг даргын шийдвэрээр түр хугацаагаар дайчлан авч болохоор хуульчилсан байна. Ийнхүү Дайчлан авсаны улмаас газар өмчлөгч иргэнд учирсан хохирлыг нь бүрэн хэмжээгээр нөхөн төлнө. Мөн Дайчлан авсан газрыг эргүүлэн өгөх боломжгүй болсон тохиолдолд өмчлөгчид нь уг газрын үнэ, хохирлыг тухайн үеийн зах зээлийн ханшаар тооцож нөхөн төлөх буюу дайчлан авсан газраас төлөв байдал, чанарын хувьд дордохооргүй өөр газрыг өмчлүүлж учирсан хохирлыг нөхөн төлөхийн зэрэгцээ газар өмчлөгч иргэнд учирсан хохирлын хэмжээг тогтоохтой холбогдсон маргааныг шүүх шийдвэрлэнэ гэж заажээ. Газрыг дайчлан авах зохицуулалтад Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 34.1-д "... хуульд заасан журмын дагуу..." газрыг түр хугацаагаар дайчлан авахаар хуульчилсан боловч "хуульд заасан журам" гэх ойлголтыг хуулиар зохицуулаагүй байна.³³

Иргэний өмчийн газрыг хураах – Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 35 дугаар зүйлд зааснаар Газар өмчлөгч иргэн буюу түүний газрыг энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасны дагуу эзэмшиж, ашиглаж байгаа этгээд энэ хуулийн 28 дугаар зүйлд заасныг зөрчсөн бол шүүхийн журмаар түүний газрыг хураан авч болно. Иргэний өмчийн газрыг хураах үндэслэл нь хуульд хангалттай бэхжигдсэн хэдий ч иргэн, захиргааны дагнасан шүүхийн аль шүүх нь хэрэг маргааныг шийдвэрлэх эсэх нь нарийвчилсан зохицуулалтгүй байна.³⁴ Түүнчлэн бусдын өмчлөлийн газрыг эзэмшиж, ашиглаж байгаа этгээдийн хууль зөрчсөн үйлдлийн улмаас иргэний өмчийн газрыг хураах нь шударга ёсны зарчимд тохирох эсэхийг анхаарах нь зүйтэй.

2008 оны Хот байгуулалтын тухай хуулийн 27 дугаар зүйлд хот байгуулалтын батлагдсан төлөвлөлтийн дагуу иргэнийг албадан нүүлгэх тохиолдолд түүний газар, бусад үл хөдлөх эд хөрөнгө болон энэ хугацаанд тухайн газарт эрхэлж байсан аж ахуйн үйл ажиллагаанаас олох байсан орлогыг нь үнэлэх асуудлыг тусгайлан хуулиар зохицуулж, албадан нүүлгэх, түүнчлэн иргэний эзэмшлийн газрыг тохиролцсоны үндсэн дээр төр худалдан авах тохиолдолд нүүлгэн шилжүүлэхэд гарах тээврийн болон холбогдох бусад зардлыг иргэнд нөхөн олгохоор заажээ. Иймд иргэний газар өмчлөх эрхийг тасалдуулахгүй байх үүднээс нөхөх олговорт газар, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээнээс гадна, бизнесийн үйл ажиллагааны ашиг орлогын хохирол, алдагдал, үл хөдлөх эд хөрөнгийг буулгах, нүүлгэн шилжүүлэх зардал, амьдрах түрээсийн байрны хөлс зэргийг тооцох нь зөв байна.³⁵

Газрыг хураан авахтай холбоотойгоор Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "Иргэд хувийн өмчийнхөө газрыг худалдах, арилжих, бэлэглэх, барьцаалах зэргээр гадаадын иргэн, харьяалалгүй хүний өмчлөлд шилжүүлэх, түүнчлэн төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр бусдад эзэмшүүлэх, ашиглуулахыг хориглоно" гэсэн заалт нь нэг мөр ойлгоход нэлээд бэрхшээлтэй. Энэ заалтыг ойлгохдоо³⁶

Нэгд, "Бусдад" гэдэг үгийг гадаадын иргэн, харьяалалгүй хүн гэж уншвал "Иргэд хувийн өмчийнхөө газрыг худалдах, арилжих, бэлэглэх, барьцаалах зэргээр гадаадын иргэн, харьяалалгүй хүний өмчлөлд шилжүүлэх, түүнчлэн төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр бусдад эзэмшүүлэх, ашиглуулахыг хориглоно". Харин төрийн эрх бүхий байгууллага зөвшөөрвөл гадаадын иргэн, харьяалалгүй хүнд эзэмшүүлж, ашиглуулж болно гэж нэг ойлгож болно. "Бусдад" гэдэгт Монгол Улсын иргэнийг хамааруулж ойлгохгүй зөвхөн гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг багтааж ойлгох онолын өөр нэг үндэслэл бол өмчлөх эрх хүний салшгүй жам ёсны үндсэн эрх учраас түүнийг ямар нэг зөвшөөрлөөр

³³ Р.Очирбал, "Газрын эрх ба хязгаарлалт" илтгэл, "Газартай холбоотой хүний эрхийн асуудлууд" онол, практикийн бага хурал, 2015.

³⁴ Р.Очирбал, "Газрын эрх ба хязгаарлалт" илтгэл, "Газартай холбоотой хүний эрхийн асуудлууд" онол, практикийн бага хурал, 2015.

³⁵ З.Өнөржаргал, "Албадан нүүлгэлт ба төрийн оролцоо" илтгэл, "Газартай холбоотой хүний эрхийн асуудлууд" онол, практикийн бага хурал, 2015.

³⁶ Н.Лүндэндорж, "Монголд газрыг хувьд өмчилж байсан эсэх талаархи түүхэн маргаан, түүнд хийсэн түүх, философи, эрх зүйн шинжилгээ", "Газар, удирдлага, эрх зүй" түүвэр өгүүлэл, УБ, 2005, 77-79 дэх тал.

хязгаарлаж болохгүй Монгол Улсын Үндсэн хуулиар өмчлөх эрхийг хүлээн зөвшөөрч, газрыг хувьд өмчилж болно гэж заасан учраас өмчлөх эрхийн агуулгад халдсан заалт эрх зүйт Үндсэн хуульд байх ёсгүй гэсэн үзлийн үүднээс авч үзэх явдал юм.

Хоёрт, “Бусдад” гэдэг үгийг Монгол Улсын иргэд гэж уншвал “Иргэд хувийн өмчийнхөө газрыг худалдах, арилжих, бэлэглэх, барьцаалах зэргээр гадаадын иргэн, харьяалалгүй хүний өмчлөлд шилжүүлж үл болно. Түүнчлэн иргэд хувийн өмчийн газраа бусдад /өөрийн улсын иргэд/ эзэмшүүлэх, ашиглуулахдаа төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрөл авна” гэсэн утгаар ойлгоно. Үүнийг баримталж Монгол Улсын Иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1-д “Иргэн өмчийн газраа зориулалтаар нь, тодорхой хугацаагаар сум, дүүргийн Засаг даргын зөвшөөрлөөр бусдад эзэмшүүлж, ашиглуулж” болно,³⁷ 29.2-т уг газраа бусдад эзэмшүүлэх, ашиглуулах хүсэлтээ сум дүүргийн засаг даргад бичгээр гаргаж³⁸ Засаг дарга хүсэлтийг хүлээж авсанаас хойш 15 хоногийн дотор шийдвэрлэнэ.³⁹ Тус хуулийн 28 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэгт зааснаар “Өмчийн газраа энэ хуулийн 29.1-д заасан зөвшөөрөлгүйгээр бусдад эзэмшүүлэх, ашиглуулахыг хориглоно”, улмаар иргэний өмчийн газрыг хураах тухай 35-р зүйлийн 35.1-д Газар өмчлөгч иргэн буюу түүний газрыг энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасны дагуу эзэмшиж, ашиглаж байгаа этгээд энэ хуулийн 28 дугаар зүйлд заасныг зөрчсөн бол шүүхийн журмаар түүний газрыг хураан авч болохоор Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 5-д заасан байна. Энэ хуулийн 3 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэгт: “иргэнд газар өмчлүүлэх” гэж Монгол Улсын Үндсэн хуульд Монгол Улсын иргэнд өмчлүүлж болохоор заасан газраас энэ хуульд заасан хэмжээ, болзол, шаардлага, журам, нөхцөлөөр иргэний өмчлөлд шилжүүлэхийг⁴⁰ хэлнэ. Өөрөөр хэлбэл, энэ хуулийн үйлчлэх хүрээ нь гагцхүү иргэдийн өмчлөлд газар шилжүүлэх харилцаагаар хязгаарлагдах ёстой байхад иргэний эрх зүйн үндсэн суурь зарчим болох өмчийн халдашгүй байдлын зарчмыг бүдүүлгээр зөрчиж⁴¹ үйлчилж байгааг засах шаардлагатай. Тухайлбал, өмчийн эзэн Монгол Улсын иргэн өмчилж буй газраа өөр хоорондоо захиран зарцуулахдаа өмчлөх эрхээ хэрэгжүүлэх эрхтэй атлаа бусдад эзэмшүүлэх, ашиглуулахдаа төрийн эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авах нь утга чанаргүй бөгөөд өмчлөх эрхийг нь хязгаарласан хэрэг болж таарна. Үндсэн хуулийн 6.3-т Гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнд эзэмшүүлэхээс сэрэмжилж зөвшөөрөл авах тухай заалт оруулсан гэж үзвэл төрийн эрх бүхий байгууллага зөвшөөрвөл гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүн газар эзэмшиж болох хууль зүйн логик гарна. Гэтэл Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар “Төрөөс гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнд газрыг төлбөр, хугацаатайгаар болон хуульд заасан бусад болзол, журмаар ашиглуулж болно” гэж заасан. Ингэхлээр гадаадын иргэн, харьяалалгүй хүнд Монгол Улсын иргэн өмчийн газраа эзэмшүүлж болзошгүйг зохицуулах үүднээс иргэдийнхээ өмчлөх эрхийн агуулгыг хязгаарлахад хүрсэн байна.⁴²

Иймээс Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 3-ыг “Иргэд хувийн өмчийнхөө газрыг худалдах, арилжих, бэлэглэх, барьцаалах зэргээр гадаадын иргэн, харьяалалгүй хүний өмчлөл, эзэмшилд шилжүүлэхийг хориглоно” гэж өөрчилбөл Газрын тухай хууль болон Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиудын Монгол Улсын иргэний өмчлөх эрхийг хязгаарласан заалтуудыг хүчингүй болгох шаардлага бий болох юм.

³⁷ Монгол Улсын Иргэнд газар өмчлүүлэх тухай хууль -Төрийн мэдээлэл, 2002, №27(264).

³⁸ Монгол Улсын Иргэнд газар өмчлүүлэх тухай хууль -Төрийн мэдээлэл, 2002, №27(264).

³⁹ Монгол Улсын Иргэнд газар өмчлүүлэх тухай хууль -Төрийн мэдээлэл, 2002, №27(264).

⁴⁰ Монгол Улсын Иргэнд газар өмчлүүлэх тухай хууль -Төрийн мэдээлэл, 2002, №27(264).

⁴¹ Янжинхорлоо Д. Монгол улсын иргэний эрх зүй, үл хөдлөх эд хөрөнгийн эрх зүй, 2016, 67 дахь тал.

⁴² Лүндэндорж Н. “Монголд газрыг хувьд өмчилж байсан эсэх талаархи түүхэн маргаан, түүнд хийсэн түүх, философи, эрх зүйн шинжилгээ”, “Газар, удирдлага, эрх зүй” түүвэр өгүүлэл, УБ, 2005, 79 дэх тал.

III. Газрыг нөхөх олговортойгоор авах гадаад улсын эрх зүйн зохицуулалт

Эртний Ромын эзэнт гүрний нэг захаас нөгөө зах хүртэл шулуун шугамаар буюу Ромын усан суваг татсан усан сувгийн байгууламж нь хувийн өмч, газрыг дайчлан авч бүтээн байгуулалтыг хийсэн байх гэдэг дээр судлаачид санал нэгддэг.⁴³ Газар албадан чөлөөлөх талаар 1948 онд НҮБ-ээс батлан гаргасан “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”-ын 17 дугаар зүйлд: Хүн бүр эд хөрөнгийг хувьдаа буюу бусадтай хамтран өмчлөх эрхтэй. Хэний ч эд хөрөнгийг дураар хураан авч болохгүй гэж иргэний эд хөрөнгө өмчлөх эрхийг олон улсын хэмжээнд тунхагласан.⁴⁴ Олонх улсын хууль тогтоомжид үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг тусад нь зааглаж үздэг бөгөөд үл хөдлөх эд хөрөнгийн талаарх хууль тогтоомж, шүүхийн практик, номлолд үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх нь уг хөрөнгийн оршин буй газар нутгийн хуулиар зохицуулагдана гэсэн зарчмыг баримталдаг. Гадны зарим орны Үндсэн хуульд иргэний өмчийн газрыг солих буюу эргүүлэн авах, газартай нь холбогдсон үүрэг хүлээлгэх, хураан авах⁴⁵ хэд хэдэн төрлийн зохицуулалтыг тусгажээ. НҮБ-ын судалгаагаар зах зээлийн эдийн засагтай хөгжингүй олон оронд газар чөлөөлөх нөхөн олговрын стандарт нь тухайн газрын зах зээлийн шударга үнэд суурилдаг.⁴⁶ Зарим улс орны эрх зүйн зохицуулалтыг харьцуулан авч үзье.

Англи улс. 1215 оны Магна Хартын 39 дүгээр зүйлд: Чөлөөт иргэний өмч хөрөнгийг хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр, эсвэл хуульгүйгээр... булааж... болохгүй. Хувийн ямар ч өмчийг шударга нөхөн олговоргүйгээр нийтийн хэрэгцээнд хураан авч болохгүй, 40 дүгээр зүйлд Хүний эрх, шударга ёсыг үгүйсгэх эсвэл түүнд саад тотгор хийхийг хэнд ч зөвшөөрөхгүй⁴⁷ гэж заасан нь эрх зүйн шударга процесс болон хөгжих суурийг тавьжээ. Өөрөөр хэлбэл Тухайн иргэний газар өмчлөх эрх нь хүний салшгүй эрх байдаг тул хүчин төгөлдөр хуулийн дагуу эсвэл шүүхийн шийдвэрийн үндсэн дээр албадан авах бөгөөд шударга нөхөх олговор олгох санааг тусгажээ.

ХБНГУ. Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлд: Өмч болон өв залгамжлах эрх нь баталгаатай байна. Өмч нь үүрэг үүсгэнэ, нийтийн сайн сайхны төлөө өмчийг албадан хурааж болно. Ийнхүү газрыг нийтийн өмчлөлд нөхөн олговрын хүрээ болон хуульд үндэслэн шилжүүлж болно⁴⁸ гэж Үндсэн хуулийн 15 дугаар зүйлийн 1-т заажээ. Энэ нь өмчлөх эрхийг Үндсэн хуулиар хамгаалж баталгаажуулдаг ч газар өмчлөх эрхийг хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж, өмчийг нийгмийн ашиг сонирхлын төлөө нөхөн төлбөртэй хураан авч болдог. Өмчийн эрхийг хамгаалахын зэрэгцээ нийтийн ашиг сонирхлын төлөө өмчийн эрхийг хязгаарлахыг зөвшөөрсөн онцлогтой юм. ХБНГУ-д нийтийн зайлшгүй хэрэгцээ, нийтийн чухал хэрэгцээ, нийтийн ашиг сонирхол хэмээн гурав ангилж үздэг ба зарим эрх, эрх чөлөөг хязгаарлахын тулд зөвхөн нийтийн зайлшгүй хэрэгцээнд л үндэслэн хязгаарлаж болно гэж үздэг.⁴⁹ Газар өмчлөх эрхийг хуулиар хамгаалж, газрыг нийтийн сайн сайхны төлөө ашиглах ёстойг Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заажээ.⁵⁰ Тухайлбал, улсын хэрэгцээний шаардлагаар газар өмчлөх эрхийг хурааж болох бөгөөд энэ нөхцөлд зах зээлийн үнээр газрын төлбөр төлдөг. ХБНГУ-ын хуулиар төр нь хувийн өмчлөлд байгаа газрыг захиргааны акт гаргах замаар хураан авч болдог. Газрыг төрийн өмчлөлд зөвхөн дараах нөхцөлд шилжүүлэн авахыг зөвшөөрдөг. Үүнд:

⁴³ Дам ишлэв. Jones, Expropriation in Roman law, 45 L.Q. Rev. 512, 521 (1929), See also Pound, The Valuation of Property in Roman law, 34, HARV.L. Rev. 227, 252, (1921).

⁴⁴ Universal Declaration of Human Rights, <https://www.un.org/sites/un2.un.org/files/2021/03/udhr.pdf>

⁴⁵ М.М. Богуславский. Международное частное право, 1994 г, стр 165.

⁴⁶ Food and Agriculture Organization of the United Nations (2008). Compulsory Acquisition of Land and Compensation. FAO Land Tenure Studies: 23, 27-30, 40-41, 43, 53.

⁴⁷ Магна Харт, Орчуулсан П. Амаржаргал, Уб, 2012, 12 дахь тал.

⁴⁸ ХБНГУ-ын Үндсэн Хууль, Уб, 2020, Орчуулсан: П. Амаржаргал.

⁴⁹ Д.Гангабаатар, “Нөхөх олговрын тухай Үндсэн хуулийн үзэл баримтлалын онолын үндэс”, Хууль дээдлэх ёс сэтгүүл, 2015, №1(51).

⁵⁰ ХБНГУ-ын Үндсэн Хууль, Уб, 2020, Орчуулсан: П. Амаржаргал, 14.2-р зүйл.

- Дэд бүтцийн байгууламж, зам, шугам сүлжээ, эрчим хүч,
- Нийтийн орон сууцны барилга, үйлдвэрийн байгууламж,
- Нийгмийн барилга байгууламж барих зорилгоор шилжүүлэн авахаар заасан байна.

Ингэхдээ тухайн зориулалтын байгууламжийг барихад үүнээс өөр газрын боломжгүй нөхцөлд энэхүү ажлыг хэрэгжүүлнэ.⁵¹

ОХУ. Эдэлбэр газрыг төрийн хэрэгцээнд, нутгийн захиргааны хэрэгцээнд гэсэн 2 төрлийн хэрэгцээнд хураан авах ба “Эдэлбэр газрыг тусгай хэрэгцээнд эргүүлэн авах тухай хууль”-иар зохицуулна. Газрын тухай хуулиар хураагдаж байгаа газрын оронд мөнгө биш газар олгохыг зөвшөөрдөг.⁵² Газрыг тусгай хэрэгцээнд авах тусгайлсан хуулийн зохицуулалт үйлчилдэг.

БНХАУ. Иргэний хуулийн II дугаар хэсгийн 4-р бүлгийн 240 дүгээр зүйлд: Өмчлөгч нь хууль ёсны дагуу үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийг эзэмших, ашиглах, ашиг хүртэх, захиран зарцуулах эрхтэй⁵³ бөгөөд хуульд төрийн өмч гэж заасан үл хөдлөх... хөрөнгийг аливаа байгууллага, хувь хүн өмчлөх эрхгүй.⁵⁴ Хамтын өмчийн газрыг хууль, журмын дагуу хураан авбал газрын нөхөн олговор, нүүлгэн шилжүүлэлтийн татаас, газар дээрх бусад эд хогшлын нөхөн олговрыг бүрэн хэмжээгээр төлнө⁵⁵ гэж заажээ.

Хятад Улсын Газар удирдах тухай хууль⁵⁶-д тусгасан зохицуулалтыг авч үзье.

Тус хуулийн 45 дугаар зүйлд зааснаар Нийтийн ашиг сонирхлын үүднээс тариачдын хамтын өмчлөлийн газрыг цэргийн болон дипломат, барилга байгууламж барих, эрчим хүч, зам тээвэр, усны нөөц, харилцаа холбоо, шуудан болон бусад дэд бүтцийг барих, Шинжлэх ухаан, технологи, боловсрол, соёл, эрүүл мэнд, спорт, экологийн орчин, орон сууцны төслүүдийг засгийн газраас зохион байгуулж байгаа бол газрыг хуулийн дагуу албадан чөлөөлөх ажлыг хийж болно.

Мөн хуулийн 46-р зүйлд байнгын үндсэн тариалангийн талбай, тариалангийн талбай 35 га-аас дээш, 70 га-аас дээш талбай бүхий газрыг эргүүлэн авах ажиллагааг Төрийн зөвлөлийн зөвшөөрлийг авна.

Үүнд хөдөө аж ахуйн газрыг өөрчлөх асуудлыг Төрийн зөвлөл зөвшөөрсөн бол газар эргүүлэн авах зөвшөөрөл олгох журмыг нэгэн зэрэг авах, газар эргүүлэн авах зөвшөөрлийг тусад нь авч хэлэлцэхгүй; Хэрэв тариалангийн газрыг өөрчлөхийг зөвшөөрөл авах ба газар эргүүлэн авах зөвшөөрлийг хамтдаа Муж, Өөртөө засах орон, шууд харьяа хотын засгийн газраас зөвшөөрөл авна. Хэрэв газар эргүүлэн авах асуудал нь Төрийн зөвлөлийн харьяалах асуудал бол энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу тусад нь шийдвэрлэнэ.

47-р зүйл. Төрөөс газрыг эргүүлэн авахдаа хууль журмын дагуу зөвшөөрөл авсны дараа Сум, дүүргийн хэмжээнд буюу түүнээс дээш орон нутгийн засаг захиргаа зарлаж хэрэгжүүлнэ.

- Тухайн Сум, дүүргийн болон түүнээс дээш түвшний орон нутгийн засаг захиргаа газар эргүүлэн авах хүсэлт гаргах гэж байгаа бол эргүүлэн авах газрын өнөөгийн нөхцөл байдалд судалгаа хийж, нийгмийн тогтвортой байдлын эрсдэлийн үнэлгээг хийж, хамрах хүрээ, одоогийн газрын байдал, эргүүлэн авах зорилго, нөхөн олговор олгох стандарт, нүүлгэн шилжүүлэх арга, тухайн газрын байршил дахь нийгмийн хамгаалал зэрэг асуудлыг Тосгон, тосгоны багд 30-аас доошгүй хоногийн хугацаатай зарлах, тухайн хөдөөгийн хамтын аж ахуйн байгууллагууд болон тэдгээрийн гишүүдийн, тосгоны хороодын болон бусад ашиг сонирхолтой этгээдийн санал бодлыг сонсоно.

⁵¹ Б.Гантулга, Б.Сайнжаргал, ХБНГУ-ын үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний тогтолцоо, эрх зүйн орчны туршлага, Уб, 2010, 28 дахь тал.

⁵² С.Энхмэнд, “Иргэний өмчийн газрыг төр улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах эрх зүйн үндэслэл” илтгэл, “Газартай холбоотой хүний эрхийн асуудлууд” онол, практикийн бага хурал, 2015.

⁵³ БНХАУ-ын Иргэний хууль, Уб, 2021, орчуулсан: Х.Цэрэндолгор, 240-р зүйл.

⁵⁴ БНХАУ-ын Иргэний хууль, Уб, 2021, орчуулсан: Х.Цэрэндолгор, 242-р зүйл.

⁵⁵ БНХАУ-ын Иргэний хууль, Уб, 2021, орчуулсан: Х.Цэрэндолгор, 243-р зүйл.

⁵⁶ Land administration law of the people's republic of china, <https://faolex.fao.org/docs/pdf/chn3560.pdf>.

- Газар эргүүлэн хураагдсан хөдөө орон нутгийн нэгдлийн аж ахуйн байгууллагын олонх гишүүд газар эргүүлэн авах нөхөн олговор олгох, нүүлгэн шилжүүлэх төсөл нь хууль тогтоомжид нийцэхгүй байна гэж үзвэл тухайн хошуу болон түүнээс дээш түвшний орон нутгийн засаг захиргаагаас сонсгол зохион байгуулж, хууль тогтоомж болон сонсголын дагуу төсөлд нэмэлт өөрчлөлт оруулна.

- Эргүүлэн хураагдсан газрын өмчлөгч, ашиглагч нь зард заасан хугацаанд үл хөдлөх эд хөрөнгийн холбогдох гэрчилгээ, нотлох баримтын хамт нөхөн олговрын бүртгэлийг хийлгэнэ. Хошуу болон түүнээс дээш орон нутгийн ардын засаг захиргаа нь холбогдох зардлыг тооцож хэрэгжүүлэх ажлыг холбогдох албад зохион байгуулж, бүрэн хэмжээгээр гаргуулж, эргүүлэн авах газрын өмчлөгч, ашиглагчтай нөхөн олговор олгох гэрээ байгуулна. Холбогдох этгээд гэрээ байгуулах сонирхолгүй байвал эргүүлэн авах газарт хүсэлт гаргах үед тодорхойлно

- Холбогдох урьдчилсан ажил дууссаны дараа хошуу болон түүнээс дээш түвшний орон нутгийн засаг захиргаа газар эргүүлэн авах хүсэлт гаргаж болно.

Газраа эргүүлэн хураалгасан тариаланчдын угийн амьжиргааны түвшинг бууруулахгүй байх, урт хугацааны амьжиргааг нь баталгаажуулахын тулд шударга, тохиромжтой нөхөн олговор олгоно.

- Эргүүлэн авсан газрын хүрээнд газрын нөхөн төлбөр, нүүлгэн шилжүүлэлтийн төлбөр, хөдөө тосгоны иргэдийн орон сууц, газар дахь бусад хавсралт, үр тарианы нөхөн төлбөрийг хуульд заасан журмын дагуу бүрэн, хугацаанд нь төлж, газар эргүүлэн хураалгасан тариаланчдад нийгмийн даатгалыг хариуцна.

- Тариалангийн газрыг эргүүлэн авахад холбогдох газрын нөхөн төлбөр болон нүүлгэн шилжүүлэлтийн төлбөрийн хэмжээг Муж, Өөртөө засах орон, шууд харьяа хотоос тухайн холбогдох хэсэгчилсэн газрын үнэ ханшийг тогтооно. Энэхүү хэсэгчилсэн үнэ ханшийг тогтооход түүнийг угийн газрын ашиглалтын зорилго, газрын нөөц, газрын ургацын хэмжээ, газрын байршил, газрын хэрэгцээ ба эрэлт, хүн ам болон эд хөрөнгийн байдлыг харгалзан үзнэ.

- Эргүүлэн авах газраас бусад газар, газрын дагалдах зүйл, үр тарианы нөхөн олговор олгох стандартыг муж, өөртөө засах орон, шууд харьяа хотын захиргаа тогтооно. Үүнд хөдөө тосгоны иргэдийн орон сууцны хувьд нөхөн олговор олгож, амьдрах нөхцөлийг нь сайжруулсны дараа нүүлгэн шилжүүлэх зарчмын дагуу хөдөөгийн иргэдийн хүсэл сонирхлыг хүндэтгэж, орон сууцны газар, орон сууц барих, нүүлгэн шилжүүлэхэд зориулсан орон сууц, мөнгөн нөхөн олговор олгох замаар шударга, тохиромжтой нөхөн төлбөр олгох; нүүлгэн шилжүүлэх, түр нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой зардлыг нөхөн төлж, хөдөө тосгоны иргэдийн амьдрах эрх, хууль ёсны өмчийн эрхийг хамгаална.

- Хошууны түвшний дээд засаг захиргаа нь газраа хураалгасан тариаланчдыг тэтгэвэр гэх мэт нийгмийн хамгааллын зохих тогтолцоонд хамруулна. Газар хураалгасан тариаланчдын нийгмийн даатгалын шимтгэлийг голчлон нийгмийн даатгалын нөхцөл хангасан нийгмийн даатгалын шимтгэлийн нөхөн олговорт хэрэглэнэ. Газар эргүүлэн хураалгасан тариаланчдын нийгмийн даатгалын шимтгэлийг хураах, удирдах, ашиглах арга хэмжээний дүрэм журмыг муж, өөртөө засах орон, шууд харьяа хотын захиргаагаас тогтооно гэж заажээ.

Газар албадан чөлөөлөх нь газэр өмчлөгчдийг үндсэн үйлдвэрийн материалаас нь салгадаг. Тиймээс нөхөн олговрын зорилго нь тариачдад тогтвортой аж ахуй эрхлэх үндэс суурийг бий болгох явдал гэж тодорхойлжээ. Хятад улсад газар албадан чөлөөлөх нөхөн олговор хангалтгүй байгаагаас гадна нөхөн олговор авсан өмчлөгчид уг төлбөрөө богино хугацаанд тансаг байдлаар зарцуулж байгаа нь тэднийг ирээдүйд ядуурах эрсдэлд оруулах

бас нэг хүчин зүйл юм.⁵⁷

Казахстан Улсын Иргэн болон бусад этгээдээс түүний мэдлийн газрыг улсын хэрэгцээнд авахтай холбоотой хуулийн зохицуулалт

Энэ төрлийн харилцааг Казахстан улсын газрын тухай хууль, Хувийн орон сууц барих тухай, Төрийн өмчийн тухай хуулиуд, мөн бусад хуулиар зохицуулдаг.

“Казахстан улсын газрын тухай”⁵⁸ хуульд зохицуулалтыг хэрхэн тусгасан талаар авч үзье.

Иргэн болон бусад этгээдээс түүний эдэлбэр газрыг улсын хэрэгцээнд авах үндэслэл шаардлага (84 дүгээр зүйл)

Казахстан улсын газрын тухай хуулийн 6 дугаар бүлэг 84 дүгээр зүйлийн 1-д “Эдэлбэр газрыг улсын хэрэгцээний улмаас онцгой тохиолдол буюу энэхүү хэрэгцээг өөрөөр зохицуулах боломжгүй тохиолдолд газар эзэмшигчтэй, эсвэл газар ашиглагчтай (төрийн бус) гэрээ хэлэлцээр хийсний үндсэн дээр, мөн шүүхийн шийдвэрээр албадан авч болно”, мөн 84 дүгээр зүйлийн 2-т эдэлбэр газрыг улсын хэрэгцээнд албадан авах зайлшгүй тохиолдлуудыг заасан бөгөөд бусад тохиолдолд, өөрөөр хэлбэл, хэн нэгний бизнесийн үйл ажиллагааг дэмжих, хэн нэгэнд ашигтай давуу байдал олгох г.м. ашиг сонирхлын үүднээс авахыг хориглоно. Түүнээс гадна эдэлбэр газрыг улсын хэрэгцээнд авахдаа хэрэгцээт хэмжээнээс хэтрүүлж болохгүй талаар хуульчилсан байна.

Уг хуулийн 84.2-т Эдэлбэр газрыг дараах тохиолдолд улсын хэрэгцээнд албадан авна.

1. Казахстан Улсын олон улсын гэрээнд хүлээсэн үүргийн дагуу,
2. Батлан хамгаалах болон үндэсний аюулгүй байдлын шаардлагаар, байгалийн тусгай хамгаалалтад авах, эрүүлийг хамгаалах, амарч зугаалах болон түүх соёлын хэрэгцээнд өгөхөөр болсон, мөн эдийн засгийн тусгай бүсүүдийг байгуулан үйл ажиллагаа явуулахад,

3. Ашигт малтмал уурхайн орд олдох болон тэдгээрийг олборлоход,

4. Авто зам болон төмөр замын байгууламжууд (тэдгээрийг шинэчлэн барих), нисэх онгоцны буудал, аэронавигацийн объектууд болон авиатехникийн төвүүд, төмөр замын тээврийн объектууд, гүүр, мэтрополитен, туннель, эрчим хүч болон цахилгаан дамжуулах шугам, харилцаа холбооны шугам, сансар судлалын объектууд, магистраль хоолойнууд, инженер-холболтын шугамуудыг барьж байгуулах, концессын төслүүдийг хэрэгжүүлэх, суурин газарт нийтийн эзэмшлийн барилга объектуудыг барьж байгуулахад (тэдгээрийг шинэчлэн засварлах),

5. Хүн ам оршин суудаг нутаг дэвсгэрийн ерөнхий төлөвлөгөөнд энд заасан онцгой объектууд баригдахаар тусгагдсан бол, түүнчлэн “Казахстан Улсын төлөвлөлтийн систем”-ийн баримт бичигт тусгасан объектуудыг төсвийн хөрөнгөөр барихад газрыг албадан авахаар хуульчилсан.

Эдэлбэр газрыг улсын хэрэгцээнд албадан авах

Энэхүү харилцааг Казахстан улсын “газрын тухай” болон “Төрийн өмчийн тухай” хуулиар зохицуулна. Эдэлбэр газрыг улсын хэрэгцээнд албадан авах ажлын дараалал нь:

1. Шийдвэр гаргах – Казахстан улсын газрын тухай хуулийн 84 дүгээр зүйлд заасан онцгой нөхцөлд эдэлбэр газрыг улсын хэрэгцээнд авах болсноор газар болон үл хөдлөх хөрөнгийг албадан авах ажлыг эхлүүлэх тухай Засгийн газраас, эсвэл орон нутгийн гүйцэтгэх байгууллагаас албан ёсны шийдвэр (тогтоол) гаргах бөгөөд энэ талаар ажлын 3 хоногт хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлана. Уг шийдвэрт дараах зүйлсийг заавал тусгах ёстой. Үүнд:

А) Улсын хэрэгцээнд албадан авах болсон зорилго, үндэслэл

Б) Эдэлбэр газрын байршил, талбайн хэмжээ, кадастрын дугаар

⁵⁷ Zhang Hueying, Lu Haiyuan. Compensation for Compulsory Land Acquisition in China: to Rebuild Expropriated Farmer's long-term livelihoods.

⁵⁸ Земельный кодекс Республики Казахстан - ИПС “Эдiлет” (zan.kz).

В) Газар эзэмшигч, газар ашиглагчийн нэр

Г) Албадан авах он, сар, өдрийг заах, Энэ хугацаа нь эдэлбэр газрыг улсын хэрэгцээнд авахаар албан ёсоор зарласнаас хойш 3 сараас багагүй байх

Д) Гэрээ хэлэлцээр хийх газрыг тодорхой заана. Шаардлагатай бол шийдвэрт бусад материалуудыг хавсаргадаг байна. Хэрэв Б болон Г -д өөрчлөлт орохоор бол нэмэлт, өөрчлөлт оруулах тухай шийдвэрийг зарласан өдрөөс эдэлбэр газрыг улсын хэрэгцээнд албадан авах ажлыг дахин эхлүүлнэ.

2. Мэдэгдэх – Албан ёсны шийдвэр гарснаас хойш 3 өдрөөс хэтрэхгүй хугацаанд, газар эзэмшигчид, эсвэл газар ашиглагчид (төрийн бус) түүний газрыг улсын хэрэгцээнд авах болсноор газар болон үл хөдлөх эд хөрөнгийг албадан авах тухай бичгээр мэдээлнэ. Мөн түүнд газар болон үл хөдлөх эд хөрөнгийг худалдан авах талаар гэрээний төслийг хавсаргаж шуудангаар явуулна. Хэрэв бичиг авснаа мэдэгдэж хариу ирүүлэхгүй байвал материалыг дахин явуулна. Эдэлбэр газрыг улсын хэрэгцээнд авах болсноор газар болон үл хөдлөх хөрөнгийг албадан авах тухай газар эзэмшигчид, эсвэл газар ашиглагчид (төрийн бус) мэдэгдсэнээс хойш төр түүнийг худалдаж авах давуу эрх эдэлнэ. Газар эзэмшигч, эсвэл газар ашиглагч (төрийн бус) нь эдэлбэр газрыг улсын хэрэгцээнд албадан авах мэдэгдэл авсан өдрөөс хойш эдэлбэр газрыг төрийн өмчид бүртгэх хүртэл, эсвэл газар ашиглах эрхийг дуусгавар болгох хүртэл хугацаанд эрхээ /газар эзэмших, ашиглах/ бусдад шилжүүлэх, өв залгамжлуулах зэргээр эзэн өөрчлөгдсөн ч албадан авах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

3. Хэрэгжүүлэх – Эдэлбэр газрыг улсын хэрэгцээнд авах болсноор газар болон үл хөдлөх хөрөнгийг албадан авах ажлыг Казахстан улсын хуулиудад өөрөөр заагаагүй бол шийдвэрт заасан хугацаанд газар эзэмшигчийн эсвэл ашиглагчийн (төрийн бус) зөвшөөрлөөр, мөн шүүхийн шийдвэрээр гүйцэтгэнэ. Газар эзэмшигчийн, эсвэл газар ашиглагчийн (төрийн бус) зөвшөөрлөөр, түүнд зохих үнэ төлбөрийг төлснөөр газар эзэмших, эсвэл ашиглах эрхийг дуусгавар болгоно. Үл хөдлөх хөрөнгийн эрхийг улсын бүртгэлд бүртгэх байгууллагад төлбөр төлөгдсөнийг батлах баримтыг өгснөөр уг хөрөнгө төрийн эзэмшилд бүртгэгдэх эрх үүсэх буюу төрийн өмчид шилжинэ.

4. Шаардлагатай бол шүүхэд хандах – Хэрэв засгийн газар, эсвэл орон нутгийн гүйцэтгэх байгууллагаас эдэлбэр газрыг улсын хэрэгцээнд албадан авахтай холбоотой гаргасан шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй бол талууд хуулийн дагуу шүүхэд гомдол гаргаж болно. Эдэлбэр газрыг улсын хэрэгцээнд авах асуудлыг шүүхийн шийдвэрээр зохицуулах:

“Казахстан Улсын газрын тухай” хуулийн 88 дугаар зүйлд зааснаар

- Хэрэв газар эзэмшигч, ашиглагч этгээд (төрийн бус) эдэлбэр газрыг улсын хэрэгцээнд албадан авах ажил эхлүүлэх тухай шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй, газрын үнэ төлбөр болон бусад асуудлаар тохиролцоонд хүрээгүй бол орон нутгийн гүйцэтгэх байгууллага уг асуудлаар шүүхэд хандах эрхтэй.

- Эдэлбэр газар эзэмшигч, эсвэл газар ашиглагч (төрийн бус) нь эдэлбэр газрыг улсын хэрэгцээнд албадан авах тухай мэдэгдэл авснаас хойш 3 сарын хугацаанд / гэхдээ эдэлбэр газрыг улсын хэрэгцээнд албадан авах ажлыг эхлүүлэх тухай шийдвэрт заасан гүйцэтгэх хугацаанаас хэтрэхгүй хугацаанд/ уг асуудлаар шүүхэд өргөдөл, гомдол гаргаж болно.

Казахстан улсад газрыг албадан чөлөөлөхдөө гэрээний үндсэн дээр буюу хуулийн дагуу талууд шүүхийн шийдвэрээр зохицуулдаг байна.

Тайвань орны газар чөлөөлөх тухай хууль⁵⁹

Энэ хуулийн 1 дүгээр зүйлд газар чөлөөлөх асуудлыг зохицуулах, газар чөлөөлөхөд энэ хуулийн заалтыг баримтлах бөгөөд энэ хуульд заагаагүй тохиолдолд бусад хуулийн зохицуулалт хамаарна. Бусад хууль тогтоомж нь энэ хуультай зөрчилдсөн тохиолдолд

⁵⁹ <https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=D0060002>.

энэхүү хуулийг баримтална. Төрөөс газрыг чөлөөлж болох хүрээ нь үйл ажиллагааны шаардлагаар хязгаарлагдана.

1. Үндэсний батлан хамгаалах, 2. Тээврийн бизнес, 3. Нийтийн ашигтай хамааралтай, 4. Усны чиглэлээрх үйл ажиллагаа, 5. Нийгмийн эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа, 6. Төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага болон бусад олон нийтийн барилга байгууламж, 7. Боловсрол, эрдэм шинжилгээ, соёлын үйл ажиллагаа, 8. Нийгмийн халамжийн үйл ажиллагаа, 9. Төрийн өмчит үйл ажиллагаа, 10. Хуулийн дагуу газар чөлөөлөх бусад үйл ажиллагаа хамаарна. Мөн хувийн өмчийн газрыг дайчлан авах дараах нөхцөлүүд байна.

1. Хот суурин газрын зарим хэсгийг буюу бүхэлд нь барилга байгууламжийн ажиллагаа хийх;

2. Хотын хуучин бүсийг нийтийн аюулгүй байдал, ариун цэвэр, тээврийн хэрэгцээнд зориулан шинэчлэх, эсвэл газрыг зүй зохистой ашиглахыг дэмжих;

3. Хот дахь хөдөө аж ахуйн бүс, тусгай хамгаалалттай бүсээс барилгын газар, үйлдвэрийн бүсээс суурьшлын бүс, худалдааны бүс болгон өөрчлөх;

4. Хотын бус газрыг хөгжүүлэх;

5. Хөдөө орон нутгийн иргэд нийтийн байгууламжийг бэхжүүлэх, нийгмийн эрүүл мэндийг сайжруулах, эсвэл хөдөө аж ахуйн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулах шинэтгэх;

6. Хуулийн дагуу бусад хэсэгчлэн дайчлан авалт;

Иргэний өмчийн газрыг дайчлан буулгасан газар, хэсэгчилсэн дайчлан авалт ба энэ хууль болон бусад хууль тогтоомжид өөрөөр зааснаас бусад, дараах нөхцөл байдалд уг өмчлөгч нь албадан чөлөөлөх тухай зарласан өдрөөс хойш 20 жилийн дотор эрх бүхий хотын захиргаа, дүүрэгт (хот) эрх бүхий байгууллагад хүсэлт гаргах дайчлан авалтын анхны нөхөн олговрын үнийн дагуу газрыг буцаан авч болохоор Газар чөлөөлөх хуулийн 9 дүгээр зүйлд тусгажээ. Газрыг буцаан авахдаа:

1. Дайчлан авалтын нөхөн олговрын төлбөрийг хүлээн авсны дараа гурван жилийн дотор дайчлан авалтын төлөвлөгөөний дагуу ашиглаагүй.

2. Зөвшөөрөгдсөний дагуу үйл ажиллагаанд ашиглаагүй.

3. Дайчлан авалтын төлөвлөгөөний дагуу ашиглаж эхэлснээс хойш таван жилийн дотор төлөвлөгөөг ашиглахгүй.

Нөхөн төлбөр. Газар чөлөөлөх хуулийн 30 дугаар зүйлд Дайчлан хураалгасан газрын хувьд тухайн үеийн зах зээлийн үнээр газрын үнийг нөхөн төлнө. Хот төлөвлөлтийн бүсийн нутаг дэвсгэрт байгаа нийтийн зориулалттай барилга байгууламжийн нөөцөд байгаа газрын үнийг зэргэлдээх нийтийн зориулалт бус газрын зах зээлийн дундаж үнээр нөхөж олгоно. Өмнөх хэсэгт дурдсан зах зээлийн үнийг хотын болон хошууны эрх бүхий байгууллага үнэлгээ хийлгэхээр газрын үнийн үнэлгээний хороонд хүргүүлэн тогтоолгоно.

Хотын захиргаа, хошуу (хот)-ын эрх бүхий байгууллага нь харьяа нутаг дэвсгэрийнхээ газрын үнийн динамик байдалд тогтмол судалгаа хийж, газар чөлөөлөгдсөн газрын зах зээлийн үнийн хэлбэлзлийн хүрээний үнэлгээг зургаан сар тутамд Газрын үнийн үнэлгээний хороонд хүргүүлнэ. Газрын үнийг судлах, тооцох журам, арга, баримтлах арга хэмжээ зэрэг асуудлыг эрх бүхий төв байгууллага өмнөх гурван зүйлийг үндэслэл болгоно.

IV. Монгол Улсын Газрын багц хуулийн төсөл

Монгол Улсын Засгийн газраас 2022 онд Улсын Их Хуралд “Нийгмийн зайлшгүй хэрэгцээнд зориулан газар чөлөөлөх тухай хуулийн төслийг өргөн мэдүүлсэн байх бөгөөд тус хуулийн төсөлд хот байгуулалтын болон газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулан газар чөлөөлөх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, нийгмийн зайлшгүй хэрэгцээг бодит үндэслэлтэй тогтоох, нийтийн эрх ашгийг хангах, газар чөлөөлөлттэй холбоотой сөрөг үр дагаварыг багасгах, газар чөлөөлөлтөд өртөгчтэй зөвшилцөх замаар оновчтой шийдэлд хүрэх болон сонсох ажиллагаа явуулж, газар чөлөөлөх тохиолдлуудыг

тусгаснаараа онцлогтой байна.⁶⁰ Газар чөлөөлөх 19 зориулалтыг тусгайлан зааж, эдгээр нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлнө гэжээ. Үүнд: 1) Сургуулийн өмнөх боловсрол, 2) Ерөнхий боловсрол, 3) Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, 4) Нийгмийн халамжийн үйлчилгээ, 5) Нийтийн номын сан, 6) Соёлын байгууллага, 7) Спортын байгууламж, 8) Цахилгаан эрчим хүч, 9) Дулаан хангамж, 10) Ус хангамж, ариутгах татуурга, 11) Нийтийн аж ахуйн үйлчилгээ, 12) Харилцаа холбооны шугам, 13) Авто болон төмөр зам, гүүр, 14) Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, 15) Гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах, 16) Хог зайлуулах, хадгалах, устгах, 17) Тохижилт, цэцэрлэгжүүлэлт, явган зам, дугуйн зам, 18) Нийтийн тээврийн үйлчилгээ, 19) Хийн болон газрын тос дамжуулах хоолой гэж тусгажээ.⁶¹

Иймд нийгмийн зайлшгүй хэрэгцээ гэдэгт юут, ямар хэрэгцээг ойлгох, тохиролцоонд хүрээгүй, гэрээ байгуулагдаагүй тохиолдолд газрыг хэрхэн чөлөөлөх, нөхөх олговрыг хэрхэн тооцох зохицуулалт байхгүй. Түүнчлэн газар албадан чөлөөлөх хуулийн зохицуулалт нь нэг талаас нийтийн эрх ашгийн үүднээс нөгөө талаас нөлөөлөлд өртөж буй иргэд, аж ахуй нэгж байгууллагын эрх ашгийг зөв зохистой эрх зүйн орчинг бий болгох шаардлагатай. Уг хуулийн төслийн 33 дугаар зүйлд газар чөлөөлөлтөд өртөгч нь мэдэгдэл хүлээн авсанаас хойш 30 хоногийн хугацаанд чөлөөлөөгүй бол төсөл зохион байгуулагч байгууллага нь аймаг, нийслэлийн Засаг даргад албадан чөлөөлөх нэхэмжлэл гаргах хүсэлт хүргүүлснээр эрх бүхий байгууллага нь газар албадан чөлөөлүүлэх тухай нэхэмжлэлийг харьяалах шүүхэд гаргана. Түүнчлэн дээрх зарим улсын газар албадан чөлөөлөх хуулийн сайн туршлагаас авч хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байна. Тухайлбал, Тайван орны газар чөлөөлөх хуулийн газар албадан чөлөөлсөн боловч гурван жил төлөвлөгөөний дагуу ашиглаагүй, газрын нөхөн олговрыг тухайн зах зээлийн үнээр нөхөн төлнө. Мөн Казакстан улсын газрын тухай хуулийн ашигт малтмал уурхайн орд олдох болон тэдгээрийг олборлоход эдэлбэр газрыг улсын хэрэгцээнд албадан авна зэрэг зүйлээс уг хуулийн төсөлд тусгах бололцоотой юм.

V. Дүгнэлт

Хувийн өмчийн газрын албадан чөлөөлөх асуудлыг тусгай хуулиар зохицуулж, Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу өмчлөгчийн эрхийг гагцхүү хуулиар хязгаарлах шаардлагыг хангах нь чухал юм. Ингэхдээ иргэний өмчилсөн газрыг албадан чөлөөлөх тохиолдолд нөхөх олговор нь урьдчилсан, шударга байх ёстой. Цаашид төрийн албан хаагчид захиргааны эрх мэдлээ урвуулан ашиглахаас хамгаалах арга хэмжээ хангалтгүй байгааг анхаарах, өмчлөгч эрх, үүргээ шударгаар хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бий болгох нь зүйтэй. Төрөөс газрыг албадан чөлөөлөх талаар тухайн өмчийн эзэнтэй тохиролцоно гэснээс бус зөвшилцөх, эрх зүйн туслалцаа авах бололцоо хангагдсан эсэх, тухайн орон нутаг нийтэд мэдээлэх, тэдэнтэй зөвлөлдөн хэлэлцэж, ил тод нээлттэй байх зарчим тусгагдаагүй, мөн хуульд урьдчилан тохирох гэсэн хугацаа гаргаж өгсөн мэт боловч тухайн орон нутгийн иргэд нийтээрээ ижил түвшний мэдээлэл авч хэлэлцэх, алдах боломж, орчны өөрчлөлтөө хэлэлцэх бололцоог хангасан бие даасан хуулийн зохицуулалт үгүйлэгдэж байна.

⁶⁰ Нийгмийн зайлшгүй хэрэгцээнд зориулан газар чөлөөлөх тухай хуулийн төсөл (2022).

⁶¹ Нийгмийн зайлшгүй хэрэгцээнд зориулан газар чөлөөлөх тухай хуулийн төсөл (2022).

ЭХ СУРВАЛЖ

Монгол хэл дээрх

Хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 №1.
2. Монгол Улсын Иргэнд Газар өмчлүүлэх тухай хууль- Төрийн мэдээлэл, 2002, №27(264).
3. Газрын тухай хууль- Төрийн мэдээлэл, 2002, №27(264).
4. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль-Төрийн мэдээлэл, 2015, №28(889).
5. Газрын багц хуулийн төсөл, МУ-ын засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлсэн, 2022.06.17.

Ном, өгүүлэл, судалгааны тайлан

1. О.Жамбалдорж нар, Иргэний эрх зүй, ерөнхий анги, I дэвтэр, Уб, 2004.
2. С.Нарангэрэл, “English – Mongolian jurisprudence dictionary”, Уб, 2005.
3. Н.Лүндэндорж, Монгол Улсын Үндсэн хууль шинжлэх ухааны тайлбар, Уб, 2022.
4. Н.Лүндэндорж, “Монголд газрыг хувьд өмчилж байсан эсэх талаархи түүхэн маргаан, түүнд хийсэн түүх, философи, эрх зүйн шинжилгээ”, “Газар, удирдлага, эрх зүй” түүвэр өгүүлэл, Уб, 2005.
5. Д.Сүнжид, Үл хөдлөх эд хөрөнгийн Үндсэн хуулийн асуудлууд, 2016, www.Legaldata.mn.
6. Г.Совд нар, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, Уб, 2000.
7. Д.Сугар, Өмчийн харилцааны хөгжил, эрх зүйн зохицуулалтын зарим асуудал, Уб, 2020.
8. Д.Гангабаатар, “Хувийн өмчийн газрыг шууд бусаар дайчлан авахаас хамгаалах Үндсэн хуулийн зохицуулалт”, Эрх зүй сэтгүүл, 2015, №1(31).
9. Д.Гангабаатар, “Үндсэн хуулийн эрх зүй” төрийн байгуулал, зарчим, үзэл баримтлал, Уб, 2016.
10. Д.Гангабаатар, “Нөхөх олговрын тухай Үндсэн хуулийн үзэл баримтлалын онолын үндэс”, Хууль дээдлэх ёс сэтгүүл, 2015, №1(51).
11. Г.Багаа, Ч.Жадамба, Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн төр иргэний газрыг дайчлан авахтай холбоотой нөхөн олговрын хүрээг тодорхойлоход тулгамдаж буй эрх зүйн асуудал, Эрх зүй сэтгүүл, 2013, №2.
12. МУИС-ХЗС, Нийтийн болон хувийн өмчийн эрх зүйн тулгамдсан асуудал, Уб, 2012.
13. Н.Баярсайхан, Л.Дондов, “Газар чөлөөлөх бодлогод эрхэд суурилсан хандлагыг нэвтрүүлэх шаардлага” илтгэл, “Газартай холбоотой хүний эрхийн асуудлууд” онол, практикийн хурал, 2015.
14. Р.Очирбал, “Газрын эрх ба хязгаарлалт” илтгэл, “Газартай холбоотой хүний эрхийн асуудлууд” онол, практикийн бага хурал, 2015.
15. З.Өнөржаргал, “Албадан нүүлгэлт ба төрийн оролцоо” илтгэл, “Газартай холбоотой хүний эрхийн асуудлууд” онол, практикийн бага хурал, 2015.
16. Д.Янжинхорлоо, Монгол Улсын иргэний эрх зүй, үл хөдлөх эд хөрөнгийн эрх зүй, 2016.
17. Б.Гантулга, Б.Сайнжаргал, ХБНГУ-ын үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний тогтолцоо, эрх зүйн орчны туршлага, Уб, 2010.
18. С.Энхмэнд, “Иргэний өмчийн газрыг төр улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах эрх зүйн үндэслэл” илтгэл, “Газартай холбоотой хүний эрхийн асуудлууд” онол, практикийн бага хурал, 2015.

Гадаад хэл дээрх**Хууль тогтоомж**

1. ХБНГУ-ын Үндсэн Хууль, Уб, 2020, Орчуулсан: П. Амаржаргал
2. БНХАУ-ын Иргэний хууль, Уб, 2021, орчуулсан: Х.Цэрэндолгор.

Ном, өгүүлэл, судалгааны тайлан

1. Kevin Gray, Land law and human rights, Willan publishing, 2002, p.2011-245.
2. Jones, Expropriation in Roman law, 45 L.Q. Rev. 512, 521 (1929), See also Pound, The Valuation of Property in Roman law, 34, HARV.L. Rev, 227, 252, (1921).
3. Robin Mearns. Pastoral institutions, land tenure and land policy reform in Post-Socialist Mongolia <https://opendocs.ids.ac.uk/opendocs/bitstream/handle/20.500.12413/2427/Research%20Report%20No.3.pdf?sequence=1>.
4. М.М. Богуславский. Международное частное право, 1994 г, стр 165.
5. Food and Agriculture Organization of the United Nations (2008). Compulsory Acquisition of Land and Compensation. FAO Land Tenure Studies: 23, 27~30, 40~41, 43, 53.
6. Магна Харт, Орчуулсан П. Амаржаргал, Уб, 2012.
7. Land administration law of the People's Republic of China, <https://faolex.fao.org/docs/pdf/chn3560.pdf>.
8. Zhang Hueying, Lu Haiyuan. Compensation for Compulsory Land Acquisition in China: to Rebuild Expropriated Farmer's long-term livelihoods.
9. Universal Declaration of Human Rights, <https://www.un.org/sites/un2.un.org/files/2021/03/udhr.pdf>.
10. Земельный кодекс Республики Казахстан - ИПС "Әділет" (zan.kz).
11. <https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=D0060002>.

THE LEGAL REGULATION ON EXPROPRIATING LAND OWNED BY CITIZENS OF MONGOLIA FOR PUBLIC USE: A COMPARATIVE STUDY

Unurbayan.Ya

Ph.D student, School of Law, NUM

ABSTRACT:


One of the most important issues in the process of implementing urban development and urban planning and redeveloping the city in Mongolia are about land. Although the basic legal principles of land ownership for Mongolian citizens are established and protected by the Constitution of Mongolia, these principles are not well reflected in other laws, such as the Land Law, Civil Law, and the Land on Land Ownership for Mongolian Citizens.

In the context of this article, Monitoring and analyzing the implementation of the above legislation, revealing the weaknesses and inconsistencies of the legal regulation of land expropriation, and comparing the good practices of some foreign countries, is to give a correct assessment from the point of view of making an independent law.

KEYWORDS:


Land acquisition, compensation, social necessity, cost of land acquisition.

СОНГУУЛИЙН ЭРХ ЗҮЙН АНТРОПОЛОГИ¹ ГЭЖ ЮУ ВЭ?



С.Номынбаярсалан

Монголын Криминологичдын холбооны ахлах судлаач (ВВА), МУИС–ийн ШУС–ийн Нийгмийн ухааны салбарын антропологийн хөтөлбөрийн докторант, МУИС–ийн Хууль зүйн сургуулийн докторант



Э.Тамир

“Ворд Медиа” ХХК–ийн “Өрөг.мн” сайтын Үйл ажиллагаа эрхэлсэн захирал, Монголын Криминологичдын холбооны гэрээт судлаач (LL.B)

ТОВЧЛОЛ:

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно” гэж заажээ. Энэхүү өгүүллийн сэдвийг “Сонгуулийн эрх зүйн антропологи гэж юу вэ” гэж томъёолон, агуулгыг антропологийн асуудлаар хязгаарлав. Эндээс “сонгуулийн эрх зүйн антропологи” гэсэн ойлголтыг судлах, танин мэдэх, түүний агуулгыг үндэслэлтэй тодорхойлох шаардлагатай байна. Энэ ойлголтын агуулгад юу хамаарах асуудлыг тодруулахад энэхүү өгүүллийн зорилго оршино. Антропологи бол бодит туршлагад суурилсан ухаан юм. Судлагдахуун нь гол төлөв урт хугацааны туршид зорилтот оролцогчдыг ажиглаж, бодит амьдрал дээрх зүйлсийг судлахад оршино. Энэ өгүүлэл нь хууль зүйн антропологи судлалын хөгжилд тодорхой хувь нэмэр оруулна гэж үзэж байна.

ТҮЛХҮҮР ҮГС:

Монгол Улсын Их Хурлын сонгууль, Монгол Улсын ерөнхийлөгчийн сонгууль, орон нутгийн хурлын сонгууль, улс төрийн антропологи, эрх зүйн антропологи, нийгэм, соёлын антропологи, сонгуулийн эрх зүй.

1. ОРШИЛ

Эртний Грек, Ромын хот улсуудад уугуул эзэн болох хүмүүс “Ард түмний хурал” зохион байгуулагчид хууль тогтоогчдыг сонгож улс гэрээ төвхнүүлэх гэж “сонгууль” нэрээр өрсөлдөн тэмцэлдэж байсан тухай ном сударт бий. Сонгууль үүссэн хийгээд үргэлжилж ирсний уг шалтгаан нь ард түмэн улс орноо өөрсдөө удирдах амин хэрэгцээнээс улбаатай

¹ Энэхүү өгүүлэлд “антропологи” гэсэн гадаад нэр томъёог “хүн судлал” хэмээн монгол нэр томъёонд буулгалгүйгээр хэрэглэв.

бөгөөд хамгийг эзэрхэгч хаант ёсыг халж, ганцаар дарангуйлагчийг хавчин зайлуулах тэмцлийн үр дүн² гэж үздэг. Сонгууль, түүнийг тойрсон асуудлыг улс төр, эрх зүй, социологи, сэтгүүл зүй, сэтгэл судлал зэрэг олон салбар ухааны үүднээс нилээдгүй судалсан хэдий ч салбар дундын байдлаар, ялангуяа сонгуулийн эрх зүйн асуудлыг антропологийн ухааны үүднээс авч үзсэн судалгаа хомс байна. Тиймээс эрх зүйн антропологийн судалгааны “арилжааны эрх зүйн антропологи”³, “худалдааны эрх зүйн антропологи”⁴, “хэвлэл мэдээллийн эрх зүйн антропологи”⁵ гэх зэрэг төрөлжсөн чиглэлүүд байдгийн нэгэн адил эрх зүйн антропологийн судалгааг “сонгуулийн эрх зүйн антропологи”⁶ гэх мэтээр салбар эрх зүйгээр төрөлжүүлэн хөгжүүлэх боломжтой гэж үзэж байна. Ерөнхийдөө сонгууль бол зайлшгүй, тогтмол, цаг үеэ олсон чөлөөтэй өрсөлдөөн бөгөөд ард түмэн засгийн эрхэнд шууд оролцож, төлөөлүүлэн хэрэгжүүлэх хууль ёсны гол арга мөн. Тэр нь төр ёсны орчин үеийн загварын бүрэлдэхүүн хэсэг болсон ардчилсан төлөөлөх байгууллагыг төлөвшүүлэх зүй зохистой, хүчтэй хэрэглүүр болов.⁷ Энэ үүднээс авч үзвэл сонгуулийн эрх зүй гэдэг нэг их ойлгомжгүй зүйл биш. Сонгуультайгаа холбоод ойлгож болно. Сонгуулийн эрх зүй бол Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүйн нэг дэд салбар юм. Түүний ач холбогдол ямар өндөр болох нь үүнээс ерөнхийдөө мэдэгдэнэ. Түүнчлэн сонгуулийн эрх зүй нь сонгуулийн эрх, сонгох эрх зэрэг ойлголтоос илүү өргөн утга агуулгатай.⁸ Ийнхүү сонгуулийн эрх зүй гэдгийг өргөн агуулгаар тодорхойлохоос гадна “сонгуулийн харилцааг зохицуулж байгаа хууль, түүнчлэн эрх зүйн бусад хэм хэмжээний нийлбэр”⁹ эсвэл “төрийн сонгуульт байгууллагыг бүрдүүлэх журам буюу өөрөөр хэлбэл сонгуулийн эрх зүйн нэг институт болох сонгуулийн тогтолцоог зохицуулдаг эрх зүйн хэм хэмжээний нийлбэр цогц”¹⁰ гэж явцуу утгаар авч үзэж болно. Өөрөөр хэлбэл сонгуулийн эрх зүй, сонгуулийн тогтолцооны үр дүнгийн гол шалгуур нь иргэдийн оролцоо юм.¹¹ Энэ утгаар сонгуулийн эрх зүйн амин сүнс нь иргэний улс төрийн суурь эрх болох сонгох, сонгогдох эрх болох учир сонгуулийг сонгогчгүйгээр, сонгуулийн эрх зүйг сонгогчийн эрхгүйгээр сэтгэж, зохицуулж, зохион байгуулж болдоггүйн учир үүнд л оршиж байна.¹² Энэ утгаар жишээ болгон Монгол Улсын Үндсэн хуулийн¹³ Арван зургадугаар зүйлийн холбогдох заалт, түүнийг хэлэлцэн баталсан тэмдэглэл зэргийг “сонгуулийн эрх зүйн антропологийн судалгааны үндсэн судлагдахуун”¹⁴ гэж үзэж болох юм.

² Б.Чимид, Сонгуульд суралцахуй, (Тогтолцоо, үйл явц, эрх зүй), Уб., Адмон принтинг, 2008, 21 дэх тал., Б.Чимид, Сонгуулийн тогтолцоонд ард түмэн, түүний үндсэн хууль буруутай юу?!, (Үндсэн хууль ёсны төлөвшил цувралын IV), Уб., Мөнхийн үсэг, 2011, 27 дахь тал.

³ С.Номынбаясгалан, “Арилжааны эрх зүйн антропологи гэж юу вэ?”, Хууль дээдлэх ёс, №1 (2023), 29 – 39 дэх тал.

⁴ С.Номынбаясгалан, “Худалдааны эрх зүйн антропологийн тухай”, Хууль дээдлэх ёс, №2 (2023), 196 – 220 дахь тал.

⁵ С.Номынбаясгалан, Э.Тамир, “Хэвлэл мэдээллийн эрх зүйн антропологи”, Эрсдэлд суурилсан тогтвортой хөгжил сэдэвт олон улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл, II, Уб., 2023, 208 – 222 дахь тал.

⁶ С.Номынбаясгалан, “Сонгуулийн эрх зүйн антропологи”, Политологи, №21 (2023), 194 – 207 дахь тал.

⁷ Б.Чимид, Сонгуульд суралцахуй, (Тогтолцоо, үйл явц, эрх зүй), Уб., Адмон принтинг, 2008, 40 дэх тал.

⁸ Б.Чимид, Сонгуульд суралцахуй, (Тогтолцоо, үйл явц, эрх зүй), Уб., Адмон принтинг, 2008, 41 дэх тал.

⁹ Б.Чимид, Сонгуульд суралцахуй, (Тогтолцоо, үйл явц, эрх зүй), Уб., Адмон принтинг, 2008, 41 дэх тал.

¹⁰ С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг, Хоёр дахь хэвлэл, Уб., Адмон принтинг, 2008, 383 дахь тал.

¹¹ Б.Чимид, Сонгуулийн тогтолцоонд ард түмэн, түүний үндсэн хууль буруутай юу?!, (Үндсэн хууль ёсны төлөвшил цувралын IV), Уб., Мөнхийн үсэг, 2011, 44 дэх тал.

¹² Б.Чимид, Сонгуульд суралцахуй, (Тогтолцоо, үйл явц, эрх зүй), Уб., Адмон принтинг, 2008, 45 дахь тал.

¹³ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367> [Сүүлд үзсэн: 2023.11.30].

¹⁴ Энэхүү өгүүллийн хавсралт хэсгээс дэлгэрүүлж харна уу.

Онолын хувьд нийгэм, соёлын антропологийн дэд салбарууд болох “улс төрийн антропологи”¹⁵ болон “эрх зүйн антропологи”¹⁶–ийн харилцан хамааралд сонгуулийн эрх зүйн антропологийн асуудал илүүтэй холбогдож байна. Учир нь энэхүү асуудлыг салбар дундын агуулгын хүрээнд нэг талаас “улс төрийн хүн судлал “улс төрийг” хамгийн энгийн бичил хэлбэрээс хамгийн нүсэр улс үндэстэн хоорондын улс төрийн асуудлыг хамран судалдаг бөгөөд үүгээрээ улс төр судлалаас ялгагддаг. Үүнтэй адилгүйгээр улс төр судлалын шинжлэх ухаан улс төрийг ихэвчлэн макро түвшинд судалдаг. Улс төр судлал аль нэгэн тосгон, баг, хот айл, хоёр хүний хоорондох улс төрийн асуудлыг судалдаггүйгээс тодорхой юм. Нийгмийн шинжлэх ухааны энэ цоорхойг бөглөн хүн судлал улс төрийн бичил хэлбэр болох алслагдмал овгууд, бага үндэстэн, угсаатнууд, хүмүүсийн хоорондох “улс төрийг” судалж эхэлсэн бөгөөд аажимдаа цар хүрээгээ тэлэн томоохон улс орны хэмжээн дэх асуудлыг ч судлах болсон нь хөгжлийн сүүлийн үед хамаарна . . . Улс төр судлалын шинжлэх ухаанаас улс төрийн хүн судлалын өөр нэгэн ялгагдах шинж гэвэл улс төр судлал голдуу өөрийн улс орныхоо улс төрийн тогтолцоог судалдаг бол улс төрийн хүн судлал өөр соёл, нийгэм, улс орон, үндэстэн угсаатан, бүлэг хүний улс төрийг судалдаг. Энэ бол нийгэм, соёлын хүн судлалын бусдын нийгэм соёлыг судалдаг гол шинжийн нэгэн хэсэг”¹⁷ гэсэн улс төрийн антропологийн ойлголтоор; нөгөө талаас “эрх зүйн антропологи нь нэг талаас нийгмийн олон талт харилцаа, соёл, ухамсарын ижилсэл, ондоошлыг; нөгөө талаас хүнийг эрх зүйн харилцааны объект болох талаас нь авч үздэг бөгөөд эрх зүйн антропологийн онцлог нь нийгэм, соёлын бүтээгдэхүүн болох эрх зүйн сэтгэлгээ, ухамсар, соёл, уламжлал, зан заншил, үнэт зүйлс, хүний эрх, эрх чөлөө болон тэдгээрийг тусгасан хэв хууль, ахуй зэрэгт ач холбогдол өгч, гол судлагдахуунаа болгон судалдаг”¹⁸ гэсэн эрх зүйн антропологийн ойлголтоор тус тус тайлбарлагдаж болох юм.

Ийнхүү антропологийн ухааны үүднээс өөрийн үндэсний сонгуулийн хууль тогтоомж болох Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль¹⁹, Монгол Улсын ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль²⁰, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль²¹ зэргийг шинжлэн судлах нь нийгэм, соёлын антропологийн дэд салбар болох эрх зүйн антропологи, нэн ялангуяа сонгуулийн эрх зүйн антропологи Монгол Улсад хөгжүүлэх үндэс суурь гэж үзэж байна. Энэ нь монголын эрх зүйн тогтолцоонд антропологийн ухааны сэтгэлгээ, онолын урсгалыг бий болгохоос гадна энэ чиглэлийн судалгааг “дан ганц эрх зүйн онол, сэтгэлгээний хүрээнд бус харин хууль зүйн хэрэглээ болгох үүднээс салбар эрх зүйн жишээлбэл “сонгуулийн эрх зүйн антропологи” гэх зэргээр төрөлжүүлж болох” талаархи салбар дундын асуудлыг гаргаснаар ихээхэн онцлог юм. Үүнээс гадна арга зүйн хувьд сонгуулийн эрх зүйн антропологийн этнографийн асуудлыг бий болгох ач холбогдолтой гэж үзэж байна. Хэдий тийм боловч Монгол Улсад угсаатны зүй (ethnography), угсаатан судлал (ethnology), хүн судлал (anthropology) гурвыг нэг нэгнээсээ ангид тусдаа, судлагдахуунаа булаацалдаж байдаг мэтээр ярьж, бичиж байгаа явдал мэр сэр гардаг. Энэхүү үзлээсээ ургуулан хүн судлалын ухааныг барууны “харь”, “ангид”; харин нөгөө талд угсаатны зүй, угсаатан судлал гэдгийг Франц, Орос, Монголд хөгжиж байсан “манай, бидний” гэх маягтайгаар өөр төрлийн ухаан мэтээр эсрэгцүүлэн

¹⁵ Д.Бум – Очир, Улс төрийн хүн судлалын онолын үүд, Уб., Бемби сан, 2008

¹⁶ С.Номынбаясгалан, “Эрх зүйн хүн судлал”, Хууль дээдлэх ёс, №3 (2022)

¹⁷ Д.Бум – Очир, Улс төрийн хүн судлалын онолын үүд, Уб., Бемби сан, 2008, 7 – 8 дахь тал.

¹⁸ С.Номынбаясгалан, “Эрх зүйн антропологи”, Эрх зүй, №3 (2022)

¹⁹ Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 12 дугаар сарын 20–ны өдөр Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг баталсан. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=14869> [Сүүлд үзсэн: 2023.11.30].

²⁰ Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 24–ний өдөр Монгол Улсын ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг баталсан. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16106891958781> [Сүүлд үзсэн: 2023.11.30].

²¹ Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 1 дүгээр сарын 30–ны өдөр Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийг баталсан. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=15125> [Сүүлд үзсэн: 2023.11.30].

өрсөлдүүлэх, түүхийн ухааны салбар гэж үзсэн тайлбар ч ажиглагддаг.²² Харин ч угсаатны зүй, угсаатан судлал хоёрыг хүн судлалын судалгааны арга хэмээж, түүн дотор нь багтаадаг нэгэнт тогтсон, маргаангүй ойлголт дэлхий нийтэд түгээмэл болж байгаа нь илэрхий байх юм.²³ Энэ талаар судлаачид “Монгол Улсын угсаатан зүй нь Зөвлөлтийн угсаатан судлалын болон улс төржсөн нийгмийн ухааны уламжлалаас төрөн гарсан бүтээгдэхүүн”²⁴ гэж үздэг.

Энэ байдлыг харгалзан энэхүү өгүүллээр сонгуулийн эрх зүйг (хууль зүйн толь бичигт “election law” – сонгуулийн хууль, сонгуулийн эрх зүй²⁵ гэж орчуулахын зэрэгцээ “election law = electoral law”²⁶ гэдгийн утгыг адилтган авч үзэв) нийгэм, соёлын антропологийн (Social and cultural anthropology) дэд салбарууд болох улс төрийн антропологи (Political anthropology) болон эрх зүйн антропологийн (Anthropology of law) үүднээс сонгуулийн эрх зүйн антропологи гэж юу вэ? гэсэн асуултад хариулахыг гол зорилгоо болгов. Энэ өгүүллийн хүрээнд “сонгуулийн эрх зүйн антропологи бол эрх зүйн антропологийн бусад төрөлжсөн чиглэлүүдийн нэгэн адил” гэж үзэж байгаа учраас энэхүү өгүүллийн агуулга эрх зүйн антропологийн үндсэн (нийтлэг) асуудлаас хөндийрөх учиргүй юм. Энэ утгаар өгүүлэлд нэр томъёоны нэршил, оноолтыг хэрхэн хэвшүүлэн хэрэглэх вэ?, үзэл санаа, утга агуулгад юу хамаарах, хэрхэн тодорхойлох вэ?, үүний шинжлэх ухааны ач холбогдол нь юу вэ?, сонгуулийн эрх зүй гэж юу вэ?, цаашлаад сонгуулийн эрх зүйн антропологи эрх зүй судлалын шинжлэх ухааны салбар болох уу, түүний гол судлагдахуун нь юу болох вэ?, сонгуулийн эрх зүйн антропологийн асуудлыг антропологийн ухаан болон хууль зүйн шинжлэх ухааны үүднээс хэрхэн оновчтой тодорхойлох вэ? гэсэн асуултуудад хариулахаас гадна, эцэст нь сонгуулийн эрх зүйн антропологи антропологийн ухааны дэд салбарууд болох улс төрийн болон эрх зүйн антропологийн харилцан хамаарлын үүднээс тодорхойлох оролдлого хийв.

II. СОНГУУЛИЙН ЭРХ ЗҮЙН АНТРОПОЛОГИ: ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ, СУДЛАХ ЗҮЙЛ, ТӨРӨЛЖҮҮЛЭХ АСУУДАЛ

Оршил хэсэгт сонгуулийн эрх зүй гэдгийг товчхон тайлбарласан тул үндсэн хэсэгт энэ талаар давхардуулан авч үзэхгүй. Энэхүү өгүүллийн үндсэн хэсэг нь хоёр дэд хэсгээс бүрдэх бөгөөд агуулгын хувьд ерөнхий ойлголтоос тухайлсан ойлголт руу шилжих байдлаар бичигдсэн. Тиймээс дэд хэсэг бүр нь дотроо хэд хэдэн дэд хэсгүүдэд хуваагдаж байгааг анхаарна уу.

1. Антропологийн ухааны дэд салбаруудын учир холбогдол

Энэ дэд хэсэгт эрх зүйн антропологи болон улс төрийн антропологи нь нийгэм, соёлын антропологийн дэд салбарууд болох нь; эрх зүйн антропологи эрх зүй судлалын шинжлэх ухааны салбар болох нь; эрх зүйн антропологи, угсаатны зүйгээр дэмжигдэн буй хүний эрхийн хандлагын талаар; эрх зүйн антропологи төрөлжүүлэн хөгжүүлэх зэрэг асуудлуудын хүрээнд антропологийн ухааны дэд салбаруудын учир холбогдлыг авч үзэв.

²² Г.Мөнх – Эрдэнэ, П.Чулуунбат, Нийгэм – соёлын хүн судлалын удиртгал, Уб., МУИС Пресс хэвлэлийн газар, 2017, 12 дахь тал.

²³ Мөн тэнд. Илүү дэлгэрэнгүйг Д.Бум – Очир, Улс төрийн хүн судлалын онолын үүд, Уб., Бемби сан, 2008 хэмээх бүтээлээс үзнэ үү.

²⁴ Э.Булаг, Монгол дахь ясны үзэл ба үндэстний эв нэгдэл, тэдгээрт холбогдох эрх зүйн асуудал, орч. Э.Туулайхүү, Ш.Туяа, Уб., 2020, 101 – 102 дахь тал.

²⁵ С.Нарангэрэл, Хууль зүй судлалын англи – монгол тайлбар толь, Уб., Мөнхийн үсэг, 2005, 351 дэх тал., С.Нарангэрэл, Хууль зүйн англи – монгол эх толь, Уб., Адмон принтинг, 2012, 227 дахь тал.

²⁶ С.Нарангэрэл, Хууль зүй судлалын англи – монгол тайлбар толь, Уб., Мөнхийн үсэг, 2005, 352 дахь тал., С.Нарангэрэл, Хууль зүйн англи – монгол эх толь, Уб., Адмон принтинг, 2012, 227 дахь тал.

А. “Эрх зүйн” болон “улс төрийн” антропологи нийгэм, соёлын антропологиин дэд салбарууд болох нь

Аливаа ухаан (discipline) онол бүтээснээрээ өөрийнхөө түүхэн замналыг бий болгож байдаг учиртай. Уг зарчмын дагуу антропологи ч гэсэн өөрийн онолыг бүтээж тэр нь бидний үед улиран хувьссаар түүх болон уламжлан ирсэн. Энэ түүхийг бүтээж эхлэн нийгэм, соёлын антропологиин онол бий болсон он цагийг XIX зууны сүүл, XX зууны эхэн үе гэж нэрлэж болно. Дурдан буй энэ үед зөвхөн антропологиин онол хөгжиж эхэлсэн биш, харин антропологи бие даасан ухаан болон нэгдэн хөгжих үндэс суурь тавигдаж эхэлсэн үе гэж давхар үзэх ёстой. Энэ үүргээс улбаалан антропологиин онол болон угсаатны зүй (этнографи) гэсэн антропологиин ухааны хоёр тал ялгаран харагддаг. Дээрх хоёр талын харилцаа холбоо антропологиин ухааны хөгжил, чиг баримжааг тодруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг гэж болно.²⁷ Энэ утгаар XX зуун гэдэг бол зөвхөн нийгэм, соёлын антропологи төдийгүй нийгэм, хүмүүнлэгийн ухааны олон салбарууд үүсэн бий болох үндэс сууриа зассан түүхэн үе юм. Ийнхүү эхлэлээ тавьж байсан шинжлэх ухаанууд цааш хөгжихдөө тухайн цагт нөлөө ихтэй байсан гүн ухаан, байгалийн ухааны онол судалгаануудад тулгуурлаж байсан нь тодорхой. Ялангуяа нийгэм, соёлын антропологид гүн ухааны онолууд зөвхөн тэр цагт төдийгүй, өдгөө ч чухал нөлөөтэй байдаг. Гүн ухаанаас гадна антропологиин үүсэлд ихээхэн хувь нэмэр болсон дэг сургууль бол өрнө дахинд өргөн хүрээтэй дэлгэрсэн Дарвинизм (Darwinism) болон түүний хувьслын онол (Evolutionism) байсан тул тэр үеийн олонхи антропологичид нэг талаас хувьслын онолыг баримтлагчид байсан гэж тодорхойлж болно. Ийм учраас хувьслын онолын нөлөө XX зууны дунд үе хүртэл антропологид хүчтэй байсан байдаг.²⁸ Үүнээс гадна XIX зууны сүүл үеэс анхны антропологичид гэж нэрлэгдсэн хүмүүс нийгэм, соёлын судалгааг биологийн судалгаанаас ангид авч үзэх гэж хичээж эхэлсэн байна.²⁹

Антропологиин ухааныг 1/ нийгэм, соёлын; 2/ биологийн салбар; 3/ хэл шинжлэлийн; 4/ археологи гэсэн дэд салбаруудад хуваан үзэж байна. Эдгээр салбаруудын дундаас хамгийн өргөн хүрээтэй нь нийгэм, соёлын салбар болж байна. Эдгээр нь аль алиныгаа өөртөө багтааж байх бололцоогүй болтлоо өргөжин тэлж хөгжсөн. Жишээ нь нийгэм, соёлын антропологи л гэхэд 50 гаруй дэд салбартай бөгөөд цаашид энэ тоо нэмэгдэх төлөвтэй байна.³⁰ Нийгэм, соёлын антропологиин ухааны мөн чанараас үүдэн аливаа асуудлыг цогц байдлаар нь судлах оролдлого нь энэ олон дэд салбарын эхлэл болов.³¹

Нийгэм, соёлын антропологиин (Social and cultural anthropology) бусад дэд салбаруудын нэгэн адил эрх зүйн антропологи нь харьцуулсан судалгааны талбар³² бөгөөд түүнийг яг хэзээ үүссэн гэдгийг баттай хэлэхэд хэцүү; эрдэмтэд эрх зүйн антропологиин судалгаа гэдгийг авч үзэхээсээ (ойлгохоосоо) өмнө энэ чиглэлийн судалгааг хийж байв. Зарим судлаачид улс төр болон эрх зүйн талаархи антропологиин үүслийг НТӨ V зуунд Грект (Herodotus), эсвэл XVIII зуунд Францид (Baron Charles – Louis de Montesquieu) гэж авч үзсэн байна.³³ Шарль Монтескьогийн 1748 онд хэвлүүлсэн Хуулийн амин сүнс (The spirit of laws) хэмээх бүтээлд “. . . хууль нь тухайн орныхоо газарзүйн шинж чанарт,

²⁷ Д.Бум – Очир, Г.Мөнх – Эрдэнэ, Нийгэм, соёлын хүн судлалын онолын үүд, Уб., Адмон принтинг, 2012, 9 дэх тал.

²⁸ Д.Бум – Очир, Г.Мөнх – Эрдэнэ, Нийгэм, соёлын хүн судлалын онолын үүд, Уб., Адмон принтинг, 2012, 12 дахь тал.

²⁹ Д.Бум – Очир, Г.Мөнх – Эрдэнэ, Нийгэм, соёлын хүн судлалын онолын үүд, Уб., Адмон принтинг, 2012, 15 дахь тал.

³⁰ Г.Мөнх – Эрдэнэ, П.Чулуунбат, Нийгэм – соёлын хүн судлалын удиртгал, Уб., МУИС Пресс хэвлэлийн газар, 2017, 4 – 5 дахь тал.

³¹ Г.Мөнх – Эрдэнэ, П.Чулуунбат, Нийгэм – соёлын хүн судлалын удиртгал, Уб., МУИС Пресс хэвлэлийн газар, 2017, 209 дэх тал.

³² Elizabeth Mertz, Mark Goodale, “Comparative anthropology”, *Comparative Law and Society (Research handbooks in Comparative law)*, USA, Edward Elgar Publishing, 2012, p.77.

https://books.google.mn/books?hl=ru&lr=&id=q3vK0g2jOAO&oi=fnd&pg=PR1&dq=Cover+Comparative+Law+and+Society+Comparative+Law+and+Society+David+S.+Clark&ots=50BTU1Rq9U&sig=20qMgAtsxf6Fp33Y9YIHKE7PU&redir_esc=y#v=onepage&q&f=false [Сүүлд үзсэн: 2023.11.30].

³³ Elizabeth Mertz, Mark Goodale, “Comparative anthropology”, *Comparative Law and Society (Research handbooks in Comparative law)*, USA, Edward Elgar Publishing, 2012, p.79.

хүйтэн, халуун эсвэл сэрүүн цаг агаарт нь, газрын хөрсний чанарт, уг орны байршилд, нутаг дэвсгэрийнх нь хэмжээ дамжаанд, цаашилбал, тариачид, тариачид, анчид, малчид болох ард түмнийх нь амьдралын хэв маягт, улсынх нь байгууллаар тодорхойлогддог эрх чөлөөнийх нь хэр хэмжээнд, оршин суугчдынх нь шашин шүтлэг, авъяас чадварт, мөнөөх ард түмнийх баялаг, тоо хэмжээнд, худалдаанд нь, зан төлөв, ёс заншилд нь нийцэж байх учиртай . . .”³⁴ гэж бичиж байв. Энэ талаар Жан Копаны Угсаатан судлал, хүн судлалын удиртгал хэмээх (2007) бүтээлд “. . . хууль цаазын болон аман уламжлалын өргөн талбар бол хуулийн хүн судлалын салбарыг үүсгэдэг. Хүн судлалын олон сэтгэгчид хуульчид (Henry Sumner Maine, Lewis Henry Morgan зэрэг) байсан учраас хуулийн үүднээс бодож сэтгэж байв. Энэ ухааны хамгийн эртний мэргэжил мэргэшлийн нэг болсон . . .”³⁵ тухай бичжээ. Антропологийн ухааны үндэслэгчид болох Мейне, Морган бүгд л ямар нэгэн байдлаар тухайн судалж буй нийгмийнхээ уламжлал, зан заншил, дэг журам, хууль, соёлын тухай бүтээлдээ тусгаж байжээ. Жишээ болгон Мейнегийн Эртний хууль (Ancient Law, 1861)³⁶ хэмээх бүтээлийг, Морганы Эртний нийгэм (Ancient Society, 1877)³⁷ хэмээх бүтээл зэргийг дурдаж болох юм. Энэ тухай нийгэм, соёлын антропологийн зарим бүтээлүүдэд “. . . АНУ–д антропологийн үүсэл нь XIX зууны дунд үеийн судлаач Морганы үйл ажиллагаатай салшгүй холбоотой . . .”³⁸ гээд “. . . хувьслын онолч байсан нь хожим Боас, Кроебер, Малиновски нарын шүүмжлэлд өртөж байсан ч, бүтээлүүд нь Маркс, Энгельс зэрэг материалист онолчдын ажилд ихээхэн нөлөө үзүүлсэн. Жишээ нь Энгельсийн “Гэр бүл, хувийн өмч, төрийн үүсэл” хэмээх (1884) бүтээл тэр чигээрээ Морганы “Эртний нийгэм” хэмээх (1877) бүтээлийн эх хэрэглэгдэхүүн дээр суурилсан гэж хэлж болно . . .”³⁹ гэж бичжээ. Мейне, Морган нарыг эрх зүйн антропологийн төдийгүй улс төрийн антропологийн хөгжилд зохих нөлөө үзүүлсэн сэтгэгчид гэж судлаачид нэрлэдэг.⁴⁰ Улс төрийн антропологийн эхлэл үе нь XIX зууны эхэн үеийн антропологичдын бүтээлтэй салшгүй холбоотой. Морган, Мейне нарын бүтээл тэдгээрийн тоонд орно. Харин уг салбар олонд танигдан хөгжих болсон үе нь 1940 – 1950–аад он гэж үздэг.⁴¹

Н.Лүндэндорж Төрийн онол хэмээх (2020) бүтээлд “XX зууны дунд үеэс өрнөдийн улс төрийн антропологийн нэг томоохон ололт болсон “удирдагчийн онол” (chiefdom)–д суурилсан төр улсын үүслийг авч үзэх шинэ чиглэл бий болжээ”⁴² гээд “улс ба төрийн үүслийн талаархи улс төрийн антропологийн онолын талаар авч үзээд энэ онол байгалийн захиргаанаас нийтийн захиргаанд (төрийн бюрократ бүтэц бүхий институт) шилжих завсрын шатыг удирдагчийн захиргаа”⁴³ гэж тодорхойлсон байна. Мөн тус бүтээлд төр улсын үүсэлд нөлөөлсөн түгээмэл хүчин зүйлсийг авч үзэхдээ “антропологийн хүчин зүйл”–ийн талаар авч үзсэн нь ихээхэн онцлог байв.⁴⁴

Харин энэ талаар Д.Бум – Очир Улс төрийн хүн судлалын онолын үүд хэмээх (2008) бүтээлд “Нийгэм, соёлын антропологит улс төрийн антропологи (Political anthropology) гэдэг салбар чиглэл бий болсон цаг үеийг 1940 – 1960–аад он гэж Винсент (Vincent) тооцсон байна. Хэдий ийм цаг тогтоож болох боловч харин түүнээс бүр түрүүн антропологийн ямар ч судалгаанд улс төрийн (political) гэж тодорхойлж болох хэсэг бүлгүүд элбэг байсныг

³⁴ Шарль Монтескье, Хуулийн амин сүнс, орч. Т.Төмөрхүлэг, Уб., Монсудар, 2008, 17 дахь тал., Шарль Монтескье, Хуулийн амин сүнс, орч. Т.Төмөрхүлэг, Уб., Монсудар, 2009, 6 дахь тал., Барон де Монтескье, Хуулийн амин сүнс, орч. Т.Төмөрхүлэг, Уб., Монсудар, 2009, 34 – 35 дахь тал.

³⁵ Жан Копан, Угсаатан судлал, хүн судлалын удиртгал, орч. С.Дулам, Уб., 2007, 71 дэх тал.

³⁶ <https://archive.org/details/ancientlawitsco18maingoog/page/n10/mode/2up> [Сүүлд үзсэн: 2023.11.30].

³⁷ <https://archive.org/details/ancientsociety00morg> [Сүүлд үзсэн: 2023.11.30].

³⁸ Г.Мөнх – Эрдэнэ, П.Чулуунбат, Нийгэм – соёлын хүн судлалын удиртгал, Уб., МУИС Пресс хэвлэлийн газар, 2017, 18 дахь тал.

³⁹ Д.Бум – Очир, Г.Мөнх – Эрдэнэ, Нийгэм, соёлын хүн судлалын онолын үүд, Уб., Адмон принтинг, 2012, 32 дахь тал.

⁴⁰ Д.Бум – Очир, Улс төрийн хүн судлалын онолын үүд, Уб., Бемби сан хэвлэлийн газар, 2008, 15 дахь тал.

⁴¹ Г.Мөнх – Эрдэнэ, П.Чулуунбат, Нийгэм, соёлын хүн судлалын удиртгал, Уб., МУИС Пресс хэвлэлийн газар, 2017, 210 дахь тал.

⁴² Н.Лүндэндорж, Төрийн онол, нэмж засварласан 4 дэх хэвлэл, Уб., 2020, 47 дахь тал.

⁴³ Н.Лүндэндорж, Төрийн онол, нэмж засварласан 4 дэх хэвлэл, Уб., 2020, 48 – 49 дэх тал.

⁴⁴ Н.Лүндэндорж, Төрийн онол, нэмж засварласан 4 дэх хэвлэл, Уб., 2020, 49 дэх тал.

дурдалгүй өнгөрч болохгүй юм. Энэ утгаар нь авч үзвэл Винсент улс төрийн антропологиийг анх 1851 оны үеэс Америкийн уугуул иргэдийг судалж байсан эрдэмтэн Левис Хенри Морганаас (Lewis Henry Morgan) эхтэй гэж хэлж болох юм. Антропологи улс төртэй холбогдсон түүхэн хугацааг Винсент гурван үе болгон хуваасан байна. Эхний үе нь 1851 – 1939 оны үе буюу антропологичид улс төрийг санамсаргүй судалж байсан үе гэж нэрлэжээ. Өөрөөр хэлбэл яг улс төрийн антропологи гэдэг тодорхой салбар чиглэл бий болоогүй боловч өөр зүйлсийг судалж байх явцдаа судлаачид шууд бус утгаар улс төрийн асуудлуудыг хөндөж байсан гэж тайлбарлаж болох юм. Үнэндээ ч нийгэм, соёлыг нэгэн бүхэл цогц гэж харвал түүнийг бүрэлдүүлэгч олон зүйл дотор улс төр зайлшгүй багтаж байдаг. Иймээс нийгмийг, соёлыг бүхэл цогцоор нь ойлгохын тулд түүн дотор байгаа улс төрийн хүчин зүйлийг судлаач хүн анхаарахгүй өнгөрөх аргагүй гэж антропологиин ухаан номлодог. Дэд үе нь 1940 – 1972 он гэж үзсэн бөгөөд энэ бол улс төрийн антропологи биелэлээ олж ухамсартай тогтолцоо бүхий мэдлэг бие даасан салбар болохоо тунхагласан үе ажээ. Харин хөгжлийн дараагийн буюу гурав дахь үе бол 1970–аад оноос хойшхи үе бөгөөд энэ үед улс төрийн антропологиин тогтсон ойлголтуудыг задалж (deconstruct), дахин шинжилсэн үе гэж Винсент тодорхойлжээ. Ийнхүү улс төрийн антропологиийг шинээр, өөрөөр харахад нэн тэргүүнээ феминизм, нийгмийн түүх, газар зүйн онол, шүүмжлэл ихэд нөлөөлсөн⁴⁵ гэж дэлгэрэнгүй авч үзэж бичсэн байна. Мөн тус бүтээлд “Сайн бөхийн шинж, хурдан морины шинж бол бие махбодийн физик хүчийг илэрхийлсэн шинжүүд мөн бөгөөд энэ утгаараа биологийн, байгалийн гаралтай. Энэ шинж нь цаашдаа улам нийгэмшин хөгжиж ноёрхлын нэгэн хэлбэрийг бий болгодог нь ноёрхлыг биологийн байгалийн гаралтай зүйл мэт харагдуулдаг. Үүний яг эсрэгээр цэвэр нийгмийн чанартай ноёрхлын хэлбэрүүдийг авч үзвэл тэнд биологийн ямар ч эх сурвалж байхгүй төдийгүй зөвхөн хүн төрснөөс хойш нийгэмших явцад л бий болон хөгждөг. Энд дурдаж байгаа сүүлийн нийгэм, соёлын гэгдэх ноёрхлын хэлбэр антропологиин гол судлагдахуун болдог⁴⁶ гээд “нийгэм, соёлын антропологиин улс төр судлалд гол асуудлаа болгон анхааран судалдаг нь биологийн, амьтнаас гаралтай гэх физик хүч биш харин нийгэм, соёлын бүтээгдэхүүн болох хүч ноёрхлын тухай асуудал болно⁴⁷ гэж улс төрийн антропологиин судлагдахууныг ихээхэн тодорхой болгосон байна.

Мөн түүнчлэн Г.Мөнх – Эрдэнэ, П.Чулуунбат нарын Нийгэм, соёлын хүн судлалын удиртгал хэмээх (2017) бүтээлд “1980–аад оноос улс төрийн антропологи угсаатны ухамсар, үндсэрхэг үзэлд анхаарах болсон юм. Өмнө нь анхааран судалж байсан ураг төрөл, нийгмийн зохион байгуулалт дээрээ тулгуурлан “ижилсэл” хийгээд “ижилслийн улс төрийг” сонирхон судлах болсон нь энэ үеийн онцлог юм. Мөн төрөөс бий болгосон үндсэрхэг үзлийн хүрээ, соёлын ялгааны улс төрийн зохион байгуулалт дахь угсаатны ухамсар зэрэг нь нилээд сонин сэдэв байжээ. Төр – үндэстний хүрээнд гадуур бий болдог соёл болон улс төрийн ижилсэл дээрхтэй мөн адил юм. Энэ мэтээс гадна өөр олон судалгааны чиг хандлага улс төрийн антропологиид байна⁴⁸ гэж бичиж тэмдэглэжээ.

Б. “Эрх зүйн антропологи” эрх зүй судлалын шинжлэх ухааны салбар болох нь

Д.Бум – Очир, Г.Мөнх – Эрдэнэ нар Нийгэм, соёлын хүн судлалын онолын үүд хэмээх (2012) бүтээлдээ зааг ялгаагүй салбар ухаануудын (Becoming Undisciplined) талаар “Антропологиин салбар ухаанууд тухайлбал хууль, эдийн засаг, улс төр, шашин гэх мэт, хэзээ ч зөвхөн антропологиин ухааны сэдэв байдаггүй харин дандаа аль нэгэн нийгэм, хүмүүнлэгийн ухааны салбартай голдуу давхцаж байдаг. Үүний учир нь үнэндээ соёл,

⁴⁵ Д.Бум – Очир, Улс төрийн хүн судлалын онолын үүд, Уб., Бемби сан хэвлэлийн газар, 2008, 12 – 14 дэх тал.

⁴⁶ Д.Бум – Очир, Улс төрийн хүн судлалын онолын үүд, Уб., Бемби сан хэвлэлийн газар, 2008, 27 дахь тал.

⁴⁷ Д.Бум – Очир, Улс төрийн хүн судлалын онолын үүд, Уб., Бемби сан хэвлэлийн газар, 2008, 28 дахь тал.

⁴⁸ Г.Мөнх – Эрдэнэ, П.Чулуунбат, Нийгэм, соёлын хүн судлалын удиртгал, Уб., МУИС Пресс хэвлэлийн газар, 2017, 212 дахь тал.

нийгмийн доторх салбарууд нь бие биесээ салшгүй нийтлэг байдагтай холбоотой⁴⁹ гэж бичсэн нь (үүнд “хууль” гэж авч үзсэн нь) ихээхэн онцлог байна.

Хэдий тийм боловч нэгэн хуулийн баримт бичгийн эмхэтгэлд “. . . Монголын хууль монголын амьдралаас урган гарч баймааж Монголын хууль байх ёстой гэдгийг хэн бүхэн мэдэх билээ . . .”⁵⁰ гэж дурджээ. Мөн түүнчлэн Хууль зүйн техник хэмээх орчуулгын бүтээлд “. . . төрийн антропологи болон эрх зүйн антропологи (гэдгээрийн үүсэл, хөгжлийн тухай сургаал) . . .”⁵¹ гэж бичсэн байв. Энэ нь эрх зүй судлалын шинжлэх ухааны салбарууд болох нь ““эрх зүйн философи”, “эрх зүйн онолын”⁵² нэгэн адил “эрх зүйн антропологи” нь эрх зүйн судлалын шинжлэх ухааны нэг салбар⁵³ гэдгийг илэрхийлж байна. Энэ утгаар антропологийн ухааны салбар болох эрх зүйн антропологийг Монгол Улсад хөгжүүлэх нь онолын төдийгүй практикын ихээхэн ач холбогдолтой гэж үзэж байна. Монголын хууль зүйн салбарт Чезаре Ломброзо (Cesare Lombroso)–ийн үндэслэсэн биологийн антропологийн үүднээс илүүтэй авч үзэж ирсэн болохоос эрх зүйн антропологийн талаар төдийлөн судалж байгаагүй болно. Жишээ болгон доктор, профессор Н.Лүндэндорж,⁵⁴ Н.Жанцан,⁵⁵ С.Жанцан⁵⁶ зэрэг судлаачдын бүтээлүүдийг дурдаж болох юм. Хэдий тийм боловч доктор, профессор Ц.Сарантуяа,⁵⁷ Х.Сэлэнгэ⁵⁸ зэрэг судлаачид эрх зүйн антропологийн талаар өөрсдийн бүтээлдээ товчхон хөндсөн байна. Тодруулбал, Х.Сэлэнгэ “Хүн ба эрх зүй” хэмээх (2000) өгүүлэлд “. . . эрх зүйн мөн чанарын тухай асуудал нь эрх зүй гэсэн үзэгдлийн дотоод талд хамаарагдах асуудал тул түүний уг сурвалжийг авч үзэхгүйгээр эрх зүйн мөн чанарыг тодорхойлох боломжгүй юм. Эрх зүйн уг сурвалж бол хүн. Иймд хүний мөн чанарыг танин мэдэхгүйгээр эрх зүйн мөн чанарыг ойлгож, түүний тухай ярих боломжгүй байна. Ер нь аливаа нийгмийн шинжлэх ухаан нь хүн судлалгүйгээр хөгжих боломжгүй . . .”⁵⁹ гэж бичсэн байна. Тэгвэл доктор, профессор Ч.Нямсүрэн Эрх зүйн ерөнхий онол хэмээх (2017) бүтээлд “өнөө үед (XX зууны сүүл, XXI зууны эхэн) эрх зүйн ерөнхий онол нь дэлхийн улс орнуудад, ялангуяа эх газрын эрх зүйн тогтолцоотой улс оронд хууль зүйн цоо шинэ шинэ шинжлэх ухааны (эрх зүйн антропологи болон бусад) шинэ мэдлэг, арга зүйн болон үзэл суртлын олон ургалч хандлагад тулгуурлан хөгжиж байна”⁶⁰ гэж бичиж байв. Үүнийг улам тодруулан доктор Б.Тамир “. . . олон улсын хувийн эрх зүйн хөгжил нь салбар дундын байдлаар буюу эдийн засаг, улс төр ба антропологийн шинжлэх ухааны чиг хандлагыг хослуулан хөгжсөөр байна . . .”⁶¹ гэж баримталж байгаа хандлагуудыг онцлон гаргаж ирсэн байна. Харин доктор, профессор Хайнрих Шоллэр “Эрх зүйн ангилал ба соёлын тухай” илтгэлдээ “. . . эрх зүйн антропологи чигдэг эс тооцвол эрх зүйн хүрээний онол нь хэвшиж амжаагүй байгаа юм. Антроплогичид бол газар зүй болон гарал үүслийн хувьд эрс тэс ялгаатай угсаатнуудыг соёл иргэншлийн тодорхой элемент, тэдний бүтээж байсан сав суулга, барилга байгууламжийн онцлогт үндэслэн соёл иргэншлийн нэг хүрээнд хамааруулдаг юм . . . Одоо цаг үед эрх зүйн соёл иргэншил болон эрх зүйн соёл иргэншлийн хүрээний тухай ярих нь арай эртгэдсэн зүйл байж магадгүй. Тэгсэн хэдий ч эрх зүйн хүрээ

⁴⁹ Д.Бум – Очир, Г.Мөнх – Эрдэнэ, Нийгэм, соёлын хүн судлалын онолын үүд, Уб., Адмон принтинг, 2012, 203 дахь тал.

⁵⁰ Монгол Улсын иргэний хуульд холбогдох баримт бичиг (2001 – 2002), эмх. А.Доржготов, Б.Амарсанаа, З.Сүхбаатар, Уб., Адмон принтинг, 2018, 828 дахь тал.

⁵¹ Т.В.Кашанина, Хууль зүйн техник, орч. С.Гэрэлмаа, Д.Отгончимэг, Н.Тунгалаг, Уб., 2012, 19 – 20 дахь тал.

⁵² Х.Сэлэнгэ, “Эрх зүй, хууль зүй гэсэн нэр томьёоны талаарх шүүмж, эргэцүүлэл”, Эрх зүй сэтгүүл №1 (2014), 151 дэх тал.

⁵³ С.Номынбаясгалан, “Эрх зүйн антропологи”, Эрх зүй сэтгүүл №3 (2022), 51 дэх тал.

⁵⁴ Н.Лүндэндорж, Монгол Улсын Үндсэн хууль: Шинжлэх ухааны тайлбар, Уб., Адмон принтинг, 2022, 168 – 169 дэх тал.

⁵⁵ Н.Жанцан, Криминологи, Уб., 2004, 118 дахь тал

⁵⁶ С.Жанцан, Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол, Уб., 2009, 926 дахь тал.

⁵⁷ Ц.Сарантуяа, “Үндсэн эрх болон хүний эрх: Харьцуулалт, онолын эргэцүүлэл”, Эрх зүй сэтгүүл, №1 (2000), 20 – 21 дэх тал.

⁵⁸ Х.Сэлэнгэ, “Хүн ба эрх зүй”, Эрх зүй сэтгүүл, №2 – 3 (2000), 97 – 99 дэх тал.

⁵⁹ Х.Сэлэнгэ, “Хүн ба эрх зүй”, Эрх зүй сэтгүүл, №2 – 3 (2000), 97 дахь тал.

⁶⁰ Ч.Нямсүрэн, Эрх зүйн ерөнхий онол, Уб., 2017, 44 дэх тал.

⁶¹ Б.Тамир, Олон улсын хувийн эрх зүй, Уб., 2019, 48 дахь тал.

хэмээх ухагдахуун бий болсон нь эрх зүйн бүл ба эрх зүйн тогтолцоо гэсэн ойлголтоос яваандаа салах юм гэсний дохио . . .”⁶² гэж бичсэн нь “эрх зүйн хүрээ” гэсэн онолын хувьд ихээхэн ач холбогдолтой үзэл санааг гаргаж ирснийг онцлон тэмдэглэмээр байна.⁶³

В. Эрх зүйн антропологи, угсаатны зүйгээр дэмжигдэн буй хүний эрхийн хандлагын талаар товчхон

Э.Булаг Монгол дахь ястны үзэл ба үндэстний эв нэгдэл, тэдгээрт холбогдох эрх зүйн асуудал хэмээх (2020) бүтээлд “хүн судлалаар дэмжигдэн буй хүний эрхийн хандлага (the human rights approach supported by anthropology/ethnology)⁶⁴–ын талаар авч үзсэн нь ихээхэн онцлог байв. Энэ талаар цааш нь гүнзгийрүүлж судлах зүйлүүд цөөнгүй бий. Энэ хандлагын үүднээс угсаатны асуудалд баримталж буй Монгол Улсын байр суурь нь хүний эрхийн орчинд дахин шинээр мэндэлсэн буюу бидний ойлгож байгаагаар хүний эрхэжсэн байна. Хүний эрхийн хандлага нь монголын уламжлалт үзэл санаатай үл зохицох бөгөөд ямар ч тохиолдолд Үндсэн хуульд хэрэглэгдсэн нэр томъёотой зөрчилдөнө гэж тэрээр бичсэн байна.⁶⁵

Г. Эрх зүйн антропологиогийг төрөлжүүлэх нь

Антропологиин ухааны, нэн ялангуяа нийгэм, соёлын антропологиин дэд салбар болох эрх зүйн антропологиогийг “дан ганц эрх зүйн онол, сэтгэлгээний хүрээнд бус харин хууль зүйн хэрэглээ болгох үүднээс салбар эрх зүйгээр жишээлбэл арилжааны (худалдааны) эрх зүйн антропологи, хэвлэл мэдээллийн эрх зүйн антропологи, сонгуулийн эрх зүйн антропологи гэх зэргээр төрөлжүүлж болох талаархи энд ийнхүү онцлон авч үзэж байна. Ийнхүү үндэсний хууль тогтоомжийг антропологиичлон судалгааны объектоор нь буюу салбар эрх зүйгээр нь төрөлжүүлэн авч үзэх нь эрх зүйн антропологиин хэрэглээний ач холбогдлыг цаашид нэмэгдүүлэх хөшүүрэг болох учиртай юм.

2. УЛС ТӨРИЙН БОЛОН ЭРХ ЗҮЙН АНТРОПОЛОГИЙН ХАРИЛЦАН ХАМААРЛЫН ҮҮДНЭЭС “СОНГУУЛИЙН ЭРХ ЗҮЙН АНТРОПОЛОГИЙН АСУУДАЛ”–ЫГ АВЧ ҮЗЭХ НЬ

Энэ дэд хэсэгт сонгуулийн эрх зүйн антропологиин үндсэн асуудлыг улс төрийн болон эрх зүйн антропологиин харилцан хамаарлын үүднээс “сонгуулийн эрх зүйн антропологи” хэмээх нэр томъёоны нэршил, оноолтын талаар, сонгуулийн эрх зүйн антропологиогийг хөгжүүлэх шинжлэх ухааны хэрэгцээ шаардлага болон түүний үндсэн (нийтлэг) судлагдахууныг нь тодорхойлох, түүнд холбогдох бусад асуудлыг авч үзэв.

А. “Сонгуулийн эрх зүйн антропологи” хэмээх нэр томъёоны нэршил, оноолтын тухай цөөн үгээр

Нэгэнт тогтсон хууль зүйн нэр томъёог өөрчлөх гэхээсээ илүүтэй утга агуулга, үзэл санааг нь нэг мөр ойлгох нь чухал⁶⁶ гэж үздэг. Тиймээс нийтээр хэвшсэн нэр томъёог аль болох хэвээр нь хэрэглэхийн зэрэгцээ антропологиин ухаан болон хууль зүйн шинжлэх ухааны онолын үүднээс хүлээн зөвшөөрөгдөхүйц байх ёстой. Энэ утгаараа жишээлбэл “антропологи” хэмээх нэр томъёог хууль зүйн салбарт, нэн ялангуяа сонгуулийн хуулийн антропологи гэсэн томъёог хэрэглэснээр “сонгуулийн эрх зүйн антропологиин агуулгыг хэт явцууруулан тодорхойлуулах” төдийгүй “эрх зүйн илрэн гарах хэлбэрийн тухай ойлголтыг эрх зүйн мөн чанарын тухай ойлголттой адилтган ойлгох” нөхцлийг бүрдүүлэх юм.

⁶² Хайнрих Шоллер, “Эрх зүйн ангилал ба соёлын тухай”, Эрх зүй сэтгүүл, №1 (2000), 29 – 30 дахь тал.

⁶³ С.Номынбаясгалан, “Худалдааны эрх зүйн антропологиин тухай”, Хууль дээдлэх ёс, №2 (2023), 202 – 203 дахь тал.

⁶⁴ Э.Булаг, Монгол дахь ястны үзэл ба үндэстний эв нэгдэл, тэдгээрт холбогдох эрх зүйн асуудал, орч. Э.Туулайхүү, Ш.Туяа, Уб., 2020, 102 дахь тал.

⁶⁵ Э.Булаг, Монгол дахь ястны үзэл ба үндэстний эв нэгдэл, тэдгээрт холбогдох эрх зүйн асуудал, орч. Э.Туулайхүү, Ш.Туяа, Уб., 2020, 101 – 102 дахь тал.

⁶⁶ “Хууль зүйн нэр томъёоны судалгаа, хэрэглээ” (Улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл) Уб., 2016, 73 болон 77 дахь тал.

Тухайлбал, *сонгуулийн хуулийн антропологи гэх зэргээр нэрлэх нь **сонгуулийн эрх зүйн антропологиос агуулга, мөн чанарын хувьд эрс ялгаатай гэж үзэж байна. Түүнчлэн эрх зүйн онолын хувьд эрх зүй хуулиас ялгаатай төдийгүй илүү өргөн агуулгаар тодорхойлогддог⁶⁷ болохыг мартах учиргүй юм. Өөрөөр хэлбэл, эрх зүй судлал (эрх зүйг тогтолцооноос нь хальж, илүү өргөн хүрээтэй судалдаг) нь хууль зүй судлал (эрх зүйн тогтолцооны хүрээнд) – аас судалгааны онол, арга зүйн хувьд ялгаатай болно. Эрх зүй, түүний илрэн гарах хэлбэр болох хууль, тэдгээрийн ялгаа, харилцан хамаарлын тухай үзэл санаа нь эрх зүйн тухай үзэл санаатай зэрэгцэн нэн эртнээс үүссэн бөгөөд одоо ч гэсэн эрх зүйн танин мэдэхүйн анхаарлын төвд байсаар байна.⁶⁸ Энэ дээр үндэслэн эрх зүй, хуулийг агуулгын ялгаагүй гэж үзэж болохгүй, ялангуяа хууль нь агуулгаасаа гажсан тохиолдол бүр ч болохгүй юм. Харин хууль нь агуулгаасаа гажаагүй, эрх зүйд нийцсэн буюу эрх зүйт хуулийг эрх зүй гэж үзэж болох боловч өнөөг хүртэл хууль тогтоох явцад хууль нь агуулгаасаа гажиж байдаг тул эрх зүй, хууль хоёрыг ялгах хэрэгцээ шаардлага байгаа юм.⁶⁹ Өөр үгээр хэлбэл, нэр томьёог хэрхэн оноож өгснөөс шалтгаалан хоёрдмол утгаар ойлгогдох үр дагавартай байна. Үүнээс гадна эрх зүйн онол, философийн үүднээс эрх зүйн хэлбэрийг агуулгатай адилтган авч үзэх эрсдэлтэй болж байна. Тийм учраас хууль эрх зүйт шинжийг бүрэн олоогүй байгаа тохиолдолд “эрх зүй”, “хуулийн” ялгааг сайтар ухаарах, судлах, хууль тогтоомж бүрийг эрх зүйн шалгуураар шалгах шаардлага зайлшгүй бий. Энэ бол эрх зүйт төр, хуультай болох нэн чухал угтвар нөхцөл⁷⁰ болохыг онолын хувьд бас санах учиртай. Иймд нэр томьёоны нэршил, оноолтын хувьд хууль зүйн болон улс төрийн салбаруудад нэгэнт нийтээр хүлээн зөвшөөрч нэрлэж, цаашлаад хэрэглэж дадсан “дадна” гэж үзвэл салбар бүрт адил утгаар ойлгон хэрэглэгддэг нийтлэг нэр томьёо болгон хэвшүүлэх боломжтой юм. Энэ нь бас антропологийн ухаан болон хууль зүйн шинжлэх ухааны онолын үүднээс сонгуулийн хуулийн антропологи гэж нэрлэхийн оронд *сонгуулийн эрх зүйн антропологи гэсэн нэр томьёонд хэвшүүлэн нэрлэх (хэрэглэх) нь зүйтэй гэж үзэж байна.

Б. Сонгуулийн эрх зүйн антропологийг хөгжүүлэх шинжлэх ухааны хэрэгцээ шаардлага

Антропологийн ухааны, нэн ялангуяа нийгэм, соёлын антропологийн дэд салбар болох эрх зүйн антропологийг, тэр дотроо сонгуулийн эрх зүйн антропологийн чиглэлээр төрөлжүүлэн Монгол Улсад хөгжүүлэх нь онолын төдийгүй практикын ихээхэн ач холбогдолтой тухай өмнө дурдсан. Энэ утгаар “сонгуулийн эрх зүйн хөгжлийн асуудлыг сонгуулийн эрх зүйд хамаарах эрх зүйн зохицуулалтын тодорхой жишээн дээр авч үзвэл сонгуулийн эрх зүйн антропологийг хөгжүүлэх хэрэгцээ шаардлага бий болсныг хууль зүйн практик харуулж байна. Энэ байдал нь цаашлаад иргэний сонгох, сонгогдох эрх зөрчигдөхөд хүргэж байгаа”⁷¹ талаар хөндсөн байна. Товчхондоо бол эрх зүйн антропологи нь XIX зууны дунд үеэс хөгжсөн бөгөөд нэг талаас нийгмийн олон талт харилцаа, соёл, ухамсарын ижилсэл, ондоошлыг, нөгөө талаас хүнийг эрх зүйн харилцааны объект болох талаас нь судалдаг антропологийн ухааны болон хууль зүйн шинжлэх ухааны салбар

⁶⁷ 1. Хууль нь эрх зүйн илрэх гадаад хэлбэр. Д.Баярсайхан, Эрх зүйн онол, Тав дахь хэвлэл, Уб., 2018, 34 дэх тал.

2. Эрх зүйн ба хууль тогтоомжийн тогтолцооны харьцаа: эрх зүйн тогтолцоо ба хууль тогтоомжийн тогтолцоо бие даасан бөгөөд харилцан уялдаатай юм. Эдгээр нь өөр хоорондоо хэлбэр ба агуулгын харьцаатай байна. Эрх зүйн тогтолцоо бол агуулгыг илэрхийлэх бөгөөд нийгмийн харилцааг зохицуулах шинжид нийцсэн эрх зүйн дотоод бүтэц юм. Хууль тогтоомжийн тогтолцоо нь эрх зүйн эх сурвалжийн байгууламжийг илэрхийлдэг эрх зүйн гадаад хэлбэр өөрөөр хэлбэл хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актын тогтолцоо. Эрх зүй нь хууль тогтоомжгүйгээр оршихгүй болохын хамт харин хууль тогтоомж нь өргөн хүрээтэй ойлгоцоор эрх зүй болно. С.Нарангэрэл, Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо, (Харьцуулсан эрх зүй), Уб., 2001, 87 дахь тал.

⁶⁸ Х.Сэлэнгэ, “Эрх зүй, хууль зүй гэсэн нэр томьёоны талаарх шүүмж, эргэцүүлэл”, Эрх зүй сэтгүүл, Уб., 2014, №1, 150 дахь тал.

⁶⁹ Х.Сэлэнгэ, “Эрх зүй, хууль зүй гэсэн нэр томьёоны талаарх шүүмж, эргэцүүлэл”, Эрх зүй сэтгүүл, Уб., 2014, №1, 151 дэх тал.

⁷⁰ Н.Лүндэндорж, Эрх зүй судлал: Философи, онол, Уб., 2011, 26 дахь тал.

⁷¹ С.Номынбаясгалан, “Сонгуулийн эрх зүйн антропологи”, Политологи, №21 (2023), 194 – 207 дахь тал.

дундын бие даасан хавсарга шинжлэх ухаан⁷² гэж үзэж болох юм. Энэ салбар ухааны үүднээс сонгуулийн эрх зүйн асуудлыг авч үзсэн судалгаа өнөө хэр нь үндэсний хууль зүйн салбарт хэвлэгдээгүй байна. Энэ нь хүн төрөлхтний түгээмэл үнэт зүйлсийг үндэсний сонгуулийн хууль тогтоомжид тусгахдаа монгол орны өвөрмөц онцлог, үндэсний хэв маяг, монголчуудын сэтгэлгээ, хандлага, уламжлал, монгол хүний онцлогт нийцүүлэн “монгол хөрсөнд” буулгаж чадсан уу гэх мэт асуулт түгээмэл тохиолдох боловч өнөөг хүртэл (шинжлэх ухааны) мэргэжлийн түвшинд хариултгүй байсаар байгаа нь эрх зүйн антропологийн судалгаа хийх нийгмийн хэрэгцээ шаардлага үгүйлэгдэж байгааг харуулна. Дээрхи асуултад эрх зүйн антропологийн судалгааны үр дүн зохих хариултыг өгнө гэж үзэж байна.

В. Сонгуулийн эрх зүйн антропологийн судлагдахууныг тодорхойлох нь

Сонгуулийн эрх зүйн антропологийн судлагдахууныг дараахь байдлаар ерөнхийд нь тодорхойлж болох юм. Үүнд:

Д.Бум – Очир Улс төрийн хүн судлалын онолын үүд хэмээх (2008) бүтээлд “Улс төрийн хүн судлал юу судалдаг вэ гэдэг асуултын хариу нь мөн л улс төр гэдэг нэр томьёо шигээ өргөн хүрээнд тайлбарлагдах шаардлагатай болдог. Иймээс улс төрийн хүн судлалыг зөвхөн макро түвшний улс орон, нийт үндэстэн угсаатныг хамарсан төр засгийн асуудлыг л судалдаг гэвэл түүний хүрээ хэмжээг ихэд хумин хязгаарласан хэрэг болно. Харин ямар ч нийгмийн давхаргад, ямар хүрээ хэмжээнд тохиолдож болох захирах захирагдах, удирдах удирдуулах, эмх цэгц тогтоох харилцаа болон энэ харилцаанд бий болж байгаа хүчний их багын асуудлыг судалдаг гэвэл үнэнд илүү нийцтэй. Ингэж үзвэл хамгийн багадаа хоёр хүний хоорондох ямар ч харилцаа захирах захирагдах харилцаа байж болох юм. Тухайлбал ах дүүгийн харьцаа, албан хаагч дарга хоёрын харьцаа, үйлчлэгч үйлчлүүлэгчийн харьцаа гэхчилэн ямар ч хүний ямар ч харилцааны хэлбэр улс төрийн хүн судлалын судлагдахуун байж болох бололцоотой ажээ. Тодруулбал их, бага аливаа хүний бүлгэмдэл ямар нэгэн зохицол, цэгц, захиргаатай байх бөгөөд иймгүй бол манай монгол сэтгэлгээнд хэлдэг шиг хөл толгой нь мэдэгдэхгүй, эх зах нь олдохгүй замбараагүй байдал бий болно. Энэ утгаараа улс төрийн хүн судлал ёс дэг, дүрэм журам, хууль цааз, хорио хяналтыг ч судалдаг”⁷³ гэж улс төрийн антропологийн судлагдахууны талаар бичсэн байна. Үүнээс гадна улс төрийн антропологийн этнографийн (олон тооны антропологичдын хээрийн шинжилгээний ажил түүн дээр үндэслэн гарсан тайлбар, шинжилгээ) талаар хөндсөн нь ихээхэн онцлог байв.⁷⁴

Энэ дэд хэсэгт сонгуулийн хуулийн хувийн хэрэг, тэр дундаа сонгуулийн хууль тогтоомжийг (Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Монгол Улсын ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль гэх мэт) хэлэлцсэн тэмдэглэлүүд болон холбогдох бусад баримт бичиг сонгуулийн эрх зүйн үндсэн судлагдахуун болох уу гэсэн асуултад хариулахыг оролдов. Энэ утгаар сонгуулийн эрх зүйн антропологийн үндсэн (нийтлэг) судлагдахуун нь “сонгох, сонгогдох эрх” гэж үзээд “Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтыг хэлэлцэн баталсан БНМАУ–ын Бага Хурлын чуулганы болон Ардын Их Хурлын хуралдааны тэмдэглэл”⁷⁵ зэргийг онцлон авч үзэв.

⁷² С.Номынбаясгалан, Б.Баатарцогт, Г.Мөнх – Эрдэнэ, Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн хууль зүйн антропологийн судалгаа, (Хууль зүйн антропологийн судалгаа хийх судлаачдад зориулсан гарын авлага), Уб., Тотопресс, 2021, 5 дахь тал.

⁷³ Д.Бум – Очир, Улс төрийн хүн судлалын онолын үүд, Уб., Бемби сан, 2008, 8 – 9 дэх тал.

⁷⁴ Д.Бум – Очир, Улс төрийн хүн судлалын онолын үүд, Уб., Бемби сан, 2008, 10 дахь тал.

⁷⁵ Энэхүү өгүүлдийн “хавсралт” хэсгээс Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн холбогдох заалтуудыг хэлэлцэн баталсан БНМАУ–ын Бага Хурлын гишүүдийн болон Ардын Их Хурлын депутатуудын үг хэлсэн байдлыг үзнэ үү.

Тиймээс энэхүү хэсэгт дээрхи тэмдэглэлүүдийн түүвэрлэлтээс авч үзвэл,⁷⁶ “БНМАУ–ын Бага Хурлын гишүүдийн хувьд (1991.05.17., 1991.10.12., 1991.10.14–ний өдрүүдэд) 9 дэх заалтад 31 удаа (үүнийг тодруулбал БНМАУ–ын Бага хурлын гишүүд болох Р.Гончигдорж, Д.Ламжав, Гү.Лхагважав, Н.Сагат, С.Төмөр, Л.Цогт – Очир, Ч.Цэрэндагва, Б.Чимид, Ш.Шагдарсүрэн зэрэг хүмүүс); харин БНМАУ–ын Ардын Их Хурлын депутатуудын хувьд (1991.11.27., 1991.11.28., 1992.01.03–ны өдрүүдэд) 9 дэх заалтад 31 удаа (үүнийг тодруулбал БНМАУ–ын Ардын Их Хурлын депутат болох С.Бат – Үүл, Б.Лханаасүрэн, Б.Сундуйжав, Ж.Уртнасан, Ш.Цэндбаяр, Б.Чимид зэрэг хүмүүс) давхардсан тоогоор үг хэлсэн байна; Хэлэлцүүлгийн эцэст “9 дэх заалтыг 326 депутат буюу 99 хувь нь зөвшөөрч, 2 хүн татгалзаж, 1 хүн түдгэлзэж баталсан. 329 депутат санал хураалтад оролцсон. Цөөнх байхгүй”⁷⁷ болох нь тэмдэглэлүүдээс харагдаж байна. Энэхүү тэмдэглэлүүд болох угсаатны зүйн баримт бичгүүдэд үндэслээд сонгуулийн эрх зүйн антропологийн судалгаа хийж болох юм.

Учир нь Монгол Улсын Үндсэн хуулийг Улсын Бага Хурлын чуулган, Ардын Их Хурлын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэл (протокол)–ээс зөвхөн уг хуулийн 2 дугаар бүлгийн 16 дугаар зүйлийг хэлэлцсэн тэмдэглэлийг холбогдох албан ёсны эх сурвалжаас нь түүвэрлэн нэгтгэх нь нэгдүгээрт, эрх зүйн соёл сэтгэлгээний хүрсэн түвшинг; хоёрдугаарт, уг зүйлийн заалт бүрийн үндэслэлийг хэрхэн ойлгож, томьёолсон байдлыг; гуравдугаарт, хэлэлцүүлгийн явцад Улсын Бага Хурлын гишүүд, Ардын Их Хурлын депутатуудын илэрхийлж байсан байр суурийг; дөрөвдүгээрт, Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдалд НҮБ болон бусад олон улсын байгууллагаас өгсөн үнэлгээнд дүн шинжилгээ хийхэд; тавдугаарт, уг зүйлийн заалт бүрийн хэрэгжилтийг хангах, илэрхийлсэн утга санааны мөн чанарыг тус тус судлахад чухал ач холбогдолтой юм.⁷⁸ Үүнээс гадна нэгдүгээрт, БНМАУ–ын (1924, 1940, 1960 оны) Үндсэн хуулиуд дахь сонгох, сонгогдох эрхэд холбогдох эрх зүйн зохицуулалтууд, тэдгээрийг хэлэлцэн баталсан тэмдэглэл зэргийг сонгуулийн эрх зүйн антропологийн түүхэн тойм, сонгуулийн эрхийн хөгжлийн түүх гэх агуулгаар зэрэгцүүлэн судалж болох юм. Хоёрдугаарт, Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцийн хэрэгжилтийн талаархи Монгол Улсын Засгийн газрын ээлжит илтгэлүүд, тухайн илтгэлүүдийг хэлэлцсэн талаархи НҮБ–ын гэрээний хороодын хуралдааны тэмдэглэлүүд, Монгол Улсын Засгийн газарт өгсөн зөвлөмжүүд, НҮБ–ын Хүний эрхийн зөвлөлийн хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлэгт өргөн барьсан Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын талаархи үндэсний илтгэлүүд, эдгээр илтгэлийг хэлэлцээд НҮБ–ын Хүний эрхийн зөвлөлөөс өгсөн зөвлөмжүүд⁷⁹ зэрэг нь сонгуулийн эрх зүйн антропологийн нийтлэг судлагдахуун болж байна. Гуравдугаарт, үндсэн хуулийн эрх зүйн дэд салбар болох сонгуулийн эрх зүйд холбогдох үндсэн хуулийн маргаанууд, түүнчлэн тодорхой сонгуулийн хэргүүд нь сонгуулийн эрх зүйн антропологийн нийтлэг (үндсэн) судлагдахуун байж болох юм. Дөрөвдүгээрт, эдгээр угсаатны зүйн баримт бичиг дээр тулгарласан сонгуулийн эрх зүйн антропологийн судалгааны тэмдэглэл зэрэг нь бүгдээрээ (хамтдаа) сонгуулийн эрх зүйн антропологийн үндсэн судлагдахуунууд болох учиртай.

⁷⁶ Энэхүү өгүүллийн “хавсралт” хэсгээс Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад холбогдох төсөл, тэдгээрийг хэлэлцэн баталсан БНМАУ–ын Бага Хурлын гишүүдийн болон Ардын Их Хурлын депутатуудын үг хэлсэн байдлыг №1, №2, №3 хүснэгтүүдээс дэлгэрүүлж үзнэ үү.

⁷⁷ Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийг хэлэлцсэн БНМАУ–ын Бага Хурлын чуулганы болон Ардын Их Хурлын хуралдааны тэмдэглэлүүд, (түүвэр), эмх. С.Номынбаясгалан, Б.Баатарцогт, Э.Тамир, Уб., Адмон принтинг, 2023, 296 дахь тал.

⁷⁸ Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийг хэлэлцсэн БНМАУ–ын Бага Хурлын чуулганы болон Ардын Их Хурлын хуралдааны тэмдэглэлүүд, (түүвэр), эмх. С.Номынбаясгалан, Б.Баатарцогт, Э.Тамир, Уб., Адмон принтинг, 2023, 11 дэх тал.

⁷⁹ Хүний эрхийн олон улсын гэрээ ба Монгол Улс, (Хүний эрхийн олон улсын гэрээний хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ээлжит илтгэлүүд, НҮБ–ын гэрээний хороод, хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлгээс Монгол Улсад өгсөн зөвлөмжийн эмхэтгэл /1971 – 2020/), Нэгдүгээр боть, эмх. Г.Агар – Эрдэнэ, Ч.Ариунаа, Э.Туул, Уб., Бэмби сан, 2021

Өмнө оршилд дурдсанчлан антропологи бол бодит туршлагад суурилсан ухаан бөгөөд түүний онцлог нь нийгэм, соёлын бүтээгдэхүүн болох эрх зүйн сэтгэлгээ, ухамсар, соёл, ёс, уламжлал, зан заншил, үнэт зүйлс, хүний эрх, эрх чөлөө болон тэдгээрийг тусгасан хэв хууль, ахуй, аж байдал зэрэгт ач холбогдол өгч, гол судлагдахуунаа болгон судалдаг. Эрх зүйн уламжлал нь эрх зүйн тогтолцоог тухайн соёлтой холбож илэрхийлдэг. Тэгэхлээр эрх зүйн антропологи нь эрх зүйн мөн чанарыг нийгмийн үзэгдэл талаас нь судална. Тодруулбал эрх зүйн антропологи нь байгаа болон байх ёстой зүйлийн хүрээнд бус харин байгаа зүйлийн хүрээнд илүүтэй авч үздэгээрээ эрх зүйн философиос ялгаатай гэж үзэж болох юм. Энэ утгаар сонгуулийн эрх зүйн антропологи нь сонгуулийн эрх зүйн болон эрх зүйн тогтолцооны талаархи антропологи анализ болж байна. Тиймээс сонгуулийн эрх зүйн антропологи судлагдахуун нь үндэсний сонгуулийн хууль тогтоомж, олон улсын гэрээ хэлэлцээр, шүүхийн шийдвэр зэргээр хязгаарлагдахгүй ихээхэн өргөн хүрээтэй гэсэн үг.

Г. “Сонгуулийн” болон “хэвлэл мэдээллийн” эрх зүйн антропологийн харилцан хамаарал

Энэхүү дэд хэсэгт сонгуулийн эрх зүйн антропологи болон эрх зүйн антропологийн бусад төрөлжсөн чиглэлүүдийн нэг болох хэвлэл мэдээллийн эрх зүйн антропологийн уялдаа холбоо, харилцан хамаарлын асуудлыг авч үзэх оролдлого хийв. Энд онцлон жишээ болгон дурдахад, хэвлэл мэдээллийн хэрэгсэл хэрхэн улс төрд нөлөөлдөг вэ, эсвэл сонгуулийн үеэр хэвлэл мэдээллийн хэрэгслийн баримтлах зарчим юу вэ, ардчилалд хэвлэл мэдээллийн хэрэгсэл яагаад чухал байдаг вэ, сонгуулийн үеэр баримтлах хариуцлагатай сэтгүүл зүйн зарчмын ач холбогдол юунд оршиж байна вэ гэх зэрэг асуултауд цөөнгүй. Энэ нь цаашлаад сонгуулийн эрх зүйн антропологийн судлагдахуун нь хэвлэл мэдээллийн эрх зүйн антропологийн судлагдахуунтай давхцаж болохыг харуулна. Эндээс авч үзвэл сонгуулийн болон хэвлэл мэдээллийн эрх зүйн антропологи хоорондоо ихээхэн уялдаа холбоотой болох нь харагдаж байна. Энгийнээр бол улс төрийн тоталитар тогтолцооны үед төр хэвлэл мэдээллийн хэрэгслийг хяналтандаа байлгадаг бол ардчилсан тогтолцоотой орнуудад эрүүл хараат бус хэвлэл мэдээллийн хэрэгсэл амин чухал байдаг. Гэхдээ ардчилсан тогтолцооны үед ч хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон улс төрийн хоорондох харилцаанд сүүдэртэй тал бас бий.⁸⁰ Үүнд: (1) Мэдээг сенсацитайгаар сурвалжилдаг. Улс төрийн амьдралын мэдээг бодит байдалтай нь нийцэхгүй туйлширсан байдлаар бэлтгэдэг; (2) Нэг нам, тодорхой итгэл үнэмшлийн талаар нэг тал руугаа хэт хэлбийсэн байдал үзүүлдэг. Хэрвээ тодорхой мэдээний сайт ажиллуулдаг хүмүүс улс төрийн хүчтэй итгэл үнэмшилтэй бол тэдгээрийн үзэл бодол мэдээний агуулгад нөлөөлнө; (3) Авлигад өртдөг. Сэтгүүлч, нэвтрүүлэгчид нь зарим улс төрчийн талаар магтсан болон буруушаасан мэдээ бэлтгэхийн тулд авлига авдаг тал бий (Гэхдээ бусад сэтгүүлч ийм авлигыг илрүүлэх ажлыг хийж чадна); (4) Хэдийгээр авлига аваагүй байсан ч ажил олгогчийнхоо нөлөөнд автах тохиолдол байдаг. Олон тооны мэдээний агентлагуудыг тодорхой улс төрийн намд тусалж эсхүл түүнд хор хохирол учруулж ашиг олдог хувь тэрбумтнууд эзэмшдэг; (5) Хэт туйлширсан үзэл бодолтойгоор ярихыг зөвшөөрөх⁸¹ зэргээр хэвлэл мэдээллийн хэрэгслийн сул талуудыг дурдаж болох юм.

Харин (1) Үнэнийг олж гарган, улс төрчдийн халхлан далдалж байсан нууцыг илрүүлж, засгийн газар юуны төлөө ажиллаж байгааг мэдэх боломжийг иргэдэд олгоно; (2) Ямар хууль баглагдаж, юуны талаар маргаан мэтгэлцэж байгаа, улс оронд ямар үйл явдал өрнөж байгаа талаар иргэдийг мэдээлэлтэй байлгана; (3) Улс төрчдөөс сорьсон асуулт асууж, тэдний хариулт үнэний ортой болоход дүгнэлт хийн, тэд хэрхэн амлалтаас биелүүлж байгааг харах боломжийг олон нийтэд олгоно; (4) Сонгуулийн турш кампанит

⁸⁰ Алекс Фрид, Роза Хор, Люэви Хөүл, Улс төр эхлэн суралцагчдад, орч. Ч.Өнөрбаяр, Э.Туулайхүү, Д.Отгонгал, Уб., 2020, 110 дахь тал.

⁸¹ Алекс Фрид, Роза Хор, Люэви Хөүл, Улс төр эхлэн суралцагчдад, орч. Ч.Өнөрбаяр, Э.Туулайхүү, Д.Отгонгал, Уб., 2020, 111 дэх тал.

ажлын амлалтуудыг олон нийтийн сонорт хүргэснээр хүмүүс саналаа өгөхдөө мэдээлэлтэй болсон байна; (5) Улс төрд ямар нэгэн том зүйл болох нь урьд өмнө болж байсан ямар нэгэн зүйлтэй төстэй байх нь цөөнгүй. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь түүхэн давхцлын талаар тайлбарлаж чадах экспертүүдийг авч ирж, бидэнд өнөөгийн нөхцөл байдлыг илүү сайн ойлгоход туслах⁸² зэргийг хэвлэл мэдээллийн хэрэгслийн сайн талд тооцож байна. Ардчилсан нийгмүүдэд дийлэнх хүмүүсийн хувьд сонгуулийн кампаниуд нь мэдээллээр дамжуулагдан мэдрэгдэж байдаг.⁸³ Сонгуулийн кампани дахь мэдээллийн үүрэг, байр суурь нэгэнт тодорхой. Гэвч сонгуулийн мэдээнүүдэд дэвшүүлэгдэж байгаа асуудал, мэдээллийн хэрэгслээр дамжигдсан байдал, санал өгөгчдөд хүртээмжтэй байгаа мэдээллийн хүрээ ба чанар, улс төрийн элитүүд ба олон нийт дэх мэдээллийн үр нөлөө зэрэг улс орнуудад мэдэгдэхүйц ялгаатай байж болно.⁸⁴

Энэ нь нэг талаас улс төрийн аль ч тогтолцоонд засгийн эрх баригчид өөрийн бодлогыг иргэдээр дэмжүүлж, хүлээн зөвшөөрүүлэхийг хичээдэг. Тэд хүн амын ихээхэн хэсэгт зөвхөн сонин хэвлэл, радио, телевиз гэх мэт олон нийтийн мэдээллийн хэрэгслийн тусламжтайгаар хүрэх боломжтой учраас мэдээллийн хэрэгсэл нь төрийн шийдвэр гаргах үйл явцыг олон нийтэд дамжуулахад онцгой чухал үүрэгтэй.⁸⁵ Ялангуяа сонгуулийн үеэр сэтгүүлчид шударгаар ажиллаж, олон түмний өмнө, түүхийн өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлэх шаардлага өндөр байдаг. Зөвхөн баримтад түшиглэсэн үнэн бодит, тэнцвэртэй мэдээлэл л сонгогчдод шийдвэр гаргахад нь тус болдог гэдгийг санах хэрэгтэй.⁸⁶

Нөгөө талаас хэвлэмэл болон цахим, төрийн болон хувийн хэвшлийн мэдээллийн хэрэгсэл нь олон нийтэд сонгуулийн менежментийн байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагаа, ардчилсан сонгуулийн ажиллагааны талаар мэдээлэл өгөхөд гол үүрэг гүйцэтгэх хамтрагч юм.⁸⁷ Хэвлэл мэдээлэлтэй эерэг харилцаа холбоо тогтоох, сонгуультай холбоотой үнэн зөв, бодит мэдээлэл түгээх талаар сонгуулийн менежментийн байгууллага хэвлэл мэдээллийн байгууллагатай харилцах стратеги бодлоготой байх нь чухал юм. Хэрэв сонгуулийн менежментийн байгууллага хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй ил тод нээлттэй харилцаа тогтоохгүй бол сонгуулийн менежментийн байгууллагын үйл ажиллагаанд эргэлзсэн ташаа мэдээлэл хэвлэлд гарах эрсдэлтэй байдаг.⁸⁸ Сонгуулийн менежментийн байгууллагын хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй харилцах (1) хэвлэл мэдээллийн хэрэгсэл, түүний хамрах хүрээг тодорхойлох; (2) хэвлэл мэдээллийн хэрэгсэл мэдээлэл өгөхдөө ил тод, хамтран ажиллах байдлаар хандах; (3) сонгуультай холбоотой мэдээлэл өгөх тодорхой цаг хугацааны хуваарь гаргах; (4) сонгуулийн менежментийн байгууллагын үйл ажиллагааны талаар тууштай, үнэн зөв мэдээлэл өгч чадах хэвлэлийн ажилтнуудыг тодорхойлох гэсэн стратегийн бүрэлдэхүүн хэсгүүдтэй байна.⁸⁹ Үүнээс гадна сонгуулийн менежментийн байгууллага хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй зар сурталчилгаа хэвлүүлэх зэрэг арилжааны

⁸² Алекс Фрид, Роза Хор, Люэви Хөүл, Улс төр эхлэн суралцагчдад, орч. Ч.Өнөрбаяр, Э.Туулайхүү, Д.Отгонгал, Уб., 2020, 110 дахь тал.

⁸³ Лоуренс Делүк, Ричард Ниэми, Пиппа Норрис, Ардчилалуудыг харьцуулахуй: Сонгууль ба санал өгөлт глобал төвшинд, орч. Л.Мөнх – Эрдэнэ, Уб., МУИС–ийн хэвлэл үйлдвэр, 2008, 253 дахь тал.

⁸⁴ Лоуренс Делүк, Ричард Ниэми, Пиппа Норрис, Ардчилалуудыг харьцуулахуй: Сонгууль ба санал өгөлт глобал төвшинд, орч. Л.Мөнх – Эрдэнэ, Уб., МУИС–ийн хэвлэл үйлдвэр, 2008, 253 дахь тал.

⁸⁵ Ардчилсан сонгууль ба хариуцлагатай сэтгүүл зүй, Сэтгүүлчдэд зориулсан гарын авлага, бэлт. Ч.Байгалмаа, М.Ганхүү, Л.Өнөржаргал, Ц.Чимэддондог, Г.Гүнжидмаа, Уб., Соёмбо принтинг, 2012, 20 дахь тал.

⁸⁶ Ардчилсан сонгууль ба хариуцлагатай сэтгүүл зүй, Сэтгүүлчдэд зориулсан гарын авлага, бэлт. Ч.Байгалмаа, М.Ганхүү, Л.Өнөржаргал, Ц.Чимэддондог, Г.Гүнжидмаа, Уб., Соёмбо принтинг, 2012, 22 дахь тал.

⁸⁷ Алан Уолл, Эндрю Эллис, Эйман Айуб, Карл У.Дундас, Жорам Рукамбэ, Сара Стено, Сонгуулийн менежментийн хувилбарууд: Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын институтын гарын авлага, орч., 236 дахь тал.

⁸⁸ Алан Уолл, Эндрю Эллис, Эйман Айуб, Карл У.Дундас, Жорам Рукамбэ, Сара Стено, Сонгуулийн менежментийн хувилбарууд: Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын институтын гарын авлага, орч., 236 дахь тал.

⁸⁹ Алан Уолл, Эндрю Эллис, Эйман Айуб, Карл У.Дундас, Жорам Рукамбэ, Сара Стено, Сонгуулийн менежментийн хувилбарууд: Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын институтын гарын авлага, орч., 236 дахь тал.

асуудлаар хамтран ажиллах шаардлага бас гарна.⁹⁰ Энэ утгаар сонгуулийн үеэр баримтлах зарчмууд бий. Жишээ болгон дурдвал (1) олон эх сурвалж ашигла; (2) өрөөсгөл хандлагаас зайлсхийх; (3) үзэл бодол; (4) бодит, тэнцвэртэй мэдээлэл; (5) төлбөртэй сэтгүүл зүйгээс татгалз гэх мэт.⁹¹

III. ДҮГНЭЛТ, САНАЛ

Сонгуулийн эрх зүйд хамаарах үндэсний хууль тогтоомж, тэдгээрийг хэлэлцэн баталсан тэмдэглэл (хуулийн хувийн хэрэг), практикт тогтсон нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад хэм хэмжээ (заншил гэх мэт) болон олон улсын гэрээ, хэлэлцээр зэрэг нь эрх зүйн антропологийн, тодруулбал сонгуулийн эрх зүйн антропологийн нэн чухал судлагдахуун болох юм. Энэ утгаараа сонгуулийн эрх зүйн антропологи бол эрх зүйн антропологийн бусад төрөлжсөн чиглэлийн нэгэн адил төдийгүй сонгуулийн эрх зүйн антропологи нь эрх зүй судлалын шинжлэх ухааны нэгэн салбар болж байна. Тиймээс антропологийн ухааны онол, арга зүйн үүднээс үндэсний сонгуулийн хууль тогтоомжийг судлах нь “эрх зүйн антропологийг, ялангуяа түүний төрөлжсөн чиглэлүүдийг Монгол Улсад хөгжүүлэх нэн таатай нөхцлийг бүрдүүлэхээс гадна энэ чиглэлийн судалгаануудыг дан ганц эрх зүйн онол, философийн (гүн ухааны) хүрээнд бус харин хууль зүйн хэрэглээ болгох үүднээс салбар эрх зүйгээр нь (объектоор нь) буюу сонгуулийн эрх зүйн антропологи гэх зэргээр төрөлжүүлэн хийх боломжтой байна” гэсэн дүгнэлтэд хүрч байна. Үүн дээр үндэслэлд *сонгуулийн эрх зүйн антропологи гэдгийг энгийнээр “сонгуулийн эрх зүйн болон үндэсний эрх зүйн тогтолцооны талаархи антропологи анализ” гэж тодорхойлж болохоор байна.

Эцэст нь тэмдэглэхэд, сонгуулийн эрх зүйн антропологийн үндсэн (нийтлэг) судлагдахуун нь “сонгох, сонгогдох эрх” гэж үзээд түүнтэй холбогдох “Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтуудыг хэлэлцэн баталсан БНМАУ–ын Бага Хурлын чуулганы болон Ардын Их Хурлын хуралдааны тэмдэглэл”, мөн түүнчлэн “Сонгуулийн хууль тогтоомжийг хэлэлцэн баталсан Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэл” зэргийг угсаатны зүйн онцлог баримт бичгүүд гэдэгт хамруулж үзэж болох юм. Эдгээрт үндэслэлд сонгуулийн эрх зүйн антропологийн судалгааг антропологийн этнографийн аргаар хийж болохоор байна. Ийнхүү судалснаар сонгуулийн эрх зүйд ямар (практик) ач холбогдолтой болох, цаашлаад хууль зүйн шинжлэх ухааны үүднээс анхаарах асуудал зэргийг илүү тодорхой гаргаж ирэх боломжтой гэж үзэж байна.

⁹⁰ Алан Уолл, Эндрю Эллис, Эйман Айуб, Карл У.Дундас, Жорам Рукамбэ, Сара Стено, Сонгуулийн менежментийн хувилбарууд: Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын институтын гарын авлага, орч., 237 дахь тал.

⁹¹ Ардчилсан сонгууль ба хариуцлагатай сэтгүүл зүй, Сэтгүүлчдэд зориулсан гарын авлага, бэлт. Ч.Байгалмаа, М.Ганхүү, Л.Өнөржаргал, Ц.Чимэддондог, Г.Гүнжидмаа, Уб., Соёмбо принтинг, 2012, 23 – 26 дахь тал.

ЭХ СУРВАЛЖ**Монгол хэл дээрх*****Ном, өгүүлэл, судалгааны тайлан***

1. Д.Бум – Очир, Улс төрийн хүн судлалын онолын үүд, Уб., Бемби сан, 2008.
2. Д.Бум – Очир, Нийгэм, соёлын хүн судлалын онолын үүд, Уб., Адмон принтинг, 2012.
3. Э.Булаг, Монгол дахь ястны үзэл ба үндэстний эв нэгдэл, тэдгээрт холбогдох эрх зүйн асуудал, орч. Э.Туулайхүү, Ш.Туяа, Уб., 2020.
4. Г.Мөнх – Эрдэнэ, П.Чулуунбат, Нийгэм, соёлын хүн судлалын удиртгал, Уб., МУИС пресс, 2017..
5. Н.Лүндэндорж, Төрийн онол, нэмж засварласан 4 дэх хэвлэл, Уб., 2020
6. С.Номынбаясгалан, Э.Тамир, “Хэвлэл мэдээллийн эрх зүйн антропологи”, Эрсдэлд суурилсан тогтвортой хөгжил сэдэвт олон улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл, II, Уб., 2023.
7. С.Нарангэрэл, Хууль зүй судлалын англи – монгол тайлбар толь, (English – Mongolian jurisprudence dictionary), Уб., Мөнхийн үсэг, 2005.
8. С.Нарангэрэл, Хууль зүйн англи – монгол эх толь, (English – Mongolian jurisprudence dictionary), Уб., Адмон принтинг, 2012.
9. Б.Чимид, Сонгуульд суралцахуй, (Тогтолцоо, үйл явц, эрх зүй), Уб., Адмон принтинг, 2008.
10. Б.Чимид, Сонгуулийн тогтолцоонд ард түмэн, түүний үндсэн хууль буруутай юу?!, (Үндсэн хуульт ёсны төлөвшил цувралын IV), Уб., Мөнхийн үсэг, 2011.
11. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийг хэлэлцсэн БНМАУ–ын Бага Хурлын чуулганы болон Ардын Их Хурлын хуралдааны тэмдэглэлүүд, (Түүвэр), эмх. С.Номынбаясгалан, Б.Баатарцогт, Э.Тамир, Уб., Адмон принтинг, 2023.
12. Ардчилсан сонгууль ба хариуцлагатай сэтгүүл зүй, Сэтгүүлчдэд зориулсан гарын авлага, бэлт. Ч.Байгалмаа, М.Ганхүү, Л.Өнөржаргал, Ц.Чимэддондог, Г.Гүнжидмаа, Уб., Соёмбо принтинг, 2012.
13. Лоуренс Делүк, Ричард Ниэми, Пиппа Норрис, Ардчилуудыг харьцуулахуй: Сонгууль ба санал өгөлт глобал төвшинд, орч. Л.Мөнх – Эрдэнэ, Уб., МУИС–ийн Хэвлэх үйлдвэр, 2008.

Англи хэл дээрх

1. Фернанда Пирие, Эрх зүйн антропологи, анхны хэвлэл, Оксфорд Университи пресс, 2013.

ХАВСРАЛТ

Хүснэгт – I

/Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтыг хэлэлцсэн байдал⁹²

БНМАУ–ын Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах комиссын өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их цааз (Үндсэн хууль) төсөл /1991.05.25/	БНМАУ–ын Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах комиссын хуралдаанаар хэлэлцээнд БНМАУ–ын Бага Хуралд өргөн барьсан хувь /1991.10.05/
Монгол Улсын Үндсэн хууль /Их цааз/ Хоёрдугаар бүлэг Хүний эрх, эрх чөлөөг илтгэн тунхаглах нь 19 дүгээр зүйл Монгол Улсын иргэд дараахь үндсэн эрхийг баталгаатай эдэлнэ: 12/ иргэд шууд буюу төлөөлсөн байгууллагаараа уламжлан нийгэм, төрийг удирдах хэрэгт чөлөөтэй оролцох эрхтэй. Хуулиар тогтоосон насанд хүрсэн иргэн төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй;	Монгол Улсын Үндсэн хууль /Их цааз/ Хоёрдугаар бүлэг Хүний эрх, эрх чөлөө Арван долдугаар зүйл Монгол Улсын иргэд дараахь үндсэн эрхийг баталгаатай эдэлнэ: 9/ шууд буюу төлөөлсөн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт чөлөөтэй оролцох эрхтэй. Хуулиар тогтоосон насанд хүрсэн иргэн төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг 18 наснаас эдлэх бөгөөд сонгогдож болох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавигдах шаардлагыг харгалзан хуулиар тогтооно;
/Монгол Улсын Үндсэн хуулийг хэлэлцэн баталсан нь /1992.01.13//	
Монгол Улсын Үндсэн хууль Хоёрдугаар бүлэг Хүний эрх, эрх чөлөө Арван зургадугаар зүйл Монгол Улсын иргэд дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ: 9/ шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно;	

⁹² Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийг хэлэлцсэн БНМАУ–ын Бага Хурлын чуулганы болон Ардын Их Хурлын хуралдааны тэмдэглэлүүд, (түүвэр), эмх. С.Номынбаясгалан, Б.Баатарцогт, Э.Тамир, Уб., Адмон принтинг, 2023, 537 – 542 дахь тал

Хүснэгт – 2

/Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтыг хэлэлцсэн БНМАУ–ын Бага Хурлын гишүүд болон холбогдох бусад хүмүүсийн үг хэлсэн байдал/⁹³

Д/д	Гишүүдийн нэр	Монгол Улсын Үндсэн хуулийн “Хүний эрх, эрх чөлөө” гэсэн Хоёрдугаар бүлгийн Арван зургадугаар зүйлийн заалт	Үг хэлсэн давтамж
		9/	
1	Авирмэд Б.,	-	-
2	Авхиа Ж.,	-	-
3	Амарсанаа Ж.,	-	-
4	Баасанжав Д.,	-	-
5	Балдан – Очир Д.,	-	-
6	Барамсай Ж.,	-	-
7	Батмөнх С.,	-	-
8	Батсүх Д.,	-	-
9	Баттулга Д.,	-	-
10	Баяр С.,	-	-
11	Баярцогт С.,	-	-
12	Болат А.,	-	-
13	Бямбажав Ж.,	-	-
14	Бямбацэрэн Н.,	-	-
15	Галсан Т.,	-	-
16	Галсандорж Б.,	-	-
17	Ганбаатар .,	-	-
18	Ганбаяр Н.,	-	-
19	Ганболд Д.,	-	-
20	Гантөмөр Т.,	-	-
21	Ганхуяг Ө.,	-	-
22	Гончигдорж Р.,	5	5
23	Дагвадорж Б.,	-	-
24	Дэндэв Г.,	-	-
25	Зориг С.,	-	-
26	Зуунай Г.,	-	-
27	Жанцан Н.,	-	-
28	Ламжав Д.,	2	2
29	Лүндээжанцан Д.,	-	-
30	Лхагважав Гү.,	1	1
31	Лханаасүрэн Б.,	-	-
32	Одончимэд Л.,	-	-
33	Очиржав О.,	-	-
34	Очирхүү Т.,	-	-

93 Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийг хэлэлцсэн БНМАУ–ын Бага Хурлын чуулганы болон Ардын Их Хурлын хуралдааны тэмдэглэлүүд, (түүвэр), эмх. С.Номынбаясгалан, Б.Баатарцогт, Э.Тамир, Уб., Адмон принтинг, 2023, 543 – 544 дэх тал

35	Өөлд Ц.,	-	-
36	Пүрэв Д.,	-	-
37	Пүрэвдагва Х.,	-	-
38	Пүрэвдорж Ч.,	-	-
39	Пүрэвжав.,	-	-
40	Самат Н.,	1	1
41	Сандуйжав Б.,	-	-
42	Сумьяа Б.,	-	-
43	Товуусүрэн Ц.,	-	-
44	Төмөр С.,	1	1
45	Төмөрбаатар Г.,	-	-
46	Улаанхүү П.,	-	-
47	Уртнасан Ж.,	-	-
48	Хатанбаатар Р.,	-	-
49	Цог Л.,	-	-
50	Цогт – Очир Л.,	1	1
51	Цэндбаяр Ш.,	-	-
52	Цэрэндагва Ч.,	2	2
53	Чилхаажав Д.,	-	-
54	Чимид Б.,	10	10
55	Чулуун Д.,	-	-
56	Чулуунбаатар С.,	-	-
57	Шагдарсүрэн Ш.,	8	8
58	Элбэгдорж Ц.,	-	-
59	Энхбаатар Д.,	-	-
60	Энхсайхан М.,	-	-
		31	31

/Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтыг хэлэлцсэн БНМАУ–ын Ардын Их Хурлын депутатуудын үг хэлсэн байдал/⁹⁴

Д/д	Гишүүдийн нэрс	Монгол Улсын Үндсэн хуулийн “Хүний эрх, эрх чөлөө” гэсэн Хоёрдугаар бүлгийн Арван зургадугаар зүйлийн заалт	Үг хэлсэн давтамж
		9/	
1	Аварзэд Ү.,	-	-
2	Авхиа Ж.,	-	-
3	Адъяа М.,	-	-
4	Алгаа.,	-	-
5	Алтангэрэл Э.,	-	-
6	Амарбаян.,	-	-
7	Анигар.,	-	-
8	Баарин.,	-	-
9	Баасанжав Д.,	-	-
10	Бадам Ш.,	-	-
11	Бадарч.,	-	-
12	Балдан – Очир Д.,	-	-
13	Банди Б.,	-	-
14	Барамсай Ж.,	-	-
15	Барсболд Р.,	-	-
16	Батбаяр.,	-	-
17	Батжаргал.,	-	-
18	Батмөнх С.,	-	-
19	Батсайхан Б.,	-	-
20	Батсүх С.,	-	-
21	Баттулга Д.,	-	-
22	Бат – Үүл С.,	4	4
23	Баяндалай Л.,	-	-
24	Баянмөнх Б.,	-	-
25	Баяншагай.,	-	-
26	Баяр С.,	-	-
27	Баярцогт С.,	-	-
28	Баярцэнгэл Д.,	-	-
29	Билэгсайхан С.,	-	-
30	Болат А.,	-	-
31	Болд Л.,	-	-
32	Буяндэлгэр Б.,	-	-
33	Бямбаа Ж.,	-	-
34	Бямбажав Х.,	-	-
35	Вандандагва Г.,	-	-

94 Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийг хэлэлцсэн БНМАУ–ын Бага Хурлын чуулганы болон Ардын Их Хурлын хуралдааны тэмдэглэлүүд, (түүвэр), эмх. С.Номынбаясгалан, Б.Баатарцогт, Э.Тамир, Уб., Адмон принтинг, 2023, 545 – 548 дахь тал.

36	Галсан Т.,	-	-
37	Галсандорж Б.,	-	-
38	Ганболд Г.,	-	-
39	Ганболд Д.,	-	-
40	Ганзориг П.,	-	-
41	Гантөмөр Д.,	-	-
42	Ганхуяг Ө.,	-	-
43	Гаравсүрэн Н.,	-	-
44	Гарамжав Д.,	-	-
45	Гомбо.,	-	-
46	Гомбожав.,	-	-
47	Гомбосүрэн.,	-	-
48	Гончиг С.,	-	-
49	Гончигдорж Р.,	-	-
50	Гүнджалам.,	-	-
51	Гүрбазар Ш.,	-	-
52	Даваажид Ц.,	-	-
53	Дагвадорж Б.,	-	-
54	Дамдин.,	-	-
55	Дамдинсүрэн Л.,	-	-
56	Данаа Х.,	-	-
57	Даргахуу Ж.,	-	-
58	Даш.,	-	-
59	Дашбалбар О.,	-	-
60	Дашням Л.,	-	-
61	Дүйсинсанги Л.,	-	-
62	Дэмбэрэлиням Ч.,	-	-
63	Дэмид Д.,	-	-
64	Дэндэв Г.,	-	-
65	Зардыхан К.,	-	-
66	Зарыккан Д.,	-	-
67	Зориг С.,	-	-
68	Зуунай Г.,	-	-
69	Жамсран М.,	-	-
70	Жанцан Н.,	-	-
71	Жанжаадорж З.,	-	-
72	Ламжав Д.,	-	-
73	Лантуу Л.,	-	-
74	Лоохууз Ц.,	-	-
75	Лүндээжанцан Д.,	-	-
76	Лхагвадорж Д.,	-	-
77	Лхагвасүрэн Д.,	-	-
78	Лхагвасүрэн С.,	-	-
79	Лханаасүрэн Б.,	1	1
80	Мандах Д.,	-	-
81	Марав Д.,	-	-

82	Мизамхан К.,	-	-
83	Моголцог Е.,	-	-
84	Мөнгөн Б.,	-	-
85	Мөнхөө Д.,	-	-
86	Найдан.,	-	-
87	Намсрай Ч.,	-	-
88	Норовсамбуу Ж.,	-	-
89	Нямбуу Б.,	-	-
90	Нямдаваа.,	-	-
91	Одончимэд Л.,	-	-
92	Оросоо Ж.,	-	-
93	Осор Б.,	-	-
94	Очирбат Г.,	-	-
95	Очирбат Р.,	-	-
96	Очирхүү Т.,	-	-
97	Өөлд Ц.,	-	-
98	Пүрэв Д.,	-	-
99	Пүрэвдагва Х.,	-	-
100	Пүрэвдорж Д.,	-	-
101	Пүрэвжав.,	-	-
102	Рэнцэннацаг Д.,	-	-
103	Сайраан.,	-	-
104	Самат Н.,	-	-
105	Сандуйжав Б.,	1	1
106	Содном.,	-	-
107	Сумьяа Б.,	-	-
108	Сүрэнхорлоо Д.,	-	-
109	Төмөрбаатар Г.,	-	-
110	Улаанхүү П.,	-	-
111	Уртнасан Ж.,	14	14
112	Хаадгар П.,	-	-
113	Харжаубай С.,	-	-
114	Хатанбаатар Р.,	-	-
115	Хашбаатар Г.,	-	-
116	Хишигдалай Ч.,	-	-
117	Цог Л.,	-	-
118	Цогтбаяр Д.,	-	-
119	Цогт – Очир Н.,	-	-
120	Цэндбаяр Ш.,	4	4
121	Цэрэндагва Ч.,	-	-
122	Чагнаа Н.,	-	-
123	Чимид Б.,	7	7
124	Чинбат Ч.,	-	-
125	Чойжамц.,	-	-
126	Чойжилсүрэн.,	-	-
127	Чулуун Д.,	-	-

128	Чулуунбаатар С.,	-	-
129	Чунагсүрэн Ж.,	-	-
130	Шагдарсүрэн Ш.,	-	-
131	Шоовдор Ж.,	-	-
132	Элдэв – Очир Б.,	-	-
133	Элбэгдорж Ц.,	-	-
134	Энхсайхан М.,	-	-
135	Ядамсүрэн Т.,	-	-

WHAT IS THE ANTHROPOLOGY OF ELECTORAL LAW?

Nomynbayasgalan.S

*Senior researcher of Mongolian
Criminological Society (BBA),
Ph.D. Student, School of Arts and Sciences,
NUM,
Ph.D. Student, School of Law, NUM*

Tamir.E

*Researcher of Mongolian Criminological
(LL.B)
Chief Operating Officer (COO) of “www.
urug.mn” of “Word Media” LLC*

ABSTRACT:

The article 16 (Citizen’s rights) of the Constitution of Mongolia says that “The right to take part in the government of the country directly or through representative bodies. The right to elect and to be elected to State bodies. The right to elect is enjoyed from the age of eighteen years and the age eligible for being elected is determined by law according to the requirements in respect of the bodies or posts concerned”. The article is named as the “What is the anthropology of Electoral law” and its content is conducted within legal issues on the anthropology. What is a “The anthropology of Electoral law” and what is contained in this concept; it is an eternal subject of jurisprudence. And the aim of this is to introduce this eternal topic to the Mongolian lawyers. Anthropology is an empirically – grounded discipline. Its material is observed in the real world, typically through long – term, focused participant observation. This esearch paper will certainly contribute to the development of the legal anthropological studies.

KEYWORDS:

Parliamentary election, presidential election, citizen representative’s hural election, anthropology, political anthropology, anthropology of law (legal anthropology), social and cultural anthropology, electoral law (election law).

ХҮҮХЭД ҮРЧЛЭЛТИЙГ ХҮЧИНГҮЙД ТООЦОХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ ХАРЬЦУУЛАН СУДЛАХ НЬ



А.Батбаатар
ИЗОУИС-ийн багш, докторант

ТОВЧЛОЛ:

Байгалийн жам ёсоор хүүхэдтэй болж чадахгүй тохиолдолд эрх зүйн арга хэрэгслийн тусламжтайгаар хүүхэдтэй болж байгаа нь хүүхэд үрчлэлтийн эрх зүйн зохицуулалтын онцлог давуу тал болно. Гэсэн хэдий ч үрчлэн авсан хүүхдээ нийгмийн янз бүрийн шалтгааны улмаас буцаах, үрчлэлтийг хүчингүйд тооцох зэрэг сөрөг асуудлууд ихээр гарсаар байна. Энэ нь үрчлэгдсэн хүүхдийн эрх ашиг сонирхлыг хангаж, хамгаалж чадаж байгаа эсэх нь дэлхий нийтийн өмнө тулгамдаж буй асуудлын нэг болсон. Иймд Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенц болон гадаад улс орнуудын үрчлэлтийг хүчингүйд тооцох зохицуулалтыг Монгол Улсын хүүхэд үрчлэлтийг хүчингүйд тооцох зохицуулалттай харьцуулан судалж гадаад улс оронд үрчлэгдсэн хүүхдийн эрх зөрчигдсөн тохиолдолд хүүхдийг буцаах, үрчлэлтийг хүчингүйд тооцоход нөлөөлж буй шалтгаан үндэслэлийг харьцуулан судлахын зэрэгцээ шүүхийн шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийх замаар тодруулах, практикт тулгамдсан асуудлыг нээн илрүүлэх, зөрчлийг арилгахтай холбоотой санал, дүгнэлт дэвшүүлсэн болно.

ТҮЛХҮҮР ҮГС:

Хүүхэд үрчлэлт, үрчлэгч, үрчлүүлэгч, үрчлэгдэгч, үрчлэлтийг хүчингүйд тооцох Гаагийн конвенц, Хүүхдийн эрхийн конвенц

УДИРТГАЛ

Сэдэв сонгон судлах болсон үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 11-д “Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална”¹ гэж заасан. Уг зохицуулалтын хүрээнд Монгол Улс нь Үндсэн хуулиар хүлээсэн үүргийнхээ дагуу дараах конвенцуудад нэгдэн орсон байдаг. Үүнд:

- Хүүхдийн эрхийн тухай конвенц²
- Хүүхдийг хамгаалах ба улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай

Гаагийн конвенц³ /цаашид Гаагийн конвенц гэх/

1 “Төрийн мэдээлэл” тусгай дугаар сэтгүүл, 1992, №1.

2 “Төрийн мэдээлэл” тусгай дугаар, 1-р боть, 2004.

3 Мөн тэнд, 1-р боть 2004.

• Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенц⁴

Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж заасан.⁵ Улмаар дээрх конвенцуудаар хүлээсэн үүргийнхээ дагуу Гэр бүлийн тухай хуулийг шинэчлэн баталсан хэдий ч үрчлэгдсэн хүүхдийн эрх, ашиг сонирхлыг бодитоор хамгаалж чадахгүй байгаа нь дараах зохицуулалт байхгүйтэй шууд холбоотой болно. Үүнд:

Дотоод үрчлэлтийн механизм, үрчлэн авагч эцэг эхэд тавигдах шалгуур, үрчлэгчийн гэр бүлд судалгаа хийх, хараат бус дүгнэлт гаргах нийгмийн ажлын үйлчилгээ, үрчлэгчдийг сургалтад хамруулах, үрчлэгдсэн хүүхдийн байдалд хяналт тавьж үнэлгээ хийх зохицуулалт байхгүй нь улмаас шийдвэрлэвэл зохих дараах асуудлууд тулгарч байна. Үүнд:

➢ Үрчлэлтийг хүчингүйд тооцох хуулийн зохицуулалт нь практикт үүсээд байгаа асуудлыг шийдвэрлэдэггүй.

➢ Шүүхийн шийдвэрийн цахим сангаас үрчлэлтийг хүчингүйд тооцсон шийдвэрүүдийн талаарх тоон мэдээлэл, судалгаа тусад нь гаргадаггүй.

➢ Үрчлэлтийг хүчингүйд тооцуулсан этгээд ахин хүүхэд үрчлэн авч байгаа эсэхийг хянах механизм бүртгэл байхгүй байна.

Иймд дээрх асуудлуудын шалтгаан нөхцөлийг тогтоох, үрчлэлтийн хүчингүйд тооцох зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлыг онол, практикийн түвшинд нарийвчлан судлах зорилгоор уг сэдвийг сонгон авсан болно.

Судалгааны ажлын шинэлэг тал

• Олон улсын болон гадаадын зарим улс орнуудын хүүхэд үрчлэлтийг хүчингүйд тооцох зохицуулалтыг харьцуулан судлах

• Хүүхэд үрчлэлтийг хүчингүйд тооцсон шүүхийн шийдвэрүүдийн хууль зүйн үндэслэлийг судалж, практикт тулгамдаж буй асуудлыг нээн илрүүлж, судалгаанд үндэслэн өөрийн санал, дүгнэлтийг дэвшүүлэх

Судалгааны ажлын ач холбогдол

Энэхүү судалгааны ажлын хүрээнд хүүхэд үрчлэлт түүнийг хүчингүйд тооцохтой холбогдох харилцаа, олон улсын гэрээ болон гадаадын зарим улс орнуудын хууль тогтоомжийн онцлог, ач холбогдол, үндэсний эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судалж, судалгааны үр дүнд үндэслэн хүүхэд үрчлэлтийг хүчингүй болгохтой холбогдсон санал боловсруулж, эрдэм шинжилгээний бүтээл хэвлүүлэн, Гэр бүлийн эрх зүйн шинжлэх ухаанд өөрийн зохих хувь нэмэр оруулахыг зорьсон болно.

• Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжуудын хэрэгжилтэд судалж санал дүгнэлт гаргах

• Хүүхэд үрчлэлтийг хүчингүйд тооцсон шүүхийн шийдвэрүүдийн хууль зүйн үндэслэлийг судалж, дүн шинжилгээ хийх замаар түүнд нөлөөлж буй шалтгаан нөхцөлийг арилгах талаар санал боловсруулах замаар үрчлэгдсэн хүүхдийн эрхийг хангах

• Олон улсын болон гадаадын зарим улс орнуудын хүүхэд үрчлэлтийг хүчингүйд тооцох зохицуулалтыг харьцуулан судлах замаар оновчтой зохицуулалтыг бий болгох

Судлагдсан байдал:

Судлаач: Ч.Адьяасүрэн⁶ өөрийн бүтээлдээ хүүхэд үрчлэх зан үйлийг Монгол ёс заншлын талаас нь тодорхой тайлбарласан байна. Эрх зүйн чиглэлээр Доктор, профессор

⁴ Мөн тэнд, 1-р боть 2004.

⁵ “Төрийн мэдээлэл” тусгай дугаар сэтгүүл, 1992, №1.

⁶ Ч. Адьяасүрэн, Монгол ёс заншлын их тайлбар толь, Уб., 1992.

Т. Мөнхжаргал⁷, судлаач А.Дугармаа, ⁸Ц.Алтанцэцэг⁹, Ч. Отгонбаяр¹⁰ нар нь өөрсдийн бүтээлдээ хүүхэд үрчлэлтийн өнөөгийн эрх зүйн зохицуулалтыг сурах бичиг талаас нь тайлбарлаж бичсэн байна.

Гадаад хэл дээрх ном сурах бичгийн хувьд:

Barbara A.Moe ¹¹- Дэлхийн улс орнуудын үрчлэлтийн эрх зүйн зохицуулалтуудыг түүхчлэн авч үзсэн. Тухайлбал: Үрчлэлтийн түүхэнд чухал байр суурь эзлэх үрчлэлттэй холбоотой анхны хууль, тогтоомжууд, үрчлэлтийн анхны агентлаг, анхны үрчлэлтийн гэрээ, анхны гадаад үрчлэлт, анхны зуучлалын байгууллагуудын үүсгэн байгуулагдсан түүх, олон улсын гэрээ хүртэлх огноо цагийн хэлхээсийн талаар судлан үзсэн бүтээл болно.

Керри О'Халлоран¹² Хүүхэд үрчлэлтийг эрх зүйн бүлээр болон тивээр нь үрчлэлтийн хөгжилд нөлөө үзүүлэгч голлох 15 улсын уламжлалаас авхуулан олон улсын эрх зүйн хэтийн төлөв, цаашдын чиг хандлага талаас нь цогц байдлаар бичсэн судалгааны томоохон бүтээл байна.

Монгол улсад хүүхэд үрчлэлтийг хүчингүйд тооцсон эрдэм шинжилгээ судалгааны нэг сэдэвт бүтээл байхгүй болно.

2.1 Хүүхэд үрчлэлтийн тухай ойлголт

Онолын хувьд авч үзвэл үрчлэлтийн хэлбэрийг гадаад, дотоод үрчлэлт гэж ангилах бөгөөд дотоод үрчлэлт гэдэг нь хүүхэд төрсөн улсдаа үрчлэгдэхийг хэлэх бөгөөд иргэний харьяалаас үл хамааран өөр улсад амьдарч буй гэр бүл, ганц бие хүнд үрчлүүлэхийг гадаад үрчлэлт буюу улс хоорондын үрчлэлт гэж үздэг байна.¹³

Үүнээс үзвэл хүүхэд үрчлэлт гэдэг нь асрамжлах хүнгүй хүүхдийг өсгөж хүмүүжүүлэх, тэжээн тэтгэхийг хүссэн хүний хүсэл зоригийн илэрхийлэл хэмээн үзэж болох юм.

Энэ талаар доктор, Ж.Амарсанаа “...Үрчлэгдсэн хүүхэд болон үрчилж авсан эцэг, эх хоёрын хооронд төрсөн эцэг, эхийнхтэй адил эрх, үүрэг, хариуцлага үүсгэж буй харилцаа¹⁴..., судлаач Ц.Алтанцэцэг “...Бусдын хүүхдийг өсгөж хүмүүжүүлэх, тэжээн тэтгэхээр гэр бүлдээ авч үрчлэгдсэн хүүхэд үрчлэгчийн хооронд төрсөн эцэг, эх хүүхдийн нэгэн адил эрх, үүрэг үүсэж байгаа үйл явц¹⁵,...” судлаач А.Дугармаа “... Бусдын хүүхдийг өөрийн хүүхэд болгон өсгөж хүмүүжүүлэх явцад үрчлүүлэгч, үрчлэгдэгч, үрчлэгчийн хооронд эд хөрөнгийн ба амин хувийн шинжийг агуулсан эрх зүйн тодорхой төрлийн харилцаа¹⁶...” гэж тус тус тодорхойлсон байдаг. Үрчлэлт-“Хүний эрх, тэр дундаа өөрийгөө хамгаалах чадваргүй эмзэг хүүхдийн эрхийн асуудал хөндөгддөг учраас маш нарийн хяналт, зохицуулалт дор явагддаг гэж үзсэн”.¹⁷

Монгол хэлний тайлбарт толь бичигт хүүхэд үрчлэлтийг“...Хүүхэд үрчлэх нь нь бусдын хүүхдийг өөрийн болгон тэжээх, үрчлүүлэх нь үрчлэхийн үйлдүүлэх хэв маяг¹⁸ ...”, Монгол ёс заншлын тайлбар толь бичигт “...Өөр айлаас хүүхэд өргөн авч өөрийн хүүхдийн нэгэн адил өсгөн хүмүүжүүлж, өөрийн овгоор овоглох нарийн зан үйл” хэмээн¹⁹ тайлбарласан байдаг.

⁷ Т. Мөнхжаргал, Гэр бүлийн эрх зүй, Уб., 2005.

⁸ А.Дугармаа, Монгол Улсын гэр бүлийн эрх зүй, Уб., 2017.

⁹ Ц.Алтанцэцэг, Гэр бүлийн эрх зүй, Уб., 2011.

¹⁰ Ч. Отгонбаяр, Монгол Улсын Гэр бүлийн эрх зүй, Уб., 2007.

¹¹ Barbara A.Moe, Contemporary world issues :Adoption, 2007.

¹² Kerry O'Halloran, The Politics of AdoptionInternational Perspectives on Law, Policy and Practice Fourth Edition, 2021.

¹³ “Үрчлэлт ба Хүүхдийн эрх”, ХЭҮК-ийн Хүний эрхийн цуврал нийтлэл (2014), 75 дахь тал.

¹⁴ Ж.Амарсанаа, Хүүхдийн эрхийн нэр томъёоны товч тайлбар толь, Уб., 2001, 49 дэх тал.

¹⁵ Ц.Алтанцэцэг, Монгол Улсын Гэр бүлийн эрх зүй Уб., 2007, 107 дахь тал.

¹⁶ А.Дугармаа, Монгол Улсын гэр бүлийн эрх зүй, Уб., 2005, 89 дахь тал.

¹⁷ “Үрчлэлт ба Хүүхдийн эрх”, ХЭҮК-ийн Хүний эрхийн цуврал нийтлэл 2014, 75 дахь тал.

¹⁸ Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, Уб., 2000, 62 дахь тал.

¹⁹ Ч.Арьяасүрэн, Монгол ёс заншлын их тайлбар толь, Уб., 2000, 234 дэх тал.

Гадаадын зарим улс орны судалгааны бүтээлээс үзэхэд: “...Хүүхдийг хууль ёсны дагуу өөрийн асрамжид авах үйлдэл²⁰...”, “...Хүүхдийн төрсөн эцэг эхээс тусдаа хүүхэд болон үрчлэгч эцэг эхийн хооронд эрх зүйн харилцаа тогтоох үүсгэх замаар хүүхдийг өсгөн хүмүүжүүлэх үүргийг томилогдсон насанд хүрсэн хүнд даатгах үйлдэл, үйл явц...”²¹, “...Сайн дурын үндсэн дээр (бусад эцэг эхийн хүүхдийг) өөрийн хүүхэд болгон авах үйл явц...”²² “...Бодит байдал дээр эсвэл хууль ёсны дагуу хүүхэд нь биш хүний эцэг эх болох үйлдэл...”²³ үрчлэлтийг дараах байдлаар тодорхойлсон байна.

Энэ талаар ОХУ-ын судлаач Садева “...Гэр бүлийн эрх зүйн нэг бүрэлдэхүүн болох хүүхэд үрчлэлтийн институтыг улам боловсронгуй болгох нэрээр эцэг, эхийн асрамжгүй үлдсэн хүүхдийн хувь заяаг шийдвэрлэх үндсэн арга гэдгийг илүү тодотгох шаардлага байна”²⁴, Судлаач J. F. A. Stockdale Sir William Houghton нар “...Хүүхэд болон хүүхдийн төрөлхийн эцэг эх биш хүмүүсийн хооронд эцэг эх, хүүхдийнхтэй адил зохиомол гэр бүлийн харилцааг бий болгох хууль ёсны арга мөн...”²⁵ гэж тус тус бичжээ.

2.2. Олон улсын болон гадаадын зарим улс орнуудын үрчлэлтийг хүчингүйд тооцох эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлах нь

А. Олон улсын эрх зүйн зохицуулалт.

Хүүхдийг хамгаалах ба улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай Гаагийн конвенцод өнөөгийн байдлаар дэлхийн 109 орон хэлэлцэн тохирч гарын үсэг зурж, 105 орон соёрхон баталсан буюу нэгдэн орсон байна.²⁶ Уг конвенцод улс бүр хүүхдийг өөрийн төрөлх улс орны гэр бүлийн асрамжид байх боломжийг бүрдүүлэх талаар зохих арга хэмжээг тэргүүн зэрэгт тавьж ажиллах шаардлагатайг онцлон тодорхойлж, харин өөрийн төрөлх улс оронд тохиромжтой гэр бүл олдохгүй байгаа нөхцөлд хүүхдийг байнгын гэр бүлийн давуутай талыг олгох үүднээс улс хооронд үрчлэх үрчлэлтийн систем байж болохыг хүлээн зөвшөөрсөн нь конвенцын хэрэгжилтийг хангахад чухал алхам болсон. Гаагийн конвенцод Монгол Улс нь нэгдэн орсон учир хүүхэд үрчлэлттэй холбоотой бүхий л хууль, журам конвенцод нийцсэн байх зүй ёсны шаардлага үүссэн. Энэ үүднээс сэдвийн хүрээ, хязгаарт багтааж Гаагийн конвенциор хүүхдийг буцаах, үрчлэлтийг хүчингүйд тооцохтой холбогдсон зохицуулалтыг авч үзвэл.

Гаагийн конвенцын 21 дугаар зүйлийн 1-д “Хүлээн авагч улсад хүүхдийг шилжүүлсний дараа түүнийг үрчлэн авах эцэг эхийн хамт цаашид байлгахад хүүхдийн ашиг сонирхолд нийцэхгүй гэдгийг эрх бүхий төв байгууллагад мэдэгдвэл тухайн байгууллага хүүхдийг хамгаалах дараах арга хэмжээг авна”. Үүнд:

- Үрчлэн авах хүсэлт гаргасан эцэг эхээс хүүхдийг буцаан авч, түр асрамжид өгөх
- Хүүхдийн төрөлх улсын эрх бүхий төв байгууллагатай зөвшилцөн, хүүхдийг үрчлүүлэх үүднээс цаг алдалгүй шинээр шилжүүлэн суурьшуулах бөгөөд хэрэв энэ арга хэмжээ тохиромжгүй бол урт хугацааны асрамжид өгнө. Хүүхдийн төрсөн улсын эрх бүхий төв байгууллага үрчлэн авах шинэ эцэг эхийн талаар бүрэн мэдээлэл авах хүртэл хүүхдийг үрчлүүлэхгүй.

- Хүүхдийн ашиг сонирхол шаардвал эцэст нь түүнийг буцаах арга хэмжээ авна²⁷ гэж заасан байна.

²⁰ Кэмбрижийн толь бичиг тодорхойлолт.

²¹ Dictionary.com.

²² Webster's Dictionary of English Usage p.15.

²³ <https://www.britannica.com/>.

²⁴ Садева Гузель Миназымовна, *Некоторые вопросы совершенствования законодательного регулирования и применения условий усыновления в России* “Вестник Саратовской государственной юридической академии, область наук право”, 2015, с-75-81.

²⁵ Departmental Committee on the Adoption of Children Judge F. A. Stockdale Sir William Houghton 21 July 1969 HMSO, 1972 (Cmnd. 5107) 24.

²⁶ Statute of the Hague Conference on Private International Law <https://www.hcch.net/en/instruments/conventions/status-table/>

²⁷ Монгол Улсын нэгдэн орсон конвенц, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээний эмхэтгэл”, УБ, 2020, 91 дэх тал.

Б. Гадаадын зарим улс орны эрх зүйн зохицуулалт.

Судалгаанаас үзэхэд гадаадад хамгийн олон хүүхэд үрчлүүлсэн улсуудын жагсаалтыг БНХАУ, ОХУ, Этиоп²⁸ зэрэг улс орнууд тэргүүлж байна. Харин Монгол Улсын хувьд АНУ, ХБНГУ, ХБНФУ, БНИУ²⁹-руу хамгийн их үрчлэлт хийсэн байна. Иймд судалгааны ажлын сэдвийн хүрээнд АНУ, ХБНГУ, ХБНФУ, БНИУ, БНХАУ-ын хүүхэд үрчлэлтийг хүчингүйд тооцсон эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судаллаа.

Б.1 БНФУ-ын үрчлэлтийг хүчингүйд тооцох зохицуулалт

БНФУ-д үрчлэлтийн асуудлыг үрчлэлтийн төв байгууллага (Autorité Centrale pour l'Adoption Internationale эсвэл AFA) зохицуулдаг бөгөөд БНФУ-ын болон олон улсын хууль тогтоомжийн аль алинд нь захирагддаг. Хүүхэд үрчилж дууссаны дараа энэ нь эргэлт буцалтгүй бөгөөд эцсийн байх зорилготой гэдгийг олон улс орнууд илэрхийлсэн байдаг. Иймд залилан мэхлэхтэй холбоотой (эсвэл түүний хууль ёсны байдлыг алдагдуулсан хууль бус үйлдэл) үндэслэлээс бусад тохиолдолд үрчлэлтийг хүчингүй болгох нь зөвхөн онцгой нөхцөл байдалд боломжтой. БНФУ-ын эрх зүйн зохицуулалтад үрчлэлтийг хүчингүй болгох үндэслэл байгаа бол түүнийг хэрэгжүүлэх үйл явц нь тухайн хэргийн тодорхой нөхцөл байдлаас шалтгаалж өөр өөр байна. Энэ нь үрчлэлтийг хүчингүй болгох нь зөвхөн шүүхээр шийдэгдэх асуудал бөгөөд үрчлэлт нь хүүхдийн ашиг сонирхолд нийцээгүй болохыг нотлох баримт шаардана. БЭФУ-ын хуулийн дагуу үрчлэлтийг хүчингүй болгох хэд хэдэн үндэслэл байдаг бөгөөд Үүнд:

- Үрчлэх нь хүүхдийн эрх ашигт нийцээгүй
- Үрчилж авсан эцэг эх нь хүүхдэд зохих ёсоор анхаарал халамж тавьж, дэмжлэг үзүүлж чадаагүй
- Үрчилж авсан эцэг, эх нь үрчлэлтийн нөхцөлийг зөрчсөн буюу хүүхдийн эрхийг зөрчсөн
- Хууран мэхлэлт эсвэл албадлагаар үрчлүүлсэн³⁰

Б.2 ХБНГУ-д үрчлэлтийг хүчингүйд тооцох зохицуулалт

ХБНГУ-д үрчлэх тухай тушаал нь онолын хувьд байнгын бөгөөд эргэлт буцалтгүй байдаг. Гэсэн хэдий ч үрчлэлт нь анхнаасаа хууль зүйн хувьд алдаатай байсан бол үүнийг хүчингүй болгож болно. Тухайлбал: Зөвшөөрлийн мэдүүлгийг буруугаар, дарамт шахалт дор эсвэл талуудын аль нэгнийх нь эрх зүйн чадамжгүйн улмаас гаргасан бол³¹ тухайн алдааг засаагүй бол хүүхдийн сайн сайхны эрх ашгийг ноцтойгоор хохироохгүй байх нөхцөлийг бүрдүүлэн цуцлах бөгөөд үрчлэлтийн зарлиг гарснаас хойш гурван жилийн дотор хохирогч тал гомдол гаргах үүрэгтэй. ХБНГУ-д үрчлэлтийн тушаалын онцгой шинж чанар нь гэр бүлийн шүүх уг захирамжийг өөрийн үзэмжээр оролцогч талуудын аль нэгний санаачилгагүйгээр хүчингүй болгож болно.³² Үрчлэлтийн тушаал нь хосуудын талд гарсан бол зөвхөн аль нэгнийх нь хувьд хүчингүй болгож болно. Үрчлэгдэгч хүүхдийн гэрлээгүй эцэг шүүхийн шийдвэр гарахаас өмнө шүүхээр хэлэлцүүлэх үндсэн эрх нь зөрчигдсөнийг нотлох баримттай гэх мэт тохиолдолд хүчингүйд тооцно.³³ Хүчингүй болгох нөхцөл нь төрсөн эцэг эх нь хүүхдээ асран хамгаалахад бэлэн, боломжтой байх эсвэл хүчингүй болгох зорилго нь шинээр үрчлүүлэхийг зөвшөөрөх юм.³⁴ Хүчингүй болгосны үр дагавар нь: хүчингүй болгох хүртэл үрчлэлтийн хууль зүйн үр дагаврыг

²⁸ Statute of the Hague Conference on Private International Law <https://www.hcch.net/en/instruments/conventions/status-table/>

²⁹ ГИХАЭА-ны тайлан. 2022, V6.

³⁰ Dispositions générales (Articles 341 à 348) https://www.legifrance.gouv.fr/codes/article_lc/LEGIARTI000034747019?init=true&page=1&query=343&searchField=ALL&tab_selection=all

³¹ The Civil Code, 1759.

³² Мөн тэнд, 1763(1).

³³ The Federal Constitution, Basic Law, Article 103.

³⁴ The Civil Code, 1763(3).

хэвээр үлдээх үүрэгтэй. Үүний дараа хүүхэд болон тэдний төрсөн гэр бүлийн хоорондын харилцааг сэргээхийн зэрэгцээ үрчлэн авагчид болон тэдний гэр бүлтэй хууль ёсны бүх харилцааг таслах.³⁵ Төрсөн эцэг эхийн зөвшөөрөл шаардлагатай боловч хүүхэд төрснөөс хойш 8 долоо хоногоос доошгүй хугацаанд зөвшөөрөгдсөн тохиолдолд л хууль ёсоор хүчин төгөлдөр байна. Харин гэрлээгүй эцгийн зөвшөөрөл нь төрөхөөс өмнө өгсөн байсан ч хүчинтэй. Зөвшөөрөл ихэвчлэн ирээдүйн үрчлэн авагчдын хувийн мэдээллийг задруулахгүйгээр олгогддог боловч энэ нь тодорхой хүн эсвэл хосуудад хамаарах ёстой. Эцэг эхийн зөвшөөрөл авах боломжгүй дараах тохиолдол байна. Үүнд: Хүүхдийн эцэг эх нэрээ нууцалсан, (Vertrauliche Geburt), эцэг эхийн зан үйлийн улмаас зөвшөөрөл олгох эрх нь хасагдсан гэх мэт тохиолдолд боломжгүй болно.

Төрсөн эцэг, эх нь нас барсан, сэтгэцийн өвчтэй болсон, эсвэл хаана байгаа нь тодорхойгүй бол шүүх тэдний зөвшөөрлийг үгүйсгэж болно.³⁶ Хүүхдийг хүчирхийлсэн, хайхрамжгүй хандсан, хаясан, нэг жилээс дээш хугацаанд санхүүгийн дэмжлэг үзүүлээгүй зэрэг хэргээр шийтгэгдсэний дараа төрсөн эцэг, эхийн асран хамгаалах эрх нь дуусгавар болсон тохиолдолд үүнийг хийж болно.³⁷ Түүнчлэн, төрсөн эцэг эх нь хүүхдийнхээ сайн сайхан байдалд хайхрамжгүй хандсан боловч хүчирхийлсэн, хаясан гэм буруугүй бол тэдний эрхийн талаар зөвлөгөө өгснөөс хойш гурван сарын дараа зөвшөөрөл авах шаардлагагүй болно.³⁸ ХБНГУ-д үрчлүүлэх зөвшөөрөл нь эцэг эхийн төрөлхийн эрх бөгөөд эцэг эхийн аливаа асран халамжлах үүргээс эрс ялгаатай байна.

Б.3 АНУ-ын үрчлэлтийг хүчингүйд тооцох зохицуулалт

АНУ-ын бүх мужуудад үрчлэлтийн захирамжийн эсрэг давж заалдах гомдол гаргаж болохгүй бөгөөд холбогдох талуудын алиных нь ч хүсэлтээр үрчлэлтийг хүчингүй болгож болохгүй гэсэн ерөнхий журам үйлчилнэ. Үрчлэлтийн захирамж нь хууль бус, алдаатай гэх мэт ердийн үндэслэлээс бусад тохиолдолд үрчлэлтийн захирамж хөдөлшгүй хэвээр байна.³⁹

Б.4 БНХАУ-ын Үрчлэлтийг хүчингүйд тооцох зохицуулалт

БНХАУ-ын хүүхэд үрчлэх тухай хуулийн 25 дугаар зүйлд: “Үрчлэгч нь хүүхдийг насанд хүрээгүй бол үрчлэлтийг хүчингүйд тооцуулж болохгүй. Хэрэв үрчлэгч нь хүүхдийг тэжээн тэтгэх үүргээ биелүүлээгүй, насанд хүрээгүй хүүхдийн хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн үйлдэлд хариуцлага тооцоогүй бол үрчлэгч, үрчлүүлэгч нар үрчлэлтийн харилцааг дуусгавар болгохоор шүүхэд хандах эрхтэй.

Хуулийн 26 дугаар зүйлд: Үрчилсэн эцэг эх, насанд хүрсэн үрчлэгдсэн хүүхдийн хоорондын харилцаа таарамжгүй болж, хамт амьдрахаа больсон бөгөөд тэд хоорондоо үрчлэлтийг хүчингүй болгохоор тохиролцоонд хүрч чадаагүй бол шүүхэд хандаж шийдвэрлүүлэх эрхтэй” гэж заасан байна.⁴⁰

Б.5 БНИУ улс хоорондын үрчлэлтийг хүчингүйд тооцох зохицуулалтын тухай

БНИУ-д дараах үндэслэлээр хүүхэд үрчлэлтийг хүчингүйд тооцно. Үүнд:

Үрчлэх шаардлагыг хангаагүй байх: Тухайлбал. Үрчлэлтийн баримт бичиг шаардлага хангаагүй, процедурын зөрчил гаргасан нь тогтоогдсон.

Хууран мэхлэх, худал мэдүүлэх: Үрчлэлтийг оролцогч талуудын аль нэг нь залилан мэхлэх, баримтыг буруу мэдүүлэх замаар хүүхэд үрчлэн авсан нь тогтоогдсон.

Хүүхдийн ашиг сонирхолд нийцээгүй: Хүүхэд үрчилсний дараа нөхцөл байдал өөрчлөгдсөн болон бусад хүндэтгэн үзэх шалтгаанаар үрчлэгдсэн хүүхдийн ашиг

³⁵ The Civil Code, 1764(2) and (3).

³⁶ Мөн тэнд, 1747(4).

³⁷ Мөн тэнд, 1748(1) 1 and 2.

³⁸ Мөн тэнд, 1748(2) 1 and the Code of Social Law (Sozialgesetzbuch), Vol VIII, s 51(1).

³⁹ <https://travel.state.gov/content/travel/en/Intercountry-Adoption/post-adoption.html>

⁴⁰ Kerry O'Halloran, The Politics of Adoption International Perspectives on Law, Policy and Practice Fourth Edition”, White Park Bay, Northern Ireland, UK, 2021 p. 849.

сонирхолд нийцэхгүй болсон нь тогтоогдсон⁴¹.

Б.6 Монгол Улсын хүүхэд үрчлэлтийг хүчингүйд тооцох зохицуулалт

Үрчлэлтийг хүчингүйд тооцох гэдэг нь үрчлэлт хүчин төгөлдөр байх хууль зүйн шаардлагыг зөрчсөн, эсхүл үрчлүүлэгчийн /хүүхдийн/ эрх, ашиг сонирхлыг хамгаалах шаардлагатай гэж үзэх бусад үндэслэлээр сонирхогч этгээдийн хүсэлтээр шүүхээс хуульд заасан журмын дагуу үрчлэгч, үрчлүүлэгчийн хоорондын харилцааг дуусгавар болгож буй хууль ёсны ажиллагаа байдаг. Иймд үрчлэлтийг хүчингүйд тооцуулах үндэслэл нь зөрчлийн шинжтэй байх бөгөөд уг зөрчлийг гаргасан этгээдэд хариуцлага хүлээлгэх хэлбэрээр “үрчлэлтийг хүчингүйд тооцох ойлголт илэрхийлэгддэг⁴²” тул үрчлэгч эцэг эх зөрчил гаргасан, гэм буруутай, тийнхүү үрчлэгч эцэг эхтэй хамт байлгах нь гагцхүү хүүхдийн дээд ашиг сонирхол, цаашдын ирээдүй, амьдрах хөгжих эрхэд харшилсан бөгөөд хүүхдийн үзэл бодлыг харгалзсаны үндсэнд хүчингүйд тооцогдох үндэслэлтэй болно.

Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 61.1 дэх хэсэгт “Үрчлэгч нь эцэг эх байх эрхээ урвуулан ашигласан, хүүхэдтэй хэрцгий харьцсан, хуурамч бичиг баримт бүрдүүлэн үрчлэн авах шийдвэр гаргуулсан. энэ хуулийн 57.2-т заасан этгээд болох нь илэрсэн тохиолдолд төрүүлсэн эцэг, эх. сонирхогч бусад этгээд, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах байгууллага, 14 нас хүрсэн хүүхдийн өөрийн нэхэмжлэлээр шүүх үрчлэлтийг хүчингүйд тооцно”, 61.2 дах хэсэгт “Шаардлагатай гэж үзвэл бусад үндэслэлээр шүүх үрчлэлтийг хүчингүйд тооцож болно⁴³” гэж заасан байна.

Гурав: Үрчлэлтийг хүчингүйд тооцох зохицуулалтыг харьцуулсан

судалгааны үр дүн МУ-ын хувьд үрчлэгч нь эцэг эх байх эрхээ урвуулан ашигласан, хүүхэдтэй хэрцгий харьцсан, хуурамч бичиг баримт бүрдүүлэн үрчлэн авах шийдвэр гаргуулсан эсхүл хүүхэд үрчлэн авахыг хуулиар хориглосон этгээдэд хүүхэд үрчлэхийг хориглохоор зохицуулсан.

Харьцуулсан улс орнуудын хувьд бичиг баримт хуурамчаар үйлдсэн хууль зүйн хувьд анхнаасаа алдаатай буюу хууль зөрчсөн зэрэг тохиолдлууд нь ижил байгаа нь үрчлэлт нь байнгын эргэлт буцалтгүй, хөдөлшгүй гэсэн шинжтэй байдгаараа онцлог байна. Харин үрчлэлтийн зорилго зөрчигдсөн хүүхдийн эрх ашигт нийцээгүй, үрчилж авсан эцэг эх нь хүүхдийг тэжээн тэтгэх үүргээ биелүүлээгүй, хүүхдэд зохих ёсоор анхаарал халамж тавьж, дэмжлэг үзүүлж чадаагүй цаашлаад үрчлэгдсэн хүүхдийн эрхийг нь зөрчсөн зэрэг тохиолдлуудад үрчлэлтийг хүчингүйд тооцох зохицуулалтаараа ялгаатай байна.

Иймд дээрх тохиолдолд хүүхдийг буцаах эсэх асуудлыг зохицуулсан эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлагатай гэж үзэж байна.

Дөрөв: Хүүхэд үрчлэлтийг хүчингүйд тооцохтой холбогдсон харилцаанд тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам

Хүүхэд үрчлэлтийг хүчингүйд тооцохтой холбоотой дараах тулгамдсан асуудлууд байна. Үүнд:

Нэг: Хүүхэд үрчлэлтийн бүртгэл, мэдээлэл, хяналтын нэгдсэн тогтолцоо байхгүйн улмаас үрчлэлтийн нарийвчилсан бүртгэл, мэдээлэлжүүлэлт, үрчлэгч болон үрчлүүлэгчийн талаарх нэгдсэн судалгаа байхгүй байна. Цаашлаад хуулиар хориглосон этгээдэд хүүхэд үрчлэлт хийж байгаа эсэхээ мэдэх, хянах, зохицуулах, эрсдэлтэй нөхцөл байдлаас сэргийлэх бодлого журам байхгүй болно. Мөн эрүүл мэндийн хувьд хүүхэд асран хамгаалах, хэвийн өсгөн хүмүүжүүлэх чадамжгүй этгээдэд хүүхэд үрчлэхийг хориглосон хязгаарлалт байхгүй байна. Энэ талаарх эрх зохицуулалт, бодлого, журам, бүртгэлийн тогтолцоо огт алга байна. Гэр бүлийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2. “эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан,


⁴¹ <https://www.commissioneadozioni.it/media/2y1jveja/title-ii-and-iii-law-no-184-of-4-may-1983-updated.pdf>.

⁴² О.Номулин, Тэр бүлийн тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасан “Үрчлэлтийг хүчингүйд тооцох зохицуулалтыг хэрэглэхэд тулгарч буй бэрхшээлтэй асуудлууд”, *Монголын төр, эрх зүй сэтгүүл*, Тусгай дугаар №11 (2014), 211 дахь тал.

⁴³ “Төрийн мэдээлэл” сэтгүүл. 1999, №12.

хасуулсан буюу хязгаарлуулж, хасуулж байсан, урьд нь үрчлэн авсан хүүхдээ өөрийн буруугаас буцаан өгсөн, ашиг хонжоо олох зорилготой, шүүхийн шийдвэрээр иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй буюу хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон, сүрьеэ, сэтгэцийн өвчтэй”...хүнд хүүхэд үрчлүүлэхийг хориглоно⁴⁴ гэж заасан. Гэтэл дээрх хориглогдсон этгээд хүүхэд үрчлэн авах хүсэлт гаргасан тохиолдолд баримт материалыг шалгахгүйгээр үрчлэлтийн бүртгэл хийгдэж хэвшсэн байна.

Зураг1. 2019-2022 оны байдлаар Улсын хэмжээнд үрчлэлтийн материалыг шалгасан байдал⁴⁵



2019-2022 оны 3970 хэргээс хүүхэд үрчлэн авахыг хүсэгчийн материалыг хүлээн авч шаардлага хангасан эсэхийг хянахдаа дээрх иргэний хэргийн шүүхийн шийдвэрүүдийг холбогдох байгууллагуудаас лавлагаагаар гаргуулан авсан тохиолдол огт байхгүй байна. Дээрх судалгаанаас дүгнэн үзэхэд шүүхээс эцэг, эх байх эрхийг хязгаарласан, хасуулсан буюу хязгаарлуулж, хасуулж байсан, урьд нь үрчлэн авсан хүүхдээ өөрийн буруугаас буцаан өгсөн буюу үрчлэлтийг хүчингүйд тооцсон, шүүхийн шийдвэрээр иргэний эрх зүйн эрхийн хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон зэрэг тохиолдлуудад иргэний хэргийн шүүхээс гаргасан шийдвэр, магадлал, тогтоол зэрэг баримтыг шалган авах механизм болон энэ талаар зохицуулсан журам байхгүйтэй шууд холбоотой байна. Харин эрүүгийн хэрэгт ял шийтгүүлсэн эсэхтэй холбогдсон материал болох ял шалгах хуудсыг дүүрэг бүр шалгаж хүүхэд үрчлэлтийн материалд хавсаргаж хэвшсэн байна.

Хоёр: Гэр бүлийн холбогдолтой хэрэг маргаанд гэрлэлт цуцлах, хүүхдийн асрамж тогтоох, тэтгэлэг гаргуулах, гэр бүлийн дундын эд хөрөнгийн хуваах зэрэг маргаанууд хамаардаг бол онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх хэргүүдэд хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцуулах маргаан хамаарна. Үрчлэлтийг хүчингүйд тооцуулах хүсэлтийг шийдвэрлэж байгаа шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх замаар хуулийн хэрэглээнд анхаарах асуудлыг олж тогтоохоор 2013-2023 оны хооронд шийдвэрлэгдсэн 332 хэргээс 55 хэргийг түүвэрлэж, зүйлчлэлийг шалгаж дараах тоон мэдээллийг нэгтгэсэн болно.

Гэр бүлийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1-д заасны дагуу “Үрчлэгч нь эцэг, эх байх эрхээ урвуулан ашигласан, хүүхэдтэй хэрцгий харьцсан, хуурамч бичиг баримт бүрдүүлэн үрчлэн авах шийдвэр гаргуулсан, энэ хуулийн 57.2-т заасан этгээд болох нь илэрсэн тохиолдолд... шүүх үрчлэлтийг хүчингүйд тооцох”⁴⁶-оор зохицуулсан. Уг заалтаар үрчлэлтийг хүчингүйд тооцсон тохиолдол нийт хэргийн 40%-ийг эзэлж байгаа бол Гэр


⁴⁴ Мөн тэнд., Гэр бүлийн тухай хууль, 1999.

⁴⁵ НГХЗХГ-ын 2002 оны IV дүгээр улирлын тайлан. У6, 2022, 21 дэх тал.

⁴⁶ Мөн тэнд., Гэр бүлийн тухай хууль, 1999.

бүлийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.2-т заасан буюу бусад үндэслэл нь нийт хэргийн 60%-ийг эзэлж байна.

Зураг 2. Үрчлэлтийг хүчингүйд тооцсон шийдвэрт хийсэн тоон мэдээлэл 2018-2023 оны байдлаар



Уг 60 %-ийн дийлэнх нь хүүхдийн сэтгэл зүй дасахгүй байсан, ямар нэг зорилгоор төрөл садны хүнд түр үрчлүүлсэн, санхүүгийн боломжгүйн улмаас түр үрчлүүлсэн, үрчлэн авагч хүндээр өвдсөн эсхүл нас барсан, үрчлүүлсэн боловч хамт амьдардаг, ашиг олох зорилгоор үрчилж авсан /одонгийн мөнгө авах, тэтгэвэрт хамрагдах, хүүхдийн мөнгө авах/, гадаад улс орон руу хүүхдээ сургах, эсхүл өөрсдөө гадаад улсад ажиллаж амьдрах зэрэг шалтгаанаар түр үрчлүүлсэн үрчлэлтийг хүчингүйд тооцсон тохиолдлууд түгээмэл байгаа нь хууль эрх зүйн зохицуулалт дутмаг, муу байгаатай холбоотой болно.

Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн дээрх зохицуулалтын хувьд “Шаардлагатай гэж үзвэл”, “бусад үндэслэлээр” гэдэгт ямар үндэслэлүүд хамаарах талаар УДШ-ээс одоогоор албан ёсны тайлбар гаргаагүй⁴⁷, энэ талаарх заалтыг хэрхэн хэрэглэх нь тодорхой бус байгаа нь шүүхээс хүүхдийн үрчлэлттэй холбоотой асуудлыг хянан шийдвэрлэхдээ үрчлэгч эцэг эхийн гэм буруутай үйл ажиллагааны улмаас хүүхдийн эрх, ашиг сонирхол хөндөгдсөн эсэх асуудлыг тогтоохгүйгээр, үндэслэлгүйгээр энэ хүрээнд авч шийдвэрлэх өргөн боломжийг бий болгож байна.

Судлаачийн зүгээс хүсэлтийг хангасан болон хүсэлтийг хэрэгсэхгүй болгосон үндэслэлүүдийг шалгуур болгон таван хэрэгт дүн шинжилгээ хийж үзэхэд Хүүхдийн эрхийн тухай хуулийн 4-р зүйлийн 4.1.2-т “төр, иргэн, хуулийн этгээд үйл ажиллагаа явуулахдаа хүүхдийн язгуур эрхийг эн тэргүүнд хангахыг эрхэмлэж, хүүхэд эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг тэгш хангах үүрэгтэй” боловч хэргийг хянан шийдвэрлэх явцдаа хүүхдийн эрхийг хангаж хамгаалах хүрээнд тодорхой ажиллагаа явуулахгүйгээр шийдвэрлэж байгаа нь учир дутагдалтай байна. Иймд үрчлэлтийн хүчингүйд тооцохдоо хүүхдийн эрх, ашиг сонирхол зөрчигдөж, хөндөгдөж байгааг тусгайлан авч үзэх, мэргэжлийн шинжээч, сэтгэл зүйч томилж хүүхдийн сэтгэл зүйг судалж дүгнэлт гаргах, цаашлаад 7 нас хүрсэн хүүхдээс санал авах зэрэг нэмэлт ажиллагаанууд хийдэг болоход анхаарах шаардлагатай байна.

Гурав: Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 12 дугаар зүйлд хүүхдийг өөртэй нь холбоотой бүх асуудлаар хүүхдийн нас төлөвшлийн байдлыг харгалзан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээр хангах явдал мөн. Хүүхдийн эрхийн хороо энэ талаарх

⁴⁷ УДШ, хууль тайлбарласан тогтоол. Уб., 2018.

асуудлаар 2009 оны 51 дүгээр чуулганаар баталсан “Хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх” Ерөнхий зөвлөмж № 12-т “Оролцогч улсууд хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хангахын тулд 12 дугаар зүйлд харшилсан, хязгаарласан аливаа хууль тогтоомжийг хянан үзэх ба хүчингүй болгох стратегийг баримтлах нь зүйтэй” гэж үзсэн. Гэтэл Монгол улсын хувьд Гэр бүлийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.4 дэх хэсэгт зааснаар хүүхдийг үрчлүүлэхдээ 7 нас хүрсэн хүүхдийн зөвшөөрлийг авахаар зохицуулсан⁴⁸ атлаа шүүхээс үрчлэлтийг хүчингүйд тооцох тухай асуудлыг шийдвэрлэхдээ хүүхдийн үзэл бодлыг харгалзах талаар хуульд тусгаж өгөөгүй байна.

Монгол улсын Гэр бүлийн тухай хуульд үрчлэлтийг хүчингүйд тооцох асуудлыг шийдвэрлэхэд баримтлах зарчим, хүүхдийн нас төлөвшлийн байдлыг харгалзан үзэл бодлыг харгалзах талаар зохицуулаагүй болно. Гэр бүлийн тухай хуулийн 2.2 дах хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө” гэж заасны дагуу шүүх үрчлэлтийг хүчингүйд тооцох эсэх асуудлыг хянан шийдвэрлэхдээ Монгол улсын нэгдэн орсон Хүүхдийн эрхийн тухай конвенц, Гаагийн конвенцид заасан үрчлэлтийн харилцаанд хүүхдийн дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд анхаарах зарчмыг баримтлан шийдвэрлэдэг болох зайлшгүй шаардлагатай шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудлын нэг мөн.

Дөрөв: Гаагийн конвенцын 21 дугаар зүйлийн 1-д “Хүлээн авагч улсад хүүхдийг шилжүүлсний дараа түүнийг үрчлэн авах эцэг эхийн хамт цаашид байлгахад хүүхдийн ашиг сонирхолд нийцэхгүй гэдгийг эрх бүхий төв байгууллагад мэдэгдвэл тухайн байгууллага хүүхдийг хамгаалах арга хэмжээ авахаар заасан хэдий ч Монгол Улсын гэр бүлийн тухай хуулиар үрчлэгдсэн хүүхдэд тавих дотоод болон гадаад хяналттай холбоотой зохицуулалт огт байхгүй. Энэ нь гадаад улс оронд үрчлэгдэж байгаа хүүхэд болон үрчлэгч эцэг, эхэд ямар нэгэн асуудал тулгарч хүүхдийн эрх, ашиг сонирхол зөрчигдөж, хохирсон тохиолдолд /үрчлэн авагч эцэг эх нь нас барсан, сураггүй алга болсон, эрүүгийн хэрэгт ял шийтгүүлж хорих ял эдэлж байгаа, эрх зүйн чадамжгүй болсон, хүүхдийг хүчирхийлсэн, гэмт хэрэг эрх зүйн зөрчилд татан оролцуулсан зэрэг/ үрчлэлтийг хүчингүйд тооцох, хүүхдийг эх оронд нь буцаах, эрх, ашиг сонирхлыг нь хамгаалах асуудлыг зохицуулж өгөөгүй байгаа нь гадаадын иргэнд үрчлэгдсэн хүүхдийн эрх ашиг сонирхлыг зөнд орхиж байгаагийн илрэл мөн гэж үзэж байна

ДҮГНЭЛТ

Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээнээс үзэхэд хүүхдийн эрх зөрчигдөх, дээд ашиг сонирхолд харшилсан, хохирол учрах эрсдэлтэй нөхцөл байдлаас үүдэн үрчлэлтийг хүчингүйд тооцох тухай хүсэлт гаргахад, хүсэлтийг хэрэгсэхгүй болгох шийдвэрийг шүүх гаргаж байна. Уг шийдвэр нь хүүхдийн эрх, ашиг сонирхол зөрчигдөж байхад эрхийг нь хамгаалахгүйгээр эрх зөрчигчтэй үлдээж байгаа хэрэг бөгөөд энэ нь хүүхэд үрчлэлтийн гол зорилго болох хүүхдийн дээд ашиг сонирхлыг хамгаалах гэдгийг умартсан хэрэг юм.

Иймд нэг талаас дотоодын шүүхийн шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийх замаар практик судалгаанд тулгуурлаж тулгамдсан асуудлыг нээн илрүүлж, нөгөө талаар олон улсын болон гадаадын зарим улс орнуудын хүүхэд үрчлэлтийг хүчингүйд тооцсон зохицуулалтуудыг харьцуулан судалж холбогдох санал дүгнэлтийг судалгаанд тулгуурлан боловсруулсан болно.

Санал:1 Хүүхдээр ашиг олох зорилготой, хүүхдийн эрхийг зөрчсөн зэрэг зөрчлүүд тогтоогдсон, тохиолдолд хохирсон этгээд болон төрөөс уг хохирлыг нөхөн төлүүлэх, одонгийн болон хүүхдийн мөнгө, тэтгэврийн мөнгийг буцаан гаргуулах эрх зүйн зохицуулалт байхгүй учраас хүүхэд үрчилж ашиг олох тохиолдлууд гарсаар байна. Иймд буруутай этгээдээр материаллаг хохирол нөхөн төлүүлэх, цаашлаад хүүхдэд 2 дахь

⁴⁸ Төрийн мэдээлэл, сэтгүүл №12, Гэр бүлийн тухай хууль 1999.

өнчрөл үзүүлснээр хүүхэд болон үрчлэн авагчийн сэтгэл зүйд маш хүнд хохирол учирдаг тул хохирогчийн сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэхэд чиглэсэн зохицуулалтыг бий болгох шаардлагатай.

Санал: 2 Гэр бүлийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1-т “Үрчлэлтийг хүчингүйд тооцоход 7 наснаас дээш хүүхдийн саналыг авна” гэсэн зохицуулалтыг нэмж оруулах.

Санал: 3 Гэр бүлийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.2 “Шаардлагатай гэж үзвэл бусад үндэслэлээр шүүх үрчлэлтийг хүчингүйд тооцож болно” гэснийг “Шаардлагатай гэж үзвэл хүүхдийн эрх ашиг сонирхлыг хамгаалах үүднээс шүүх үрчлэлтийг хүчингүйд тооцож болно” гэж өөрчлөн найруулах.

Санал: 4 Гэр бүлийн хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д Үрчлэгдсэн хүүхдийг үрчлэн авсан эцэг, эхтэй цаашид байлгахад хүүхдийн ашиг сонирхолд нийцэхгүй гэж үзвэл, итгэмжлэгдсэн байгууллага хүүхдийг хамгаалах бүх талын арга хэмжээ авна” гэсэн зохицуулалтыг нэмж оруулах.

ЭХ СУРВАЛЖ

Монгол хэл дээрх

Хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992.
2. Гэр бүлийн тухай хууль 1999.

Ном, өгүүлэл, судалгааны тайлан

1. Ж.Амарсанаа, Хүүхдийн эрхийн нэр томъёоны товч тайлбар толь, Уб., 2001.
2. Ц.Алтанцэцэг, Монгол Улсын Гэр бүлийн эрх зүй, Уб., 2011.
3. Ч.Арьяасүрэн, Монгол ёс заншлын их тайлбар толь, Уб., 2000.
4. Б.Баярсайхан, Монгол цаазын бичиг”, Уб., 2001.
5. А.Батбаатар, Монгол Улсын гэр бүлийн эрх зүй, Уб., 2007, 2021.
6. С.Баасандорж, Монгол Улсын Гэр бүлийн эрх зүй, Уб., 2011.
7. Т. Мөнхжаргал, Гэр бүлийн эрх зүй, Уб., 2005.
8. А.Дугармаа, Ц.Алтанцэцэг, Монгол Улсын Гэр бүлийн эрх зүй гарын авлага, Уб, 2007, 2017.
9. Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, Уб., 2000.
10. Монгол Улсын нэгдэн орсон конвенц, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээний эмхэтгэл”, Уб., 2020.
11. УДШ, хууль тайлбарласан тогтоолын эмхэтгэл. Уб., 2018.
12. ГИХАЭА-ны тайлан, мэдээ 2022, УБ.
13. НГХЗХГ-ын 2002 оны IV дүгээр улирлын тайлан, мэдээ УБ, 2023.
14. Үндэсний статистикийн хорооны тайлан, мэдээ УБ.,2022.
15. “Үрчлэлт ба Хүүхдийн эрх”, ХЭҮК-ийн Хүний эрхийн цуврал нийтлэл (2014), дугаар №14.
16. О.Номуулин, «Гэр бүлийн тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасан “Үрчлэлтийг хүчингүйд тооцох зохицуулалтыг хэрэглэхэд тулгарч буй бэрхшээлтэй асуудлууд”, Монголын төр, эрх зүй сэтгүүл, Тусгай дугаар №11 (2014).

Шүүхийн шийдвэр

1. Дундговь аймаг дахь сум дундын ИХАШШ-ийн 2018 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дугаар 635 тоот шийдвэр.
2. Сонгинохайрхан дүүргийн ИХАШШ-ийн 2018 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн дугаар 184/ШШ2018/01804 тоот шийдвэр.
3. Сэлэнгэ аймаг дахь ИХАШШ-ийн 2018 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн дугаар 101/шш 335 тоот шийдвэр.
4. Сэлэнгэ аймаг дахь сум дундын ИХАШШ-ийн 2018 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн дугаар 148/ШШ2018/00326 тоот шийдвэр.
5. Дорноговь аймгийн замын-үүд сум дахь сум дундын шүүхийн 2018 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дугаар 136 тоот шийдвэр.
6. Хан-уул дүүргийн ИХАШШ-ийн 2018 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн дугаар 183/ШШ2018/01320 тоот шийдвэр.
7. Говь-алтай аймаг дахь сум дундын ИХАШШ-ийн 2018 оны 05 дугаар сарын 10 өдрийн дугаар 251 тоот шийдвэр.
8. Ховд аймаг дахь сум дундын ИХАШШ-ийн 2018 оны 05 сарын 02 өдрийн дугаар 153/ШШ2018/00249 тоот Хэргийг хэрэгсэхгүй болгох тухай шийдвэр.
9. Говь-алтай аймаг дахь сум дундын ИХАШШ-ийн 2018 оны 04 сарын 02-ний өдрийн дугаар 174 тоот шийдвэр.

10. Дорнод аймаг дахь сум дундын ИХАШШ-ийн 2018 оны 03 сарын 27-ны өдрийн дугаар 292 тоот шийдвэр.
11. Говь-алтай аймаг дахь сум дундын ИХАШШ-ийн 2018 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн дугаар 133/ШШ2018/00139 тоот шийдвэр.
12. Ховд аймаг дахь сум дундын ИХАШШ-ийн 2018 оны 01 сарын 17 өдрийн өдрийн дугаар 14 тоот шийдвэр.
13. Сонгино хайрхан дүүргийн ИХАШШ-ийн 2018 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн дугаар 184/ШШ2018/000171 тоот шийдвэр.
14. Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 04 сарын 07-ний өдрийн дугаар 101/шш2023/01753 тоот шийдвэр.
15. Баянгол дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн дугаар 102/шш2019/00725 тоот шийдвэр.
16. Сэлэнгэ аймаг дахь сум дундын ИХАШШ-ийн 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дугаар 8 тоот шийдвэр.
17. Дундговь аймаг дахь сум дундын ИХАШШ-ийн 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дугаар дугаар 139/ШШ2019/00540 тоот шийдвэр.
18. Орхон аймаг дахь сум дундын ИХАШШ-ийн 2019 оны 11 дүгээр 29-ний өдрийн дугаар 01289 тоот шийдвэр.
19. Ховд аймаг дахь сум дундын ИХАШШ-ийн 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн дугаар 00558 тоот шийдвэр.
20. Сэлэнгэ аймаг дахь сум дундын ИХАШШ-ийн 2019 оны 11 сарын 18-ны тоот өдрийн дугаар 539 тоот шийдвэр.
21. Дундговь аймаг дахь сум дундын ИХАШШ-н 2019 оны 07 сарын 30-ны өдрийн дугаар 244 тоот шийдвэр.
22. Дундговь аймаг дахь сум дундын ИХАШШ-ийн 2019 оны 06 сарын 13 өдрийн дугаар 133/ШШ2019/00120 тоот шийдвэр.
23. Говь-алтай аймаг дахь сум дундын ИХАШШ-ийн 2019 оны 04 сарын 09-ний өдрийн дугаар 133/ШШ2019/00120 тоот шийдвэр.
24. Говь-алтай аймаг дахь сум дундын ИХАШШ-ийн 2019 оны 03 сарын 05-ны өдрийн дугаар 188 тоот шийдвэр.
25. Дорноговь аймгийн Замын-үүд сум дахь сум дундын шүүхийн 2019 оны 02 сарын 27-ны өдрийн дугаар 52 тоот шийдвэр.
26. Говь-алтай аймаг дахь сум дундын ИХАШШ-ийн 2020 оны 11 сарын 27-ны өдрийн дугаар 133/ШШ2020/00816 тоот шийдвэр.
27. Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 10 сарын 16-ны өдрийн дугаар 182/ШШ2020/02346 тоот шийдвэр.
28. Ховд аймаг дахь сум дундын ИХАШШ-ийн 2020 оны 10 сарын 07-ны өдрийн дугаар 153/ШШ2020/00725 тоот шийдвэр.
29. Сэлэнгэ аймаг дахь сум ИХАШШ-ийнн 2020 оны 09 сарын 30-ны өдрийн дугаар 148/ШШ2020/00584 тоот шийдвэр.
30. Орхон аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 09 сарын 01-ны өдрийн дугаар 142/ШШ2020/01063 тоот шийдвэр.
31. Орхон аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 08 сарын 19-ны өдрийн дугаар 18/шш2020/08190 тоот шийдвэр.
32. Ховд аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 07 сарын 16-ны өдрийн дугаар 153/ШШ2020/00486 тоот шийдвэр.
33. Хөвсгөл аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 07 сарын 07-ны өдрийн дугаар 155/ШШ2020/01406 тоот шийдвэр.
34. Говь-алтай аймаг дахь сум дундын ИХАШШ-ийн 2020 оны 07 сарын 03-ны

- өдрийн дугаар 133/ШШ2020/00505 тоот шийдвэр.
35. Дорноговь аймгийн замын-үүд сум дахь сум дундын шүүхийн 2020 оны 06 сарын 18-ны өдрийн дугаар 205 тоот шийдвэр.
 36. Дархан-уул аймаг дахь сум дундын ИХАШШ-ийн 2020 оны 06 сарын 11-ны өдрийн дугаар 674 тоот шийдвэр.
 37. Дундговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 05 сарын 25-ны өдрийн дугаар 377 тоот шийдвэр.
 38. Налайх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр 2020 оны 05 сарын 19-ны өдрийн дугаар 195 тоот шийдвэр.
 39. Орхон аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 04 сарын 06-ны өдрийн дугаар 142/ШШ2020/475 тоот шийдвэр.
 40. Дундговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 03 сарын 10-ны өдрийн дугаар 177 тоот шийдвэр.
 41. Говь-алтай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 03 сарын 05-ны өдрийн дугаар 188 тоот шийдвэр.
 42. Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 01 сарын 07-ний өдрийн дугаар 101/2021/00079 тоот шүүхийн шийдвэр.
 43. Сэлэнгэ аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 11 сарын 15-ны өдрийн дугаар 148/ШШ2021/00485 тоот шийдвэр.
 44. Хан-уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 11 сарын 03-ны өдрийн дугаар 183/ШШ2021/02486 тоот шийдвэр.
 45. Дорноговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 08 сарын 31-ны өдрийн дугаар 45шш2021/08753 тоот шийдвэр.
 46. Дорноговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 06 сарын 29-ны өдрийн дугаар 136/ШШ2021/00154 тоот шийдвэр.
 47. Орхон аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 05 сарын 07-ны өдрийн дугаар 142/ШШ2021/00407 тоот шийдвэр.
 48. Ховд аймгийн булган сум дахь сум дундын шүүхийн 2021 оны 03 сарын 24-ны өдрийн дугаар 154/ШШ2021/00074 тоот шийдвэр.
 49. Ховд аймгийн булган сум дахь сум дундын шүүхийн шийдвэр 2021 оны 01 сарын 29-ний өдрийн дугаар 76/шш2021/01003 тоот шийдвэр.
 50. Ховд аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр 2021 оны 01 сарын 15-ны өдрийн дугаар 153/ШШ2021/00046 тоот шийдвэр.
 51. Сэлэнгэ аймгийн мандал сум дахь сум дундын шүүхийн шийдвэр 2022 оны 11 сарын 09-ний өдрийн дугаар 149/ШШ2022/00506 тоот шийдвэр.
 52. Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр 2022 оны 06 сарын 22-ны өдрийн дугаар 101/ШШ2022/02930 тоот шийдвэр.
 53. Орхон аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 04 сарын 07-ны өдрийн дугаар 142/ШШ2022/00527 тоот шийдвэр.
 54. Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 02-р сарын 13-ны өдрийн дугаар 181/шш2023/00931 тоот шүүхийн шийдвэр.

Гадаад хэл дээрх

Ном, өгүүлэл, судалгааны тайлан

1. United Nations Committee on the Rights of the Child Fifty-third session 11-29 J 2010.
2. Barbara A. Moe, Contemporary world issues: Adoption, 2007.
3. Kerry O'Halloran, The Politics of Adoption International Perspectives on Law, Policy and Practice Fourth Edition, 2021.

4. Садеева Гузель Миназымовна “Некоторые вопросы совершенствования законодательного регулирования и применения условий усыновления в России “Вестник Саратовской государственной юридической академии, область наук право”, 2015.
5. Departmental Committee on the Adoption of Children Judge F. A. Stockdale Sir William Houghton 21 July 1969 HMSO, 1972.
6. Загоровский А.И., Гэр бүлийн эрх зүй, 2003.
7. Ромын иргэний эрх зүйн тогтолцоо Боть 5, редактор Барон, Киев, 1889.
8. Пухарт А.А., ОХУ дахь үрчлэлтийн харилцааны эрх зүйн зохицуулалт, дэд докторын зэрэг горилсон бүтээл, Москва, 2013.

Цахим эх сурвалж

1. Dictionary.com.
2. Webster’s Dictionary of English Usage.
3. <https://www.britannica.com/>.
4. Statute of the Hague Conference on Private International Law. <https://www.hcch.net/en/instruments/conventions/status-table/>
5. https://www.legifrance.gouv.fr/codes/article_lc/LEGIARTI000034747019?init=true&page=1&query=343&searchField=ALL&tab_selection=all.
6. <https://travel.state.gov/content/travel/en/Intercountry-Adoption/post-adoption.html>.

A COMPARATIVE STUDY OF LAW REGULATIONS FOR ANNULMENT OF CHILD ADOPTION

A. Batbaatar

Lecturer at Ikh Zasag International University, Ph.D student

ABSTRACT:

If a person cannot have a child naturally, then having a child with the help of legal means is a special advantage of the legal arrangement of adoption. However, there are still many negative issues such as the return of the adopted child due to various social reasons and the annulment of the adoption. Whether it can satisfy and protect the rights and interests of adopted children, it has become one of the biggest problems facing the world. Therefore to study the international treaties and conventions that Mongolia has joined and the regulations regarding the annulment of adoption in the adoption law of foreign countries in comparison with Mongolia’s, clarifying the reasons for violating the rights and interests of domestically adopted children by analyzing court decisions, if the rights of a child adopted in a foreign country are violated, return the child and consider the adoption invalid, suggestions related to the discovery of practical problems and elimination of violations are presented.

KEYWORDS:

Child adoption, adopter, adoptee, Hague Convention on Annulment of Adoption, Convention on the Rights of the Child

БИЕ ДААСАН БАЙГУУЛЛАГЫН ТОМИЛГООНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ *



Б.Төрболд

Хууль зүйн ухааны магистр

ТОВЧЛОЛ:

Захиргааны ерөнхий хуулийн 5.1.2-т “хууль тогтоомжийг биелүүлж, захирамжилсан шийдвэр гаргадаг Засгийн газрын бус бие даасан агентлаг, түүнтэй адилтгах нийтийн эрх зүйн бусад байгууллага” гэж заасан. Ийнхүү Захиргааны ерөнхий хуулийн 5.1.2-т заасан байгууллагад төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг, мөн чанар нь гүйцэтгэх эрх мэдлээс тусдаа байгуулагдаж, бүрэлдэхүүний, төсвийн, зохион байгуулалтын хувьд хараат бусаар ажиллахыг шаарддаг, хуульд тодорхойлсноор байгуулагддаг зохицуулах чиг үүрэгтэй бие даасан агентлагууд хамаардаг.

ТҮЛХҮҮР ҮГС:

Бие даасан байгууллага (агентлаг), томилгооны эрх зүйн зохицуулалт, Монгол Улсын Их Хурал, Захиргааны ерөнхий хууль.

УДИРТГАЛ

Захиргааны байгууллага, албан тушаалтны тухайд зөвхөн батлагдсан хуулийг ёсчлон дагаж мөрдөхөөс гадна хуулиар тодорхойлсон, хуулиар олгосон хүрээ хязгаарын дотор шийдвэр гаргах эрх хэмжээний хүрээнд үйл ажиллагаа явуулж, шийдвэр гаргадаг. Ийнхүү эрх зүйд захирагдах зарчмын дагуу захиргааны шийдвэр гарах учиртай байдаг л эрх зүйт төрийн захиргааг байгуулах, төлөвшүүлэхийн амин гол асуудал нь оршдог.² 2016 оноос хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн Захиргааны ерөнхий хуулийн³ 5 дугаар зүйлийн 5.1-д заасан тодорхойлолтоос үзэхэд захиргааны байгууллага нь (1)нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэх, (2)бусдыг захирамжилсан шийдвэр гаргадаг, (3)нийтийн эрх зүйн этгээд байна. Тиймээс захиргааны байгууллага нь нийтийн эрх зүйн харилцаанд оролцохдоо нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ. Энэхүү чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд иргэн, хуулийн этгээдийг захирамжлах шийдвэр гаргагдаар уг байгууллагын онцлог оршино.

* Зохиогч энэхүү асуудлыг дэлгэрүүлэн судалж, Бие даасан агентлагийн томилгооны эрх зүйн зохицуулалт /Сонгуулийн байгууллагын томилгооны жишээ дээр/ хууль зүйн ухааны магистрын зэрэг горилсон. Харин энэхүү өгүүлэлд “Бие даасан агентлагийн томилгооны эрх зүйн зохицуулалт, тэр дундаа Монгол Улс дахь бие даасан агентлагийн томилгооны эрх зүйн зохицуулалт”-ын талаар хөндөхийг зорьсон болно.

² Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн тайлбар. (судалгаа, хэрэглээний). Анхны хэвлэл. 2017. Уб., 74 дэх тал.

³ Захиргааны ерөнхий хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2015.07.24-ний өдрийн №28 дугаарт нийтлэгдсэн.

Хууль зүйн шинжлэх ухаанд нийтийн захиргааны ойлголтыг өргөн утгаар буюу гүйцэтгэх эрх мэдлийг бүхэлд нь хамаарсан ойлголт өөрөөр хэлбэл, төр болон нийтийн засгийн хэрэгжүүлэгч бусад этгээдийн бүхий л үйл ажиллагааг нэгтгэн ойлгоно. Харин хууль тогтоох ба шүүх эрх мэдлийн байгууллага хамаарахгүй.⁴ Энэ хандлагаар Захиргааны ерөнхий хуулийн 5.1.2-т “хууль тогтоомжийг биелүүлж, захирамжилсан шийдвэр гаргадаг Засгийн газрын бус бие даасан агентлаг, түүнтэй адилтгах нийтийн эрх зүйн бусад байгууллага” гэж захиргааны байгууллагын тодорхойлолтод нэмж тусгажээ. Ийнхүү Захиргааны ерөнхий хуулийн 5.1.2-г заасан байгууллагад төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг⁵, мөн чанар нь гүйцэтгэх эрх мэдлээс тусдаа байгуулагдаж, бүрэлдэхүүний, төсвийн, зохион байгуулалтын хувьд хараат бусаар ажиллахыг шаарддаг, хуульд тодорхойлсноор байгуулагддаг зохицуулах чиг үүрэгтэй бие даасан байгууллагууд хамаардаг.

Бие даасан байгууллага (агентлаг) нь Засгийн газрын агентлагаас ялгардаг онцлог нь хэм хэмжээ тогтоосон акт гаргах замаар салбартаа зохицуулалт хийх эрхтэй байдаг.⁶ Энэхүү хараат бус бие даасан байгууллагыг бүрдүүлэхдээ Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Улсын дээд шүүх зэрэг тал талын оролцоо (санал болгох, зөвшилцөх, томилох)-г хангаж бие даасан, тэнцвэртэй, төвийг сахисан байдлыг нь баталгаажуулахыг шаарддаг.

Энэ хүрээнд судлаачийн хувьд 1992 оноос хойших бие даасан, хараат бус байгууллагын томилгооны эрх зүйн зохицуулалтыг төрийн эрх мэдлийн хуваарилалт, хяналт, тэнцэл нь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл хооронд төдийгүй тэдгээрээс хараат бусаар ажиллах бие даасан байгууллагыг бүрдүүлэх, томилгооны өнөөгийн эрх зүйн зохицуулалтыг судалж, шийдвэрлэх асуудлыг тодорхойлж, дүгнэлт өгөхийг зорьсон болно.

Нэг. Бие даасан байгууллагын тухай

Бие даасан байгууллага нь зохицуулалт хийх болон хяналт тавих чиг үүргийг хараат бусаар хэрэгжүүлэх замаар⁷ ардчилсан засаглалыг бэхжүүлж шударга, зарчимч байдлыг хангах, үндсэн хуульт ардчиллыг бататгах зорилготой.⁸ Өөрөөр хэлбэл, улс төрийн хувьд төвийг сахисан, төрийн эрх мэдлийн гурван салаа мөчрөөс хараат бус, шударга ёсыг сахиулж, ардчилсан засаглалын чанар, тогтвортой байдлыг хангах зорилго бүхий нийтийн эрх зүйн этгээд⁹ гэж ойлгодог. Улс төрийн болоод институцийн хувьд хараат бус байх нь ардчилсан тогтолцоонд хүлээх үүргээ гүйцэтгэх гол нөхцөл болно. Ардчилал болон сонгуулийг дэмжих олон улсын хүрээлэнгийн тайлбарласнаар бие даасан байгууллагууд нь ерөнхийдөө дараах үүргийг гүйцэтгэж байна:

- Төвийг сахин шударга ёсыг хамгаалагч – Төрийн үйл ажиллагааг нам, улс төрийн нөлөө, улс төрийн авлигаас хамгаалах, хэм хэмжээ, процедур шударга ёсонд нийцэх байдлыг хянах, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх.
- Байнгын мониторингийн үүрэг бүхий хянагч – тодорхой салбарт төрийн үйл ажиллагаанд хяналт тавих. Үүнд, бие даасан судалгаа шинжилгээ хийх байгууллагууд орохын зэрэгцээ Хүний эрхийн үндэсний комисс гэх мэт байгууллагууд багтана.
- Бие даасан захиргааны байгууллага – тодорхой салбарт зохицуулах, эсхүл захиргааны үүрэг гүйцэтгэнэ. Сайн засаглал, урт хугацааны төлөвлөлт, тогтвортой байдлыг хангах, техникийн чадавх бүрдүүлэх гэх мэт шаардлагын улмаас улс төрөөс хараат бусаар

⁴ Захиргааны хэргийн шүүх “Монгол дахь шинэчлэл, дэлхийн улсуудын жишиг” Ханнс-Зайделийн сан. 2004, Уб., 74-75 дахь тал.

⁵ Р.Мухийт. *Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн эрх зүйн зохицуулалтын тулгамдсан асуудал*. “Хууль дээдлэх ёс” сэтгүүл. (2013), №2, 100 дахь тал.

⁶ “Эрх зүйн боловсрол” академи, Ханнс Зайделийн сан. *Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ*. судалгааны тайлан. Уб., 2018, 62 дахь тал.

⁷ Ардчилал, сонгуулийг дэмжих олон улсын хүрээлэнгээс “бие даасан зохицуулах болон хяналт тавих чиг үүрэгтэй байгууллагууд” (independent regulatory and oversight organization) гэж нэрлэж байна.

⁸ О.Мөнхсайхан. *Ерөнхийлөгч: Эрх зүйн байдал, бүрэн эрх*. Уб., 2022, 145 дахь тал.

⁹ Eliot Bulmer. *Independent Regulatory and Oversight (Fourth-Branch) institutions*, international IDEA Constitution-Building Primer 19. 2019, 6 дахь тал.

тухайн салбарыг бодлогоор хангаж ажиллах үүрэг бүхий төв банк гэх мэт байгууллагууд хамаардаг.

Энэхүү чиг үүргийн онцлогтой нь холбоотой, төрийн эрх мэдлийн гурван салаа мөчрөөс хараат бус байх мөн чанарыг нь үндэслэн “4 дэх мөчир” ч гэж зарим судлаач нэрлэх нь бий¹⁰.

Бие даасан байгууллагыг бүрдүүлэхэд юуны өмнө Монгол Улсын Үндсэн хуулийн үндсэн бүтэц, суурь үзэл баримтлал, үндсэн зарчмыг баримталж зохицуулах нь зүйн хэрэг юм. Үүнд, төрийн эрх мэдлийг аливаа этгээдэд төвлөрүүлэх бус, хуваарилах замаар хяналт, тэнцлийг хангах нь хэзээд баримтлах учиртай гол зарчим билээ. Монгол Улсын Үндсэн хуулийн үндсэн бүтэц, суурь үзэл баримтлалын нэгээхэн хэсэг болох уг зарчмын талаар¹¹ судлаачид нэлээд дурдсан байх бөгөөд Үндсэн хуулийн эхийг баригч Б.Чимид “1990 онд Ардчилсан хувьсгал хийж, улс оронд шинэ дэглэм тогтоож эхэлсэн цагаас төрийн байгууллагын шинэ тогтолцоог бүрдүүлж эхлэхдээ “эрх мэдэл хуваарилах зарчим”-ыг баримтлахын зайлшгүйг танин мэдэж шинэ Үндсэн хуульдаа гол агуулгаар нь тусгав”¹² гэжээ.

Эдгээр байгууллагууд нь олон улсын жишгээр ихэвчлэн Парламентаас байгуулагдаж, түүний өмнө ажлаа зохих журмын дагуу хариуцан тайлагнадаг¹³ бөгөөд Парламент, Засгийн газраас хараат бус байж, өөрөө бие даан шийдвэрлэх асуудлыг хуулиар зохицуулсан¹⁴ байдаг. Энэ жишгийн дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт УИХ дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд¹⁵ хадгалж шийдвэрлэнэ гэсний дотор: 6/“Ерөнхий сайд, хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын бүрэлдэхүүнийг томилох, өөрчлөх, огцруулах”, мөн 4-т “Улсын Их Хурлын Байнгын хороо, Засгийн газар, хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын бүтэц, бүрэлдэхүүнийг тогтоох, өөрчлөх” гэж заасан.

Монгол Улсад үйлчилж буй хуулиудын хүрээнд бие даасан байгууллагуудыг гүйцэтгэх эрх мэдлийн шинжтэй тусгайлсан чиг үүргийг хэрэгжүүлэгч, Засгийн газраас хараат бус, бие даасан, мэргэжлийн байгууллагууд гэж ойлгон зохих эрх зүйн орчныг бүрдүүлсэн нь харагдаж байна.¹⁶ Тухайлбал, захиргааны эрх зүйн талаас авч үзвэл Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д захиргааны байгууллага нь (1).нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэх, (2).бусдыг захирамжилсан шийдвэр гаргадаг, (3).нийтийн эрх зүйн этгээд байна.¹⁷ гэж тодорхойлсон байна.

Улмаар Захиргааны ерөнхий хуулийн 5.1.2-т “хууль тогтоомжийг биелүүлж, захирамжилсан шийдвэр гаргадаг Засгийн газрын бус бие даасан агентлаг, түүнтэй адилтгах нийтийн эрх зүйн бусад байгууллага” гэсэнд бие даасан байгууллагууд багтаж

¹⁰ Мөн тэнд, 7 дахь тал.

¹¹ Д.Одбаяр. *Үндсэн хуулийн үндсэн бүтцийн номлол. Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал (онол, арга зүй, хэрэгжилт)*. Уб., 2017, 103 дахь тал.

¹² Б.Чимид. *Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс*. Уб., 2006, 89 дэх тал.

¹³ *Жишээ нь*: АНУ-ын хувьд холбооны гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагуудын тогтолцоонд Ерөнхийлөгч, Департамент, Засгийн газрын корпорацууд хараат бус бие даасан агентлагууд болон бусад байгууллагууд багтдаг байна.

¹⁴ *Тухайлбал*, Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийг улс орон даяар эрхлэн явуулах процесст шаардлагатай зүйлсийг сонгуулийн төв байгууллага өөрөө мэдэж шийдвэрлэдэг. Энэ талаар судалгааны ажлын хэсэгт дэлгэрүүлэн үзэх болно.

¹⁵ Монгол Улсын Их Хурлын Тамгын газар. *Монгол Улсын Үндсэн хуулийн эх сурвалж*. Боть VIII, 194 дэх тал. *БНМАУ-ын АИХ-ын 1991.12.04-ний өдрийн хуралдааны протокол*. Б.Чимид. “Онцгой бүрэн эрх” гэдэг бол ач холбогдолтой үг. Энэ бол бусад байгууллага шийддэггүй асуудлыг хэнтэй ч хуваалцдаггүйг нь онцгой гэж байгаа юм. Хуваалцдагийг нь бол хуваалцах барих, харилцах нь бол мөн адил бусад бүрэн эрх гэж байгаа юм. Тийм учраас онцгой гэдэг бол хууль зүйн ач холбогдолтой үг. Өөрөөр хэлбэл цааш нь шилжүүлж болохгүй, манайхны ширүүхэн ярьдаг үүний төлөө Их хурлаас өөр хэн ч хариуцахгүй гэсэн үг.

¹⁶ Б.Хатантуул. *Монгол Улсын Их хурлаас байгуулагдааг хараат бус, бие даасан байгууллагууд (агентлаг)-ын эрх зүйн зохицуулалт*. Уб., 2005, 21 дэх тал.

¹⁷ Захиргааны ерөнхий хуулийн үзэл баримтлал нь эх газрын эрх зүйн системийн ойлголт, хандлагад тулгуурлан боловсруулагдсан бөгөөд Германы захиргааны эрх зүйн ойлголтыг чиг баримжаа болгож боловсруулагдсан болно.

Ц.Цогт. *Захиргааны хэргийн шүүх*. Уб., 2019, 135 дахь тал.

байна. Тухайлбал, Авлигатай тэмцэх газар, Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний аудитын газар, Төрийн албаны зөвлөл, Монголбанк, Сонгуулийн ерөнхий хороо, Хүний эрхийн комисс, Үндэсний статистикийн хороо, Нийгмийн даатгалын ерөнхий зөвлөл зэрэг зохицуулах чиг үүрэгтэй бие даасан байгууллагууд хамаардаг.

Засгийн газраас хараат бус шинжтэй, Улсын Их Хурлаас байгуулагддаг субъект (бие даасан агентлаг) нь мөн чанараараа гүйцэтгэх эрх мэдэлд хамаарна гэж судлаачид үздэг. Гэхдээ бие даасан байгууллагууд гүйцэтгэх эрх мэдлээс тусдаа байгуулагдаж, бүрэлдэхүүний, төсвийн, зохион байгуулалтын хувьд хараат бусаар ажиллана. Томилгоонд Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Улсын дээд шүүх зэрэг талуудын тэнцвэртэй оролцоо (санал болгох, зөвшилцөх, томилох)-г хангах замаар бие даасан, тэнцвэртэй, төвийг сахисан байдлыг баталгаажуулна.¹⁸

Дүгнэн үзвэл, бие даасан байгууллага нь “Засгийн газраас хараат бус, бие даасан байх”-ын тулд:

1. Парламентаас буюу Улсын Их Хурлын оролцоотойгоор байгуулагдаж, үйл ажиллагаагаа хуулийн хүрээнд ямар ч байгууллагын хөндлөнгийн оролцоогүй бие даан явуулж, Улсын Их Хуралд тайлангаа танилцуулдаг;

2. Төсвөөс санхүүждэг боловч бусад төсвийн байгууллагаас ялгаатай нь хараат бус байдлыг нь хамгаалах тодорхой зохицуулалт үйлчилнэ;

3. Удирдлага нь ихэвчлэн 5-6 жилийн хугацаатай /Улсын Их Хурал, Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанаас үл хамаарах байдлаар/-аар томилогддог байна.

Хоёр. Бие даасан байгууллагыг бүрдүүлэх буюу томилгооны тухай

Бие даасан байгууллагыг бүрдүүлэхэд Улсын Их Хурал дахь олонх болон түүний байгуулсан Засгийн газар давамгайл оролцоотой бол бие даасан байдал нь алдагдаж тал засаж ажиллах, улмаар парламентын сонгуульд ялсан нам, эвсэлд хяналтгүйгээр эрх мэдэл төвлөрч, төрийн эрх мэдэл хуваарилалт, хяналт, тэнцэл алдагдах, цаашлаад ардчилсан үндсэн хуульт байгуулал үгүй болох эрсдэл үүснэ.¹⁹ Венецийн комиссоос бие даасан байгууллагуудыг бүрдүүлэхэд “улс төржилтийг сааруулах” зарчим дагах нь зүйтэйг анхааруулсан байдаг. Иймээс, сонгон шалгаруулах, санал болгох, томилох процедур нь боломжит хэмжээнд намууд хоорондын зөвшилцөлд тулгуурлавал зохино. Парламентын олонхын давамгайллыг бууруулах эсхүл эрх баригч нам, эвсэлд харьяалагддаг хүнийг албан тушаалд томилох явдлыг хязгаарлах механизмыг бүрдүүлэх хэрэгтэй гэж үзсэн байдаг.²⁰

Бие даасан байгууллагыг бүрдүүлэхэд тэнцвэрийг хангах янз бүрийн арга хэлбэр байна. Тухайлбал:

(1) Парламент дийлэнх олонхын саналаар томилох;

(2) Олон цөөнхийн хувь тэнцүүлж томилох эсхүл тус тусад нь квот өгч томилох;

(3) Мэргэжлийн холбоо, иргэний нийгмийн байгууллага зэрэг бие даасан этгээдээс санал болгох гэсэн гурван аргаар бүрдүүлэх боломжтой гэж Венецийн комисс үздэг.

Харин Ардчилал болон сонгуулийг дэмжих олон улсын хүрээлэн дараах аргаар бие даасан байгууллагыг бүрдүүлэх боломжтой гэж зөвлөсөн байна:

(1) Олонх болон цөөнх хамтран томилох;

(2) Нэр дэвшүүлэх эсхүл томилох бүрэн эрхийг парламентад суудалтай болон бусад намд хувь тэнцүүлэн олгох;

¹⁸ Зарим бие даасан байгууллагыг бүрдүүлэхэд Ерөнхийлөгчийг оролцуулж байсан нь тэнцвэртэй, бие даасан бүрэлдэхүүн гаргахад чиглэж байсан ч энэ нь Ерөнхийлөгчид эрх мэдлийн хэт төвлөрлийг бий болгож, эрх мэдлийн хуваарилалт, хяналт, тэнцлийг алдагдуулж, Үндсэн хуулиар хүлээн зөвшөөрсөн парламентын тогтолцооны мөн чанарт тохиромжгүй байсан. 2019 онд Үндсэн хуулийн 33.4-т оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу Ерөнхийлөгч Үндсэн хуульд илэрхий нэрлэн заагаагүй бүрэн эрхийг хуулиар Ерөнхийлөгчид нэмж олгохыг хориглосон тул бие даасан байгууллагуудыг бүрдүүлэхэд Ерөнхийлөгч шийдвэрлэх буюу санал болгох, зөвшилцөх, томилох байдлаар оролцох боломжгүй болсон.

¹⁹ О.Мөнхсайхан. *Ерөнхийлөгч: Эрх зүйн байдал, бүрэн эрх*. Уб., 2022, 155 дахь тал.

²⁰ Parameters On The Relationship Between The Parliamentary Majority And The Opposition In A Democracy: A checklist,” Adopted by the Venice Commission at its 119th plenary Session (Venice, 21-22 June 2019), Opinion № 845/2016, CDL-AD, 2019.

- (3) Парламент дийлэнх олонхын саналаар томилох;
- (4) Нэг институт санал болгож өөр нэгэн институт томилох;
- (5) Томилгоо хийх үүргийг олон талын төлөөлөлтэй тусгай комисст хариуцуулах;
- (6) Бие даасан нэг байгууллага нь нөгөө бие даасан байгууллагаа томилох;
- (7) Шүүх эрх мэдлийн байгууллагаас томилох²¹ гэж тодорхойлсон байна.

Дээрх аргуудыг дангаар нь эсвэл хослуулж хэрэглэж болох бөгөөд арга тус бүр нь давуу сул талтай тул Монголын нөхцөлд аль нь илүү тохирохыг судалж үзэх нь чухал юм.

Монгол Улсын хувьд хараат бус, бие даасан байгууллагуудыг Үндсэн хуульд заасны дагуу Улсын Их Хурлаас байгуулдаг. Түүнчлэн хараат бус хяналтын байгууллагуудыг чиг үүргийнх нь хүрээнд парламентын хяналтад татан оролцуулах эрх зүйн механизмыг бүрдүүлэх²² нь чухал гэх хандлага сүүлийн үед давамгайлах болсон.

Дүгнэн үзвэл, бие даасан, хараат бус байгууллагыг бүрдүүлэхэд олон талын төлөөллийг оролцуулах, улс төрөөс хараат бусаар чиг үүргээ хэрэгжүүлэхээр зохицуулах шаардлагатай байна.

Гурав. Монгол Улс дахь бие даасан байгууллагын томилгооны эрх зүйн зохицуулалт, томилгоо

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6-д “Ерөнхий сайд, хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын бүрэлдэхүүнийг томилох, өөрчлөх, огцруулах”²³ гэж, мөн Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-т “Улсын Их Хурлын Байнгын хороо, Засгийн газар, хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын бүтэц, бүрэлдэхүүнийг тогтоох, өөрчлөх” гэж заасан. Энэ нь Үндсэн хуулиар Улсын Их Хуралд олгосон “онцгой бүрэн эрх”-д хамаарахаар заасан байна.²⁴

Мөн Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн²⁵ 108 дугаар зүйлд: “Хууль тогтоомжоор эрх олгогдсон этгээд Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын эрх бүхий албан тушаалтныг томилох, чөлөөлөх санал гаргасан бол тухайн саналыг 72 цагийн дотор Улсын Их Хурлын гишүүдэд хүргүүлнэ. Холбогдох Байнгын хороо ийнхүү хүргүүлснээс хойш ажлын гурван өдрийн дараа тухайн саналыг хэлэлцэж санал, дүгнэлт гаргана. Хуульд заасны дагуу, эсхүл гишүүдийн саналаар нэр дэвшигчийн сонголт явуулсан бол сонголтын тайлан гаргаснаас хойш ажлын таван өдрийн дотор Байнгын хороо хэлэлцэж санал, дүгнэлтдээ тухайн тайлангийн агуулгыг өөрчлөхгүйгээр тусгана.” гэсэн.

²¹ Eliot Bulmer. Independent Regulatory and Oversight (Fourth-Branch) institutions, international IDEA Constitution-Building Primer 19, 2019, 24-29 дахь тал.

²² Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн үзэл баримтлал. <https://forum.parliament.mn/projects/11162> сүүлд 2023.02.08-ны өдөр хандсан.

²³ Монгол хэлний их тайлбар толь бичигт “**томилох**” гэдэг үйл үгийн утгыг үйл ажилд хүний нэр зааж гаргах, ямар нэг ажил үүргийг гүйцэлдүүлэхээр нэр заан тушаах, ямар нэг албан тушаалд хэн нэгнийг нэр заан тавих; “**өөрчлөх**” гэдэг үгийг өөр ондоо болгох, хувиргах, өөрчлөлт шинэчлэлт хийх; “**огцруулах**” гэдэг үйл үгийг “**огцрох**” гэдэг үйл үгийн үйлдүүлэх хэв гээд эрхэлсэн албан тушаалаас буух, эрхэлсэн ажлаасаа хасагдан гарах, ажлаасаа халагдах гэж тус тус тайлбарлажээ. Харин Н.Лүндэндорж. Монгол Улсын Үндсэн хуулийн шинжлэх ухааны тайлбарт “**огцрох**”, “**огцруулах**” гэсэн ойлголт хоёул ямар нэг албан тушаалтан албан ажлаа орхихыг илэрхийлдэг хэдий ч “огцрох” нь тухай албан тушаалтан өөрийн санаачилга, хүсэл зорилгоор, харин “**огцруулах**” нь өөрийн санаачилга, хүсэл зоригийн гадуур албан тушаалаа орхихыг хэлдэг.

²⁴ Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь төсөл. *Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ*. Уб., 2016, 78 дахь тал.

²⁵ Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2020 оны №22 дугаарт нийтлэгдсэн.

Угтаа Парламентын засаглалын үндсэн шинж болох гүйцэтгэх засаглалыг сонгохоос гадна ард түмнээс сонгогдон гарч иргэн төрийн тэргүүнээс эхлээд гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд шууд холбоотой бус олон албан тушаалтыг томилох эрх мэдлийг Улсын Их Хурал Үндсэн хуулиас эх үндэстэй хэрэгжүүлдэг болсон. Засгийн газрыг сонсох үндэслэл нь ард түмнээс сонгогдсон парламентын хөтөлбөр, бодлогыг хэрэгжүүлэх явдал байдаг. Ийм учраас аливаа томилгоо, чөлөөлөхтэй холбоотой олон ашиг сонирхол үүсгэхгүй, гүйцэтгэх, хууль тогтоох засаглалын хооронд хяналт, тэнцвэрийн механизмаар хангагддаг.²⁶

Хүснэгт 1. Монгол Улс дахь бие даасан байгууллагын томилгооны талаарх лавлагаа

№	Томилогдох субъект	Санал болгох субъект	Томилох субъект	Бүрэн эрхийн хугацаа	Эрх зүйн эх сурвалж
1.	Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга	-Даргыг Монгол Улсын Ерөнхий сайд, -Дэд даргыг АТГ-ын дарга	Улсын Их Хурал	6 жил	Авлигын эсрэг хууль ¹
2.	Хүний эрхийн Үндэсний комиссын дарга, гишүүн	-Даргыг гишүүдийн дотроос Улсын Их Хурлын дарга -Нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр (5) -Нэр дэвшигч саналаа өөрөө гаргаж УИХ-ын ажлын хэсэг сонгон шалгаруулалт хийх -Хууль зүйн байнгын хороо санал оруулах	Улсын Их Хурал	6 жил	Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулга ²
3.	Сонгуулийн ерөнхий хорооны дарга, гишүүн	-УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороо (5) -Ерөнхийлөгч (2) -Улс дээд шүүх (2)	Улсын Их Хурал	6 жил	Сонгуулийн төв байгууллагын тухай хууль ³
4.	Монголбанкны Ерөнхийлөгч, тэргүүн дэд ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч	-Улсын Их Хурлын дарга, -Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч нарыг Монголбанкны Ерөнхийлөгч	Улсын Их Хурал	6 жил	Төв банк / Монголбанк/-ны тухай хууль ⁴

²⁶ П.Амаржаргал. *Парламентын бүрэн эрх: төлөвшил, хөгжлийн чиг хандлага*. Хууль зүйн ухааны докторын зэрэг горилсон диссертаци. МУИС-ийн Номын сан. Уб., 2016, 230 дахь тал.

5.	Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүн	-Улсын Их Хурлын Тамгын газар (1) -Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар (1) -Засгийн газрын Хэрэг эрхлэх газар (1) -Төрийн албан хаагчийн төлөөлөл (2)	Улсын Их Хурал	6 жил	Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга ⁵
6.	Монгол Улсын Ерөнхий аудитор	Улсын Их Хурлын дарга	Улсын Их Хурал	6 жил	Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулга ⁶
7.	Санхүүгийн зохицуулах хорооны дарга, гишүүн	-Улсын Их Хурлын дарга (1) -Эдийн засгийн байнгын хороо (2) -Хууль зүйн байнгын хороо (1) -Төсвийн байнгын хороо (1) -Засгийн газрын гишүүн (1) -Монголбанкны Ерөнхийлөгч (1)	Улсын Их Хурал	5 жил	Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай ⁷
8.	Нийгмийн даатгалын ҮЗ-ийн дарга, гишүүн	-Засгийн газар (3) -Даатгуулагч (3) -Ажил олгогч (3)	Улсын Их Хурал	6 жил	Нийгмийн даатгалын тухай хууль ⁸
9.	Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүн	-Монгол Улсын Ерөнхийлөгч (4) -Улсын Их Хурал (7) -Засгийн газар (4)	Улсын Их Хурал	6 жил	Олон нийтийн радио, телевизийн тухай хууль ⁹
10.	Үндэсний статистикийн хорооны дарга	Улсын Их Хурлын дарга	Улсын Их Хурал	6 жил	Статистикийн тухай хууль ¹⁰
11.	Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөл	-Засгийн газар (3) -Датгуулагч (3) -Ажил олгогч (3)	Улсын Их Хурал	5 жил	Эрүүл мэндийн даатгалын тухай хууль ¹¹
12.	Шүүхийн ерөнхий зөвлөлийн бус гишүүн	Нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр (5)	Улсын Их Хурал	4 жил	Монгол Улсын шүүхийн тухай хууль ¹²

Дээрх хүснэгтээс харахад үйл ажиллагааны шинж байдал, тогтолцоо, эрхлэх асуудлын хүрээнээс хамаарч томилгооны эрх зүйн зохицуулалт нь өөр хоорондоо харилцан адилгүй онцлогийг агуулж байна.

(1)Монголбанк, (2)Үндэсний статистикийн хороо, (3)Үндэсний аудитын газар нь улсын хэмжээнд босоо тогтолцоотой бол (4)Авлиагатай тэмцэх газар, (5)Хүний эрхийн үндэсний комисс, (6)Сонгуулийн ерөнхий хороо, (7)Санхүүгийн зохицуулах хороо, (8) Төрийн албаны зөвлөл, (9)Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөл, (10)Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөл, (11)Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөл, (12) Шүүхийн ерөнхий зөвлөл нь улсын хэмжээнд салбар нэгж байхгүй зөвхөн дээд шатны бүтэцтэй байна.

Судлаачийн хувьд Авлигатай тэмцэх газар, санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжилд дэмжлэг үзүүлэх үндсэн зорилтыг хэрэгжүүлдэг Монголбанк, өмнө нь 6 гишүүний бүрэлдэхүүнтэй, тэдгээрийн 2 нь орон тооны, 4 нь орон тооны бусаар үйл ажиллагаа явуулж байсан Төрийн албаны зөвлөл, 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтаар “Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно” гэсэн зохицуулалт хийгдсэн Төрийн аудитын байгууллага, өмнө нь Ерөнхийлөгч, УИХ-ын Хууль зүйн байнгын хороо, Улсын дээд шүүхийн саналыг үндэслэн Улсын Их Хурлын дарга Улсын Их Хуралд өргөн мэдүүлдэг байсныг өөрчилж, 6 гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр томилох болсон Хүний эрхийн Үндэсний Комисс, шүүх эрх мэдлийн байгууллага дахь бие даасан байгууллага болох Шүүхийн ерөнхий зөвлөл гэсэн 6 байгууллагын томилгоонд дүн шинжилгээ хийсэн бөгөөд доорх дүгнэлтэд хүрсэн болно.

1. Авлигатай тэмцэх газрын хувьд 2019.11.14-ний Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Үндсэн хуулийн 33.4-ийн анхны үзэл баримтлалыг нь сэргээн “Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрхийг зөвхөн энэ зүйлд заасан хүрээнд хуулиар олгож болно” гэж өөрчилсөн. Энэ өөрчлөлт нь Үндсэн хуулийн 33 дугаар зүйлд заасан хүрээнээс гадуур Ерөнхийлөгчид хуулиар ямар ч бүрэн эрх олгож болохгүй гэх тодорхой үзэл баримтлалаар орсон нь ийнхүү Авлигын эсрэг хуульд тусгалаа олсон.

Авлигатай тэмцэх газрын даргаас 2021 оны 06 дугаар сарын 14-ний өдөр Гаваасүрэнгийн Азжаргалыг Авлигатай тэмцэх газрын дэд даргын албан тушаалд томилуулах саналыг УИХ-ын даргад хүргүүлснээр Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 15 дугаар тогтоолоор томилгооны сонголын товыг тогтоож, 14 хоногийн турш олон нийтэд мэдээлж, холбогдох санал хүсэлтийг авсан. 2021 оны 07 дугаар сарын 06-ны өдөр Хууль зүйн байнгын хороо Авлигатай тэмцэх газрын дэд даргын албан тушаалд нэр дэвшигчийн томилгооны сонголыг зохион байгуулж, УИХ-ын нэгдсэн хуралдаанд танилцуулснаар Гаваасүрэнгийн Азжаргалыг томилох эсэх асуудлыг хэлэлцүүлэхэд чуулганы нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн 71.6 хувь нь дэмжин томилсон. Энэ нь Авлигатай тэмцэх газрын дарга анх удаа санал болгосноор, томилгооны сонгол хийн Авлигатай тэмцэх газрын Дэд даргыг томилсон нь томилгооны шинэ жишгийг тогтоосон байна.

2. Монголбанкны ерөнхийлөгчөөр ажилласан нийт 8 хүний нэг нь 6 жилийн бүрэн эрхийн хугацааг дуустал ажилласан, бусад долоо нь бүрэн эрхийн хугацаанаасаа өмнө чөлөөлөгджээ. Учир нь 1996, 2000, 2012, 2016 онуудын Улсын Их Хурлын ээлжит сонгууль болсны дараа Монголбанкны ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дуусаагүй байхад өөрийнх нь хүсэлтээр гэх шалтгаанаар чөлөөлсөн байна. Энэ дүр зураг Монголбанкны тэргүүн дэд ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч нарыг шинээр томилогдсон Монголбанкны Ерөнхийлөгч ажлаа авсны дараагаар өөрчлөхөөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, томилуулдаг жишиг тогтсон байна. Мөнгөний бодлогын тогтвортой байдлыг хангаж ажилладаг Монголбанкны удирдлагын томилгоо нь улс төрийн нөлөөллөөс ангид байж чадахгүй байна.

3. Төрийн албан зөвлөлийн хувьд орон тооны 5 гишүүний бүрэлдэхүүнтэй болсон бөгөөд Зөвлөлийн даргаар зөвлөлийн гишүүд дотроосоо нэр дэвшүүлэн саналаа нууцаар хурааж, олонхийн санал авсан хүнийг гурван жилийн хугацаагаар сонгож, Зөвлөлийн даргыг нэг удаа улируулан томилж болохоор зохицуулсан нь 2008 оноос хойших томилгооны дэвшилттэй зохицуулалт болсон байна.

“1995 оны Төрийн албаны тухай хуульд нэр дэвшигч нь төрийн албан тушаалд 10-аас доошгүй жил ажилласан, ял шийтгэлгүй, Монгол Улсын 35 нас хүрсэн иргэн байна. 2002 оны Төрийн албаны тухай хуульд нэр дэвшигч нь төрийн жинхэнэ албан тушаалд 15-аас доошгүй жил ажилласан, мэргэшсэн, ял шийтгэлгүй, 40 нас хүрсэн Монгол Улсын иргэн байна. 2018 оны Төрийн албан тухай хуулиар нэр дэвшигч нь төрийн жинхэнэ албан тушаалд 15-аас доошгүй жил ажилласан, төрийн удирдлага, эдийн засаг, эрх зүй, боловсролын чиглэлээр мэргэшсэн дээд боловсролтой, ял шийтгүүлж байгаагүй, 45 нас хүрсэн Монгол Улсын иргэн байна” гэсэн бөгөөд төрийн албаны зөвлөлийн гишүүний насыг 45 болгож, төрийн удирдлага, эдийн засаг, эрх зүй, боловсролын чиглэлээр мэргэшсэн байхыг гол үндэслэл болгосон байна.

4. Монгол Улсын Ерөнхий аудиторын томилгооны хувьд Улсын Их Хурлын ээлжит сонгууль болсны дараа 2012, 2016 онд Ерөнхий аудиторыг бүрэн эрхийн хугацаа нь дуусаагүй байхад чөлөөлсөн байна. Монгол Улсын Ерөнхий аудиторыг Улсын Их Хурлаас томилдог нь томилсон байгууллагаас хараат байх нөхцөл бий болохыг үгүйсгэхгүй... Шүүмжлэлтэй хандахад Улсын Их Хуралд олонхын суудалтай нам, бүлэглэлийн сонирхол энэ томилгоонд илүү давуу байдлаар нөлөөлөх боломжтой. ...ерөнхий аудиторын томилгоо эрх баригч намын бэлэг байж болохгүй. Эс тэгвээс хоточ нохойтой болохыг хулгайчаас хүссэнтэй адил болно. Түүнчлэн, Ерөнхий аудиторын томилгооны асуудлыг улс төрөөс ангид байлгах буюу зөвхөн улс төрийн нэг институт(парламент)-ээс хамааралтай биш байдлаар томилогдох, чөлөөлөгдөх нөхцөлийг бүрдүүлсэн эрх зүйн орчинг бий болгох шаардлагатай гэж үзэж байна.

Одоогийн Ерөнхий аудиторыг томилж байгаа томилгоог өөрчилж, Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгээс нэр дэвшүүлж, нээлттэй сонголын үндсэн дээр томилох нь зүйтэй гэсэн саналыг дэвшүүлж байна. Ингэж чадвал 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр тусгасан “Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх” хөндлөнгийн хяналтыг бий болгох боломжтой байж болох юм.

5. ХЭҮК-ын тухайд томилгооны эрх зүйн зохицуулалт нь нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн явагддаг болсон нь бие даасан агентлаг үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэх боломжийг бий болгосон байна. Харин ХЭҮК-ын тухай 2020 оны хуулийн 13.4-т зааснаар “гишүүдийн дотроос Улсын Их Хурлын даргын санал болгосноор зургаан жилийн хугацаагаар Улсын Их Хурал нэг удаа томилно”. ХЭҮК-ын даргыг гурван жилээр биш, харин зургаан жилээр нэг удаа томилохоор өөрчилсөн нь түүний бие даасан байдлыг өмнөх томилгооноос дээрдүүлэх боловч ХЭҮК-ын даргыг УИХ-ын дарга санал болгож, УИХ томилсон хэвээр байгаа нь УИХ-ын дарга, УИХ-ын олонхоос Комиссыг хэт хамааралтай байлгасан хэвээр байна. Харин олон улсын сайн туршлагын дагуу ХЭҮК-ын даргыг гишүүд дотроосоо сонгодог бол Комиссын бие даасан байдал хангагдахад тустай байх байсан.

6. Шүүхийн ерөнхий зөвлөл нь шүүх эрх мэдэл дэх бие даасан байгууллага болохын хувьд 2021 оноос өмнөх томилгоонуудаас ялгарах онцлог нь олон талын төлөөллийг оролцуулан томилгоог нийт шүүгчдийн хуралдаан болон нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр 10 гишүүнийг 4 жилийн хугацаагаар ганцхан удаа томилогддог болсон. Мөн Зөвлөлийн даргаа 1 жилийн хугацаатайгаар гишүүд дотроосоо сонгодог болсон нь байгууллагын дотоод ардчиллыг бий болгосон хараат бус, бие даасан агентлагийн томилгоотой холбоотой сайн жишгийг бий болгосон байна.

Дөрөв. Томилгоо дахь Улсын Их Хурлын даргын оролцоо

Улсын Их Хурлын даргын албан тушаал бие даасан байгууллагын удирдлагын томилгоонд ихээхэн оролцоотой эрх зүйн зохицуулалттай байна. Улсын Их Хурлын дарга, дэд даргыг Улсын Их Хурлын гишүүдийн дотроос нэр дэвшүүлэн саналаа илээр гаргаж сонгоно. Улсын Их Хурлын тухайн сонгуулийн дүнд бий болсон нам, эвслийн бүлэг тус бүрээс Улсын Их Хурлын дэд даргыг сонгоно.²⁷ Улсын Их Хурлын дарга, дэд дарга нь Улсын Их Хурлаас дөрвөн жилийн хугацаагаар сонгогддог.

Улсын Их Хурлын даргын бүрэн эрхийг бусад хууль тогтоомжоор олгосон бүрэн эрхээс гадна Улсын Их Хурлын тухай²⁸ хуулийн 14 дүгээр зүйлд заасан. Тухайлбал, “Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллага хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, тэдгээрийн үйл ажиллагаанд Улсын Их Хурлаас тавих хяналтыг зохион байгуулах; ...Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын даргад дотоод, гадаад томилолт олгох, түүний журмыг баталж мөрдүүлэх; хуульд заасан үндэслэлээр Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга, дэд даргыг томилох, чөлөөлөх санал гаргаж Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх;” гэж заасан.

Түүнээс гадна доорх нэр бүхий хуульд зааснаар Улсын Их Хурлын дарга нь 8 байгууллагын удирдлагыг томилуулахаар санал болгож, тэднийг Улсын Их Хурал томилж, чөлөөлөхөөр зохицуулжээ.

Хүснэгт 2. Улсын даргын санал болгож буй томилгооны бүрэн эрх

№	Хуулийн нэр	Зохицуулалтын агуулга
1.	Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссын тухай хууль	13.4.Комиссын даргыг гишүүдийн дотроос Улсын Их Хурлын даргын санал болгосноор зургаан жилийн хугацаагаар Улсын Их Хурал нэг удаа томилно.
2.	Сонгуулийн байгууллагын тухай хууль	4.3.Хорооны дарга, нарийн бичгийн даргыг Хорооны гишүүдийн дотроос Улсын Их Хурлын даргын санал болгосноор Улсын Их Хурал томилно.
3.	Төв банк / Монголбанк/-ны тухай хууль	26 дугаар зүйл. Монголбанкны удирдлага 1.Монголбанкийг Улсын Их Хурлаас томилогдсон Ерөнхийлөгч толгойлж үйл ажиллагаагаа Улсын Их Хурлын өмнө хариуцан тайлагнана. Монголбанкны Ерөнхийлөгчийг Улсын Их Хурлын даргын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонголт хийж зургаан жилийн хугацаагаар томилно.
4.	Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулга	28 дугаар зүйл. Монгол Улсын Ерөнхий аудитор 28.1.Монгол Улсын Ерөнхий аудиторыг Улсын Их Хурлын даргын санал болгосноор Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонголт хийж зургаан жилийн хугацаагаар томилох бөгөөд түүнийг нэг удаа улируулан томилж болно.
5.	Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай	11 дүгээр зүйл. Хорооны дарга, гишүүн, түүнийг томилох 11.2.Хорооны даргад Улсын Их Хурлын дарга, ...нэр дэвшүүлж, Улсын Их Хурлаас нэр дэвшигчийн сонголт хийж томилно.

²⁷ Үндсэн хуулийн Хорин дөрөвдүгээр зүйлийн 1.

²⁸ Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2020.10.22-ны өдрийн №22 дугаарт нийтлэгдсэн.

6.	Статистикийн тухай хууль	13 дугаар зүйл. Үндэсний статистикийн хорооны удирдлага 1.Үндэсний статистикийн хорооны даргыг Монгол Улсын Их Хурлын даргын санал болгосноор Улсын Их Хурлаас нэр дэвшигчийн сонголт хийж зургаан жилийн хугацаагаар томилно.
7.	Улсын Их Хурлын тухай хууль	14 дүгээр зүйл. Улсын Их Хурлын даргын бүрэн эрх 14.1.19.Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх санал гаргаж Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх; 45 дугаар зүйл. Ерөнхий нарийн бичгийн дарга 45.2.Ерөнхий нарийн бичгийн дарга хууль зүйн өндөр мэргэшилтэй, төрийн албаны удирдах ажлын туршлагатай байх бөгөөд түүнийг Улсын Их Хурлын даргын санал болгосны дагуу Улсын Их Хурал томилж, чөлөөлнө. Төрийн албаны тухай хуульд заасан сонгон шалгаруулах журам Ерөнхий нарийн бичгийн даргыг томилоход хамаарахгүй.
8.	Ирээдүйн өв сангийн тухай хууль	15 дугаар зүйл. Хяналтын зөвлөл 15.5.2.Монгол Улсын Их Хурлын даргын сонгосон санхүү, эдийн засгийн судалгаа, шинжилгээний туршлагатай, нийгэмд үйлчлэх гурав хүртэлх төрийн бус байгууллагаас;

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Улсын Их Хурлын дарга Улсын Их Хурлын чуулганыг товлон зарлаж, даргална (Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 4 дэх хэсэг). Ерөнхийлөгчийн нэг адил тэрээр онцгой чуулганыг зарлан хуралдуулж болно (Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 3 дахь хэсэг). Мөн хуульд заасан шалтгаанаар Ерөнхийлөгчийн түр эзгүйд бүрэн эрхийг нь хэрэгжүүлэхийн зэрэгцээ Ерөнхийлөгч бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон бол бүрэн эрхийг нь шинэ Ерөнхийлөгч сонгогдох хүртэл хэрэгжүүлнэ (Үндсэн хуулийн Гучин долдугаар зүйл) гэж заасан. Энэ бол Үндсэн хуулиар Улсын Их Хурлын даргад олгосон бүрэн эрх. Төвчхондоо бол УИХ-ын дарга нь Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг сахиулах, хуралдаан удирдах, хуралдаан зарлан хуралдуулах субъект байна.

ДҮГНЭЛТ

Монгол Улсын Үндсэн хуулиар Улсын Их Хуралд олгосон “онцгой бүрэн эрх”-д хамаарах бие даасан байгууллагын удирдлагын томилгоог хийхдээ аль болох олон талын төлөөллийг оролцуулах, улс төрөөс хараат бусаар чиг үүргээ хэрэгжүүлэх байдалд анхаарч эрх зүйн зохицуулалтыг хийх шаардлагатай байна. Түүнчлэн, Бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон албан тушаалтныг ямар хугацаанд, хэн сонгон шалгаруулах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь зүйтэй байна.

Мөн Улсын Их Хурлын дарга бусад хууль тогтоомжоор олгосон бүрэн эрхийн хүрээнд бие даасан байгууллагын удирдлагыг томилуулах, чөлөөлөх санал гаргах нь Үндсэн хуулиар олгогдоогүй бүрэн эрхийг Улсын Их Хурлын нэрийн өмнөөс ганцаараа хэрэгжүүлдэг болсон муу жишиг тогтсон байна. Энэ асуудал нь Монгол Улсын Үндсэн хуулиар Улсын Их Хуралд олгосон онцгой бүрэн эрх болох “хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын бүрэлдэхүүнийг томилох, өөрчлөх, огцруулах”-тай зөрчилдөж, эрх мэдэл хуваарилах зарчмыг алдагдуулах эрсдэлийг үүсгэж, бие даасан байгууллагыг бүрдүүлэх олон талын оролцоог хангах, томилгооны хараат бус байдлыг үгүйсгэсэн бөгөөд Улсын Их Хурлын даргад хэт их эрх мэдлийг салбар хуулиудаар олгосон байгааг өөрчлөх шаардлагатай байна.

ЭХ СУРВАЛЖ**Монгол хэл дээрх*****Хууль тогтоомж***

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992.
2. Авлигын эсрэг хууль, 2006.
3. Захиргааны ерөнхий хууль, 2015.
4. Монгол Улсын Их Хурлын тухай хууль, 2020.
5. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, 2020.
6. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссын тухай хууль, 2020.
7. Монгол Улсын шүүхийн тухай хууль, 2021.
8. Нийгмийн даатгалын тухай хууль, 1994.
9. Олон нийтийн радио, телевизийн тухай хууль, 2005.
10. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, 2005.
11. Статистикийн тухай хууль, 1997.
12. Сонгуулийн төв байгууллагын тухай хууль, 2006.
13. Төв банк /Монголбанк/-ны тухай хууль, 1995.
14. Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга, 2017.
15. Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулга, 2020.
16. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, 2015.

Ном, өгүүлэл, судалгааны тайлан

1. П.Амаржаргал. Парламентын бүрэн эрх: төлөвшил, хөгжлийн чиг хандлага. Хууль зүйн ухааны докторын зэрэг горилсон диссертаци. Уб., 2016.
2. П.Баттулга, Б.Төрболд нар. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын зарим зохицуулалтад хийсэн хэрэгжилтийн мониторинг. Судалгааны тайлан. “Оюуны-Инноваци” ТББ, Иргэдийн оролцоо төсөл. Уб., 2021.
3. Захиргааны хэргийн шүүх “Монгол дахь шинэчлэл, дэлхийн улсуудын жишиг” Ханнс-Зайделийн сан. Уб., 2004.
4. Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн тайлбар. (судалгаа, хэрэглээний). Анхны хэвлэл. Уб., 2017.
5. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн үзэл баримтлал. <https://forum.parliament.mn/projects/11162> сүүлд 2023.02.08-ны өдөр хандсан.
6. Монгол Улсын хүний эрхийн Үндэсний комиссын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн судалгааны тайлан. Уб., 2018.
7. О.Мөнхсайхан. Ерөнхийлөгч: Эрх зүйн байдал, бүрэн эрх. Уб., 2022.
8. Р.Мухийт. Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн эрх зүйн зохицуулалтын тулгамдсан асуудал. “Хууль дээдлэх ёс” сэтгүүл. 2013, №2.
9. С.Нарангэрэл. Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь. Анхны хэвлэл. Уб., 2021.
10. Д.Одбаяр. Үндсэн хуулийн үндсэн бүтцийн номлол. Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал (онол, арга зүй, хэрэгжилт). Уб., 2017.
11. П.Одгэрэл. Захиргааны эрх зүйн ерөнхий анги. Уб., 2008.
12. Оюуны-Инноваци ТББ. Төрийн аудитын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ. Уб., 2019.
13. Б.Хатантуул. Монгол Улсын Их хурлаас байгуулагддаг хараат бус, бие даасан байгууллагууд (агентлаг)-ын эрх зүйн зохицуулалт. Уб., 2005.
14. Ц.Цогт. Захиргааны хэргийн шүүх. Уб., 2019.

15. Б.Чимид. Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс. Уб., 2006.
16. Д.Энхцэцэг. Шударга сонгууль: сонгуулийн зохион байгуулалтын зарим асуудал. Нээлттэй Нийгэм Форум. Бодлогын асуудал. Уб., 2010.
17. “Эрх зүйн боловсрол” академи, Хансс Зайделийн сан. Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ.судалгааны тайлан. Уб., 2018.
18. Трой Сонненберг, Д.Энхцэцэг нар. Нээлттэй сонгол: Бодлого боловсруулах үйл явцад оролцох иргэдийн гарын авлага. Уб., 2009, Нээлттэй Нийгэм Форум

Гадаад хэл дээрх

Ном, өгүүлэл, судалгааны тайлан

1. Eliot Bulmer. Independent Regulatory and Oversight (Fourth-Branch) institutions, international IDEA Constitution-Building Primer 19, 2019.
2. International IDEA. Electoral Management Design. (2014), Bulls Graphics, Sweden.
3. Parameters On The Relationship Between The Parliamentary Majority And The Opposition in A Democracy: A checklist.

LEGAL REGULATIONS REGARDING THE APPOINTMENT TO THE INDEPENDENT AGENCIES

Turbold.B (LL.M)

ABSTRACT:

Article 5.1.2 of the General Administrative Law states that “an independent non-governmental agency that complies with the legislation and makes administrative order, and other public organization similar to it”. In this way, the organizations specified in Article 5.1.2 of the General Administration Law include independent agencies that exercise the executive power of the state, are established separately from the executive power, require independent work in terms of composition, budget, and organization, and are established by law and have regulatory functions.

KEYWORDS:

Independent agencies, Legal regulations regarding the appointment, parliament of Mongolia, General administrative law.

ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭХЭЭС ТАТГАЛЗУУЛАХ КРИМИНОЛОГИЙН ОНОЛ (DETERRENCE THEORY): ӨСВӨР НАСНЫ ХҮН



Д.Нямбат

*Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх
Сургалт, судалгааны хүрээлэнгийн
хяналтын прокурор*

ТОВЧЛОЛ:

Криминологийн шинжлэх ухаан нь гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг тодорхойлох, урьдчилан сэргийлэх онол, сургаал, аргуудаас бүрддэг. Тэр дундаа өсвөр насны хүнийг гэмт хэрэг үйлдэхээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар онолын үндэслэлтэй судалгаа хийгдэж, тогтоогдсон үр дүнд нь суурилсан эрх зүйн зохицуулалт, бодлого, хөтөлбөрүүд бий болдог. Эрүүл мэндийн салбарт аливаа өвчнөөс урьдчилан сэргийлж буй аргуудыг гэмт хэрэг үйлдэхээс татгалзуулан урьдчилан сэргийлэх аргуудтай холбон тайлбарлахыг зорилоо.

ТҮЛХҮҮР ҮГС

Криминологийн шинжлэх ухаан, онол, нийгмийн шинжлэх ухаан, гэмт хэрэг үйлдэхээс татгалзуулах, эмээлгэх, ял шийтгэл, эрүүл мэнд, өвчтөн, өсвөр нас, эрсдэл, арга, урьдчилан сэргийлэх

УДИРТГАЛ

Энэхүү нийтлэлд Криминологийн шинжлэх ухааны “Гэмт хэрэг үйлдэхээс татгалзуулах онол”-оор өсвөр насны хүүхдийг гэмт хэрэг үйлдэхээс хэрхэн урьдчилан сэргийлэх асуудлыг дэвшүүлсэн нь дараах бүтэцтэй болно. Үүнд:

- Криминологийн шинжлэх ухааны онолын ерөнхий ойлголтын талаар
- Криминологийн шинжлэх ухааны татгалзуулах онолын талаар
- Өсвөр насны хүнийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд криминологийн шинжлэх ухааны татгалзуулах онол болон эрүүл мэндийн салбарт ашиглагдаж байгаа аргуудтай холбон тайлбарлах нь
- Дүгнэлт

Нэг. Криминологийн шинжлэх ухааны онолын ерөнхий ойлголтын талаар

Криминологийн шинжлэх ухаан нь нийгмийн шинжлэх ухааны нэг хэсгийнхээ хувьд хүний зан чанар болон нийгмийн нөхцөл байдлыг тайлбарлан ойлгоход тусалдаг. Яагаад хүмүүс хууль, дүрэм, нийгмийн болон ёс суртахууны хэм хэмжээг сахин биелүүлж эсвэл

зөрчиж байдаг тухай судалж мэддэг тул чөлөөт сэтгэлгээний боловсролын салшгүй нэг хэсэг юм.

Иймд гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн төрийн бодлого, хууль тогтоомж, төсөл хөтөлбөрүүд боловсруулахдаа заавал онолын үндэслэлтэй байх ёстой юм. Криминологийн шинжлэх ухаанд хууль боловсруулах, хуулийг хэрхэн сахин биелүүлэх болон хуулийг хэрхэн зөрчиж буй нөхцөл байдлыг тайлбарлаж байдаг хэдэн арван онолууд бий бөгөөд аливаа асуудлыг макро болон микро түвшинд судална¹.

Тухайлбал, макро түвшинд өөр хоорондоо ялгаатай нийгэм, эрх зүйн бүлийн ялгаатай байдлууд, үндэстэн ястны гэмт хэргийн гаралт, нөхцөл байдлыг судална. Жишээ нь: Монгол Улсын Эрүүгийн хуульд цаазаар авах ял байхгүйн дээрээс тухайн хүн хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн бол нэг төрлийн ялыг нэмж нэгтгэн нэгтгэсэн ялын нийт хэмжээ нь тухайн бүлэгт заасан хамгийн хүнд ялтай гэмт хэргийн хорих ялын дээд хэмжээнээс хэтэрч болохгүй гэж заасан байдаг². Ингэхээр Эрүүгийн хуулийн нэг бүлэгт заасан хэд хэдэн гэмт хэргийг үргэлжилсэн үйлдлээр үйлдсэнийг нэмж нэгтгэсэн ч тухайн гэмт хэрэгт нь тохирохгүй хөнгөдөх тохиолдолууд гарч байна.

Эсрэгээрээ Англо-Саксоны эрх зүйн бүлд хамаарагдах орнууд гэмт хэрэг тус бүрд нь ял оногдуулах, тэр нь хүний биологийн боломжит наслах наснаас л илүү тэр ч бүү хэл хэдэн 100 жилийн хорих ял оногдуулах боломжтой байдаг. Өөрөөр хэлбэл, эрх зүйн аль бүлд хамаарах ямар орны ялын бодлого нь гэмт хэрэг үйлдэхээс татгалзуулах үр дүнтэй байгааг судлах нь макро түвшний судалгааны нэг хэлбэр юм.

Мөн өнгөт арьстай хүмүүс эсвэл цагаан арьстай хүмүүсийн хэн нь илүү их хар тамхины хэрэглээтэй, зохион байгуулалттай гэмт бүлэглэлд хамаардаг, худалдан борлуулдаг вэ гэдгийг арьсны өнгөөр нь ялган судлах нь макро түвшний судалгаа гэсэн үг.

Харин микро түвшинд хувь хүмүүсийн ялгаа, нийгмийн амьдралаас шалтгаалсан үзэгдэл, тодорхой төрлийн гэмт хэргийг сонгон авч судалдаг.

Дээрх хоёр түвшинд хийгдэх судалгаануудын зорилго нь нэг л бөгөөд ямар хууль, тогтоомж, илүү хэрэгтэй, эсвэл шаардлагагүй болохыг маш үндэслэлтэйгээр хөндөж чаддаг. Гэхдээ философиин дүгнэлтүүд шиг яг тийм байх ёстой гэж хэлдэггүй. Иймд криминологийн онолыг үнэлж дүгнэх, бусад нийгмийн шинжлэх ухааны онолтой нь харьцуулах, логик уялдаа холбоо, цар хүрээ, практик үр дүн, туршилтын үр дагавар зэргийг харьцуулсны үндсэн дээр ашиглах нь зүйтэй байдаг. Эдгээр хүчин зүйлсийг заавал ч үгүй анхаарч, дүн шинжилгээ хийсний үр дүнд хууль тогтоомж болон түүний хэрэгжилтийг замчлах боломж бүрдэх юм.

Криминологийн шинжлэх ухааны онолууд өөр өөрийн онцлогтой байдаг ба заримаас нь жишээлэн дурдвал:

- Deterrence theory-татгалзуулах, эмээлгэх онол нь бүх төрлийн гэмт хэргийг судлахад ашиглах боломжтой.
- Labeling theory- хаяглах, шошголох онол нь рецедив гэмт хэрэгтний дахин дахин гэмт хэрэг үйлдээд байгаа шалтгааныг тайлбарлахад түлхүү ашиглагдана.
- Social control theory- нийгмийн хяналтын онол нь гэр бүлийн хүчирхийллийг судлахад голчлон ашиглагдана.
- Strain theory -ачааллын (дарамт) онол нь авлига, албан тушаал, залилах, дээрэмдэх, хулгайлах, завших гэмт хэргийн учир шалтгааныг тайлбарлахад хэрэглэгдэнэ.
- Routine activity theory-давтагдах хөдөлгөөний онолыг хулгайлах болон цахим гэмт хэргийн судлахад ашиглах боломжтой гм. Голчлон, түлхүү гэсэн нь тухайн төрлийн гэмт хэргийг, гэмт этгээдийг судлахад зөвхөн дээрх нэг л аргыг ашиглана гэсэн үг биш бөгөөд

¹ Kristine Levan, David A. Mackey (2015 он), “Нийгмийн болон Зан үйлийн шинжлэх ухааны олон улсын нэвтэрхий толь”, хоёр дахь хэвлэл, цахим эх сурвалж: <https://www.sciencedirect.com/topics/social-sciences/criminology-theory#:~:text=Deterrence%20theory%2C%20the%20most%20prominent,the%20likely%20costs%20of%20crime>.

² 2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.8 дугаар зүйлийн 3 болон 4 дэх хэсэг.

нэг үзэгдлийг хэд хэдэн арга хослуулан, эсвэл дээр дурдсанаас өөр арга ч ашиглаж судлах боломжтой байдгийг анхаарах нь зүйтэй.

Дээрх онолуудыг үр ашигтайгаар хэрэглэж чадвал аливаа гэмт хэргийг ул суурьтай, тухайн гэмт хэргийн гаралтыг тодорхой хувиар бууруулж чадах үр дүн бий болгосон санал, зөвлөмж бүхий судалгааг онолын үндэслэлтэй бий болгодог. Криминологийн шинжлэх ухааны арга нь бусад нийгмийн шинжлэх ухааны аргуудын адилаар ерөнхийгөөс тусгай руу нарийсах, хувьсагчид тулгуурлаж үр дүн нь бий болгох, хоёр эсвэл түүнээс олон үйл явдлыг харьцуулах, харилцаа хамааралтай эсэхийг холбон тайлбарлаж чаддаг. Криминологийн онол нь үйл явдал ямар байх ёстойг хэлж өгдөг хариулт биш боловч гэмт хэрэг болон нийгмийг философич, шашинлаг, биологи, сэтгэл зүй, метафизикийн системийн итгэл үнэмшил, мөн чанарт үндэслэн тайлбарладаг³.

Хоёр. Криминологийн шинжлэх ухааны татгалзуулах онолын талаар

Гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс татгалзуулах маш олон төрлийн арга бий. Жишээ нь: цагдан хорих, баривчлах зэрэг нь сэтгэл зүйд нөлөөлж айлгах, тээврийн хэрэгслийн хурд хэтрүүлсэн торгууль, түүнийг дагаад даатгалын төлбөр өсөх зэрэг нь дахин гэмт хэрэг, зөрчил үйлдүүлэхгүй байхад чиглэсэн эдгээр арга хэмжээг татгалзуулах онолын хэсэг юм.

Уг онолын гол агуулга нь аливаа хүн гэмт үйлдэл хийх, эрсдэлтэй шийдвэр гаргах нь тухайн этгээдийн хийх нь зүйтэй юм, оновчтой юм гэж үзсэн өөрийнх нь чөлөөт сонголт гэж үздэг. Энэ нь ихэвчлэн Эрүүгийн хуульд заасан ял шийтгэлийн төрөл, хэмжээтэй холбогддог бөгөөд гэмт этгээд ял шийтгэлийн хэмжээ, төрлийг дэнслэхийн зэрэгцээ баригдах эрсдэлээ бас тооцож үзэх ба хэрвээ гэмт этгээд нь хуульд заасан ял шийтгэл нь гэмт хэрэг үйлдэж ашиг хонжоо олохоос илүүтэй намайг зовоох юм байна гэж тооцвол тухайн хүн гэмт хэрэг үйлдэхгүй байх сонголтыг хийнэ гэж сургадаг. Улмаар 1/ял шийтгэл тодорхой байх, 2/хатуу чанга байх, 3/гомдол мэдээллийг бүртгэснээс эхлүүлээд шүүхээр ял оногдуулах хүртэлх процесс түргэн шуурхай байх гэсэн зарчмыг баримтлан тухайн этгээдийг дахин гэмт хэрэг үйлдэхээс болон бусад хүмүүсийг ч гэмт хэрэг үйлдэхээс татгалзуулах боломжтой гэж сургадаг.

Иймд Эрүүгийн хуулийн ял шийтгэлийн нэн тэргүүний зорилго бол гэмт хэрэг үйлдсэнийх нь дараа ял шийтгэл эдлүүлж цээрлүүлэх, ял эдэлж байхад болон дууссаных нь дараа нийгэмшүүлэх, эсвэл хохирол нөхөн төлүүлэх гэхээсээ илүүтэй гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлж айлгах явдал юм. Учир нь бусад зорилгуудаас энэрэнгүй шинжтэй гэж хэлж болно. Гэмт хэрэг үйлдэхээс татгалзуулах онолыг судлан, үзэл сургаалтай манай улсын Эрүүгийн хуультай дараах байдлаар уялдахгүй байна. Жишээ нь:

1. Ялтай байдал буюу урьд нь шийдвэрлэсэн хэргийг сөхөж, ял шийтгэл оногдуулахдаа харгалзан үздэг байдлыг эргэж бий болгосон зохицуулалтыг хулгайлах гэмт хэргийн шинжид тусгаж өгснөөр гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдийг гэмт хэрэг үйлдэхээс айлган татгалзуулах боломжтой. Урьд ял шийтгүүлсэн этгээд ял эдэлж дууссанаас хойш тодорхой хугацаа өнгөрөх хүртэл гэмт хэрэг шинээр үйлдэхгүй байх нь түүнд ашигтай тул түүнийг дахин гэмт хэрэг үйлдэхээс татгалзуулж чадах хүчин зүйл нь “ялтай байдал” гэдэг ойлголтыг тусгаж өгөх арга бий боловч энэ нь шинэчлэн найруулсан 2015 оны Эрүүгийн хуульд нэг төрлийн гэмт хэргийг 2 ба түүнээс дээш удаа үйлдсэн тохиолдолд гэмт хэргийг давтан үйлдсэн шинжээр нь хүндрүүлэн зүйлчлэхийг хассан шударга ёс, тэгш эрхийн зарчимтай зөрчилдөх тул хууль тогтоогчоос давтан гэмт хэрэг, ялтай байдал гэсэн ойлголтуудыг Эрүүгийн хуульд тусгаж өгөөгүй юм. Энэхүү хүндрүүлэн зүйлчлэх асуудлыг Эрүүгийн хуулийн 6.6 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэгт заасан нэг бүлэгт заасан санаатай гэмт хэргийг хоёр, түүнээс дээш үйлдсэн бол хүндрүүлэх нөхцөл байдалд тооцдог зохицуулалттай хольж ойлгож болохгүй. Жишээ нь: 2015 оны Эрүүгийн хуульд хулгайлах гэмт хэрэгт оногдуулах хорих ялын хугацаа 2002 оны Эрүүгийн хуультай харьцуулахад

³ Ronald L Akers, Christine S. Sellers, and Wesley G. Jennings (2017), “Криминологийн онолууд” номны долоо дахь хэвлэл.

чангарсан боловч тухайн гэмт хэргийн гаралт өссөөр байгаа нь гэмт этгээдийн гэмт үйлдэл хийх тухай шийдвэр гаргахад нөлөөлөхгүй байгааг илэрхийлж байна⁴.

2. Эрүүгийн хуульд хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулах зохицуулалтыг тусгаж өгөхдөө “хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулахдаа гэмт хэрэг тус бүрд ял оногдуулж нэмж нэгтгэн нийт эдлэх ялын төрөл, хэмжээг тогтооно” гэж үйлдэл тус бүрд ял оногдуулж, ялыг нэмж нэгтгэж нийт эдлэх ялыг тогтоож өгөх зохицуулалт бий. Гэвч жишээлбэл, олон дүүрэг, аймаг дамжсан хэдэн 100 удаагийн үйлдэлтэй залилах, хулгайлах гэмт хэрэгт Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар “энэ хуулийн тусгай ангид заасан нэг гэмт хэргийн шинжийг хэд хэдэн удаагийн үйлдэл, эс үйлдэхгүйгээр хангасан байвал үргэлжилсэн нэг гэмт хэрэг үйлдсэнд тооцно” гэсэн заалтаас шалтгаалж гэмт хэрэг тус бүрд ял оногдуулах заалт хэрэгжихгүй байна⁵. Ингээд тухайн этгээд бусдын орон байранд нэвтрэн хулгайлах гэмт хэргийг 100 удаа үйлдсэн ч 2-8 жил, 1 удаа үйлдсэн ч 2-8 жилийн хорих ял оногдуулж буй нь шударга, зөв шийдэл бишээс гадна гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ялын зорилгод нийцэхгүй зохицуулалт болжээ.

Харин АНУ-д 2009 онд залилах гэмт хэрэгт 150 жилийн, цуврал аллага үйлдсэн этгээдэд 835, 957, 10.0000 жилийн, Испани Улсад залилах гэмт хэрэгт 2000 жилийн, 2004 онд Израйл Улсад 63 хүнийг тэсрэх бөмбөгөөр алсан этгээдийг 63 удаагийн бүх насаар нь / 1 удаа нь 25 жилтэй тэнцэнэ/ буюу 1575 жилийн, 1996 онд 35 хүнийг алсан этгээдийг 35 удаагийн бүх насаар нь буюу 875 жилийн хугацаагаар хэзээ ч тэнсэж суллахгүй, эргэлт оруулахгүй нөхцөлтэйгөөр хорих ял шийтгэж байсан олон жишээнээс үзэхэд энэ нь гэмт хэрэг тус бүрд ял оногдуулж түүнийгээ нэмэх хэлбэрээр хүний амьд байх боломжтой биологийн насны хязгаараас хэтэрсэн хугацаагаар ял шийтгэсэн байна⁶. Яагаад гэвэл түүний үйлдсэн гэмт хэрэг бүрийн ард хохирсон иргэд, гэр бүл нь бий. Энэ нь тэдний эрх ашгийг хохирогч нэг бүрээр хангаж, улмаар цаашдын аюулгүй байдлыг нь хамгаалж байгаа шийдэл гэж тэд үздэг.

Гэвч дээрх жишээгээр олон 100 жилийн ял шийтгэл оногдуулдаг улсад ч ялгаагүй гэмт хэргийн гаралт буурахгүй байгааг анхаарах нь зүйтэй.

Манай улсын Эрүүгийн хуульд нэг гэмт хэрэгт нэг ял шийтгэл гэсэн үзэл баримтлал бий болсон боловч түүнийг хэрэглэх боломжгүй байгаа нь хуулийн мөн чанарыг алдагдуулах, гэмт хэрэгтэнд ял завшуулах, хуулийн байгууллагад зохиомол ачаалал, давхардал үүсгэсэн, хохирсон иргэдийг чирэгдүүлэх, хохирсон дээр нь нэмж хохироох, гэмт хэргийн гаралт буурахгүй байх сөрөг үр дагавруудыг бий болгож эсэхийг судлан тогтоох шаардлагатай байна.

Гурав. Өсвөр насны хүнийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд криминологийн шинжлэх ухааны татгалзуулах онол болон эрүүл мэндийн салбарт ашиглагдаж байгаа аргуудтай холбон тайлбарлах нь:

Уламжлалт криминологийн шинжлэх ухааны гэмт хэрэг үйлдэхээс эмээлгэх буюу татгалзуулах онол нь голлох онолын нэг бөгөөд эрүүгийн эрх зүйн бодлого, шийдвэр, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх стратегийн түүхэн үндэс суурийг тавьж өгсөн байдаг. Эрүүл мэндийн салбарт ашиглагдаж байгаа өвчнөөс урьдчилан сэргийлэх аргыг гэмт хэрэг үйлдэхээс татгалзуулах онолтой холбон тайлбарлах боломжтой. Эрүүл мэндийн салбарт 3 түвшинд ашиглаж байгаа аргыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд ашиглаж болно гэсэн үг. Үүнд:

1/Анхан шатны урьдчилан сэргийлэлт: олон нийтийг хамарна.

Эрүүл мэндийн салбарынхан зүрхний шигдээс, хорт хавдар, чихрийн шижин, цусны даралт ихсэх зэрэг иргэдийн эрүүл мэндэд эрсдэл учруулж буй олон төрлийн өвчнөөс

⁴ Цагдаагийн ерөнхий газар (2018) Монгол Улсад 2008-2017 онд бүртгэгдсэн гэмт хэргийн статистик үзүүлэлт.

⁵ Шинэчлэн найруулсан 2015 оны Эрүүгийн хуулийн ерөнхий анги.

⁶ ВВС-ийн мэдээ: Яагаад хорих ял ийм удаан хугацаатай байдаг вэ? Цахим эх сурвалж: <https://www.bbc.com/news/blogs-magazine-monitor-23495284>.

урьдчилан сэргийлэхийг эрэлхийлдэг олон янзын аргууд ашиглаж байна. Тухайлбал, зүрхний шигдээс болсон тохиолдолд үзүүлэх эмчилгээ, яаралтай тусламжийн байгууллагын санхүү, хүний нөөц, ур чадвар, технологи, эмчилгээний цаг хугацаанд анхаарал хандуулах нь дундаж наслалт, гэнэтийн үхлийг даван туулахад эерэг үр дүн авчрах нь дамжиггүй боловч ийм арга барилд дангаараа найдах нь зүрхний шигдээс болох анхдагч эрсдэлийг бууруулж чадахгүй. Өөрөөр хэлбэл, хоолны дэглэм барих, дасгал хөдөлгөөн хийх, архи, тамхи хэрэглэх зэрэг хорт зуршлаасаа салах, амьдралын хэв маягаа өөрчлөхийг санал болгох аргыг дээрх аргатай хослуульж хэрэглэнэ. Жишээ нь: зүрхний шигдээс тусах эрсдэл өндөртэй хүмүүс энэ эрсдэлийг эм уух, амьдралын хэв маягийг өөрчлөх замаар бууруулах боломжтой юм.

Криминологийн шинжлэх ухаанд энэхүү анхдагч урьдчилан сэргийлэлтийг тухайн хүний гэмт хэрэгт холбогдох магадлалтай холбоотой хүчин зүйлсийг багасгах зорилгоор ашиглана. Тухайлбал, төрөхийн өмнөх ээжүүдэд зориулсан хөтөлбөр, эцэг эх болоход бэлдэх хөтөлбөр, сургуулийн өмнөх боловсрол олгох зэрэг арга хэмжээнүүд нь хүүхэд бага жинтэй төрөх, мэдрэлийн эмгэг, хүрээлэн буй орчны янз бүрийн хорт бодист өртөх зэрэг хүүхдийн хөгжил, согогтой төрөхөөс зайлсхийх, багасгахад чиглэгдэж байдаг. Жишээ нь: төрөхийн өмнөх хөтөлбөрүүд нь жирэмсэн эхчүүдийн амин дэм, биеийн дархлааны дутагдлыг тодорхойлж, төрөөгүй хүүхдийн бие бялдрыг хөгжүүлэх, сайжруулах үйлчилгээ үзүүлэхэд чиглэгддэг.

Өнгөц харахад эрүүл мэндийн салбарт ашиглаж байгаа аргууд мэт боловч сургуульд сурах амжилтыг дээшлүүлэх, гэмт хэрэгт холбогдох эрсдэлийг бууруулж байгаа хэлбэр юм. Тухайлбал, бие махбодын хувьд гажигтай төрөх, бусдаас ялгаатай байх нь нийгэмд сөргөөр шошгологдох, үе тэнгийнхэндээ гоочлуулах, ялгаварлан гадуурхагдаж энэ нь гэмт хэрэг үйлдэх нөхцөлийг бүрдүүлэх юм⁷. Анхдагч урьдчилан сэргийлэх ажилд эрүүл мэнд болон хууль зүйн салбарынхан хамтран ажиллах шаардлагатай болж байна.

2/Хоёрдогч урьдчилан сэргийлэлт: зорилгод бүлгийг хамарна.

Хоёрдогч урьдчилан сэргийлэлт нь гэмт хэрэг, зөрчилд өртөх эрсдэл өндөртэй хүн, газруудад чиглэнэ. Дээр дурдсан шиг зүрхний шигдээстэй өвчтөний тасгийн үйл ажиллагааг сайжруулах нь эрүүл мэндийн салбарт бол хоёрдогч урьдчилан сэргийлэлт юм. Үүний нэгэн адилаар криминологийн шинжлэх ухааны гэмт хэрэг үйлдэхээс тагталзуулах онолын хувьд хоёрдогч урьдчилан сэргийлэлтийн зорилго бол гэмт хэрэг, зөрчлийн тархалт, харгис хэрцгий аргаар үйлдэж буй байдал, гэмт үйлдлийн үргэлжлэх хугацаа багасгах, өсвөр насныхныг алдаа гаргахаас урьдчилан сэргийлэх явдлууд багтана. Лондон болон Питтсбург хотуудад хоорондоо хамааралгүй тус тусад нь судалгаа явуулж үр дүнд нь 8-10 насны хөвгүүдийн гэмт хэргийн эрсдэлт есөн хүчин зүйлийг тодорхойлсон байдаг⁸. Үүнд:

- хүүхдийн оргилуун дэврүүн байдал,
- анхаарал төвлөрөл сул,
- сурлагын амжилт тааруу,
- эцэгтэйгээ тааруу харьцаатай байх,
- ам бүл олонтой,
- гэр бүлийн орлого бага,
- гэр бүл салалт,
- эцэг эхийн хараа хяналтгүй байдал,
- эцэг эхийн хоорондын таарамжгүй харьцаа

Эдгээр хүчин зүйлс (хувьсагч) өсвөр насныхны гэмт хэрэг үйлдэх эрсдэлийг бий болгоход голлох шалтгаан болж байна гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, хоёрдогч урьдчилан

⁷ Осман Дону (2022) Криминологийн онолууд номны орчуулга. 11-р бүлэг.

⁸ Kristine Levan, David A. Mackey (2015), “Нийгмийн болон Зан үйлийн шинжлэх ухааны олон улсын нэвтэрхий толь”, хоёр дахь хэвлэл, цахим эх сурвалж: <https://www.sciencedirect.com/topics/social-sciences/criminology-theory#:~:text=Deterrence%20theory%2C%20the%20most%20prominent,the%20likely%20costs%20of%20crime>.

сэргийлэлтийн хүрээнд дээрх хүчин зүйлсийг арилгах, багасгах, нөхцөл байдлыг сайжруулахад чиглэгдсэн төрийн бодлого, шийдвэр, хөтөлбөрүүд бий болох учиртай юм. Жишээ нь: насанд хүрээгүй хүүхдэд зориулсан сургууль дээр зөвлөгөө өгөх, сэтгэл зүйн эмчилгээнд хамруулах хөтөлбөрүүд, цагийг үр дүнтэй өнгөрөөх хөтөлбөр, дугуйлан, клубуудыг олноор бий болгох явдал үүнд хамаарна.

3/Гуравдагч урьдчилан сэргийлэлт: нэгэнт алдчихсан иргэдэд хамаарна.

Гуравдагч урьдчилан сэргийлэх хүчин чармайлт бол аль хэдийн гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг дахин гэмт хэргээс үйлдэхээс ирээдүйд урьдчилан сэргийлэх зорилготой. Эрүүл мэндийн салбарынханд бол өвчтөнийг дахин өвдөхгүй байх зөвлөгөө өгөх, гам барихыг сануулах, эмнэлгээс гарсан ч эмчийн байнгын хяналтад байхтай ижил юм. Хорих ангид суурилсан хөтөлбөрүүдийг энд дурдаж болно. Жишээ нь: барууны зарим оронд одоогоос 40 гаран жилийн өмнөөс одоог хүртэл гэмт хэрэг үйлдэх эрсдэлтэй өсвөр насныхныг хорих ангид оруулж тэндхийн хоригдлуудын дундуур явуулж айлгах хөтөлбөрийг хэрэгжүүлж байдаг⁹. Гэвч уг хөтөлбөрийн үр дүнг багш, эцэг, эх, хүүхдийн хорих ангийн ажилтнууд өсвөр насныхан амьдралын хэв маягаа л өөрчлөхгүй бол цаашид өөрөөсөө ч хэцүү хүүхдүүдтэй нөхөрлөж найзлах, гэмт хэрэг үйлдэх эрсдэл нь буурахгүй байгаа талаар дүгнэсэн байна.

Энэ нь гуравдагч урьдчилан сэргийлэх ажлыг тухай бүр нь улам бүр боловсронгуй болгох шаардлагыг илэрхийлж байна. Түүнчлэн, иргэд нэгэнт алдаа гаргаад эрүүгийн хариуцлага хүлээж байгаа явдал нь бидний өмнө дурдаад байгаа анхдагч, хоёрдогч урьдчилан сэргийлэх аргуудын зорилго яагаад хүссэн үр дүндээ хүрэхгүй байгаа талаар дүн шинжилгээ, судалгаа хийгдэж, дүгнэлт хийхийг давхар шаардаж байгаа гэсэн үг.

Дөрөв. Дүгнэлт

Эрүүгийн эрх зүйн салбар дахь бүхий л хууль, дүрэм нь гэмт хэрэг, зөрчилтэй холбоотой байх ба гэмт хэргийн талаарх онол, суурь онолд үндэслэн батлагдаж байдаг. Криминологийн онолыг ойлгох, дүгнэх, судлах нь зөвхөн криминологийн шинжлэх ухааны мэргэшсэн судлаач нарын ажил биш бөгөөд, хууль зүйн салбарт ажиллаж байгаа мэргэжилтэн бүрийн мэдэж байвал зохих сургаал юм. Энэхүү нийтлэлийн үр дүнд дараах дүгнэлт хийгдлээ. Үүнд:

1. Криминологийн шинжлэх ухааны олон арван онолууд бий бөгөөд тэдгээрийн судалгаанд ашиглаж буй аргууд нь бусад шинжлэх ухааны аргуудын адилаар ерөнхийгөөс тусгай руу нарийсах, хувьсагчид тулгуурлан үр дүнг тогтоох, хоёр эсвэл түүнээс олон үйл явдлыг харьцуулах, харилцаа хамааралтай эсэхийг холбон тайлбарлах боломжтой. Гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох чухал ач холбогдолтой байдаг байна.

2. Криминологийн шинжлэх ухааны гэмт хэрэг үйлдэхээс тагталзуулах онол нь уламжлалт онолуудаас голлох байр суурийг эзэлдэг бөгөөд ихэвчлэн ял шийтгэлээр дамжиж зорилгодоо хүрэхийг эрмэлзэх ба манай улсын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгтэй энэхүү онолын сургаал нь зөрчилдөж байна.

3. Эрүүл мэндийн салбарт ашиглагддаг өвчнөөс урьдчилан сэргийлэх 3 аргыг гэмт хэрэг үйлдэхээс тагталзуулах онолтой холбон өсвөр насны хүнийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх боломжтой байна. Гэхдээ гэмт хэрэг үйлдэхээс тагталзуулах онолд суурилсан эрх зүйн зохицуулалт, бодлого, шийдвэр, хөтөлбөрүүдэд дүн шинжилгээ хийж засаж сайжруулах, эсвэл бүр мөсөн солих шаардлагатай эсэхийг байнга тодорхойлж байх нь зүйтэй.

⁹ Anthony Petrosino, Carolyn Turpin-Petrosino, Meghan E. Hollis-Peel, Julia G Lavenberg нарын бүтээл (2013) “Өсвөр насныхныг гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд шууд болон бусад хөтөлбөрүүд: Дүн шинжилгээ”, цахим эх сурвалж: <https://onlinelibrary.wiley.com/doi/pdf/10.4073/csr.2013.5>

ЭХ СУРВАЛЖ**Монгол хэл дээрх*****Хууль тогтоомж***

1. 2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль.

Ном, өгүүлэл, судалгааны тайлан

1. Ronald L Akers, Christine S. Sellers, and Wesley G. Jennings (2017 он), “Криминологийн онолууд” номны долоо дахь хэвлэл.
2. Цагдаагийн ерөнхий газар (2018 он) Монгол Улсад 2008-2017 онд бүртгэгдсэн гэмт хэргийн статистик үзүүлэлт.
3. Осман Долу (2022 он) Криминологийн онолууд номны орчуулга. 11-р бүлэг.

Гадаад хэл дээрх***Цахим эх сурвалж***

1. Anthony Petrosino, Carolyn Turpin-Petrosino, Meghan E. Hollis-Peel, Julia G Lavenberg нарын бүтээл (2013) “Өсвөр насныхныг гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд шууд болон бусад хөтөлбөрүүд: Дүн шинжилгээ”, цахим эх сурвалж: <https://onlinelibrary.wiley.com/doi/pdf/10.4073/csr.2013.5>.
2. Kristine Levan, David A. Mackey (2015), “Нийгмийн болон Зан үйлийн шинжлэх ухааны олон улсын нэвтэрхий толь”, хоёр дахь хэвлэл, цахим эх сурвалж: <https://www.sciencedirect.com/topics/social-sciences/criminology-theory#:~:text=Deterrence%20theory%2C%20the%20most%20prominent,the%20likely%20costs%20of%20crime>.
3. BBC-ийн мэдээ: Яагаад хорих ял ийм удаан хугацаатай байдаг вэ? Цахим эх сурвалж: <https://www.bbc.com/news/blogs-magazine-monitor-23495284>

CRIMINOLOGY DETERRENCE THEORY: ADOLESCENT***Nyambat.D****Public prosecutor of Training and research institute,
The State Prosecutor General's Office of Mongolia***ABSTRACT:**

The science of criminology consists of theories, doctrines, and methods for determining and preventing the causes and conditions of crimes such as delinquency. In particular, theoretical research is conducted on how to prevent adolescents from committing crimes, regulations, policies, and programs created on the results. It is intended to explain the methods of prevention of any disease in the health science and methods of prevention from crimes.

KEYWORDS:

Criminology, Theory, Social Science, Deterrence, Sentence, Health, Patients, Adolescence, Risk, Methods, Prevention

ХҮНИЙГ ГЕНИЙГ ХУВИЛАХ БУЮУ ГЕНЕТИКИЙН ИЖИЛ ХУУЛБАРЫГ БҮТЭЭХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ХУУЛЬ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ



Ц.Амарсанаа
докторант

ТОВЧЛОЛ:

Хүний генийн хувилах буюу генетикийн ижил хувилбар бүтээх инженерчлэлийн үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомжууд нь соёл, шашин шүтлэг, үр хөврөлийн төлөв байдлын талаарх нийгэмд давамгайлж буй үзэл санаанаас хамаарч улс орон бүрт харилцан адилгүй байдаг. Уг асуудал нь шинэ зүйл учир түүнээс үүдэн гарах эрсдэлийг тооцоолох боломж хомс юм. Иймд зарим улс орны хувьд хууль зүйн хязгаарлалт тогтоож байгаа бөгөөд зөвхөн судалгааны хүрээнд зөвшөөрч байна.

Нэгдсэн Үндэсний Байгууллагын Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллага 1997 онд Хүний геном ба хүний эрхийн түгээмэл тунхаглалыг баталсан. Уг тунхаглал нь заавал дагаж мөрдөх албагүй баримт бичиг боловч гишүүн орнуудыг дагаж мөрдөхийг уриалсан байна. Тус тунхаглалд судалгаа, шинжилгээ, оношилгоо хийх эрх чөлөөг нээлттэй үлдээсэн.

Цөөн улс орнуудын хувьд үр хөврөл, үүдэл эдийн эсийг импортлох, экспортлоход тусгай зөвшөөрөл олгож байгаа бол зарим улсад шууд хориглодог. Олон улсад хүний эрүүл мэнд, сайн сайхны төлөө генийн инженерчлэлийг зөвшөөрөх эсэх нь эргэлзээтэй үлдэж байна.

ТҮЛХҮҮР ҮГС:

Ген, генетик, геном, хүний ген, генийн инженерчлэл, ген шилжүүлэн суулгасан, Хүний геном ба хүний эрхийн түгээмэл тунхаглал

ОРШИЛ

Хүний генийг хувилах буюу генетикийн ижил хуулбарыг бүтээх ажиллагаа нь шинжлэх ухааны хувьд харьцангуй шинэ зүйл юм. Гэхдээ улс орнуудад генетикийн шинжлэх ухаан хурдацтай хөгжиж байна. Үүнтэй зэрэгцэн уг судалгааны ажлыг хууль зүйн үүднээс судлах хэрэгцээ шаардлага бодиттой бий болсон.

Генетикийн ижил хуулбар бүтээх ажиллагаа нь хүний эрхтэй шууд холбоотой бөгөөд хүний удамшлын мэдээллийг хадгалж байгаа үнэ цэнтэй мэдээлэл юм. Иймд олон улсын байгууллагаас олон улсын гэрээ, конвенц баталж гишүүн улс орнуудыг дэмжихийг уриалсан

байна. Уг уриалгыг улс орнууд хүлээн авч дотоодын хууль тогтоомжийг боловсруулан батлан гаргаж байна. Генетикийн судалгаа шинжилгээ нь хүний эрүүл мэнд, сайн сайхны төлөө байх шаардлагатай. Энэхүү зарчмын дагуу улс орнууд хүний генийн инженерчлэлийн талаар судалгаа, шинжилгээ, оношилгоо хийхийг хүлээн зөвшөөрч эхэлсэн.

Уг илтгэлд гадаадын зарим улс орнуудын хууль тогтоомжийн зохицуулалтыг тусгасан бөгөөд монгол улсын хувьд мөн хэрхэн зохицуулсан талаар дүн шинжилгээ хийх зорилго дэвшүүлсэн болно. Уг зорилгын хүрээнд дараах зорилтуудыг тусгана. Үүнд:

1. Хүний генийг хувилах буюу генетикийн ижил хуулбарыг бүтээх тухай ойлголт
2. Олон улс дахь хүний генийг хувилах буюу генетикийн ижил хуулбарыг бүтээх талаарх хууль зүйн зохицуулалт
3. Монгол улсад хүний генийг хувилах буюу генетикийн ижил хуулбарыг бүтээх талаарх хууль зүйн төлөв байдал зэрэг дэд сэдвийн хүрээнд судалгаа хийлээ.

Генетикийн шинжлэх ухаан нь дан ганц биологийн шинжлэх ухааны салбарт хамаарахгүй бөгөөд хүний эрхийн асуудал хөндөгдөх учир хууль зүйн шинжлэх ухааны судлагдахуун болох юм. Хууль зүйн шинжлэх ухааны гол судлах салбар бол хүний эрхийг хангах, хамгаалахад чиглэдэг. Ийм ч учраас хүний эмзэг мэдээлэл болох генийн мэдээллийг хамгаалах болон генийг хувилах буюу генетикийг ижил хуулбарыг бүтээх ажиллагааг хүлээн зөвшөөрөх эсэх асуудлыг хууль зүйн үүднээс судлах хэрэгцээ шаардлагатай тулгарч байна.

Хүний генийг хувилах талаарх судалгааны ажлын мэдээлэл нь түгээмэл бус байна. Уг асуудалд улс орнууд болгоомжтой хандаж байгаа нь хууль тогтоомжийн зохицуулалтаас ажиглагдаж байна. Хүний генийг хувилах буюу генетикийн ижил хуулбар бүтээх ажиллагааны явцад шууд хүний эрх зөрчигдөж болзошгүй бөгөөд улс орны эрх ашиг, аюулгүй байдал хөндөгдөх асуудал юм. Цаашид хүний эрхийг зөрчихгүй байх үүднээс хууль зүйн зөв зохистой зохицуулалтыг бий болгох үүрэг улс орнуудад үүсжээ.

Монгол Улсын хувьд Малын генетик нөөцийн тухай хууль 2017 онд, Генетик нөөцийн тухай хууль 2021 онд баталсан. Уг хуулиудаар мал, амьтан, ургамал, бичил биетний генетикийн талаарх хууль батлан гаргасан бөгөөд хүний генетикийн хууль одоо хүртэл батлагдан гараагүй.

1. Хүнийг генийг хувилах буюу генетикийн ижил хуулбарыг бүтээх тухай ойлголт.

1865 онд Gregor Johann Mendel¹ хотын байгаль судлаачдын нийгэмлэгийн хурал дээр “Эрлийз ургамлууд дээр тавьсан туршилтын дүн” хэмээх илтгэл тавьжээ. Г.Мендель вандуйн долоон альтернатив шинж эвдэгдэнэ. 1920-иод онд дрозофил ялааны хэдэн зуун генийг тодорхойлж дөрвөн хромосом дахь тэдгээрийн байрлал-зургийг зохиожээ.² Ингэснээр генетикийн шинжлэх ухааны суурь тавигдсан байна. Үүний дараагаар хэд хэдэн үе шатыг дамжин хөгжсөнөөр хүний генетикийн асуудал хөндөгдөн судлагдаж эхэлсэн. 20-р зуунд хүнийг хувилах боломж нь таамаглалын сэдэв байсаар ирсэн ч эрдэмтэд, бодлого боловсруулагчид 1969 оноос хойш энэ асуудалд нухацтай хандан судалж эхэлсэн.

J.B.S.Haldane³ нь хүнийг хувилах санааг анх гаргаж ирсэн бөгөөд үүнд тэрээр 20-р зууны эхэн үеэс хөдөө аж ахуйд ашиглагдаж байсан “clon-клон”, “cloning-колончлох”⁴

¹ Грегор Иоган Мендель (1822 оны 7 сарын 20 – 1884 оны 1 сарын 6) нь Герман-Чехийн биологич, цаг уур судлаач, математикч, Августинийн лам, Моравийн Маргравиагын Брно дахь Гэгээн Томасын сүмийн хамба лам байв. Мендель Австрийн эзэнт гүрний Силезийн хэсэгт (одоогийн Чех) герман хэлтэн гэр бүлд төрж, орчин үеийн генетикийн шинжлэх ухааныг үндэслэгч гэдгээрээ нас барсны дараа хүлээн зөвшөөрөгдсөн. 1856, 1863 онуудад удамшлын олон дүрмийг тогтоож, одоо Менделийн өв залгамжлалын хуулиуд гэж нэрлэдэг.

² Ж.Хулан. “Ерөнхий генетик”. УБ., 2010. 1-2 дахь тал.

³ Жон Бурдон Сандерсон Халдане (1892 оны 11-р сар - 1964 оны 12-р сарын 1) физиологи, генетик, хувьслын биологи, математикийн чиглэлээр ажиллаж байсан Британи-Энэтхэгийн эрдэмтэн байв. Биологийн салбарт статистикийг шинэлэг байдлаар ашигласан тэрээр нео-дарвинизмыг үндэслэгчдийн нэг байв Их Британийн иргэншлээсээ татгалзаж, 1961 онд Энэтхэгийн иргэн болж, насаараа Энэтхэгийн Статистикийн хүрээлэнд ажилласан.

⁴ Thomas, Isabel. (2013). “Should scientists pursue cloning?” (Sci-Hi). p. 5.

гэсэн нэр томъёог ашигласан. Тэрээр 1963 онд “Сиба сангийн Хүн ба түүний ирээдүй” симпозиум дээр “Ирэх арван мянган жилийн хүний төрөл зүйлийн биологийн боломжууд” сэдэвт илтгэлд хэлсэн үгэндээ:⁵ “...Хүний эсийн зарим шугам (үр хөврөл)-ыг яг тодорхой химийн найрлагатай орчинд ургуулж чадна гэдэгт маш их найдаж байна...” гэж байжээ.

Нобелийн шагналт генетикч Joshua Leberberg⁶ 1966 онд “The American Naturalist” сэтгүүлд, дараа жил нь “The Washington Post” сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэлдээ клончлол болон генетикийн инженерчлэлийг дэмжсэн байна.⁷ Тэрээр консерватив био-этикч Leon Kass⁸-тай мэтгэлцээн өрнүүлсэн бөгөөд тэрээр тухайн үед “хүний программлагдсан нөхөн үржихүй нь үнэндээ хүнийг хүн чанаргүй болгох болно” гэж бичжээ.

Мөн нобелийн шагналт James D. Watson⁹ 1971 онд Атлантын сар бүрийн сэтгүүлд “Клон хүн рүү шилжих нь” нэртэй эссэгээ клончлолын боломж, хор хөнөөлийн талаар олон нийтэд нийтэлжээ.¹⁰

1972 онд эрдэмтэн Paul Berg¹¹ ДНХ-ийн эрлийз молекулыг хуруу шилэнд (in vitro) буй болгосон үеэс эхлэн генийн инженерчлэлийн үндэс суурь тавигдсан. 1996 онд соматик эсийн цөмийн дамжуулалт (Somatic Cell Nuclear Transfer) аргаар Долли гэх нэртэй хонь хувилснаар хүний хувилах санаа халуун маргааны сэдэв болсон. Олон улс орнууд үүнийг хориглосон бол цөөн хэдэн эрдэмтэд ойрын хэдэн жилийн дотор клон хийхээ амласан. Анхны эрлийз хүний клоныг 1998 оны 11-р сард Advanced Cell Technology компани бүтээжээ. Үүнийг SCNT ашиглан бөгөөд хүний хөлний эсээс авч үнээний өндөг эс рүү хийж, эрлийз эсийг өсгөвөрлөн үүдэл эс болгон хөгжүүлсэн. Үүдэл эсийг 12 хоногийн дараа устгасан.¹² 2018 онд SCNT-ийг ашиглан приматуудыг¹³ хувиан Жун Жун, Хуа Хуа гэх хоёр эмэгтэй Макак төрүүлсэн байна.

Ингэснээр амьтан хувилах судалгаанууд амжилттай хэрэгжиж эхэлсэн бөгөөд хүний үүдэл эсийг өсгөврийг бий болгох туршилтууд улс орнуудад түгээмэл хийгдэж зарим нь амжилттай болж байна. Ийм учир уг асуудлыг хууль тогтоомжийн зохицуулалт хийх шаардлага бий болсон. Уламжлалт шинжлэх ухааны салбарууд цоо шинэ төлөв байдалд орж, эдүгээ шинэ зүйлийг олон шинжлэх ухаан хавсарч, нийлж судлах хэрэгцээ урган гарч ирсэн. Иймд хүний генетикийн засварлах, хувилах, өөрчлөх нь биологи, генетикийн шинжлэх ухааны хүрээнээс хальсан бөгөөд хууль зүйн шинжлэх ухааны судлах хэрэгцээ шаардлагатай судлагдахуун болжээ.

2. Олон улс дахь хүнийг генийг хувилах буюу генетикийн ижил хуулбарыг бүтээх талаарх хууль зүйн зохицуулалт

1997 оны арван нэгдүгээр сарын 11-ний өдөр ЮНЕСКО-гоос баталсан Хүний геном ба хүний эрхийн түгээмэл тунхаглалын 11 дүгээр зүйлд¹⁴ “хүнийг нөхөн үржихүйн хувилах зэрэг хүний нэр төрд харшлах үйлдлийг хориглоно” гэж заасан байдаг. Судалгааны

⁵ Haldane, J.B.S. (1963). “Biological Possibilities for the Human Species in the Next Ten Thousand Years”. In Wolstenholme, Gordon (ed.). *Man and his future*. Novartis Foundation Symposia. London: J. & A. Churchill. p. 337–361.

⁶ Жошуа Ледерберг (1925 оны 5-р сарын 23 - 2008 оны 2-р сарын 2) Америкийн молекул биологич, бичил биетний генетик, хиймэл оюун ухаан, АНУ-ын сансрын хөтөлбөр зэрэг чиглэлээр ажилладаг.

⁷ Lederberg, Joshua (1966). “Experimental Genetics and Human Evolution”. *The American Naturalist*. 100 (915): 519–531.

⁸ Леон Ричард Касс (1939 оны хоёрдугаар сарын 12-нд төрсөн) Америкийн эмч, эрдэмтэн, сурган хүмүүжүүлэгч, олон нийтийн сэхээтэн юм. Кассыг био-ёс зүйч гэж нэрлэдэг ч тэрээр энэ нэр томъёоноос татгалзаж, өөрийгөө “хуучин үеийн хүмүүнлэг үзэлтэн” гэж хэлдэг.

⁹ Жеймс Дьюн Уотсон (1928 оны дөрөвдүгээр сарын 6-нд төрсөн) Америкийн молекул биологич, генетикч, амьтан судлаач юм.

¹⁰ <https://www.theatlantic.com/magazine/archive/1971/05/moving-toward-the-clonal-man/305435/> 2023 оны 10 дугаар сарын 20 өдөр хандав.

¹¹ Пол Берг (1926 оны 6-р сарын 30 - 2023 оны 2-р сарын 15) нь Америкийн биохимич, Стэнфордны их сургуулийн профессор юм. Тэрээр 1980 онд Уолтер Гилберт, Фредерик Сэнгер нарын хамт химийн салбарт Нобелийн шагнал хүртэж байсан.

¹² <http://news.bbc.co.uk/2/hi/science/nature/371378.stm> 2023 оны 10 дугаар сарын 20 өдөр хандав.

¹³ Анхдагч амьтад нийтлэг өвөг дээдсийг хуваалцдаг хөхтөн амьтад. Примат гэдэг үг нь Латин хэлний “эхнийх” гэсэн үгнээс гаралтай.

¹⁴ <https://www.ohchr.org/en/instruments-mechanisms/instruments/universal-declaration-human-genome-and-human-rights> 2023 оны 10 дугаар сарын 27 өдөр хандав.

зорилгоор клончлох эрх зүйн байдал ийнхүү нээлттэй үлдэж байна. НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2005 оны 2-р сарын 24-ний өдрийн 6-р хорооны (хууль) зөвлөмжийн үндсэн дээр 2005 оны 3-р сарын 8-нд НҮБ-ын Ерөнхий Ассамблей “Хүн хувилах (cloning) тухай тунхаглал”¹⁵-ыг батлав. Үүнд НҮБ-ын гишүүн бүх улс орнуудад шаардлагатай бүх арга хэмжээг авахыг уриалсан байна.

Мөн “Эмчилгээний клончлол” гэж нэрлэгддэг эмнэлгийн зориулалтаар клончлох зэрэг хүний хувилах бүх хэлбэрийг хориглоход шаардлагатай бүхийг арга хэмжээг авахыг НҮБ-ын бүх гишүүн орнуудад уриалсан байна. Тунхаглалд хүний хувилах бүх хэлбэр нь хүний нэр төр, хүний амь насыг хамгаалахад үл нийцнэ гэж заасан.

Уг тунхаглалд улс орнууд дэмжих болон эсэргүүцэх байр суурьтай байгаагаа илэрхийлсэн бөгөөд дэмжигч улс орнуудын хувьд хүний нэр төрийг хамгаалах, хүний эрхийг хамгаалах чухал үйл явдал гэж үзсэн. Харин Хятад, Бельги, Их Британи зэрэг засгийн газрын төлөөлөгчид энэхүү шийдвэр нь “эмчилгээний клончлол”-ын талаарх тэдний байр сууринд ямар ч нөлөө үзүүлэхгүй гэж үзжээ. Одоогийн тунхаглал нь заавал биелүүлэх үүрэг биш бөгөөд зөвхөн зөвлөмжийн статустай.

Уг тогтоолын төслийг анх Коста Рика 2003 онд өргөн барьж, “эмчилгээний клон” гэх мэт хүний хувилах бүх хэлбэрийг бүхэлд нь хориглохыг уриалсан байна. Бельгийн санал болгосон сөрөг төсөлд мөн адил нөхөн үржихүйн клончлолыг хориглох тухай тусгасан байсан ч “эмчилгээний клончлол” шийдвэрийг үндэсний засгийн газруудын үзэмжээр үлдээсэн. 2004 оны арван нэгдүгээр сард хэлэлцээ сунжирсан ч тогтоолын төслүүдийн аль нь ч олонхын санал авч чадаагүй байна.¹⁶

Улс орнууд суулгацын өмнөх генетикийн оношилгоо (PGD), удамшлын генетикийн өөрчлөлт (IGM), клончлох, үүдэл эсийн судалгаа хийхийг зөвшөөрдөг эсэхийг дараах хүснэгтээс харна уу.

Улс	PGD- генетикийн оношилгоо	IGM- удамшлын генетикийн өөрчлөлт	Cloning – хувилах	Stem Cell Research - Үүдэл эсийн судалгаа
Австрали	Тийм	Үгүй	Үгүй - нөхөн үржихүйн бус	Тийм
Канад	Тийм	Үгүй	Үгүй	Тийм
Франц	Тийм	Үгүй	Үгүй	Тийм
Герман	Тийм хязгаарлагдана (pre-fertilization)	Үгүй-	Үгүй	Зарим импортын үүдэл эсийн шугамаар хязгаарлагддаг
Израил	Тийм	Үгүй - нөхөн үржихүйн бус	Үгүй - нөхөн үржихүйн бус	Тийм
Шинэ Зеланд	Тийм	Үгүй	Үгүй - нөхөн үржихүйн бус	Тийм
Орос	Тийм	Үгүй	Үгүй - нөхөн үржихүйн бус	Тийм
Их Британи	Тийм	Үгүй	Үгүй - нөхөн үржихүйн бус	Тийм

Хувилах (Cloning)-ийг улс орнууд нөхөн үржихүйн зорилгоор хүнийг хувилахыг

¹⁵ <https://press.un.org/en/2005/ga10333.doc.htm> 2023 оны 10 дугаар сарын 27 өдөр хандав.

¹⁶ https://web.archive.org/web/20140420052032/http://www.drze.de/in-focus/research-cloning/legal-aspects?set_language=en 2023 оны 10 дугаар сарын 27 өдөр хандав.

хориглодог. Австрали, Израиль, Шинэ Зеланд, Их Британи эмчилгээний зорилгоор хувилахыг зөвшөөрдөг. Австрали, Израиль, Шинэ Зеланд, Их Британи эмчилгээний зорилгоор клончлохыг зөвшөөрдөг. ОХУ-д клончлохыг хориглосон нь шинэ мэдлэг, ёс суртахуун, нийгэм, ёс суртахууны дүрэмд өөрчлөлт гарсан тохиолдолд хоригийг цуцлах механизмыг бий болгосон байна.¹⁷

Хүн генийг хувилах буюу генетикийн ижил хувилбарыг бүтээх ажиллагааны талаар улс орнуудын хуулийн зохицуулалтыг дараах жагсаалтаас харна уу.

№	Улс	Хуульчилсан байдал	Хуулийн зохицуулалт
1	Аргентин	Хориглосон	Ерөнхийлөгчийн 1997 оны 3-р сарын 7-ны өдрийн 200/97 тоот зарлигаар хүн хувилахыг хориглосон. ¹ Тус тогтоолын 1-р зүйл - Хүнтэй холбоотой хувилах туршилт хийхийг хориглоно.
2	Австрали	Зарим хэлбэрийг зөвшөөрсөн	2002 оны Хүний хуулбарлахыг хориглох тухай хуульд (Cth) зарим үйлдлийг бүр мөсөн хориглож, заримыг нь зөвхөн тусгай зөвшөөрлийн дагуу зөвшөөрдөг. Хуулийн §9-д заасны дагуу Австралийн нутаг дэвсгэрт хүн хувилахыг хориглосон. Гэвч 2007 оны 6-р сарын 12-ны өдрөөс эхлэн судлаачид үр хөврөлийн үүдэл эсийг бүтээхийн тулд хүний клончлол хийх тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргах боломжтой болсон. Зөвшөөрлөөс бусад тохиолдолд хориглосон үйл ажиллагаа, үйлдлүүд нь гэмт хэрэг гэж үздэг бөгөөд дээд тал нь арван таван жилийн хорих ялтай. ² 2007 оны 3-р сарын 31-ний байдлаар Австралид 329 илүүдэл үр хөврөлийг лицензтэй судалгаанд ашигласан байна. ЭХЭМҮТ-ийн үр хөврөлийн судалгааны тусгай зөвшөөрлийн хорооноос 1915 хүртэл илүүдэл үр хөврөл ашиглахыг зөвшөөрсөн есөн лиценз олгосон бөгөөд дөрөв нь хүний үр хөврөлийн үүдэл эсийг гарган авахад 550 хүртэл үр хөврөл ашиглахыг зөвшөөрсөн (үүнээс 197 үр хөврөлийг ашигласан). ³
3	Канад	Хориглосон	2004 онд Канадын парламент Хүний нөхөн үржихүйн тухай хуулийг баталсан. ⁴ Канадын хуульд дараах зүйлийг хориглодог: хүнийг хувилах, үүдэл эсийг хувилах, судалгааны зорилгоор хүний үр хөврөлийг өсгөх, үр хөврөл, эр бэлгийн эс, өндөг болон хүний нөхөн үржихүйн бусад материалыг худалдан авах, худалдах. ⁵ Түүнчлэн хүний ДНХ-д нэг үеэс нөгөөд шилжих өөрчлөлтийг, тэр дундаа амьтны ДНХ-г хүнд ашиглахыг хориглодог. Тээгч эхийг нөхөн үржихүйн зорилгоор эр бэлгийн эс эсвэл өндөг хандивлахыг хуулиар зөвшөөрдөг. Хүний үр хөврөл болон үүдэл эсийг мөн судалгаанд хандивлахыг зөвшөөрдөг. ⁶ Нөхөн үржихүйн шинэ технологийн тухай Хатан хааны комиссын 1993 оны тайлангаас хойш Канадад хүний нөхөн үржихүйн клончлолыг хориглох уриалга байнга гарсаар ирсэн.

¹⁷ Clare Feikert .(2008) “Regulation of human genetic technology comparative analysis”.Law library of congress.p 1-3.

4	Хятад	Зарим хэлбэрийг зөвшөөрсөн	<p>Засгийн газар хүний нөхөн үржихүйн хувилах туршилтыг “батлахгүй, зөвшөөрдөггүй, дэмждэггүй, хүлээн зөвшөөрдөггүй” боловч эмчилгээний клонжуулалтыг эсэргүүцдэггүй.⁷</p> <p>2021 оны гуравдугаар сарын 1-нээс мөрдөгдөж эхэлсэн Эрүүгийн хуулийн арван нэгдүгээр нэмэлт, өөрчлөлтийн тухай хуулийн 336 дугаар зүйлд “Хүний үр хөврөлийг генийн засварласан буюу хувилсан хүний болон амьтны биед суулгах, эсхүл генийг суулгах” гэсэн нэмэлт заалт оруулсан. Засварласан, хувилсан амьтны үр хөврөлийг хүний биед суулгасан бол нөхцөл байдал хүнд бол гурван жилээс дээшгүй хугацаагаар хорих, эсхүл эрүүгийн хэрэг үүсгэн баривчлах, торгох ял, онц хүнд бол хорих ялаар шийтгэнэ. гурваас доошгүй жил, харин долоон жилээс илүүгүй хугацаагаар хорих, торгох.”⁸</p>
5	Колумб	Хориглосон	<p>Эрүүгийн хууль 133 дугаар зүйл. Хүний давтагдах чадвар. Клончлох эсвэл өөр ямар нэгэн аргаар ижил төстэй хүмүүсийг бий болгосон хэн бүхэн гучин хоёр (32)-аас зуун найм (108) сар хүртэл хорих ял онооно.</p> <p>133 дугаар зүйл. Хүний давтагдах байдал. Клончлох эсвэл өөр ямар нэгэн аргаар ижил төстэй хүмүүсийг бий болгосон хүн хоёр (2) жилээс зургаан (6) жилийн хорих ял онооно.⁹</p>
	Израил	Зарим хэлбэрийг зөвшөөрсөн	<p>Хүний генийн инженерчлэл нь 5759-1999,7 шинэчилсэн найруулгын дагуу Генетикийн хөндлөнгийн оролцоог хориглох тухай хуулиар (Хүний нөхөн үржихүйн клонжуулалт ба нөхөн үржихүйн эсийн генетикийн өөрчлөлт) зохицуулагддаг.¹⁰</p>
6	Европын зөвлөл	Хориглосон	<p>Хүний эрх ба био анагаах ухааны тухай Европын конвенц нь нэг нэмэлт протоколдоо хүний хувилахыг хориглодог. Энэ протоколыг 24 улс соёрхон баталсан.¹¹</p>
	Герман	Хориглосон	<p>Үрийг хөврөлийг хамгаалах хуулийг 1990 онд баталсан. Үр хөврөлийг хамгаалах тухай хуулийн 6-р хэсэгт нөхөн үржихүйн хувилахыг хориглосон байдаг бөгөөд энэ нь “өөр үр хөврөл, ураг, хүн эсвэл нас барсан хүнийхтэй ижил генетикийн мэдээлэлтэй хүний үр хөврөлийг зохиомлоор хөгжүүлэхэд хүргэсэн» хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.”¹² гэж заасан.</p>
7	Франц	Хориглосон	<p>Нийгмийн эрүүл мэндийн тухай хуулийн 16-4-р зүйлд хувилах бүх хэлбэрийг хориглодог. 2004 оны 8-р сарын 6-ны өдрийн биоэтикийн хуулиар клончлолын бүх хэлбэрийг эмчилгээний аргаар хуваахыг тусгайлан хориглосон байдаг.¹³</p>
	Шинэ Зеланд	Хориглосон	<p>Хүний үр хөврөлийг клонжуулах, судлах ажлыг 2004 оны Хүний нөхөн үржихүйн технологийн тухай хууль, 1996 оны Аюултай бодис ба шинэ организмын тухай хуулиар зохицуулдаг. Хориглосон үйл ажиллагаа явуулсан бол тав хүртэл жил хорих эсвэл 200,000 доллар хүртэл торгууль оногдуулдаг.</p>

8	Энэтхэг	Зарим хэлбэрийг зөвшөөрсөн	Энэтхэгт клончлолын талаар тусгайлсан хууль байдаггүй ч хүнийг бүхэлд нь хувилах эсвэл нөхөн үржихүйн хувилахыг хориглосон удирдамж байдаг. Энэтхэг улс эмчилгээний зорилгоор клончлох, үр хөврөлийн үүдэл эсийг судалгааны зорилгоор ашиглахыг зөвшөөрдөг. Энэ тохиолдолд хууль эрх зүйн үр дагавар бий. ¹⁴ Энэтхэг аль хэдийн хөхтөн амьтдыг хувилах ажлыг амжилттай хийж чадсан. ¹⁵
9	Пакистан	Зарим хэлбэрийг зөвшөөрсөн	Пакистаны исламын үзэл суртлын зөвлөл хүн хувилах явдлыг исламын бус үйлдэл гэж зарласан. Пакистаны исламын үзэл суртлын зөвлөлийн дагуу исламын шашинд судалгаа, сэтгэлгээг хориглодоггүй, харин шашны хүрээнд шинэ санаа гаргахыг зөвшөөрдөг. ¹⁶
10	Польш	Хориглосон	Эс, эд, эрхтнийг цуглуулах, хадгалах, шилжүүлэн суулгах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2015 оны 6-р сарын 25-ны өдрийн хуулийн 87 дугаар зүйлд заасны дагуу хүн хувилахыг хориглосон ¹⁷
11	Орос	Хориглосон	ОХУ-ын Холбооны Ассамблей 2002 оны 4-р сарын 19-ний өдөр “Хүн хувилахыг түр хориглох тухай” N 54-FZ Холбооны хуулийг танилцуулсан. 2002 оны 5-р сарын 20-нд ерөнхийлөгч хүний хувилах үйл ажиллагааг зогсооход гарын үсэг зурсан. 2010 оны 3-р сарын 29-нд Холбооны Ассамблей энэ хуулийн хоёр дахь өөрчлөлтийг хугацаагүйгээр танилцуулав. ¹⁸
12	Серби	Хориглосон	Сербийн 2006 оны Үндсэн хуулийн “Амьд явах эрх”-ийн 24-р зүйлд хүн хувилахыг тодорхой хориглосон байдаг. ¹⁹
13	Сингапур	Зарим хэлбэрийг зөвшөөрсөн	2004 оны Хүний хувилах болон бусад хориглосон зан үйлийн тухай хуулийн 5-р хэсэгт хүний үр хөврөлийн клоныг хүн эсвэл амьтны биед байрлуулахыг хориглосон байдаг. ²⁰
14	Өмнөд Африк	Хориглосон	1983 оны 65-р Хүний эдийн тухай хуулийн 39А хэсгийн хувьд хүний биеэс гадуур бэлгийн эс эсвэл зиготыг генетикийн аргаар өөрчлөхийг туйлын хориглоно. Зигот нь хоёр бэлгийн эсийн нэгдлээс үүссэн эс бөгөөд үр тогтсон өндгөн эс юм. Тиймээс 39А-д хүн хувилахыг хориглодог. ²¹

15	Их Британи	Зарим хэлбэрийг зөвшөөрсөн	<p>2001 оны 1-р сарын 14-нд Их Британийн засгийн газар 2001 оны Хүний бордолт ба үр хөврөлийн (Судалгааны зорилго) журмуудыг баталж, 1990 оны Хүний бордолт ба үр хөврөлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах зорилгоор үр хөврөлийн судалгааны зөвшөөрөгдөх үндэслэлийг үүдэл эс болон эсийн цөмийн орлуулах судалгааг зөвшөөрөхийн тулд сунгаж, ингэснээр эмчилгээний клонжуулалтыг зөвшөөрдөг. Гэсэн хэдий ч 2001 оны 11-р сарын 15-нд амьдралыг дэмжигч бүлэг Дээд шүүхийн хууль эрх зүйн маргаанд ялсан бөгөөд энэ нь зохицуулалтыг цуцалж, Их Британид клончлолын бүх хэлбэрийг үр дүнтэйгээр орхисон юм. Тэдний итгэл найдвар нь парламент хориглосон хууль тогтоомжийг батлах замаар энэ орон зайг нөхөх болно гэж найдаж байв.²² Парламент 2001 онд нөхөн үржихүйг хувилахыг хориглосон Хүний нөхөн үржихүйг хувилах тухай хуулийг яаралтай баталжээ. Давж заалдах шатны шүүх Дээд шүүхийн өмнөх шийдвэрийг хүчингүй болгосноор эмчилгээний клончлолын үлдэгдэл хуулийн цоорхойг хаасан.</p> <p>Анхны лицензийг 2004 оны 8-р сарын 11-нд Ньюкасл их сургуулийн судлаачдад чихрийн шижин, Паркинсоны өвчин, Альцгеймерийн өвчний эмчилгээг судлах боломжийг олгох зорилгоор олгосон.²³ 2008 оны Хүний бордолт ба үр хөврөлийн тухай хууль нь үржил шимтэй холбоотой хууль тогтоомжийн томоохон тойм бөгөөд 1990 оны хуультай ижил нөлөө бүхий нэмэлт, өөрчлөлт оруулснаар 2001 оны Клончлолын тухай хуулийг хүчингүй болгосон. Мөн 2008 оны хууль нь хүн амьтны эрлийз үр хөврөл дээр туршилт хийхийг зөвшөөрдөг.²⁴</p>
16	Нэгдсэн Үндэстний байгууллага	Хориглосон	<p>2001 оны 12-р сарын 13-нд НҮБ-ын Ерөнхий Ассамблей хүн төрөлхтний нөхөн үржихүйн клончлолын эсрэг олон улсын конвенцийг боловсруулж эхэлсэн. Испани, Итали, Филиппин, АНУ, Коста-Рика, Ватикан зэрэг улс хүний клончлолын бүх хэлбэрийг хориглох тухай мэтгэлцээн өрнүүлсэн. Тэдний үзэж байгаагаар хүний эмчилгээний зорилгоор хувилах нь хүний нэр төрийг зөрчиж байна гэж тэмдэглэжээ. Коста Рика хүн хувилах бүх хэлбэрийг хориглох олон улсын конвенц батлахыг санал болгов. 2005 оны 3-р сард заавал биелүүлэх ёстой конвенцийн талаар зөвшилцөлд хүрч чадаагүй тул хүний нэр төрд харшлах хүнийг хувилах бүх хэлбэрийг хориглохыг уриалсан НҮБ-ын Хүнийг хувилах тухай тунхаглалыг батлав.²⁵</p>

17	АНУ	Зарим хэлбэрийг зөвшөөрсөн	Одоогоор АНУ-д клончлохыг бүрэн хориглосон холбооны хууль байдаггүй. Америкийн 15 муж (Арканзас, Калифорниа, Коннектикут, Флорида, Жоржиа, Айова, Индиана, Массачусетс, Мэрилэнд, Мичиган, Хойд Дакота, Нью Жерси, Род Айленд, Өмнөд Дакота, Виржиниа) болон гурван муж (Аризона, Мэрилэнд ба Миссури) ийм үйл ажиллагаанд төсвийн хөрөнгийг ашиглахыг хориглоно. ²⁶ Калифорниа, Коннектикут, Иллинойс, Айова, Мэрилэнд, Массачусетс, Миссури, Монтана, Нью Жерси, Род Айленд зэрэг арван мужид хүүхэд төрүүлэхийн тулд үр хөврөлийг хувиан суулгахаас сэргийлдэг, харин үр хөврөлийг устгахыг зөвшөөрдөг «"клон, устгах" хууль байдаг. ²⁷
----	-----	----------------------------	--

3. Монгол Улсад хүний генийг хувилах буюу генетикийн ижил хуулбарыг бүтээх талаарх хууль зүйн төлөв байдал

БНМАУ-ын Ерөнхийлөгчийн 1991 оны 115 дугаар зарлигаар “БНМАУ-ын хүн ам зүйн талаар баримтлах чиглэл”¹⁸ баталсан. Уг зарлигийн хавсралтад “Удамшлын өвчин, бие эрхтний согог, тахир дутуугаас сэргийлэх зорилгоор гэр бүл-эмнэлэг-удамшлын зөвлөгөө өгөх газруудыг хот, аймгийн түвшинд зохион байгуулах, ургийн элдэв өвчнийг эхийн хэвлийд оношлон сэргийлэх удамшил зүй, биохимийн орчин үеийн шинжилгээний аргыг өргөн хэрэглэнэ” гэж заасан байна.

Монгол улсын их хурлаас 1996 оны 22 дугаар тогтоолын хавсралтаар “Монгол Улсын төрөөс баримтлах хүн амын бодлого”-ыг хэрэгжүүлж ирсэн ба 2004 оны 21 тогтоолын хавсралтаар “Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого”¹⁹ батлагдсанаар тус тогтоол хүчингүй болсонд тооцсон. 2004 оны тогтоолд “1.1.1. Хүүхдийг оюун ухаан, бие бялдрын хувьд өв тэгш хөгжилтэй, эсэн мэнд, эрүүл чийрэг, сайн сайхан амьдрах нөхцөлийг бүрдүүлж 20-39 насны эхчүүдийн 2-3 жилийн зайтай төрөлтийг түлхүү дэмжинэ” зохицуулалт тусгасан.

Монгол улсын их хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”²⁰-д энэ талаар 3.1. Оршин тогтнохуйн аюулгүй байдал “Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хил хязгаарын халдашгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, монгол соёл иргэншлийн аюулгүй байдал, хүн ам, удмын сангийн аюулгүй байдлыг хангах нь оршин тогтнохуйн аюулгүй байдлын үндэс мөн”, “3.1.3.4. Цус ойртолтыг багасгах, архи дан согтууралт, мансууралтай тэмцэх ажлыг эрчимжүүлж, хүн амын удмын санд учрах сөрөг нөлөөллийг бууруулна” гэж бодлого тодорхойлсон.

Монгол улсын их хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг²¹ баталсан байна. Тус тогтоолын хавсралт 1-ийн “2.7.1. хүн бүр удмаа мэдэж, угийн бичгээ хөтлөх үндэсний уламжлалыг сэргээнэ”, “2.7.2. цус ойртолтоос сэргийлж, удамшлын өвчин болон төрөлхийн согогтой хүүхдийн эрт оношилгооны чадавхыг дээшлүүлнэ”, “2.7.4. хүн амын удмын сан, нөхөн үржихүйг хамгаалах төрийн бодлого, эрх зүйн орчныг бий болгоно” гэж тус тус

¹⁸ БНМАУ-ын Хүн ам зүйн талаар баримтлах чиглэлийг зөвшөөрөх тухай. 1991 он. Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/law/details/692>

¹⁹ Монгол Улсын төрөөс Хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогыг батлах тухай. 2004 он. Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/law/details/6278?lawid=6278>

²⁰ Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. 2010 он. Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/law/details/6163?lawid=6163>

²¹ Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл. 2020 он. Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/law/details/15584?lawid=15584>

тусгасан байна.

Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 6 дахь хэсэг “Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй...”, Арван зургадугаар зүйлийн 11 дэх хэсэг “...Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” гэх зэрэг үндсэн эрхүүдийг хуульчилж өгсөн.²²

2000 онд Донорын тухай хуулийг анх баталсан. Уг хуулиар “цус, цусан бүтээгдэхүүн, эд эрхтэнг эмчилгээний зориулалтаар хэрэглэхээр авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, хэрэглэх, экспортлох, импортлох” зохицуулалтыг тусгасан. Гэхдээ уг зохицуулалт генийн хувилах ажиллагаа биш бөгөөд зөвхөн генийн мэдээлэл агуулах эд, эрхтэнг хүнд шилжүүлэн суулгах ажиллагааг зохицуулсан. Харин уг хуулийн шинэчилсэн найруулга нь 2018 онд батлагдсан бөгөөд үүдэл эс болон эд, эсийн талаар зохицуулалтыг тусгасан. Мөн хуулийн 4 дүгээр зүйлд Донорын үйл ажиллагаанд баримтлах зарчмыг тусгасан бөгөөд хүний эмзэг мэдээллийг хамгаалах талаар тусгажээ.

1995 онд Хувь хүний нууцын тухай хууль баталсан боловч хэт ерөнхий зохицуулалттай байсан бөгөөд 2021 онд Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль батлагдан гарснаар хүний эмзэг мэдээллийг хамгаалах зохицуулалт бий болсон. Уг зохицуулалт нь Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3-т “хуульд заасан эрх бүхий байгууллага гэмт хэрэг, зөрчилтэй гэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, шалган шийдвэрлэх зорилгоор генетик болон биометрик мэдээллийг;” гэж заасан. Уг генетик мэдээллийг ашиглахтай холбоотой Цахим хөгжил, харилцаа холбооны Сайдын 2023 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн А/90 дүгээр тушаалын хавсралтаар “Хүний эмзэг мэдээлэл, генетик болон биометр мэдээлэл боловсруулахад баримтлах технологийн аюулгүй байдлын шаардлага, журам”²³ баталсан.

Уг зохицуулалтаар зөвхөн гэмт хэрэг, зөрчилтэй гэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, шалган шийдвэрлэх зорилгоор ашиглах харилцааг зохицуулсан. Харин Шүүх шинжилгээний тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3-т “Шинжилгээний адилтгал, мэдээллийн нэгдсэн сан дараах мэдээллээс бүрдэнэ:” гэж заасан бөгөөд мөн хуулийн 22.3.3-т “генетик мэдээллийн” гэж заажээ.

Хариуцлагын тооцох зохицуулалтын хувьд Зөрчлийн хуульд 2020, 2021 оны нэмэлтээр Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль болон Донорын тухай хууль зөрчигчид хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг тусгасан. Эрүүгийн хуулийн 15.3 дугаар зүйл, Хүний цус, эд, эрхтнийг хууль бусаар авах, мөн хуулийн 15.4 дүгээр зүйл, Хүний цус, эд, эрхтнийг шаардлага хангаагүй нөхцөлд бэлтгэх, шилжүүлэн суулгах гэж тусгасан байна. Дээрх зохицуулалт нь генийн шинжилгээ, судалгааны талаар шууд хориглосон агуулгатай байна. Мөн Зөвшөөрлийн тухай хуульд зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагааны жагсаалтад тусгаагүй байна. Ингэснээр генийн судалгаа, шинжилгээний үйл ажиллагаа явуулах боломжгүй нөхцөл байдал үүсжээ.

Үүнээс үзвэл Монгол Улсад хүний генетик мэдээллийн ерөнхий зохицуулалт байгаа боловч судалгаа, шинжилгээний зорилгоор ашиглах нарийвчилсан зохицуулалтгүй байсаар байна. Иймд хүний генийг хувилах буюу генетик ижил хувилбарыг бүтээх талаар хуулиар зохицуулах залшгүй шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ

Монгол Улсад хүний генетикийн талаарх хууль тогтоомжийн нарийвчилсан зохицуулалтыг бий болгох, хүний генетикийн асуудлыг төрийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх, хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулах зайлшгүй шаардлагатай

²² Ц.Амарсанаа. “Хүний удмын сан буюу генетикийн хууль зүйн асуудал” илтгэл 2021 он. Эх сурвалж: <https://legaldata.mn/buteel/pdf?id=927>

²³ Хүний эмзэг мэдээлэл, генетик болон биометрик мэдээлэл боловсруулахад баримтлах технологийн аюулгүй байдлын шаардлага, журам. 2023 он. Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760452348261&showType=1>

байна. Хүн амын эрүүл мэнд, генетик мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах, судалгаа, шинжилгээ, оношилгоо хийх талаар анхдагч хуулийг батлан гаргах хэрэгцээ зайлшгүй бий болжээ. Ингэснээр хүний генетикийн мэдээллийг хамгаалах, хүний эрүүл мэнд, сайн сайхны төлөө судалгаа, шинжилгээ, оношилгоо хийх, хадгалах, хамгаалах боломж хууль зүйн хувьд нээгдэх юм.

Дээрх үндэслэлүүдтэй холбогдуулан дараах санал дэвшүүлж байна. Үүнд:

1. Хүний генетикийн тухай анхдагч хуулийг батлах. Ингэснээр одоо хэрэгжиж байгаа Шүүх шинжилгээний тухай, Донорын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль зэрэг хуулиудад тусгах боломжгүй эмчилгээний зориулалтаар хүний генийн судалгаа, шинжилгээ, оношилгооны үйл ажиллагааг нээлттэй болгох боломжтой. Мөн хүний генетикийн талаар нарийвчилсан зохицуулалтуудыг тусгаж зохицуулагдаагүй харилцааг зохицуулах эрх зүйн орчин бүрдэнэ. Тухайлбал, хүний генийг эмчилгээний зорилгоор судалгаа, шинжилгээ хийх, мэдээллийг аюулгүй байдлыг хангах, мэдээллийг дамжуулах, устгах зэрэг харилцааг тус хуулиар зохицуулах боломжтой юм. Харин олон улсын туршлагаас авч үзвэл хүний генийн хувилах зохицуулалтыг хориглох шаардлагатай байна.

2. Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах. Хүний генетикийн судалгаа, шинжилгээ, оношилгоотой холбоотой үйл ажиллагааг хувийн хуулийн этгээд, судлаачид явуулах боломжийг бүрдүүлнэ. Генетикийн шинжлэх ухааныг хөгжүүлэхэд дан ганц төрийн чиг үүрэгт хамааруулж болохгүй бөгөөд бусад хувийн хуулийн этгээд, судлаачид, эрдэмтдийг оролцуулах шаардлагатай. Бусад улс орнуудын судалгаа, шинжилгээ, оношилгооны үйл ажиллагаа нь их сургуулиудын дэргэдэх лаборатори түшиглэн явуулж байна. Ингэхдээ мэдээлэл, сорьцын хадгалалт нь хуулиар хамгаалагдаж байна.

3. Эрүүл мэндийн тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль зэрэг холбогдох хууль зохицуулалтыг тусгах.²⁴ Хэдийгээр эрүүл мэнд, эмчилгээтэй холбоотой зохицуулалт байгаа боловч хүний генетикийн мэдээлэл агуулсан эмчилгээний талаар тусгаж өгөөгүй байна. Цаашид генетикийн түвшний эмчилгээ, оношилгоо явуулж буй тохиолдолд түүнд эмчлүүлэгчээс зөвшөөрөл авах, сорьцыг хадгалах, хамгаалах, устгах зэрэг үйл ажиллагааг зохицуулах шаардлагатай.

4. Эрүүгийн хуульд нэмэлт оруулах. Хүний генийг хувилах буюу генетик мэдээллийн холбогдолтой хуулийг ноцтой зөрчсөн, зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэх. Улс орнууд уг үйлдлийг эрүүгийн хариуцлага ногдуулж байна. Монгол улсын хувьд үүнийг нарийвчлан зохицуулсан хууль байхгүй учир хувь хүний нууцад халдах, задруулах гэх байдлаар хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан байна. Гэтэл хувь хүний мэдээлэл дотроо ач холбогдлын хувьд өөр өөр үр дагвар бий болгох учир тусгайлан гэмт хэрэг гэж хуульчлах шаардлагатай.

5. Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах. Хүний генийг хувилах буюу генетик мэдээллийн холбогдолтой хуулийг зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх зохицуулалт тусгаж өгөх шаардлагатай. Ингэснээр гэмт хэргээс бусад төрлийн зөрчилд хариуцлага тооцох нөхцөл бүрдэнэ.

6. Төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хуульчлан тусгаж өгөх. Төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хүний генетиктэй холбоотой асуудал хөндөгдөх тохиолдолд түүнийг зохицуулсан хуульд зохицуулалтуудыг байх шаардлагатай.

Цаашид хүний генетик түүнтэй холбоотой судалгаа, шинжилгээ, оношилгоо, хадгалалт, мэдээлэл шилжүүлэх, устгах зэрэг үйл ажиллагааг тусгайлан бусад үйл ажиллагаанаас ялган зохицуулах хэрэгцээ бий болсон байна. Мөн хүний генетикийн талаар зөвхөн биологи, ангаах ухааны салбарт судлах биш хууль зүйн салбар судлах шаардлагатай гэдгийг бусад улс орны хууль, тогтоомжоос дүгнэн үзэж болохоор байна.

²⁴Ц.Амарсанаа. Хүний генетикийн шинжилгээний талаарх зарим улс орны хууль тогтоомжийн зохицуулалт. 2023 он. Эх сурвалж: <https://legaldata.mn/buteel/pdf?id=1540> дэлгэрүүлэн үзнэ үү.

ЭХ СУРВАЛЖ**Монгол хэл дээрх*****Хууль, тогтоомж***

1. Монгол Улсын Үндсэн хууль.
2. Эрүүгийн хууль.
3. Зөрчлийн хууль.
4. Шүүх шинжилгээний тухай.
5. Эрүүл мэндийн тухай хууль.
6. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль Донорын тухай хууль.
7. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль.
8. Монгол Улсын хувьд Малын генетик нөөцийн тухай хууль
9. Генетик нөөцийн тухай хууль

Ном, өгүүлэл, судалгааны тайлан

1. Ж.Батсуурь, Э.Энхмаа, Монгол улсын иргэн угийн бичиг хөтлөх үлгэрчилсэн загвар, Уб.,2010.
2. С.Нарангэрэл, Монгол Улсын Хууль зүйн нэвтэрхий толь бичиг, Уб.,1995.
3. Ж.Хулан, Ерөнхий генетик, Уб.,2010.

Гадаад хэл дээрх***Ном, өгүүлэл, судалгааны тайлан***

1. Clare Feikert (2008), Regulation of human genetic technology comparative analysis, Law library of congress
2. Edith Palmer (2008) Regulation of human genetic technology Germany. Law Library The Law Library of Congress, Global Legal Research Directorate.
3. Haldane, J.B.S. (1963). "Biological Possibilities for the Human Species in the Next Ten Thousand Years". In Wolstenholme, Gordon (ed.). Man and his future. Novartis Foundation Symposia. London: J. & A. Churchill.
4. Lederberg, Joshua (1966), Experimental Genetics and Human Evolution, The American Naturalist.
5. Thomas, Isabel. (2013), Should scientists pursue cloning?, (Sci-Hi).

Цахим эх сурвалж

1. <https://www.theatlantic.com/magazine/archive/1971/05/moving-toward-the-clonal-man/305435/>
2. <http://news.bbc.co.uk/2/hi/science/nature/371378.stm>
3. <https://www.ohchr.org/en/instruments-mechanisms/instruments/universal-declaration-human-genome-and-human-rights>
4. <https://press.un.org/en/2005/ga10333.doc.htm>
5. https://web.archive.org/web/20140420052032/http://www.drze.de/in-focus/research-cloning/legal-aspects?set_language=en
6. <https://web.archive.org/web/20221102193924/http://servicios.infoleg.gob.ar/infolegInternet/verNorma.do?id=42213>
7. http://classic.austlii.edu.au/au/legis/cth/consol_act/pohcfra2002465/s23c.html
8. <https://laws-lois.justice.gc.ca/eng/acts/a-13.4/fulltext.html>

9. <https://web.archive.org/web/20140421105301/http://archive.wired.com/medtech/health/news/2004/03/62695>
10. https://ethics.gc.ca/eng/tcps2-epts2_2018_chapter12-chapitre12.html
11. <https://web.archive.org/web/20180416110933/http://www.people.com.cn/GB/shizheng/16/20020227/675390.html>
12. <http://npc.people.com.cn/n1/2020/1227/c14576-31980014.html>
13. <https://www.alcaldiabogota.gov.co/sisjur/normas/Norma1.jsp?i=6388>
14. http://www.knesset.gov.il/privatelaw/plaw_display.asp?LawTp=2
15. <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX%3AC2007%2F306%2F01>
16. <https://www.legifrance.gouv.fr/jorf/id/JORFTEXT000000441469>
17. https://web.archive.org/web/20140420050704/http://www.dnapolicy.org/policy.international.php?action=detail&laws_id=26
18. <https://www.businessworld.in/article/NDRI-uses-clone-technology-to-develop-buffalo-calf-Tejas-for-high-milk-yield/20-09-2020-322611/>
19. <https://www.dawn.com/news/1054305>
20. <https://web.archive.org/web/20190502130353/http://www.sejm.gov.pl/Sejm7.nsf/PrzebiegProc.xsp?nr=608>
21. <http://ivo.garant.ru/#%2Fdocument%2F184467%2Fparagraph%2F8889%2Fdoclist%2F9693%2Fshowentries%2F0%2Fhighlight%2FВременный%20запрет%20на%20клонирование%20человека%3A3>
22. <https://mjp.univ-perp.fr/constit/rs2006.htm#2>
23. <https://sso.agc.gov.sg/Act/HCOPPA2004?ProvIds=P13-P21-#P13-P21->
24. <http://www.sajbl.org.za/index.php/sajbl/article/view/171>
25. <https://web.archive.org/web/20170802214453/http://news.bbc.co.uk/1/hi/sci/tech/1657707.stm>
26. <https://web.archive.org/web/20071009024233/http://www.hfea.gov.uk/en/1048.html>
27. http://news.bbc.co.uk/2/hi/uk_news/politics/7682722.stm
28. <https://web.archive.org/web/20131215040939/http://www.bioeticaweb.com/content/view/1267/765/lang,es/>
29. <https://web.archive.org/web/20171204220325/http://www.ncsl.org/research/health/embryonic-and-fetal-research-laws.aspx>
30. <https://www.lexology.com/library/detail.aspx?g=81132fd8-f391-48a7-ad0b-7f96eda2caf8>
31. <https://www.legalinfo.mn/law/details/692>
32. <https://www.legalinfo.mn/law/details/6278?lawid=6278>
33. <https://www.legalinfo.mn/law/details/6163?lawid=6163>
34. <https://www.legalinfo.mn/law/details/15584?lawid=15584>
35. <https://legaldata.mn/buteel/pdf?id=927>
36. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760452348261&showType=1>

LEGAL REGULATION REGARDING HUMAN GENE COPYING OR GENETIC IDENTITY

Amarsanaa.Ts

Ph.D student

ABSTRACT:

Laws governing cloning, or engineering to create genetically identical versions of humans, vary from country to country depending on culture, religion, and prevailing societal views on the status of embryos. Because the problem is new, it is difficult to estimate the risk. Therefore, some countries have legal restrictions and allow research only.

The United Nations Educational, Scientific and Cultural Organization adopted the Universal Declaration of Human Genome and Human Rights in 1997. The declaration is a non-binding document, but calls on member states to comply. However, the declaration leaves open the freedom of research, analysis and diagnosis.

A few countries grant special licenses for the import and export of embryos and stem cells, while others prohibit them outright. Internationally, the acceptability of genetic engineering for human health and well-being remains questionable.

KEYWORDS:

Gene, genetics, genome, human genes, genetic engineering, transgenic, The Human Genome and the Universal Declaration of Human Rights

АВТОМАШИН АЧИЛТЫН КОМПАНИУД ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛЬД ЗААСАН ЭРХ ШИЛЖҮҮЛЭН АВСАН ЭТГЭЭД МӨН ҮҮ?



Н.Хулан

МУИС-ийн ХЗС-ийн магистрант,

УДШ-ийн дэргэдэх ШССМХ-ийн Захиргааны эрх зүйн секторын судлаач

ТОВЧЛОЛ:

Тус өгүүллээр автомашин ачилтын компаниудын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодруулахыг зорьсон бөгөөд тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах зөвшөөрөл олгох эрх бүхий цагдаагийн албан хаагчийн үйл ажиллагаа болон тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах явцад үүссэн хохирол зэрэг бусад асуудлын тухай хөндөөгүй болохыг дурдах нь зүйтэй.

ТҮЛХҮҮР ҮГС:

Автомашин ачилтын компани, зөөж шилжүүлэх, түр саатуулах, захиргааны гэрээ, эрх шилжүүлэн авах, захиргааны чиг үүрэг, иргэдийн Төлөөлөгчдийн хурал, нийслэлийн Засаг дарга

Удиртгал

Монцамэ мэдээллийн агентлагийн мэдээнд дурдсанаар¹ 2022 оны 3 дугаар улирлын байдлаар улсын хэмжээнд 1,112,644 автомашин байгаагаас 57 хувь буюу 642,315 нь нийслэлд бүртгэлтэй байна гэжээ. Автомашины тоо жил бүр тогтмол өсөж байгаа боловч үүнтэй уялдан авто зогсоолын тоо нэмэгдэхгүй байгаа учраас замын хөдөлгөөний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх үйлдэл, нөхцөлийг таслан зогсоох зорилгоор зөвшөөрөлгүй газар жолоочгүй зогссон тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах ажлыг хувийн хэвшлийн автомашин ачилтын компаниуд гүйцэтгэж байна. Авто тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах үйл ажиллагаа нь нийтийн /тодруулбал, захиргааны/ эрх зүйн асуудал хэдий ч Улаанбаатар хотын хэмжээнд 15 компани (хувийн эрх зүйн хуулийн этгээд) машин ачилтын үйл ажиллагаа явуулдаг². Автомашин ачилтын компани, тэдгээрийн үйл ажиллагаа болон ачуулсан автомашинуудтай холбоотой статистик, мэдээллийг олж үзэх боломжтой нээлттэй мэдээллийн сан байхгүй боловч албан бус эх сурвалжид³ дурдсанаар

¹ “Нийслэлд зорчиж буй тээврийн хэрэгслийн тоо 10 жилд 50 хувиар нэмэгджээ”, *Монцамэ агентлаг*, <https://montsame.mn/mn/read/303251> [Сүүлд үзсэн: 2023.10.01]

² Ачигч автомашинуудын нэгдсэн холбооны албан ёсны вэбсайт, <https://auto-ub.com/law> [Сүүлд үзсэн: 2023.10.01]

³ “Түр зогссон машин ачдаг журмыг өөрчилнө” сурвалжилга, *News.mn*, <https://news.mn/r/2633643/> [Сүүлд үзсэн: 2023.10.01]

цагдаагийн байгууллагын алба хаагчаас 2021 он, 2022 оны эхний хагас жилийн байдлаар тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах 130,537 зөвшөөрөл олгожээ.

Монгол Улсын Үндсэн хуульд өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаалж, өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно гэж заасан. Гэвч иргэний өмч (тээврийн хэрэгсэл)-ийг зөөж шилжүүлэх, түр саатуулах эрхийг хувийн эрх зүйн хуулийн этгээдүүд хэрэгжүүлж байх тул тус эрхийг аливаа хууль тогтоомж, нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр гүйцэтгэж байх учиртай.

Иймд энэхүү өгүүллээр автомашин ачилтын компаниудыг Захиргааны ерөнхий хуульд заасан эрх шилжүүлэн авсан этгээд мөн эсэхийг тодорхойлохыг зорилоо.

Үндсэн хэсэг:

Нэг. Захиргааны зарим чиг үүргийг бусад этгээдэд шилжүүлэх тухай хуулийн зохицуулалт

Захиргааны эрх зүй нь нийтийн эрх зүйн субъектив эрхийг хамгаалах үндсэн зорилгоо хэрэгжүүлэхийн тулд харилцааны нэг талд захиргааны байгууллага байхыг шаарддаг. Сурах бичигт⁴ дурдсанчлан захиргааны байгууллага гэж төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлж буй, нийтийн эрх зүйн хэм хэмжээнд үндэслэгдсэн, тодорхой хариуцсан чиг үүрэгтэй, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах тусгай эрх хуулиар олгогдсон нийтийн эрх зүйн хуулийн этгээд байх бөгөөд Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т хувийн эрх зүйн хуулийн этгээд захиргааны байгууллага гэж тооцогдох онцгой тохиолдлыг хуульчилсан.

Төр нь төрийн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагууд /шууд захиргаа/ болон нийтийн эрх зүйн бусад хуулийн этгээд, эрх шилжүүлэн авсан этгээд /шууд бус захиргаа/-ээр дамжуулан чиг үүргээ биелүүлж болдог тул өөрийн чиг үүргээ нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр шилжүүлж, хувийн хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх боломж бий. Тодруулбал, Засгийн газрын тухай хууль⁵-ийн 19 дүгээр зүйлийн 19.1-д “Засгийн газар нь төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг холбогдох хууль, түүнд үндэслэсэн Засгийн газрын шийдвэр, гэрээний үндсэн дээр Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн буюу хэсэгчлэн санхүүжүүлж болно” гэж заасан нь захиргааны чиг үүргийг шилжүүлэх эрх зүйн зохицуулалтын үндэс болж байх ба тус зохицуулалтаас үзвэл Засгийн газар өөрийн тодорхой чиг үүргийг хууль, түүнд үндэслэсэн шийдвэр, гэрээний үндсэн дээр шилжүүлнэ гэж тодорхой заасан байна.

Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-ийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 1995 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 111 дүгээр тогтоолоор “Төрийн гүйцэтгэх байгууллагын тусгай чиг үүрэг буюу дэд салбарын тодорхой чиг үүргийг Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлэх ерөнхий журам”⁶-ыг баталжээ. Тус журмын 2-т “Төрийн гүйцэтгэх байгууллагын тусгай чиг үүрэг буюу дэд салбарын тодорхой чиг үүргийг Засгийн газрын бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай шийдвэрийг холбогдох сайдын санал болгосноор Засгийн газар гаргана” гэж, 3-т “Засгийн газрын бус байгууллага нь төрийн гүйцэтгэх байгууллагын тусгай чиг үүрэг буюу дэд салбарын тодорхой чиг үүргийг гүйцэтгэхдээ хууль тогтоомж, түүнд үндэслэсэн Засгийн газрын шийдвэр, гэрээг баримталж, холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж тус тус заасан.

Түүнчлэн Захиргааны ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Хуульд зааснаас бусад тохиолдолд захиргааны байгууллага хуулиар тусгайлан заасан бүрэн эрхийг бусдад шилжүүлэхийг хориглоно” гэж заасан бөгөөд үүнийг Захиргааны ерөнхий хуулийн

⁴ П.Одгэрэл, *Захиргааны эрх зүйн ерөнхий анги*, 3 дахь хэвлэл, Уб, Мөнхийн үсэг, 2016, 103 дахь тал.

⁵ *Төрийн мэдээлэл эмхэтгэл*, 1993, №03

⁶ Засгийн газрын 1995 оны 111 дүгээр тогтоолын хавсралт, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=201046&showType=1>

тайлбарт⁷ хуульд заасан бүрэн эрхийг хуульд заасан тохиолдолд бусад этгээдэд шилжүүлж болох ба хэрэв захиргааны байгууллага тодорхой чиг үүргээ бусдад шилжүүлэхийг хүсвэл, тухайлбал захиргааны гэрээ байгуулах замаар бусдад зарим чиг үүргээ шилжүүлэх тохиолдолд заавал хуулиар зөвшөөрөгдсөн байх шаардлагатай гэжээ.

Дээрхээс үзвэл аливаа эрх бүхий захиргааны байгууллага нь хууль, түүнд үндэслэсэн Засгийн газрын тогтоолд үндэслэн аливаа этгээдтэй захиргааны гэрээ байгуулсны үндсэн дээр л захиргааны чиг үүргийг шилжүүлж болно. Жишээ нь, Барилгын тухай хууль⁸-ийн 34 дүгээр зүйлийн 34.1-д барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (Барилга, хот байгуулалтын яам)-ын чиг үүргийг хуульчилсан байх ба 34.2-т “Энэ хуулийн 34.1.2, 34.1.3, 34.1.4, 34.1.6, 34.1.7, 34.1.8, 34.1.9, 34.1.10, 34.1.11, 34.1.13, 34.1.14, 34.1.15-д заасан чиг үүргийг эрх бүхий байгууллагын шийдвэрийн үндсэн дээр төрийн бус, мэргэжлийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно” гэж заасан байна. Ийнхүү Барилгын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2-т заасны дагуу Засгийн газрын 2018 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 51 дүгээр тогтоол⁹-оор Барилгын тухай хуулийн 34.1.2, 34.1.4, 34.1.6, 34.1.7, 34.1.8, 34.1.9, 34.1.10, 34.1.11, 34.1.13, 34.1.15-д заасан барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг «Барилгын хөгжлийн төв» аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газраар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэхээр тогтоожээ. Тодруулбал, Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Барилгын хөгжлийн төвд хууль болон Засгийн газрын тогтоол, гэрээний үндсэн дээр өөрийн зарим чиг үүргийг шилжүүлэн өгчээ.

Хувийн эрх зүйн хуулийн этгээд нь Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 8 дугаар зүйлийн 8.1, 52 дугаар зүйлийн 52.2.2-т заасны дагуу захиргааны байгууллагаас хууль болон нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр тухайн захиргааны байгууллагын зарим чиг үүрэг, эрх мэдлийг шилжүүлэн авч болдог.

Гэвч Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т заасан “... болон...” гэдэг холбоосыг анхаарах шаардлагатай юм. Тодруулбал, монгол хэлний нэг төрлийн аливаа хоёр нэгжийг холбох ёс, холбох ерөнхий зүй тогтол, холбох гол тогтолцооны үүднээс авч үзвэл холбох үг нь тухайн хоёр нэгжийг нэг бол зэрэгцүүлэн аль эсвэл угсруулан холбодог¹⁰ бөгөөд “болон” холбоос нь зэрэгцүүлэн холбох ангилалд хамаардаг. Харин хэд хэдэн нөхцөлөөс сонгох боломжтой, нэг нөхцөл нь дангаар биелэх тохиолдолд “эсвэл (эсхүл)” холбоосыг ашигладаг. Хэл шинжлэлч эрдэмтэд “эсвэл (эсхүл)” гэх холбоосыг тусгаарлан ялгах, салгах утгатай холбоос үг мөн гэж тайлбарласан байдаг.¹¹

Дээрхээс үзвэл Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т захиргааны чиг үүргийг шилжүүлэн авахдаа “хууль эсхүл нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр” гэж хуульчлаагүй харин “хууль болон нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр” дээр гэж хуульчилсан байх тул тус хоёр нөхцөл зэрэг биелэгдэнэ гэж ойлгох нь зүйтэй байна.

Захиргааны ерөнхий хуулийн төслийг хэлэлцсэн Хууль зүйн байнгын хорооны тэмдэглэл¹², Улсын Их Хурлын анхны¹³ болон эцсийн¹⁴ хэлэлцүүлгээс үзвэл захиргааны чиг үүргийг бусад этгээдэд шилжүүлэхтэй холбоотой зохицуулалт буюу Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 52 дугаар зүйлийн 52.2.2-той холбоотойгоор тухайлан

⁷ Ханнс-Зайделийн сан, Эрх зүйн боловсрол академи, Монгол Улсын захиргааны ерөнхий хуулийн тайлбар, 2017, 87-88 дахь тал.

⁸ Төрийн мэдээлэл эмхэтгэл (2016) №09 [Сүүлд үзсэн: 2023.10.09]

⁹ Засгийн газрын 2018 оны 51 дүгээр тогтоол, <https://legalinfo.mn/mn/detail/13222> [Сүүлд үзсэн: 2023.10.09]

¹⁰ Ю.Мөнх-Амгалан, Кан Шин, *Орчин цагийн монгол хэлний бүтээвэр судлал*, Уб, Соёмбо принтинг, 2014, 298-299 дэх тал.

¹¹ Б.Батбаяр, Л.Энхтайван, Хууль зүйн тодорхойгүй нэр томьёо: Практик хэрэглээ, асуудал, шийдэл (цуврал 1), Хууль дээдлэх эс сэтгүүл 48 (4), 2019, 29 дэх тал [Сүүлд үзсэн: 2023.10.09]

¹² Улсын Их хурлын 2015 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сарын 09-ний өдрийн хуралдааны тэмдэглэл, *Parliament.mn*, <https://www.parliament.mn/nn/2098/> [Сүүлд үзсэн: 2023.10.07]

¹³ Улсын Их хурлын 2015 оны хаврын ээлжит чуулганы 6 дугаар сарын 12-ны өдрийн хуралдааны тэмдэглэл, *Parliament.mn*, <https://www.parliament.mn/nn/4658/> [Сүүлд үзсэн: 2023.10.07]

¹⁴ Улсын Их хурлын 2015 оны хаврын ээлжит чуулганы 6 дугаар сарын 19-ний өдрийн хуралдааны тэмдэглэл, *Parliament.mn*, <https://www.parliament.mn/nn/6912/> [Сүүлд үзсэн: 2023.10.07]

санал хэлэлцээгүй баталжээ. Мөн Захиргааны ерөнхий хуулийн тайлбарт¹⁵ нарийвчлан тайлбарлаагүй байна.

Захиргааны чиг үүргийн эрх зүйн үндсийг хуулиар тогтоодог буюу аливаа захиргааны байгууллагын эдлэх эрх, гүйцэтгэх үүргийг Улсын Их Хурлаас хууль тогтоох замаар баталдаг. Ийнхүү Улсын Их Хурлаас олгосон бүрэн эрхийг хэрэгжүүлэгч захиргааны байгууллага нь Улсын Их Хурлын зөвшөөрөл (өөрийн чиг үүргийг шилжүүлж болох тухай хуулийн зохицуулалт)-гүйгээр захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт, захиргааны гэрээ гаргах замаар бусад этгээдэд шилжүүлэх нь хууль тогтоогчийн үзэл санаанд нийцэхгүй бөгөөд эрх зүйн үндэслэлгүй болох юм.

Хоёр. Автомашин ачилтын компаниуд тээврийн хэрэгслийг түр саатуулах, зөөж шилжүүлэх эрх зүйн үндэс

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль¹⁶-ийн 8 дугаар зүйлийн 8.3-т “Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах зөрчлийн бүртгэлийн оноо тооцох журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасныг үндэслэн «Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах журам»¹⁷-ыг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн А/101 тушаалын хавсралтаар баталсан бөгөөд тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах асуудлыг Хууль зүй дотоод хэргийн сайдын 2019 оны А/101 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан журамд заасны дагуу шийдвэрлэж байна. Тус журамд тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах зөвшөөрлийг цагдаагийн алба хаагч өгсний үндсэн дээр аймаг, нийслэл, сумын Засаг даргатай гэрээ байгуулсан автомашин ачилтын компани тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах ажлыг гүйцэтгэнэ гэж зохицуулжээ.

Тус журмын дагуу иргэний өмч (тээврийн хэрэгсэл)-ийг зөөж шилжүүлэх, түр саатуулах эрхийг хувийн эрх зүйн хуулийн этгээдүүд буюу машин ачилтын компаниуд хэрэгжүүлж байх бөгөөд уг эрхийг ямар хууль тогтоомжийн үндсэн дээр аль захиргааны байгууллагаас шилжүүлэн авсан болохыг тогтоосноор машин ачилтын компаниуд нь Захиргааны ерөнхий хуульд заасан эрх шилжүүлэн авсан этгээд гэж үзэх боломжтой болох юм.

Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах тухай эрх зүйн зохицуулалтыг судлаад үзвэл Цагдаагийн албаны тухай хууль¹⁸-ийн 34 дүгээр зүйлийн 34.1-д замын хөдөлгөөний дүрэмд түр, эсхүл удаан зогсохыг хориглосон газарт зайлшгүй зогсолтоос бусад хэлбэрээр зогсоож орхисон эсхүл Цагдаагийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.3-т заасан тохиолдолд цагдаагийн алба хаагч нь тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлнэ гэж зохицуулсан байна. Мөн Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.1-д замын хөдөлгөөний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх үйлдэл, нөхцөлийг таслан зогсоох үндэслэлээр тээврийн хэрэгслийг албадан зогсоох, дайчлах, түр саатуулах, зөөж шилжүүлэх нь цагдаагийн байгууллагын эрх байхаар хуульчилжээ.

Судалгааны эх сурвалж болон Засгийн газрын тогтоолуудад дурдсанчлан төрийн гүйцэтгэх байгууллагын чиг үүргийг шилжүүлэн авсан этгээд тухайн чиг үүргийг гүйцэтгэхтэй холбогдон гарах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх бөгөөд гэрээний хэрэгжилт буюу тухайн чиг үүргийг хэрхэн хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд хяналт тавих эрх бүхий этгээд нь тухайн чиг үүргийг шилжүүлсэн захиргааны байгууллага байна гэжээ.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны тушаалын 9.6-д “Нийслэлд замын цагдаагийн нэгж, орон нутагт тухайн нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага

¹⁵ Ханнс-Зайделийн сан, Эрх зүйн боловсрол академи, Монгол Улсын захиргааны ерөнхий хуулийн тайлбар, 2017, 247 дахь тал

¹⁶ Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2015, №28

¹⁷ Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн А/101 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан «Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах журам», <https://legalinfo.mn/mn/detail?lawId=209856&showType=1> [Сүүлд үзсэн: 2023.10.09]

¹⁸ Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017, №08.

тээврийн хэрэгсэл түр саатуулах, зөөж шилжүүлэх үйл ажиллагаанд өдөр тутмын хяналтыг тавьж ажиллана” гэж заасан байх ба үүнийг дээрх өгүүлбэртэй харьцуулан үзвэл ачилтын компаниуд цагдаагийн байгууллагаас эрх шилжүүлэн авах шаардлагатай гэж үзэж болохоор байна. Мөн тус журамд санхүүжилттэй холбоотой зохицуулалт байхгүй бөгөөд автомашин ачилтын компаниуд нь төсвийн санхүүжилт авдаггүй.

Тус эх сурвалжуудаас үзэхэд хууль тогтоогч тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах эрхийг цагдаагийн байгууллагад олгосон гэж үзэхээр байх ба цагдаагийн байгууллага нь Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар 5.1.1-д заасны дагуу захиргааны байгууллага болдог тул машин ачилтын компаниуд нь цагдаагийн байгууллагаас эрх шилжүүлэн авсны үндсэн дээр тус эрхийг хэрэгжүүлж байх учиртай. Гэвч холбогдох хуулиудад тус бүрэн эрхийг шилжүүлж болох тухай зохицуулалт байхгүй байна.

Иймд, автомашин ачилтын компаниуд нь эрх бүхий захиргааны байгууллагаас тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах бүрэн эрхийг шилжүүлэн аваагүй гэж үзэх боломжтой байх бөгөөд санхүүжилт, хяналтын тогтолцооноос үзвэл Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т заасан захиргааны чиг үүргийг хууль болон нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр шилжүүлж авсан этгээд мөн гэж шууд үзэхэд учир дутагдалтай байна. Гэвч практикт автомашин ачилтын компаниуд нь нийтийн эрх зүйн этгээдийн адилаар захирамжилсан шийдвэр гаргаж иргэдийн хувийн өмчид халдаж байгаа нь бодитой тул тус харилцааны эрх зүйн үндсийг зайлшгүй тодорхойлох шаардлагатай болно.

Хувийн эрх зүйн хуулийн этгээд тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах болсон анхдагч нөхцөлийг судалбал, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.4-т аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, тээврийн хэрэгслийг түр саатуулах хашаа /байр/ ажиллуулах шийдвэр гаргах, төлбөрийн хувь хэмжээг тогтоох үүргийг хэрэгжүүлнэ гэж, Хууль зүйн сайдын 2015 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн А/190 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах журам”¹⁹-ын 3.2-т “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь энэхүү журмын 3.1-д заасан саналд үндэслэн тээврийг хэрэгслийг зөөж шилжүүлэх гудамж, зам, хамрах хүрээ, үйлчлэх цаг болон түр саатуулах хашаа/байр/, түүний зогсоолын нийт талбайн хэмжээ, зориулалтын чирэгч, ачигч автомашины нийт тоо, үйл ажиллагааны төлбөрийн хувь хэмжээг тогтооно” гэж тус тус заасныг үндэслэл болгон Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас 2015 онд “Нийслэлд тээврийн хэрэгслийг зориулалтын автомашинаар зөөж шилжүүлэх, түр саатуулах хашаа /байр/ ажиллуулах болон эдгээр үйл ажиллагааны төлбөрийн хувь хэмжээг тогтоох тухай” 33/35 дугаар тогтоолыг баталсан байна.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 33/35 дугаар тогтоолын дагуу Нийслэлд тээврийн хэрэгслийг зориулалтын автомашинаар зөөж шилжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах тухай нийслэлийн Засаг даргын 2016 оны А/35 дугаар захирамж гарсан²⁰ ба тус захирамжаар нийслэлийн хэмжээнд замын хөдөлгөөний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх үйлдлийг таслан зогсоох, замын хөдөлгөөнд оролцогчдын хэвийн, аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах ажлыг гүйцэтгүүлэх аж ахуйн нэгжийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулахыг нийслэлийн Засаг даргын Зам тээвэр дэд бүтцийн асуудал хариуцсан орлогчид, гэрээ байгуулан, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллахыг нийслэлийн Авто замын газарт даалгажээ.

¹⁹ Хууль зүйн сайдын 2015 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн А/190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан «Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах журам», <http://road.ub.gov.mn/?p=736> <http://road.ub.gov.mn/?p=736> [Сүүлд үзсэн: 2023.10.07]

²⁰ “Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах ажлыг гүйцэтгэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулна” сурвалжилга, Мнб.мн, <https://www.mnb.mn/i/76019> (Уг захирамж <https://legalinfo.mn/mn>-д нээлттэй байршаагүй, бусад эх сурвалжаас олдоогүй болно) <http://road.ub.gov.mn/?p=736> [Сүүлд үзсэн: 2023.10.07]

Ийнхүү нийслэлийн Засаг даргын захирамжийн дагуу тээврийн хэрэгслийг зориулалтын автомашинаар зөөж шилжүүлэх, түр саатуулах хашаа /байр/ ажиллуулах үйл ажиллагааг явуулах хуулийн этгээдийн сонгон шалгаруулалтыг зарласан²¹ байх ба тухайн үед үйлчилж байсан Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах журам (Хууль зүйн сайдын 2015 оны А/190 дүгээр тушаал)-ын 3.3-т “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь энэхүү журмын 3.2.-т заасан шийдвэрийн дагуу тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах хашаа/байр/ ажиллуулахад тавигдах шаардлагыг хангасан аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулж, ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэх гэрээ байгуулна...” гэж заасны дагуу сонгон шалгаруулалтын үр дүнд шаардлага хангасан компаниудтай гэрээ байгуулсан гэж үзэж болохоор байна²².

Дээрх нөхцөл байдлаас дүгнэвэл нийслэлийн Засаг дарга нь замын хөдөлгөөний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх үйлдлийг таслан зогсоох, замын хөдөлгөөнд оролцогчдын хэвийн, аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх зорилгоо хэрэгжүүлэхийн тулд аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулж байх тул гэрээгээр зохицуулж буй харилцаа, гэрээний зорилго, агуулга зэргээс харгалзан үзвэл тус гэрээг захиргааны гэрээ гэж үзэх үндэслэлтэй.

Гэвч энэ тохиолдолд холбогдох журмуудад аймаг, нийслэл, сумын Засаг дарга нь сонгон шалгаруулалтад тэнцсэн аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулна (ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэх гэрээ) гэж хувийн эрх зүйн эсхүл захиргааны гэрээ алийг нь байгуулахыг тодорхойгүй зохицуулсан байгаа бөгөөд тухайн аж ахуйн нэгж, байгууллагуудтай байгуулсан гэрээ нь нийтэд ил байхгүй байх тул эргэлзээ үүсэж байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах журам (Хууль зүйн сайдын 2015 оны А/190 дүгээр тушаал), Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах журам (Хууль зүйн сайдын 2019 оны А/101 дүгээр тушаал)-аас үзвэл иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, тээврийн хэрэгслийг түр саатуулах хашаа /байр/ ажиллуулах шийдвэр гаргах эрхийг л хууль болон журмаар олгосон. Харин тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах эрхийг хууль болон журмаар эрх шилжүүлэн өгөөгүй байна.

Дээрхээс дүгнэвэл, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах хашаа /байр/ ажиллуулахад тавигдах шаардлагыг хангасан аж, ахуйн нэгж, байгууллагатай ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэх гэрээ байгуулах эрхийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад олгосон байна. Гэвч нийслэлийн Засаг дарга нь 2016 оны А/35 дугаар захирамжаар өөрт олгогдоогүй эрхийг хэрэгжүүлсэн буюу тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах ажлыг гүйцэтгүүлэх аж ахуйн нэгжийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулахыг даалгажээ.

Зүй нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас олгосон эрхийн дагуу аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь шаардлага хангасан аж, ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулж; тус сонгон шалгаруулалтад тэнцсэн аж, ахуйн нэгж, байгууллагууд нь цагдаагийн байгууллагаас хуульд заасны дагуу эрх шилжүүлэн авах учиртай. Гэвч тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах эрхийг шилжүүлж болох тухай зохицуулалт Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон Цагдаагийн албаны тухай хуульд байхгүй байгааг анхаарууштай.

²¹ Дүрэм зөрчсөн тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах урилга, Монгол Улсын Засгийн албан ёсны вебсайт, <https://mongolia.gov.mn/news/view/12040> (Тус сонгон шалгаруулалтад оролцсон байгууллага, үр дүнгийн талаар нээлттэй мэдээлэл байхгүй байв) <http://road.ub.gov.mn/?p=736> [Сүүлд үзсэн: 2023.10.07]

²² “Машин ачилтын компаниудын «угж»-ны мөнгө нэмэгдэж иргэд 100 мянган төгрөгөөр торгуулдаг болох нь” сурвалжилга, Tentswer.mn, <https://tentswer.mn/s/2537> (... намайг уг ажлыг 2016 онд авахад 21 ачилтын компани бүртгэлтэй байсан. Түүнээс хойш гэрээний зөрчил болон бусад дүрэм журмаа зөрчсөн асуудлаар зарим ачилтын компанийн үйл ажиллагааг нь зогсоосон. Одоо хувийн 14 ААН үйл ажиллагаагаа явуулж байна...) <http://road.ub.gov.mn/?p=736> [Сүүлд үзсэн: 2023.10.07]

Гурав. Автомашин ачилтын компаниуд болон иргэд хооронд үүсэж буй төлбөрийн харилцаа

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2015 оны 33/35 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх болон тусгай хашаа /байр/-ны үйл ажиллагааны төлбөрийн хувь хэмжээг тогтоосон байна. Тус тогтоолын дагуу иргэн өөрийн автомашинаа ачуулсан тохиолдолд суудлын автомашин бол 60 мянган төгрөг, том оврын автомашин, автобус бол 90 мянган төгрөг, мотоцикл бол 30 мянган төгрөгийг машин ачилтын компанид төлж, машинаа эргүүлэн авахаар журамлажээ.

Сурах бичигт²³ дурдсанаар төлбөр нь агуулгаараа бусдын шаардлагыг биелүүлэх үйл ажиллагаа бөгөөд төлбөрийг нийтийн эрх зүйн төлбөр, хувийн эрх зүйн төлбөр гэж ангилна. Шаардлага нь хууль буюу захирамжилсан актын үндсэн дээр үүссэн бол энэ нь нийтийн эрх зүйн шаардлага болох бөгөөд үүнээс нийтийн эрх зүйн төлбөр үүснэ. Харин шаардлага нь тэгш эрх бүхий субъектүүдийн харилцан тохиролцсон гэрээ хэлцлийн үндсэн дээр бий болсон бол энэ нь хувийн эрх зүйн шаардлага болох бөгөөд үүнээс хувийн эрх зүйн төлбөр үүснэ. Уг тодорхойлолтоос үзвэл иргэн ачуулсан машинаа авахын тулд төлбөр төлөх үүрэг нь гэрээ, хэлцлийн үндсэн дээр бий болоогүй харин захирамжилсан актын үндсэн дээр бий болж байх тул нийтийн эрх зүйн төлбөрт хамаарна.

Нийтийн эрх зүйн мөнгөн төлбөр нь татвар болон бусад төлбөр (онцгой төлбөр, хураамж, торгууль)-өөс бүрдэнэ. Татварын ерөнхий хууль²⁴-ийн 6 дугаар зүйлийн 6.1.36-д “«төлбөр» гэж төрийн өмчийн газар, газрын хэвлий, байгалийн баялаг, ой, ургамал, рашаан, ашигт малтмал, газрын тосны нөөц, агаар, ус, хөрс ашигласны, бохирдуулсны, ан амьтан агнасны төлөө аливаа этгээдээс авч төсөвт төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгийг” хэлнэ гэж заасан тул машин ачилтын төлбөр нь үүнд хамаарахгүй байна.

Иймд машин ачилтын компаниудын иргэдээс авч буй төлбөр нь албан татвар, төлбөр, торгуульд хамаарахгүй байх тул хураамж байж болох юм. Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.40-д “«хураамж» гэж төрийн байгууллагаас аливаа этгээдэд хууль тогтоомжийн дагуу үйлчилгээ үзүүлсний төлөө тэднээс тухай бүр авч төсөвт төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгийг” хэлнэ гэжээ. Хураамж нь төрийн байгууллагаас хууль хэрэгжүүлэх явцдаа иргэдэд тодорхой үйлчилгээ үзүүлсэн тохиолдолд тухайн үйлчилгээг авч хэрэглэсэн хувь этгээдээс үйлчилгээнийхээ хөлсөнд авч буй мөнгөн төлбөр байна.²⁵

Хууль тогтоогч Татварын ерөнхий хуульд Монгол Улсын татварын 30 төрлийг нэг бүрчлэн жагсааж, мөн хуульд зааснаас бусад тохиолдолд татварыг зөвхөн Улсын Их Хурал татварын хуулиар бий болгох, тогтоох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох эрхтэй²⁶ буюу Монгол Улсын иргэн зөвхөн татварын хуульд заасан тохиолдолд татвар төлөхөөр хуульчилсан. Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т “Тодорхой төрлийн татварын харилцааг энэ хууль болон тухайн төрлийн татварын хуулиар зохицуулна” гэж заасны дагуу хураамжийн хэмжээг тогтоох, төлөх, чөлөөлөх харилцааг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль²⁷-аар зохицуулдаг.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд хураамж төлөх үйлчилгээний төрлийг нэг бүрчлэн жагсааж, мөн хураамжийг тогтоох эрхтэй байгууллагыг зааж өгсөн байх бөгөөд машин ачилтын төлбөртэй холбоотой зохицуулалт тус хуульд байхгүй байгааг дурдах нь зүйтэй.

Татварын ерөнхий хууль нь цаг хугацааны хувьд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн дараа батлагдсан хэдий ч Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль нь Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулиас өмнө үйлчилж байсан. Иймд

²³ П.Одгэрэл, *Татварын эрх зүй*, 3 дахь хэвлэл, Уб, 2021, 24 дэх тал.

²⁴ *Төрийн мэдээлэл эмхэтгэл*, 2019, №22

²⁵ П.Одгэрэл, *Татварын эрх зүй*, 3 дахь хэвлэл, Уб, 2021, 29 дэх тал.

²⁶ Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг

²⁷ *Төрийн мэдээлэл эмхэтгэл*, 2011, №01.

тус хуулиар зохицуулаагүй хураамжийн төрлийг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд тусгаж, аймаг, нийслэл, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хуралд бүрэн эрх олгосон нь эрх зүйн үндэслэлгүй байна.

Дүгнэлт:

Нийтлэг ойлголтоор автомашин ачилтын компаниудыг нийтийн эрх зүйн этгээдийн адилаар захирамжилсан шийдвэр гаргаж, тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах үүргийг хэрэгжүүлж буй утгаар нь Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т заасан захиргааны зарим чиг үүргийг шилжүүлэн авсан этгээд мөн гэж ойлгодог. Гэвч судалгааны явцад хууль тогтоомж, онолын болон бусад мэдээллийн эх сурвалжуудаас үзэхэд Монгол Улсын өнөөгийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд автомашин ачилтын компаниудыг Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т хамааруулах боломжгүй байна. Энэ нь хууль хоорондын уялдаа холбоогүй, эрх зүйн зохицуулалтын тодорхойгүй байдлаас үүдэлтэй гэж дүгнэх үндэслэлтэй.

Тодруулбал, хууль тогтоогч нь тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах эрхийг анхнаасаа цагдаагийн байгууллагад өгсөн байх бөгөөд тус эрхийг шилжүүлэх эрхийг хуулиар олгоогүй нь Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.1, Цагдаагийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-ээс харагддаг. Хэдийгээр Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгээр хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд замын хөдөлгөөн зохицуулах ... журмыг батлах эрхийг өгсөн байх боловч тус Засгийн газрын гишүүн нь хуулиас давсан журам баталжээ. Ийнхүү дүгнэх учир нь дээр дурдсанчлан тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах эрхийг шилжүүлэх эрхийг цагдаагийн байгууллагад хуулиар олгоогүй байхад Хууль зүй, дотоод хэргийн сайд А/101 тушаалаар баталсан “Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах журам»-аараа тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах зөвшөөрлийг цагдаагийн алба хаагч өгсний үндсэн дээр аймаг, нийслэл, сумын Засаг даргатай гэрээ байгуулсан автомашин ачилтын компани тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах ажлыг гүйцэтгэхээр журамлажээ. Энэ нь нэгдүгээрт, Захиргааны ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Хуульд зааснаас бусад тохиолдолд захиргааны байгууллага хуулиар тусгайлан заасан бүрэн эрхийг бусдад шилжүүлэхийг хориглоно” гэснийг; хоёрдугаарт, хууль тогтоогчоос олгосон цагдаагийн байгууллагын тусгай эрхийн асуудлыг аймаг, нийслэл, сумын Засаг даргын бүрэн эрхэд хамааруулан журамласан нь чиг үүргийн хамаарлыг зөрчсөн шийдвэр болжээ.

Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах шийдвэр нь үр дагаврын хувьд иргэний өмчлөх эрхээ хэрэгжүүлэхтэй шууд холбоотой учир хууль тогтоогчоос зориуд цагдаагийн байгууллагын тусгай бүрэн эрхэд хамааруулсан байх үндэслэлтэй. Гэвч цагдаагийн байгууллага, цагдаагийн алба хаагч нь тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах үйл ажиллагааг эрхлэхэд ажлын ачаалал, хүний нөөцийн хувьд дутагдалтай гэдэг нь илт тул тус нөхцөл байдлыг захиргааны гэрээний үндсэн дээр шийдвэрлэх боломжтой юм. Тодруулбал, цагдаагийн байгууллага, цагдаагийн албан хаагч нь тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах шийдвэрийг гаргаж, харин тус шийдвэрийг биелүүлэх буюу тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах ажлыг хувийн аж ахуйн нэгжээр захиргааны гэрээний үндсэн дээр хэрэгжүүлж болно.

Хэдийгээр одоо ч гэсэн тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах зөвшөөрлийг цагдаагийн алба хаагч өгсний үндсэн дээр автомашин ачилтын компани тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах ажлыг гүйцэтгэж байгаа боловч эдгээр автомашин ачилтын компаниуд нь хуульд нийцээгүй журамд үндэслэн, эрх олгогдоогүй этгээдтэй гэрээ байгуулан ажиллаж байгаа учир үйл ажиллагаа нь бүхэлдээ эрх зүйн үндэслэлгүй болох юм.

Түүнчлэн өгүүллийн 3 дахь хэсэгт автомашин ачилтын компаниудын иргэдээс авч буй төлбөр эрх зүйн үндэслэлгүй байгаа тухай авч үзсэн. Гэвч нэгэнт тодорхой үйл ажиллагаа явуулж, түүнтэй холбоотой зардал гарах нь зайлшгүй бөгөөд үүнийг зөрчил гаргасан этгээдээс гаргуулах нь зүйтэй. Иймд тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлсэн, түр саатуулсан тохиолдолд иргэнээс тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлсэн, түр саатуулсан зардлыг гаргуулж, цагдаагийн байгууллагын дансанд, эсхүл тухайн нэгжийн төсөвт төвлөрүүлэхээр журамлаж, харин автомашин ачилтын компаниуд нь шууд иргэдийн төлбөрөөс санхүүжихээ больж, захиргааны гэрээний үндсэн дээр санхүүждэг болсноор автомашин ачилтын компаниудын үйл ажиллагаа хуульд нийцэх юм.

Өгүүллийн туршид машин ачилтын компаниудын тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах эрхийг эдэлж буй эрх зүйн үндэслэлийг эрж хайсан бөгөөд судлаачийн зүгээс дүгнэлт болон саналаа дараах байдлаар ерөнхийлж байна.

1. Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах нь Цагдаагийн албаны тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд зохицуулснаар цагдаагийн алба хаагчийн бүрэн эрхэд хамаарч байна. Мөн хуулиудад тус бүрэн эрхийг бусад этгээдэд шилжүүлж болох тухай хуульчлаагүй бөгөөд цагдаагийн байгууллагаас өөрийн зарим чиг үүргийг машин ачилтын компаниудад шилжүүлсэн байдал тогтоогдоогүй тул машин ачилтын компаниуд нь Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т хамаарахгүй байна.

2. Харин машин ачилтын компаниудын үйл ажиллагааны эрх зүйн үндэс болсон хуулиуд болон иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолуудаас үзэхэд машин ачилтын компаниуд нь улсын төсвөөс санхүүжилт авахгүйгээр хэрэглэгч, зах зээлээс санхүүжих нөхцөлтэйгөөр нийслэлийн Засаг даргатай ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, цагдаагийн байгууллагын зөвшөөрлөөр тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах ажлыг гүйцэтгэж байна.

3. Гэвч нийслэлийн Засаг даргын машин ачилтын компаниудтай байгуулж байгаа гэрээ, машин ачилтын компаниудыг хэрхэн сонгон шалгаруулж ажил гүйцэтгүүлж байгаа нь ил тод биш байна. Нийслэлд тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, саатуулах, төлбөртэй зогсоол ажиллуулах журмын хэрэгжилтэд хийсэн аудитын тайлан²⁸-гаас үзвэл 2020 оны эцсийн байдлаар гэрээ байгуулсан 14 аж ахуйн нэгж байсан бол өнөөдрийн байдлаар Ачигч автомашинуудын нэгдсэн холбооны вэбсайтад гэрээ байгуулсан 15 аж ахуйн нэгж байгаа гэсэн мэдээлэл байгаа юм. Уг байдлаас үзвэл 1 аж ахуйн нэгж хэрхэн нэмэгдсэн, мөн бусад 14 аж ахуйн нэгжийн хувьд ч өөрчлөгдсөн эсэх нь тодорхойгүй байна.

4. Машин ачилтын компаниудын иргэдээс авч буй үйлчилгээний төлбөр нь хууль хоорондын уялдаа холбоогүй байдлаас үүдэн эрх зүйн үндэслэлгүй байх үр дагаварт хүргэж байна. Тодруулбал, 2011 оны Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд хуульчлаагүй байсан хураамжийн төрлийг 2015 оны Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд тусгасан. Ингээд 2019 оны Татварын ерөнхий хууль батлагдсанаар тус хуульд зааснаас бусад тохиолдолд иргэн татвар төлөх үүрэггүй байдлаар хуульчилснаар машин ачилтын компаниудын иргэдээс авч буй төлбөр нь эрх зүйн үндэслэлгүй болж байна.

Санал:

Дээрх дүгнэлтэд үндэслэн судлаачийн зүгээс дараах саналыг дэвшүүллээ. Үүнд:

1. Автомашин ачилтын компаниудын эрх зүйн байдлыг тодорхой болгож хууль болон холбогдох журамд тусгах;
2. Автомашин ачилтын компаниудтай Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу захиргааны гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилт, үр дүнг нээлттэй болгох;
3. Машин ачилтын компаниудын иргэдээс авч буй төлбөрийг хуульд нийцүүлэх, өөрчлөн тогтоох.

²⁸ Үндэсний аудитын газар, Нийслэлд тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, саатуулах, төлбөртэй зогсоол ажиллуулах журмын хэрэгжилтэд хийсэн аудитын тайлан

<https://open.audit.mn/reports/open.audit.mn/pages/20211228005103/watermarked.pdf> [Сүүлд үзсэн: 2023.10.09]

ЭХ СУРВАЛЖ**Монгол хэл дээрх*****Хууль тогтоомж***

1. Захиргааны ерөнхий хууль, 2015.
2. Засгийн газрын тухай хууль, 1993.
3. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, 2015.
4. Цагдаагийн албаны тухай хууль, 2017.
5. Татварын ерөнхий хууль, 2019.
6. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, 2011.
7. Барилгын тухай хууль, 2016.
8. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн А/101 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан «Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах журам».
9. Хууль зүйн сайдын 2015 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн А/190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан «Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах журам».
10. Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2015 оны “Нийслэлд тээврийн хэрэгслийг зориулалтын автомашинаар зөөж шилжүүлэх, түр саатуулах хашаа / байр/ ажиллуулах болон эдгээр үйл ажиллагааны төлбөрийн хувь хэмжээг тогтоох тухай” 33/35 дугаар тогтоол.

Ном, өгүүлэл, судалгааны тайлан

1. С.Нарангэрэл, Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг, УБ, Адмон принт, 2021.
2. П.Одгэрэл. Захиргааны эрх зүйн ерөнхий анги, 3 дахь хэвлэл, УБ, Мөнхийн үсэг, 2016.
3. Г.Банзрагч, Эдийн засгийн захиргааны эрх зүй, УБ, Pronta Press, 2013).
4. П.Одгэрэл, Татварын эрх зүй, 3 дахь хэвлэл, УБ, 2021.
5. Ханнс-Зайделийн сан, Эрх зүйн боловсрол академи, Монгол Улсын захиргааны ерөнхий хуулийн тайлбар, УБ, 2017.
6. Ч.Баатар, “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаарх онолын зарим асуудалд” Legaldata.mn, 2018.
7. Б.Батбаяр, Л.Энхтайван, “Хууль зүйн тодорхойгүй нэр томъёо: Практик хэрэглээ, асуудал, шийдэл (цуврал 1)”, Хууль дээдлэх ёс сэтгүүл 48 (2019).
8. Ю.Мөнх-Амгалан, Кан Шин, Орчин цагийн монгол хэлний бүтээвэр судлал, УБ Соёмбо принтинг, 2014.
9. Үндэсний аудитын газар, Нийслэлд тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, саатуулах, төлбөртэй зогсоол ажиллуулах журмын хэрэгжилтэд хийсэн аудитын тайлан, 2021.

Цахим эх сурвалж

1. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем – <https://legalinfo.mn/mn>.
2. Хууль зүйн судалгааны бүтээлийн цахим сан – <https://legaldata.mn/>.
3. Улсын Их Хурлын Тамгын газрын цахим хуудас – <https://www.parliament.mn/>.
4. Ачигч машинуудын нэгдсэн холбооны албан ёсны вэбсайт – <https://auto-ub.com/law>

**ARE TOWING COMPANIES THE SUBJECT ENTITIES WHO ARE GRANTED
ADMINISTRATIVE FUNCTIONS UNDER THE GENERAL ADMINISTRATIVE
LAW?**

Khulan.N,

Master's student, School of Law, NUM

Researcher, Administrative Law sector,

Judicial Training, Research and Information Institute

ABSTRACT:

The article aims to clarify the legal basis of the service of the towing companies. However, it does not cover the operation of the police officers who are entitled to grant permission to detain and relocate vehicles and any other issues such as damage caused during the service.

KEYWORDS:

Towing companies, to detain or relocate vehicles, an administrative agreement, to assign the functions, functions of an administrative body, local self-governing body, the Governor or Mayor of the Capital city

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ДОТООД МЭДЭЭЛЭЛ АШИГЛАН АРИЛЖААНД ОРОЛЦОХ: ХАРИУЦЛАГЫН ТОГТОЛЦОО

/ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА/



М.Ганди

*Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн
Эрдэм шинжилгээний ажилтан*

ТОВЧЛОЛ:

Хөрөнгийн зах зээлийн үр ашигтай, өгөөжтэй байлгах чухал хүчин зүйлийн нэг бол дотоод мэдээлэл эзэмшигч түүнийгээ ашиглан арилжаанд оролцохгүй байх явдал юм. Үнэт цаасны зах зээл (цаашид “ҮЦЗЗ” гэх)-д дотоод мэдээллийг ашиглаж арилжаанд оролцох нь ихэнх тохиолдолд бусдад их хэмжээний хохирол учруулах боломжтой, мэргэжлийн түвшинд урьдчилан бэлтгэгдэж, эсвэл үгсэн хуйвалдах замаар хийгддэг зохион байгуулалттай гэмт хэрэг учраас ҮЦЗЗ-д дотоод мэдээллийг хууль бусаар ашиглан арилжаанд оролцсон үйлдэлд Эрүүгийн хуулиар хариуцлага ноогдуулах нь оновчтой байна. Үнэт цаасны зах зээл нь зайлшгүй төрийн зохицуулалт, хяналтын дор үйл ажиллагаа явуулах шаардлага тулгардаг ба тус зах зээлд буруу практик болох дотоод мэдээлэл ашиглан давуу байдал бий болгон үнэт цаасны арилжаанд оролцох асуудал ил, далд хэлбэрээр цөөнгүй гардаг тул тус сэдвийн хүрээнд АНУ болон ХБНГУ-ын хууль тогтоомжийн харьцуулсан судалгаа хийв.

ТҮЛХҮҮР ҮГС:

Хөрөнгө оруулагчдад тэгш хандах зарчим, инсайдер (Insider), нон-инсайдер (Non-insider), үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 78 дугаар зүйл, үнэт цаасны зах зээлийн үнэн зөв мэдээлэл, үйл ажиллагаа

ОРШИЛ

Үнэт цаасны зах зээлд дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцох тухай ойлголт нь 1934 онд анх удаа АНУ-д insider trading нэртэйгээр Хөрөнгийн биржийн тухай хуульд орж ирсэн байдаг. Харин манай улсад хөрөнгийн зах зээлд дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцохыг хориглосон зохицуулалтыг 2013 оны Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд анх удаа тусгасан байдаг бөгөөд энэ хуулийн хэрэгжилтийг хангах, Үнэт цаасны зах зээлд хууль бус арилжаа эрхлэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2019 онд “Үнэт цаасны зах зээл зэх дотоод мэдээллийн жагсаалт, түүнийг мэдээлэх журам”-ыг шинэчилсэн байдаг. Ийнхүү манай улсад хожуу орж ирсэн

ойлголт ч гэсэн үнэт цаасны эрх зүйн салбарт ил, далд хэлбэрээр гардаг зөрчлийн дийлэнх хувийг ҮЦЗЗ-д дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцох үйлдэл эзэлж байна. Иймд тус судалгааны ажлын хүрээнд Үнэт цаасны дотоод мэдээллийн ашиглан арилжаанд оролцох хориг нь эрүү-, захиргааны хэм хэмжээтэй хэрхэн уялдаж буй талаар судалсан ба тэдгээрийн хэм хэмжээний зөрчлийг илрүүлэхээс гадна бусад улс орнуудын дотоод мэдээлэл болон дотоод мэдээлэл эзэмшигчийн тухай ойлголтыг харьцуулав.

Нэг. хувьцаа эзэмшигчийн тэгш эрхийн зарчим

Компанийн дотоод мэдээлэл эзэмшигч нь тухайн мэдээллийг журамд заасны дагуу нийтэд мэдээлэхээс өмнө уг мэдээллийг санамсаргүй болон санаатайгаар мэдээлэх, дамжуулах, ашиглах, бусдад олж авах нөхцөлийг бүрдүүлэхийг хориглодог.¹ Хэрэв хууль тогтоогч дотоод мэдээлэл эзэмшигч болон бусад оролцогсдыг эдгээр мэдээллийг ашиглан арилжаанд оролцохыг зөвшөөрвөл зах зээлд мэдээлэл түгэхээс урьтаж, өөрийн давуу талыг ашиглан үнэт цаас худалдах эсвэл худалдаж авснаар маш их ашиг олох боломжтой.²

Жишээлбэл тун эерэг (уг мэдээллийн улмаас тухайн компанийн хувьцааны үнэ өсөх нь тодорхой) мэдээллийг олон нийтэд хүргэх гэж буй хувьцаат компанийн захирал өмнөхөн нь компанийн хувьцааг ихээр худалдаж аваад энэ мэдээлэл цацагдсаны дараа хувьцааны ханш өсөхийг хүлээнэ. Хувьцаа нь өссөний дараа тэрээр хувьцааг зарж тэр хэмжээний ашиг олох боломжтой болно. Мөн санхүүгийн бэрхшээлтэй болсон компанийн хувьцааг энэ талаар олж мэдсэн банкны ажилтан үнийг буурахаас өмнө худалдаж өөртөө хохиролгүй, эсвэл байж болох хэмжээнээс илүү бага хэмжээний хохиролтой байхаар тооцох зэрэг үүнд хамаарна.³

Эдийн засгийн ухааны үүднээс дотоод мэдээлэл ашиглан зах зээлд оролцох явдлыг ашигтай, ашиггүй хэмээн маргаж болох ч үнэт цаасны зах зээлийн эрх зүйн хөрөнгө оруулагчдад тэгш хандах зарчимд энэ нь харшилж байна.⁴ Хувьцаа эзэмшигчийн тэгш эрхийн зарчмын (англи хэл., principle of equal treatment of shareholders) ач холбогдол нь хувьцаанаас олох ашгийг урьдчилан таамаглах боломжийг олгож, хувьцаа худалдаж авах замаар хөрөнгө оруулахыг дэмжихэд оршино. Хувьцаа эзэмшигчийн тэгш эрхийн зарчим байхгүй тохиолдолд том хувьцаа эзэмшигч өөрийн эзэмшлийн хувиас илүү хэмжээний ашгийг хүртэж, бусад хувьцаа эзэмшигчдийн эзэмшлийн хувьцааны үнэ цэнэ буурах эрсдэл үүснэ. Өөрөөр хэлбэл, уг зарчим нь дээрх эрсдэлийг бууруулж, хувьцаагаар дамжуулан хөрөнгө оруулах боломжийг дэмждэг.⁵ Тиймээс хуульд дотоод мэдээллийг нэн даруй мэдэгдэх, нийтэд ил болгох үүргийг тусгасан байдаг. Харин ийнхүү мэдээлэл хийх хүртэл дотоод мэдээлэл эзэмшигчид тухайн үнэт цаас, санхүүгийн хэрэгслийн арилжаанд оролцохыг хориглон, ҮЦЗЗтХ §78.

ХОЁР. ДОТООД МЭДЭЭЛЭЛ БОЛОН ДОТООД МЭДЭЭЛЭЛ ЭЗЭМШИГЧИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ

Дотоод мэдээлэл

Монгол улс нь иргэний эрх зүйн системтэй улс учир эх газрын эрх зүйн тогтолцоотой улсуудаас хүчтэй төлөөлөл болох ХБНГУ-ыг сонгосон бөгөөд дээр дурдсанчлан хамгийн анх Үнэт цаасны зах зээлд дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцох тухай ойлголтыг Хөрөнгийн биржийн тухай хуульд оруулж ирсэн АНУ-ыг тус тус сонгож харьцуулалт хийх үндэслэл болов.

Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 76.1: Монгол улсын Үнэт

¹ Үнэт цаас гаргагчийн дотоод мэдээллийн ил тод байдлын журам, 5.1 дэх тал.

² Б.Буянхшиг, *Үнэт цаасны зах зээлийн эрх зүй*, Анхны хэвлэл, Уб, 2014, 211 дэх тал.

³ Мөн тэнд

⁴ Katja Langenbucher: *Aktien- und Kapitalmarktrecht*, 2008 Beck Verlag, S.260; Б.Буянхшиг, *Үнэт цаасны зах зээлийн эрх зүй*, Анхны хэвлэл, Уб, 2014, 212 дахь тал.

⁵ Г.Давааням, *Хувьцаат компанийн эрх зүйн үндсэн ойлголт*, Уб, 2021, 142 дахь тал.

цаасны зах зээлийн тухай хууль (цаашид “ҮЦЗЗТХ” гэх) болон журамд зааснаар дотоод мэдээлэл гэж үнэт цаас гаргагчтай холбоотой нийтийн хүртээл болоогүй, нийтийн хүртээл болсон тохиолдолд тодорхой үнэт цаасны үнэ ханшид мэдэгдэхүйц хэмжээгээр нөлөө үзүүлэх мэдээллийг ойлгоно. Нийтэд нээлттэй мэдээлэлд үндэслэн хийсэн дүн шинжилгээ нь үнэт цаасны ханш, арилжааны хэмжээнд мэдэгдэхүйц нөлөөлөх боломжтой байсан ч түүнийг дотоод мэдээлэл гэж үзэхгүй. Дотоод мэдээлэлд Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 72 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Үнэт цаасны зах зээл дэх дотоод мэдээллийн жагсаалт, түүнийг мэдээлэх журам”⁶ (цаашид “Журам” гэх)-ын 2 дугаар зүйлд жагсаасан 30 зүйл заалт хамаарна.

Америкийн Нэгдсэн улсын 1934 оны Securities Exchange Act: АНУ-ын шүүхийн үзэж байгаагчлан «дотоод мэдээлэл» гэж материаллаг, нийтэд ил болоогүй, хэрэв ил болбол компанийн хувьцааны үнэд нөлөөлөхүйц, эсвэл хувьцааг худалдаж авах, худалдах шийдвэр гаргаж буй хүний хөрөнгө оруулалтын шийдвэрт нөлөөлөхүйц мэдээллийг ойлгоно⁷. “Материаллаг” гэж хувьцаа эзэмшигчид болон хөрөнгө оруулагчид хувьцаа болон үнэт цаасыг худалдаж авах, худалдах эсэхээ шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой гэж үзэх мэдээллийг ойлгоно. “Нийтэд ил болоогүй” гэж олон нийтэд журмын дагуу цацагдаагүй мэдээллийг ойлгоно. Материаллаг дотоод мэдээлэл эерэг эсвэл сөрөг байж болно. Жишээлбэл, дотоод мэдээлэлд дараах зүйлс агуулагдана⁸:

- хүлээгдэж буй орлогын мэдэгдэхүйц өөрчлөлт (дээш эсвэл доош);
- үнэт цаасыг нийтэд болон хувийн санал болгох;
- зээлийн хугацаа хэтэрсэн талаарх мэдээлэл;
- хүлээгдэж буй эсвэл санал болгож буй нэгдэх, худалдан авах, хамтарсан үйлдвэр байгуулах, томоохон хөрөнгө борлуулах эсвэл бусад стратегийн төлөвлөгөө;
- зохицуулалтын зөвшөөрөл, патентын бүртгэл, зөвшөөрөл, судалгаа гэх мэт;
- шинээр үнэт цаас гаргах, санал болгох;
- томоохон маргаан, нэхэмжлэл, чухал маргаан гарсан эсвэл чухал өөрчлөлт гарсан;
- удирдлагын өөрчлөлт;
- шинэ бүтээгдэхүүний зарлал; болон
- томоохон үйлчлүүлэгчид, ханган нийлүүлэгчид эсвэл бизнесийн түншүүдийн ашиг, алдагдал.

ХБНГУ-ын Зах зээлийг зүй бусаар ашиглах тухай журам: Европын парламент болон Зөвлөлийн 2014 оны 4-р сарын 16-ны өдрийн 596/2014 тоот бүхий Зах зээлийг зүй бусаар ашиглах тухай журам⁹-ын 7 дугаар зүйлд “дотоод мэдээлэл”-ийг дараах байдлаар тусгасан байна.

(a) Нэг буюу хэд хэдэн үнэт цаас гаргагчтай, эсхүл нэг буюу хэд хэдэн санхүүгийн хэрэгсэлтэй шууд болон шууд бусаар холбоотой, нарийн шинж чанартай, нийтэд ил болгоогүй, ил болсон тохиолдолд тэдгээр санхүүгийн хэрэгслийн үнэ эсвэл холбогдох үүсмэл санхүүгийн хэрэгслийн үнэд ихээхэн нөлөө үзүүлэхүйц мэдээлэл;

(b) нэг буюу хэд хэдэн деривативтай шууд болон шууд бусаар холбоотой, эсхүл холбогдох спот барааны гэрээтэй шууд холбоотой, нарийн шинж чанартай, нийтэд ил болгоогүй, ил болсон тохиолдолд эдгээр дериватив болон холбогдох спот барааны гэрээний үнэд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх магадлалтай, мөн олон нийтэд дүрэм, журмын дагуу ил болгох шаардлагатай мэдээлэл;

(c) үнэт цаас гаргах болон түүн дээр үндэслэн дуудлага худалдаагаар зарагдсан

⁶ Холбоо: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=209750&showType=1> Сүүлд үзсэн: 2023.11.30

⁷ Secure Exchange Act of 1934 (АНУ-ын Үнэт цаас ба арилжааны комиссын албан ёсны цахим хуудас), <https://www.sec.gov/about/about-securities-laws>, Үнэт цаасны зах зээлд гарч байгаа гэмт хэрэг, зөрчлийн эрх зүйн зохицуулалт, хяналтыг сайжруулах зарим асуудал, И.Ургамал, <https://legaldata.mn/buteel/pdf?id=1414>

⁸ АНУ-ын Үнэт цаас ба арилжааны комиссын албан ёсны цахим хуудас, https://www.sec.gov/Archives/edgar/data/1164964/000101968715004168/globalfuture_8k-ex9904.htm#:~:text=The%20Company%20officers%2C%20directors%2C%20certain,purchase%20of%20the%20Company%20stock.

⁹ Market Abuse Regulation (MAR), 596/2014 тоот <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/PDF/?uri=CELEX:32014R0596>

бүтээгдэхүүнтэй холбоотой, нарийн шинж чанартай, нийтэд ил болгоогүй, ил болсон тохиолдолд холбогдох үнэт цаасны үнэд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх магадлалтай мэдээлэл;

(d) санхүүгийн хэрэглүүртэй холбоотой захиалгыг гүйцэтгэх үүрэг хүлэсэн этгээдийн хувьд нэг буюу хэд хэдэн үнэт цаас гаргагчтай, эсхүл нэг буюу хэд хэдэн санхүүгийн хэрэгсэлтэй шууд болон шууд бусаар холбоотой, нарийн шинж чанартай, нийтэд ил болгоогүй, ил болсон тохиолдолд тэдгээр санхүүгийн хэрэгслийн үнэ, холбогдох спот барааны үнэд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх боломжтой үйлчлүүлэгчийн дамжуулсан болон санхүүгийн хэрэглүүр дэх үйлчлүүлэгчийн хүлээгдэж буй захиалгатай холбоотой мэдээллийг ойлгоно.

“Нарийн шинж чанартай мэдээлэл” гэдэг нь тухайн мэдээлэл нь одоо байгаа эсвэл ирээдүйд бий болох нь тодорхой болсон үйл явдал, хувьцааны үнэ, гэрээ, хэлцэл, болон дуудлага худалдаанд оруулсан бүтээгдэхүүнд үндэслэсэн аливаа мэдээллийн ойлгоно. “Нийтийн хүртээл болбол холбогдох үнэт цаасны үнэд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх мэдээлэл” гэдэг нь хувьцаа эзэмшигчид болон хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтын шийдвэрийнхээ үндэс болгон ашиглах боломжтой мэдээллийг ойлгоно.¹⁰

Дотоод мэдээлэл эзэмшигч

Монгол улсын Санхүүгийн зохицуулах хорооны журам, АНУ болон ХБНГУ-ын зохицуулалт дахь “Дотоод мэдээлэл эзэмшигч”-ийн талаарх ойлголтыг энэ хэсэгт тусгав.

Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаасны зах зээл дэх дотоод мэдээллийн жагсаалт, түүнийг мэдээлэх журам”: Үнэт цаас гаргагчийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан, ажилтан болон тэдгээрийн холбогдох этгээд, албан үүргээ хэрэгжүүлэх, гэрээ, хэлцлийн бэлтгэл болон түүнийг байгуулах, гүйцэтгэх үе шатанд дотоод мэдээллийг олж авсан этгээд болон тэдгээрийн холбогдох этгээдийг дотоод мэдээлэл эзэмшигч гэж үзнэ. Дотоод мэдээлэл эзэмшигчид дараах этгээд хамаарна¹¹:

- Үнэт цаас гаргагч, түүний толгой болон охин, хараат компанийн эрх бүхий албан тушаалтан;
- Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон гаргасан хувьцааны хяналтын багцыг эзэмшигч;
- Өөрийн албан үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдон аль нэг үнэт цаас гаргагчтай холбоотой дотоод мэдээллийг олж авах боломжтой, эсхүл олж авсан Хороо, хөрөнгийн бирж, үнэт цаасны зах зээлд оролцогч зохицуулалттай этгээдийн ажилтан, тэдгээрийн холбогдох этгээд;
- Үнэт цаас гаргагчийн хараат бус зөвлөхүүд болох хуульч, аудитор, үнэлгээчин, бусад санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын эрх бүхий албан тушаалтан, ажилтан;
- Журмын 2.1.13-д заасны дагуу үнэт цаас гаргагчтай аливаа гэрээ байгуулсан, эсхүл гэрээ байгуулахаар завдаж буй этгээд, тэдгээр нь хуулийн этгээд бол эрх бүхий албан тушаалтан;
- Дээрх үүрэгт албан тушаал өөрчлөгдсөнөөс хойш 1 жилийн хугацаа өнгөрөөгүй байгаа этгээд.

Америкийн Нэгдсэн улсын 1934 оны Securities Exchange Act: Дотоод мэдээлэл эзэмшигч гэдэгт тухайн компанийн эрх бүхий албан тушаалтан, захирал, мөн компанийн саналын эрхтэй хувьцааны 10 хувийг эзэмшигч болон эдгээр хүмүүстэй ямар нэгэн эрх зүйн харилцааны үндсэн дээр дотоод мэдээллийг олж авсан этгээдийг ойлгоно.¹² Этгээд гэдэгт хувь хүн, хуулийн этгээд, Засгийн газар, төрийн байгууллага, агентлагууд орно.¹³ Дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцохыг хориглох ойлголт нь уг тухайн дотоод мэдээллийг

¹⁰ Европын парламент болон Зөвлөлийн 596/2014 тоот бүхий Зах зээлийг зүй бусаар ашиглах тухай журмын 7 дугаар зүйл.

¹¹ Журмын 3 дугаар зүйл.

¹² АНУ-ын Үнэт цаас ба арилжааны комиссын албан ёсны цахим хуудас, https://www.sec.gov/Archives/edgar/data/1164964/000101968715004168/globalfuture_8k-ex9904.htm#:~:text=The%20Company%20officers%20directors%2C%20certain,purchase%20of%20the%20Company%20stock.

¹³ Secure Exchange Act of 1934, Sec.3 (9).

ямарваа нэгэн байдлаар (гэр бүлийн гишүүд, найз нөхдөөс) олж авсан хүн бүрийг дотоод мэдээлэл эзэмшигчид хамруулах ба тэдгээрийг арилжаанд оролцохыг хориглодог.¹⁴

ХБНГУ-ын Зах зээлийг зүй бусаар ашиглах тухай журам: Харин Европын парламент болон Зөвлөлийн 2014 оны 4-р сарын 16-ны өдрийн 596/2014 тоот бүхий Зах зээлийг зүй бусаар ашиглах тухай журмын 8 дугаар зүйлийн (4)-т заасны дагуу дотоод мэдээллийг дараах байдлаар олж авсан этгээдийг “Дотоод мэдээлэл эзэмшигч” гэнэ. Үүнд:

(a) Үнэт цаас гаргагч, эсхүл үнэт цаасны зах зээлд оролцогч захиргааны, удирдлага, хяналтын байгууллагын гишүүн байх;

(b) Хяналтын багц эзэмшигч эсвэл тус зах зээлд оролцогч байх;

(c) Ажил мэргэжлийн чиг үүргийг хэрэгжүүлэх явцад мэдээлэл олж авах боломжтой этгээд байх;

(d) Гэмт хэрэгт холбогдсоны үндсэн дээр мэдээлэл олж авсан.

Мөн дээр заасан дотоод мэдээлэл эзэмшиж буйгаа мэдэж байгаа, мэдэх боломжтой хүмүүсээс гадна ямарваа нэгэн байдлаар дотоод мэдээллийг эзэмшиж буй хүн бүрийн “дотоод мэдээлэл эзэмшигч” гэж үзнэ.¹⁵ Дотоод мэдээлэл эзэмшигчийг “insider” болон “non-insider” хэмээн ангилж болно.

Хүснэгт 1. Insider ба Non-insider-ийн тухай ойлголт

¹⁴ <https://www.investopedia.com/terms/i/insider.asp>

¹⁵ Мөн тэнд.

<p>Инсайдер (Insider): ХБНГУ-ын хууль тогтоомжид дотоод мэдээлэл эзэмшигч гэдэгт үнэт цаас гаргагчтай дараах 3 холбоосны аль нэгэнтэй нь холбогдож дотоод мэдээлэл эзэмшдэг хүмүүсийг хэлдэг.</p> <p>- Эхний бүлэг хүмүүс нь удирдлага эсвэл хяналтын зөвлөлийн гишүүдээс бүрдэнэ. ХБНГУ-ын хууль АНУ-ын хууль тогтоомжийг бодвол илүү өргөн хүрээтэй бөгөөд энэ нь зөвхөн үнэт цаас гаргагчийн захирал, албан тушаалтнуудад төдийгүй нэгдмэл сонирхолтой компанийн захирал, албан тушаалтнуудад “Insider” статус олгодог.¹ Энэ нь Европын парламент болон Зөвлөлийн 2014 оны 4-р сарын 16-ны өдрийн 596/2014 тоот бүхий Зах зээлийг зүй бусаар ашиглах тухай журмын² 8 дугаар зүйлийн (4) (а)-д тусгалаа олсон байна.</p> <p>- Хоёрдох бүлэгт дотоод мэдээлэл эзэмшигчид нь тухайн компани дахь хувьцааны эзэмшлийн улмаас дотоод мэдээлэл авах боломжтой хүмүүсээс бүрдэнэ. Энэ нь дотоод хариуцлагын онолыг үгүйсгэдэг тул АНУ-аас арай өөр байдаг байна. Өөрөөр хэлбэл, хяналтын багц эзэмшигчийг захирал, эрх бүхий албан тушаалтан шиг дотоод мэдээлэл эзэмших эрх бүхий этгээд гэж үзэж дотоод мэдээлэл эзэмших эрх мэдлийг олгодог байна. Үүний нэг шалгуур нь хэн нэгний хувийн ашиг тусын тулд бус зөвхөн байгууллагын зорилгоор ашиглах боломжтой нууц мэдээлэлд хандах эрхтэй байх юм.³ Уг ойлголт нь Зах зээлийг зүй бусаар ашиглах тухай журмын⁴ 8 дугаар зүйлийн (4) (b) -д тусгалаа олсон байна.</p>	<p>Non-insider: ХБНГУ-ын хуулийн дагуу нийтэд ил болоогүй дотоод мэдээллийг ямарваа нэгэн байдлаар хүлээн авсан бүх этгээд тус мэдээллийг ашиглан арилжаа хийх эрхгүй байхад АНУ өмнө нь гадны этгээдэд ял шийтгэлгүй арилжаа хийх боломж олгодог байсан. Жишээ нь, АНУ-ын Хөрөнгийн биржийн тухай хуулийн 10b-5-д заасны дагуу дотоод мэдээлэл эзэмшигч уг мэдээллийг бусдад дамжуулсны үндсэн дээр тухайн этгээд хувийн ашиг сонирхлын үүднээс арилжаа хийсэн тохиолдолд хариуцлагыг арилжаа хийсэн этгээд бус дотоод мэдээллийг бусдад дамжуулсан этгээд хүлээдэг байсан байна.</p> <p>Хариуцлагын эдгээр хоёр арга зам нь харилцан итгэлцлийн үүргийг зөрчсөнөөс хамаарна. Шалтгаант онолын үүднээс, хэрэв дотоод мэдээлэл эзэмшигч нь хувийн ашиг сонирхлын үүднээс компанийн өмнө хүлээсэн үүргээ зөрчиж тус мэдээллийг бусдад дамжуулаагүй бол тухайн этгээд уг мэдээллийг ашиглан арилжаа хийхгүй байх байсан хэмээн үздэг.⁷</p>
<p>- Гуравдах бүлэг нь ажил мэргэжлийн үүргээ биелүүлсний үндсэн дээр дотоод мэдээлэл олж авсан этгээдүүдийг ойлгоно. Тиймээс ажилчид нь байгууллагын шатлал зэрэглэлээс үл хамааран ажил эрхлэх явцад нийтийн хүртээл болоогүй мэдээлэл санамсаргүй болон санаатайгаар олж мэдсэн үедээ дотоод мэдээлэл эзэмшигч болдог. Ажил эрхэлж байх хугацаандаа дотоод мэдээлэл эзэмшигч болсон ажилчин нь зарчмын дагуу уг мэдээллийг ашиглан арилжаа эрхлэхээс татгалзах шаардлагатай байдаг.⁵ Уг ойлголт нь Зах зээлийг зүй бусаар ашиглах тухай журмын⁶ 8 дугаар зүйлийн (4) (c)-д тусгалаа олсон байна.</p>	<p>ХБНГУ-ын хувьд итгэлцлийн элемент агуулаагүй байна. Өөрөөр хэлбэл ямарваа нэгэн байдлаар дотоод мэдээллийг олж авсан Insider болон Non-insider аль аль нь уг мэдээллийг ашиглан арилжаанд оролцохоос татгалзах үүрэгтэй байна.⁸</p>

ГУРАВ. ХАРИУЦЛАГЫН ТОГТОЛЦОО

1.3.Монгол Улс

Үнэт цаасны зах зээлд дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцох үйлдэл нь ихэнх тохиолдолд бусдад их хэмжээний хохирол учруулах боломжтой, мэргэжлийн түвшинд урьдчилан бэлтгэгдэж, эсвэл үгсэн хуйвалдах замаар хийгддэг зохион байгуулалттай гэмт хэрэг учраас ҮЦЗЗ-д дотоод мэдээллийг хууль бусаар ашиглан арилжаанд оролцсон

үйлдэлд хариуцлага ноогдуулах шаардлагатай байдаг. Монгол улсын хувьд тус хууль бус үйлдэлд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 78.1, Эрүүгийн хуулийн 18.8, Зөрчлийн тухай хуулийн 11.10 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасан гэмт үйлдлийн бүрэлдэхүүнийг тогтоож хариуцлагыг ноогдуулж байна.

2019 онд СЗХ-оос баталсан Журмын¹⁶-ын 4 дүгээр зүйлийн 4.1-т заасныг харвал уг зохицуулалт нь дотоод мэдээллийг ашиглан үнэт цаасны арилжаанд оролцох (1), гуравдагч этгээдэд дотоод мэдээллийг дамжуулах, мэдээлэх эсхүл мэдээлэл олж авах нөхцөлийг бүрдүүлэх (2), дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцохыг бусдад зөвлөх, санал болгох (3) мөн хөрөнгө оруулагчдыг төөрөгдөлд оруулах мэдээллийг нийтийн хүртээл болгох (4) гэсэн үндсэн бүрэлдэхүүнтэй байна.

Үүнээс дүгнэвэл дотоод мэдээлэл эзэмшигч нь санаатай болон санамсаргүйгээр дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцсон; бусдад дамжуулсан; олж авах нөхцөлийг бүрдүүлсэн; санал болгосон; төөрөгдөлд оруулах мэдээллийг нийтийн хүртээл болгосон бол түүнийг ҮЦЗЗТХ-ийн 78.1-ийг зөрчсөнд тооцно. Үнэт цаасны зах зээлд дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцох үйлдэл нь зах зээлд бодит бус үнэ ханш тогтоох, хөрөнгө оруулагчдын итгэх итгэлийг бууруулах, тэдэнд тэгш бус боломж олгох, зах зээлийн тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлдэг тул 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж буй ҮЦЗЗТХ-иар дээрх гаргасан зөрчилд хүлээлгэх хариуцлагын хэмжээ ихээхэн өндөр байхаар хуульчлагдсан.

3.1.1. Зөрчлийн тухай хуулийн зохицуулалт

Зөрчлийн тухай хуулийн 11.10 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт зааснаар дотоод мэдээлэл эзэмшигч бусдад дотоод мэдээллийг задруулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол уг мэдээллийн улмаас ханш, арилжааны хэмжээ нь хэлбэлзэх үнэт цаас, түүнд суурилсан санхүүгийн хэрэгслийн арилжаанд оролцсон (1); уг мэдээллийг дотоод мэдээлэл гэдгийг мэдсэн эсэхээс үл хамааран ханш, арилжааны хэмжээ нь хэлбэлзэх үнэт цаас, түүнд суурилсан санхүүгийн хэрэгслийн арилжаанд оролцохыг бусдад санал болгосон, эсхүл ятгасан (2); албан тушаал, ажил үүргийн хувьд мэдээллийг нээлттэй болгох үүрэг хүлээснээс бусад тохиолдолд бусдад дотоод мэдээллийг задруулсан (3) гэсэн үндсэн бүрэлдэхүүнтэй байна. Үүнээс харвал Журам ба Зөрчлийн тухай хууль нь дараах байдлаар төсөөтэй болон ялгаатай байна:

Төсөөтэй тал: Объект, субъект, субъектив тал ижил. Объектив талын хувьд арилжаанд оролцсон (1), арилжаанд оролцохыг бусдад санал болгосон, эсхүл ятгасан (2), бусдад дотоод мэдээллийг задруулсан (3) үйлдлүүд аль алинд нь хамаарч байна.

Ялгаатай тал: Зөрчлийн тухай хуульд хөрөнгө оруулагчдыг төөрөгдөлд оруулах мэдээллийг нийтийн хүртээл болгох гэсэн объектив тал хамаарагдахгүй байна.

3.1.2. Эрүүгийн хуулийн зохицуулалт

Үнэт цаасны зах зээлд дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцох үйлдлийг ҮЦЗЗТХ тогтоомжоор хориглож уг үйлдлийг хийсэн этгээдийг торгох, үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрхийг хасах зэрэг захиргааны хариуцлага ногдуулж ирсэн (2014 оноос өмнө). Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт орсноор дээрх үйлдлийг эрүүгийн хэрэгт тооцон хууль, тогтоомж зөрчсөн, бусдад их хэмжээний хохирол учруулсан, энэ нь гэмт хэргийн шинжтэй бол уг этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалт үүсээд байна.¹⁷

2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 18 дугаар зүйлийн 18.8-ийн (1)-т зааснаар үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх нийтийн хүртээл болоогүй дотоод мэдээллийг ашиглаж үнэт цаасыг худалдсан, худалдан авсан (1); дотоод мэдээллийг бусдад дамжуулсан

¹⁶ Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 72 дугаар тогтоолын хавсралт.

¹⁷ Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд, бүртгэлтэй компанийн удирдлага, эрх бүхий албан тушаалтны анхааралд, <http://www.frc.mn/a/748>.

(2) гэсэн үндсэн бүрэлдэхүүнтэй байна. Үүнээс харвал Журам, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хууль дараах бүрэлдэхүүнтэй байна:

Хүснэгт 2. Журам, Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хуулийн бүрэлдэхүүн

Бүрэлдэхүүн	Журам	Зөрчлийн тухайн хууль	Эрүүгийн хууль ⁹
Объектив тал	(1) дотоод мэдээллийг ашиглан үнэт цаасны арилжаанд оролцох, (2) гуравдагч этгээдэд дамжуулах, мэдээлэх эсхүл мэдээлэл олж авах нөхцөлийг бүрдүүлэх (3) бусдад зөвлөх, санал болгох (4) хөрөнгө оруулагчдыг төөрөгдөлд оруулах мэдээллийг нийтийн хүртээл болгох	(1) арилжаанд оролцсон (2) арилжаанд оролцохыг бусдад санал болгосон, эсхүл ятгасан (3) албан тушаал, ажил үүргийн хувьд мэдээллийг нээлттэй болгох үүрэг хүлээнээс бусад тохиолдолд бусдад дотоод мэдээллийг задруулсан	(1) Үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх нийтийн хүртээл болоогүй дотоод мэдээллийг ашиглаж үнэт цаас худалдсан, худалдан авсан; (2) дотоод мэдээллийг бусдад дамжуулсан үйлдэл байна.
Субъектив тал	Санаатай болон санаандгүй хэлбэрээр	-	Гэм буруугийн санаатай хэлбэр
Субъект	Дотоод мэдээлэл эзэмшигч		16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай нийтлэг, хүндрүүлэх шинж байдал нэмэгдсэн тохиолдолд тусгай субъект байна.
Объект	Үнэт цаасны зах зээлийн үнэн зөв мэдээлэл, үйл ажиллагаа		

3.1.3. Коллизи

Эрх зүйн нэг харилцаа нэг зэрэг хэд хэдэн салбар эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдахыг хэм хэмжээний зөрчилдөөн буюу коллизи гэнэ. Зарим тохиолдолд аливаа этгээдийн үйлдэл хувийн болон эрүүгийн эрх зүйн аль алинд нь хамруулан үзэх боломжтой байдаг. Бодит байдал дээр тодорхой эрх, үнэт зүйлсэд халдсаны улмаас холбогдох этгээдэд гэм хорын буюу иргэний эсвэл эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэхийн аль нь зүйтэй болох тухай асуудал эргэлзээ төрүүлсээр байна.¹⁸ Үүний нэгэн адил ҮЦЗЗ-д дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцсон үйлдэлд ноогдуулах хариуцлагын хэм хэмжээний зохицуулалтууд коллизи мөн эсэх нь эргэлзээтэй байдаг. Зөрчлийн тухай хууль ба ҮЦЗЗТХ-ийн зорилго, үр дагавар өөр байдаг ч ижил ухагдахууныг ижил тайлбарлах нь хууль хэрэглээний нэгдмэл байдлыг бүрдүүлдэг.

Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хуулийг системчлэх аргаар¹⁹ тайлбарлахад дараах зөрчил илэрч байна:

1. Бүрэлдэхүүний хувьд : Зөрчлийн тухай хуулийн 11.10 дугаар зүйлийн 6 дах хэсэгт “Үнэт цаасны тухай хууль тогтоомжид заасан дотоод мэдээлэл эзэмшигч ... арилжаанд оролцсон, ... арилжаанд оролцохыг бусдад санал болгосон, эсхүл ятгасан, ... бусдад дотоод мэдээллийг задруулсан...” гэдэг заалтыг Эрүүгийн хуулийн 18 дугаар зүйлийн 18.8 дах хэсэгт “Үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх нийтийн хүртээл болоогүй дотоод мэдээллийг ашиглаж үнэт цаасыг худалдсан, худалдан авсан; дотоод мэдээллийг бусдад дамжуулсан” гэсэн заалтаас хэрхэн ялгах нь тодорхойгүй байна.

2. Хариуцлагын хувьд: Зөрчлийн тухай хуульд заасны дагуу үнэт цаасны зах зээлийн дотоод мэдээллийг хууль бусаар ашиглах үйлдэл нь “...эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол ...” хэрэглэхээр зохицуулсан байна. Гэхдээ уг үйлдэл нь ямар тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь тодорхойгүй²⁰ ба энэ талаар одоогоор Улсын дээд шүүх албан ёсны тайлбар гаргаагүй байна.

Доктор Б.Буянхишиг “дотоод мэдээллийг ашиглан арилжаанд оролцох хориг нь ҮЦЗЗТХ-ийн §77.1.1+§78-д заасан ч холбогдох эрүү-, зөрчлийн бүрэлдэхүүнийг тодорхойлоход хангалтгүй байна... Хэрэв ҮЦЗЗТХ-ийн §78-д заасан зөрчилд тооцох үйлдэл тодорхой бус бүрэлдэхүүнтэй бол хэрэглэж буй байгууллага /СЗХ/ нь тайлбарлан хэрэглэх боломжтой ч журам батлан хуулийн бүрэлдэхүүнийг дэлгэрүүлэх, хязгаарлах эрхгүй. Өөрөөр хэлбэл шүүх СЗХ-ны шийдвэрийг хянахдаа хуулийн зохицуулалт тайлбарлахын онрд СЗХ-ны журмыг мөрдөх болно.”²¹ хэмээн үзсэн байна.

Үнэт цаасны зах зээлд дотоод мэдээллийг ашиглаж арилжаанд оролцох үйлдлийг нийгэмд аюултай үр дагавартай гэмт хэрэг гэж үзэн Эрүүгийн хуульд хариуцлага тооцохоор заасан байдаг ч тус үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй гэж үзэж захиргааны шийтгэл оногдуулжээ. Ер нь манай улсын хувьд ҮЦЗЗ-д манипуляцыг илрүүлэх хуулийн хариуцлага тооцоход тулгарч байгаа том бэрхшээл бол энэ зах зээлийн бүрэн цэгцрээгүй байдал байна.²²

1.4. АНУ-ын үнэт цаасны эрх зүйн зохицуулалт дахь хариуцлагын тогтолцоо

АНУ-ын хувьд Үнэт цаасны болон биржийн комисс нь хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд захиргааны арга хэмжээ авдаг ба мэргэжлийн байгууллагын эрх бүхий албан

¹⁸ Б.Буянхишиг, *Иргэний эрх зүйн удиртгал*, УБ, 2012, 21 дэх тал.

¹⁹ “Системчлэн арга нь тайлбарлаж байгаа хэм хэмжээг эрх зүйн бусад хэм хэмжээ, баримтлал, эрх зүйн зарчимтай харьцуулан үзэж эрх зүйн агуулгыг нээн гаргах арга юм.”, О.Амархүү, *Эрх зүйн онолын арван таван сэдэв*, УБ, 2008, 65 дахь тал.

²⁰ О.Амархүү: “Хоёр хуулийн зүйл заалтыг харьцуулахад юу харагдаж байна вэ? Адил үйлдэлд эрүүгийн ч хариуцлага, захиргааны ч хариуцлага хүлээлгэж болдог “сонгомол” жишиг Монголд л тогтсон мэт байна. Эрх зүйн онол практикийн аль алинд нь ч ийм “сонгомол” жишиг байдаггүй, байх ч ёсгүй. Хуулийн энэ хэм хэмжээний зөрчилдөөн одоо ч арилагүй үргэлжилсээр байна.”

²¹ Law in action in Mongolia, Эрдэм шинжилгээ, сургалтын улирал тутмын сэтгүүл (УБ, 2023 оны анхдугаар), *Үнэт цаасны зах зээлийн хэм хэмжээний актанд тавигдах эрх зүйт төрийн зарчмын шаардлага*, 74 дэх тал.

²² И.Ургамал, *Үнэт цаасны зах зээлд гарч байгаа гэмт хэрэг, зөрчлийн эрх зүйн зохицуулалт, хяналтыг сайжруулах зарим асуудал*, <https://legaldata.mn/buteel/pdf?id=1414>

тушаалтан, эсхүл тухайн хуулийн этгээдэд мөн үнэт цаас гаргагчдад торгууль тавих эрхтэй. Дотоод мэдээллийг ашиглан арилжаа эрхлэх журмыг зөрчих тохиолдолд хувь этгээдэд 5-100 мянган доллар, хуулийн этгээдэд 50-500 мянган долларын торгууль тавьдаг байна. Мөн мэргэжлийн байгууллага дотоод мэдээллийг ашиглан арилжаа эрхлэх журмыг зөрчсөн тохиолдолд Комисс нь тухайн мэдээллийг ашиглан олж авсан орлого, эсхүл тухайн мэдээллийг ашиглан урьдчилан сэргийлсэн учирч болох байсан алдагдлын хэмжээг гурав нугалсан хэмжээний торгууль тавих эрхтэй. Энэ тохиолдолд хяналт тавьж байсан этгээдийг торгож бас болно. Дотоод мэдээллийг ашиглан арилжаа эрхлэх журмыг зөрчих хэргийн хөөн хэлэлцэх хугацаа иргэний хэргээс их буюу 5 жил байдаг байна.²³

Дотоод мэдээллийг ашиглан арилжаа эрхлэх журмыг зөрчсөнийг илрүүлэхэд мэдээллээр тусалсан этгээдэд Комисс нь торгуулийн 10% хүртэл хэмжээний шагнал, урамшуулал олгох эрх хэмжээтэй. Торгуулийн санкцаас гадна Комисс нь холбогдох этгээдийн бусад үйл ажиллагааг нь хязгаарлах арга хэмжээ авах боломжтой. Мөн комисс нь тухайн байгууллагыг татан буулгах, өөрчлөн зохион байгуулах тухай шүүхэд хүсэлт гарган шийдвэрлүүлэх боломжтой.²⁴

1.5.ХБНГУ-ын үнэт цаасны эрх зүйн зохицуулалт дахь хариуцлагын тогтолцоо

ХБНГУ-ын хувьд Үнэт цаасны арилжааны тухай хууль (WpHG), Арилжааны хуульд (HGB) тусгасан нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай, Хувьцааны тухай хууль зэрэг хөрөнгийн зах зээлийн бусад хуулиар илүү нарийвчлагдсан. Эдгээрт үнэт цаасны арилжаатай холбоотой амин чухал суурь асуудлыг нэгтгэж, парламентын хууль тогтоомжийн эрх хэмжээнд хамаатуулжээ. Харин эдгээрийн хэрэгжилтийг хангах алхмуудыг Санхүүгийн дүгнэлт гаргах дүрэм журам (FinAnV), Үнэт цаасны арилжааг мэдэгдэх, дотоод мэдээлэл эзэмшигчийн жагсаалт гаргах журам (WpAIV) зэрэг гүйцэтгэх эрх мэдлийн актаар зохицуулсан.²⁵ Дотоод мэдээллийг зохицуулалтыг хувьд Германы Үнэт цаасны арилжааны тухай хууль (WpHG)-ийн 39.2-т Холбооны Санхүүгийн Үйлчилгээний Хяналтын албанд / BaFin/ гүйцэтгэх эрх мэдлийн акт гаргах эрх хэмжээ олгосон хуулийн заалт нь үг хэллэгийн хувьд мөн “дотоод мэдээллийн жагсаалт гаргах, мэдээлэх журам” гэсэн ижил найруулгатай.²⁶

ХБНГУ-ын Үнэт цаасны арилжааны тухай хууль (WpHG)-ийн §119 дүгээр зүйлийн (3)-т заасны дагуу Европын парламент болон Зөвлөлийн 2014 оны 4-р сарын 16-ны өдрийн 596/2014 тоот бүхий Зах зээлийг зүй бусаар ашиглах тухай журам²⁷ (ЕХ-ны)-ийг дараах байдлаар зөрчсөн хүнд хариуцлага ноогдуулахаар заажээ:

- Журмын 14 дүгээр зүйлийн (а)-д заасны дагуу дотоод мэдээллийг ашиглах арилжаанд оролцох, оролцохыг завдах эсвэл,
- Журмын 14 дүгээр зүйлийн (b)-д заасны дагуу дотоод мэдээллийг ашиглан гуравдагч этгээдэд арилжаанд оролцохыг санал болгох, арилжаанд оролцоход нь нөлөөлөх эсвэл,
- Журмын 14 дүгээр зүйлийн (c)-д заасны дагуу журмын дагуу бус дотоод мэдээллийг олон нийтийн хүргээл болгох.

Хариуцлагын хувьд ХБНГУ-ын Үнэт цаасны арилжааны тухай хууль (WpHG)-ийн §119 дүгээр зүйл нь “Эрүүгийн шийтгэлтэй холбоотой заалт” хэмээн гарчигтай ба тус зүйлийн (3)-т заасны дагуу дотоод мэдээллийг ашиглан арилжаанд оролцсон, оролцохын завдсан, эсхүл дотоод мэдээлэл ашиглан бусдад арилжаа хийхийг санал болгосон, арилжаанд

²³ ХЗҮХ, *Монгол улсын үнэт цаасны зах зээлд дагаж мөрдөж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц*, https://nli.gov.mn/pdf/unet_tsaasnii.pdf, 259 дэх тал.

²⁴ Мөн тэнд

²⁵ Law in action in Mongolia, Эрдэм шинжилгээ, сургалтын улирал тутмын сэтгүүл (Уб, 2023 оны анхдугаар), Б.Буянхшиг, *Үнэт цаасны зах зээлийн хэм хэмжээний актад тавигдах эрх зүйт төрийн зарчмын шаардлага*, 73 дахь тал.

²⁶ Мөн тэнд

²⁷ Market Abuse Regulation (MAR), 596/2014 тоот <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/PDF/?uri=CELEX:32014R0596>

оролцоход нь нөлөөлсөн, эсхүл журмын дагуу бус дотоод мэдээллийг олон нийтэд ил тод болгосон бол эрүүгийн хариуцлага хүлээлгэх буюу 5 жилээс хэтрэхгүй хугацаагаар хорих ял, эсвэл торгуулийн арга хэмжээ авна.²⁸ Энэ нь Insider болон Non-insider аль алинд нь хамаарах зохицуулалт болно. Уг зохицуулалт нь ХБНГУ-ын цагаан захтны гэмт хэргүүдийн хамгийн өндөр шийтгэлтэй зохицуулалтуудыг нэг юм.

Хэрвээ уг гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэглэл мэргэжлийн түвшинд үйл ажиллагаа явуулж эсвэл ХБНГУ-ын санхүүгийн хяналтын байгууллага, хөрөнгө оруулагчдын үйлчилгээ эрхэлдэг аж ахуй нэгж, хөрөнгийн бирж, арилжааны операторын чиг үүргийг гүйцэтгэх явцад үйлдэж хүнд хохирол учруулсан бол 1-ээс 10 жил хүртэлх хугацаагаар хорих ялаар шийтгэнэ. WpHG §119 (5). Харин санхүүгийн хяналтын байгууллага, хөрөнгө оруулагчдын үйлчилгээ эрхэлдэг аж ахуй нэгж, хөрөнгийн бирж, арилжааны операторын чиг үүргийг гүйцэтгэх явцад тус гэмт хэргийг үйлдэхдээ хүндэвтэр хохирол учруулсан бол 6 сараас 5 жил хүртэлх хугацаагаар хорих ялаар шийтгэнэ. WpHG §119 (6).

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Дотоод мэдээлэл болон дотоод мэдээлэл эзэмшигчийн ойлголтыг харьцуулан үзвэл дотоодын хууль тогтоомжид хаалттай хүрээнд жагсаасан, харин АНУ болон ХБНГУ-д үүнийг нээлттэй хүрээнд хуульчилсан байна. Хаалттай хүрээнд журамлахын сул тал нь хэдийн тухайн мэдээлэл онолын хувьд дотоод мэдээллийг шаардлагыг хангасан ч тухайн жагсаалтад бичигдээгүй тохиолдолд гэмт хэргийн бүрэлдэхүүнийг хангаж чадахгүй болох явдал юм. Иймд дотоодын хууль тогтоомжид “дотоод мэдээлэл”-ийг жагсаалтын аргаар тодорхойлох явдлыг хасаж, АНУ, болон ХБНГУ-ын жишгийн дагуу “нийтэд ил болоогүй, нийтийн хүртээл болбол холбогдох үнэт цаасны үнэд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх, нарийн шинж чанартай мэдээлэл” хэмээн тодорхойлох нь оновчтой байна.

Эрүүгийн эрх зүйн үндсэн зарчим нь гэмт үйлдэл болгонд тохирсон ял шийтгэл ногдуулахад оршдог бол Зөрчлийн тухай хуульд иргэдийн гаргасан зөрчил бүрд шийтгэл ногдуулахаар хуульчилснаар зөрчлийг жижиг гэмт хэрэг хэмээн үздэг. Гэтэл ҮЦЗЗ дэх дотоод мэдээллийг ашиглаж арилжаанд оролцох нь ихэнх тохиолдолд бусдад их хэмжээний хохирол учруулах боломжтой, мэргэжлийн түвшинд урьдчилан бэлтгэгдэж, эсвэл үгсэн хуйвалдах замаар хийгддэг зохион байгуулалттай гэмт хэрэг учраас ҮЦЗЗ-д дотоод мэдээллийг хууль бусаар ашиглан арилжаанд оролцсон үйлдлийг нэг мөр Эрүүгийн хуулиар зохицуулах нь оновчтой байна.

Эрх зүйн хэм хэмжээний зөрчилдөөн гаргахгүй байх нь хууль тогтоогчдын нэг гол үүрэг. Нэгэнт зөрчилдөөнтэй байгаа энэ асуудлыг даван туулах гол арга зам нь нэмэлт, өөрчлөлт оруулах, шинээр батлан гаргах, албан ёсоор хүчингүй болгох, Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт гаргах явдал мөн.²⁹ АНУ болон ХБНГУ-ын хувьд тус хууль бус үйлдлийг хариуцлагын тогтолцоог тухайн хуульдаа шууд тусгаж өгсөн байдаг. Жишээ нь, ХБНГУ-ын Үнэт цаасны арилжааны тухай хууль (WpHG)-ийн 119 дүгээр зүйлд заасны дагуу тус хууль бус үйлдэлд шууд эрүүгийн хариуцлага ноогдуулахаар заасан байна. Ийнхүү хоёрдмол утга агуулга, хэм хэмжээний зөрчилдөөн гаргахаас сэргийлж суурь хуульдаа шууд тусгах нь оновчтой хэдий ч манай улсын хувьд эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хэргийг гэмт хэрэгт тооцдог тул уг зөрчилдөөнтэй асуудлыг Зөрчлийн тухай хуулиас хасаж, Эрүүгийн хуулийн 18 дугаар зүйлийн 18.8-д заасан гэмт хэргийн бүрэлдэхүүнд “дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцохыг бусдад санал болгосон; хөрөнгө оруулагчдыг төөрөгдөлд оруулах мэдээллийг нийтийн хүртээл болгосон” гэх объектив талыг нэмэлтээр тусгаж, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх боломжтой байна.

²⁸ Германы Үнэт цаасны арилжааны тухай хууль §119.

²⁹ О.Амархүү, *Эрх зүйн онолын арван таван сэдэв*, Уб, 2008, 66 дахь тал.

ЭХ СУРВАЛЖ

Монгол хэл дээрх

Хууль тогтоомж

1. Монгол улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, 2013.
2. Монгол Улсын Эрүүгийн хууль, 2015.
3. Монгол улсын Зөрчлийн тухай хууль, 2017.
4. Үнэт цаасны зах зээл дэх дотоод мэдээллийн жагсаалт, түүнийг мэдээлэх журам, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 72 дугаар тогтоолын хавсралт
5. Үнэт цаас гаргагчийн дотоод мэдээллийн ил тод байдлын журам, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 443 дугаар тогтоолын хавсралт

Ном, сурах бичиг судалгааны тайлан

1. Г.Давааням, Хувьцаат компанийн эрх зүйн үндсэн ойлголт, УБ, 2021.
2. Б.Буянхишиг, Үнэт цаасны зах зээлийн эрх зүй. УБ, 2014.
3. Хууль зүйн үндэсний хүрээлэн. Судалгааны эмхэтгэл УБ, 2011.
4. Т.Золбоо, Сургалтын эрүүгийн хууль. УБ, Соёмбо, 2017.
5. Б.Буянхишиг, Үнэт цаасны зах зээлийн хэм хэмжээний актад тавигдах эрх зүйт төрийн зарчмын шаардлага. Эрдэм шинжилгээ, сургалтын улирал тутмын сэтгүүл, 2023.
6. И.Ургамал, Үнэт цаасны зах зээлд гарч байгаа гэмт хэрэг, зөрчлийн эрх зүйн зохицуулалт, хяналтыг сайжруулах зарим асуудал, УБ, 2021.
7. О.Амархүү, Эрх зүйн онолын арван таван сэдэв. УБ, 2008.

Гадаад хэл дээрх

Хууль тогтоомж

1. Европын парламент болон Зөвлөлийн 2014 оны 4-р сарын 16-ны өдрийн 596/2014 тоот бүхий Зах зээлийг зүй бусаар ашиглах тухай журам, <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/PDF/?uri=CELEX:32014R0596>
2. Secure Exchange Act of 1934 (АНУ-ын Үнэт цаас ба арилжааны комиссын албан ёсны цахим хуудас), <https://www.sec.gov/about/about-securities-laws>

Ном, сурах бичиг, судалгааны тайлан

1. Krause, H. (1996). The German Securities Trading Act (1994): A Ban on Insider Trading and an Issuer's Affirmative Duty to Disclose Material Nonpublic Information. *The International Lawyer*, 30(3), 555–588. <http://www.jstor.org/stable/40707800>
2. Дүрэм 10b-5 гэж юу вэ? Үнэт цаасны зах зээлийн дотоод мэдээллийг ашиглан арилжаанд оролцох үйлдлийн тодорхойлолт ба үүрэг
3. <https://www.investopedia.com/terms/r/rule10b5.asp#toc-2023-changes-to-trading-plan-rules>
4. Katja Langenbucher: Aktien- und Kapitalmarktrecht, 2008 Beck Verlag

ДОТООДЫН БОЛОН ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙ УЛС ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТОГТОЛЦООНЫ САЛШГҮЙ ХЭСЭГ БОЛОХ НЬ



С.Уянга
Эрх зүйч

ТОВЧЛОЛ:

Энэхүү өгүүлэлд дотоодын болон олон улсын эрх зүйгээр улс үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоог цогц болгох асуудлыг тодруулж, үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоонд эрх зүйн үүрэг оролцоо нэн чухал болохыг тайлбарлана. Өөрөөр хэлбэл, аюулгүй байдлыг хангахтай холбоотойгоор баталсан хууль эрх зүйн актыг дагаж мөрдөх, ийм төрлийн олон улсын гэрээ конвенцид нэгдэх асуудал улс үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцооны чухал бүрэлдэхүүн болохыг тодруулна.

Төр, нийгэм, иргэний аюулгүй байдлыг харилцан уялдуулж, үндэсний болон олон улсын аюулгүй байдлыг эрх зүйн бүрэлдэхүүн хэсгээр бэхжүүлэх асуудлыг та энэхүү өгүүллийг уншсанаар танилцах болно.

ТҮЛХҮҮР ҮГС:

Аюулгүй байдал, эрх зүй, эрх зүйн тогтолцоо, эрх зүйн акт, үзэл баримтлал, нэгдмэл ойлголт

ОРШИЛ

Эдүгээ улс орны болон нийгмийн харилцааны бүхий л салбар аюулгүй байдлын асуудалтай холбогдох болсон гэхэд хилсдэхгүй. Ялангуяа даян дэлхийн геополитикийн орчин өөрчлөгдөж, их гүрнүүдийн сэргөлдөөн эргээд бодит (realist) хэлбэрээр аюулгүй байдлаа хангахаар шуударч, дотоодын хууль эрх зүйн орчин болон ОУЭЗ-д нэгэнт тогтсон хэм хэмжээг алдагдуулж, зарим нь дэлхийн шинэ дэг журмын тухай хөндөж, үүнийг хүссэн эс хүссэн хүлээн зөвшөөрөх хандлагатай болсноор олон улсын амьдрал эмзэг, аюулгүй байдлыг хангах либерал сургаал ганхах болоод байна. Мөн улсууд өөрсдийн аюулгүй байдлын эрх зүйн баримт бичигт сэргөлдөгч талаа албан ёсоор дайснаа хэмээн цохон тэмдэглэх хандлага бэхжиж байна. Энэ нь өрсөлдөгч талаа хууль ёсны дайсан гэж тооцох, хориг болон шахалтын арга хэрэгслийг ашиглахыг хуульчилж буй хэлбэр болно.

Олон улсын аюулгүй байдал гэдэг улс бүр энх тайван, эв найрамдалтай орших, энх тайвныг зөрчсөн, дайн болон аюул занал өдөөсөн аливаа үйлдлийг хязгаарлах тухай эрх зүй болон дипломатын ойлголт байдаг. Түүнийг бэхжүүлэх нэг чиглэл бол дэлхийн хамтын нийгэмлэгийн хүлээн зөвшөөрсөн эрх зүйн хэмж хэмжээ юм. Гэвч их гүрнүүдийн

геополитикийн өрсөлдөөн тогтсон хэм хэмжээ, дэг журмыг илэрхий зөрчиж, эрх зүйгээр аюулгүй байдлыг хангах арга замыг үл ойшоож буй явдал аливаа улсын аюулгүй байдлаа хангах тогтолцоонд сорилт учруулж байна.

Аюулгүй байдлыг хангах тогтолцоо иж бүрэн, цогц ойлголт байх ёстой. Гэвч эдүгээ манай бодлогын болон эрх зүйн баримт бичигт аюулгүй байдлыг хангах тогтолцоо дахь эрх зүйн актын ач холбогдлыг төдийлөн хөндөөгүй, аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчин аюулгүй байдлыг хангах тогтолцооны чухал бүрэлдэхүүн болохыг тодруулаагүй байна. Аливаа тогтолцоо ямагт алив явцуу ойлголтоос ангид байдаг. Өөрөөр хэлбэл бүх хүрээг хамарсан өргөн ойлголт байдаг.

Энэхүү өгүүлэлд аюулгүй байдлыг эрх зүйгээр хангах асуудлын ач холбогдлыг тодорхойлж, үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцооны салшгүй хэсэг болохыг тайлбарлахыг зорино. Ингэхдээ:

- аюулгүй байдлын болон аюулгүй байдлыг хангах тогтолцооны онцлогийг тодруулах;

- улс орны аюулгүй байдлыг хангах тогтолцооны талаарх судлаач, төрийн алба хаагчдын фокус асуулгыг явуулах;

- аюулгүй байдлын судлаач болон төрийн албан хаагчдын дунд аюулгүй байдлыг эрх зүйгээр хангах асуудлаар асуулга авсныг нэгтгэж, уг асуудлыг хэрхэн тодорхойлж буйд дүн шинжилгээ хийх;

- баримт бичгийн судалгаа явуулах зэргээр судалгааны сэдвийн ач холбогдлыг тодорхойлох зорилтыг дэвшүүлсэн болно.

Өгүүлэл бүхэлдээ үндэсний аюулгүй байдлыг хангах дотоодын болон олон улсын эрх зүй, гэрээ конвенцоор хангах асуудал аюулгүй байдлыг хангах тогтолцооны салшгүй хэсэг мөн болохыг нотлох зорилготой тул судалгааны объект аюулгүй байдлыг хангах тогтолцоо болно. Энэ хүрээнд хууль зүйн шинжлэх ухааны судалгааны тэргүүлэх чиглэлийн нэг бол аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчны баталгааг хэрхэн бүрдүүлэх, аюулгүй байдалтай холбогдох хууль эрх зүйн актыг хэрэгжүүлэх явдал өөрөө аюулгүй байдлыг хангах тогтолцооны салшгүй хэсэг мөн болохыг нотлох асуудал болохыг судлаачийн зүгээс санал болгосон болно.

Өгүүлэлд баримт бичгийн судалгааны аргыг түлхүү ашиглаж, дүн шинжилгээ хийлээ.

Нэг. Дотоодын эрх зүйн баримт бичгээр Аюулгүй байдлыг хангах асуудал Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцооны салшгүй хэсэг болох нь

Үндэсний аюулгүй байдлын тогтолцоог нэн тэргүүнд үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцооноос ялгаж, салгаж ойлгох нь зөв. Үндэсний аюулгүй байдлын тогтолцоо бол үндэсний язгуур эрх ашиг сонирхол, аюул заналхийллийн харилцан үйлчлэлийг тодорхойлсон функциональ тогтолцоо байдаг. Харин үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо бол аюулгүй байдлыг хангах тусгай чиг үүргийн байгууллага, хүч хэрэгсэл, бусад байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах үйл ажиллагаа төдийгүй аюулгүй байдлаа хангах чиглэлээр байгуулсан олон улсын гэрээ хэлэлцээр, конвенц, хууль тогтоомжийг мөрдөх, биелүүлэх болон сахин биелүүлэхийг шаардах тогтолцоо болно.

“Үндэсний аюулгүй байдал” гэх нэр томъёог олон улсын амьдралд Дэлхийн II дайны дараа Америкийн Нэгдсэн Улс 1947 онд Үндэсний аюулгүй байдлын тухай акт баталснаар түгээмэл хэрэглэх болсон. Монгол Улсын тухайд шинэ тутам ойлголт, гэхдээ бид өнгөрсөн зууны 90-ээд оны дунд хүртэл нийгмийг аюулаас хамгаалах, улсыг аюулаас хамгаалах үйл ажиллагааны хүрээнд үндэсний аюулгүй байдлаа хангаж ирсэн. Улмаар 2001 оны 12 дугаар сарын 27-ны өдөр “Үндэсний аюулгүй байдлын тухай” хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалаа 1994 онд баталж, 2010 онд шинэчлэн найруулсан авч Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцооны тухай авч үзсэнээс Үндэсний аюулгүй байдлын тогтолцооны тухай огт дурдаагүй байдаг.

Өмнө нь дурдсан Нэгдсэн улсын 1947 оны эрх зүйн баримт бичгийн нэр томъёоны тайлбар хэсэгт “Үндэсний аюулгүй байдлын тогтолцоо”-г “... Үндэсний аюулгүй байдлын тогтолцоо гэж Холбооны засгийн газар чиг үүрэг, үйл ажиллагаа, хэрэглээндээ ашиглах харилцаа холбоо, мэдээ мэдээллийн тогтолцоог хэлнэ. Тухайлбал,

- (А) тагнуулын үйл ажиллагаа;
- (Б) үндэсний аюулгүй байдалтай холбоотой криптологийн үйл ажиллагаа;
- (В) цэргийн хүчний удирдлага, хяналт;
- (Г) зэвсэг, зэвсэглэлийн салшгүй хэсэг болох тоног төхөөрөмж; эсвэл

(Д) (2)-д заасны дагуу цэргийн болон тагнуулын даалгаврыг шууд гүйцэтгэх зэрэг багтана ...” гэжээ¹. Өөрөөр хэлбэл, үндэсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгсэлд суурилсан тогтолцоог ойлгож байна.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 1.1.1-д “Монгол Улсын үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл бүрдсэн байхыг хэлнэ” хэмээн заасан байдаг. Энэ заалтаас үзвэл Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын тогтолцооны гол цөм бол үндэсний язгуур ашиг сонирхол болно.

Оршин буй болон илэрч байгаа орон зайгаар гадаад, дотоод аюул гэж хуваадаг. Иймд үндэсний язгуур ашиг сонирхолд нөлөөлөх, нөлөөлж болзошгүй гадаад дотоод хүчин зүйлийг саармагжуулах, ангид байх ёстойг уг заалтад мөн тусгасан гэж ойлгоно. Дээрх заалтад үндэслэн Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын тогтолцоог схемчлэн үзүүлье.

Схем 1. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тогтолцоо



Энэхүү схемээс авч үзвэл Монгол Улсын аюулгүй байдлын тогтолцооны гол объект бол үндэсний язгуур ашиг сонирхлыг алдагдуулахгүй байх асуудал болно.

Харин үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо нь аюулгүй байдлыг хангах хандлага, арга замтай шууд холбоотой байна. Аюулгүй байдлыг хангах үндсэн хоёр

¹ 40 U.S. Code § 11103 - Applicability to national security systems https://www.law.cornell.edu/uscode/text/40/11103#a_1

хандлага бий. Тухайлбал,

1. Бодит (realist) хандлагад үндэсний язгуур ашиг сонирхлыг хангахыг гол цөм болгодог буюу батлан хамгаалах чадавх, аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын хүчин чадлаар;

2. Эрх зүйт (constitutional) хандлагад олон улсын болон дотоодын эрх зүйн тогтолцоо нь аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх ёстой буюу олон улсын эрх зүйн хэм хэмжээ, гэрээ, конвенц болон аюулгүй байдлын тухай дотоодын хууль эрх зүйн актын хүчин төгөлдөр хэрэгжилтээр хангана гэж үздэг болно.

Монгол Улсын тухайд өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчинтэй, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудтай, аюулгүй байдлаа хангах эрх зүйн цөөнгүй баримт бичгийг боловсруулж, баталж заримыг нь шинэчлэн боловсруулж байна. Үүнээс үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоог дан ганц түүнийг хангах тусгайлсан чиг үүргийн байгууллагын хүчин чадлаар хязгаарлах бус үүний дээр эрх зүйн баримт бичиг, тэдгээрийг хэрэгжүүлэх, сахин биелүүлэх нэгдмэл цогц хэмээн үзэхийг анхаарах шаардлагатай юм.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцооны бүтэц, удирдлагын тухайд Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд "... Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо нь Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, түүний тэргүүлсэн Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газар, үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй төрийн байгууллага, орон нутгийн өөрөө удирдах байгууллага болон холбогдох албан тушаалтнаас бүрдэнэ ..." гэж, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуулийн 2 дугаар зүйлд "... Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл нь үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн нэгдмэл бодлого боловсруулах үйл ажиллагаа болон түүнийг хэрэгжүүлэх явдлыг уялдуулан зохицуулах, энэхүү зохицуулалт нь хэрхэн хангагдаж байгаад хяналт тавих төрийн зөвлөлдөх байгууллага мөн ..." гэж тус тус заасан байдаг.

Түүнчлэн Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлд "... Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал нь үндэсний аюулгүй байдлын талаарх төрийн бодлогын нэгдмэл, залгамж чанарын үндэс болно ...", 8 дугаар зүйлд "... Улсын Их Хурал нь үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн бодлогыг тодорхойлж, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг батална, Монгол Улсын Засгийн газар нь үндэсний аюулгүй байдлыг хангах шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна ...", Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуулийн 3 дугаар зүйлд "... Үндэсний аюулгүй байдлын зөвлөл нь Улсын Их Хурлаас баталсан Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тулгуурлан ажлаа явуулна ..." гэж тус тус хуульчилсан байдаг.

Үүний зэрэгцээ Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 4.2.1-д "... Үндэсний аюулгүй байдлыг хангах үүргийг Монгол Улсын Их хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Монгол Улсын Засгийн газар, хууль сахиулах болон тусгай чиг үүрэгтэй байгууллагууд, төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагууд гүйцэтгэнэ ..." гэж заасан байдаг.

Мөн Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч болон нутгийн өөрөө удирдах байгууллагууд нь үндэсний аюулгүй байдлыг хангах зорилтыг Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн, тус тусын бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх үүрэгтэй гэж заасан байдаг.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй дараах байгууллага байна:

- Байгаль орчныг хамгаалах алба;
- Гаалийн алба;
- Дипломат алба;

Гамшгаас хамгаалах алба;
Мэргэжлийн хяналтын алба;
Зэвсэгт хүчин, бусад цэрэг;
Татварын алба;
Тусгай алба;

Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба;

Иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн алба;

Цагдаагийн алба багтана. Эдгээр субъект бүр тус тусын хуультай. Харамсалтай нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хууль болон бусад эрх зүйн баримт бичигт эдгээр байгууллага үндэсний аюулгүй байдлыг бие даан болон хамтарч хэрхэн хангах тухай зүйл заалт бүрхэг. Өөрөөр эдгээр байгууллагын эрх зүйн харилцааг зохицуулах буюу байгууллагад зориулсан хуулийг хэрэгжүүлж байгаа явдал аюулгүй байдлын эрх зүйн орчны уялдаа холбоо тодорхойгүй болж, дотоодын аюулгүй байдлын эрх зүйн баримт бичиг үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцооны нэг чухал бүрэлдэхүүн болохыг оогоорох үндэс болсон хэмээн бид үзэж байна.

Иймээс Үндэсний аюулгүй байдлыг хангах асуудалд аюулгүй байдлыг эрх зүйгээр хангах ухагдахууныг аюулгүй байдлын онол, хандлага төдийгөөр авч үзэх явдал түгээмэл болж байна. Тухайлбал, үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, стратегийн тулгуур баримт бичиг, үзэл баримтлалыг боловсруулахдаа тунхаглалын шинж чанартай зарчим, зүйл, заалттайгаар боловсруулж байна. Өөрөөр хэлбэл, дурдсан баримт бичгээс үүсэх эрх зүйн үр дагавар, хэрэгжих боломжийг төдийлөн тооцоолохгүй байх хандлага ажиглагдаж буй. Энэ нь аюулгүй байдлын эрх зүйн тулгуур баримт бичиг өөрөө үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцооны нэг хэсэг болохыг ойлгоогүйтэй холбоотой хэмээн үзнэ. Үүнээс улбаалж судлаач эрдэмтдийн дунд үзэл баримтлалыг заавал хэрэгжүүлэх баримт бичиг мөн эсэхийн талаарх маргаан одоо хэр үргэлжилж байна. Хэт ерөнхий, хэрэгжих бодит хөрс сул, тунхаглалын шинж чанартай болсон баримт бичгийг аюулгүй байдлыг хэрхэн хангах жанжин чиг шугамыг заагч гэж үзэхэд хүргэж байна. Угтаа тунхаглал / declaration/ эсвэл заавал хэрэгжүүлэх /action-oriented/ баримт бичиг нэн ялгаатай, тэрхүү заагийг нарийвчлан тогтох шаардлагатай болно. Эдүгээ манай улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал хууль тогтоомжийн хуулиар эрх зүйн үндсэн эх сурвалж буюу эрх зүйн акт мөн. Харин агуулгын хүрээнд улс төрийн шинж чанартай, бодлогын баримт бичиг бөгөөд эрх зүйн эрэмбээр Үндсэн хуулийн дараах бусад хуулийн адил эрэмбэлэгдэх учиртай.

Зүй нь өмнө нь дурдсанчлан тунхаглалын шинж чанартай болон заавал хэрэгжүүлэх ёстой хоёр үндсэн эрх зүйн баримт бичигтэй болох нь зөв. Аль аль нь эрх зүйн баримт бичиг боловч өөр өөр үүрэгтэй болно. Тухайлбал үзэл баримтлал бол жанжин чиг шугамыг заагч байх бол, стратегийн баримт бичиг заавал хэрэгжүүлэх онцлогтой байдаг.

Эдүгээ бидний үзэж байгаагаар аюулгүй байдлыг эрх зүйгээр хангах ойлголтын ач холбогдлыг онцлох шаардлагатай байна.


Нэн тэргүүнд үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоог дан ганц түүнийг хангах тусгайлсан чиг үүргийн байгууллага (субъектын түвшинд)-ын үйл ажиллагаа, оролцоогоор хязгаарлах бус аюулгүй байдлын эрх зүйн баримт бичиг, тэдгээрийг хэрэгжүүлэх, сахин биелүүлэх үйл ажиллагааг хамарсан нэгдмэл цогц гэж үзэх хэрэгтэй, ийм эрх зүйн орчныг баталгаажуулах шаардлагатай юм. Өөрөөр хэлбэл, үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо бол аюулгүй байдлыг хангах тусгай чиг үүргийн байгууллага, хүч хэрэгсэл, бусад байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах үйл ажиллагаа төдийгүй аюулгүй байдлаа хангах чиглэлээр байгуулсан олон улсын гэрээ хэлэлцээр, конвенц, хууль тогтоомжийг мөрдөх, биелүүлэх болон сахин биелүүлэхийг шаардах тогтолцоо хэмээн үзэх нь зөв.

Аюулгүй байдлыг хангах эрх зүйн баримт бичгийг үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцооны нэг хэсэг гэдгийг аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүргийн байгууллага, субъектуудад таниулснаар эдүгээ хэр тунхгийн шинж чанартай байгаа төр, нийгэм, иргэний аюулгүй байдал харилцан уялдаатай хангагдсанаар үндэсний аюулгүй байдал хангагдах тухай үндэслэлийн эрх зүйн ойлголт тодорхой болно. Ингэснээр мөн аюулгүй байдлын бодлого цогц байх үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны зарчмыг баримтлах эрх зүйн баримт бичиг стратегийн чанартай болж, заавал хэрэгжүүлэх, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон дагалдах (action oriented) баримт бичиг (нууцын зэрэг)-тэй болно. Ийм дагалдах баримт бичигт аюулгүй байдлыг хэрхэн харилцан уялдаатай хангах арга замыг тодорхой тусгасан удирдамж (Guidance) байх боломжтой. Тиймээс нууцын зэрэглэлтэй байх ёстой. Монгол Улсад ийм стратегийн баримт бичиг нэн чухал байна.

Монгол Улсад аюулгүй байдлыг хангах цөөнгүй баримт бичиг байх ч хоорондын уялдаа холбоо дутмаг. Ийм тохиолдолд хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, шинэчлэн найруулснаас илүүтэй дурдсан стратегийн дагалдах баримт бичгийг боловсруулж, аюулгүй байдлыг хангах тусгай чиг үүргийн байгууллага, субъектын чиг үүрэг, оролцоо, харилцан ажиллагаа, уялдаа холбоог тодорхой тусгах илүү ач холбогдолтой хэмээн үзнэ.

Түүнчлэн Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсгээр авч үзвэл тэдгээртэй холбоотой цөөнгүй багц хууль байна. Гэхдээ Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй бүх хууль тодорхой хэмжээгээр аюулгүй байдалтай холбогддог хэмээн ойлгох нь зөв.

Схем 2. Үндэсний аюулгүй байдлын эрх зүйн орчны бүдүүвч



Эх сурвалж. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал: онол, практикийн асуудлууд. Уб., 2023 он


Энэхүү схемд Үндэсний аюулгүй байдлын зургаан бүрэлдэхүүн хэсэгт хамааралтай хууль эрх зүйн баримт бичгийг нэгтгэж гарсан байна. Цаашид хууль тус бүр аюулгүй байдлыг хангах тогтолцоонд хэрхэн уялдсан талаар нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай бий. Үүнийг судлаач үргэлжлүүлэн судлахаар төлөвлөж буй.

Өгүүлэлд дэвшүүлсэн зорилтын хүрээнд аюулгүй байдлыг эрх зүйгээр хангах ойлголтын талаар судлаач, төрийн жинхэнэ алба хаагчдаас² дөрвөн асуулт бүхий асуулгыг google form аппликейшн ашиглаж явуулсныг танилцуулъя.

Асуулгад нийт 110 хүн оролцсон болно.

Аюулгүй байдлыг эрх зүйгээр хангах боломжтой юу?


107 responses



Дээрх асуултад оролцогчдын 4,7 хувь боломжгүй, 7,5 хувь мэдэхгүй, бусад буюу мэднэ, нэг бүрэлдэхүүн хэсэг, дангаар бол бүрэн боломжгүй, 100 хувь хангах боломжгүй гэж оролцогчдын 3,7 хувь үзжээ. Гэхдээ оролцогчдын 84,1 хувь буюу дийлэнх аюулгүй байдлыг эрх зүйгээр хангах боломжтой гэж үзсэн явдал аюулгүй байдлын эрх зүй өөрөө аюулгүй байдлын хамгаалалтын хэрэгсэл болохыг зөвшөөрч байна гэж үзнэ.

Аюулгүй байдлыг эрх зүйгээр хангах явдал аюулгүй байдлыг хангах тогтолцоонд багтах уу?

104 responses




Энэ асуултад оролцогчдын 3,8 хувь багтахгүй, 9,6 хувь мэдэхгүй, 86,5 хувь аюулгүй байдлыг хангах тогтолцоонд багтана гэж хариулсан байна. Үүгээр асуулгад оролцогчдын дийлэнх аюулгүй байдлыг эрх зүйгээр хангах асуудлыг аюулгүй байдлыг хангах тогтолцооны нэг хэсэг гэдгийг хүлээн зөвшөөрч буй байна.

² Шинжээч судлаач болон төрийн алба хаагчдын нэрсийг нууцалж явуулсан болно.

Аюулгүй байдлыг эрх зүйгээр хангах баталгааг


105 responses



Энэ асуултыг аюулгүй байдлын эрх зүйн талаар нэгдмэл ойлголттой байгаа эсэхийг тандах зорилготой тавьсан болно. Оролцогчдын 9,5 хувь мэдэхгүй, 59 хувь бүх бүрэлдэхүүн хэсгээр, 11 хувь олон улсын эрх зүйгээр, 18,1 хувь дотоодын хууль, 1,9 хувь олон улсын гэрээгээр аюулгүй байдлыг эрх зүйгээр хангах баталгааг гарна гэж хариулсан болно. Хэдийгээр оролцогчдын 59 хувь бүх бүрэлдэхүүн хэсгээр баталгааг гаргана гэж үзэж буй ч 31,5 хувь аюулгүй байдлыг эрх зүйгээр хангах талаар нэгдмэл ойлголтгүй, 9,5 хувь огт мэдэхгүй байна.

Монгол Улс аюулгүй байдлаа хэрхэн хангах нь зөв бэ?

105 responses



Монгол Улсын аюулгүй байдлыг хангах тогтолцооны тухай тандсан энэ асуултад оролцогчдын 5,7 хувь олон улсын баталгаа гаргуулах гэж хариулсан бол 7,6 хувь мэдэхгүй байна. Олон улсын баталгаа гаргуулах явдал аюулгүй байдлыг эрх зүйгээр хангах асуудлын гол ойлголт. Оролцогчдын 29,5 хувь эрх зүйгээр, 8,6 хувь зэвсэгт хүчнээр хангана гэх хариултыг сонгосон явдал өнөөгийн манай аюулгүй байдлаа хангах тогтолцоог л асуултад оролцогчид хүртэл ойлгох төдий байгааг харууллаа.

Аюулгүй байдлыг хангахад эрх зүйн хамгаалалт чухал болохыг судлаач, төрийн алба хаагчдад ойлгож байна. Гагцхүү оролцогчдын хувьд нэгдмэл ойлголт хараахан бэхжээгүй байгааг энэхүү асуулгын дүн харуулсан болно. Иймээс судлаач, төрийн албан хаагчдыг аюулгүй байдлыг хангах тогтолцооны талаар нэгдмэл ойлголттой болгох сургалт, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж, энэ асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна. Үүнд мөн хууль тогтоогчдын хүчин чармайлт нэн чухал юм.


Зүй нь манай улсын аюулгүй байдлыг хангах тогтолцоог:

1. Бодит хандлагаар буюу үндэсний язгуур ашиг сонирхлыг батлан хамгаалах чадавх,

аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын хүчин чадлыг гол цөм болгох;

2.Эрх зүйн хандлагаар буюу олон улсын болон дотоодын эрх зүйн тогтолцоо аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх, олон улсын хэм хэмжээ, гэрээ, конвенц болон аюулгүй байдлын тухай дотоодын хууль эрх зүйн актын хүчин төгөлдөр хэрэгжилтийг өөр нэг гол цөм болгох хэлбэрээр буюу дурдсан хоёр хандлагын салшгүй холбоо, нэгдмэл цогц байдлаар хангах нь зөв болно. Өөрөөр хэлбэл үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоог хангах тусгай субъектүүдийн дээр эрх зүйн баримт бичиг, тэдгээрийг хэрэгжүүлэх бодит нөхцөлийн хамт цогцоор томъёолох нь зүйтэй хэмээн үзнэ.

Зураг 1. Үндэсний аюулгүй байдлыг хангах бодит болон эрх зүйт тогтолцоо



Эх сурвалж. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал: онол, практикийн асуудлууд. Уб., 2023 он

Сэдвийг өргөн хүрээнд авч үзвэл аюулгүй байдлын эрх зүйн асуудлыг олон улсын түвшинд хэрхэн хүлээн авах ёстойг дараах бүлэгт авч үзье.

Хоёр. Олон улсын эрх зүйгээр Аюулгүй байдлыг хангах асуудал олон улсын аюулгүй байдлыг хангах тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болох нь

Үндэсний болон олон улсын аюулгүй байдал харилцан уялдаатай. Иймээс улс орнууд олон улсын аюулгүй байдлыг бэхжүүлэхэд хамтран ажиллах шаардлагатай байдаг. Ерөөс хамтын шударга ёсыг олж авах, аливаа хүчирхийллээс хамгаалах, аюул заналыг өдөөгч хүчин зүйлийг бууруулах явдал дэлхийн хамтын нийгэмлэгийн гишүүн улс орны үүрэг юм.

Эдүгээ их гүрнүүдийн өрсөлдөөнд жижиг буурай улс золиос болох хандлага нэмэгдэж байна. (Афганистан, Сири, Украин). Энэ нь эрх ашгаа аюул заналхийллээс хамгаалах жижиг улсын хүчин чармайлт болон өөрийн ашиг сонирхлыг тулгах хүчирхэг улсуудын дарамт шахалтын дилеммаг үүсгэж, хэзээ, хэрхэн эцэслэх нь тодорхойгүй хямралыг үүсгэж байна.

Энэ бол өөрийн ашиг сонирхлын үүднээс дэлхийн дэг журмыг эвдэж буй их гүрнүүд аюулгүй байдлыг эрх зүйгээр хангах асуудал олон улсын аюулгүй байдлыг хангах тогтолцооны бүрэлдэхүүн гэдгийг огоорч, олон улсын эрх зүйгээр хүлээсэн үүргээ зөрчиж, эдийн засаг, зэр зэвсэг, цэргийн хүчээр олон улсын аюулгүй байдлын тогтолцоог ганхуулж байгаа хэрэг юм. Үүгээр цөөнгүй олон улсын байгууллагын үйлчлэх чадамж суларч, хүч түрэмгийлэх бодлого олон улсын эрх зүйн тогтолцоог сүйтгэж буйг илтгэдэг.

Сонирхолтой нь хямралыг өдөөх болон өртөж буй улс орон угтаа НҮБ-ын дүрмийг хүлээн зөвшөөрөхөө илэрхийлж, “шударга ёсыг сахих, гэрээ болон олон улсын эрх зүйн бусад эх сурвалжаас үүдэн гарах аливаа үүргийг хүндэтгэн мөрдөх нөхцөлийг бүрэлдүүлэх, хүлээцтэй байх, найрсаг хөршийн ёсоор эв эеийг сахин хамтдаа аж төрөх, олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахиулахын төлөө хүчээ нэгтгэх, зарчим батлах, арга тогтоох замаар зэвсэгт хүчнийг гагцхүү нийтийн ашиг тусынхаас бусад зорилгод хэрэглэхгүй байлгах, олон улсын арга хөшүүргийг бүх улс түмний эдийн засаг, нийгмийн дэвшилд тус дөхөм үзүүлэхэд ашиглах”³-аа батлан тангарагласан байдаг. Энэхүү үзэл баримтлалыг олон улс дотоодын болон олон улсын эрх зүйн баримт бичигтээ тусгасан ч бодит амьдрал дээр хэрэгжүүлэхгүй, дагаж мөрдөхгүй байгаа явдал харамсалтай.

НҮБ-ын дүрмийг олон улсын аюулгүй байдлын олон улсын гол баримт бичиг гэж хүлээн зөвшөөрөх ёстой. Учир нь энэ баримт бичиг “олон улсын энх тайван, аюулгүй байдлыг хангах” механизмын үндсийг тодорхойлдог. Тухайлбал, НҮБ-ын дүрмийн 1-р зүйлийн 1-д “...Олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахиулах, энэ зорилгын үүднээс энх тайванд учрах аюул заналыг сэрэмжлэн зайлуулах, түрэмгийлэл буюу энх тайвныг бусниулах бусад явууллагыг дарахын тулд үр нөлөөтэй хамтарсан арга хэмжээ авах, олон улсын маргаан буюу энх тайвныг бусниулахад хүргэж болзошгүй байдлыг шударга ёс, олон улсын эрх зүйн зарчмын дагуу эв зүйгээр зохицуулах буюу шийдвэрлэж байх ...”⁴ үүргийг заасан байдаг.

Их гүрнүүдийн өнөөгийн геополитикийн өрсөлдөөнд татагдаж орж буй талуудын нийтлэг зөвтгөл шударга ёс байдаг. Ямартаа ч шударга ёсыг аль аль тал нь хүлээн зөвшөөрч байна. Гагцхүү шударга ёсыг улс орон өөр өөрийн өнцгөөр тайлбарлаж, ойлгож болохгүй. Энэ шударга ёсыг НҮБ-ын дүрэм болон олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр сахиулах ёстой.

Гэтэл сөргөлдөгч талууд аюулгүй байдлынхаа эрх зүйн актуудад харилцан бие дэснаар зарлах үзэгдэл хэвийн үйлдэл болж байна. Тухайлбал, ОХУ-ын “Үндэсний аюулгүй байдлын стратеги”-даа “... Өрнөдийн орнуудын ноёрхлоо хадгалах хүсэл эрмэлзэл, эдийн засгийн орчин үеийн загвар, арга хэрэгслийн хямрал, улс орнуудын хөгжлийн тэнцвэргүй байдлыг нэмэгдүүлж, нийгмийн тэгш бус байдлын түвшинг эрс өөрчилж, үндэстэн дамнасан корпорацуудын улс орнуудын хүсэл эрмэлзлийг хязгаарлаж буйн дээр улс орнуудын дотоод улс төрийн асуудлууд хурцдаж, үүнтэй холбоотойгоор улс хоорондын зөрчилдөөн олширч, олон улсын байгууллагуудын нөлөө хүч суларч, дэлхийн аюулгүй байдлын тогтолцооны үр нөлөө буурч байна ...”, “... ОХУ-д үзүүлэх цэргийн аюул, цэргийн аюул заналхийллийг бэхжүүлэхэд Орос, түүний холбоотнууд, түншүүд рүү хүчтэй шахалт үзүүлэх оролдлого, Оросын хилийн ойролцоо Умард Атлантын эвслийн цэргийн дэд бүтцийг бий болгох, тагнуулын үйл ажиллагааг эрчимжүүлэх зэргээр ОХУ-ын эсрэг томоохон цэргийн анги, цөмийн зэвсгийн хэрэглээг хөгжүүлж байна ...”, “... Дэлхийн пуужингийн довтолгооноос хамгаалах системийн чадавхыг хөгжүүлж байгаатай холбогдуулж, Америкийн Нэгдсэн Улс (АНУ) зэвсгийн хяналтын чиглэлээр олон улсын өмнө хүлээсэн үүргээсээ татгалзах чиглэлийг тууштай баримталж байна. АНУ дунд болон богино зайн тусгалтай пуужингуудыг Европ болон Ази, Номхон далайн бүс нутагт байрлуулахаар төлөвлөж байгаа явдал стратегийн тогтвортой байдал, олон улсын аюулгүй байдалд заналхийлж байна ...”⁵ хэмээн заасан байна.

Харин АНУ тэргүүтэй Умард Атлантын гэрээний байгууллагын гишүүн улсуудын төрийн тэргүүн нар Мадрид хотноо 2022 оны зургаадугаар сарын 29-ний өдөр болсон Умард Атлантын эвслийн төр засгийн тэргүүн нарын дээд хэмжээний уулзалтын үеэрээ

³ Монгол Улсын олон улсын гэрээ. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрэм. <https://legalinfo.mn/mn/detail/1211>

⁴ Charter of the United Nations and Statute of the Court of Justice <https://treaties.un.org/doc/publication/ctc/uncharter.pdf>

⁵ Указ Президента Российской Федерации от 02.07.2021 г. № 400. О Стратегии национальной безопасности Российской Федерации. <http://www.kremlin.ru/acts/bank/47046/page/1>

“НАТО 2022 Стратегийн үзэл баримтлал” баримт бичгийг баталсан байдаг. Уг баримт бичигт: ОХУ-ын үйлдэл Евро-Атлантын бүс нутгийн аюулгүй байдалд нөлөөлж буйг онцолж, Африк, Ойрхи Дорнод, Сахелийн бүс нутаг, БНХАУ-ын өсөлт, Бээжин-Москвагийн түншлэл, террорист бүлэглэл, кибер орон зай, Иран, Хойд Солонгос, Сири болон цөмийн зэвсэглэл эвслийн аюулгүй байдлын стратегийн орчинд нөлөөлж буйг тэмдэглэсэн байна. Тухайлбал, ОХУ-ын түрэмгийлэлтэй холбоотойгоор Евро-Атлантын бүс аюул эрсдэлтэй болсон. Энэ нь аюулгүй байдлын орчныг эрс өөрчилж, тогтворгүй байдал, стратегийн өрсөлдөөн, авторитаризмыг нэмэгдүүлж эвслийн ашиг сонирхол, үнэт зүйлсэд сорилт учруулж буйг онцолсон. Иймээс НАТО-ын хамтын хамгаалалт 360 градусын хяналттай болохыг зарласан байна. Түүнчлэн ОХУ-ын цөмийн зэвсгийн сүрдүүлэг, цөмийн зэвсгийн шинэчлэл, хоёрдмол зориулалттай шинэ тээвэрлэлтийн системийн өргөжилт, тус улсын Хойд туйл дахь хүчин чадавч эвслийн стратегийн сорилт гэж томъёолжээ. Москва цэргийн хүчээ Балт, Хар болон Газар дундын тэнгисийн бүс нутагт нэмэгдүүлж, Беларусьтай явуулж буй цэргийн интеграцчлал эвслийн аюулгүй байдал, ашиг сонирхлыг сорьж байгааг мөн тэмдэглэжээ. Хэдийгээр ОХУ-ыг шууд дайсан гэж зарлаагүй ч түнш гэж үзэхгүйгээ мэдэгдсэн. НАТО-ын зүгээс тус улсад ямар нэгэн аюул занал учруулахгүй. Оросын заналхийлэл, дайсагнасан үйлдэлд нэгдсэн, хариуцлагатай хариу арга хэмжээ авахыг болон эрсдэлийг зохицуулах, бууруулах, хурцадмал байдлаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг нэмэгдүүлэхийн тулд Москвагай харилцах сувгийг нээлттэй байлгах үүрэг хүлээсэн хэвээр байхыг тэмдэглэсэн байна. Энэхүү харилцаанд өөрчлөлт гарах эсэх ОХУ-ын түрэмгий зангаа зогсоож, олон улсын хуулийг бүрэн хүндэтгэх эсэхээс хамаарах аж⁶.

Дээрх хоёр эрх зүйн баримт бичгийг үзэхэд талууд бие биеэ илэрхий сөрсөн зүйлгүй мэт авч цаад агуулга нь харилцах бие биеэ хүлээн зөвшөөрөхгүйгээ эрх зүйн эх сурвалждаа зааж өгч буй үйлдэл бөгөөд ямарваа маргаан гарвал эдгээр баримт бичгийн заалтыг өөр өөрийнхөө ашиг сонирхлын үүднээс тайлбарлах хууль эрх зүйн орчинг бүрдүүлж буй хэрэг болно.

Олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчим улс хоорондын харилцаанд “тоглоомын дүрэм”-ийг тодорхойлоход юуны өмнө олон улсын аюулгүй байдлын эрх зүйн үндсийг системтэйгээр бэхжүүлэх шаардлагатай болно. Тодруулбал, олон улсын эрх зүйн субъектуудын үйл ажиллагааг олон улсын хэм хэмжээгээр зохицуулах, “хатуу хүч”-ний арга хэрэгслийг бууруулах, олон улсын эрх зүй, дэг журамд заналхийлэх, эмх замбараагүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх хамтын ажиллагааны арга барилыг бий болгох явдал аюулгүй байдлын эрх зүйн үндсэн үүрэг юм.

Түүнчлэн олон улсын тэргүүлэх байгууллагад шинэчлэл хийх, олон талт дипломат харилцааг бэхжүүлэх, аливаа салбарт нэг улсын ноёрхол тогтохоос сэргийлэх үүднээс нэг “тоглоомын дүрэм”-тэй болох шаардлагатай байна. Үүний тулд аюулгүй байдлыг эрх зүйгээр хангах арга хэрэгслийн үйлчлэх хүрээг олон улсын амьдралд бэхжүүлэх шаардлагатай. Үүний зэрэгцээ “асуудалтай” гэгдэх улсуудыг тусгаарлахад биш, харин олон улсын яриа хэлэлцээ, дэлхийн хамтын нийгэмлэгийн үйл ажиллагаанд нээлттэй оролцуулах, эрх зүйн эрх үүргийг хүлээн зөвшөөрүүлэх улс төр дипломатын аргыг ашиглах явдал үүссэн болон үүсэж болзошгүй хямралыг шийдвэрлэх арга зам болно. Энэ утгаараа аюулгүй байдлыг эрх зүйгээр хангах асуудал улс төрийн аюулгүй байдлыг хангах арга хэрэгсэл юм. Өөрөөр хэлбэл, хууль эрх зүйн утгаараа хамгаалалтын агуулгатай төдийгүй төр, нийгэм, иргэн цаашилбал улс орны хөгжил дэвшил, амар амгалан байдалд хүргэх, нийгмийн институцийн үр дүнтэй үйл ажиллагааг хангах зорилготой болно.

Үндэсний болон олон улсын аюулгүй байдлыг хангах явдал төрийн үйл ажиллагааны үндсэн зорилго байдаг. Үүнийг олон улсын түвшинд (гадаад), дотоод улс төрийн хүрээнд үйл ажиллагаандаа барих үүрэгтэйг дэлхийн хамтын нийгэмлэгийн гишүүдэд уриалан

⁶ NATO 2022 Strategic concept. https://www.nato.int/nato_static_fl2014/assets/pdf/2022/6/pdf/290622-strategic-concept.pdf

таниулах хэрэгтэй байна.

Олон улсын эрх зүйн үйлчлэх хүрээ баталгаанд оршдог. Энэ баталгааг гаргаж чадахуйц улс орнууд үүнийг үл ойшоож буй явдал даян дэлхийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог уламжлалт хэлбэр рүү хазайлгаж буйгаас аюулгүй байдлыг хангах тогтолцоо дахь эрх зүйн асуудлыг бүдгэрүүлж байна. Иймээс НҮБ болон бусад олон улсын эрх бүхий байгууллага олон улсын эрх зүй болон гэрээ конвенцыг халдашгүй баталгаатай байлгах, үл зөрчихийг ямагт сануулж, аюулгүй байдлын эрх зүйн ирээдүйн хөгжилд анхаарах явдал нэн чухал болно.

ДҮГНЭЛТ

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын туухай хууль болон бусад эрх зүйн баримт бичигт үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүргийн байгууллагууд үндэсний аюулгүй байдлыг бие даан болон хамтарч хэрхэн хангах тухай зүйл заалт бүрхэг байна. Эдгээр субъект тус бүртээ хуультай. Гэвч эдгээр субъектын эрх зүйн харилцааг зохицуулах буюу байгууллагад зориулсан хуулийг хэрэгжүүлж байгаа явдал аюулгүй байдлын эрх зүйн орчны уялдаа холбоо тодорхойгүй болж, дотоодын аюулгүй байдлын эрх зүйн баримт бичиг үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцооны нэг чухал бүрэлдэхүүн болохыг огоорох үндэс болсон хэмээн бид үзэж байна. Иймд үндэсний аюулгүй байдлын тогтолцоог хангах, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын болон үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоотой холбоотой эрх зүйн акт хоорондын уялдаа холбоог нягтлах, нэг цөм ойлголтыг бий болгох шаардлагатай байна.

Өөрөөр хэлбэл, үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоог эрх зүйн баримт бичиг, түүний үйлчлэх хүрээний хамт тодорхойлж, аюулгүй байдлыг хангах асуудлыг цогцоор харах нь зөв. Энэ талаар явуулсан Асуулгад оролцогчдын дийлэнх (86,5 хувь) аюулгүй байдлыг эрх зүйгээр хангах асуудлыг үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцооны нэг хэсэг гэдгийг хүлээн зөвшөөрч байна.

Энэ нь аюулгүй байдлыг хангахад эрх зүйн хамгаалалт чухал болохыг манай судлаач, төрийн алба хаагчдад ойлгож байгааг харуулж буй. Гагцхүү хувьд нэгдмэл ойлголт хараахан бэхжээгүйг судалгааны дүн харуулж байна. Өөрөө хэлбэл, аюулгүй байдлыг хангах эрх зүйт хандлагын талаар судлаач болон төрийн алба хаагчид харилцан адилгүй ойлголттой буюу үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоог мөнөөх тусгайлсан чиг үүргийн байгууллага, алба хаагчийн үүргийн хүрээнд ойлгож байна.

Иймд төрийн албан хаагчдад аюулгүй байдлыг хангах тогтолцооны талаар нэгдмэл ойлголттой болгох сургалт, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж, энэ асуудлыг шийдвэрлэх шаардлагатай болно.

Тогтолцоо ямагт алив явцуу ойлголтоос ангид байдаг. Өөрөөр хэлбэл бүх хүрээг хамарсан өргөн ойлголт байдаг. Иймээс Аюулгүй байдлыг хангах тогтолцоог дан ганц түүнийг хангах тусгайлсан чиг үүргийн байгууллагын үйл ажиллагаа, оролцоогоор хязгаарлах бус аюулгүй байдлын эрх зүйн баримт бичиг, тэдгээрийг хэрэгжүүлэх, сахин биелүүлэх үйл ажиллагааг хамарсан нэгдмэл цогц гэж үзэх хэрэгтэй, ийм эрх зүйн орчныг баталгаажуулах шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл, үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо бол аюулгүй байдлыг хангах тусгай чиг үүргийн байгууллага, хүч хэрэгсэл, бусад байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах үйл ажиллагаа төдийгүй аюулгүй байдлаа хангах чиглэлээр байгуулсан олон улсын гэрээ хэлэлцээр, конвенц, хууль тогтоомжийг мөрдөх, биелүүлэх болон сахин биелүүлэхийг шаардах тогтолцоо хэмээн үзэх нь зөв болно.

Олон улсын эрх бүхий байгууллага олон улсын эрх зүй болон гэрээ конвенцыг халдашгүй баталгаатай байлгах, үл зөрчихийг ямагт сануулж, зэр зэвсэг, зэвсэгт хүчнээр хамгаалахтай ижил хүчтэй байлгахад анхаарах шаардлагатай байна.

Хямралыг өдөөгч улс оронд олон улсын эрх зүйн эрх үүргийг хүлээн зөвшөөрүүлэхэд улс төр дипломатын аргыг ашиглах явдал үүссэн болон үүсэж болзошгүй хямралыг шийдвэрлэх арга зам мөн. Энэ утгаараа аюулгүй байдлыг эрх зүйгээр хангах асуудал улс төрийн аюулгүй байдлыг хангах арга хэрэгсэл байна.

Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоонд дотоодын болон олон улсын эрх зүйн баримт бичиг буюу эрх зүйн орчныг хамааруулж, уг тогтолцоог цогцоор хангах боломжтой талаар дэвшүүлж буй судалгаа, анализ дан ганц судлаачийн өөрийн санаа, үндэслэл тул уг өгүүллийг уншиж авхай, хөндсөн асуудлаар харамгүй санал шүүмж өгөхийг хүсэж буйг эцэст нь тэмдэглэе.

САНАЛ

Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоог бодит /realist/ болон эрх зүйт хандлагын хамт цогцоор ойлгох, аюулгүй байдлын асуудлаар хууль эрх зүйн баримт бичгийг үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцооны салшгүй хэсэг болохыг судлаач болон төрийн алба хаагч, ялангуяа хууль тогтоогчдын түвшинд бүрэн таниулах. Ингэснээр үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо иж бүрэн, цогц хүртээмжтэй болно хэмээх саналыг дэвшүүлж байна.

ЭХ СУРВАЛЖ

Монгол хэл дээрх

Ном, өгүүлэл, судалгааны тайлан

1. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал. Эрх зүйн баримт бичиг. Уб., 2020.
2. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал: онол, практикийн асуудлууд. Уб., 2023.

Цахим эх сурвалж

1. Монгол Улсын олон улсын гэрээ. нэгдсэн үндэстний байгууллагын дүрэм. <https://legalinfo.mn/mn/detail/1211>

Гадаад хэл дээрх

Цахим эх сурвалж

1. Charter of the United Nations and Statute of the Court of Justice <https://treaties.un.org/doc/publication/ctc/uncharter.pdf>
2. Указ Президента Российской Федерации от 02.07.2021 г. № 400. О Стратегии национальной безопасности Российской Федерации. <http://www.kremlin.ru/acts/bank/47046/page/1>
3. NATO 2022 Strategic concept. https://www.nato.int/nato_static_fl2014/assets/pdf/2022/6/pdf/290622-strategic-concept.pdf
4. 40 U.S. Code § 11103 - Applicability to national security systems https://www.law.cornell.edu/uscode/text/40/11103#a_1

THE INTEGRATION OF DOMESTIC AND INTERNATIONAL LAW IN NATIONAL SECURITY SYSTEMS

Uyanga.S
Lawyer

ABSTRACT:

This article elucidates the comprehensive nature of a state's national security system through the incorporation of domestic and international law. It further underscores the pivotal role of legal frameworks in ensuring national security. Upon reading this article, you will gain insight into the interconnection between state, social, and civil security, as well as how legal components contribute to enhancing both national and international security.

KEYWORDS:

Security, law, legal system, legal acts, concepts, common understanding.

ГЭМ БУРУУГУЙГЭЭР ҮҮРГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙГ БИЕЛҮҮЛЭХ БОЛОМЖГҮЙ БОЛОХТОЙ ХОЛБООТОЙ ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ



М.Уянга

МУИС-ийн ХЗС-ийн магистрант

ТОВЧЛОЛ:

Улс орныг хамарсан гэнэтийн хязгаарлалтын улмаас үүрэг гүйцэтгэгчийн гэм буруугүйгээр үүрэг гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд талуудын эрх ашгийг хамгаалан хэрхэн авч шийдвэрлэхийг судлан, ИХ-ийн 219.1-д заасан зохицуулалтын хүрээнд үүрэг гүйцэтгэгчийн “гэм буруугүй”-гээр үүргийн гүйцэтгэл боломжгүй болоход хуулийн зохицуулалтыг хэрхэн авч тайлбарлаж байгааг тус өгүүлэл харуулна. Мөн Япон улсын Иргэний хуулийн зохицуулалттай харьцуулан түүний онцлогийг гаргаж тавина. Ингэснээр үүрэг гүйцэтгэгчийн гэм буруугүйгээр үүргийн гүйцэтгэл боломжгүй болсон тохиолдолд асуудлыг хэрхэн шийдвэрлэх арга хэмжээг сайжруулах гарц гаргалгааг танилцуулах юм. Энэхүү өгүүлэл нь эрдэмтэн судлаачдын судалгаанд үндэслэн дэвшүүлсэн асуудалд оновчтой гаргалгааг эрэлхийлсэн болно.

ТҮЛХҮҮР ҮГ:

Үүргийн гүйцэтгэл боломжгүй болох, нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас үүргийн гүйцэтгэлийг биелүүлэх боломжгүй болох, шударга ёсны зарчим, гэм буруу.

I Оршил

Шинээр бүртгэгдсэн Ковид-19 цар тахлын халдварын тархалтыг зогсоох үүднээс Засгийн газар олон хязгаарлалтуудыг авч хэрэгжүүлсэн. Манай улс дотооддоо хэсэгчилсэн болон хатуу хөл хориог бүс нутагт харилцан адилгүйгээр тогтоосон. Ингэснээр худалдаа эрхэлдэг иргэдийн хувьд тодорхой хязгаарлалтын доор гэрээний үүргээ биелүүлэх боломжгүй болсон. Тухайн гэнэтийн шийдвэрийн нөхцөлд байдлаас гэрээний үүргээ биелүүлээгүйн улмаас талууд хохирол амсах эсвэл үүргийн гүйцэтгэл хангагдах боломжгүй нөхцөл байдалд орсон. Энэ нь аль нэг талын гэм буруугүйгээр бий болсон үр дүн юм. Тиймээс талуудад ашигтай шийдвэрлэх хууль зүйн гаргалгааг олох нь ихээхэн ач холбогдолтой юм.

Түүнчлэн талууд гэрээндээ гэнэтийн шийдвэрийн хязгаарлалтын талаар нарийн тусгаагүй тохиолдолд эрхзүйн хүрээнд хэрхэн асуудлыг шийдвэрлэх нь анхаарал татсаар байна. Энэхүү сэдвийг судалснаар талуудад харилцан ашигтай шийдвэрлэх боломжийг эрэлхийлэх юм. Өөрөөр хэлбэл практикт энэхүү тохиолдолд хэрхэх талаар судлаачдын байр суурийг илэрхийлсэн тодорхой судалгаа шаардлагатай байна.

Ковид-19 цар тахлын шууд бус дам нөлөөнөөс үүрэг гүйцэтгэгчийн гэм буруугүйгээр үүрэг гүйцэтгэх боломжгүй болж болно. Энэ талаарх зохицуулалтыг гэрээнд нарийвчлан тусгаагүй бол шүүх гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл хэмээн авч үзэх нь эргэлзээтэй байгааг судалгаа харуулж байна¹. Өөрөөр хэлбэл гэнэтийн хязгаарлалтын дам нөлөөний улмаас гэрээний үүргээ биелүүлэхгүй боломжгүй болсон гэдгээ нотлох боломжгүй тохиолдол гарч болох юм. Ингэснээр үүрэг гүйцэтгэгч ИХ-ийн 219.1-ийн дагуу үүргийн зөрчил гаргасанд тооцогдоно. Гэвч үүрэг гүйцэтгэгчийн гэм буруугүйгээр гарсан зөрчлийн үр дагаврыг үүрэг гүйцэтгэгч хариуцах нь шударга ёсны зарчимд нийцэхгүй юм.

Нээлттэй Нийгэм форумаас гаргасан “Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлаас үүссэн хэрэг маргааныг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ”-ээс ялгарах онцлог нь үүрэг гүйцэтгэгчийн гэм буруугүйгээр үүргийн гүйцэтгэл боломжгүй болох болон нөхцөл байдал өөрчлөгдсөнөөс үүрэг гүйцэтгэх боломжгүй болох зохицуулалтыг харьцуулах замаар үүрэг гүйцэтгэгчийн гэм буруугүйгээр үүргийн гүйцэтгэл боломжгүй болохтой холбоотой асуудлыг хөндөн тавих болно. Өөрөөр хэлбэл нөхцөл байдал өөрчлөгдсөнөөс үүрэг гүйцэтгэх боломжгүй болох зохицуулалтад хамаарахгүй, үүргийн гүйцэтгэл үүрэг гүйцэтгэгчийн гэм буруугүйгээр боломжгүй болоход хэрхэх талаарх судлаачдын байр суурийг авч судална.

Энэхүү судалгааны зорилго нь Ковид-19-ийн хязгаарлалтын улмаас үүрэг гүйцэтгэгч үүргийн гүйцэтгэлийг хангах боломжгүй болсон тохиолдолд талууд хэрхэн шийдвэрлэхийг авч судлах юм. Тодруулбал ИХ-ийн 219.1-д заасан зохицуулалт болон ИХ-ийн 220.1 заасан зохицуулалтыг дэлгэрэнгүй судална. Ийнхүү судлах болсон шалтгаан нь үүрэг гүйцэтгэгчийн “гэм буруугүй”-гээр үүргийн гүйцэтгэл боломжгүй болоход талууд хохирлыг хэрхэн шийдвэрлэх нь тодорхойгүй байгаад оршино. Иймд дэвшүүлсэн асуудалтай холбоотой судлаачдын байр суурийг тодруулан дүгнэж, харьцуулсан судалгаагаар оновчтой шийдэл олох нь судалгааны шинэлэг тал хэмээн үзэж байна.

II. Үндсэн хэсэг

A. Гэм буруугүйгээр үүргийн гүйцэтгэл боломжгүй болох тухай ойлголт

Үүргийн зүйл нь нэг бүрийн шинжээр тодорхойлогдох тохиолдолд уг зүйл нэг талын буруугаас, эсвэл бусад шалтгаанаар устаж, байхгүй болсон бол үүргийг биелүүлэх бодит боломжгүй болох юм². Хуульд үүргийн гүйцэтгэл боломжгүй болох тохиолдлыг 3 янзаар тодорхойлон хуульчилсан байна. Үүнд үүргийн гүйцэтгэл боломжгүй болсон нь үүрэг гүйцэтгэгчийн буруугаас болсон тохиолдолд Иргэний хуулийн 219.1-дэх хэсэгт заасны дагуу үүрэг гүйцэтгэгчээр хохирлыг барагдуулах зохицуулалт юм.

Иргэний хуулийн 219 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн зохицуулалтыг тайлбарлахдаа тухайн анхдагч үүргийг гүйцэтгүүлэхэд чиглэсэн шаардах эрх дуусгавар болж оронд нь хоёрдогч шаардах эрх болох хохирол нэхэмжлэх эрх үүснэ хэмээн тайлбарласан байна³. Үүргийн гүйцэтгэл боломжгүй болохыг онолын хувьд объектив ба субьектив байдлаар болон өөр олон байдлаар ангилах нь зүйтэй. Энэ нь хоёрдогч шаардах эрхийн хэмжээ хязгаарыг тогтооход нэн ач холбогдолтой⁴.

Субьектив байдлаар боломжгүй болно гэдэг нь үүрэг гүйцэтгэгчийн хувийн зүгээс тус үүргийг гүйцэтгэж чадахаа болихыг хэлнэ. Харин объектив байдлаар байдлаар боломжгүй болно гэдэг нь өөр хэн ч үүргийг гүйцэтгэх боломжгүй болохыг хэлнэ. Мөн гэрээ байгуулах мөчид гүйцэтгэл аль хэдийн боломжгүй болсон байсан бол үүнийг анхдагч,

¹ Энхбаяр.Б, Домжан.Б, Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлаас үүссэн хэрэг маргааны хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ, ННФ, 2022, 245 дахь тал.

² Ж.Оюунтунгаалаг, Иргэний эрхзүй II Гэрээний үүрэг, Уб, 2022, 89 дахь тал.

³ Б.Буянхшиг, Үүргийн эрхзүйн ерөнхий анги, Уб, 2017, 148-149 дахь тал.

⁴ Б.Буянхшиг, Үүргийн эрхзүйн ерөнхий анги, Уб, 2017, 150-151 дахь тал.

гэрээ байгуулсны дараа боломжгүй байдал үүссэн нөхцөлд хожим үүсэн боломжгүй нөхцөл хэмээн үзнэ. Хууль тогтоогч анхдагч болон хожим үүссэн боломжгүй нөхцөлийн үр дагаврын хувьд адилтган авч үзсэн⁵. Мөн дээрх ангиллаас гадна эрхзүйн шинжлэх ухаанд үүрэг гүйцэтгэх боломжгүй болох фактын болон практик шинжтэй, мөн ёс суртахууны шинжтэй нөхцөл байдал үүсэж болохыг тогтоосон⁶.

Иргэний хуулийн 219 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт үндэслэн хохирол шаардахад дараах урьдчилсан нөхцөл байхыг тусгасан байдаг. Үүнд үүргийн харилцаа үүссэн эсэх, үүргийн зөрчил мөн эсэх, гэм буруутай эсэх, нэмэлт хугацаа, хохирол байгаа эсэх зэрэг хамаарна⁷. Үүрэг гүйцэтгэгч үүргийн гүйцэтгэл боломжгүй болсонд гэм буруугүй гэдгээ өөрөө нотлох тухай тусгасан байна.⁸

Үүргийн харилцаанд үүрэг гүйцэтгэгчийн гэм буруугийн талаар авч үзэхдээ гэрээний үүргээ гүйцэтгэх талаар зохих анхаарал тавьсан боловч өөрөөс нь үл хамааран шалтгаанаар үүргээ зөрчсөн бол үүрэг гүйцэтгэгчийг аливаа хариуцлагаас чөлөөлөх нь шударга ёсонд нийцнэ. Гэвч гэрээг заавал биелүүлэх *pacta sunt servanda*⁹ зарчмыг зөрчин¹⁰.

Иргэний хуулийн 222 дугаар зүйлийн 2 дахь хэсэг болон 227 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт үүрэг гүйцэтгэгчийн гэм буруу байхгүй бол хугацаа хэтрүүлсэн тооцохгүй эсхүл хохирол төлөх хариуцлагаас чөлөөлөх тухай заалт тусгагдсан. Үүнээс дүгнэхэд “гэм буруу” нь хохирол арилгах нэг урьдчилсан нөхцөл мөн гэж үзсэн. Өөрөөр хэлбэл нэгэнт зөрчил байхгүй гэж үзвэл хариуцлагын асуудал яригдахгүй. Үүнээс гадна үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгэх талаар зохих анхаарал тавьсан боловч үүргээ зөрчсөн тохиолдолд хамаарна. Өөрөөр хэлбэл шударга ёсны үүднээс түүнийг гэм буруутайд тооцох боломжгүй бусад тохиолдол (Иргэний хуулийн 206-д дурдсан шударга ёсны зарчмыг баримтална) хамаарна хэмээжээ¹¹.

Зарим судлаач үүрэг гүйцэтгэгч үүргийн гүйцэтгэлд боломжгүй болсонд гэм буруугүй бол түүнийг хариуцлагаас чөлөөлж, үүргийн харилцааг дуусгавар болгох үзэл баримтлалыг давхар агуулж байгаа эсэх нь анхаарал хандуулсан байна. Тэрээр цааш нь бичихдээ хууль тогтоогчид Иргэний хуулийн 219.1 дүгээр зүйлд үүргийн гүйцэтгэл гэм буруутай бол хохирол нөхөн төлүүлэх зохицуулалтыг үүргийн гүйцэтгэл үүрэг гүйцэтгэгчийн гэм буруугүйгээр боломжгүй болох нөхцөлд гэрээний харилцаа дуусгавар болгох нэгэнт хуульчилсан. Ингэхдээ хууль зүйн техник, найруулга зүйн хувьд зөвхөн хохирол нөхөн төлүүлэх мэт ойлгогдохоор зохицуулсан нь эдийн засгийн хүнд нөхцөл үүссэн тохиолдолд ойлгомжгүй байдал үүсгэсэн гэжээ¹². Судлаач С.Должин ИХ-ийн 219.1-ийг дүгнэхдээ үүргийн гүйцэтгэл боломжгүй болох нь ямар нөхцөлийг агуулж байгаа нь маш тодорхойгүй байгааг дурдсан¹³.

Үүрэг гүйцэтгэгчийн гэм буруугүйгээр түүний хүсэл зоригоос үл хамаарсан нөхцөл байдлаас үүрэг биелэгдэх боломжгүй бол үүрэг дуусгавар болно. Харин үүрэг гүйцэтгэгчийн гэм буруугаас үүрэг гүйцэтгэх боломжгүй болбол үүрэг дуусгавар болж байгаа гэж үзэхгүй. Үүрэг гүйцэтгэгч нь хариуцлага хүлээх буюу хохирлыг нөхөн төлөх,

⁵ Мөн тэнд

⁶ Д.Энхзүл, Иргэний эрх зүйн 40 бодлого, УБ, 2009, 53-60 дахь тал,

⁷ Б.Буянхшиг, Үүргийн эрхзүйн ерөнхий анги, УБ, 2017, 150-151 дахь тал.

⁸ Мөн тэнд

⁹ 18 дугаар зуунаас эхлэн өдийг хүртэл олон улсын эрхзүйн баримт бичиг болон зан заншлын хэм хэмжээнд хэрэглэгдэж ирсэн үзэл хандлага юм. Латин хэлнээс Англи хэлрүү “agreements must be kept” гэж орчуулагдана. Орчин үед энэхүү үзэл олон улсын эрхзүй болон гэрээний эрхзүйд өргөнөөр хэрэглэгдэж байна.

¹⁰ Т.Мэндсайхан, Гэрээний эрхзүй, УБ, 2021, 260-263 дахь тал.

¹¹ Мөн тэнд.

¹² С.Должин, “Үүрэг гүйцэтгэх боломжгүй болох нөхцөлд эдийн засгийн дүн шинжилгээ хийх хөгжлийн чиг хандлага” Монгол Улсын хувийн эрх зүйн тулгамдсан асуудал: Иргэний болон худалдааны хууль тогтоомжийн олон улсын жишиг (2019 оны хавар): 307-318 дахь тал.

¹³ Мөн тэнд

хууль буюу гэрээнд заасан үүрэг хүлээх этгээд болж хувирдаг¹⁴ хэмээн тайлбарласан байна.

Тодруулбал үүргийг гүйцэтгэх бодит боломж байхгүй болсон нь үндсэн үүргийг дуусгавар болгох үндэслэл болно. Үүнийг онолын хувьд “бодит байдалд боломжгүй”, “хууль зүйн хувьд боломжгүй гэсэн хоёр төрөлд хувааж үздэг. Бодит байдалд боломжгүй гэдэг нь ихэвчлэн нэг бүрийн шинжээр тодорхойлогдох эд зүйл устаж алга болсонтой холбоотой¹⁵. Жишээлбэл, хөлслүүлж буй байшин гал түймэрт шатсан зэрэг болно. Энэхүү үүргийг гүйцэтгэх боломжгүй байдал бий болоход үүргийн аль ч тал залруулах боломжгүй байгаа тохиолдолд үүргийг дуусгавар болсон гэж үзнэ. Үүргийг гүйцэтгэх боломжгүй болсноор үүрэг дуусгавар болж байгаа тохиолдолд гэрээгээр шилжүүлсэн зүйлээ шаардах эрхтэй. Энэ нөхцөл байдалд буруугүй этгээд үүргийн гүйцэтгэлийг буцааж өгөх үүрэг хүлээхгүй¹⁶.

ИХ-ийн 219.1 дүгээр зүйлийн зохицуулалтаас логикийн хувьд дүгнэвэл үүрэг гүйцэтгэх боломжгүй нөхцөл байдал үүсвэл хохирлыг нөхөн төлөхийг шаардах эрхтэй ба үүний тулд үүрэг гүйцэтгэгч гэм буруутай байх шаардлагатай гэжээ¹⁷. Гэрээний үүргээ хугацаанд нь бүрэн бүтэн биелүүлэх баталгаа өгөх, мөн үүрэг гүйцэтгээгүйгээс болон хугацаанд нь биелүүлээгүйгээс үүрэг гүйцэтгэгчид учирч болох аливаа эрсдэлийг бүрэн хариуцахаар амлах ёстой гэж үздэг эрхзүйн тогтолцоо байдаг. Иргэний хуулийн 219.1 дэх хэсэгт үүрэг гүйцэтгэгчийн буруутай эсэх талаар дурдаагүй байдал нь Монгол улсын хууль тогтоох байгууллага дээрх үзлийг баримталсан болов уу гэж үзэхэд хүргэж буй ч ийм зохицуулалт дутагдаж байгааг дурджээ¹⁸.

Үүрэг гүйцэтгэгчийн гэм буруугийн болгоомжгүй үйлдэл, эс үйлдэхүй нь бусдад учирсан гэм хорыг арилгах үүргээс чөлөөлөхгүй гэсэн байна. Болгоомжгүй гэдэгт тухайн этгээд өөрийн үйлдлийн үр дагаврыг урьдаас мэдэх ёстой болон түүнээс зайлсхийж болохоор байхыг хэлнэ. Урьдаас мэдэх боломжтой байх болон зайлсхийх боломжтой боломжтой байх нь болгоомжгүй үйлдлээр бусдад гэм буруу учруулсан гэж үзэх үндэслэл болдог¹⁹.

Б. Нөхцөл байдал өөрчлөгдсөнөөс үүрэг гүйцэтгэх боломжгүй болох тухай ойлголт

Гэрээний талуудын гэрээ байгуулж байсан нөхцөл байдал нь гэрээ байгуулагдсанаас хойш гэнэт өөрчлөгдөж болно. Энэ тохиолдолд талуудын гэрээний харилцааг тухайн нөхцөл байдалд нийцүүлэн зохицуулахаар хууль тогтоогч энэхүү заалтыг хуульд тусгасан. Тус зохицуулалт ямар нөхцөлд хэрэглэгдэх болон тус ойлголтын талаар тодруулъя.

Энэхүү ойлголт нь европын орнуудад дахь Дэлхийн нэг, хоёрдугаар дайны дараах гэрээний харилцаанд бэрхшээл болоод байсан инфляцтай холбоотой эдийн засгийн хямралд нийцүүлэн зохицуулах зорилгоор гарч ирсэн. Тус зохицуулалтаар анх талууд гэрээг өөрчлөгдсөн нөхцөл байдалд нийцүүлэхийг харилцан шаардах эрхтэй байхаар хэрэглэгдэж эхэлсэн. Тус онолын үзэл баримтлалын үндэс нь үүргээ шударгаар биелүүлэх суурь зарчим юм. Гэсэн ч *pacta sunt servanda* зарчмыг хөндөхгүй гэдэг үүднээс гэрээг шинэ нөхцөл байдалд нийцүүлэх явдалд ихээхэн хатуу шаардлага тавьж ирсэн²⁰.

“Нөхцөл байдал өөрчлөгдөх” ойлголт, нэр томъёог анх удаа 2002 оны Иргэний хуульд ашигласан. 2002 оны Иргэний хуулийн 202.1 ба 206.1-д тусгасан “харилцан итгэлцэл, шударга ёс”-ны зарчим зарчмыг хангах үүднээс “нөхцөл байдал өөрчлөгдөх” онцлог

¹⁴ Н.Чинбат, Иргэний эрхзүйн лекцийн товчоон ерөнхий анги, Уб, 2014, 285-286 дахь тал.

¹⁵ Ж.Оюунгунгалаг, Иргэний эрхзүйн ерөнхий анги, Уб, 2020, 200-201 дахь тал.

¹⁶ Мөн тэнд.

¹⁷ Б.Тэмүүлэн, “Үүргийн эрхзүйн ерөнхий анги дахь зөрчилдөөнтэй ба дутуу хийгдсэн зохицуулалтын асуудал” Эрхзүй сэтгүүл №2 : 72-78 дахь тал.

¹⁸ Мөн тэнд.

¹⁹ Кают Ё, Шпанглер Э нар, Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар, Уб, 2010, 421-430 дахь тал.

²⁰ Б.Буянхшиг, Үүргийн эрхзүйн ерөнхий анги, Уб, 2017, 162 дахь тал.

зохицуулалтыг бий болгосон байна²¹. Үүнээс өмнө нь анх 1926 оноос гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн тухай зохицуулалт тусгагдаж байсныг судлаач нарийвчлан судалсан байна²².

ИХ-ийн 220.1-ийн урьдчилсан нөхцөлийг тодорхойлсон бөгөөд энэ талаар дэлгэрэнгүй авч үзье. Нэгдүгээрт гэрээ байгуулах үндэслэл болсон нөхцөл байдал гэрээ байгуулсны дараа илтэд ноцтой өөрчлөгдөх юм. Ноцтой өөрчлөлт гэдэгт талуудын төсөөлөл, тооцооллоос их хэмжээгээр зөрөхийг ойлгоно. Нөхцөл байдал өөрчлөгдсөнийг тогтоохын өмнө талуудын ашиг сонирхлыг зэрэгцүүлэн харьцуулах шаардлагатай болдог. Хоёрдугаарт тухайн нөхцөл байдал нь зөвхөн гэрээний суурь үндэслэлд хамаарсан байх юм. Энэ нь гэрээний зорилго, гэрээний талуудын нийтлэг хүсэл зориг, гэрээний талуудын харилцан үүргийн шинж, гэрээний үндсэн нөхцөлийг тогтооход баримталсан шалгуур, үнэ хөлс тохиролцоход харгалзан үзсэн хүчин зүйл юм. Гуравдугаарт нөхцөл байдал өөрчлөгдөхийг талууд урьдчилан мэдэж байсан эсхүл нөхцөл байдлын талаар үнэн зөв төсөөлөлтэй байсан бол гэрээг байгуулахгүй байх эсхүл өөр агуулгаар байгуулах боломжтой байсан. Энэхүү нөхцөлийг тухайн төрлийн гэрээний тогтсон практик болон гэрээний талуудын хүсэл зоригоос хамаарна. Дөрөвдүгээрт гэрээний өөрчлөлт оруулахыг аль нэг тал сайн дураар хүлээн зөвшөөрөөгүй байх юм. Хэрэв талууд өөрчлөлт оруулах талаар тохиролцсон бол үүнийг гэрээний эрх чөлөөнд үндэслэсэн гэж үзнэ. Зөвхөн талууд хожим үүссэн нөхцөл байдлын талаар тохиролцож чадахгүй, нэг тал гэрээнд өөрчлөлт оруулахаас татгалзсан үед энэхүү зохицуулалтыг хэрэглэж болно. Тавдугаарт нөхцөл байдалд нийцүүлэн гэрээг тайлбарлах аргаар гэрээний зүйл заалтыг хэрэглэх боломжгүй байх юм. Гэрээг үргэлжлүүлэн дагаж мөрдөх нь хүлээн зөвшөөрч үл болохуйц, шударга ёсонд үл нийцэх үр дагаварт хүргэх, үүний улмаас аль нэг талд гэрээг баримтлахыг тулгаж хүлээлгэх зохисгүй тохиолдолд хэрэглэнэ²³.

Иргэний хуулийн 220.1 дэх хэсгийн зохицуулалтын урьдчилсан нөхцөл нь гэрээ байгуулагдсаны дараах нөхцөл өөрчлөлт, гэрээний агуулгаас гадуурх нөхцөл байдал, нөхцөл байдлыг урьдчилан харсан бол гэрээ байгуулахгүй нь илт байх, гэрээг биелүүлэх туйлын бэрхшээлтэй байх зэрэг хамаарна²⁴. Гэрээний агуулгаас гадуурх нөхцөл байдал гэдэг нь өөрчлөгдөөд буй нөхцөл байдал нь гэрээний агуулга болоогүй байх нь чухал. Гэрээний агуулгыг биелүүлэх боломжгүй болсон бол ИХ-ийн 219-ийн хуулийн зохицуулалт хэрэглэгдэх тул энэ асуудал ИХ-ийн 220.1-т хамаардаггүй²⁵. Гэрээ биелүүлэх нь туйлын бэрхшээлтэй байх гэдэг нь гэрээг чандлан баримталснаар хууль, шударга ёсонд үл нийцэх хүнд үр дагавар бий болохыг ойлгоно гэж дурджээ²⁶. Дээрх урьдчилсан нөхцөлүүд нь объектив нөхцөл байдал өөрчлөгдсөнийг тогтооход чухал ач холбогдолтой байна.

Судлаач Б.Буянхишиг үүргийн гүйцэтгэл боломжгүй болсон шалтгаанаар үүргээс чөлөөлөгдөөгүй нөхцөл л гэрээг өөрчлөгдсөн нөхцөл байдалд нийцүүлэх асуудал яригдах бололцоотой тул ИХ-ийн 219 нь ИХ-ийн 220-оос давуу хэрэглэгдэнэ²⁷ гэжээ. Үүнээс харахад үүргийн гүйцэтгэл боломжгүй болоход “гэрээний зорилго биелсэн эсэх” болон “эдийн засгийн үүднээс ашиггүй болсон эсэх”-ийг шалгах нь ИХ-ийн 220-ийн хүрээг тодорхойлж байна. Гэрээний зорилготой уялдуулан авч үзсэн нь үүргийн гүйцэтгэлийг явуулах бүрэн боломжтой ч үүрэг гүйцэтгүүлэгч үүнийг хүлээн авах ямар ч сонирхолгүй болсон бол үүнийг үүргийн гүйцэтгэл боломжгүй болсон гэж үзэхгүй. Тодруулбал гэрээний зорилго гэрээний зүйлийн үнийн дүнг тодорхойлоход ач холбогдолтой байсан явдал нь хамаарна.

²¹ Т.Мэндсайхан, Гэрээний эрхзүй, Уб, 2021, 260 дахь тал.

²² С.Солонго, “Ковид-19 Цар тахал нь гэрээний үүргийн гүйцэтгэлд нөлөөлөх эрх зүйн үр дагавар, шийдвэрлэх арга зам”, магистрын зэрэг горилсон бүтээл, МУИС-ХЗС, 2022, 9-11 дэх тал.

²³ Т.Мэндсайхан, Гэрээний эрхзүй, Уб, 2021, 263-265 дахь тал.

²⁴ Мөн тэнд

²⁵ Б.Буянхишиг, Үүргийн эрхзүйн ерөнхий анги, Уб, 2017, 181 дэх тал.

²⁶ Мөн тэнд

²⁷ Б.Буянхишиг, Үүргийн эрхзүйн ерөнхий анги, Уб, 2017, 183 дахь тал.

Нөгөө талаас ИХ-ийн 220.1-д тусгагдсан “гэрээ байгуулах үндэслэл” гэх ойлголтыг тодруулах шаардлагатай ба гэрээ байгуулах үндэслэл гэх ойлголтод гэрээ байгуулах болсон зорилго, эдийн засгийн бизнесийн үндэслэл зэрэг багтах боломжтой. Гэвч практик амьдралд өргөн тохиолдох боломжтой субъектив болон объектив байдал, эрхзүйн хувьд үүрэг гүйцэтгэх боломжгүй байдал зэрэг нь үүнд багтах эсэх нь тодорхойгүй байна гэж дүгнэжээ²⁸.

Судлаач С.Солонго гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдал ямар нөхцөл байдлыг ойлгох, талууд гэрээ байгуулахдаа гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн талаар тусгаагүй тохиолдолд хэрхэн зохицуулах гэх мэт нэн шаардлагатай заалтууд Иргэний хуульд тусгагдаагүй хэмээн дүгнэсэн байна²⁹. Шүүхийн шийдвэрүүдэд түүвэр байдлаар дүгнэлт хийхээр авч үзэхэд талууд гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн талаар гэрээнд тусгаагүй тохиолдолд гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлийг харгалзан үздэггүй. Мөн МҮХАҮТ-ын тухай хуульд гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлийг гэрчлэх эрх бүхий байгууллага хэмээн хуульчилсан байх боловч энэхүү гэрчилгээ нь шүүхэд нотлох баримтад тооцогдохгүй байгаа нь харагдаж байна хэмээн дүгнэжээ³⁰.

МҮХАҮТ-ын “Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл болон хүнд нөхцөл байдлын гэрчлэх” журамд гэрчилгээ гаргуулахдаа тухайн харилцааг зохицуулж буй гэрээндээ гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл, хүнд нөхцөл байдлыг тусгасан байхыг шаардсан байна³¹. Нөгөө талаас гэрчилгээ олгохгүй тохиолдол нь хүсэлт гаргагчид тохиолдсон үйл явдал, нөхцөл байдал нь талуудын хооронд байгуулагдсан гэрээ, эсхүл энэхүү журамд заасан давагдашгүй хүчин зүйл эсхүл хүнд нөхцөл байдлын тохиолдолд хамаарахгүй болохыг дурджээ³².

Талуудын хувьд дараах гурван шаардлагыг хангасан тохиолдолд гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл тохиолдсон хэмээн үзэж хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл үүсэнд тооцно гэжээ³³. Үүнд:

1. Тухайн нөхцөл байдал үүргээ биелүүлээгүй талын хяналтаас гадуур болсон.
2. Гэрээг байгуулах үед тухайн нөхцөл байдлыг таамаглах боломжгүй байсан.
3. Тухайн нөхцөл байдлыг даван туулах боломжгүй байсан.

Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл бий болж, түүнийг нотолсноор тухайн тал гэрээний үүргээ биелүүлээгүй хариуцлагаас чөлөөлөгдөхгүй ба гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн тохиолдол нь гэрээний үүргийг бүхэлд нь дуусгавар болгохгүй. Зөвхөн уг нөхцөл байдал бий болсноос дуусах хүртэл, дууссаны дараа үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай тогтоосон хугацаа өнгөртөл үүргийн гүйцэтгэл түр хойшлогдож болно³⁴. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл тохиолдоход гэрээ биелэгдэх боломжгүй болох ба гэрээг цуцлах эсвэл хүчингүй болгоно.

Ковид-19 цар тахлын үед УИХ-аас Ковид-19-ийн цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг 2020 оны 4 сарын 29-ний өдөр баталсан. Тус хууль хэрэгжсэнээр Засгийн газрын зүгээс нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн тогтоолуудыг баталсан. Ковид-

²⁸ Б.Тэмүүлэн, “Үүргийн эрхзүйн ерөнхий анги дахь зөрчилдөөнтэй ба дутуу хийгдсэн зохицуулалтын асуудал” Эрхзүй сэтгүүл №2, 72-78 дахь тал.

²⁹ С. Солонго, “Ковид-19 Цар тахал нь гэрээний үүргийн гүйцэтгэлд нөлөөлөх эрх зүйн үр дагавар, шийдвэрлэх арга зам”, магистрын зэрэг горилсон бүтээл, МУИС-ХЗС, 2022, 12 дахь тал.

³⁰ С. Солонго, “Ковид-19 Цар тахал нь гэрээний үүргийн гүйцэтгэлд нөлөөлөх эрх зүйн үр дагавар, шийдвэрлэх арга зам”, магистрын зэрэг горилсон бүтээл, МУИС-ХЗС, 2022, 57 дахь тал.

³¹ Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл болон хүнд нөхцөл байдлыг гэрчлэх журам, 2.2.1 дэх хэсэг.

³² Мөн тэнд.

³³ МҮХАҮТ-ын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитр, “Давагдашгүй хүчин зүйл болон хүнд нөхцөл байдлын тухай” гарын авлага, 2020, 9 дэх тал.

³⁴ Мөн тэнд.

19-ийн эсрэг хуульд³⁵ хязгаарлалтын дэглэмийн улмаас үйл ажиллагаа нь доголдсон аж ахуй нэгж, байгууллага, цалин, орлого нь тасалдсан иргэдэд зохих дэмжлэг үзүүлэх талаар тусгасан байна. Энэхүү зохицуулалт нь гэрээний эрхзүйн харилцаанд шууд нөлөөлсөн нөлөө нь тодорхойгүй байна.

Иргэний хуулийн тайлбарт нөхцөл байдал өөрчлөгдсөн тохиолдолд тухайн нөхцөлийг тодорхойлоход “гэрээний үндэс, суурь” хэмээх ойлголтыг авч үзсэн. Гэрээний үндэс суурь гэдэгт гэрээний агуулгаар тодорхойлоогүй, гэрээ байгуулах үед илэрхий болсон гэрээний хоёр талын санал нэгдэж, хамтарсан төсөөллүүд хамаарна. Мөн бий болсон буюу хожим бүрэлдэх нөхцөл байдал, цаашид хэвээр үргэлжлэх нөхцөл байдлын талаарх хэлцлийн нэг талыг төсөөллийг ойлгож болох юм. Нэг талын ийм төсөөллийн тухайд энэ нь гэрээний нөгөө талд ойлгомжтой, илэрхий, түүний зүгээс ямар нэг байдлаар маргаангүй байх шаардлагатай. Гэхдээ гэрээний үндэс суурьт тооцогдох аливаа төсөөлөл нь ажил хэрэг явуулах хүсэл зоригийн тулгуур болох ёстой гэжээ³⁶. Гэрээний үндэс суурь нь гэрээний талуудад ач холбогдолтой, чухал байхаар харагдаж байна.

Ковид-19 цар тахал нь гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл хэмээн авч үзэхэд гэрээнд заавал энэ талаар тусгах эсвэл зайлшгүй хязгаарлалтад орсон тухайгаа нотлохыг үүргийг үүрэг гүйцэтгэгч хүлээж байна. Түүнчлэн Ковид-19-ийн шууд бус дам нөлөөг гэрээний үүргийн гүйцэтгэл боломжгүй болоход нөлөөлсөн хэмээн нотлох нь хүндрэлтэй байхаар байна.

Дээрхээс харахад Ковид-19-ийн нөхцөл байдал нь ИХ-ийн 220.1-д заасан нөхцөл байдал өөрчлөгдсөнөөс үүрэг гүйцэтгэх боломжгүй болох нөхцөл хамаарч болохоор байна. Гэвч гэрээнд энэ талаар нарийвчлан тусгаагүй болон Ковид-19-ийн шууд бус дам нөлөөнд автсан тохиолдолд дээрх нөхцөлд хамааруулах эсэх нь тодорхойгүй эргэлзээтэй байна. Өөрөөр хэлбэл үүрэг гүйцэтгэгч гэм буруугүйгээр үүргийн зөрчлийн хариуцлагыг хүлээж болзошгүй байна.

В. Япон улстай хийсэн харьцуулалт

Үүргийн гүйцэтгэл боломжгүй болох зохицуулалтыг Японы иргэний хуулийн нэмэлт өөрчлөлтөөр шинээр тусгасан. Иргэний хуулийн 412 дугаар зүйлийн 2 дахь заалтын 1 дэх хэсэгт “Нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн бусад шалтгааны улмаас үүргийн гүйцэтгэл боломжгүй болсон бол үүрэг гүйцэтгэгчийг үүргээс чөлөөлнө” гэжээ. Харин гэрээ байгуулахаас өмнө үүргийн гүйцэтгэл хангагдах боломжгүй байсан нь тогтоогдвол үүрэг гүйцэтгүүлэгч үүрэг гүйцэтгэгчээс хохирлоо шаардах эрхтэй хэмээн тусгажээ.

Өмнөх хуульд мөрдөгдөж байсан үүргийн гүйцэтгэл боломжгүй болох үзэл санаа нь анхнаасаа үүргийн гүйцэтгэл хангагдах боломжгүй болсон тохиолдолд гэрээг хүчин төгөлдөр бус хэмээн тооцдог. Энэ тохиолдолд үүргийн гүйцэтгэл боломжгүй болсонд хохирол шаардах боломжгүй байсан. Одоо мөрдөгдөж байгаа нэмэлт өөрчлөлтөөр хохирол шаардах боломжтой болсон.

Одоогийн мөрдөгдөж байгаа үзэл санаанд анхнаасаа үүргийн гүйцэтгэл хангагдах боломжгүй байсныг хүчин төгөлдөр бусаар тооцох шаардлагагүй хэмээн гэж үздэг нь шүүмжлэлийг дагуулж байна. Өөрөөр хэлбэл үүргийн гүйцэтгэл боломжгүй болох нь гэрээ байгуулахаас өмнө, гэрээ байгуулсны дараах байдлаас хамааран дүгнэлт нь ялгаатай байх нь зохимжгүй хэмээн шүүмжилдэг³⁷. Тиймээс анхнаасаа үүргийн гүйцэтгэл хангагдах боломжгүй тохиолдолд хохирол нэхэмжлэхээр тусгасан.

Үүргийн гүйцэтгэл боломжгүй болох тохиолдлыг гурван төрөл хуваасан. Нэгдүгээрт объектив байдлаар үүрэг гүйцэтгэх боломжгүй болох гэдэг нь үүргийн зүйл устаж алга

³⁵ Ковид-19-ийн цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, 2020.

³⁶ Кают Ё, Шпанглер Э нар, Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар, Уб, 2010, 430 дахь тал.

³⁷ 弁護士 金子 剛、” 民法解説 ” 金子総合法律事務所 (2020 Хавар): 7-8.<https://tek-law.jp/civil-code/claims/general-provisions/effects-of-claims/liability-for-non-performance/article-412-2/> (2022 оны 11-р сарын 20-ны өдөр үзэв.)

болох тохиолдлыг ойлгоно. Хоёрдугаарт нийгмээс хамааран үүргийн гүйцэтгэл боломжгүй болох гэдэг нь тухайн үүрэг гүйцэтгэгчийн гэм буруугүйгээр үүргийн гүйцэтгэл боломжгүй болохыг хэлнэ. Гуравдугаарт хууль зүйн хүрээнд үүргийн гүйцэтгэл боломжгүй болох гэдэг нь хуулийн хязгаарлалтаас тухайн үүргийг гүйцэтгэх боломжгүй болохыг хэлдэг.

Японы Иргэний хуулийн 412.2-т заасныг үндэслэн үүргийн гүйцэтгэл боломжгүй болсныг тогтооход “нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн бусад шалтгаан”³⁸-ыг тодруулах шаардлагатай болдог. Ингэхэд дээрх гурван төрлөөс аль нь болохыг тодорхойлно. Үүний дээр “гэрээний болон нэмэлт үүргийн үүссэн шалтгаан болон гэрээний харилцааны нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээнд үндэслэн тодруулдаг”³⁹.

2020 оны 4 сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн Японы Иргэний хуулийн нэмэлт өөрчлөлттэй харьцуулан судалгаа хийв. Иргэний хуулийн зохицуулалтын хүрээнд үүргийн гүйцэтгэл боломжгүй болохыг тогтооходоо үүргийн гүйцэтгэл боломжгүй болсон нь гэрээ байгуулагдахаас өмнө эсвэл дараа эсэхийг тодруулах нь чухал ач холбогдолтой байна. Ингэснээр үүрэг гүйцэтгүүлэгч үүрэг гүйцэтгэгчээс хохирол шаардах эрхтэй эсэхийг тодруулах юм. Манай улсын хувьд үүргийн гүйцэтгэл гэрээ байгуулах үед аль хэдийн боломжгүй байсан “анхдагч” нөхцөл болон гэрээ байгуулсны дараа боломжгүй болсон “хожим” үүссэн боломжгүй нөхцөл нь үр дагаврын хувьд ижил байгааг судлаач дүгнэсэн⁴⁰.

*Хүснэгт №1. Японы Иргэний хуулийн нэмэлт өөрчлөлт*⁴¹

	Японы Иргэний хуулийн нэмэлт өөрчлөлтийн өмнө	Японы Иргэний хуулийн нэмэлт өөрчлөлтийн дараа
Анхнаасаа үүргийн гүйцэтгэл боломжгүй байх (原始的不能)	Хүчин төгөлдөр бусад тооцно	Иргэний хуулийн 412.2.2 ⁴² дахь хэсэгт заасны дагуу шийдвэрлэнэ.
Гэрээ байгуулсны дараа үүргийн гүйцэтгэл боломжгүй болох (後発的不能)	Үүргийн гүйцэтгэл боломжгүй болсонд тооцно.	Үүргийн гүйцэтгэл боломжгүй болсонд тооцно.

Үүрэг гүйцэтгэгчийн гэм буруугүйгээр үүргийн гүйцэтгэл боломжгүй болсон тохиолдолд гэрээ байгуулах үед анхнаасаа боломжгүй байсан тохиолдолд гэрээ хүчин төгөлдөр бусад тооцогдоно. Харин гэрээ байгуулсны дараа үүргийн гүйцэтгэл боломжгүй болсон тохиолдолд гэрээний эрсдэл шилжих асуудлын талаар хөндөгдөнө.⁴³ Энэ талаар Японы Иргэний хуулийн 534 дугаар хэсэгт зохицуулсан байдаг. Харин гэрээний зүйлд ямар нэгэн доголдол илэрсэн тохиолдолд үүргийн бүрэн бус гүйцэтгэлд хамааруулан зохицуулдаг.

Үүрэг гүйцэтгэгчийн гэм буруугүйгээр үүргийн гүйцэтгэл боломжгүй болсон тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч хохирол шаардах эрхгүй болно. Үүнийг Япон Иргэний хуулийн 412 дугаар зүйлийн 1 дэх хэсгээр зохицуулсан байна. Үүрэг гүйцэтгэгчийн гэм буруутай эсэхийг тогтооходоо нийгмээс хамаарах нөлөөг чухалчлан авч үзэж байна. Энэ нь тухайн үүрэг гүйцэтгэгчийн хүсэл зоригоос үл хамаарах нийгмийн хүчин зүйлийн нөлөө юм.

Үүрэг гүйцэтгэгчийн гэм буруугүйг тогтооход нийгмээс хүлээн зөвшөөрөгдсөн нийтлэг үзэл, хандлагыг чухалчлан авч үзэж байна. Энэ нь нийгмээс хүлээн зөвшөөрөгдсөн

³⁸ Япон хэлэнд 会社通念上 гэж нэрлэдэг. Энэ нь нийгэмд нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн ойлголт, үзэл бодол зэрэг юм.

³⁹ 増野 圭, “履行不能とは” 国際総合事務所 (2020 Хавар):1-4. <https://xn--3kqu8h74fvjh21bnlehqde40h44r.com/> (2022 оны 11-р сарын 18-нд үзэв.)

⁴⁰ Б.Бат-Эрдэнэ, Үүргийн эрхзүйн ерөнхий анги, УБ, 2017, 149 дэх тал.

⁴¹ 債務不履行の改正債権法改正のポイント【第04回】～債務不履行の改正を押さえよう～

[https://yotsuyagakuin-tsushin.com/blog_takkenshiken/saikenho04/\(2023 оны 11-р сарын 15-нд үзэв.\)](https://yotsuyagakuin-tsushin.com/blog_takkenshiken/saikenho04/(2023 оны 11-р сарын 15-нд үзэв.))

⁴² 債務の履行が契約その他の債務の発生原因及び取引上の社会通念に照らして不能であるときは、債権者は、その債務の履行を請求することができない。

⁴³ 加賀山茂, 契約法講座、日本評論社.2017, 261 дэх тал.

хэм хэмжээгээр тохирсон цар хүрээгээр тодорхойлогдож байна. Энэхүү үүргийн зохицуулалт нь гэрээний талуудын тогтвортой, найдвартай харилцааг бий болгоход чухал үүрэгтэй байна.

III. ДҮГНЭЛТ, САНАЛ

ИХ-ийн 219.1-ийн урьдчилсан нөхцөлд үүрэг гүйцэтгэгчийн “гэм буруу”-тай эсэхийг тогтоох нь чухал болохыг судлаачид дүгнэсэн байна. Гэвч үүрэг гүйцэтгэгчийн “гэм буруу”-гүйгээр үүргийн гүйцэтгэл боломжгүй болсон тохиолдолд хэрхэх талаар судлаачид ялгаатай байр суурьтай байна. Т.Мэндсайхан (2021), Н.Чинбат (2014), Ж.Оюунтунгалаг (2020) нар үүрэг гүйцэтгэгч “гэм буруугүй” тохиолдолд үүрэг гүйцэтгэгчийг үүргээс чөлөөлж үүргийн харилцааг дуусгавар болгоно хэмээн үзсэн байна. Харин С.Должин (2019), Б.Тэмүүлэн (2020) нар үүнийг хуулийн зохицуулалтад нэгэнт хуульчлагдсан боловч найруулга зүйн хувьд тодорхойгүй байгаа нь тухайн зохицуулалтыг дутмаг болгож байна гэжээ. Иймд нэмэлт зохицуулалт хийх шаардлагатай хэмээн дүгнэсэн байна.

ИХ-ийн 220.1-д үндэслэн талуудын харилцааг шийдвэрлэхэд судлаачдын тавьсан урьдчилсан нөхцөлийг судлав. Үүнээс харахад талуудын гэрээ байгуулах үеийн төсөөлөл өөрчлөгдөхөд анхаарлаа хандуулсан байна. Тухайн талуудын төсөөлөл өөрчлөгдсөнөөр гэрээг цааш нь үргэлжлүүлэх боломжгүй болсныг тодотгосон байна. Мөн гэрээний үүргээ биелүүлэх нь хууль зөрчсөн үр дагаварт хүргэхээр бол нөхцөл байдал өөрчлөгдсөнд хамааруулан авч үзсэн. Нөгөө талаас зарим судлаач үүрэг гүйцэтгэгчийн гэм буруугүйгээр эрхзүйн хувьд үүрэг гүйцэтгэх боломжгүй байдал нь нөхцөл байдал өөрчлөгдөх тохиолдолд хамаарах эсэх нь тодорхойгүй хэмээн дүгнэсэн байна.

Үүрэг гүйцэтгэгчийн гэм буруугүйгээр үүргийн гүйцэтгэл боломжгүй болоход хэрхэн авч шийдвэрлэх нь тодорхойгүй байна. Энэ нь нэг талаараа бизнесийн олон талт харилцаанд зохицуулалтын хийдэл үүсгэж, нөгөө талаараа иргэний эрхзүйн харилцаанд оролцож буй талуудын эрх ашгийг хөндөн тэгш бус байдлыг үүсгэж болзошгүй байна. Япон улсын Иргэний хуультай харьцуулан судалсны ололт нь үүрэг гүйцэтгэгчийн гэм буруугүйгээр үүргийн гүйцэтгэл боломжгүй болсон тохиолдолд үүрэг гүйцэтгэгчийн хүсэл зоригоос үл хамаарсан нийгмийн хүчин зүйлийг анхааран авч үзэж байгаа талаар дурдах нь зүйтэй. Гэм буруугүйгээр үүргийн гүйцэтгэл боломжгүй болсныг тэр бүр гэнэтийн давагдашгүй хүчин зүйл хэмээн тооцуулах нь хүндрэлтэй. Иймд хүсэл зоригоос үл хамаарах нийгмийн хүчин зүйлийн талаар судлан гэм буруугүйгээр үүргийн гүйцэтгэл боломжгүй болсон тохиолдлыг үүргээс чөлөөлөх асуудлыг цааш нь нэмж судлах шаардлагатай байна.

Үүрэг гүйцэтгэгчийн гэм буруугүйгээр үүргийн гүйцэтгэл боломжгүй болох асуудлыг хуульд тодорхой байдлаар тусгах нь зүйтэй байна. Учир нь бизнесийн олон талт харилцаанаас гадна бусад төрлийн гэрээнүүдэд үүрэг гүйцэтгэгчийн гэм буруугүйгээр үүргийн гүйцэтгэл боломжгүй болж болох юм. Энэ тохиолдолд гэрээ байгуулснаас өмнө үүрэг гүйцэтгэх боломжгүй байсан нөхцөл байдал болон гэрээ байгуулсны дараа үүрэг гүйцэтгэх боломжгүй болсон нөхцөл байдлыг ялган хуульчлах шаардлагатай байна. Иймд дараах саналыг дэвшүүлэв.

– үүргийн гүйцэтгэл үүрэг гүйцэтгэгчийн гэм буруугүйгээр боломжгүй болсон тохиолдолд түүнийг авч шийдвэрлэхдээ үүрэг гүйцэтгэгчид нөлөөлсөн нийгмийн хүчин зүйлийн нөлөөг харгалзан авч үзэх;

– үүрэг гүйцэтгэгчийн гэм буруугүйгээр үүргийн гүйцэтгэл боломжгүй болох тохиолдлыг хуульд тодорхой болгох шаардлагатай байна.

ЭХ СУРВАЛЖ

Монгол хэл дээрх

Ном, өгүүлэл, судалгааны тайлан

1. Б.Буянхишиг, Үүргийн эрхзүйн ерөнхий анги. Уб. 2017.
2. С.Должин, “Үүрэг гүйцэтгэх боломжгүй болох нөхцөлд эдийн засгийн дүн шинжилгээ хийх хөгжлийн чиг хандлага” Монгол Улсын хувийн эрх зүйн тулгамдсан асуудал: Иргэний болон худалдааны хууль тогтоомжийн олон улсын жишиг (2019 оны хавар): 307-318.
3. Ж.Оюунтунгалаг, Иргэний эрхзүй II Гэрээний үүрэг. Уб. 2022.
4. Ж. Оюунтунгалаг, Иргэний эрхзүйн ерөнхий анги. Уб.2020.
5. Т.Мэндсайхан, Гэрээний эрхзүй. Уб. 2021.
6. Б.Тэмүүлэн, “Үүргийн эрхзүйн ерөнхий анги дахь зөрчилдөөнтэй ба дутуу хийгдсэн зохицуулалтын асуудал” Эрхзүй сэтгүүл 2. 2021 оны хавар.
7. Н.Чинбат, Иргэний эрхзүйн лекцийн товчоон ерөнхий анги. Уб. 2014.
8. Кают.Ё, Шпанглер.Э нар, Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар. Уб. 2010.
9. Д.Энхзул, Иргэний эрх зүйн 40 бодлого. Уб. 2009.
10. С.Солонго, “Ковид-19 Цар тахал нь гэрээний үүргийн гүйцэтгэлд нөлөөлөх эрх зүйн үр дагавар, шийдвэрлэх арга зам”, магистрын зэрэг горилсон бүтээл, МУИС-ХЗС, Уб. 2022.

Гадаад хэл дээрх

Ном, өгүүлэл, судалгааны тайлан

1. 鳥毛 拓馬. なぜ債権法は改正 されるのか. 大和総研調査季報新春号 Vol.9.2013 年.
2. 加賀山茂、契約法講座、日本評論社. 2017.
3. 弁護士 金子 剛、”民法解説” 金子総合法律事務所 (2020 Хавар): 7-8.<https://tek-law.jp/civil-code/claims/general-provisions/effects-of-claims/liability-for-non-performance/article-412-2/>.
4. 増野 圭、”履行不能とは” 国際総合事務所 (2020 Хавар):1-4. <https://xn--3kqu8h74fvjh21bnlehqde40h44r.com/>.
5. 弁護士中澤智慧, “民法（債権法）改正の解説1 なぜ民法改正なのか” [横浜ロード法律事務所](Spring 2019): https://www.yokohama-roadlaw.com/column/post_717.html.
6. 債務不履行の改正債権法改正のポイント【第04回】～債務不履行の改正を押しさえよう～
7. https://yotsuyagakuin-tsushin.com/blog_takkenshiken/saikenho04/.

LEGAL ISSUES RELATED TO INNOCENT DEFAULT***Uyanga.M****Master's student, School of Law, NUM***ABSTRACT:**

Unexpected country-wide restrictions may make it impossible to execute the obligation through no fault of the obligor. In this case, it will be principle of justice how to protect the interests of the parties. It is possible that execution of the obligation becomes impossible without the fault of the obligor. In this case, the article will show how the regulation of the law is interpreted. Also, it will be compared with the regulations of the Civil Code of Japan and its distinction will be presented. In this way, it will be presented a way to improve the measures to solve the problem in the event that the execution of the obligation becomes impossible without the fault of obligor. This article is written on research by academics.

KEYWORDS:

Obligator, impossibility to execute obligation, fault, changes in circumstances, principle of justice

**2023 ОНЫ IV УЛИРЛЫН
ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ
(МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ)**

ШҮҮГЧ, ӨМГӨӨЛӨГЧДИЙН ХАРААТ БУС БАЙДЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН НҮБ-ЫН ТУСГАЙ ИЛТГЭГЧ МАРГАРЕТ САТТЕРТУЭЙТЫГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗЛАА

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах (Dr.jur), Эрдэмтэн нарийн бичгийн дарга М.Түвшинжаргал (Ph.D) нар 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр Шүүгч, өмгөөлөгчдийн хараат бус байдлын асуудал хариуцсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тусгай илтгэгч Маргарет Саттертуэйт, НҮБ-ын Хүний эрхийн Дээд Комиссарын алба (ХЭДКА)-ны хүний эрхийн мэргэжилтэн Мелание Сантизо болон Тусгай илтгэгчийн туслах Катарина Сидов нарыг хүлээн авч уулзлаа.



Уулзалтын үеэр ХЗҮХ-ийн захирал Х.Эрдэм-Ундрах (Dr.jur) ХЗҮХ-ийн үйл ажиллагаа, бүх нийтийн эрх зүйн боловсролыг дэмжих хөтөлбөр, 1800-1202 подкаст болон эрх зүйн хөтөч бэлтгэх сургалт, судалгааны талаар харилцан мэдээлэл солилцлоо.

Тус уулзалтад Эрдэм шинжилгээний ахлах ажилтан О.Энххүслэн, Эрдэм шинжилгээний ажилтан Д.Дэмидханд нар байлцав.



/ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тусгай илтгэгч Маргарет Самтертуэйт болон бусад албан хаагчидтай хийсэн уулзалтын үеэр/



ХЗҮХ-ийн төлөөлөл

НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 35, 17 ДУГААР СУРГУУЛЬД “ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ” СЭДЭВТ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Хууль зүйн үндэсний хүрээлэн Нийслэлийн ерөнхий боловсролын 35, 17 дугаар сургуулийн 130 гаруй сурагчдад “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Сургалтад Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Арга зүйч багш Д.Цэцэгдарь хичээл заав.

Сургалтаар:

- Зөв хандлага төлөвшүүлэх;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх /хулгай, дээрэм, танхайрах гэмт хэрэг, мансууруулах бодисын хор хөнөөл/-ийн ойлголт;
- Сургуулийн орчин дахь үе тэнгийн дээрэлхэлт сэдвээр хичээл заалаа.



БНСУ-ЫН СОЛОНГОСЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭН (KLRI)-ГЭЭС ЦАХИМ СЕМИНАРЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Хууль зүйн үндэсний хүрээлэн болон Солонгосын хууль тогтоомжийн судалгааны хүрээлэн (KLRI)-гийн хамтын ажиллагааны хүрээнд 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн албан хаагчид Солонгосын хууль тогтоомжийн судалгааны хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах судлаач, хууль зүйн ухааны доктор Ким Хён Гүний “Солонгос улсын оюуны өмчийн тухай хууль” сэдэвт семинарт хамрагдлаа.



НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 39 ДҮГЭЭР СУРГУУЛЬД СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Хууль зүйн үндэсний хүрээлэн Нийслэлийн ерөнхий боловсролын 39 дүгээр сургуулийн сурагчдад “Цахим орчин дахь хүүхдийн эрх” сэдэвт сургалтыг өнөөдөр зохион байгууллаа. Сургалтад Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ахлах ажилтан, хуульч Р.Хатансайхан хичээл зааж, 35 сурагч хамрагдлаа.



НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 57 ДУГААР СУРГУУЛЬД СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Хууль зүйн үндэсний хүрээлэн Нийслэлийн ерөнхий боловсролын 57 дугаар сургуулийн сурагчдад “Цахим орчин дахь хүүхдийн эрх” сэдэвт сургалтыг өнөөдөр зохион байгууллаа. Сургалтад Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ахлах ажилтан, хуульч Р.Хатансайхан хичээл зааж, 60 сурагч хамрагдлаа.



ХУВИЙН ЭРХ ЗҮЙГ ИЖИЛТГЭХ ОЛОН УЛСЫН ХҮРЭЭЛЭН (UNIDROIT)-ГИЙН ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА ПРОФЕССОР ДОКТОР ИГНАЧИО ТИРАДОГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗЛАА

Хууль зүй үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах (Dr.jur) Хувийн эрх зүйг ижилтгэх олон улсын хүрээлэн (UNIDROIT)-гийн Ерөнхий нарийн бичгийн дарга ноён профессор доктор Игначио Тирадо (Ph.D), ахлах хуульч Виллиам Брайди-Ватсонтой нарыг 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр хүлээн авч уулзлаа.

Хувийн эрх зүйг ижилтгэх олон улсын хүрээлэн нь улс хоорондын хувийн эрх зүйг уялдуулах, харилцан нийцүүлэх арга барилыг судлах, хууль, эрх зүйн нийтлэг арга, хэрэгсэл, зарчим, дүрмийг батлахад бэлтгэх зорилготой Засгийн газар хоорондын бие даасан, эртний түүхтэй байгууллагуудын нэг юм.

Монгол Улс 2023 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр тус байгууллагын 65 дугаар гишүүнээр элсэн орсон. Уг ажлын хүрээнд хууль зүйн үндэсний хүрээлэн нь хувийн эрх зүйг ижилтгэх олон улсын хүрээлэнгийн үйл ажиллагаа, баримт бичгүүдтэй танилцах зорилгоор албан хаагчдыг уг байгууллагад урт, богино хугацаагаар ажиллуулж дадлагажуулах, салбарын хуульчдын чадавхыг нэмэгдүүлэх, судалгааны болон ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллах зэргээр хамтын ажиллагааг эхлүүлэх талаар санал солилцлоо. Тус уулзалтад ХЗҮХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга М.Түвшинжаргал (Ph.D), Эрдэм шинжилгээний ажилтан Б.Сүнжидмаа нар байлцав

БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН ТУЛУЗ КАПИТОЛИЙН ИХ СУРГУУЛИЙН ТӨЛӨӨЛӨЛТЭЙ УУЛЗЛАА

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль зүйн сургалт, мэдээлэл, сурталчилгааны төвийн дарга С.Билигсайхан, Эрдэм шинжилгээний ажилтан Б.Сүнжидмаа нар Франц улсын Тулуз Капитолийн их сургуулийн зочин судлаач Чарльз Даган, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн профессор М.Мөнхнаран(Ph.D) нарыг 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдөр хүлээн авч уулзлаа.



Уулзалтын үеэр Хууль зүйн сургалт, мэдээлэл, сурталчилгааны төвийн дарга С.Билигсайхан тус хүрээлэнгийн чиг үүрэг, бүх нийтийн эрх зүйн боловсролыг дэмжих хөтөлбөр, эрх зүйн хөтөч бэлтгэх сургалт, “Хууль дээдлэх ёс” сэтгүүлийн талаар мэдээлэл солилцож цаашид хамтарсан судалгаа хийх, сэтгүүлд өгүүлэл нийтлүүлэх болон хоёр байгууллагын хамтын ажиллагааг эхлүүлэх талаар харилцан санал солилцлоо.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН “БҮС НУТГИЙН СОЁЛЫН ФОРУМ 2023: ХОЙД БҮСИЙН СОЁЛЫН БҮТЭЭН БАЙГУУЛЛЫГ ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁСООР ДЭМЖИХ НЬ” СЭДЭВТ ФОРУМД УРИЛГААР ОРОЛЦЛОО.

БНХАУ-ын Өвөр Монголын Их Сургуулийн Хууль зүйн сургууль санаачлан 2023 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотноо зохион байгуулсан “Бүс нутгийн соёлын форум 2023: Хойд бүсийн соёлын бүтээн байгууллыг хууль дээдлэх ёсоор дэмжих нь” сэдэвт форумд Хууль зүйн үндэсний хүрээлэн урилгаар оролцлоо.

Тус арга хэмжээний нээлтэд Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, доктор(Dr. jur) Х.Эрдэм-Ундрахыг төлөөлж Хүний эрх, олон улсын эрх зүйн болон харьцуулсан эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ахлах ажилтан Б.Энх-Амгалан мэндчилгээ дэвшүүлж үг хэлэв. Тус форум үндсэн ба 4 салбар хуралдаанаас бүрдсэн бөгөөд “Хятад-Монгол-Орос гурван улсын Эдийн засгийн коридорын эрх зүйн асуудал” сэдэвт салбар хуралдаанд эрдэм шинжилгээний ахлах ажилтан Б.Энх-Амгалан, эрдэм шинжилгээний ажилтан Э.Сэлэнгэ нар “Монгол Улсын хувийн эрх зүйн шинэтгэл ба эдийн засгийн хамтын ажиллагааны зарим асуудал” сэдвээр илтгэл хэлэлцүүлсэн.



/Өвөр Монголын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн профессор, хууль зүйн ухааны доктор, түүхийн ухааны доктор Д.Наранцогт, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан Б.Энх-Амгалан, эрдэм шинжилгээний ажилтан Э.Сэлэнгэ, Өвөр Монголын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн дэд профессор, хууль зүйн ухааны доктор Дайчин нар/



/“Бус нутгийн соёлын форум 2023: Хойд бүсийн соёлын бүтээн байгууллыг хууль дээдлэх ёсоор дэмжих нь” сэдэвт форумын үеэр/

Эрх зүйн түүх, соёлын өвийг эрхэмлэх, соёлын бүтээн байгууллыг хууль дээдлэх ёсоор дэмжих олон талт ажиллагааны арга замыг хөндсөн энэхүү форумд 100 орчим судлаач, мэргэжилтэн оролцов. Үүний хүрээнд “Хятад-Монгол-Орос гурван улсын Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-ийн эрх зүйн асуудал, цаашдын чиг хандлага болон хууль зүйн хамтын ажиллагааг сайжруулах хэрэгцээ, шаардлага, шийдвэрлэх боломжийг хөндсөн нь онцлог юм.



/"Хятад-Монгол-Орос гурван улсын Эдийн засгийн коридорын эрх зүйн асуудал" сэдэвт салбар хуралдааны үеэр/

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН ӨВӨР МОНГОЛЫН ИХ СУРГУУЛИЙН ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГАА ХӨГЖҮҮЛЭХ ХЭЛЭЛЦЭЭ ХИЙВ.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль зүйн судалгааны төвийн Хүний эрх, олон улсын эрх зүйн болон харьцуулсан эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ахлах ажилтан Б.Энх-Амгалан, Иргэний эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан Э.Сэлэнгэ нар 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр Өвөр Монголын Их Сургуулийн Хууль зүйн сургуульд зочилж, хамтын ажиллагааны хэлэлцээ хийв.

Өвөр Монгол Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн талаас захирал, профессор Дин Фэн тэргүүтэй удирдлагын багаас гадна салбар эрх зүйн тэнхимийн эрхлэгч, хятад, монгол хос хэлтэй багш нарын бүрэлдэхүүн тус уулзалтад байлцлаа. Байгууллагууд өөрсдийн чиг үүрэг, үйл ажиллагааны талаар танилцуулан, эрх зүйн судалгаа, сургалт, мэдээлэл, сурталчилгааны хүрээнд хамтран ажиллах чиглэл, боломжийн талаар санал солилцож, хамтын ажиллагааны санамж бичгийн төслийг хэлэлцсэн нь энэ удаагийн уулзалтын үр дүн юм. Тухайлбал, хувийн эрх зүй судлал, арилжаа, худалдааны эрх зүйн хууль тогтоомжийн судалгаа хийж, чанар, үр нөлөөг дээшлүүлэх тал дээр хамтран ажиллах хэрэгцээ, шаардлага их байгааг чухалчлан тэмдэглэсэн.



/Хууль зүйн үндэсний хүрээлэн, Өвөр Монголын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн хамтын ажиллагааны уулзалтад оролцогсдын төлөөлөл/

Талууд хууль тогтоомжийг хятад хэл дээр орчуулж хэвлүүлэх, олон улсын эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлж оролцох зэргээр хамтран ажиллаж ирсэн түүхэн ач холбогдлыг онцолж, харилцаа, хамтын ажиллагааг шинэ шатанд гаргаж ажиллахаа харилцан илэрхийлсэн болно.

Мөн судлаач Б.Энх-Амгалан, Э.Сэлэнгэ нар Өвөр Монголын Их Сургууль болон тус сургуулийн Хууль зүйн сургуулийн үйл ажиллагаа, дэд бүтцийн бүтээн байгуулал, номын сангийн ажил үйлчилгээтэй танилцаж, туршлага солилцов.



/Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Э.Сэлэнгэ, эрдэм шинжилгээний ахлах ажилтан Б.Энх-Амгалан, Өвөр Монголын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн дэд профессор, хууль зүйн ухааны доктор Дайчин нар/

